Улсын бүртгэлийн дугаар Нууцын зэрэглэл А
Код

## ГЕОПОЛИТИК СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# ГЕОПОЛИТИКИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Суурь судалгааны төслийн тайлан
2017-2019

**I БОТЬ**


Төслийн удирдагч: Д.Мягмар. Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал. Геополитик судлалын хүрээлэнгийн захирал.



Захиалагч байгууллага: БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн бодлогын газар


**Улаанбаатар хот**
**2019 он**

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар | Нууцын зэрэглэл А |
| Код | Гэрээний дугаар ШуСс/2017/03 |

## ГЕОПОЛИТИК СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# ГЕОПОЛИТИКИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Суурь судалгааны төслийн тайлан
2017-2019

**I БОТЬ**

| | |
|---|---|
| Төслийн удирдагч | Д.Мягмар, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал, Геополитик судлалын хүрээлэнгийн захирал. |
| Санхүүжүүлэгч байгууллага | Шинжлэх ухаан технологийн сан |
| Захиалагч байгууллага | БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн бодлогын газар |
| Тайлан өмчлөгч | Геополитик судлалын хүрээлэн. Улаанбаатар-14210. Энх тайвны гудамж 7а. ГХЯ-ны байр. Өрөө 31. Утас 93138353. 80018142. И-мэйл: igsmongolia@gmail.com |

**Улаанбаатар хот**
**2019 он**

## РЕФЕРАТ. ТҮЛХҮҮР ҮГ

### Реферат

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн юм. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзлэж байгаа геополитикийн орон зай дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болжээ. Энэ нь манай орныг эдгээр их гүрний зүгээс Зүүн хойд болон Төв Азид явуулж буй геостратегийн бодлогынхоо хүрээнд байлгах зайлшгүй ашиг сонирхлыг үүсгэж байгаа болно.

Удаа дараа явуулсан судалгааны дүнгээс харахад геополитикийн энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлого, Гадаад бодлогын үзэл баримтлал болон Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг тулгуур баримт бичигт улс орны аюулгүй байдал, хөгжлийн бодлогыг хангахад геополитикийн хүчин зүйлсийг тооцох асуудал тийм ч тодорхой тусгагдаагүй болох нь улам бүр ойлгогдсоор байна.

Ийм учраас энэ суурь судалгааны төсөлд анх удаа улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд хамаарах өргөн хүрээт, олон талт асуудлуудын дотроос геополитикийн шинэ нөхцөл байдлын улмаас манай улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлсийг тусгайлан судалж үнэлэлт дүгнэлт өгөн, тулгамдсан асуудлыг нээн илрүүлж, улмаар энэ салбарт баримтлах төрийн бодлогын үндсийг боловсруулан, түүний үндсэн чиглэл, агуулга болон хэрэгжүүлэх арга замыг судлан тодорхойлж, үндэсний аюулгүй байдлын салбарын үндсэн баримт бичгүүдэд тодотгол хийх саналыг цэгцлэн боловсруууллаа.

Суурь судалгааны төслийн үндсэн үр дүн:

1. “Геополитикийн шинэ нөхцөл байдал ба Монгол Улсын үндэсний аюулгүй байдал” сэдэвт суурь судалгааны тайлан.

2. ”Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийн төсөл.

3. “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдэд тодотгол хийх санал зөвлөмж.

**Түлхүүр үг.**

Олон улс, геополитик, геостратеги, аюулгүй байдал, гадаад бодлого, батлан хамгаалах,

## ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

**Төслийн удирдагч**

| | |
|---|---|
| Довчингийн Мягмар. | Геополитик судлалын хүрээлэнгийн захирал, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал.<br><br>(Удиртгал, 1-р бүлгийн 2-р дэд бүлгийн 2, 3, 4, 5-р хэсэг, 2-р бүлгийн 2-р дэд бүлэг, 3-р бүлгийн 2-р дэд бүлгийн 1 хэсэг, Төгсгөл. Хавсралтууд) |

**Гүйцэтгэгчид:**

| | |
|---|---|
| Ноосгойн Алтанцэцэг. | ГПСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор, профессор<br><br>(1-р бүлгийн 1-р дэд бүлэг) |
| Ринчингийн Батмэнд. | ГПСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, гавьяат эдийн засагч, доктор, профессор<br><br>(1-р бүлгийн 2-р дэд бүлгийн 1-р хэсэг, 4-р бүлгийн 1-р дэд бүлгийн 1-р хэсэг) |
| Хасбазарын Бэхбат. | ГПСХ-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүн, доктор, Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд.<br><br>(1-р бүлгийн 2-р дэд бүлгийн 2-р хэсэг, 2-р бүлгийн 1-р дэд бүлэг, 3-р бүлгийн 1-р дэд бүлэг, 2-р дэд бүлгийн 2,3 хэсэг) |
| Тойнхүүгийн Баярмагнай. | Орчуулагч, редактор. |
| Дугаржавын Сүрэнбаяр. | Туслах ажилтан, магистр. |

## НЭР ТОМЬЁО, ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АНДБН | Ази, Номхон далайн бүс нутаг |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Улс |
| БНМАУ | Бүгд Найрамдах Монгол Ард Улс |
| БХЯ | Батлан хамгаалах яам |
| БСШУС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам |
| ГХЯ | Гадаад хэргийн яам |
| ЕАБХАБ | Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага |
| ЗХА | Зүүн Хойд Ази |
| ЗХЖШ | Зэвсэгт хүчний жанжин штаб |
| ЗХУ | Зөвлөлт Холбоот Улс |
| НАТО | Умард Атлантын гэрээний байгууллага |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| АБХАГБ | Аюулгүй байдал, хамтын ажиллагааны гэрээний байгууллага |
| ОУАЭА | Олон улсын атомын энергийн агентлаг |
| ОУЭСА | Олон улсын энхийг сахиулах ажиллагаа |
| ТУХН | Тусгаар улсуудын хамтын нийгэмлэг |
| ЦЗАС | Цөмийн зэвсгээс ангид статус. |
| ҮАБЗ | Үндэсний аюулгүй байдлын зөвлөл |
| ШХАБ | Шанхайн хамтын ажиллагааны байгууллага |
| ШУТС | Шинжлэх ухаан технологийн сан |
| ЭҮНХ | Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн |

## ГАРЧИГ


**УДИРТГАЛ** 7

**Нэгдүгээр бүлэг. ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ: ГЕОПОЛИТИКИЙН ТУХАЙ ӨНӨӨ ҮЕИЙН ОЙЛГОЛТ**

**1.1. Олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт**

1.1.1. Äýëõèé íèéòèéí олон улсын нөхцөл байдлын ººð÷ëºëò 15
1.1.2. Ази, Номхон далайн бүс нутгийн улс хоорондын харилцааны õàíäëàãà 17
1.1.3. Бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудал 20
1.1.5. Олон улсын нөхцөл байдлын цаашдын төлөв 22

**1.2. Геополитикийн тухай өнөө үеийн ойлголт**

1.2.1. Геополитикийн үндсэн асуудал, судлах зүйл 24
1.2.2. Олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдал, учир шалтгаан 30
1.2.3. Геополитикийн аюулгүй байдлын тухай ойлголт 41
1.2.4. Соёл, иргэншлүүдийн геополитикийн эрмэлзэл 42
1.2.5. Их гүрнүүдийн геополитикийн мөн чанар, гол зорилго 44

**Хоёрдугаар бүлэг. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛС: МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ,**

**2.1. Аюулгүй байдлын гадаад орчинд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс**

2.1.1. Зүүн хойд Ази ба Орос, Хятадын хүчин зүйлс 61
2.1.2. Аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагууд ба Монгол Улс 64

**2.2. Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдол**

2.2.1. Монгол Улсын геополитикийн ач холбогдлын мөн чанар, учир шалтгаан 94
2.2.2. Монгол Улсын геополитикийн аюулгүй байдлын асуудал 100
2.2.3. Монголын талаарх их гүрнүүдийн геостратегийн бодлого. 101

**Гуравдугаар бүлэг. ТӨРИЙН ГАДААД, ДОТООД БОДЛОГЫН ГЕОСТРАТЕГИЙН АГУУЛГА**

**3.1. Гадаад бодлогын геостратегийн агуулга**

3.1.1. Далайд гарцгүй бага орны геополитикийн онцлог 113
3.1.2. Гадаад бодлогын олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн агуулга 117
3.1.3. Гуравдагч хөршийн бодлого 121
3.1.4. Солонгосын хойгийн асуудлаар баримталж буй бодлого 140
3.1..5. Цөмийн аюулаас ангид байх бодлого 150
3.1.6. Эвсэлд үл нэгдэх бодлого 170

**3.2. Батлан хамгаалах бодлогын геостратегийн агуулга**

3.2.1. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа 184
3.2.2. Олон улсын энхийг сахиулах ажиллагаа дахь Монголын оролцоо 189
3.2.3. Олон улсын терроризмтой хийх тэмцэл дэх Монголын оролцоо 197

**Дөрөвдүгээр бүлэг. ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭСЛЭГЭЭ, САНАЛ ЗӨВЛӨМЖ**

**4.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэслэгээ**

4.1.1. Геополитикийн салбарт баримтлах бодлого боловсруулах шаардлага, үндэслэл 203
4.1.2. Үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл сорилт, аюул заналын таамаглал 212
4.1.3. Геополитикийн салбарт баримтлах бодлогын үндсэн зорилго, чиглэл, агуулга 217

**4.2. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэст тодотгол хийх үндэслэл**

4.3.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодотгол хийх үндэслэл 224
4.3.2. Гадаад бодлогын үзэл баримтлалд тодотгол хийх үндэслэл 227
4.3.3. Батлан хамгаалах бодлогын үндэст тодотгол хийх үндэслэл 230

**ДҮГНЭЛТ** 234

**Ашигласан материалын жагсаал** 257

**Хавсралт** 265

## УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Зүүн хойд Ази болон Төв Азид улс төр, эдийн засгийн нөлөөллийн дахин хуваарилалт явагдаж, үүний улмаас том гүрнүүдийн гео улс төр, гео эдийн засаг болон геостратегийн ашиг сонирхол өөр хоорондоо хүчтэй зөрчилдөх болсон нь эдгээр бүс нутгийн геополитикийн нөхцөл байдалд хүчтэй нөлөөлөх боллоо. Энэ их өөрчлөлт биднийг тойрон өнгөрөхгүй нь тодорхой бөгөөд Монгол Улс үүнд нэлээд гүнзгийгээр татагдан орж болзошгүй байна. Сүүлийн жилүүдэд манай орны хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах гэсэн бие даасан эрмэлзэл, стратегийн ач холбогдол бүхий газар зүйн байршил, ашигт малтмалын асар их баялаг, нүүдлийн ахуй соёл болон  онгон уудам байгал орчин зэрэг нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, бидний оршин сууж буй газар нутаг тэдний геополитикийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирах магадлал  хүчтэй мэдрэгдэж эхэллээ.

Үүний зэрэгцээ манай орны өөрийн улс төр, нийгэм, эдийн засаг, хувь хүний амьдралд олон шинэ эрсдэл сорилт, тулгарах болж, зарим нь лавшрах хандлагатай байна. Улс төрийн дотоод нөхцөл байдал хурцадмал хэвээр, нийгмийн хэсэг бүлэг хоорондын зөрчил сөргөлдөөн үргэлжилсээр, эдийн засгийн тэнцвэртэй хөгжил төдийлөн хангагдаж чадахгүй, сайн засаглал бий болгох ажил удаашралтай, авилаг, шударга бус явдал, хуулийг үл тоомсорлох үйлдэл газар авсаар, ард түмний нэлээд хэсгийн амьдралын түвшин сайжрахгүй байгаа зэргээс улбаалан нийгэмд тогтворгүй, хуваагдмал байдал бий болох шинж тэмдэг ажиглагдаж байна.

Түүнчлэн, өнөө үед том гүрнүүд хоорондын харилцан сөргөлдөөний агуулга аажмаар өөрчлөгдөж улам бүр  геополитикийн орон зайн төлөөх шинж чанартай болсоор байгаа нь манай орныг эдгээр улсын  геостратегийн бодлогын гүн эргүүлэгт татан оруулах хүчтэй магадлалыг бий болгож байна. Монгол улс улс хоорондын харилцаанд  энхийг эрхэмлэх, итгэлцлийг бэхжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачилга гарган оролцож, дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн зүгээс дэмжлэг олж авч чадсан хэдий ч геополитикийн аюулгүй байдлын хувьд маш эмзэг орчинд оршиж байна.

Иймээс шинээр үүсэн бий болж байгаа геополитикийн үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилтыг нээн илрүүлж, цоо шинээр ухаарч ойлгох, Монгол улсын

үндэсний аюулгүй байдалд сөргөөр хүчтэй нөлөөлж эхэлж буй эдгээр хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах практик шийдлийг хайн олох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн юм.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзлэж байгаа геополитикийн орон зай дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болжээ. Энэ нь:

- нэгдүгээрт, нүүрс, зэс, молибден, алт, уран болон бусад ашигт малтмалын асар том ордууддаа бусад оронтой хамтран ашиглаж эхэлсэнтэй;
- хоёрдугаарт, үндсэндээ тоталитар дэглэмтэй дэлхий хоёр том гүрний дунд хавчигдан оршиж байгаа боловч ардчиллыг хөгжүүлэх талаараа социализмын дараах орнуудад, ялангуяа Азийн улсуудад үлгэр жишээ болж байгаатай;
- гуравдугаарт, дэлхий нийтийн хувьд тогтворгүй байдлын нэг үндэс болоод байгаа лалын ертөнцтэй хил залгаа оршдогтой;
- дөрөвдүгээрт, магадгүй хамгийн чухал нь, Орос, Хятад гээд өөр хоорондоо болон АНУ тэргүүтэй барууны орнуудтай багагүй зөрчил, сөргөлдөөнтэй хоёр том улсын дунд оршдог стратегийн чухал байршил зэрэгтэй холбоотой юм.

Эдгээр нь манай орныг эдгээр их гүрний зүгээс Зүүн хойд болон Төв Азид явуулж буй геостратегийн бодлогынхоо хүрээнд байлгах зайлшгүй ашиг сонирхлыг үүсгэж байгаа болно.

Монгол улс хоёр их хөрш, АНУ болон гуравдагч бусад улс оронтой олон талт, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа боловч

их гүрнүүдийн зүгээс Монгол Улсад улс төрийн нөлөөллийнхөө давамгай байдлыг бий болгох, эдийн засгийн тодорхой салбаруудыг нь хараандаа оруулах, улсынх нь хөгжлийг зөвхөн уул уурхайн болон хөдөө аж ахуйн салбарын түүхий эдийн экспортод түшиглэсэн, олон улсын зах зээлээс хэт хамааралтай байдал руу хөтлөхийг оролдох буюу эцсийн дүндээ өөрсдийн геополитикийн нөлөөллийн хараany орон байлгах гэсэн хандлага сүүлийн жилүүдэд хүчтэй ажиглагдаж эхэллээ.

Удаа дараа явуулсан судалгааны дүнгээс харахад геополитикийн энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлого, Гадаад бодлогын үзэл баримтлал болон Батлан хамгаалах бодлогын үндэс зэрэг тулгуур баримт бичигт улс орны аюулгүй байдал, хөгжлийн бодлогыг хангахад геополитикийн хүчин зүйлсийг тооцох асуудал тийм ч тодорхой тусгагдаагүй болох нь улам бүр ойлгогдсоор байна.

Үүний зэрэгцээ, аливаа улс дэлхий ертөнцөд, түүний дотор оршин тогтнож буй бүс нутгийнхаа хүрээнд өөрийн орон зайг эзлэх буюу хадгалах, газар зүйн байршил, нөөц баялаг, цаг агаарын нөхцөл байдал, хүн амын тоо, чанар зэрэг геостратегийн давуутай талуудаа ашиглан тусгаар тогтнолоо бэхжүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх, ард иргэдийнхээ энх амгалан, элбэг хангалуун амьдралыг хангах зорилгоор геополитикийн салбарт баримтлах өөрийн гэсэн үзэл баримтлалтай байж үүнийгээ хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн бодлогыг боловсруулж мөрддөг. Энэ нь улс орны хөгжлийн хэтийн зорилго, ойрын зорилтуудыг үндэслэлтэй төсөөлөх, учирч болзошгүй эрсдэл сорилт, аюул заналыг урьдчилан тодорхойлох, тэдгээрээс сэргэмжлэх, хамгаалах арга замыг оновчтой сонгох, хүч хөрөнгө, нөөц бололцоогоо зөв хуваарилах бололцоог олгох чухал ач холбогдолтой байдаг.

Энэ бүхнээс үүдэн улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос Монгол Улсын төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал, монгол үндэстний удмын сан, угсаа гарвал, соёл иргэншлийг хадгалан хамгаалахад буюу үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг суурь судалгааны түвшинд тусгайлан авч үзэх, эдгээрийг тооцсон ”Геополитикийн

салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” нэртэй байж болох баримт бичгийн төслийг цэгцлэн боловсруулах, улмаар үндэсний аюулгүй байдлын салбарын үзэл баримтлалд хамаарах үндсэн баримт бичгүүдэд тодотгол хийх нь зайлшгүй шаардлага болон тавигдаж байгаа болно.

Ер нь үндэсний үнэт зүйлсээ хадгалан хамгаалахтай холбогдол бүхий онцгой асуудлыг үе үеийн хаад ноёд, төрийн жолоодогч нар ухаантнуудынхаа хязгаарлагдмал хүрээнд тусгайлан бодож боловсруулан, үүнийхээ цөм үндсийг “хар хайрцгийн бодлого” хэмээн нэрлэж, хамгийн чандаар хадгалан хамгаалж, эрхэмлэн баримталж, үйл ажиллагаандаа тууштай мөрдлөг болгон, дараагийн залгамжлагчдаа өвлүүлэн үлдээж ирсэн нь Монгол төрийн эрхэмсэг уламжлал билээ.

**Сэдвийн судлагдсан байдал**

Геополитикийн шинэ нөхцөл байдалтай холбогдол бүхий асуудлаар сүүлийн жилүүдэд манай улсад цөөнгүй тооны бүтээл гарах болсон. Эдгээр бүтээлд уг асуудлыг гол төлөв улс төр, эдийн засаг, нийгмийн болон бодлого судлалын байр сууринаас судлан дүгнэсэн байна. Харин асуудалд аюулгүй байдлын судалгааны онол, практикийн үүднээс хандаж үнэлэлт, дүгнэлт өгсөн эрдэм шинжилгээний ажил одоогоор хийгдээгүй бөгөөд, бичигдсэн, боловсруулагдсан ном, бүтээл чиг ховор байна.

**Суурь судалгааны төслийн шинэлэг тал**

Энэхүү төслийн шинэлэг тал нь шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдал ба Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд холбогдох  олон талт асуудлыг анх удаа суурь судалгааны түвшинд тусгайлан авч үзэн, дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгсөнд оршиж байгаа юм. Түүнчлэн шинээр бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдлын улмаас Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд тулгарах болсон тулгамдсан чухал асуудлуудыг нээн илрүүлэх, геополитикийн үүдэл сэдэл бүхий учирч болзошгүй аюулын тухай шинэ төсөөллийг боловсруулах, эдгээрээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах зорилго бүхий шинжлэх ухааны үндэслэлтэй арга замыг судлан тодорхойлох, улмаар холбогдох дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулахыг зорилго болгосонд уг ажлын бас нэг шинэлэг агуулга оршиж байгаа болно.

**Суурь судалгааны төслийн зорилго, зорилтууд**

Энэхүү төслийн зорилго нь: олон улсын харилцаанд гарч буй эрс өөрчлөлт, Монгол Улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдлын улмаас үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлст дүн шинжилгээ хийх, тулгамдсан чухал асуудлуудыг нээн илрүүлэх, улмаар геополитикийн үүдэл сэдэл бүхий учирч болзошгүй аюулын тухай шинэ төсөөллийг боловсруулах, эдгээрээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах зорилго бүхий шинжлэх ухааны үндэслэлтэй арга замыг судлан тодорхойлоход оршиж байгаа болно

Энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд судалгааны дараах зорилтуудыг дэвшүүлсэн болно. Үүнд:

1. Дэлхий íèéòèéí олон улсын нөхцөл байдлын өөрчлөлтийн мөн чанар учир шалтгааныг судлан тодорхойлох, геополитикийн тухай өнөөгийн ойлголтод дүн шинжилгээ хийх;

2. Аюулгүй байдлын гадаад орчинд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс, Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдлын мөн чанар, учир холбогдол болон геополитикийн аюулгүй байдалд хамраах үндсэн асуудлуудыг нээн илрүүлэх, үнэлэлт , дүгнэлт өгөх;

3. Монгол Улсын гадаад болон батлан хамгаалах бодлогын геостратегийн агуулгад хамаарах үндсэн асуудлуудыг судлан тодорхойлох, дүн шинжилгээ хийх.

3. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах шаардлага, үндэслэл, хэрэгжүүлэх арга зам, үндсэн зорилго, чиглэл, агуулгыг судлан тодорхойлох, холбогдох дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах.

**Суурь судалгааны төслийн объект, судлах зүйл**

Олон улсын геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлт нь энэхүү төслийн объект бөгөөд Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй геополитикийн шинэ хүчин зүйлс нь түүний судлах зүйл болно.

### Суурь судалгааны төслийн хязгаарлалт

Төслийг хэрэгжүүлэхдээ олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт, түүний нөлөөллийн олон талт асуудал дотроос Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн асуудлыг тусгайлан авч үзэх, ингэхдээ өнөө үед баримталж буй олон улсын аюулгүй байдлын тухай онол, эрх зүйн үндсэн ойлголт, Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалт, одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, энэ салбарын хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг судлахаар хязгаарлалаа.

### Суурь судалгааны төсөлд хэрэглэсэн арга зүй

Энэхүү төслийг гүйцэтгэхэд олон улс судлал, эрх зүй, улс төр, эдийн засаг, нийгэм судлалын нийтлэг болон бодлого судлал, аюулгүй байдал, геополитик судлал, цэргийн шинжлэх ухаан, түүхэн баримт, статистик мэдээлэлд тулгуурлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг нийтлэг аргууд, түүнчлэн аюулгүй байдал, стратегийн судалгааны тусгай аргуудыг хэрэглэсэн болно.

### Суурь судалгааны төслийн ач холбогдол

Энэхүү төслийн шинжлэх ухааны ач холбогдол нь үндэсний аюулгүй байдлын бодлого, үйл ажиллагааг  боловсронгуй болгоход тодорхой хэмжээний хувь нэмэр оруулж байгаа болон энэ бодлогыг геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан боловсронгуй болгоход тус дөхөм болох арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлан тодорхойлсонд оршиж байгаа болно.

Төслийн практик ач холбогдол нь түүний үр дүнг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд, энэ салбарт хамаарах их, дээд сургууль, энэ чиглэлээр судалгаа, шинжилгээ явуулдаг эрдэм шинжилгээний байгууллагад ашиглаж болохоор боловсруулсанд оршино. Түүнчлэн уг судалгааны үр дүнгээр  боловсруулсан дүгнэлт, санал зөвлөмж нь энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажлыг цаашид гүнзгийрүүлэх болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын өдөр тутмын ажил, тэдгээрээс боловсруулан гаргах баримт бичгүүдэд тусгалаа олох боломжтойгоор хийгдсэн болно.

**Суурь судалгааны төслийн тайлангийн бүтэц, товч агуулга**

Энэхүү төслийн тайланг удиртгал, гурван бүлэг, дүгнэлт, хавсралт гэсэн бүтэцтэйгээр боловсруулна.

**Удиртгал** хэсэгт судалгааны ажлын сэдвийг сонгох болсон үндэслэл, түүний зорилго, зорилт, судалгааны объект, судлах зүйл, судалгааны ажлын хязгаарлалтыг тодорхойлон, үндсэн гурван бүлэг, дүгнэлт, хавсралтад тусгагдсан гол агуулгыг илэрхийлж, шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр, шинэлэг тал, ач холбогдлыг тодорхойлон, санал болгож буй асуудлуудын үндсэн агуулгыг нэгтгэн тодорхойллоо.

**“Олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт ба геополитикийн тухай өнөө үеийн ойлголт**” хэмээх Нэгдүгээр бүлэгт дэлхий íèéòèéí олон улсын нөхцөл байдлын өөрчлөлтийн мөн чанар учир шалтгааныг судлан тодорхойлж, геополитикийн тухай өнөөгийн ойлголтод дүн шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өглөө;

**“Аюулгүй байдлын гадаад орчинд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс: Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдол”** гэсэн Хоёрдугаар бүлэгт аюулгүй байдлын гадаад орчинд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлсийг судлан тодорхойлж Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдлын мөн чанар, учир холбогдол болон геополитикийн аюулгүй байдалд хамраах үндсэн асуудлуудыг нээн илрүүлж,үнэлэлт, дүгнэлт өглөө;

“**Төрийн гадаад, дотоод бодлогын геостратегийн агуулга”** гэсэн Гуравдугаар бүлэгт Монгол Улсын гадаад болон батлан хамгаалах бодлогын геостратегийн агуулгад хамаарах үндсэн асуудлуудыг судлан тодорхойлж, дүн шинжилгээ хийн, холбогдох дүгнэлтүүдийг боловсрууллаа;

**“Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэслэгээ”** хэмээх Дөрөвдүгээр бүлэгт геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах шаардлага, үндэслэл, хэрэгжүүлэх арга зам, үндсэн зорилго, чиглэл, агуулгыг судлан тодорхойлж, холбогдох дүгнэлт, санал зөвлөмжийг боловсрууллаа.

**Дүгнэлт хэсэгт** бүлэг бүрийн агуулгад товч үнэлэлт өгөн, судалгааны ажлын  зорилго, зорилтын биелэлт, үр дүнг нэгтгэн дүгнэж, геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын тухай санал, зөвлөмжийн үндсэн агуулга болон тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, онол, практикийн ач холбогдлыг тодорхойлон, тухайн сэдвээр хийх судалгааг цаашид үргэлжлүүлэх үндсэн чиглэлийг тодорхойллоо.

**Хавсралт** хэсэгт төслийн үндсэн үр дүнд тулгуурлан “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого” баримт бичгийн хувилбар, түүнчлэн “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг баримт бичгүүдэд тодотгол хийх санал боловсруулснаа оруулав.

Энэхүү төслийг  Монгол Улсын БСШУС-ын яам, ШУТС-аас тавьж буй шаардлагыг нягт баримтлан боловсруулаа. Ингэхдээ, аюулгүй байдлын салбарын нэр хүнд бүхий судлаачид, эрдэмтэн, багш нар, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагад ажилладаг хувь хүмүүсийн туршлага, санал зөвлөмжийг талархалтайгаар хүлээн авч, нэг бүрчлэн тунгааж тусгахыг хичээхийн зэрэгцээ бусад судлаачийн энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд хийгдсэн эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг бүрэн дүүрэн ашиглахыг эрмэлзсэн болно.

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
# ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ГЕОПОЛИТИКИЙН ТУХАЙ ӨНӨӨ ҮЕИЙН ОЙЛГОЛТ

## 1.1. Олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт

### 1.1.1. Дэлхий нийтийн олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт

XXI зууны эхэнд даяаршлын үйл явц эрчимтэй өрнөж, олон улсын харилцаа, олон талт хамтын ажиллагааны цар хүрээ улам бүр тэлэн өргөжиж байна. Энэ үйл явц дэлхий нийтийн шинж чанартай болж улс төр, нийгэм, эдийн засаг, цэрэг-стратегийн зэрэг бүхий л салбарыг хамарч, улс хоорондын харилцааг өөр хоорондоо нягт уялдаатай, ихээхэн түгээмэл агуулгатай болгож байна.

Дэлхийн улсууд, ялангуяа хөгжиж байгаа орон түүний давалгаанд өөрийн эрхгүй татагдан орохдоо давуу талыг нь үр өгөөжтэй ашиглах, сөрөг талыг нь даван туулж, үндэсний өвөрмөц шинж чанар, тогтвортой хөгжил, эцсийн дүндээ үндэсний аюулгүй байдлаа хадгалж үлдэх талаас нь ихээхэн анхаарах боллоо.

“Хүйтэн дайн”-ы дараах олон улсын харилцаанд , ялангуяа 2001 оны 9 дүгээр сарын 11-нд АНУ-д болсон террорист халдлагаас хойш олон улсын аюулгүй байдлын асуудалд хандах дэлхий нийтийн байр суурьт онол, үзэл санааны гэхээр томоохон өөрчлөлтүүд гарлаа. Эдүгээ улс орнууд хэдий хүчирхэг хөгжилтэй ч байлаа гэсэн аюулгүй байдлаа дангаараа хангах боломжгүй нь улам бүр ойлгомжтой болсоор байна.

Дэлхийн II дайнаас хойш бүрэлдэн тогтсон улс хоорондын цэрэг-улс төрийн харилцааны хэв шинж өөрчлөгдөж оронд нь хэн ч төсөөлж байгаагүй цоо шинэ үйл явц өрнөж эхэлсэн нь үүний угтвар нөхцөл болсон юм. Энэ үйл явц удаан хугацаагаар үргэлжлэх төлөвтэй бөгөөд өнөөдөр хэдийгээр эсрэг тэсрэг хоёр өөр тогтолцоонд хамрагдаж байсан олон улс орны харилцаа зарим талаар сайжран, түншлэлийн чанартай болж байгаа ч улс, үндэстэн хоорондын зөрчил, сөргөлдөөн шинэ өнгө аясаар даамжирсаар байгаа бөгөөд бүрмөсөн зохицуулагдах нь ирээдүй цагийн асуудал хэвээр байна.

Дэлхийн улс орнууд зэвсэглэлээр хэт хөөцөлдөж, цөмийн дайны ирмэгт тулж очоод байсан аюул тодорхой хэмжээгээр тодорхой хугацаагаар хойшлогдон,

нэг талаас хүн төрөлхтнийг хувааж байсан үзэл суртлын саад арилж, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, технологи, мэдээллийн харилцаа үндэсний болоод цэрэг-улс төрийн болон эдийн засаг-улс төрийн эвсэл холбоодын хил хязгаараар зааглагдахаа больж байгаа ч нөгөө талаас энх тайван, аюулгүй байдлын асуудлыг дэлхий нийтэд шийдвэрлэх гэсэн хүний нийгмийн хөгжлийн нэг гол хандлага зарим сорилттой тулгараад байна.

Цаг хугацааны хүчин зүйлтэй өрсөлдөн явагдаж буй дэлхий нийтийг хамарсан эдгээр өөрчлөлт янз бүрийн үүдэл шалтгаан бүхий шийдвэрлэгдээгүй олон асуудал, аюул заналыг араасаа дагуулж буй нь бас тодорхой болж байна.

Эсрэг тэсрэг хоёр тогтолцооны захиргаа, нөлөөлөлд байсан бүс нутгуудын зарим хэсэгт янз бүрийн шалтгаанаас үүдэлтэй зөрчил сөргөлдөөнүүд хадгалагдан улам бүр даамжирсаар байна. Тухайлбал: Кавказ, Балканы хойг, Төв Ази, Ойрх Дорнодод иргэний дайны хэлбэрээр дэгдсэн угсаатан, ястан, шашин шүтлэгтэн хоорондын зэвсэгт мөргөлдөөн, тэдгээрт өөрийн ашиг сонирхлоо хамгаалах гэсэн их гүрнүүдийн тэмцэл, Өмнөд болон Зүүн Өмнөд Ази, Африкийн зарим оронд болж буй цус асгаруулсан хэрэг явдлууд үүний нотолгоо болж байна.

Түүнчлэн хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, бүх төрлийн зэвсэг, тэсрэх болон мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж, хамрах орчин, хил хязгаар нь тэлж байгаагийн дотор олон улсын терроризм дэлхийн улс түмэнд бүхэлд нь нүүрлэсэн шинэ аюул занал болон хувирч байна.

Уламжлалт бус эдгээр аюул занал иргэд хувь хүмүүсийн төдийгүй, улс гүрнүүдийн аюулгүй байдалд шууд нөлөөлөх болж байгаатай холбогдон дэлхий нийтийн аюулгүй байдлыг улс орон бүрийн идэвхтэй оролцоотойгоор, тэр дотроо олон улсын зэвсэгт хүчний нэгдсэн чармайлтаар хангах асуудал улс хоорондын харилцааны нэг гол агуулга болон тавигдах боллоо.

Баруун Европт аюулгүй байдлыг хангах бие даасан өөрийн гэсэн тогтолцоог бүрдүүлэх ажил нэгэнт эхэлж, тэрчлэн эрчимтэй хөгжиж буй бусад салбар бүс нутаг, улс орнуудын бие даах эрмэлзэл улам бүр тодорхой болсоор байна.

Өрнөдийнхөн НАТО-г дорно зүгт тэлж, хуучин Дорнод Европын орнуудыг өөртөө элсүүлсний дээр Балтийн тэнгис хавийн орнуудаар эгнээгээ нэгэнт сэлбэж чадлаа. ОХУ үүний хариуд НАТО-гийн нөлөөллийн өргөжилтийг хязгаарлахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулж, үүндээ ТУХН-ийн орнууд, Төв, Зүүн, Өмнөд Азийн хүчирхэгжиж буй, түүний дотор Хятад, Энэтхэг, Пакистан зэрэг зарим улсыг хамруулах, тэдэнтэй цэрэг-ул төрийн талаар түншлэх бодлогоо сүүлийн үед идэвхжүүлж эхэллээ. Үүний нэг илэрхийлэл нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллага болж байна.

Үүний зэрэгцээ дэлхийн шинэ дэг журам тогтоох үйл ажиллагаа, аюулгүй байдал, улс хоорондын харилцааны өнөөгийн нөхцөл байдлыг удирдлага хяналтад байлгахад олон улсын нэр хүнд бүхий байгууллагууд, ялангуяа НҮБ-ын үүрэг чухлаар шаардагдах хандлагатай болж улмаар олон улс, ялангуяа бага орнууд энэ чиглэлийг гадаад бодлогодоо улам бүр эрхэмлэх болж буй цаг үед бид амьдарч байна.

### 1.1.2. Ази, Номхон далайн бүс нутгийн улс хоорондын харилцааны хандлага

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын аюулгүй байдал сүүлийн жилүүдэд харьцангуй тогтвортой шинж чанарыг агуулсаар байгаа юм. Энэ нь дэлхий нийтийг хамарсан эрс өөрчлөлт болон бүс нутагт өөрийнх нь хүрээнд болж буй үйл явдлуудын аль алиных нь үр дүн юм.

1990-ээд оны эхээр дэлхийн том гүрнүүд үзэл суртал, цэргийн хүчийг “ялалт” байгуулах гол хэрэгсэл гэж үзэх реалист үзлээсээ татгалзаж, улмаар “Хүйтэн дайн” төгсгөл болсон нь энэ бүс нутгийн олон улсын аюулгүй байдал тогтворжиход хүчтэй нөлөө үзүүлсэн билээ. Түүнчлэн бүс нутгийн улс хоорондын найрсаг харилцаа, итгэлцэлд тулгуурласан, улам бүр өргөжиж буй эдийн засгийн хамтын ажиллагаа нь энэхүү тогтвортой байдлыг хангах нэг гол хүчин зүйл болж байна.

Ази, Номхон далайн бүс нутгийг зааглан хувааж байсан хоёр тогтолцооны сөргөлдөөн үгүй болсны дээр Орос-Хятадын харилцаа үндсэндээ бүрэн хэвийн болж, стратегийн түншлэл тогтоож, тэд өөрсдийн дотоод байдлыг тогтвортой болгох, эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд голлон анхаарах болсон нь бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлж байна.

Үндэстэн дамжсан томоохон эвслүүд бий болж АСЕАН, АПЕК, НАФТА, ПЕКК, ШХАБ зэрэг олон улсын байгууллагуудын нэр нөлөө, байр суурь дэлхийн үйл хэрэгт улам бүр жинтэй болсоор байна. Иймээс ойрын ирээдүйд Номхон далайн баруун, зүүн эргийн улс үндэстнүүд дэлхийн хөгжлийн нэг гол хөтлөгч хүчин зүйл байх болно гэдэг нь тодорхой боллоо.

Үүний зэрэгцээ Европын нийтлэг эрх ашгийг хамгаалах мэт ойлголт Ази, Номхон далайн бүс нутагт өнөө хэр бий болоогүй байна. Энэ бүс нутгийг хэд хэдэн салбар бүс нутаг болгон зааглан үзэж болох бөгөөд одоогоор тэдгээрийн дотор ойртон нягтрах, түүний дотор хамтын аюулгүй байдлын нийтлэг зүйлийг бий болгох чармайлт ид явагдаж байна.

Энэ хүрээнд Хятадын эдийн засгийн эрчимтэй өсөлт нь анхаарч үзэх нэг хүчин зүйл болж байна. АНУ, ОХУ-ын улс төр, эдийн засгийн нөлөө Азид зарим талаар суларч түүний оронд эдийн засгийн тогтвортой, эрчимтэй хөгжилд тулгуурласан Хятад улсын оролцоо өсөж байгаа нь сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Энэ нь ЗХУ задран тарснаар болон лалын ертөнц бүхэлдээ АНУ-ын эсрэг байр суурьтай байгаагаар нөхцөлдөх бөгөөд үүнээс үүдэн Ази, Номхон далайн бүс нутагт өөртөө ашигтай эдийн засаг, цэрэг-улс төрийн байр суурь эзлэх бололцоо Хятадад бий болох талтай юм.

Улс хоорондын харилцааны хувьд Ази, Номхон далайн бүс нутагт Европт бий болсон шиг ардчилсан орнуудын эвсэл, аюулгүй байдлын нэгдмэл тогтолцоо бүрэлдэн тогтох үйл явц харьцангуй удаан хугацааг шаардах бололтой. Гэвч терроризмын эсрэг олон улсын хамтын ажиллагааг бий болгоход чиглэсэн нийтлэг зарчим давамгайлсан улс үндэстний цэрэг-улс төрийн харилцаа бий болох эхлэл ажиглагдаж байна. Харин энэ харилцаанд лалын зарим улс орон төдийлөн хамрагдахгүй нь ойлгогдож байгаа бөгөөд тэд нийгмийн болон хувь хүний амьдралын бүх хэв шинжийг хатуу чанд зохицуулахад тулгуурласан төр, нийгмийн байгуулалтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ үүнийгээ олон улсын чанартай болгохыг эрмэлзэх нь илэрхий болж байна.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй, улс хоорондын харилцааны талаасаа шийдвэрлэгдээгүй асуудлууд ч бас хадгалагдсаар байна.

Энэ бүс нутгийн нэлээд олон улс орны зэвсэгт хүчнүүд харьцангуй олон хүнтэй бөгөөд тэдний зэвсэглэл, тоо хэмжээнд хяналт тавих буюу хязгаарлах, үнэлэх олон улсын бодитой механизм одоогоор бий болоогүй байна.

Хуучин ЗХУ задран тарсан боловч түүний эзэлж байсан цэрэг-улс төрийн орон зай өөрчлөгдөх үйл явц дуусаагүй байна. ОХУ-ын гадаад бодлогын нэг чухал чиглэл нь Ази, Номхон далайн бүс нутагт, ялангуяа ТУХН-ийн хүрээнд нөлөөгөө хадгалах явдал болж байна. Гэтэл ТУХН-ийн улсуудын зургаа нь Ази тивд оршиж, дэлхийн тэргүүлэх бусад гүрнүүд, тухайлбал АНУ болон бүс нутгийн хүчирхэгжиж буй лалын ертөнцтэй харьцаж, зарим тохиолдолд шашны болон үндэстний хэт даврах байр сууринаас, эсвэл түүний эсрэг тэмцэх зорилгоор эвсэн нэгдэх, бие даахыг эрмэлзэх нь нэмэгдсээр байна. Өрнөд-Дорнодын сөргөлдөөн үгүй болсон нь эдгээр улс орнуудын дотор нуугдмал шинжтэй байсан орон нутгийн зөрчил, үндэстэн ястан, шашин шүтлэг, нутаг дэвсгэрийн маргаан илрэн хурцдах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Энэ нь Кавказ, Төв Ази, Ойрх Дорнодод бусдаас илүүтэй мэдрэгдэж байна.

Цөмийн заналхийлэл Ази, Номхон далайн бүс нутагт бодитой хадгалагдсаар байгаа бөгөөд цөмийн зэвсэг тархах, улмаар дарангуйллын буюу дангаар захирах дэглэмтэй улс орнууд өөрсдийн явцуу эрх ашгаа хамгаалахын тулд түүнийг хэрэглэж болзошгүй магадлал ч ажиглагдаж байна. АНУ, ОХУ хоёр цөмийн зэвсгээр түрий барихаа багасгаж, Хятад улс цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнд нэгдсэн нь түүнд тавих хяналтыг сайжруулах эерэг талтай боловч цөмийн зэвсгийг өөр бусад орон эзэмших, мөн тархаж болзошгүй асуудал санаа зовоох боллоо. Умард Солонгос, Ираны цөмийн хөтөлбөр сэрдлэг төрүүлж, Энэтхэг, Пакистан хоёр бие биеэсээ цөмийн зэвсгээр давамгайлахаар өрсөлдөж буй нь тогтворгүй байдлын шинэ эх сурвалж болж байна.

Хурц, хувьсмал харилцаа бүхий хоёр Солонгос, Хятад-Тайван, Энэтхэг-Пакистан, Хятад-Энэтхэг хоорондын харилцааны зөрчилдөөнтэй асуудлууд, Курилийн арлууд, Энэтхэг-Хятадын хойг хийгээд Зүүн Азийн эрэг хавийн хэсэг арлуудын талаарх маргаан, тэрчлэн Ойрх Дорнодод хэд хэдэн орны нутаг дэвсгэрийг хамарсан зэвсэгт мөргөлдөөн үргэлжилж, олон улсын терроризм, улс үндэстэн дамжсан мансууруулах бодисын зөөвөр, шашны ба үндэстний хэт даврах үйл ажиллагаа улам бүр Ази тивд төвлөрөх болсон зэрэг нь энэ бүс нутгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх голомтууд болж байна.

### 1.1.3. Бүс нутгийн аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудал

Хэдийгээр дээр дурдсан шийдвэрлэгдээгүй асуудлууд байгаа боловч Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын аюулгүй байдал ноцтой хүндрэх, томоохон зөрчил сөргөлдөөн үүсэх магадлал бага байна. “Хүйтэн дайн” Азийн өргөн уудам нутагт Европынх шиг тэгтлээ хүчтэй нөлөөлөөгүй, улс үндэстнүүдийн хооронд гүн гүнзгий, урт удаан хугацаагаар үргэлжлэх үзэл суртлын ан цав үүсгэж чадаагүй билээ. Энэ утгаараа дэлхийн хоёр том туйлын нэг алга боллоо гээд энэ бүс нутгийн аюулгүй байдлын орчинд хүчний тэнцвэр алдагдахад хүргэсэн ноцтой өөрчлөлт ажиглагдаагүй болно.

Ази, Номхон далайн бүс нутагт цэргийн хүчний харьцааны эрс өөрчлөлт гараагүй, Өмнөд Солонгос, Япон, Афганистан, Ирак, Сирийг эс тооцвол Азид бусад орны зэвсэгт хүчний оролцоо одоогоор төдийлөн шаардагдахгүй байна. Ази тив нь зэвсэглэлээр хэт хөөцөлдөх болон цөмийн зэвсгийн өрсөлдөөнд бусдаас харьцангуй бага нэрвэгдсэн юм. Солонгосын дайн, Вьетнам, Афганистан, Ирак, Сирид болсон хэрэг явдлууд бүгд гадны оролцоотойгоор үүсэж өрнөсөн бөгөөд Дэлхийн II дайнаас хойш азичууд өөр хоорондоо тэгтлээ дайтаж байлдаагүй болно.

Гэхдээ энэ нь Ази, Номхон далайн бүс нутагт улс хоорондын харилцааны тогтвортой байдлыг хангах асуудал чухал болохыг үгүйсгэсэн хэрэг биш юм. Хельсинкийн төгсгөлийн баримт бичиг /1975 он/, эсвэл Парисын тунхаглал /1990 он/ шиг улс хоорондын маргаантай асуудлыг улс төрийн аргаар зохицуулах механизм бий болгох гэж энэ бүс нутгийн улс орнууд удаа дараа санал, санаачилга гаргаж байгаа нь үүний илэрхийлэл болно.

Европт хэрэглэсэн түншлэл дээр тулгуурласан аюулгүй байдлын хамтын тогтолцоог бий болгох ерөнхий зарчмууд Ази, Номхон далайн бүс нутагт ач холбогдолтой юм. Гэхдээ энэ бүс нутгийн онцлогийг тооцох нь зайлшгүй зүйл болно.

Ази, Номхон далайн бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын асуудлыг зохицуулах үйл ажиллагаа нь зэвсэгт мөргөлдөөн үүсэж болзошгүй районуудад сөргөлдөгч талуудын үйл ажиллагааг хянах, бүс нутгийн хүрээнд цөмийн болон химийн зэвсгийг хязгаарлах буюу тэдгээрээс чөлөөтэй бүсүүдийг бий болгох, харилцан тохиролцох үндсэн дээр улс орнуудын цэрэг, зэвсгийн тоо хэмжээг

хорогдуулах, цэргийн үйл ажиллагаа, түүний дотор томоохон хээрийн сургууль, маневр явуулах асуудлыг ил тод болгох, зэвсэглэлийн тоо хэмжээг харилцан хязгаарлах, зэвсэгт хүчнүүдээ зөвхөн өөрийгөө хамгаалах, энхийг сахиулах, терроризмтой тэмцэх болон хүмүүнлэгийн үүрэг биелүүлэх бүтцэд аажмаар шилжүүлэх, цэргийн томоохон бүлэглэлүүдийн байршлыг улсын хилээс холдуулах, цэргийн бодлого, цэргийн номлолоо ил тод болгож, бие биедээ харилцан мэдээлэх замаар цэргийн итгэлцлийг бэхжүүлэх зэрэг хэлбэрээр хэрэгжих боломжтой юм.

Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар гэрээ хэлэлцээр байгуулж, маргаантай асуудлуудыг эвийн аргаар шийдвэрлэж байх улс хоорондын механизмыг бүрдүүлэх нь чухал болж байна. Ингэхдээ голлох улс орнуудын оролцоотойгоор зөрчил маргалдааныг улс төрийн аргаар зохицуулах үүрэг бүхий салбар бүс нутгийн байгууллагуудыг бий болгох нь улс хоорондын харилцааны тогтвортой байдлыг хангах, итгэлцлийг нэмэгдүүлэх үндсэн арга байж болох юм.

Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлыг хангахад улс хоорондын цэргийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх явдал ихээхэн чухал байна. Энэ нь аль нэг салбар бүс нутаг, улс орны зэвсэгт хүчнийг хэт бэхжүүлэх эсвэл бүр хорогдуулахыг хязгаарлах, тэнцвэрт байдлыг алдагдуулахаар огцом өөрчлөлт гаргахгүй байх нэгдсэн бодлогоор хэрэгжиж болох юм. Ер нь энэ бүс нутагт цэрэг, зэвсгээр хөөцөлдөх явдал одоогоор олон улсын гэрээ хэлэлцээний хүрээний гадна ямар нэгэн хязгаарлалт, хяналтгүйгээр явагдаж байгаа нь үнэн болно..

Хоёр том туйлт сөргөлдөөн үндсэндээ төгсгөл болсонтой уялдан Ази, Номхон далайн эрэг хавийн бүс нутагт АНУ-ын цэргийн оролцоо багассаар, үүнтэй холбоотойгоор, мөн эдийн засгийн бололцоо нь хязгаарлагдмал байгаагийн улмаас ОХУ-ын Зэвсэгт хүчний хөгжилд саад бэрхшээл учирсаар байхад шинээр хөгжиж буй зарим орон, түүний дотор БНХАУ зэвсэгт хүчнийхээ хүчин чадлыг нэмэгдүүлэх тууштай бодлогоо амжилттай хэрэгжүүлсээр байна.

Сүүлийн жилүүдэд Ази, Номхон далайн бүс нутагт зэвсэг экспортлох, импортлох, зөөвөрлөх цар хэмжээ байнга өсөх боллоо. Бүс нутагт олон улсын харилцаа Европтой харьцуулахад нэгдмэл бус байгаа нөхцөлд зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлах асуудал амар хэрэгжих боломжгүй юм. Ер нь том гүрнүүд, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудаас энэ бүс нутагт шинэ зэвсэг,

цэргийн технологи нэвтрүүлэхийг хязгаарлах нэгдсэн бодлого явуулах нь хойшлуулшгүй зорилт болж байна. Зэвсэг үйлдвэрлэгч зарим орнуудын экспортыг хязгаарлах хүртэл арга хэмжээ авч болох юм. Япон болон Европын хамтын нийгэмлэгийн санаачилгаар 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар баталсан "Зэвсэглэл нийлүүлэлтийн ил тод байдлыг дээшлүүлэх, ердийн зэвсгийн нийлүүлэлтийг бүртгэх арга хэмжээний тухай" тогтоолыг хэрэгжүүлэх нь энд нэн чухал байх болно.

### 1.1.4. Олон улсын нөхцөл байдлын цаашдын төлөв

Олон улсын аюулгүй байдлыг хангахын тулд өнөөдөр мэдрэгдэж байгаа зүйлүүдэд үндэслэлтэй дүгнэлт хийх, ойрын ирээдүйд үүсэж болох нөхцөл байдлыг аль болох бодитойгоор төсөөлөн хооронд нь харьцуулж үзэх нь чухал бөгөөд ер нь иймэрхүү харьцуулалтыг үе үе хийж байх нь ойрын ирээдүйд гарч болох өөрчлөлтийг тухай бүрд нь тодорхойлох бололцоог олгох ач холбогдолтой байдаг. Эдгээрийн дотроос сүүлийн жилүүдэд бий болоод байгаа дараах хүчин зүйлс анхаарал татаж байгаа юм. Үүнд:

1. Юуны өмнө ойрын ирээдүйд улс орнуудын улс төр, эдийн засаг, нийгэм, түүний дотор техник, технологи, цэрэг-стратеги, байгаль орчныг хамгаалах болон соёлын хүрээнд гарах өөрчлөлт өмнөх жилүүдтэй харьцуулбал маш өндөр хурдацтай, хамгийн гол нь улам бүр харилцан хамааралтай, маш нягт уялдаатайгаар өрнөх нь тодорхой байна.

2. Үндэстэн улсууд хоорондын харилцаанд цоо шинэ хандлагууд бий болж Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын Холбоо, Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сангаас эхлээд АСЕАН, АПЕК гэх мэтийн улс хоорондын олон талт харилцааг зохицуулах зорилго бүхий байгууллагуудын үүрэг чухлаар шаардагдах төлөвтэй байна. Энэ нь бага буурай орны хувьд төр, засгийн бие даасан үйл ажиллагаа тодорхой хүрээнд хязгаарлагдахад хүргэх, өөрөөр хэлбэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудлаа олон улсын харилцааны хэм хэмжээ болон дээрх байгууллагуудын "дохио, зангаа"-тай уялдуулан шийдвэрлэж байх гарцаагүй шаардлагыг үүсгэж болох юм.

3. Үндэстэн дамнасан корпорациуд, олон улсын байгууллагууд болон гадны дэмжлэг бүхий янз бүрийн зорилготой иргэний хөдөлгөөн, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжиж үндэсний засгийн газруудад хүчтэй

нөлөөлөхийг оролдох, зарим тохиолдолд зөрчилдөөн, тэмцэлдээн, бослого, үймээн үүсгэх явдал газар авах хандлагатай байна. Эдгээрийн жишээ нь хэд хэдэн оронд гарсан “өнгөт” хувьсгал, арабын орнуудад болж буй үйл явдлууд юм.

4. Үүний зэрэгцээ хүмүүс өөрсдийгөө үндэстэн ¬улсын иргэн гэж үзэх нь ойрын ирээдүйд давамгайлсан хэвээр байх нь бас тодорхой байна. Ялангуяа ийм байдал Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудад, түүний дотор Зүүн Хойд Азид нэлээд удаан хугацаагаар хадгалагдах бололтой.

5. Мэдээллийн технологи урьд үзэгдээгүйгээр хөгжиж аль ч улс оронд хэрэгтэй мэдээллээ хамгийн хямд өртгөөр, хамгийн хурдан авах боломжийг бий болгох бөгөөд энэ нь том бага гэлтгүй бүх улс орон хоорондын улс төр, эдийн засаг, соёл урлагийн гээд бүхий л харилцааны уялдаа холбоог нэмэгдүүлэн нээлттэй байдлыг гүнзгийрүүлж, улмаар хүний нийгмийн нарийн нандинд тооцогддог зүйлсийг танигдашгүйгээр өөрчилж болзошгүй нь улам бүр тодорхой болсоор байна.

6. Шинэ материал, биотехнологи, нанотехнологи, генийн инженерчлэл зэрэг нь ойрын ирээдүйд хөгжлийнхөө шинэ түвшинд гарах бөгөөд энэ нь улс орнуудын үйлдвэрлэл, ахуй хөтлөх арга ухааныг болон хүний амьдралын хэв загвар, эрхэмлэж ирсэн үнэт зүйлсийн тогтолцоог үндсээр нь өөрчилж болзошгүй байна.

7. Олон улсын харилцаа, олон улсын эрх зүйн хүрээнд батлан хамгаалах гэдэг нэр томьёо улам бүр өөр агуулгыг илэрхийлэх болж үүнтэй уялдаатайгаар аливаа улсад учирч болзошгүй дайны аюул заналхийлэл, үндэсний зэвсэгт хүчин, түүний үүрэг зориулалтын тухай ойлголт ч эрс өөрчлөгдөж байна.

8. Хүний амьдрах орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, нэн халдварт өвчний тархалт, ядуурал, цагаачлал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд, материал хулгайлах, дамжуулан худалдаалах оролдлого гэх мэт уламжлалт бус аюулын хүрээ өргөжиж, хамрах орчин, хил хязгаар нь тэлж, байгаагийн дотор олон улсын терроризм дэлхийн улс түмэнд бүхэлд нь нүүрлэсэн шинэ аюул занал болон хувирч байна. Эдгээр уламжлалт бус аюул заналхийлэл нь иргэд хувь хүмүүсийн төдийгүй, улс гүрнүүдийн оршин тогтнохын аюулгүй байдалд шууд нөлөөлөх болж байгаатай холбогдон дэлхий нийтийн аюулгүй байдлыг улс орон бүрийн идэвхтэй хамтын ажиллагаагаар, тэр дотроо олон улсын

зэвсэгт хүчний нэгдсэн чармайлтаар хангах асуудал улс хоорондын харилцааны нэг гол зангилаа асуудал болон тавигдах боллоо.

Эдгээрээс харахад олон улсын харилцааны орон зайн асар хурдацтай өөрчлөлт дэлхий ертөнцийг ойрын ирээдүйд хүлээж байна. Мэдээж энэ өөрчлөлт улс орон бүрд харилцан адилгүй нөлөөлөх боловч юуны өмнө бага улсуудын үндэсний аюулгүй байдалдаа хандах байр суурьд шинэчлэлийн гэж хэлж болох тодотгол хийх шаардлагыг үүсгэж болох нь улам бүр ойлгогдсоор байна. Орчин үед аливаа нэг улс нөгөөгийнхөө тусгаар тогтнолд цэргийн хүчээр шууд заналхийлэх аюул ихээхэн багассанаар хүн төрөлхтөнд тайвшрах бололцоо гарч ирж байгаа мэт боловч улс болгоны үндэсний ашиг сонирхолд харшлах, аюулгүй байдлыг нь хэврэгшүүлэхэд хүргэж болзошгүй олон шинэ үйл явдал, хүчин зүйлс бий болж байгаа нөхцөлд бид амьдарч байна.

### 1.2. Геополитикийн тухай өнөө үеийн ойлголт

#### 1.2.1. Геополитикийн үндсэн асуудал, судлах зүйл

**Геополитикийн түүхээс.** Геополитик (газар зүйн улс төр; эртний грекээр γῆ - газар, πολιτική, төрийн буюу нийгмийн ажил хэрэг) гэдэг нь аль нэг хүчирхэг улс гүрэн, эсхүл, холбоотнууд тодорхой бүс нутаг, улс орнуудын газар нутгийг газрын гадаргуу хийгээд гүнд байх бүх нөөцийн хамт хянах, өөрсдийн нөлөөллийн хүрээг хүчний төвүүдэд буюу нөлөөллийн бүсүүдэд хуваарилан захирах зүй тогтлын тухай үзэл баримтлал юм .

Геополитик нь цогцоороо тусгай шинжлэх ухаан бөгөөд өөрийн зарчим, аргазүйд суурилдаг. Гэхдээ геополитик, олон улсын харилцаа судлал хоёулаа олон улсын тавцанд өрнөж буй үйл явцыг судалдгаараа нийтлэг асуудал олонтой. Геополитикийн шинжлэх ухаан бусад шинжлэх ухааны нэгэн адил XX зууны эхэн үед улс төр, нийгэм-газар зүйн шинжлэх ухааны нэг төрөл болон бий болсон байна. Түүнийг Германы Ратцель, Шведийн Челлен, ялангуяа, английн сэр Макиндер нарын эрдэмтдийн бүтээлд үндэслэсэн гэж үздэг аж.

Геополитикийн шинжлэх ухааны анхны тодорхойлолтыг Шведийн эрдэмтэн Рудольф Челлен өгсөн байна. Түүнийхээр бол геополитик нь “үндэстэн улс, орон зай хоорондын харилцааг судалдаг шинжлэх ухаан” юм. Харин Х.Макиндер “геополитик бол өөрийн зорилго, бүтэц шаарддаг, ерөнхийллийн шинэ түвшинд

хүрч, шинэ солбицлын тогтолцоо бий болгож улс төрийн шинжлэх ухаан, цэргийн стратеги, эдийн засгийн газар зүй, социологи, соёл иргэншлийн шинжилгээ судалгааны огтлолцол дээр байдаг цогцоор бие даасан шинжлэх ухаан гэжээ. Харин оросын судлаач Александр Дугин "геополитик бол эрх мэдлийн тухай танин мэдэхүй, эрх мэдлийн шинжлэх ухаан бөгөөд тэдгээр нь эрх мэдэлд зориулагдана" гэжээ. Геополитик судлаачид энэхүү тодорхойлолтод суурилж шинжилгээ судалгаа явуулж, ном зохиол туурвих нь олонтоо байна. Бид ч энэхүү тодорхойлолтыг баримталж байна. Их британийн философич, логикч Б.Рассел "эрх мэдэл бол хүмүүний эцсийн зорилго бөгөөд аль ч нийгмийн хөгжлийн цорын ганц бүрдүүлэгч нь болдог" хэмээжээ. Тэгэхлээр, геополитик бол аль нэг гүрэн орон зайд эрх мэдэл тогтоох, тодорхой хяналтдаа авах тухай асуудлыг авч үздэг гэсэн үг юм

Геополитикийн шинжлэх ухаан нь түүний хоёрдмол шинж (дуализм), түүнчлэн арга зүй, нэр томьёо, онолынх нь хосолмол чанараас үүдэн академик салбаруудын дунд өөрийн гэсэн байр сууриа олж чадалгүй удсан бөгөөд шинжлэх ухааны салбаруудын дунд өөрийн гэсэн байраа эзлэх хугацаа нь бараг зуун жилээр удааширсан юм. Орчин үед уг шинжлэх ухаан уламжлалт, шинэ (гео эдийн засаг), нэн шинэ геополитик (гео философи) гэж дэд салбартай болоод байна.

Уламжлалт геополитик нь улс орны цэрэг-улс төрийн хүчин чадал, бусдын нутгийг эзлэн түрэмгийлэхэд газар зүйн хүчин зүйлийн давамгай үүрэгт гол анхаарлаа хандуулдаг бөгөөд германы эрдэмтэн Хаусхоферийн тодорхойлсноор улс орны "газар зүйн ухаан" нь болж байв . Гео эдийн засаг нь улс орны эдийн засгийн хүчин чадалд анхаардгаараа уламжлалт геополитикоос ялгаатай. Нэн шинэ геополитикт цэргийн болон эдийн засгийн хүчин чадлаас оюун санааны хүч илүүтэй гэж үздэг бөгөөд олон улсын харилцаанд улс орны зан үйлдлийг тодорхойлогч суурь хүчин зүйлүүдийг өргөжүүлснээр газар зүй ба эдийн засгийн уламжлалт тэргүүлэх ач холбогдлыг бууруулахад хүргэж болох хандлагатай байгаа юм.

Орчин үеийн геополитикийн онолын хувьд улс оронд байгаа технологийн боломжийг тооцон орон зайд хяналт тавих улс төр, цэрэг, эдийн засаг, иргэншил, харилцаа холбоо, хүн ам зүй, мэдээллийн гэх мэт хэлбэрүүдийг судлах явдал чухал ач холбогдолтой болсоор байна. Үүнээс үүдэн дэлхийн улс төрд болж буй геополитикийн дараах үүдэл сэдэл бүхий үйл явцын үндсэн чиглэлүүд өрнөх төлөвтэй байна:

1. Дэлхий нийтийн түгээмэл зүй тогтол, нэг цул байдал, хил хязгаарын нээлттэй байдалд тулгуурласан даяаршлын үйл явц;

2. Улам бүр хүчээ авч буй даяаршлын эсрэг хөдөлгөөн;

3. Нэг, хоёр том гүрэн бус, харин нэлээд тооны хүчирхэг улс нөлөөгөө тогтоосон олон туйлт дэлхий ертөнц бүрэлдэн тогтох үйл явц үргэлжлэх төлөвтэй байна.

**Геополитикийн судлах зүйл.** Хамгийн ерөнхий бөгөөд ихэнх геополитикчдын хүлээн зөвшөөрдгөөр нэг талаасаа Хуурай газар буюу “номос” (номос – улс гүрэн, орон зайн харилцааны онцгой цогцолбор) -ыг авч үзвэл хуурай газар, Еврази буюу “газрын хүйс” (газарзүйн төв тэнхлэг), оюун санааны тэргүүлэгч ёс, соёл иргэншил, нөгөө талаас Тэнгисийн их гүрэн, атлантын англи-саксон ертөнц буюу худалдаа арилжааны ертөнц, бас хуурай газраас гадна орших “гадаад буюу арлын хагас дугариг ертөнц” хоорондын харилцааны түүхэн бөгөөд суурь хоёрдмол үзэл санаа (дуализм) оршиж байна. Үүнийг геополитикийн суурь хууль гэж үздэг ажээ. Энэхүү хоёрдмол үзэл санааны үүсгэл үнэнээс гадуурх бүх онол дүгнэлт геополитикт утга учраа алддаг гэж үздэг байна. Тийм учраас Еврази бол оюун санааны тэргүүлэгч ёс, соёл иргэншлийн оршин тогтнох орон зай бөгөөд дэлхийн зүрхэн тольт (heartland), баялгийн гол төв юм.

Энэ газар нутагт оюун санааны тэргүүлэгч ёс, соёл иргэншилт хүмүүс нийгэмшиж суудаг билээ. Савицкийн үзэж буйгаар Евразийн улс гүрэн дээрээсээ доошоо хүртэл жинхэнэ оюун санааны түлхцэд суурилан байгуулагддаг ёстой аж. Үүнээс үүдээд түүний бүтэц таамнал үзэл санаанд нийцэж байгуулагдах ёстой аж. Энэ бол оюун санаа тэргүүлэгч үзэлтний гол баримтлал юм. Ийнхүү Еврази бол эд баялгийн уурхай, оюун санааны ундарга, аж үйлдвэрлэлийн цогцолбор юм. Иймээс Евразийг эрхшээсэн нь хуурай газрын агуу их хүчийг олж авдаг байна. Хуурай газрын агуу их хүч нь орон зайн хатуу байршил, түүний мөн чанарын чиг хандлага, тодорхойлолтын тогтворт чанартай холбоотой юм. Хүчирхэг гүрэн Евразийг хянаснаар дэлхийн бүх баялгийг хянах чадвартай болох ажээ.

Харин түүний эсрэг далайн сүр хүчийг олж авах нь өмнөхийг эсрэг чанар бүхий худалдааны иргэншлийг бий болгожээ. Энэ төрлийн иргэншил хүчлэг, хөдөлгөөнтэй, техникийн хөгжилд чиглэсэн хандлагатай байна. Түүний тэргүүлэх чиглэл нь далай тэнгисээр нүүдэллэх (хөвөх), худалдаа арилжаа хийх, бодгалийн

овсгоотой зангийн урам зориг байдаг. Бодгаль эрхэм дээд үнэт зүйл байдаг. Үүнтэй зэрэгцээд ёс зүй, хууль эрхийг хэм хэмжээ бүдгэрч харьцангуй бөгөөд хөдөлгөөнтэй болдог байна. Далай тэнгисийн хүчирхэг гүрэн болж түүнийг хяналтдаа авснаар дэлхийн худалдааг хянах боломжтой болдог ажээ.

Эх газрын болон тэнгис хоёрын геополитикийн үндсэн зарчмыг тодорхойлсны дараах хамгийн чухал зарчим бол “эрэг орчмын бүс” юм. Эрэг орчмын бүс нь эх газар болон далай, тэнгисийн аль алиных нь нэг хэсэг байж чадах далд боломжийг агуулдаг байна. Энэ бол хамгийн нарийн нийлмэл, утга төгөлдөр соёлтой бүс нутаг юм. Эрэг орчмын бүс нэг талаасаа “арал”, тэнгисийн хөлөг болдог бол харин нөгөө талаасаа Эзэнт гүрэн, Орон гэр болж хувирдаг байна. Эрэг орчмын бүс өөрийнхөө байршлаар заяагдсан газарзүйн асуудалд хариу өгөх шаардлагатай тулгардаг. Эрэг орчмын бүс нь хилийн бүс, бүслүүр, зурвас болдог. Гэхдээ геополитикийн хил хязгаар нь улс хоорондын хил хязгаараас ялгаатай. Далайн хүчирхэг гүрэн эрэг орчмын бүс нутагт ноёрхлоо тогтоож чадсанаар эх газар, түүний дотор Евразийг хаан боогдуулж эрхшээлдээ авч болно гэж үздэг байна.

Геополитикийн судалгааны үндсэн объект бол газар нутаг, нутаг дэвсгэрийн болон түүн дээр орших хүний болон бусад төрлийн бүх нөөцийн олон тооны загвараар илэрхийлэгдсэн дэлхий ертөнцийн орон зайн бүтэц юм. Газар нутаг, нутаг дэвсгэрийг хянах механизм болон хэлбэрийг судлах нь геополитикийн үндсэн зорилтын нэг мөн. Геополитикийн түүхэн цөм бол газар зүй бөгөөд үүндээ тулгуурлан газар нутаг, нутаг дэвсгэр ба дэлхийн хүчний тэнцвэрийн буюу өрсөлдөөн эсвэл хамтын ажиллагааны шинж байдлын хоорондох шууд болон эргэх холбоог судлах явдлыг чухалчилдаг.

Геополитикийн арга зүйн цөм бол дэлхий нийтийн түвшин дэх “том загварчлал”. Гэхдээ шинжлэх ухааны энэхүү салбарт бүс нутаг ба орон нутгийн гэсэн бүлгүүд багтдаг. Жишээлбэл хил хязгаарын судалгаа, нутаг дэвсгэрийн байгалийн баялгийн болон улс хоорондын газар нутгийн маргаан, зөрчилдөөний асуудал гэх мэт. Ингэхдээ, бүс нутгийн болон орон нутгийн асуудлуудыг зөвхөн арга зүйн дээр дурдсан цөмийн хүрээнд буюу өөрөөр хэлбэл, нийтлэгээс хэсэгчилсэн рүү хандах зарчмаар судалдаг болно.

Оросын нэрт геополитикч А.Дугин хэлэхдээ: “Марксизм болон либерализм нь хүн төрөлхтний оршин тогтнохын эдийн засгийн талыг үндэс болгодог… Тэгвэл геополитик нь “газрын гадаргуу бол хувь тавилан” гэсэн ойлголт дээр суурилдгаараа “эдийн засгийн үзэл суртлаас” ялгаатай юм гэжээ. Тэр бээр мөн Геополитикт газар зүй ба газар нутаг, нутаг дэвсгэр, нөөц гэсэн ухагдахуунууд нь марксизм болон либерализмын хувьд мөнгө, үйлдвэрлэлийн харилцаа гэсэн ухагдахуунтай ижил үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хүн төрөлхтний оршин тогтнохын суурь асуудал, өнгөрснийг тайлбарлах үндсэн арга, ахуй амьдралын гол хүчин зүйлд тооцогддог бөгөөд оршин тогтнохын бусад бүх тал эдгээрийг тойрч эргэлдэн, эдгээрээс хамааралтай байдаг гэсэн байна.

Үүнээс гадна “геополитик гэдэг нь “дэлхий хэмээх шатрын хөлөг” дээрх байрлалын төлөөх тоглоомын онол мөн” гэж америкийн тэргүүлэгч геополитикчдийн нэг Збигнев Бжезинский тэмдэглэсэн байдаг .

Еврази бол дэлхийн хамгийн том тив, эзэнт гүрнүүдийн, ялангуяа, АНУ-ын геополитикийн гол тэнхлэг юм. Евразийг хяналтдаа авсан хүчирхэг гүрэн дэлхийн хамгийг тэргүүний бөгөөд бүтээмж сайтай гурван тивийн хоёрыг нь эрхшээлдээ оруулна гэсэн үг. Евразийг хянаснаар Африк тивийг бараг автоматаар эрхшээн захирах ба дэлхийн бөмбөрцгийн баруун хагас, далай тэнгисийн орнууд энэ гол тивийн зах хязгаар нутаг болно.

Евразид дэлхийн хүн амын 75 хувь нь оршин суух ба түүний бодит баялгийн дийлэнх нь газар дээрх үйлдвэр завод, газрын хөрсөн доорх баялаг хэлбэрээр оршиж байна. Евразид дэлхийн ДНБ-ний 60 хувийг үйлдвэрлэдгийн дээр дэлхийн эрчим хүчний мэдэгдэж байгаа нөөцийн дөрөвний гурав нь энд төвлөрдөг.

Еврази бас дэлхийн улс төрийн хувьд өөртөө хамгийн итгэлтэй, хөдлөл хөгжил сайтай орнуудын өлгий юм. Энд АНУ-ын дараа ордог зургаан томоохон эдийн засагтай орон, мөн тийм хэмжээний цэргийн зардалтай улс байрлаж байна. Дэлхийн цөмийн зэвсэгтэй нь илэрхий орнуудын нэгээс бусад, тийм нууц зэвсэгтэй бүх орон Евроазид оршиж байна. Дэлхийн хамгийн олон хүн амтай хоёр орон бүс нутагт ноёлж, даян дэлхийд нөлөөлөхийг хичээж байна.

Америкийн геополитикч З.Бзжинский Евразийг дөрвөн бүс болгон авч үзжээ. Үүний хамгийн гол, томоохон хэсэг нь Дундад орон зай (ойролцоогоор хуучин ЗХУ), тэгээд баруун, өмнөд, зүүн хэсгийн орон зай хэмээн задарч байна. Эндээс

Евразийн баруун хэсэг буюу Европ бол АНУ-ын хувьд цэргийн холбоотон, нэг эрхэмлэл, шашин шүтлэгтэй, хоёулаа ардчилсан улс төрийн бодлого баримталдаг, дийлэнх америк хүний жинхэнэ төрсөн нутаг болдог учраас түүний жам ёсны холбоотон юм.

Харин ОХУ-ын хувьд Европ бол эдийн засгийн харилцааны гол түнш, технологийн гол сурвалж, шинэ эзэнт гүрний үүсгэл болох далд чадвараас нь үүдэн Европ-Америкийн холбооноос сэргийлэх, Берлин-Москвагийн геостратегийн тэнхлэг бий болгох стратегийнх нь түшиц газар болдог аж. Харин дундад орон зай (ОХУ) Европ буюу Евразийн баруун хушууны орнуудын байгалийн баялгийн шавхагдашгүй эх булаг, ундарга нь юм.




**Зураг 1.** Евразийн геополитикийн хил хязгаар (Збигниев Бзжинский, The Grand Cheesboard)

АНУ-ын геополитикч Мэйнигийхаар бол Хятад, Монгол, Афганистан зэрэг орнууд Евразийн “эрэг орчмын нутаг”-т багтдаг аж. Харин орчин үеийн геополитикч нар Киргиз, Казахстан, Монголыг ОХУ-Хятад хоорондын орон зай дахь “эрэг орчим”-ын бүс буюу римланд (rimland) хэмээн үзэж байна.

Орчин үеийн Евразийн геополитикийн талаар олон улсын харилцаа судлаачид эрдэм шинжилгээний арвин өв бүтээсэн байдаг, энэ ажил эдүгээ улам бүр эрчимжин арвижиж байна. Геополитикийг “үндэслэгч эцгүүдээс” эхлээд

хорьдугаар зууны хоёрдугаар хагасын агуу “геостратегич-практикуудаар” /Х.Киссинжер, З.Бзежински г.м/ буухиалан, эдүгээгийн Ж.Фридман, Оросын А.Дугин, К.Гаджиев гээд бүгд Евразид онцгой ач холбогдол өгч ирсэн, өгч байгаа нь үнэн бөлгөө. XX зууны эцэс, XXI зууны эхэн үеийн дэлхийн, нэн ялангуяа евразийн геополитикийн тухай бүтээлүүд дотор З.Бзежинскийн 1997 онд хэвлүүлэн нийтэлсэн “The Grand Chessboard. American Primacy and Its Geostrategic Imperatives” онцгой байр эзэлдэг бөгөөд түүний хийсэн ажиглалт, дүгнэлт, дэвшүүлсэн таамаглалын дийлэнх нь өнөөдрийг хүртэл үнэ цэнээ хадгалсан хэвээр байна.

Манай улсын геополитик судлалын өнөөгийн байдлын талаар аливаа дүгнэлт хийхэд амаргүй боловч зарим хүний тооцоолсноор энэ чиглэлийн тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрөгдсөн судлаач ойролцоогоор 20 орчим байгаа юм. Манай геополитик судлаачид Евразийн геополитикийн уудам орон зайд Орос, Хятад, АНУ гурав зонхилон, гол тоглогчоор тодроод удаж байгааг цохон тэмдэглэдэг. Дэлхийн II дайнаас хойш эдүгээг хүртэлх хугацаанд энэ гурван их гүрний тус тусын жин нөлөө, үүрэг өөр хоорондоо уялдаатайгаар харьцангуйгаар өөрчлөгдсөөр ирсэн боловч геостратегийн зорилго нь үндсэндээ хэвээр байгаа юм. Энэ нь 1904 онд Макиндерийн зарлан тунхагласан “даян дэлхийд ноёрхлоо тогтоох түлхүүр” болох ”Евразийн голт зүрх” хэмээх газар нутагт хяналтаа тогтоохын төлөө өрсөлдөөний агуулга үндсэндээ хэвээр үргэлжилсээр байгааг харуулж байна.

### 1.2.2. Олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдал, учир шалтгаан

Гучаад жилийн тэртээ “Хүйтэн дайн” эцэслэж, Ф.Фукуяма “Түүхийн төгсгөл” хэмээх үзэл санаагаа тунхагласнаар буюу геополитикийн шинэ эрин эхэлснийг зарласнаар энэ асуудлаар улс төрч, эрдэмтэн мэргэд, шинжээчдийн дунд үүссэн онолын маргаан эдүгээ ч үргэлжилсээр байна.[1] 2016 онд АНУ-ын Ерөнхийлөгчөөр Д.Трамп сонгогдож, 2017 онд ХКН-ын их хурал Дундад улсын ирээдүйг тодорхойлж Си Жинпинь-д үндсэндээ бүх насаараа тус улсын тэргүүн байх бололцоог олгон, 2018 онд В.Путин ОХУ-ын төрийн тэргүүнээр дахин заларч лав л 2024 он хүртэл энэ улсыг удирдахаар болсон зэрэг нь эртний Грекийн Фукидид, хожмын Макиавелли, Гоббс нараас эх авч, орчин үеийн Х.Моргентау,Р.Арон нарын бойжуулсан улс төрийн реализм олон улсын харилцаанд хүч түрэн эргэн ирснийг

[1] Francis Fukuyama. The End of History and The Last Man.NY: Free Press,1992

нотлон харуулсан зүйл болсон юм. Гэвч нөгөө талаас, даяаршил эрч хүчээ авч гүнзгийрэхийн хэрээр улс хоорондын харилцаанд хүч хэрэглэх явдал улам бүр явцгүй болж, бүх нийтийн сүйрэл нүүрлэхгүй, амгалан тайван цаг ирнэ хэмээн өнөөгийн шинэ либералчид цэц булаалдсан хэвээр байна.[2] Гэхдээ энэ маргааны аль ч тал нь өнөөдрийн дэлхий дахины байдал улам бүр ээдрээтэй, олон улсын үйл явдлын өрнөл хөгжил төдийлөн тодорхойгүй, урьдчилан төсөөлшгүй болж байгааг санал нэгтэй хүлээн  зөвшөөрч байгаа юм.[3]

Шинжээчид геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлтийг юуны өмнө олон улсын глобал харилцааны түвшинд хөгжин тодорч байгаа суурь хандлагуудын (мегатренд) үндсэн дээр авч үздэг.

Судлаач, шинжээчдийн дунд даяаршлын талаар, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар нэгдсэн ойлголтгүй хэвээр байгаа нь энэ үзэгдэл хэчнээн ярвигтай, олон талтай, зөрчлөөр дүүрэн болохыг харуулж байна. Дийлэнх судлаачийн үзэж байгаагаар бол даяаршил нь “олон улсын харилцан үйлчлэлийн бүх субъект, түүний дотор төрт улсууд, улс хоорондын болон үндэстэн дамнасан, төрийн бус тоглогчдын оролцсон тэгш бус харилцан хамаарлын тор дэлхийн  улс үндэстнийг улам бүр бүрхэх үйл явц” юм.[4] Адил утгатай ч өөр нэг томьёоллыг иш татвал ”нийгмийн амьдралын бүхий л салбарыг хамарсан харилцан үйлчлэл, солилцооны бүс хоорондын систем**,** бүтцийн үүсэн бүрэлдэх бодит үйл явц” ажээ.[5] Дурдсан тодорхойлолт дотроос “бүс хоорондын” гэсэн үгийг  анхаарах нь зүйтэй болов уу. Учир нь өнөөгийн улс, үндэстэн хоорондын холбоо, харилцан хамаарал хэвтээ, босоо аль ч тэнхлэгээрээ нэн түрүүнд бүс нутгаар дамжин, бүс хоорондын систем, бүтцийн түвшинд илүү эрчимжин гүнзгийрэх хандлагаар тодорхойлогдож байна.

Олон улс судлалын асуудлаар эдүгээ тэргүүлэх байр суурь эзэлж буй нэгэн судлаачийн тодорхойлолтоор бол даяаршил нь:

---

[2] Timothy Stanley and Alexander Lee. It’s Still Not The End of History// “The Atlantic”Sep,1.2014 http://www.theatlantic.com/politics/archive/2014/09/its-still-not-the-end-of-history-francis-fukuyama/379394/
Eliane Glaser. Bring Back Ideology: Fukuyama’s ‘end of history’ 25 years on// “The Guardian” March,21.2014 https://www.theguardian.com/books/2014/mar/21/bring-back-ideology-fukuyama-end-history-25-years-on

[3] Current Debates in International Relations. Ed. by Eric B.Shiraev and Vladislav M.Zubok. Oxford University Press,2015

[4] Современная мировая политика. Прикладной анализ. Под ред А.Д. Богатурова. . М., 2009.

[5] Хелд Д., и др. Глобальные трансформации. Политика, экономика и культура. Пер. с англ. М., 2004.

- технологийн хөгжил дэвшил зэрэг нийтлэг процессууд бүх нийтийн шинжтэй болж түгж байгаа,
- олон нийтийн харилцаа холбооны хэрэгсэл хөгжиж, худалдаа, капиталын урсгал эрчимжихийн хэрээр харилцан хамаарал улам бүр гүнзгийрч буй,
- үйлдвэрлэл, хэрэглээний төрөлжилт, стандартчилал хүчтэй явж байгаа,
- янз бүрийн улс, үндэстнүүдийн байгууллага, соёл, амьдралын хэв маяг гэх мэт зүйлсийн харилцан холбоос улам бүр өргөжин гүнзгийрч байгааг хэлэх ажээ[6].

Гэвч даяаршлыг дэлхий нийтийн глобал (даяар) нийгэм бүрэлдэх үйл явцтай бас адилтгаж хараахан болохгүй юм. Энэ нь өнөөдөр улс үндэсний системүүд илүү өргөн, глобал шинжтэй үйл явцуудын хүрээнд нэвтэрч нийлэх явдал эрчимжиж байгаагаар илэрнэ гэж үзэж байгаатай холбоотой юм.

Глобал харилцан холбоосны орон зай тэлж бүтэц нь нарийсахын хэрээр дотоод ба гадаад улс төр, эдийн засгийн үйл явцын зааг, ялгаа бүдгэрч, төв болон захын бүс хоорондын хил хязгаар улам бүр харьцангуй шинжтэй болж байна. Үүнтэй зэрэгцэн даяаршлын үйл явцууд нь аливаа улс төр , эдийн засгийн хямралын тэлэх болон гүнзгийрч ужгирахад хүчтэй нөлөөлөх болж байгаа учраас үүнд төр засгаас оролцох, хянах явдал өргөжиж, түүний үндсэн загварын амин сүнс болж ирсэн философи – шинэ либерализмын үндсийг ганхуулж эхлээд байгааг мөн анхаарахгүй байж болохгүй байна.

Даяаршлын нэгэн тодорхой, маргаангүй илрэл бол дэлхийн хөгжлийн хүндийн төв Өрнөдөөс Дорнод (өргөн утгаар) руу шилжиж байгаа явдал юм. Европ төвтэй систем аажмаар боловч тууштай өөрчлөгдөж буй энэ үйл явцын учир шалтгаан-үр дагаврын холбоос тодорхой байдаг. Уг шилжилт нь эдийн засаг, эд баялгаар зогсохгүй улс төрийн нөлөөний өсөлтийг ч хамарч буй. Энэ утгаар дэлхийн улс төрийн бүтцийн өөрчлөлтөд шууд нөлөөлж байгаа билээ. XVIII зууны үед дэлхийн үйлдвэрлэлийн тал орчмыг бүтээдэг байсан Хятад, Энэтхэг хоёр нэн удахгүй тэр байр сууриа эргүүлэн авч бататгах нь тодорхой болжээ. Мөн Зүүн Өмнөд Ази, Бразил зэрэг хүчний шинэ төвүүд төлөвших үйл явц тууштай үргэлжилсээр байна.

[6] К.С.Гаджиев. Геополитические горизонты России:Контуры нового мирового порядка. Изд,Экономика. Москва., 2007

Дэлхийн хөгжлийн хүндийн төв шилжих чигийн эсрэг өөр нэг урсгал эрчээ авч байгаа нь бас л даяаршлын үр дагавар гэлтэй. Энэ бол хүн амын шилжин суурьших (миграцийн) үзэгдэл бөгөөд нэн хурц глобал асуудал болж байгаа явдал юм. Өнөөдөр Европт 35 сая гаруй европ бус хүн амьдарч байгаагаас 15-18 сая нь лалын шашинтан гэсэн тоо баримт байдаг. Гэтэл сүүлийн үед тус бүс нутагт жил тутам сая гаруй хүн цагаачлан ирж байгаа бөгөөд 2025 он гэхэд зөвхөн лалын шашинтай цагаачдын тоо 25-30 саяд хүрнэ гэсэн тооцоо байгаа ажээ.[7] Хэрэв 1970-аад оны үед АНУ-ын цагаан арьстнууд хүн амын 80 гаруй хувийг эзэлдэг байсан бол эдүгээ 60 гаруй хувь болж буурсан бөгөөд 2040 он гэхэд 50 хувь болтлоо буурна гэсэн таамаг байна.[8] Ийнхүү өрнөдийн орнуудад хүн амын арьс өнгө, үндэс угсааны бүтцэд өөрчлөлт гарч, цагаачдын нийгэмших үйл явц “бүтэлгүйтэж” байгаа нь тухайн нийгмийн уур амьсгал хурцдах , тогтворгүй байдал үүсэх, улмаар цаашдын хөгжил дэвшилд нь сөргөөр нөлөөлөх ноцтой хүчин зүйл болон хувирч байна.

Даяаршлын тухай ярихдаа түүний мөн чанараас гарч буй даяаршил ба тодорхой улс орны үндэсний өвөрмөц шинж байдал хоорондын зөрчлийн асуудлыг хөндөх ёстой. Мэдээллийн технологийн хөгжил нь, нэг талаас соёл иргэншил хоорондын харилцан үйлчлэлийг өсгөн хурдасгах боловч, нөгөө талаас соёл иргэншил хоорондын ялгарлыг бас турхирдаг нь амьдрал дээр нотлогдож буй юм. Өөрөөр хэлбэл, даяаршин ижилсэхийн нөгөө тал нь бутран задрах, ялгарах явдал бөгөөд нэгэн нэгдмэл үйл явцын өөр хоорондоо уялдаатай хоёр тал юм. З.Бауман энэхүү үйл явцыг “глобализаци” болон “локализаци”-ийн нэгдэл гэж үзэж “глокализаци” хэмээн томьёолох санал дэвшүүлснийг олонх эрдэмтэн хүлээн зөвшөөрч байгаа билээ.

Даяаршлын зарим үр дагавар, тухайлбал ижилсэх, унаган төрхөө алдах, өрсөлдөх чадвар сулрахаас эмээх, өөрийн нийгмээ удирдан зохицуулах бололцоо хумигдах зэрэг нь зарим улсын эсэргүүцэн хамгаалах сэрлийг өдөөн өөрийгөө элдвээр тусгаарлахад хүргэж болох юм. Чингэх нь даяар хөгжлийн “хурдны замыг” захалж, ялгаран хоцрогдоход хүргэх нь ойлгомжтой. Харин даяаршил, үндэсний өвөрмөц байдал хоёрыг хослуулан, органик нэгдлийг нь хангах арга замыг байнга эрэлхийлж байх нь харилцан хамаарал улам бэхжиж байгаа өнөөгийн нөхцөлд

[7] Мир после кризиса. Глобальные тенденции – 2025: меняющийся мир. Доклад Национального разведывательного совета США. Пер. с англ. М., 2009.
[8] U.S. Census Bureau. Percent of the Projected Population by Race and Hispanic Origin for the United States: 2010 to 2050 (NP 2008-T6). August 14, 2008.

олон улсын тогтвортой байдлыг хангах, маргаан зөрөлдөөнийг харилцан ашигтайгаар шийдвэрлэн урагшилж байх үндэс суурь болж байна.

Олон улсын Ялт-Потсдамын дэг журам задран унаснаас хойш энэ дэлхийн улс төрийн бүтэц хэрхэн өөрчлөгдөж, чухам ямар дэг журам үйлчилж байгаа талаар шинжээчдийн дунд дэгдсэн багагүй маргаан эдүгээ ч намжаагүй байна. Эрдэмтдийн зарим нь "ганц туйлт" дэг журам гэж байхад, нөгөө хэсэг нь үгүйсгэн "туйлгүй" үе буюу "хоёр туйлт" дэг журмаас "олон төвт дэг журамд" шилжих шилжилтийн үе хэмээн тодорхойлж байгаа. Гэтэл хэргийн учир нь "туйл" гэдэг ухагдахуунаа хэн, хэрхэн ойлгоход оршиж байна.

Оросын эрдэмтэн Э.Баталовын үзэж байгаагаар хүчний "туйл", "төв" хэмээх хоёр ойлголтыг тодорхой хэмжээгээр адилтгаж болох боловч нарийвчлан үзвэл тийм биш аж. "Туйл" нь глобал хүчний харьцааны тэнхлэгийн хоёр үзүүрт харилцан нөхцөлдөхийн хамт харилцан нэгнээ үгүйсгэж оршдог, хурц тэмцлийн дунд харилцан үйлчлэх замаар дэлхийн улс төрийн системийн ажиллагааны шинж чанар, хөгжлийг тодорхойлдог "төвүүдийг" хэлэх бөгөөд туйл бол хоёрхон байдаг. Нэг туйл үгүй бол нөгөө нь үгүй болж , энгийн төв болдог. Өөрөөр хэлбэл, Дэлхийн хоёрдугаар дайны дараа үүссэн "хоёр туйлт" дэг журам өмнөх зууны 90-ээд оны зааг дээр задран унаснаар "туйлгүй" дэг журам эхэлсэн. "Туйлгүй" дэлхийн дэг журам нь нэг бол ганц төвтэй, эсвэл олон төвтэй дэлхийнх байх бөгөөд АНУ дангаараа глобал манлайлагчийн үүрэг гүйцэтгэж байсан үе арваадхан жил үргэлжилж эдүгээ, XXI зууны эхнээс олон төвтэй дэг журам үйлчилж байна гэж үзэж байна.[9]

Оросын өөр нэг тэргүүлэх эрдэмтэн В.Барановскийн үзэж байгаагаар бол "хоёр туйлт" дэг журмын дараах үеийн мөн чанарууд бүрэн тодорхойлогдоогүй, цэгцтэй үзэл баримтлал боловсруулах хэмжээнд хүрээгүй байна. Тэр бээр 1990-ээд оноос хойших үеийг бүхэлд нь **"**шилжилтийн үе" гэж нэрлэхийг санал болгож, шилжилтийн үе нь "Олон улсын харилцааны шинэ бүтцийн суурь бүрэлдэж "араг яс" хангалттай тогтворжсоноор" төгсгөл болох боловч энэ өөрчлөлт дуусах болоогүй" гэж үзэж байна.[10]

---

[9] Баталов Э., Как развивается глобальный мир. Международные процессы.Том 10, Январь-Апрель 2012

[10] Барановский В., Новое в мирополитической системе. Международные процессы. Том 8, ЯнварьАпрель 2010

Эдүгээ “туйлгүй”, эсвэл “олон төвт” ертөнц үйлчилж, дэлхийн бодлогын түвшинд нөлөөлөн шийдвэр гаргагч хэд хэдэн төв бий болж байна. Чухам хэдэн төв, ямар чанар чансаатай талаар нэгдсэн санал одоогоор байхгүй ч гэсэн энэ үйл явц цаашид ч үргэлжлэх бөгөөд орчин үеийн олон улсын харилцааны үндсэн онцлогийн нэг гэж үзэж болно.

Хүчний төвийн тухай ярихдаа бид юуны өмнө их гүрнүүдийн тухай, аль нэг том улсын дэлхий даяар гүйцэтгэх үүргийн тухай, эдүгээ нүүрлээд буй даяар манлайллын хямралын тухай ярих болно. Юуны түрүүнд улс төрийн үгсийн санд байгаа дор хаяад дөрвөн үгийн (оноосон үг) ялгааг сайтар гаргаж байхгүй бол төөрөлдөх магадлал өндөр байх нь анзаарагддаг юм. Үүнд: leadership (манлайлах), domination(давамгайлах, ноёрхох), primacy (тэргүүлэх), hegemony (жанжлах) юм. Өмнө дурдсан Э.Баталовын тайлбарлаж байгаагаар бол манлайлах гэдэг нь “ тухайн улс өөрийн болон бусад улсын чиг зүгийг тодорхойлох үндсэн дээр бусдыгаа сайн дураар нь удирдан явах улс төрийн арга. Удирдагч, удирдуулагч хоёр нь нийтлэг ашиг сонирхолтой байж түүнийгээ дэлхийн тавцан дээр хамгаалж явахыг” хэлнэ гэсэн бол давамгайлах гэдэг нь “үгэнд нь орж, аялдан дагалдахад тулгуурласан улс төрийн арга” гээд жанжлахыг “зүгээр л дагнан ноёрхохыг хэлнэ” гэжээ. Тэргүүлэх гэдгийг тодорхойлохдоо “бусад улстай харьцуулбал илүү олон улсад, илүү олон асуудлаар, илүү нөлөө үзүүлэх чадвар” хэмээн С.Хантингтоноос шууд иш татсан байна. [11]

Берлиний хана нурсны дараа АНУ “глобал манлайлагчийн” үүрэг гүйцэтгэхэд хүрч, үүнийг нь бусад улс, түүний дотор ОХУ ч хүлээн зөвшөөрч байлаа.[12] Гэвч арваадхан жилийн дараагаар АНУ, хэдийгээр олон салбарт тэргүүлэх байр сууриа хадгалж байсан боловч, цаашид бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн “ манлайлагч” байж чадахгүй нь тодорхой болсон ажээ.[13] Үүний шалтгаан нь нэгд, хүчний хэд хэдэн төв бий болж дэлхийн улс төрийн бүтэц өөрчлөгдсөн, хоёрт, АНУ-ын гадаад бодлогын “зарим алдаатай” холбоотой байсан.

---

[11] Huntington S. Why International Primacy Matters //International Security. 1993. Spring. Vol.17. № 4.
[12] William I.Robinson.Gloabalization, the World System, and “Democracy Promotion” in U.S. Foreign Policy // Theory and Society, Vol.25,no.5(Oct.1996), pp.615-665
[13] Alexandra de Hoop Scheffer, Rory Kinane, Martin Quencez, Xenia Wickett. The Future of US Global Leadership Implications for Europe, Canada and Transatlantic Cooperation// The German Marshall Fund of the United States. May 2016
Dmitry Suslov.US Global Leadership Dilemma as a Challenge for the US- Russia relations // National Research University Higher School of Economics. WP BRP 03/IR/2013

Ийм нөхцөлд буюу хэн ч “глобал манлайлагчийн” үүрэг гүйцэтгэх боломжгүй болсон үед олон улсын үйл явдал “эмх замбараагүй” болох эрсдэл өсөн нэмэгдэж, “даяар удирдлага (global governance)”-ын хямралын асуудал хурцаар тавигдаж ирлээ. Тийм ч учраас НҮБ-ын үүргийг хүчтэй болгох үр дүн муутай хүчин чармайлтын зэрэгцээ “Их долоо”, “Их найм”, “Их хорь” гэх мэт олон талт бүтцийн байгууллагуудын хэлбэр бий болсон бөгөөд судлаачдын үзэж байгаагаар ийм байдал цаашид ч хүчтэй үргэлжлэх ажээ.[14]

Олон нийтийн харилцаа холбооны техник, технологийн дэвшил гүнзгийрэхийн хэрээр нийгэм-улс төрийн харилцааны биет бусаар хийсвэрлэн тусгах боломж улам бүр өсөн нэмэгдэж байна. Өөрөөр хэлбэл, иргэд хоорондын шууд, уламжлалт биет харилцаа хийгээд иргэд, төр засаг хоорондын харилцаа биет бус харилцаагаар баяжин өргөжиж байна гэсэн үг юм. Энэ боломжийн үүрэг, эзлэх хувь хэмжээ асар түргэн өсөж байгаа бөгөөд үүнд интернет онцгой үүрэг гүйцэтгэж байна. Интернет буй болсноор хүмүүс хооронд уламжлалт бус, шинэ харилцаа, хэлхээ холбооны хэлбэрүүд үүсэн, эргээд хүн, нийгмийн харилцаанд гүн гүнзгий нөлөө үзүүлэх болжээ. Иргэдээс улс төрд оролцох хэлбэр өргөжиж, төрийн удирдлагын өөр механизмууд бий болж байна. Олон улсын хэмжээнд улс хоорондын харилцааг хөнгөвчлөхийн зэрэгцээ иргэд, төрийн бус байгууллагуудаас олон улсын бодлогод оролцох бололцоог асар ихээр өргөтгөж өглөө.

Нийгмийн бүх талын харилцааг хэвтээ болон босоо тэнхлэгээр, орон нутгаас даярын түвшинд хүртэл хөнгөвчлөхийн хамт шинэ шинэ сорилт, аюул заналыг бий болгож байгаа бөгөөд тухайлбал, бодит ба бодит бус хоорондын хязгаар, ялгаа хэврэгшиж, “хөл хөрснөөс хөндийрснөөр” хүний ухамсраар тоглох, “мэдээлэл-сэтгэл зүйн” дайнд ашиглах бололцоог тавьж өгч байна. Сүүлийн үед бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох, улс төрийн засаглалыг нь өөрчлөн солих “ улс төрийн харилцааны шинэ технологийн”-ын тухай яригдах болсон. Хэдийгээр нэг улсын доторх цэргийн эргэлт, хувьсгал хүртэл гадны нөлөөгөөр гарах явдал цөөнгүй тохиолдож ирсэн ч энэ шинэ технологийн нөлөөгөөр гадаад хүчин зүйл эдүгээ тоо, чанар, бүтцийн хувьд ч асар хүчирхэгжиж, нөлөөллийн хүч нь урьд өмнө үзэгдээгүйгээр өсөн нэмэгджээ.

---

[14] Frances Mautner-Markhof. Order and Chaos in the 21st Century. Do We Need a New Standpoint for Seeing and Judging Events“? // Studien und Berichte zur Sicherheitspolitik 1/2004

Хүн төрөлхтний дэвшил, нийгмийн түүхэн хөгжлийн хурдац ямагт түргэсэж ирсэн билээ. Ялангуяа, та бидний амьдран буй хоёр зууны зааг дээр улам түргэсэж байгааг бид мэднэ. Жишээ болгож бага зэрэг хуучирсан ч гэсэн дараах баримтыг дурдъя. Зарим эрдэмтдийн тооцоолсноор "түүхэн үйл явдлын нягтрал 1751-1775 онуудад 20,6 нэгж байсан бол 1976-1995 онуудад 213 нэгж болж, даруй 10,3 дахин өссөн" байна.[15] Өөрөөр хэлбэл, тодорхой тооны далайц, агуулгаараа адил төстэй үйл явдлын тохиолдох цаг хугацаа байнга агшсаар байна гэсэн үг юм. Түүхэн үйл явдал гэж байгааг анхаарцгаагаарай. Түүхэнд хамаарахгүй, тодорхой нэг хүн, хэсэг хүн, нэг ард түмэнд хамаатай хэчнээн их үйл явдал цаана нь байгааг төсөөлөхөд амаргүй юм.

Түүхэн үйл явцын хурдыг эрчимжүүлэгч хүчин зүйлүүд, тухайлбал эдийн засаг, хүн амын тооны өсөлт, нягтрал, улс хоорондын цэрэг-улс төр,эдийн засгийн болон бусад өрсөлдөөн, олон улсын амьдралд оролцогсдын /төрийн ба төрийн бус тоглогчид/ тоо, хүрээний өргөжилт, шинжлэх ухаан, техник, цахим технологийн өнөөгийн хөгжил, бусад хүчин зүйлийг үзвэл дээрх хандлага цаашид ч тогтвортой үргэлжлэх нь тодорхой байна. Энэ тогтвортой хандлага нийт хүн төрөлхтний төдийгүй нэг хувь хүний ч амьдралд шууд болон шууд бусаар нөлөөлж буй нь ойлгомжтой юм. Гэтэл бүхий л түүхэн хөгжил дэвшлийн турш хүн , хүмүүсийн хам оршин тогтнохуйн баталгааны хэмжээ, түвшин байнга буурсаар ирсэн байдаг. Ялангуяа, сүүлийн зуу хүрэхгүй жилийн дотор энэ түвшин асар хурдтайгаар унаж ирсэнд хэн бүхний санаа зовж буй нь зүйн хэрэг юм.

Өмнөх түүхэнд хүмүүс амьдралдаа аюул заналтай бишгүй л учирч ирсэн байдаг. Харин нийт хүн төрөлхтөн устаж сөнөх аюул цөмийн зэвсэгт үүсэнтэй хамтаар бодитойгоор бий болсон юм. Цөмийн зэвсгийн олон улсын хяналт эдүгээ алдагдаж ийм зэвсэг бүхий "албан ёсны" гүрнүүдийн зэрэгцээ ийм зэвсэг бүхий, эсвэл бүтээх чадавхтай улсын тоо нэмэгдсээр байгаа нь геополитикийн асар их өөрчлөлтийг өдөөж байна.

"Дамокловын илд"-ийг толгой дээрээ залсан гэж хэлж болох хүн төрөлхтөн сүүлийн хэдхэн арван жилийн дотор глобал шинжийн шинэ аюул, сорилтуудтай тулгараад байна. Хүрээлэн байгаа орчны бохирдол, эвдрэл, цаг уурын өөрчлөлт, экологийн хямрал, байгалийн үл сэргэх нөөц баялаг шавхрах, усны хомсдол гээд

[15] Кузык Б.Н. , Яковец Ю.В. Цивилизации: теория, история, диалог, будущее. В двух томах. Том II. Будущее цивилизаций и геоцивилизационные измерения. М., 2006.

нийтийн хүчээр хэлэлцэн шийдвэрлэх асуудлууд ар араасаа ундарч байх боловч ойрын ирээдүйд байдал эргэж дээрдэх төлөв тодорхой ажиглагдахгүй байна гэж мэргэжилтнүүд үзэж байна. Дээр нь шашны болон салан тусгаарлагчдын хэт туйлшралд үндэслэсэн **олон улсын терроризм** хэмээх "үзэгдэл" дэлхий нийтийн анхаарал татаж, хүч чармайлтыг нь дайчилсан нийтийн аюул болоод байна.[16]

"Терроризм" хэмээх үзэгдэл гүн гүнзгий үндэс, учир шалтгаантай. Өнөөгийн терроризм нь улс үндэстэн дамнан хөгжиж дэлхий нийтийн тогтвортой байдлыг бусниулахын хамт олон улсын харилцааны уламжлалт ойлголтууд үндсээрээ ганхаж байгааг харуулсан бас нэгэн хүчин зүйл болжээ. "Исламын улсын" эсрэг олон улсын "дайн" өрнүүлсний үр дүнд энэ үзэгдлийн нэг хүчит давалгаа дарагдаж буй боловч **"**соёл иргэншил хоорондын мөргөлдөөн" цаашид ч үргэлжилсээр байх болно гэж шинжээчид үзэж байна.

Олон улсын харилцаа нь улс хоорондын гэхээсээ нийгэм хоорондын харилцаа болон түлхүү хөгжиж байгааг дээрх үзэгдэл дахин нотлов. Түүнчлэн эдүгээ аливаа улс иргэдийнхээ аюулгүй байдлыг эрх чөлөөг нь хязгаарлахгүйгээр хангах баталгаа өгч чадахаа байхад хүргэж, үүнээс үзвэл хувийн эрх чөлөө, аюулгүй байдал хоёр байраа сольж, юуны өмнө өрнөдийн нийгмийн ухамсарт нэгэн эргэлт гарч байна. Цаашилбал, аливаа хөгжил, түүний дотор олон улсын харилцааны хөгжил тодорхой үе шаттайгаар дэвшин урагшилдгийн нотолгоо болж либерализмын дараах буюу шинэ консерватизм, харилцан хамаарлын дараах бүрэн эрхт байдал, чөлөөт худалдааны дараах протекционизм гэх мэт ойлголтууд давамгайлах тухай дуу хоолой улам бүр тод сонсогдох болж байна.[16]

Өмнө өнөөгийн олон улсын байдлыг тодорхойлж буй үндсэн хандлага, үйл явцаас сонголтоор, аль болохоор базаж үзүүлэхийг хичээлээ. Эдгээр нь аль хэр

---

[16] Elimma C. Ezeani. The 21st Century Terrorist: Hostis Humani Generis?// Beijing Law Review, 2012, no3, pp.158-169
Boaz Ganor. Terrorism in the Twenty-First Century// S.C. Shapira et al. (eds.), Essentials of Terror Medicine, Springer,2009,pp.13-26
Peter R. Neumann. Terrorism in the 21st century .The rule of law as a guideline for German policy // Compass 2020. Germany in international relations: Aims, instruments, prospects, May 2008
[16] Бертран Бади. Конец истории отменяется. Международные процессы. Том 14. Апрель-Июнь 2016
[17] Пантин В.И., Лапкин В.В. Философия исторического прогнозирования: ритмы истории и дерспективы мирового развития в первой половине XXI века . Дубна "Феникс",2006.

удаан үйлчлэх, төрж байгаа нь хэзээ биежиж дэлхийн бодлогыг тодорхойлогч хүчин зүйл болохыг эдүгээ таахад бэрх юм. Зарим нь бодит зүйл болж, нэг хэсэг нь бөхөж мөхөж, өөр шинэ хандлагууд үүсэж, эдгээр нь олон улсын харилцаанд оролцогч бүх субъект: төр засаг, иргэний нийгмийн төлөөлөл, шинжлэх ухаан, бизнесийнхэн төдийгүй идэвхтэй нэгэн иргэнд хүртэл бүгдэд нь сорилт болон тулгарах болно. Энэ нь дотоод , гадаад бодлогын дадал болсон сэтгэлгээ, практик, ахуй хөтлөх арга барил, өдөр тутмын амьдралын хэв маяг бусадтай харилцах, өөр ард түмэн, улс гүрэнтэй хамтран ажиллах ур ухаанаа эргэн харж өөрчлөхийг шаардах болно.

Хүн төрөлхтөнд учирч буй, цаашид ч шинээр тулгарах бүх сорилтыг хүн л шийдвэрлэж, давж амьдрах учиртай. Харамсалтай нь, шинжлэх ухаанч эрдэмтэн мэргэдийн оношилж байгаагаар эдүгээ нийгмийн ахуй, нийгмийн ухамсар хоёр өөр хоорондоо таарахаа байгаад, зай завсар нь өссөөр байгаа юм.[17] Шинжлэх ухааны ухамсрын хэмжээнд бол дэлхий дахинаа юу болж байгаа, өөрчлөлт, сорилтод ямар хариу барьж болох тухай их, багаар ямар ч болов ойлгон мэдэж байгаа. Харин сэтгэл зүй, ёс суртахууны түвшинд хүмүүс тэр бүр зайлшгүй шаардлагуудыг хангаж чадахгүй байна гэнэ. Мэдсээр байж "хэтрүүлж хэрэглээд" орчноо бохирдуулахаас авхуулаад дайн хэмээх үзэгдэл сүйрэл авчрах аюултай ухаангүй зүйл гэж тунхагласаар байж шүдээ хүртэл зэвсэглэхээс эхлээд зэвсгээр өдөх хүртэл үйлдлээсээ салж чадахгүй хэвээр байна. Юуны өмнө хувийн болоод өөрийн явцуу ашиг сонирхлоо хангахын төлөө тэмцэхээс хүн төдийлөн салж чадахгүй хэвээр байна. Өөрөөр хэлбэл, дэлхийн хамтын нийгэмлэгийн геополитикийн бүтэц, нийгэм-улс төрийн системд гүн гүнзгий өөрчлөлт гарч, энэ нь дэлхий дахины хөгжлийн түүхэн нэгэн үе шувтарч, чанарын цоо шинэ өөр үе эхэлж байна гэж үзэх үндэс болж байна.

К.С.Гаджиевийн тэмдэглэснээр, "дэлхий нийтийн хэмжээнд шинэ төрлийн гэж хэлж болох олон улсын нийгэмлэг бүрэлдэн тогтох үе шат чухамхүү одоо л эхэлж байж болзошгүй"* гэдгийг ойлгон ухамсарлах явдал туйлын чухал болой.

Дээрх зүйлүүдээс XXI зууны эхээр дэлхий даяар геополитикийн шинж чанартай дараах өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Үүнд:

---

[17] К.С.Гаджиев. Геополитические горизонты России:Контуры нового мирового порядка. Изд,Экономика. Москва., 2007

- Стратегийн ач холбогдол бүхий чухал газар нутаг, орон зайн төлөөх дэлхийн том гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр зах зээл, соёл иргэншлийн орон зайн дахин хуваарилалтын утга агуулгатай болж, дэлхий нийтийг бүхэлд нь хамран, хурцдах төлөвтэй байна.

- Хүн төрөлхтний хөгжлийн төв буюу эцсийн дүндээ том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн аажмаар дорно зүгт шилжиж байна.

- Дэлхийн болон бүс нутгуудын хүчний дахин хуваарилалтад Европ, Хойд Америкийн зэрэгцээ олон зуун саяас дээш, тэрбумаар тоологдох хүн амтай Хятад, Энэтхэг, Латин Америкийн болон лалын гэгдэх ертөнцүүд хүч түрэн орж ирж байна.

- Том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөний объектод цэрэг-стратегийн хувьд чухал болон эдийн засгийн стратегийн ач холбогдол бүхий район, бүс нутаг, далай тэнгисийн сав газрын зэрэгцээ байгалийн баялаг их хэмжээгээр төвлөрсөн болон нэгдмэл соёл иргэншилт үндэстэн ястны төвлөрөн суурьшсан газар нутаг бас хамаарах боллоо.

- Геополитикийн хувьд өндөр ач холбогдол бүхий тив дэлхий, бүс нутгийг өөрийн эзэмшилд буюу нөлөөндөө байлгах нь соёл иргэншлүүдийн геополитикийн өндөр статус, аюулгүй байдлын түвшин, эдийн засгийн хөгжлийн чадавхын илэрхийлэл болж байна.

- Геополитикийн орон зайн төлөөх өрсөлдөөний хүч хэрэгсэл, арга хэлбэр хүн төрөлхтний амьдралын бүх салбарыг хамран өргөжиж, зөрчил, сөргөлдөөний гол талбар нь эдийн засгийн зах зээл, оюун санаа, соёл иргэншлийн үнэт зүйлсийн өрсөлдөөн болж хувирах талтай байгаа боловч үүнтэй зэрэгцэн цэрэг, зэвсгийн хүчээр асуудлыг шийдвэрлэх хандлага улам бүр түгээмэл болсоор байна.

Эцсийн дүндээ энэ зууны дунд гэхэд хүн төрөлхтөн соёл, иргэншлийн хуваарилалтын шинэ эринд амьдарч болзошгүй байна. Үүний дотор дээр хэлснээр Хятад, Энэтхэгийн соёл иргэншил хүч түрэн гарч ирж, европын соёл иргэншлийн нөлөө ихээхэн сулран, Хойд Америк танигдахыг аргагүй өөрчлөгдөх магадлалтай байна. Гэхдээ дэлхий ертөнц илүү ёс суртахуунтай, байгаль орчинтойгоо зохицсон, ухаалаг болох төлөвтэй байна. Энэ нь өнөө үед дэлхий ертөнцөд давамгайлж буй барууны гэж нэрлэгддэг, мөнгө хөрөнгө, ашиг хонжоог хэт эрхэмлэсэн, эх дэлхий, байгаль орчноо үл хайрласан үйлдвэрлэл, амьдрах зарчим, ёс суртахууны хэм

хэмжээ, төрөөс болон шашны зүгээс хатуу тогтоодог нийгмийн дэг журмын сөрөг талыг дэлхий нийтээрээ улам бүр мэдрэх болсонтой холбоотой юм.

### 1.2.3. Геополитикийн аюулгүй байдлын тухай ойлголт

Сүүлийн жилүүдэд хүн төрөлхтөнд бүхэлд нь болон тодорхой улс оронд учирч болзошгүй аливаа эрсдэл, сорилтын дотроос геополитикийн шинж чанартай аюул, заналхийлэл ихээхэн анхаарал татах боллоо. Түүгээр ч барахгүй "геополитикийн аюулгүй байдал" гэдэг шинэ нэр томьёо бий болж нэлээд өргөн хэрэглэгдэж эхлээд байна.

Үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг олон улсын аюулгүй байдлын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд найдвартай хадгалан, хамгаалах, бусад орон, эвсэл холбоодтой найрсаг харилцаа хамтын ажиллагаатай байх болон гадаад ертөнцөд тодорхой хэмжээгээр нөлөө бүхий байр суурь эзлэх нөхцөл бололцоог олгосон, олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдсөн, өөрийн гэсэн геополитикийн өндөр статус, нэр хүндтэй байх улс орны чадамжийг геополитикийн аюулгүй байдал гэж тодорхойлох нь нэлээд түгээмэл тохиолддог болно. Өөрөөр хэлбэл геополитикийн аюулгүй байдал гэдэг нь эцсийн дүндээ улс орны үндэсний ашиг сонирхлыг геополитикийн утга агуулга бүхий аливаа аюулаас найдвартай хамгаалах бололцоог олгосон ãäàààä, дотоод òàäòàé нөхцөл бүрдсэн байхыг хэлж болох юм.

Геополитикийн өндөр статустай байх нь аливаа улс оронд хөгжлийн илүү таатай нөхцөл бүрдүүлж, үндэсний аюулгүй байдлаа шаардлагын түвшинд хангах бололцоог олгодог болно.

Дээрхээс үүдэн олон улсын харилцааны хүрээнд энэ статусыг бий болгох, түүнийгээ улам өргөтгөх замаар геополитикийн аюулгүй байдлаа хангахыг аливаа улс орон болгон чармайдаг билээ. Энэ зорилгоор улс орнууд, ялангуяа хүчирхэг гүрнүүд өөрийн нөлөөг бусдын газар нутагт тэлэх буюу геополитикийн орон зайгаа өргөжүүлэхийн тулд улс төр, оюун санаа, цэрэг, эдийн засгийн чадавхаа байнга нэмэгдүүлж, улс төр-цэргийн эвсэл холбоодыг байгуулан зарим тохиолдолд дайн, зэвсэгт мөргөлдөөнийг ч өдөөх нь байдаг. Харин бага буурай орнууд том гүрнүүдийн геополитикийн эрх ашгийн нөлөөллийн хүрээнд улс орныхоо тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, соёл иргэншлийнхээ онцлог шинж чанарыг хадгалан хамгаалахыг чармайхын зэрэгцээ газар нутаг, орон зайн давуу талаа дээд зэргээр ашигласан геополитикийн салбарт баримтлах өөрийн гэсэн

төрийн бодлогыг хэрэгжүүлэхийг эрмэлздэг болно.

### 1.2.4. Соёл, иргэншлүүдийн геополитикийн эрмэлзэл

Өнөө үед дорнодын, юуны өмнө Хятад, Энэтхэгийн соёл иргэншил дэлхийд эрчимтэй хөгжиж, тэргүүлэх байр суурийг эзлэх болж байна. Лалын ертөнц өөрийн соёл иргэншлийн хүрээнд нэгдэн нягтрахын ач холбогдлыг улам бүр ойлгох боллоо. Түүхэнд мартагдсан маяа, инк, ацтекийн соёл иргэншил Өмнөд Америкийн улс орнуудын холбоо хэлбэрээр эргэн сэргэж байгаа нь бас ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ ерөнхийд нь авч үзвэл Европын нэгдэх, бие даах үйл явц амжилттай явагдаж байна. Европын улс орнууд АНУ-д захирагдсан байдлаасаа аажмаар салж дэлхийн улс төр, эдийн засгийн харилцаанд хараат бусаар оролцох боллоо. АНУ эдгээр орныг одоохондоо аюулгүй байдлын асуудлуудын хүрээнд өөрийн эрхшээлд барьж байгаа боловч энэ нь улам бүр суларч байгаа нь ойлгогдож байна. ОХУ Европын соёл иргэншилд нэгдэн орохыг чухалчлан үзэж байгаа боловч төдийлөн амжилтад хүрэхгүй байгаагийн зэрэгцээ Дорнод Европ, Төв Ази, Сибирь, Алс дорнодыг багтаасан Евразийн гэж нэрлэгдэж болох соёл иргэншлийг дахин бий болгох санаархал энэ улсад сүүлийн үед хүчтэй ажиглагдах боллоо.

Соёл иргэншлүүдийн дотоодод болж буй зарим үйл явц бас ихээхэн анхаарал татах боллоо. Хятадууд өөрсдийн дотоодын зөрчил сөргөлдөөнөө даван гарч чадсаны зэрэгцээ ямар хэлбэртэй байх нь одоогоор тодорхой бус боловч Япон, Солонгостой геополитикийн ашиг сонирхлын үүднээс нэгдэх гарцыг идэвхтэй эрж хайж байна. Эдгээр орон төр засаг, ахуй хөтлөх арга ухаан, түүх соёлын уламжлал талаасаа ихээхэн ойр улсууд билээ. Япон-Хятадын харилцааны түүхэнд анх удаа Японы Эзэн хаан Хятадад айлчилсан, энэ хоёр орны Засгийн газрын тэргүүнүүдийн уулзалт тогтмолжсон, хоёр талын гарын үсэг зурж буй баримт бичгүүд улам бүр стратегийн агуулгатай болж байгаа нь үүний нэг нотолгоо болж байна. Солонгосын хойгийн асуудал дээр Хятадууд ихээхэн хүлээцтэй хандаж, эцсийн дүндээ хоёр Солонгосыг нэгтгэх үйл явцыг өөрийн хяналтад байлгаж чадаж байгаа нь бас үүнтэй холбоотой байж болох зүйл юм.

Хятад Энэтхэгийн харилцаа улам бүр ойртон нягтрах болж байна. 2008 оны 1 дүгээр сард Энэтхэгийн Ерөнхий сайд М.Сингх анх удаагаа Хятадад айлчилж “XXI зууныг хамтдаа харах нь” гэсэн нэртэй стратегийн чухал хэлэлцээрт болон

хамтын ажиллагааны олон салбарын удаан хугацааны гэрээнүүдэд гарын үсэг зурсан нь Азийн энэ хоёр агуу их гүрний ирээдүйн геополитикийн холбооны дүр төрх, боломжийг тандан тодорхойлох боломжийг олгосон юм. Энэ айлчлалын үеэр М.Сингх нэг Хятадыг дэмжиж байгаагаа нотолж, эдийн засгийн хөгжил, нийгмийн шударга байдлын нэгдлийн талаар эрдэмтдийн өмнө илтгэл тавьж, үүгээрээ Энэтхэг бол Хятадын талаарх Вашингтоны бодлогыг аялдан дагагч биш гэсэн сануулгыг АНУ-д өгсөн бөгөөд үүнийхээ зэрэгцээ дорно зүгт Энэтхэгийн анхаарлын гол объект бол Хятад гэдгийг хүлээн зөвшөөрсөн болно.

Энэ бүхнээс харахад Дорнодод 2,5 тэрбум орчим хүн ам, байгалийн баялаг, оюун санаа, шинжлэх ухаан технологи, санхүүгийн асар их нөөц бүхий хүчирхэг соёл иргэншлүүдийг өөртөө багтаасан геополитикийн шинэ систем бүрэлдэн бий болж байгаа нь ойлгогдож эхэллээ. Мэдээж хэрэг ийм хүчирхэг орон зайн нягтрал нь эдгээр орнуудтай хил залгаа том, бага ялгаагүй улс орнуудын санааг зовоох болсон нь зүйн хэрэг юм. Тиймээс ч энэ том бүс нутагт тэнцвэртэй байдал бий болгох гэсэн оролдлогууд хийгдэх болсон нь бас ажиглагдаж байна. Үүний нэг тод жишээ бол 1990-ээд оны сүүлчээр ОХУ-ын Батлан хамгаалах яам, Гадаад хэргийн яамнаас санаачлан гаргаж ирсэн Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага юм. Олон улсын судлаачдын үздэгээр энэ санаачилгын гол эзэн нь тухайн үед ОХУ-ын ГХЯ-ны сайд байсан Е.М.Примаков бөгөөд түүний бодлоор энэ байгууллагад ОХУ, Тусгаар улсын хамтын нөхөрлөлийн бүх орон, Хятад, Энэтхэг, Иран, Пакистан, Монгол улс орох ёстой байсан бололтой. Гэвч энэ байгууллага арай явцуу хүрээнд байгуулагдаж, хэдийгээр үйл ажиллагаа нь тодорхой хэмжээгээр урагшилж байгаа боловч анх санасан шиг дэлхийн геополитикийн өрсөлдөөний хүчний тэнцвэр болж чадсан гэж хэлэхэд амаргүй хэвээр байгаа юм. Байдал ийнхүү эргэхэд Монгол Улсын баримталсан өвөрмөц байр суурь, АНУ болон Ази, Номхон далайн нөлөө бүхий бусад улс оронтой түүний тогтоосон найрамдалт харилцаа ихээхэн нөлөөлсөн гэж барууны судлаачид үздэг.

Лалын ертөнц дэлхийд буй болоод байгаа нөхцөл байдлыг улам бүр гүнзгий ухамсарлан ойлгох шатандаа байгаа бололтой. Лалын орнууд хүн төрөлхтний ирээдүйн хөгжлийн хувь заяа тэднээс ихээхэн шалтгаалах болсон ба дэлхийн геополитикийн өрсөлдөөний тавцанд бие даасан тоглогч байх бололцоотой болсноо ойлгож эхэлсэн нь сүүлийн үед тэнд болж байгаа үйл явдлаас тодорхой харагдаж байна. Дэлхийн нүүрс ус төрөгчийн үндсэн нөөц, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцүүд, соёл иргэншлүүдийн уулзвар, эдийн засгийн бүс нутгуудын зах

нийлсэн заагууд эдгээр оронд оршиж байгааг ч тэд тооцож байгаа. Лалын ертөнц өөрийн соёл иргэншлийн үнэт зүйлсээ маш хатуу хадгалан хамгаалахын зэрэгцээ Европ, Америк болон Зөвлөлтийн дараа бий болсон хоосон орон зайг аажмаар дүүргэхийг эрмэлзэж байгаа бөгөөд чингэхдээ өөр соёл иргэншлийн ард түмэнд үндсэндээ уусан нэгдэхгүй байна. Бүхэлд нь авч үзвэл лалын ертөнцөд болж буй үйл явц дараах хандлагуудыг бий болгож байгаа нь тодорхой байна. Үүнд:

- Лалын бага хурлын байгууллагын хүрээнд зохицуулах, удирдах бүтцийг бий болгох;

- Лалын нэгдсэн мөнгөний нэгжийг эргэлтэд оруулан нүүрс ус төрөгчийн төлбөр тооцоог ам.доллараар хийхийг зогсоож валютын өөр сагсанд хуримтлуулах;

- Лалын орнуудын аюулгүй байдлын хамтын ажиллагааны тогтолцоог байгуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд өөрийн байнгын төлөөлөгчийг суулгах шаардлага тавих зэрэг болно.

Үүний зэрэгцээ, лалын ертөнцөд хуучин ЗХУ шиг соёл, иргэншлийн холбоотон хэрэгтэй байгаа нь тодорхой. Энэ үүднээс лалын орнуудын удирдагчид ОХУ-ыг холбоотон болж магадгүй гэж олон жил найдаж хүлээсэн боловч эл хүлээлт бүтэлгүйтэх нь улам бүр тодорхой болж байна. Тэдний ойлголтоор бол ОХУ лалын ертөнцөөс холдож барууны орнуудтай түүний дотор Израйлтай олон асуудлаар санал нэгдэх болсон нь тэднийг ийм дүгнэлтэд хүргэж байгаа бололтой. Үүнээс үүдэн лалын ертөнцийн хувьд ОХУ-ын хэрэгцээ буурахын хэрээр энэ орныг тэд дайсныхаа тоонд ч оруулах магадлал байж болно. Энэ тохиолдолд лалын ертөнцийг Оросын эсрэг ашиглах бололцоог бусдад олгож болох юм. Үүний тод жишээ нь Кавказ, Төв Азийн зарим оронд болж буй хэрэг явдал. Харин энэ орон зайг Хятадууд эзлэхээр идэвхтэй ажиллаж эхэлсэн тухай барууны хэвлэлүүдэд сүүлийн үед ихээхэн бичигдэх болсныг бид бас анхаарах ёстой.

### 1.2.5. Их гүрнүүдийн геополитикийн мөн чанар, гол зорилго

#### Хятадын геополитикийн мөн чанар.

Хятад өөрийнхөө түүхийг агуу их үндэстний түүх гэж үздэг. Түүнийг “тэнгэрийн доорх орон” хэмээн нэрлэх бөгөөд “хятад хүний толгой дээр нар

жаргадаггүй” гэсэн зүйрлэл бий. Энэ бол хятад хүний оюун санаанд эзэнт гүрний холын санаархал ямагт оршиж ирсэн бөгөөд тэр бээр газар тариалангаар дундад зууны хүчирхэг гүрэн байсан нь яах аргагүй үүнийг нотолно. Наад зах нь дөрвөн мянган жилийн бичмэл түүхтэй боловч Гегель нэгэнтээ ...“Хятадын түүхийг монголчууд бичүүлсэн” хэмээн тэмдэглэсэн удаатай. Хятад өөрийгөө “дундад улс” хэмээн нэрлэдэг нь чухамдаа Евразид эзэнт гүрэн болж тэргүүлэх гэсэн алсын хараа билээ. Харин орчин үед хятад хүмүүсийн үндэсний үзэл зөвхөн нийгмийн хүрээнд шинээр төрж байгаа нэвчилт бус, харин тэдний өөрийнхөө онцгойрлоо таних хандлага, тэрбум гаруй хүний сэтгэлийн хөөрөл болоод байна. Энэ бүхэн Хятад дэлхийн харилцааны төв хэсэг болохыг цохон тэмдэглэж, үүнд нь үндэсний эв нэгдэл чухал болохыг дахин, дахин нотолж байгаа билээ. Дундад улсын нутагт нэгэн цагт монголын Юань гүрэн хүчирхэгжиж байсан юм. Тэр бээр “торгоны зам”, “цайны зам”-аар европыг хүртэл худалдаа хийж, худалдааны хөлгүүд нь далай тэнгист хөвж байв. Тиймээс Хятад бол худалдаа, арилжааг эрхэмлэдэг, олз ашгаа түүгээр олдог түүхэн уламжлалтай орон юм.

Харин түүний түүхийн сүүлчийн 150 жил Хятадыг гутаан доромжилсон үе байсан бөгөөд түүний сэтгэлийг Их Британи, Япон, Орос, Америк-Их Британи зэрэг орнууд тодорхой үйлдлээрээ шархлуулж байсан юм. Тэдгээрийн заримынх нь үйлдлийн хариуг зохих ёсоор өгсөөр ирсэн байна. Харин Орос, Япон, АНУ зэрэг орон түүнийг бүс нутгийн хийгээд бөмбөрцгийн гоц их гүрэн болоход нь өнөө хэр саад учруулсаар байна. Харин Хятадын шинэхэн түүхийн эхний зуун шинэ хуудсаа эргүүлсээр, энэ улс хүчирхэгжсээр байна.

Гэвч өнөөгийн БНХАУ хөгжин бэхжиж хэмжээгээрээ АНУ-ын дараа орох дэлхийн хоёрдох том эдийн засагтай орон болсны дээр, технологи, цэргийн хүч чадлын хувьд хүчирхэг гүрэн болж байгаагийн нэг нь цөмийн зэвсэг эзэмшиж байгаа явдал юм. Тэр бээр сансар судлал, холбоо харилцаа, мэдээллийн технологийн салбарт амжилт олсоор, ялангуяа, хиймэл оюун ухааны салбарт өрсөлдөгчөөсөө илүү гарах магадлал өндөртэй боллоо. Үүнд нь хятад хүний эв нэгдэл нэн чухал үүрэг гүйцэтгэж байгаагийн дотор дэлхий даяар, түүний дотор хөгжилтэй орнуудад тархан суурьшсан төрөл бүрийн мэргэжлийн хятадууд онцгой үүрэг гүйцэтгэж байна. Дэлхий дахинаа үүнийг “чимээгүй түрэмгийлэл” хэмээн нэрлэх хандлагатай боллоо.

Геостратегийн хувьд тус улс хөрш улсуудтайгаа нутаг дэвсгэрийн маргаан олонтой ч түүнийг зохицуулах гэж яарахгүй байна. Тэр бээр далайн тээвэрт нь тавьдаг АНУ-ын хяналтаас гарахын тулд хуучны торгоны замаа сэргээх хүсэлтэй байгаа ба үүний тулд “Нэг бүс, нэг зам” төслийг хэрэгжүүлж хуурай замаар Европ хүрэх зургаан хонгил бий болгох стратеги баримталж байна. Энэ бүхнийг АНУ зүгээр хараад суухгүй байгаа бөгөөд одоогоор Хятадтай худалдааны дайн өрнүүлж байна. Орос-Хятадын харилцаа улс төр, эдийн засгийн түвшинд өндөр байгаа боловч хоёулаа Евразийн төлөөх далд өрсөлдөгч нар билээ. Түүний зэрэгцээ Энэтхэг бол түүний бүс нутгийн их гүрэн болоход нь сөргөөр нөлөөлж чадах цорын ганц ардчилсан улс болж байна. Европт түүний эдийн засгийн нөлөө улам нэмэгдэж, далайн боомтоос эхлээд геополитикийн чухал чухал цэгүүдэд хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлсээр байна.




**Зураг 2.** Хятадын нөлөөллийн бүс (Збегнпев Бзжинский Grand Chees Board)

Дүгнэж хэлбэл, Хятад бол Евразийн эзэнт гүрэн болохын төлөө өрсөлдөгчийн нэгээр барахгүй, үүний тулд “зөөлөн хүч”-ээ, эдийн засгийн эрхшээлтэй хослуулан хэрэглэж чадах цорын ганц орон болж байна. Үүний эхний алхам нь өөрийнхөө нөлөөллийн бүсийг өргөтгөхөд оршиж байна. Ши Зиньпиний үед хятадын дипломат бодлого нь хариу үйлдлийн хандлагаас аажмаар холдож

илүү идэвхтэй болж ирсэн. Бээжин хоёр талын болон олон талт түвшинд янз бүрийн санаачилга дэвшүүлэх нь олшрох бөгөөд “зөөлөн хүчний” арга хэрэглэн Хятад бол олон улсын тавцан дээрх хариуцлагатай тоглогч гэсэн дүр төрхийг бүрдүүлэх хүсэл эрмэлзэл нь улам тодорхой харагдаж болсон. Үүний зэрэгцээ, дипломат үйл ажиллагаа нь урьдын адил дотоод зорилтуудыг шийдвэрлэхтэй холбоотой байх бөгөөд хятадын удирдагчдын зүгээс гадаад харилцаа холбоонд тавих анхаарлын түвшин нь дотоод тогтвортой байдлаас шууд хамааралтай байна.

Эдийн засгийн дипломат бодлогыг нийгэм-эдийн засгийн хөгжлийн (эрчим хүчний аюулгүй байдал, хүнсний аюулгүй байдал зэрэг) асуудлуудаас гадна нөхөрсөг түнш орнуудын сүлжээ буюу даян дэлхий дэх хятадын нөлөөг цаашид бэхжүүлэх түшиц газар бий болгоход ашиглах бололтой.

Гадаад бодлогын үйлдлийн эрсдэлийн үнэлгээ нь аливаа шийдвэр гаргахад заавал мөрдөх зарчим байх болно. Гадаад бодлогын шинжээчийн илүү үр нөлөө бүхий тогтолцоог бий болгох явдал гол чухал зорилтуудын нэг байх болно. Үүнд нийгмийн ухааны салбарт үзэл суртлын хяналт, ялангуяа “олон нийтийн чиг шугамыг мөрдөх” кампанит ажил зарласны дараа улам хүчтэй болж байгаа нь тодорхой тогтоон барих хүчин зүйл байж болох юм.

Ойрын жилүүдэд, Хятад улсын шинэ даяар үүрэгт тохирсон гадаад бодлогын аппарат бий болгоход гол анхаарал хандуулах болно. Үндсэн зарчмууд (бусад орны дотоод хэрэгт үл оролцох, эвсэлд үл нэгдэх гэх мэт) хамгийн тогтвортой байх бөгөөд чингэхдээ бүс нутаг болон улс орнуудын тэргүүлэх ач холбогдлыг тодорхойлоход хамгийн уян хатнаар хандах төлөвтэй байна.

2014 онд үйл ажиллагаагаа эхэлсэн Улсын аюулгүй байдлын Зөвлөлийн (*албан ёсны мэдээллээр, Зөвлөлийн анхны хуралдаан 2014 оны 4 дүгээр сарын 15-нд болсон бөгөөд Ши Зиньпин даргалсан байна) анхаарлын төвд уламжлалт болон уламжлалт бус аюулгүй байдлын салбарт учрах аюул заналтай холбоотой бүхий л асуудал хамаарах ажээ. ҮАБЗ байгуулагдсан нь гадаад бодлогын салбарыг оролцуулан удирдлагын хатуу чанд төвлөрөлтийн үйл явцын илрэл болно. Ингэснээр салбар хоорондын салангид байдлыг арилгаж, олон тооны яам, газруудын үйл ажиллагааг Хятадын дотоод ба гадаад аюулгүй байдлыг цогцоор хангах цор ганц зорилгод захируулах ажээ.

**Хятадын геополитикийн гол зорилго.**

XXI зуун гарсаар дэлхийн их гүрнүүдийн дундаас БНХАУ аажмаар товойн тодорч, улмаар давамгайлах төлөвтэй болж байгааг олон улсын судлаачид хүлээн зөвшөөрөх болсон. Ялангуяа “Бүс ба Зам” хэмээх санаачилгаа тунхаглаж “Торгоны замаа” дахин сэргээх үйлстээ идэвхийлэн, мэдэгдэхүйц “түрэмгийлэн” орж байгаатай үүнийг холбон тайлбарлах болоод байна.

Хятадын геополитикийн энэ гол зорилго нь янз бүрийн шинж чанартай эдийн засгуудыг аажмаар, үе шаттайгаар өөрчлөн шинэчлэх зорилго бүхий тусгай бүсүүдийг тив дэлхий, далай орчмын бүс нутгуудад байгуулахад чиглэж байна. Ингэхдээ “Шинэ торгоны зам”, “Далайн торгоны зам” зэрэг нэр томьёог ашиглаж байна. Коммунист Хятад улсын орчин үеийн нүүр царай нь хуучны колони Хонконг биш, харин эдийн засаг, технологийн хөгжлийн Пудонг төвтэй бүс эрчимтэй хөгжиж, дэлхийн болон Азийн санхүү-эдийн засгийн шинэ төв бүрэлдэн бий болж буй Шанхай болох ёстой гэж Хятадын эрх баригчид үзэж байна.

“Гадагш алх” хэмээх геополитикийн стратегид Бээжингийн гол холбоотон бол Хятад-Эх газар, Хятад-Арал (Тайван, Хонконг, Сингапур), Хятад-Цагаачид гурваас бүрддэг Их Хятад хэмээн нэрлэгддэг дэлхийн хятад үндэстний хамтын нийгэмлэг юм. Өөрийн эдийн засгийн хүчин чадлаараа (ДНБ, худалдан авах чадварын тэнцлээр тооцсон) энэхүү төр улсын дээр орших байгуулал буюу Өрнөдийнхний үл ойлгох үндэстэн дамнасан корпораци нь АНУ-тай дүйцэх хэмжээний зүйл юм. Янз бүрийн эх сурвалжийн тооцоогоор, дэлхийд нийтдээ 300 сая хүртэлх тооны хятадын цагаачид (хужаа) байдаг ажээ. Нэг үгээр хэлбэл, Их Хятад нь геополитикийн бие даасан, томоохон тоглогч болж байгаа бөгөөд Өрнөдийн ар талд ч юм уу Евразийн орон зайн хаа нэгтээ дэлхийн шатрын хөлөг дээр мад тавих чадвартай болоод байгаа юм.

Хятадын шинэ “Торгоны зам”-ын гол утга учир нь Евразийг торлох “супер хурдны зам” байгуулах явдал агаад Хятадыг Европ, Ойрх Дорнод, Зүүн өмнөд болоод Өмнөд Азитай холбох зорилготой юм. Энэ зорилгоор Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк, Торгоны замын сан зэрэг санхүүгийн шинэ бүтцүүдийг байгуулж эхлээд байна.

Шинэ торгоны замын хүрээнд төмөр зам голлох үүрэг гүйцэтгэх болно. Хятад өөрийн төмөр замын сүлжээг эрчимтэй өргөтгөн дэлхийн хурдан галт

тэрэгний салбарт тэргүүлэгч болж байгаагийн зэрэгцээ хөрш орнууд руугаа орж байна. Үүнд, юуны өмнө Төв Азийн орнууд руу гүнзгий нэвтэрч төмөр замын шугам, авто зам, нефтийн хоолой тавих зэргээр дэд бүтцийн бүтээн байгуулалт өрнүүлэн үүнийхээ тулд олон тэрбум долларын хөрөнгө оруулалт хийж эхэллээ. Түүнчлэн хойд чиглэлээ ч анхаарч Москва-Бээжинг 7000 км урт хурдан галт тэрэгний замаар холбон эдүгээ зарцуулж буй 6 өдрийг 33 цаг болтол бууруулахаар төлөвлөөд байна[18].

БНХАУ-ын Орчин үеийн олон улс судлалын академийн дэд захирал Фу Мөнзы “Бүс ба Зам” бүтээн байгуулалтын стратеги, үзэл санаа хэмээх өгүүлэлдээ “Торгоны замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх суурь нөхцөл бүрдээд байна” гээд үүнийгээ таван зүйлээр үндэслэжээ. Үүнд:

1. Улс төрийн харилцаа бүхэлдээ сайн байгаа
2. Эдийн засгийн интеграци харьцангуй өндөр түвшинд хүрсэн
3. Тээвэр холбооны цар хүрээ анхны байдлаар бүрэлдсэн
4. Бүс ба Зам дагуух улс орнууд Хятадад итгэл найдвар тавьж байна
5. Хятад улсад торгоны замыг бүтээн байгуулах материаллаг нөхцөл боломж нэгэнт бүрдээд байна[19] гэжээ.

Хэрэв энэ “төмөр замын довтолгоо” нь амжилттай болбол “тив дамжсан төмөр зам... эх газрын гүрэн хүчний нөхцөлийг өөрчлөх бөгөөд Евразийн тэр хаалттай голт зүрхэнд хаанаас ч, хэнээс ч илүү нөлөөлөх болно” хэмээн Макиндэрийн зөгнөснийг нотлох бөгөөд өөр үгээр хэлбэл “эцэс төгсгөлгүй тээврийн хэлхээсэн систем” (seamless transportation system) буй болж Хятад өөрөө **“**тэрхүү бүрэлдэн өсөж буй Евразийн хэлхээ холбоосны гол цөм **/** “principal hub of an emerging Eurasian connectivity web”/ нь болно гэж ойлгогдож байна. Ийм эх газрын сүлжээнд америкийн гар төдийлөн хүрээд байхгүй гэж үзэж болох бөгөөд

[18] Хятадаас Европ хүртэлх бараа тээвэрлэхэд далайгаар 45 хоног, Транс-Сибирийн төмөр замаар тээвэрлэхэд 18-20 хоног, Лианюнган-Хамбургийн чиглэлээр тээвэрлэвэл 11-13 өдөр шаардагдана. (Central Asian Regional Economic Cooperation, 3rd CAREC- Federation of Carrier and Forwarder Associations (CFCFA) Annual Meeting, Day 1, presentation by I.Segal.
Түүнчлэн Хятадын Гуанжоугаас бараа ачсан галт тэрэг Евразийн нутгаар дайран 18 хоногийн дотор Москвад хүрч буй нь Хонг Конгоор дамжин өмнөд Хятадын тэнгисээр дайран Владивосток хүрээд, тэндээсээ Москва руу галт тэргээр тээвэрлэснээс хоёр хоногоор хурдан хүрэх юм. Мөн Донггуан-Шинжаан-Казакстан гэх өөр нэг төмөр замын маршрут бий болсон нь Хятадыг Төв Ази, Европтой холбох гарц болж байна. Мөн түүнчлэн Хятад- Оросын консорциум Москва Казанийг холбосон 770 км өндөр хурдны галт тэрэгний замын судалгаа, суурь бүтээн байгуулалтын санхүүжилтэд зарцуулах 380 сая долларын гэрээ байгуулахаар болжээ.
[19] Fu Mengzi, Strategic Concept on Constructing One Belt One Road, Mongolian Journal of Strategic, №67 (3/2014)

эдүгээ АНУ-ын тэнгисийн цэргийн хүчин дэлхийн далайн тээврийн бүхий л чиглэлийг хянаж, чухамдаа далайгаар ихэнх бараагаа тээвэрлэж буй нь Хятадыг байнга түгшээж байдаг зүйл билээ.

Хятад "төвтэй" тив дамнасан төмөр замын сүлжээний зэрэгцээ Хятадын далайн боомтуудыг Евразийн өмнөд эргүүдтэй холбох "далайн торгон замын" төсөл хэрэгжиж эхлээд байна. Түүнчлэн хятадууд "умард далайн зам" буюу хойд мөсөн далайгаар ч дамжин Европ руу гарах арга замыг эрэлхийлэх болжээ.

Эдүгээ Хятад улс Торгоны замын санаачилгаа хэрэгжүүлэх зорилгоор 20 гаруй улстай гэрээ, хэлэлцээр байгуулсан[20], мөн 20 орчим оронтой тохиролцоонд хүрээд байгаа, өөр бусад 60 гаруй орон сонирхлоо илэрхийлээд байгаа юм байна.

Хятадын "Бүс ба Зам" санаачилгын хүрээнд эдийн засгийн 6 коридор байгуулахаар төлөвлөгдсөний нэлээд нь амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал:

- Хятад-Мьянмарын эдийн засгийн коридор үндсэндээ байгуулагдсан,
- Хятад-Пакистаны эдийн засгийн коридор байгуулах бүтээн байгуулалтын ажил эхэлсэн,
- Төв Азиас Хятад руу газрын тос, нефть дамжуулах хоолойнууд байгуулагдсан, Хятадыг Европтой холбосон төмөр замын 9 маршрут нээгдэн ажиллаж байна,
- ОХУ, Хятадыг зүүн талаар холбосон газрын тосны хоолой ашиглалтад орсон, хий дамжуулах хоолойг хоёр талаасаа барьж байгаа, баруун талаар газрын тос дамжуулах хоолойг барихаар тохиролцсон,
- ОХУ, Монгол, Хятадын эдийн засгийн коридорыг байгуулах талаар зарчмын тохиролцоонд хүрч, эхний ээлжид хэрэгжүүлэх 32 төслийг сонгосон, төслүүдийг хэрэгжүүлэх асуудлыг хариуцах "хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн төвийг Улаанбаатарт байгуулж байна.
- Хятадаас өмнө зүгт байгуулах эдийн засгийн коридорын ажлууд амжилттай хэрэгжиж байна.

Эдгээрээс гадна Хойд-Өмнөд тээврийн коридорыг тэмдэглэх нь зүйтэй юм. Энэ коридорыг байгуулах санаачилгыг анх 2000 онд Орос, Энэтхэг, Иран улсууд

[20]Н.Соёлгэрэл, СХХ, Евразийн бүс дэх эдийн засгийн хамтын ажиллагаа: МУ-ын оролцох боломж, Евразийн геополитик ба Монгол Улс сэдэв ЭШБХ" товхимол, 2016, х 9

гаргажээ. Үүнээс хойш Беларус, Казакстан, Тажикстан, Оман, Армени, Азербайжан, Украин, Киргизстан, Турк улсууд энэ төсөлд нэгдсэн юм. Энэ коридорын маршрут нь Энэтхэгийн Мумбай хотын Нхава Шева боомтоос Арабын тэнгисээр дамжин Ираны Бандар Аббас боомт хүрнэ. Тэндээс газраар Ираны хойд хэсэгт байрлах Бандар И Анзали боомт хүрч, Каспийн тэнгисийг гатлан Оросын Астрахань боомтоор дайран, цааш Москва хүрээд Орос, Финляндын хил дээрээс Европын орнуудад хүрнэ. Одоогийн байдлаар Мумбайгаас 20 тонны нэг контейнер Москва хүртэл Суэцийн сувгаар дайран явахад 32-37 өдөр зарцуулж, өртөг нь 2100-2800 доллар хүрдэг байна. Харин Хойд-Өмнөд тээврийн коридор ашиглалтад орсноор энэ зардал 1260 доллар болж буурах бөгөөд хугацааны хувьд 19 өдөр хүрч богиносох аж.[21] Уг коридор нь Энэтхэгийн хувьд Төв Азийн орнуудаас түүхий эд авах замыг нээж байгаагаараа, Төв Азийн орнуудын хувьд Энэтхэгийн далайд гарах гарц нээж байгаагаараа ач холбогдолтой юм.

Хятадын Евразийн бодлогод эдийн засгийн ч, геополитикийн ч ашиг сонирхол адилхан давхцаж байгаа нь ойлгомжтой. Эдийн засгийн хувьд энэхүү өргөн уудам орон зайг өөрийн удирдлага дор интеграцчилах нь Хятадад ашигтай бөгөөд харин стратегийн хувьд Хятадын хяналтад орсон Евразийн эх газар дотогшлох тусам АНУ-ын дайсагнал алсрах тул Хятадын эрх ашигт яах аргагүй нийцэх нь ойлгомжтой юм

Үүний зэрэгцээ, Евразид ноёрхох Хятадын хүсэл Оростой хамсан ажиллахгүйгээр, ядахдаа түүний хүлцэнгүй "зөвшөөрөл" үгүйгээр биелэх боломжгүй юм гэж судлаачид үзэж байна. Хэдийгээр Эзэн Хаант үе, Зөвлөлт засгийн үеийнх шигээ тэлэх чадваргүй болсон боловч эдүгээгийн ОХУ Евразийн умард хэсгийг эзлэн оршиж, Төв Ази болон Зүүн Европт нөлөөгөө хадгалсан хэвээр, өөрөөр хэлбэл "голт зүрхний газрын" амин чухал хэсгийг хянасан хэвээр байгаа. Харин цаашид Бээжингийн алсын харааг хэрэгжүүлэх "төлөвлөгөөний" замд тээг тавьж чадах эсэх нь багагүй маргаан дагуулах зүйл юм.

.Украйн, Крым зэрэг асуудлаар Өрнөдтэй сөргөлдөн эдийн засгийн хоригт өртөж, нефтийн үнийн бууралтаас болж санхүүгийн хямрал амсаж буй Орос оронд "Хятадад ойртохоос өөр зам алга". Хятад ч туслахад бэлэн, харин ямар

[21]Meena Singh Roy, International North-South Transport Corridor: Re-energizing India`s Gateway to Eurasia,
http://www.indiawrites.org/diplomacy/international-north-south-transport-corridor-re-energising-indias-gateway-to-eurasia/

үнээр вэ гэдэг асуулт буй. Тэр үнэ нь " хятадууд Оросын байгалийн баялаг, цэргийн технологийг эзэмших давуу эрх эдэлж, Төв Азийн хуучин Зөвлөлт бүгд найрамдах улсуудын эдийн засгийг Хятадын схемээр удирдахыг Москва зөвшөөрөх явдал" юм гэж судлаачид үзэж байна.

Оросын хятад судлаачид "шинэ торгоны зам"-ын эдийн засгийн ашиг тус, геополитикийн тооцоо хоёрын хэлхээсийг сайн мэдэж байгаа бөгөөд ер нь оросууд энэ санаачилгад нэлээд болгоомжтой хандаж буй аж. Тухайлбал, Дмитрий Тренины үзэж байгаагаар "Хятад, Орос хоёр... эрчим хүч, хөрөнгө оруулалт, аж үйлдвэр-технологийн талаар түншлэх болох бөгөөд ... Оросын хувьд энэ бүхний алс ирээдүйн уршиг дагавар ямар байхыг одоогоор хэн ч таах аргагүй, харин Евразийн холбооны талаар Оросын эрхэмлэн хөөцөлдөж буй элдэв төлөвлөгөө аажмаар нурж... Еврази дахин тэнцвэржиж, хүндийн төв нь Москвагаас Бээжин рүү шилжих бүрэн бололцоотой" ажээ.

**Оросын геополитикийн мөн чанар**.

ОХУ-ын геополитик П.Н.Савицкийн цохон тэмдэглэснээр, "татаргүйгээр Орос байхгүй" гэсэн түүхэн сэдвийн дор өрнөсөн юм. Тиймдээ ч "бүх дэлхийн түүхэн орон зай дахь баруун европын далай тэнгисийн мэдрэмж сэтгэгдлийн эсрэг цорын ганц бөгөөд монголоос үүсэлтэй тивийн буюу эх газрын мэдрэмж сэтгэгдлийг эрх тэгшээр сөргүүлэн тавьжээ". Тэгэхлээр, энэ нь "Орос улс бол монголын их хаадын залгамжлагч, Чингис хааны үйл хэргийг үргэлжлүүлэгч, Азийг нэгтгэгч" гэсэн мэдрэмжийг түүнд өгсөн байна. Орост түүхэн "сууриншиг"-ын тогтонги болон "тал"-ын нүүдэлчдийн гаарсан хүчнүүд жирмийн сүлжээ мэт сүлжилдэн оршиж байдаг гэсэн үзлийн дор оросын эзэнт гүрний геополитик бүрэлджээ. Ийм учраас Орос үндэстэн-төр улс болох ёстой ч өнөө хэр тэр нь бүрэлдээгүй байна. ОХУ бол оросын үндэсний үзэлд суурилсан үндэстнүүдийн нэгдэл юм (энэ нь иргэдээ орос үндэстэн гэх бус "россиянин" хэмээж байгаагаас илэрхий). Үүний улмаас ОХУ-ын Евразид ноёлох гол нөхцөлийн нэг нь эзэнт гүрэн байгуулах асуудал бөгөөд тэр нь "бүс нутгийн их гүрэн" бус чухамдаа "үндэстэн-төр улс" байхыг шаардаж байна.

ЗХУ бол тухайн цагтаа эзэнт гүрний түвшинд ойртож АНУ-ын дараа орох хоёрдох их гүрэн болж байлаа. Гагцхүү, түүнийгээ марксист-ленинч үзэл суртлаар халхлан далд үлдээж, илээр хэрэгжүүлж чадаагүй юм. Хорьдугаар зууны хүйтэн

дайнд өрнөдийн орнууд ялж, ЗХУ задарсан нь дэлхий ертөнцөд геополитикийн шинэ зорилт дэвшүүлж, нэг туйлт улс төрийн харилцаа бий болгон түүнийг АНУ эзэмших болсон билээ. Энэхүү задрал, АНУ-ын ноёрхлын улмаас ЗХУ-ыг залгамжлагч ОХУ-ын улс төр, эдийн засгийн хүч чадлыг сулруулан доройтуулж, түүнд Евразийн дундад орон зайд тэсэж үлдэх түүхэн үүрэг ноогдов. Өрнөдөөс тэнд хэрэгжүүлсэн анхны төсөл нь оросын либерал “шинэтгэгч” үзэлтнүүдээр дамжуулан Франсис Фукуямагийн “түүхийн төгсгөл”-ийг хэрэгжүүлэхийг оролдсон билээ. Александр Дугиныхаар бол энэхүү төслийн үзэл баримтлал ард түмэн, үндэстэн, түүх, геополитикийн ашиг сонирхол, нийгмийн шударга ёс, шашны хүчин зүйл гэх мэтийг үл хүлээн зөвшөөрдөг ажээ. Түүний хүрээнд бүх зүйл бодгалийг дээдлэх үзэл, хэрэглээч ёс, “чөлөөт зах зээл”-ийн хүчээр эдийн засгийн дээд зэргийн үр ашиг олоход суурилдаг билээ. Ерөнхийдөө, чөлөөт язгуур үзэлтнүүд (liberal-radicalism) ОХУ-ын орон зайд шинэ бөгөөд түүхэнд нь хэзээ ч байгаагүй, орчин үеийн Өрнөд, ялангуяа, АНУ-ын тоглоомын дүрэм, соёлын солбицлыг шингээсэн тийм нийгэм байгуулахыг хүссэн байна. Түүний эсрэг цагаан хаант оросын болон өөрчлөн байгуулалтаас өмнөх үеийн ЗХУ-ын үзэлтнүүдийн “цайвар ягаан” өнгө бүхий “үндэсний эх оронч сөрөг хүчин” тулж зогссон аж. Эдгээр хүчний сөргөлдөөн өнөө хэр үргэлжилсээр, заримдаа ОХУ-ын нийгмийн төлөвшилд саад тотгор болсоор байна.

Гэвч Орос үнэн алдартны шашны тугийн дор үндэсний үзлээр нэгдэж, язгуур либерализмын  эсрэг тууштай зогсож чадсаны үрээр сэргэн босож байна. Түүний цэргийн хүч чадал дахин хүчирхэгжиж байгааг ерөнхийлөгч В.Путиний хийсэн хэд хэдэн мэдэгдэл, Сирид явуулсан цэргийн ажиллагаанаас харж болно. Оросын эсрэг өрнөдийнхний, түүний дотор АНУ-ын авч байгаа эдийн засгийн хориг арга хэмжээ нь ОХУ Украйны Крымийг өөртөө нэгтгэж, Донбасын салан тусгаарлагчдыг дэмжиж байгаатай холбоотой боловч энэ бүхэн ОХУ-ын эзэнт гүрний санаархлыг дарах гэсэн санааг илэрхийлж буй. Гэвч ОХУ Украйнгүйгээр Евразийн бус харин Азийн их гүрэн л болох боломжтой.Түүний хувьд Герман-Оросын геополитикийн тэнхлэг Евразийн их гүрэн болоход нь голлох үүрэгтэй юм.

Тэр бээр өөрийнхөө далд нөөц баялагт найдаж, оюун сэхээрлийнхээ чадавхад итгэж буйн улмаас хэнээс ч айхгүй байгаа бөгөөд ганцаар захирах ёсыг далд хэлбэрээр хэрэгжүүлж байгаа нь эзэнт гүрнийг байгуулах найдварыг нь бататгаж байна. Ийм нөхцөлийн улмаас түүний холбоотон цөөн байгаагийн дээр төрөл бүрийн олон талт хамтын ажиллагаагаар (ЕАЭЗХАБ, ШХАБ, БРИКС)

дамжуулан холбоотноо бэхжүүлэх бодлого явуулж байна. Гэвч энэ бүхэн Евразийн геополитикийн оюун санааны тэргүүлэгч ёсны үзэл бодлын мөн чанарыг илэрхийлж чадахгүй байгаа бололтой.

Оросын ерөнхийлөгчийн оюун санааны гол номлогч В.Сурков хэдэн жилийн өмнө “Европоос салж болохгүй, Өрнөдийн баримтлах нь зүй” хэмээж байсан бол одоо тэр бээр “өрнөдийн соёл иргэншлийн нэг хэсэг нь болох гэсэн олон жилийн үр жимсгүй оролдлогоосоо салах хэрэгтэй” хэмээдэг болжээ. ЗХУ-ыг задарсны дараа өрнөдийн улс төр Москваг хэрэг дээрээ гарах гарцгүй болгож, АНУ болон түүний холбоотнуудын геополитикийн зорилтод бүрэн захирагдаж, аюулгүй байдлын өөрийн хандлагаас татгалзах, эсхүл өрнөдийг баримтлах бодлогоосоо татгалзаж ямар нэгэн өөр бодлого баримтлах гэсэн сонголтыг тулгасан билээ. Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Путин “Орос улс бие дааж тусгаар тогтносон биш л бол төр улс байж чадахгүй. Зарим нэг орон чадах л байх. Харин Орос бол үгүй” хэмээн 2019 оны хоёрдугаар сард Холбооны хуралд явуулсан илгээлтдээ цохон тэмдэглэсэн байна. Үүнээс үзвэл өөрийн гэсэн өнгө төрхтэй Евразийн төв болох чиглэлийг эргэлт буцалтгүй сонгосон байна.

ЗХУ задран унасны дараа түүний улс төрийн халааг авсан Орос улс олон улсын тавцан дээр урьдын (хуучин ЗХУ-ын) байр сууриа алдан, ДНБ-ийн хэмжээ нь ихээхэн унаж (дэлхийд тэргүүлэгч арван орны жагсаалтад сүүлийн хагаст ордог), шинжлэх ухааны түвшин бууран, стратегийн цөмийн хүч нь үлэмж хорогдон, ард түмний ядуурал, авилгийн түвшин ихээр нэмэгдэж, дэд бүтэц хуучран, дотоод эдийн засгийн системийн хямрал нүүрлэж, хүн ам зүйн ээдрээтэй байдал бий болсон хэдий ч дахин сэргэн мандаж буй их гүрэн хэмээн хүлээн зөвшөөрөгдөж байна. Орос улс тодорхой хугацаанд “их наймын” бүрэн эрхт гишүүн байсны дээр бусад хөгжиж буй гүрнүүдийн хамтаар БРИКС-ийг байгуулсан. Оросын өнөөгийн удирдлага болон ихэнх улс төрчид нэг туйлт ертөнц ба АНУ-ыг цор ганц хэт их гүрэн болохыг үл хүлээн зөвшөөрөх үзэл санааг идэвхтэй баримталдаг бөгөөд их гүрэн болох хэтийн төлөвтэй, бүс нутгийн гүрнүүд болон улс орнуудын том нэгдлүүд улам их үүрэг гүйцэтгэх хандлагатай олон туйлт ертөнц бий болгох шаардлагын тухай мэдэгддэг болно. Их гүрний статуст бараг хүрээд байгаа Хятад улс ч Оросын энэ санааг хуваалцдаг юм.

**Оросын геополитикийн гол зорилго.**

Оросууд түүхийн турш Византийн хаад, Чингис хааны түүхэн уламжлалын аль алиныг өвлөн авч Балтийн тэнгисээс Босфорын хоолой, улмаар дорно зүгт Манжуур, Номхон далайн эрэг хүртэлх нутгийг эзлэн авч Евразийн “удаах эзэнт улсыг” байгуулахыг ямагт эрмэлзэж ирсэн бөгөөд энэ эрмэлзэл нь өрнө зүгтээ Европын хүчирхэг бусад гүрний эсэргүүцэл, өмнө зүгтээ Турк, дорно зүгтээ Японы эсэргүүцэлтэй байнга тулгарч хязгаарлагдаж ирсэн түүхтэй. Оросын цагаан хаадыг залгамжилсан ЗХУ Евразийн гэхээсээ илүүтэйгээр бүх дэлхийг хамрах ангийн тэмцлийн үзэл суртлынхаа улмаас үүнийгээ гүйцэлдүүлэх гэсэн үл бүтэх глобал зорилго, эрмэлзэл тээж эцэстээ түүнийгээ даалгүй задарсан. Эдүгээ “Евразийн эзэнт улсын” өөрийн хувилбарыг хэрэгжүүлэх бололцоо Хятадад илүү “амтагдах” болж, үүнийгээ хэрэгжүүлэх арга зам нь оросынх шиг цэрэг зэвсгийнх бус, харин эдийн засгийн хүчин чадал нь болж байна хэмээн судлаачид бичиж байна.

Путины дэвшүүлсэн ОХУ төвтэй “Евразийн Их түншлэл” гэгч нь мөн л түүхэн уламжлалд тулгуурласан боловч түүнийгээ урагшлуулах, гүйцэлдүүлэх эдийн засгийн хүчин чадал мөхөсдөх тул урьдын адил цэрэг, зэвсгийн хүчин чадлаа зузаатгахад тулгуурлах оролдлого хийж байгаа нь тодорхой юм.

Эдийн засгийн эрчимтэй хөгжилд тулгуурласан Хятадын геостратегийн бодлогоос ялгаатай нь Орос улс цэргийн хүчийг гол болгон ашиглаж байна. Өнөөгийн байдлаар тухайн улс нь чухам ямар гүрэн болох нь тодорхойгүй байна. Энэ нь Герман улс тэргүүлсэн Европын Холбоо эсвэл Бразил тэргүүтэй Меркосуртай төстэй, Орос төвтэй улс төр, цэргийн хатуу интеграцийн бүс ч байж болно. Гэхдээ Оросын энэ эрмэлзэлд Төв Ази, Монгол, Алс дорнодод өөрийн ноёрхлоо дахин сэргээх гэсэн Бээжингийн уламжлалт далд санаархал саад болж магадгүйг үгүйсгэх аргагүй юм.

Оросын манлайлал дор Евразийг нэгтгэх гэсэн Москвагийн хүчин чармайлтыг АНУ “дургүйцэн харж”, тэр ч бүү хэл “аюул заналын” хэмжээнд үзэж байгаа нь ойлгомжтой зүйл юм. Макиндерийн үед Их Британи Оросын тэлэлтийг тогтоохыг хичээж байсны нэгэн адил эдүгээ АНУ-ын хувьд Азийн улс орнуудын хагас, хугасыг ч болтугай тогтоон барих явдал стратегийн нэн чухал зорилт болж байна. Гэтэл Азид Орос, тэгээд Хятадаар манлайлуулсан улс төр, цэрэг, эдийн засгийн дэг журам буй болохоос зайлсхийхийн тулд Вашингтоны дэвшүүлж ирсэн

санал санаачилга, авч ирсэн арга хэмжээнүүд нь төдийлөн амжилттай болохгүй байгааг судлаачид бас тэмдэглэж байна. Тухайлбал, Номхон далайг дамнасан түншлэл (TPP) нь ахиц муутай, эцэс төгсгөлгүй маргаан дагуулсаар явж байгаад төгсгөл болж, Төв Азийг Афганистанаар дамжуулан Өмнөд Азитай холбохоор дэвшүүлсэн санаачилга нь явсангүй. Стратегийн хувьд Энэтхэгийг Хятадын эсрэг сөрөх гол хүчин болгох гэсэн оролдлого нь ч бүтэхгүй бололтой байна.

Оросын улс төрийн нөлөө, цэргийн хүч чадал тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа хэдий ч Евразийн шинэ гүрэн төрөн мэндэлж буйг зарлан тунхаглахад эрт байгаа юм. Макиндерийн эриний алдаа, сургамжийн жишээг энд дахин дурдах нь зөв байх. XX зууны эхэнд АНУ-ын зэрэгцээ Оросын эзэнт гүрэн дэлхийн агуу их гүрэн болох замдаа нэгэнт орсон гэж дотоодод ч, гадаадад ч итгэж байв. 1907 онд Оросын өөрчлөн шинэчлэгч ерөнхий сайд Петр Столыпин, агуу гүрэн болохын тулд Орос оронд "хорин жилийн дотоод, гадаад энх амгалан" хэрэгтэй гэсэн алдарт үгээ хэлсэн байдаг. Гэтэл 1911 онд радикал социалистууд Столыпиний амийг хороосноор Оросын энэ их эрмэлзэл бүтэлгүйтэж эхэлсэн билээ. 1914 онд Орос орон Балканы мөргөлдөөнд татагдан орсноор Дэлхийн I дайн эхэлсэн нь үүнийг түргэтгэж улмаар 1917 онд Оросын эзэнт гүрэн нуран унасан юм.

Үүнтэй төсөөтэйгөөр эдүгээгийн Орос улсад ч түүний цэрэг, зэвсгийн эрчимтэй өсөлтийг таслан зогсоож болох дотоод ба гадаад асуудлуудтай тулгарах эрсдэл нүүрлээд байна. Тэр ч байтугай ирэх арваас арван таван жилийн хугацаанд дотоод тогтвортой байдлаа хадгалан гадаад ноцтой аюулаас зайлсхийх нь Москвагийн хувьд Евразид өөрийн толгойлсон их гүрэн байгуулах гэсэн том мөрөөдлөөс нь ч илүү амин чухал зорилт байж болох юм.

**ОХУ-ын геополитикийн талаарх зарим нэг эргэлзээтэй зүйл.**

Бид даяаршиж буй энэ дэлхий ертөнц дээр юу болж байгаа, хүн төрөлхтний жам ёсны хөгжил хаашаа явж байгааг тунгаан бодох, энэ хүрээнд ОХУ дэлхий ертөнцөд ямар байр сууриь эзэлж, дэлхийн хөгжлийн тулгуур болсон том гүрнүүд болон хөгжиж буй бусад орон, түүний дотор хуучин ЗХУ-аас хараат байсан байдлаасаа салах гэж чармайж буй улс орнууд түүнд хэрхэн хандаж байгаа, ялангуяа энэ улс гүрэн юу руу тэмүүлж, юунд хүрэхийг чармайж буйг бас тунган бодох учиртай юм.

Энэ үүднээс ОХУ-ыг хэдийгээр урьд өмнийн их гүрний эдийн засгийн болон, оюуны өндөр чадавхаа тодорхой хэмжээгээр хадгалан үлдсэн, хүний хүчин зүйлийн болон байгалийн баялгийн асар их нөөцтэй боловч улс төрийн байгуулалт, эдийн засгийг төрөөс удирдах арга барилын хувьд цаг үеэсээ ихээхэн хоцорсон, бусад улс орон ялангуяа хил залгаа, урьд нь харьяанд нь болон хараанд нь байсан улс орнуудын хувьд ихэвчлэн хүчээр түрэмгийлсэн, тулгаж тунирхсан бодлого явуулдаг, үүнээсээ болоод олон улсын тавцанд нэлээд хэмжээгээр ганцаардах талдаа орсон орон гэж олон улс орон үздэг болохыг бид бас тооцох ёстой байж болох юм.

Үүнийгээ нөхөхийн тулд олон улсын харилцаанд их гүрний дээрэнгүй гэж хэлж болох бодлогоо үргэлжлүүлэхийг санаархах, эдийн засгийн гол салбаруудаа төрийн монополийг сэргээх зэргээр олон улсын эдийн засаг, зах зээлийн харилцаанд төдийлөн зохицохгүй бодлого явуулах, хувийн өмчийн том компаниуд нь үндсэндээ 1990-ээд оны замбараагүй хувьчлалаар бараг луйврын аргаар улсын өмчийг үнэгүй шахам авах замаар байгуулагдсан, дээр нь түүхий эдийн гадагшаа чиглэсэн асар их урсгалыг далд эдийн засгийн аргаар бий болгож хэмжээлшгүй их хөрөнгө мөнгийг гадаадын банкнуудад төвлөрүүлсэн, энэ бохир мөнгөө хөгжиж буй орнуудын эдийн засагт хөрөнгө оруулалт хийх, дэмжих туслах нэрээр угаах, түүнчлэн эдийн засагт үр ашигтай ажиллах арга барилд суралцахын оронд аль болох сүрдүүлэх, боож хяхах аргыг өргөн хэрэглэдэг орон гэж гадаадын нэр хүнд бүхий олон эрдэмтэд, шинжээчид, олон улсын байгууллагууд дүгнэх болсныг бас анхаарах нь зөв юм.

ЗХУ задран унахын хамт алдсан олон улсын байр суурь, үүргээ сэргээх, өөрийн геополитикийн ашиг сонирхлын орон зайг болж өгвөл тэлэх, үүний тулд эхлээд ОХУ-ын дотоод нэгдлийг баталгаажуулах, дараа нь ТУХН, юуны өмнө Аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын гэрээний орнуудын хүрээнд цэргийн эвсэл холбоо байгуулах, улмаар ШХАБ-ын тусламжтайгаар НАТО-гийн тэлэлт болон Зүүн Азийн өндөр хөгжил бүхий орнуудын нөлөөг хязгаарлах орон зай бий болгох зорилго бүхий бодлого явуулж байгаа нь бас тодорхой байна. Чингэхийн тулд батлан хамгаалах хүчнийхээ гадагшлах чадварыг бэхжүүлэх, шинээр зэвсэглэхэд асар их хөрөнгө зарцуулах болсон нь хүн амын амьжиргааны түвшнийг сайжруулах зэрэг нийгэм-эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна Энэ үндсэн дээр ОХУ-ын дотоод

нэгдэл, улс төрийн тогтвортой байдлын цаашдын төлөв тэдийлэн тодорхой бус байна гэж үзэж болно.

Эцсийн дүндээ ОХУ өөрийн геополитикийн ашиг сонирхлын орон зайг болж өгвөл тэлэх, үүний тулд эхлээд ОХУ-ын дотоод нэгдлийг баталгаажуулах, дараа нь ТУХН, юуны өмнө түүний Аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагын гэрээний орнуудын хүрээнд цэргийн эвсэл холбоо байгуулах, цаашдаа ШХАБ-ын хүрээнд НАТО болон Зүүн Азийн өндөр хөгжил бүхий орнуудын нөлөөг хязгаарлах орон зай бий болгох зорилго бүхий бодлого явуулж байгаа нь бас тодорхой байна.

**Америкийн геополитикийн мөн чанар.**

АНУ-ын Евразийн геополитик нь түүний дэлхийн бөмбөрцгийг тэргүүлэх байр суурь (global primasy)-тай холбоотой бөгөөд АНУ-ын тэргүүлэх байр суурийн улс төр, эдийн засгийн бодлоготой арсалдаж чадах бүх далд чадал зөвхөн Евразиас гарна гэж үздэг. Евроазийн хүч чадал АНУ-ын хүч чадлыг өргөн хүрээнд сүүдэрлэх чадвартай юм (Г.Бзжинский). Үүнээс үүдээд АНУ Евразийн бүх хэсэгт нэгдмэл, өргөн хүрээтэй, урт хугацааны геостратеги хэрэгжүүлж байна. Үүнийгээ Америк өөрөө өнөөг хүртэл бөмбөрцгийн цорын ганц гоц хүчирхэг гүрэн, харин Евразийг дэлхийн төв тайз гэж үзэх суурь бодит байдлаас ургуулан гаргажээ. Тиймээс Еврази тив дэх хүчний хуваарилалт Америкийн дэлхийг тэргүүлэх байр сууринд шийдвэрлэх үүрэгтэй юм. Америкийн тэргүүлэх байр суурийг унгах нь дэлхий дахинаа олон улсын засаг замбараагүй байдал (anarchy) бий болгоно хэмээн тэд үзэж байгаагаас АНУ бол дэлхийн “зайлшгүй хэрэгтэй” үндэстэн гэдэг тодорхойлолтыг ерөнхийлөгч Клинтон өгсөн билээ. Зайлшгүй хэрэгтэй чанар болоод засаг замбараагүй байдлын нэн чухал талыг цохон тэмдэглэж болох олон жишээ бий. Хүн амын хэт өсөлт хяналтаас гарах, ядуурал, орон нутгийн дайнаас үүдсэн дүрвэгсдийн асуудлыг зохицуулах, үй олноор хөнөөх зэвсгийг түгээн дэлгэрүүлэхийг хориглох зэрэгт АНУ бодитой нөлөө үзүүлж чадна хэмээн үздэг аж. Түүнээс гадна, тус улс эдийн засгийн хүч чадлаар дэлхийн цорын ганц гоц орон байхын тулд аж үйлдвэрлэл, цэргийн үйлдвэрлэлийн цогцолборыг хөгжүүлэх шаардлагатай болдог бөгөөд түүний дийлэнх нөөц Евразид хадгалагдаж байна.

**Америкийн геополитикийн гол зорилго.**

АНУ-ын геополитикийн богино хугацаанд тавих зорилт бол Евразийн тивд геополитикийн олон ургалч үзэл (pluaralism)-ийг тогтоож түүнийг тогтворжуулах

явдал хэмээж байгаа бол дунд хугацаанд тивийн хэмжээнд найдаж болох нэн чухал боловч стратегийн хувьд нийцтэй түнш бий болгох замаар Транс-Евразийн аюулгүй байдлын тогтолцоо байгуулахыг зорьж байна. Харин урт хугацаанд өнөөгийн тэргүүн эгнээнд тавьж байгаа зорилтууд жинхэнээсээ дэлхий нийтээрээ хуваалцдаг улс төрийн хариуцлагын бөмбөрцөг дахины бодлогын үндэс болох шатандаа орох болно хэмээн найдаж буй.

Гэвч, Евразийн тив дээр АНУ-ын тэргүүлэх байр суурь энэ тивд болж байгаа улс төрийн үйл явдлын салхины хуйлралд ганхаж байна. Хэдийгээр АНУ Евразийн их, бага гүрэн, улсуудын хооронд тогтвортой харилцан ойлголцол, нэгдмэл үзэл баримтлал бий болгох боломж хамгийн бага хэмжээнд байдгийг өөрийнх нь талд байгаа давуу тал гэж үздэг ч энэ тивийн хэд хэдэн орон, улс хүчирхэгжиж байгаа нь түүний санааг зовоож байна. ОХУ зэвсэглэлийн хувьд АНУ-тай өрсөлдөхүйц болж, түүний эдийн засгийн хориг саадыг хэрэгсэхгүй байгаа нь дэлхий дахинаа АНУ-г үл тоох хандлага даамжирч, тэр ч бүү хэл АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуульд нөлөөлнө хэмээн айж байна. БНХАУ-ын эдийн засаг АНУ-ын дараа орох хэмжээнд хүрсэн, Европын орнуудтай харилцаагаа бэхжүүлж, АНУ-ын далайн замд тавих худалдааны хяналтаас гарах гэж байгаа оролдлого нь Хятадын эдийн засгийн хөгжилд туслах замаар түүнийг хянаж байсан механизмыг сулруулж, цэргийн хүчээ хяналтгүй зузаатгах боломжийг БНХАУ-д олгож байна. Дэлхийд ардчилсан орон гэж тооцогддог Энэтхэг улсын хүн ам, эдийн засгийн хүч чадал, технологи, цэргийн ажиллагаа явуулах чадвар АНУ-ын нүдэн дээр өсөж, түүнд өөрийн геостратегийн бодлогыг нялзааж чадахгүй байна.  Гэтэл, АНУ дэлхийн цорын ганц гоц хүчирхэг гүрэн хэвээр байж л Евразийн геополитикийн стратегийн зорилгоо биелүүлж чадах юм.

Ийнхүү бүрэлдэн тогтож байгаа геополитикийн шинэ бодит байдлыг америкийн геополитикчид үнэн хэрэгтээ хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болоод байна. Нэгдсэн улсын статуст их ойртож байгаа Европын Холбоонд АНУ нэлээд хүйтэн ханддаг. Дэлхийн цорын ганц валют байсан доллартай ширүүн өрсөлдөх болсон евро хэмээх нэгдмэл валютын улмаас уг холбоог их гүрэн болох хэтийн төлөвөө бүрдүүлж байгаа гэж үздэг. XXI зууны эхэнд хэт их гүрний статуст де-факто ойртсон Хятад улс руу АНУ-ын геополитикчид онцгой анхаарал хандуулах болсон. АНУ ба Хятад улсаас бүрдсэн хэт их гүрний  “Их хоёр”-г байгуулах санааг америкийн нэгэн албан байгууллага БНХАУ-ын удирдлагад хандан 2010 онд, илэрхийлсэн боловч энэ нь юуны өмнө энэ улстай тэр болгон санал нийлээд

байдаггүй хятадуудаас үүнийг америкийн гадаад бодлогын үйл ажиллагааны төлөө хариуцлага хуваалцах оролдлого хэмээн үзэж уг саналаас татгалзаж, олон туйлт үзэл баримтлалдаа үнэнч хэвээр үлдсэн билээ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ.
## АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД ОРЧИНД НӨЛӨӨЛЖ БУЙ ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛС: МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ,

### 2.1. Аюулгүй байдлын гадаад орчинд нөлөөлж буй үндсэн хүчин зүйлс

#### 2.1.1. Зүүн хойд Ази ба Орос, Хятадын хүчин зүйлс.

Шинээр бий болсон геополитикийн ийм орчинд оршиж байгаа Монгол Улсын хувьд үндэсний аюулгүй байдлаа сахин хамгаалах хүндхэн бөгөөд нэн чухал зорилт тулгараад байна. Монгол Улс өөрийн оршин тогтнох гадаад болон дотоод үндсэн орчныг үндсэн дөрвөн зорилтоор шийдвэрлэхээр эрмэлзэж байгаа юм. Үүнд:

- Дэлхийн цорын ганц хэт том гүрэн хэвээр байгаа АНУ-ын дэмжлэгтэйгээр Зүүн Хойд Азид орших энэ улсын холбоотнуудын геополитикийн хүч чармайлтад хавсарга болох;
- Хүчиндээ хэт итгэж, дэлхийд ганцаардмал болж буйн улмаас холбоотны эрэлд гарсан цэргийн хүчирхэг гүрэн ОХУ-тай хуучин нөхөрлөлөө санаж, түүнд найдах;
- Дэлхийн усан замын харилцааны хяналтаас гарч, Евразийн бүс нутагт хуурай замын харилцаа хөгжүүлэх замаар өөрийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эдийн засгийн харилцаанд нь байгаа саад бэрхшээлийг арилгахыг зорьж буй манай өнө эртний түүхэн хөрш, бас эргэлзээ, тээнэгэлзээний сурвалж болох БНХАУ-ын бодлогыг дэмжих;
- Бие дааж аюулгүй байдлаа хангах зэрэг болно.

**Зүүн Хойд Азийн хүчин зүйл.**

Ìîíãîë Óëñûã õ¿ðýýëñýí îðîí çàéä “x¿éòýí äàéí”-ààñ õîéø ãàðñàí ýðñ ººð÷ëºëò, олон улсын аюулгүй байдлын öààøäûí õàíäëàãà íü áèäíèéã èðýýä¿éí õºãæèë, àþóëã¿é áàéäëûí àñóóäëàà Ç¿¿í Хойд Азид òóëãóóðëàí àâ÷ ¿çýõýä хүргэсэн билээ. ¯¿íýýñ ¿¿äýí ÇÕÀ-ä ¿¿ñ÷ áèé áîëñîí ãåîïîëèòèê, ãåîñòðàòåãèéí орчинд Ìîíãîë Óëñûí ýçëýõ áàéðûã çºâ òîäîðõîéëîõ íü ìàíàé õºãæëèéí òóëãàìäñàí ÷óõàë àñóóäàë áîëæ áàéíà. Манай улсад Îðîñ, Õÿòàäààñ ãààíà ÀÍÓ, Ç¿¿í Хойд Азийн áóñàä îðîíòîé

èäýâõòýé, найрсаг, õàðèëöàí àøèãòàé õàìòðàí àæèëëàõ øààðäëàãà áèé áºãººä ¿¿íèéã àëü õýð óõààëàã, îíîâ÷òîé, àëñûí õàðààòàé øèéäâýðëýæ ÷àäàõààñ ìàíàé улсын аюулгүй áàéäëûí èðýýä¿é хамаарах болно.

Ç¿¿í Хойд Àçèèéí á¿ñ íóòàãò ãåîïîëèòèêèéí áîëîí ãåîñòðàòåãèéí àñàð èõ õóâüñàë ãàð÷ áàéíà. Ýíý á¿ñ íóòàãò  ÀÍÓ, Õÿòàä, ßïîí, Îðîñ çýðýã äýëõèéí òîì ã¿ðí¿¿ä, ýñýë á¿ëã¿¿äèéí ýðõ àøèã õàðèëöàí ñîëáèëöîæ, çàðèì òîõèîëäîë õàðèëöàí çºð÷èëäºæ áàéíà. ªìíºõ ò¿¿õýýñ óëàìæëàãäñàí ¿íäýñòýí óãñààòíû çºð÷èë, ãàçàð íóòãèéí ìàðãààí, õóâààãäìàë байдал, áèå áèåäýý ¿ë èòãýõ ÿâäàë ýíý á¿ñ íóòàãò õàäãàëàãäñààð áàéíà. ¯¿íèé ñàöóó äýëõèéí õºãæëèéí òºâ Àçè-Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàã ðóó аажмаар øèëæèæ , ýäèéí çàñãèéí “Ç¿¿í Àçèéí çàãâàð” ýð÷èìæèæ áàéãàà íü ýíý á¿ñ íóòãèéí ¿¿ðýã ðîëèéã óëàì á¿ð íýìýãä¿¿ëæ áàéíà.

Õýðýâ Õîéä Ñîëîíãîñûí öºìèéí õºòºëáºðèéí àñóóäëûã эс òîîöîõ áîë Ç¿¿í Хойд Азид îëîí óëñûí àþóëã¿é áàéäàë îãöîì õ¿íäðýõ, òîìîõîí çºð÷èë ñºðãºëººí ¿¿ñýõ ìàãàäëàë áàãà юм. Хэдийгээр “Õ¿éòýí äàéí” энэ бүс нутагт гүн гүнзгий хагарал үүсгэсэн боловч 90-ээд оноос àþóëã¿é áàéäëûí îð÷èíä õ¿÷íèé òýíöâýð àëäàãäàõàä õ¿ðãýñýí íöòîé ººð÷ëºëò ажиглагдахгүй байна. Харин Европын адил íèéòëýã байдал Ç¿¿í Хойд Азид бий болтол нэлээд удаан хугацаа шаардагдах нь бас тодорхой байгаа юм.

Ìîíãîë Óëñûí ãàäààä áîäëîãûí ¿çýë áàðèìòëàëä Орос, Хятадын зэрэгцээ “Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа  хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох”  нь манай улс төрийн гадаад харилцааны нэг үндсэн чиглэл байхаар заасан билээ.

Үүний äàãóó Ìîíãîë Óëñ Ç¿¿í Хойд Азийн óëñ îðíóóäòàé õî¸ð òàëûí õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã идэвхтэй õºãæ¿¿ëýõèéí ñàöóó á¿ñ íóòãèéí îëîí òàëò õàìòûí àæèëëàãààíû àñóóäàëä à÷ õîëáîãäîë ºã÷, ºíãºðñºí õóãàöààíä энэ бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлын асуудлаар óëñ òºðèéí ÿðèà õýëýëöýýíèé ìåõàíèçì áèé áîëãîõ, ýäèéí çàñãèéí õàìòûí àæèëëàãààíû á¿òýö á¿ðä¿¿ëýõýä ÷èãëýñýí хүчин чармайлтад èäýâõòýé оролцож èðëýý.

**Орос, Хятадын хүчин зүйл.**

1960-ààä îíîîñ ýõýëñýí õóó÷èí ÇÕÓ, ÁÍÕÀÓ-ûí ñºðãºëäººíèé õ¿ðýýíä Ìîíãîë Óëñ òóñ õî¸ð èõ ã¿ðíèéã çààãëàñàí çàâñðûí á¿ñ áîëæ áàéëàà. Ýíý íü Ìîíãîë Óëñûí ãàçàð ç¿éí байрлалын öýðýã-ñòðàòåãèéí à÷ õîëáîãäîëòîé óÿëäààòàé байсан þì. Ãýõäýý èéì áàéäàë çºâõºí ÕÕ çóóíû äóíä ¿åýñ ýõòýé áèø áºãººä Ìîíãîëûã öýðýã-óëñ òºðèéí õóâüä ýðõøýýëäýý áàéëãàõ íü Îðîñ, Õÿòàäûí àëü àëèíä Àçè òèâä геостратегийн íºëººãºº òîãòîîõ ÷óõàë ò¿ëõ¿¿ð áîëæ áàéñàí òóõàé îëîí çóóíû ò¿¿õ ºã¿¿ëäýã áèëýý. 1980-аад оны сүүлчээс ýõýëñýí Орос-Õÿòàäûí óëñ òºð, ýäèéí çàñàã, öýðýã-ñòðàòåãèéí õàðèëöààíû ººð÷ëºëò íü Ìîíãîëûí àþóëã¿é áàéäàëä íºëººëºõ геополитикийн öîî øèíý îð÷èí, өмнө нь байгаагүй õ¿÷èí зүйлсийг áèé áîëãîñîí þì.

1989 îíû òàâäóãààð ñàðûí Çºâëºëò-Õÿòàäûí äýýä õýìæýýíèé óóëçàëòûí õàìòàðñàí ìýäýãäýë, ò¿¿íýýñ õîéøèõ õî¸ð òàëûí óóëçàëò, ãýðýý õýëýëöýýð¿¿äýýð Ìîíãîëûã Õÿòàääàñ "õàìãààëàõ" Çºâëºëòèéí "¿¿ðãèéã" õ¿÷èíã¿é áîëãîæ, ÎÕÓ, ÁÍÕÀÓ õî¸ð áèå áèåèéí ýñðýã ÿìàð íýãýí áàéäëààð, ò¿¿íèé äîòîð õèë çàëãàñàí ãóðàâäààã÷ îðíû ãàçàð íóòàã, óñ, àãààðûí îðîí çàéã àøèãëàí õ¿÷ õýðýãëýõ áóþó õýðýãëýõýýð çàíàëõèéëýõã¿é ãýæ òîõèðîëöñîí íü Ìîíãîë Óëñûã хүрээлэн буй àþóëã¿é áàéäëûí îð÷èí ýðñ ººð÷ëºãäºõºä õ¿ðãýñýí þì. 1992 îíä Îðîñûí öýðýã Ìîíãîë Óëñààñ á¿ðýí ãàð÷ äóóññàíààð ýíý òîõèðîëöîî áîäèò àæèë õýðýã áîëñîí áèëýý.

Ìîíãîë Óëñààñ õî¸ð èõ õºðøòýéãýý õàðèëöàõ áîäëîãî íü анх 1994 îíä Ìîíãîë Óëñûí Èõ Õóðëààð áàòëàãäñàí, 2011 онд шинэчлэгдэн гарсан Ìîíãîë Óëñûí ãàäààä áîäëîãûí ¿çýë áàðèìòëàëä òóëãóóðëàí õýðýãæèæ áàéíà. Ýíý ¿çýë áàðèìòëàëààð äýâø¿¿ëñýí òýðã¿¿í çýðãèéí íýã çîðèëò íü ÎÕÓ, ÁÍÕÀÓ-òàé íàéðñàã õàðèëöààòàé áàéõ ÿâääàë áºãººä èíãýõäýý àëü íýãèéã íü ºðººñãºëººð äàãàõã¿é, òýíöâýðòýé õàðèëöàõ, ñàéí õºðøèéí ¸ñîîð ºðãºí õàìòðàí àæèëëàõûã ýðìýëçýõ ÿâääë þì. Õýðýâ өөрийн àþóëã¿é áàéäëûí àøèã ñîíèðõëûã õºíäººã¿é áîë õºðø õî¸ð îðíûõîî ººð õîîðîíäûí ìàðãààíä õºíäëºíããºñ ¿ë îðîëöîõ áàéð ñóóðèéã Ìîíãîë Óëñ òóóøòàé áàðèìòàëæ áàéíà.Òàéâàí öàãò ººðèéí íóòàã äýâñãýð äýýð ãàäààäûí öýðýã áàéðëóóëàõã¿é, äàìæóóëàí ºíãºð¿¿ëýõã¿é, öýðãèéí ÿìàð íýã ýâñýë õîëáîîíä íýãäýõã¿é áàéõ Ìîíãîë Óëñûí áîäëîãî íü õºðø õî¸ð îðîíòîéãîî àäèë òýíöâýðòýé, íàéðñàã õàðèëöààòàé áàéõûã ÷óõàë÷èëæ áàéãààãèéí èëýðõèéëýë ãýæ îéëãîãäîõ ¸ñòîé þì.

Ñ¿¿ëèéí жилүүдэд ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ûí ç¿ãýýñ Ìîíãîë Óëñòàé төрөл бүрийн õàìòûí àæèëëàãààã ýð÷èìæ¿¿ëýõ, ÿëàíãóÿà óóë óóðõàéí ñàëáàðò èäýâõòýé õàìòðàí

àæèëëàõ òàëààð èõýýõýí àíõààðàõ áîëëîî. ¯¿íèé çýðýãöýý ÎÕÓ, ÁÍÕÀÓ õî¸óë Òºâ Àçè, ЗХА áîëîí ò¿¿íèé ýðãýí òîéðíû îðîí çàéä îëîí óëñûí àþóëã¿é áàéäëûí øèíý õàðèëöààã áèé áîëãîõ òàëààð идэвхтэй чармайж ýíý хүрээндээ Монгол Улсыг хамруулах àðãà çàìûã ýðæ õàéõ áîëñîí íü áèäíèé àíõààðëûã òàòàæ байна.

Дээр дурдсан зүйлүүдийг товч дүгнэхэд, Орос, Хятадын зүгээс Монгол Улсын хувьд сайн хөршийн, найрсаг харилцаа, бүх талын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлж, "иж бүрэн стратегийн түншлэлийн" түвшинд хүргэснээ тогтвортой байлгах, олон улсын тавцан дээр харилцан зохицуулсан хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх зэрэг гол чиглэлийг баримталж байгаа нь тодорхой байна. Ìîíãîë Óëñ ººðèéí гадаад áîäëîãîî ýâñýëä ¿ë íýãäýõ çàð÷èìä òóëãóóðëàí, дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг ОХУ, БНХАУ-ын зэрэгцээ ÀÍÓ áîëîí äýëõèéí íºëºº á¿õèé áóñàä ã¿ðíèé îðîëöîîòîéãîîð шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулахын төлөө ÷èã øóãàì áàðèìòàëæ áàéãààã хөрш хоёр улс маань хоёул үндсэндээ хүлээн зөвшөөрч, õ¿íäýòãýí ¿çýæ байна гэж дүгнэж болохоор байгаа юм.

### 2.1.2. Аюулгүй байдлын хамтын ажиллагааны байгууллагууд ба Монгол Улс

Их гүрнүүд болон холбогдох улс орнуудын Евразийн геополитик нь өнөө үед юуны өмнө улс төр-аюулгүй байдлын олон талт механизм, процессуудаар дамжин илэрч, хэрэгжиж байна. Еврази дахь ийм бүтэц , процессууд олон давхаргатай, багагүй ярвигтай бөгөөд үүнээс Монголд бусдаас илүү хамаатай нь Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Умард Атлантын гэрээний байгууллага (цаашид ШХАБ, ЕАБХАБ, НАТО гэх) гэж үзэж болно

#### Монгол Улс ШХАБ-ын харилцаа

**ШХАБ байгуулсны мөн чанар, учир шалтгаан.** ШХАБ-ыг үүсгэн байгуулж байгаагаа БНХАУ, ОХУ, Казахстан, Киргиз, Тажикстан болон Узбекстаны Төрийн тэргүүнүүд Шанхай хотод хийсэн дээд хэмжээний уулзалтаасаа 2001 оны 6 дугаар сарын 15-нд зарлан тунхагласан байдаг. Энэ байгууллагын үндэс суурь нь 1996 оны 4 дүгээр сарын 26-нд байгуулагдсан Шанхайн Тавын бүлэг /Узбекстангүйгээр/ байсан бөгөөд зорилго нь өөр хоорондын хилийн бүс нутагт цэргийн итгэлцлийг бий болгоход оршиж байв. Дараа жил нь Москвад болсон дээд хэмжээний

уулзалтаар Хилийн бүс нутаг дахь цэргийн хүчийг хорогдуулах тухай Гэрээг байгуулж 1997 оны 4-р сарын 24-нд гарын үсэг зуржээ.

Шанхайн Тавын дараагийн жил тутмын дээд хэмжээний уулзалтууд 1998 онд Казакстаны Алма-Ата-д, 1999 онд Киргизстаны Бишкект, 2000 онд Тажикстаны Душанбед тус тус болсон. 2001 оны дээд хэмжээний уулзалт Шанхайд эргэж ирсэн бөгөөд эл уулзалтаар Узбекстаныг гишүүнээр элсүүлэн Шанхайн Зургаа болгон, "ШХАБ-ын Тунхаглал"-д гарын үсэг зурж хамтын ажиллагаа шинэ дээд түвшинд гарч байгааг зарласан. 2002 оны 6 дугаар сард ОХУ-ын Санкт-Петербург хотод болсон уулзалтаар ШХАБ-ын Дүрмийг баталж тус байгууллагын зорилго, зарчим, бүтэц, үйл ажиллагааны хэлбэрийг тодорхойлж олон улсын хуулийн этгээд болгов. Ийнхүү ШХАБ нь Евразийг дамнасан улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын асуудлаарх засгийн газар хоорондын байгууллага болон гарч ирсэн болно.*

Казакстаны Астана хотод 2005 оны 7 дугаар сард хийсэн дээд хэмжээний уулзалтад Энэтхэг, Иран, Монгол, Пакистаны төлөөлөгчид анх удаа оролцсон.

ШХАБ 2007 он гэхэд тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, зэрэг салбарыг хамарсан 20 гаруй том төслийг санаачлан тавьсан бөгөөд аюулгүй байдал,цэрэг, батлан хамгаалах, гадаад бодлого, эдийн засаг, соёл, банк санхүүгийн болон бусад чиглэлээр төлөөлөгчдийн уулзалтыг тогтмол хийж иржээ.

Оросын Уфа хотод 2015 онд болсон дээд хэмжээний уулзалтаар Энэтхэг, Пакистаныг жинхэнэ гишүүнээр элсүүлэхээр болж Ташкентад 2016 оны 6 дугаар сард Энэтхэг, Пакистан хоёр "Үүрэг хариуцлагын тухай Санамж бичигт" гарын үсэг зурснаар гишүүнчлэлийн үйл явц албан ёсоор эхэлсэн бөгөөд Астанад 2017 оны 6 дугаар сарын 9-нд болсон дээд хэмжээний уулзалтаар энэ хоёр улс ШХАБ-ын бүрэн эрхт гишүүнээр нэгдэн орсон болно.

ШХАБ анх байгуулагдсан 1996 оноос хойш зорилго, хэтийн төлөвөө тодорхойлж, хамтын ажиллагааны механизм, санхүү, эрх зүйн үндсийг бүрдүүлэн харьцангуй тогтворжиж, бүс нутгийн хамтын ажиллагааны зарим үйл явц, байгууллагатай харьцуулахад тодорхой амжилтад хүрч, бүс нутгийн нөлөө бүхий байгууллага болох төлөвтэй байна.

ШХАБ эдүгээ 8 гишүүнтэй /Хятад, Орос, Казахстан, Киргизстан, Тажикстан, Узбекстан, Энэтхэг, Пакистан/, 4 ажиглагчтай /Монгол, Афганистан, Беларус,

Иран/, 6 яриа хэлэлцээний түнштэй /Армени, Азербайжан, Камбож, Балба, Шри Ланка, Турк/, 4 зочин оролцогчтой /АСЕАН, ТУХН, Туркменистан, НҮБ/ байна. 2017 оны байдлаар ШХАБ-д дэлхийн хүн амын тэн хагас, ДНБ-ний дөрөвний нэг, Евразийн эх газрын 80 орчим хувь ногдож байна. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 2 гишүүн, цөмийн зэвсэгтэй 4 улсыг хамарч байна[22].

Иран, Афганистан, Турк улсууд ШХАБ-т элсэх хүсэлтээ илэрхийлсэн. Түүнчлэн Бангладеш, Сири, Египет улсууд ажиглагч болох хүсэлт гаргажээ.Энэ мэтчилэн ШХАБ-д Азийн томоохон орнууд нэгдсэн болон нэгдэх сонирхлыг илэрхийлж буй нь тус байгууллагын бодит ач холбогдлыг харуулж байна. ШХАБ-ын гишүүний тоо нэмэгдсэнээр байгууллагын хамрах хүрээ, нөлөө өсөхөөс гадна байгууллагын шинж төрх, чиглэлд цаашдын өөрчлөлт орох магадлал бий.

ШХАБ-ын төв нь Бээжин хот бөгөөд албан ёсны хэл нь хятад, орос хэл юм.

**ШХАБ-ын геополитикийн тухайд.** Энэ байгууллага үүсэж буй болсон нь "Хүйтэн дайн" дуусаж, ЗХУ задран унаснаар дэлхий ертөнц хоёр туйлт ертөнцөөс АНУ давамгайлсан ганц туйлт ертөнц болон хувирсантай шууд холбоотой билээ. Хоёр арван жилийн турш ОХУ алдсан байр сууриа нөхөн хамгаалах, БНХАУ эдийн засгийн хөгжлөө улс төр-аюулгүй байдлын ашиг болгон хувиргахын төлөө хийж ирсэн тэмцэл нь энэ байгууллагын өсөлт, хөгжлийг бүхэлд нь тодорхойлсон гэж болно.

Евразийн эх газарт хяналтаа тогтоох нь дэлхийд ноёрхохын түлхүүр, Төв Азид хяналтаа тогтоох нь Евразийн эх газарт ноёрхохын түлхүүр гэсэн онолын заалтыг геополитик үндэслэгчид, ялангуяа З. Бзежинский дэвшүүлсэн байдаг.[23] Энэ утгаар ШХАБ нь анхнаасаа ЗХУ задарсны улмаас үүссэн орон зайг эзлэн хянахын төлөөх өрсөлдөөний хэрэгсэл, үр дүн болж ирсэн гэж олон улсын шинжээчид үздэг билээ. Хятад, Орос хоёр Төв Ази дахь АНУ болон НАТО-гийн үйл ажиллагааг хязгаарлах, Өрнөдийн эсрэг сөрөг тэнцвэр бий болгохыг бодит зорилгоо болгож ирсэн. ШХАБ-ын өөр нэг зорилго нь энэ байгууллагын орнуудад либерал ардчилал гаргахгүй байхад ч чиглэж байна гэж Томас Амбросио өгүүлсэн байна.

---

[23] Рашид Алимов. Шанхайская организация сотрудничества. Становление, развитие,перспективы. Изд-во "Весь мир". Москва, 2017

ШХАБ-ын геополитикийн үндэс нь “олон туйлт” буюу “олон төвт” дэлхий ертөнц бөгөөд Оросын ерөнхийлөгч Б. Ельцин, Хятадын дарга Жиан Зэмин нар 1997 оны 5 дугаар сарын 20-нд хамтран гаргасан “Олон туйлт ертөнцийн тухай” мэдэгдэлдээ анх тунхагласан байдаг. Энэтхэг, Пакистан тус байгууллагад орсноор Евразийн өргөн уудам нутагт нэгэн шинэ туйл бодит байдал болж ШХАБ-ын “шинэ түүх” эхэллээ гэж үзэх хүмүүс ч байна. Тухайлбал, Казакстаны ерөнхийлөгч Н.Назарбаев цөмийн дөрвөн гүрнийг эгнээндээ нэгтгэснээр ШХАБ-ын глобал аюулгүй байдалд үзүүлэх нөлөө өсөж байгааг тэмдэглэсэн байдаг. Беларусын ерөнхийлөгч А.Лукашенко “ШХАБ-ын гишүүд хүсвэл хэн ч, хаана ч, хэзээ ч дэлхийн байдлыг тогтворгүйтүүлж чадахгүй. Үүнд ШХАБ-ын асар их хүч чадал оршиж байна” хэмээн мэдэгджээ.

Гэхдээ бүх гишүүн ШХАБ-ын үүрэг зорилгыг тэр бүр нэг адилаар үзэхгүй байгааг ажиглаж болно. Тухайлбал, Хятадын хувьд цаашид энэ байгууллага “Бүс ба Зам” стратегийг урагшлуулах, интеграцийн гол бүтэц гэж ойлгогдож байгаа. Энэ хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийн том төслүүдийг идэвхтэй хэрэгжүүлэх замаар Шанхай хүртэлх том төвүүдийг холбох, авто- болон төмөр замын магистралиуд, нефть-хийн хоолой байгуулах замаар дээрх бүс нутгийн орнуудыг Хятадтай шууд холбоотой болгохыг зорьж байна. Нөгөөтээгүүр, Хятад улс нь “Бүс ба Зам”-ын усан замын дагуу тэнгисийн цэргийн оролцоогоо өсгөж байна. Өнгөрсөн онд гадаад дахь анхны цэргийн баазаа Жибутид байгуулж, Шри Ланкийн Хамбантота /Hambantota/ усан боомтын хувьцааны 80 хувийг эзэмших болж түүний эргэн тойрны 15,000 акр газрыг 99 жилийн хугацаагаар түрээслэж авсан байна.Энэ нь Ази, Номхон далай дахь америкийн тэнгисийн цэргийн ноёрхлыг сөрж зогсох чадавхыг аажмаар олж авах зорилготой гэж судлаачид тэмдэглэж байна.

Хятад хэрэв эдгээр зорилтдоо хүрч чадвал бүс нутгийн зах зээлд худалдаа, хөрөнгө оруулалт, эдийн засгийн нөлөөгөө ихээхэн өсгөж чадах төдийгүй, улс төрийн байр сууриа ч бататгаж өөрийн нөлөөний хүрээг тогтоох нь тодорхой юм.

Ийм замаар Хятад Улс өөрийгөө дэлхийн хэмжээний гүрэн болгон хувиргах зорилгодоо хүрэх бөгөөд үүнийгээ ХКН-ын 19 дүгээр их хурлаар албан ёсоор үндэсний стратеги болгон дүрэмдээ тусгаж өгсөн байна.[24]

---

[24] Trump’s National Security Strategy. a Timely Counter to China’s Expansionism by Don Tse & Larry Ong, January 04, 2018

Оросын хувьд ШХАБ-ыг илүү барууны эсрэг тавцан болгон Зөвлөлтийн дараах орон зайд болон түүнээс цааш өөрийн нөлөөг өсгөхийг зорьж байна. Тус байгууллагыг өргөтгөх нь энэ зорилгод нь илүү нийцнэ хэмээн тооцоолж байна. Владимир Путин “Манай бүс нутаг дахь үйл явцад болон дэлхийн тавцанд бүхэлд нь идэвхтэй нөлөөлөх нэмэлт боломжууд нээгдэж байна” гэж мэдэгдсэн нь үүний нэг илрэл болно.

Нөгөөтээгүүр Крымээс болж АНУ болон Европын орнуудын эдийн засгийн хоригт орсон ОХУ анхаарлаа Азид илүү хандуулахаас өөр аргагүй байдалд хүрсэн. Гэтэл Төв Азийн чиглэлээрх Хятадын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, бүтээн босголтын их түрэлтээс үүдэн хуучин Зөвлөлтийн нөлөөнд байсан улсууд Хятадын геостратегийн нөлөөний хүрээнд улам бүр автах болсон нь ОХУ-ыг түгшээж, Хятадын санаачилгын хэрэгжилтэд аль болох болгоомжтой хандахыг хичээж байгаа нь харагдаж байгаа.

Энэтхэгийг ШХАБ-д оруулснаар дээрх чармайлтдаа хүч нэмэх, дэм авахыг зорьж байгаа нь илэрхий. Энэтхэгийн Ерөнхий сайд Моди Москвад айлчлахдаа “Энэтхэг, Орос хоёр олон улсын харилцааны асуудлаар ямагт нэгдмэл байр суурьтай байдаг” хэмээн мэдэгдсэн нь энэ хоёр орон ШХАБ-ын хүрээнд ч хамтдаа гэдгийг илэрхийлсэн хэрэг юм.

Өөр хоорондоо тааруухан харилцаатай хоёр орноор тус байгууллагыг өргөтгөсөн нь бүс нутгийн интеграци, эсвэл асуудлыг хамтран шийдэх хэрэгсэл болох биш, харин ШХАБ-ыг “бэлгэдлийн төдий байгууллага” болгоход хүргэнэ гэж Барнард Коллежийн Александр Күүлей болгоомжлуулсан байна.

Хэдий ийм ээдрээ, хүндрэлтэй асуудал байгаа боловч Энэтхэг Төв Азид хөрөнгө оруулах сонирхол их тул энэ бүс нутаг дахь дэд бүтцийн төслүүд, эрчим хүчний эх үүсвэрүүдийг амилуулахад чухал түлхэц үзүүлж болох талтай гэж үзэж болох юм.

АНУ ШХАБ-ын талаар тодорхой байр сууриа илэрхийлэлгүй, байдлыг харсан байдалтай явж ирсэн, Харин 2017 оны 12 дугаар сард АНУ-ын ерөнхийлөгч Д.Трамп Үндэсний аюулгүй байдлын стратегийг зарлахдаа Хятад, Орос хоёрыг нэр заан Америкийн ашиг сонирхлын эсрэг “стратегийн өрсөлдөгчид” гэж мэдэгдсэн нь “Хүйтэн дайн”-аас хойш Америктай өрсөлдөх хэмжээний хүч гарч ирснийг нэг талаар хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

Ийнхүү ШХАБ-ын геополитикийн ерөнхий хандлага нь нэг туйлт ертөнцийн эсрэг хүчний шинэ төв болон гарч ирж буй бүтэц гэж харагдаж байна. Үүн дотор Хятад нь “Бүс ба Зам” стратегиараа дамжуулан өөрөө дэлхийн гүрэн болох давхар зорилгыг агуулж байгаа бол тус бүтцийн хүрээн дэх нөлөө, хамаарлаа оролцогч орнуудад нэмэгдүүлэхэд чиглэгдсэн ил, далд өрсөлдөөн гол оролцогч гүрнүүд болох Орос, Хятадын хооронд ч өрнөсөөр байна.

**Монгол Улсын оролцооны товч түүх.** Манай улс Ази-Номхон далайн бүс нутагт өрнөж буй улс төр, эдийн засгийн хамтын үйл явцад идэвхтэй оролцох зорилтын хүрээнд ШХАБ-ыг бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд оролцох нэг чухал суваг гэж үзэн 2004 онд тус байгууллагад ажиглагчийн статустай болсон. Тухайн үед уг асуудлыг ҮАБЗ-өөр хэлэлцэж ШХАБ-ын хүрээнд эдийн засгийн салбарын хамтын ажиллагаа, тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, дамжин өнгөрөх тээврийг нэмэгдүүлэх чиглэлд түлхүү оролцох зөвлөмж гаргасныг өнөөг хүртэл баримталж байгаа. Түүнчлэн, шинжлэх ухаан, эрүүл мэнд, байгаль орчин, гамшгийн менежмент, боловсрол, соёл, терроризм, хар тамхи, мансууруулах бодисын наймаатай тэмцэхэд зохих хэлбэрээр оролцож ирэв.

2007 онд манай улс ажиглагч орнуудын дотроос хамгийн түрүүнд ШХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Нургалиевыг урьж айлчлуулсан. Түүнчлэн Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Ф.Мезенцев 2014 онд, Р.Алимов 2018 оны 3 дугаар сард тус тус айлчлаад байна. ШХАБ-ын Бүс нутгийн терроризмтой тэмцэх бүтцийн Гүйцэтгэх хорооны дарга Жан Синьфэн 2014 оны 3 дугаар сард Монгол Улсад айлчилж, Монгол Улсын Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл болон ШХАБ-ын Терроризмтой тэмцэх бүс нутгийн бүтэц хоорондын протоколд гарын үсэг зурсан. ОХУ-ын Ерөнхийлөгчийн ШХАБ-ын асуудал хариуцсан тусгай төлөөлөгч Б.М.Хакимов 2017 онд ирсэн.

ШХАБ-ын Ажил хэргийн зөвлөлийн ээлжит хуралдааныг 2010 онд Улаанбаатар хотод зохион байгуулсан нь уг зөвлөлийн хуралдаан ажиглагч оронд болсон анхны тохиолдол болсон.

Ажиглагчийн статустай болсноос хойш манай улс ШХАБ-ын гишүүн орнуудын төр, засгийн тэргүүн нарын уулзалтад тогтмол оролцохыг эрмэлзэж ирсэн. Тухайлбал, 2005-2007, 2010, 2012-2019 онуудад төрийн тэргүүн нарын уулзалтад Ерөнхийлөгч, 2004, 2008 онд Гадаад харилцааны сайд, 2009 онд Шадар

сайд, 2011 онд Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын түвшинд тус тус оролцсон. Засгийн газрын тэргүүн нарын уулзалтад 2005, 2008, 2012 онд Ерөнхий сайд, 2006, 2007, 2011, 2013, 2015, 2017 онд Шадар сайд, 2009, 2010 онд Гадаад харилцааны сайд, 2014, 2016 онд Элчин сайдын түвшинд тус тус оролцсон.

Мөн салбарын сайд нарын уулзалт болон бусад арга хэмжээнд оролцож байв. 2005 онд Гадаад хэргийн сайд нарын уулзалтад Гадаад хэргийн сайд оролцсон. 2012 оны 11 дүгээр сард Москва хотноо болсон Афганистаны асуудлаар зөвлөлдөх уулзалт, 2014 оны 1 дүгээр сард Москва хотноо болсон Бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаарх уулзалтад Гадаад харилцааны дэд сайд оролцжээ. ШХАБ-ын Нарийн бичгийн дарга нарын газраас 2014 оны 3 дугаар сард Бээжин хотноо зохиосон гишүүн орнуудын Үндэсний зохицуулагч нар болон ажиглагч орнуудын Гадаад яамны улс төрийн газрын захирлуудын түвшний “5+6” уулзалтад оролцжээ.

2009, 2010, 2011, 2012 онд Соёлын сайд нарын уулзалтад сайд болон дэд сайдын түвшинд оролцсон. 2010 онд Ерөнхий прокуроруудын уулзалтад Ерөнхий Прокурор оролцсон байна. Эдийн засгийн сайд нарын уулзалтад зохион байгуулагч оронд суугаа ЭСЯ-ын төлөөлөл оролцож байжээ. Тухайлбал, хамгийн сүүлд 2017 онд Москвагаас орсон.

2012 оны 10 дугаар сард Москва хотноо болсон ШХАБ-ын “Эрчим хүчний клуб” байгуулах асуудлаарх уулзалтад Эрчим хүчний дэд сайд оролцсон байна. Мөн 2013 оны 12 дугаар сард Москва хотноо болсон уулзалтад Эрчим хүчний дэд сайд оролцож, байгууллагын хүрээнд Эрчим хүчний клубийн тухай Санамж бичигт гарын үсэг зурсан. Москва хотноо 2016 оны 4 дүгээр сард зохион байгуулагдсан ШХАБ-ын Эрчим хүчний клубийн уулзалтад ЭХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эрчим хүчний хэлтсийн дарга оролцсон.

Ажиглагч орнуудын санхүүгийн байгууллагуудыг Ажил хэргийн зөвлөл, Банкны нэгдлийн үйл ажиллагаанд илүү татан оруулахыг гишүүн орнууд сонирхож буй. Беларусын банк 2012 онд, Пакистаны “Хабиб”банк 2015 онд ШХАБ-ын хамтран ажиллагч банк болжээ. Манай улсын Хөгжлийн банк “түнш банк”-ны статус авах асуудлыг 2015 оны 4 дүгээр сарын 20-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлсэн бөгөөд ШХАБ-ын Банкны нэгтгэлд “түнш банк”-ны статустай болох хүсэлтээ гаргасан байна.

ШХАБ-ын форумын уулзалтууд, эрдэм шинжилгээний зарим хурлуудад холбогдох байгууллагуудын мэргэжилтэн болон судлаачдын түвшинд оролцож ирсэн. Тухайлбал, 2017 онд ШХАБ-ын хүрээнд олон улсын авто тээврийн асуудлаар Бээжин хотноо 2017 оны 7 дугаар сард зохион байгуулагдсан дугуй ширээний уулзалт, Узбекистан Улсын нийслэл Ташкент хотноо 2017 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан "Олон улсын терроризм болон экстремизмийн эсрэг тэмцэхэд хамтран ажиллах асуудлаарх шинжлэх ухааны 5 дугаар бага хурал"-д холбогдох байгууллагаас төлөөлөгчид оролцсон. Ийнхүү оролцохдоо айлын талаас зардлыг дааж буй нөхцөлд л оролцож буй идэвхгүй хандлага давамгайлж буй. Түүнчлэн ШХАБ-ын хүрээнд болж буй соёл, спортын зэрэг арга хэмжээнүүдэд манай улсаас оролцуулахыг чармайж ирэв. ШХАБ байгуулагдсаны 15 жилийн ойгоор БНХАУ-ын Кунминь хотноо зохион байгуулагдсан марафон гүйлтийн тэмцээнд манай тамирчид оролцсон.

ШХАБ-т ажиглагч явж ирсэн нь улс төрийн хувьд ач холбогдолтой байсан гэж үзэж болно. Бүс нутагт сонирхлоо илэрхийлэх боломжийг ШХАБ олгож байна. Мөн ШХАБ-ын гишүүн орнуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэхэд ШХАБ-ын уулзалтууд тустай байв. Мөн ажиглагч болсноор ШХАБ-ын хүрээнд өрнөж буй хамтын ажиллагааны талаар болон оролцогч орнуудын бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл авахад ач холбогдолтой байв.

Монгол Улс ШХАБ-ын ажиглагчийн статусыг бэхжүүлэх, ажиглагчийн эрх үүргийг дээшлүүлэх, ажиглагч болон гишүүн орнуудын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чиглэлээр тодорхой санал санаачилга дэвшүүлэн ажиллаж ирсэн. Ажиглагч орнуудыг байгууллагын хүрээний хамтын ажиллагаанд илүү өргөнөөр татан оролцуулахыг чухалчлан үзэж буйгаа гишүүн орнууд дээд түвшинд гаргасан баримт бичгүүддээ илэрхийлж ирсэн.

Өнгөрсөн хугацаанд болсон сайд нарын түвшний уулзалтуудын дийлэнхэд ажиглагч орнуудыг урьсан хэдий ч ажиглагч орнуудын оролцоо жигд биш байж иржээ. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын уулзалтад ажиглагч орнуудыг урихгүй байхаар шийдвэрлэсэн гэсэн мэдээллийг НБДНГ-аас өгсөн.

ШХАБ-ын гишүүн орнуудын Үндэсний зохицуулагч нар болон ажиглагч орнуудын бүрэн эрхт төлөөлөгч нарын уулзалт буюу “6+5” механизмыг санаачилж анхны уулзалтыг 2014 онд НБДНГ –т зохион байгуулсан. Дараагийн уулзалтыг хийгээгүй байна. Дээрх уулзалтад оролцогч Афганистан, Энэтхэг, Иран, Монгол, Пакистан - ажиглагч орны төлөөлөгчид энэхүү уулзалтыг гишүүн орнууд болон ажиглагч орны хамтын ажиллагааг эрчимжүүлэх чухал суваг болохыг нотлон цаашид энэ уулзалтыг тогтмолжуулах, улмаар байнгын ажиллагаатай механизм (хороо) болгох боломжтой гэж үзэж байгаагаа илэрхийлсэн. Түүнчлэн ийм төрлийн уулзалт нь зөвхөн ШХАБ доторх хамтын ажиллагааны нэг хэлбэр төдий бус, гишүүн болон ажиглагч орны хооронд бүс нутгийн хэмжээнд яриа хэлэлцээ явуулах олон талт механизм болон өргөжих боломжтойг ч тэмдэглэж байв.

Манай улс ийнхүү ШХАБ-ын арга хэмжээнүүдэд, ялангуяа дээд түвшний уулзалтуудад идэвхтэй оролцож, зарим арга хэмжээг нутагтаа зохион байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн санаачилга дэвшүүлж байсан хэдий ч ШХАБ-ын хүрээнд эдийн засгийн чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөрт хамрагдаагүй, эдийн засгийн бодит үр ашиг ШХАБ-ын үйл ажиллагаанаас хүртээгүй хэвээр байна. Энэ нь ШХАБ-ын хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагааны түвшин доогуур байгаатай холбоотой ч манай улс өөрийн сонирхож буй чиглэлээр тооцоо, судалгаанд суурилсан хамтын ажиллагааны тодорхой санал дэвшүүлж ажиллаагүйтэй холбоотой. Манай холбогдох яам, байгууллагууд ШХАБ-ын асуудлаар тодорхой судалгаа хийдэггүй, асуудлыг хариуцаж энэ талаар мэргэшсэн тогтвор суурьшилтай боловсон хүчин байхгүй байгаа. Ерөнхий дүр зургийг харахад хоёр талын харилцааны идэвхжил, сулрал нь айлын талын санал санаачилгад хөтлөгдсөн, эсвэл манай ажлыг хариуцаж, оролцож буй хүмүүсийн идэвх санаачилгаас хамаарч, сайтар судалж, тооцоолсон зүйлгүй, урсгалаараа явж ирсэн байдал ажиглагдаж байна.[25]

**Өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашдын хандлага.**

ОХУ болон ÁÍÕÀÓ-ûí ç¿ãýýñ ÿâóóëæ áóé Òºâ Àçè, Ç¿¿í Õîéä Àçè áîëîí ò¿¿íèé ýðãýí òîéðîíä îðøèõ îðîí çàéä óëñ òºð, ýäèéí çàñàã, àþóëã¿é áàéäëûí õàìòûí àæèëëàãààíû øèíý õàðèëöààã á¿ðä¿¿ëýõ îðîëäëîãûí íýã òîìîðõîé èëýðõèéëýë íü ØХАБ-ûí èäýâõæèëòèæ áóé íýãäñýí áîäëîãî, ¿éë àæèëëàãààíä ýíý хоёр îðíû îðîëöîî óëàì

---

[25] Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) дахь Монгол Улсын цаашдын оролцоо. МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль. УБ,2017

á¿ð íýìýãäýæ áàéãàà ÿâààë õýìýýí Ìîíãîë Óëñ îéëãîæ áàéãàà áîëíî. ØХАБ íü Ìîíãîë Óëñûã á¿ðýí õ¿ðýýëñýí áîëîí îéð çýðãýëäýý îðøèõ óëñ îðíóóäààñ á¿ðäýæ áàéãàà áºãººä ò¿¿íä öºìèéí çýâñýã á¿õèé òîì ã¿ðí¿¿ä ààãòàæ áàéãàà íü áèäíèé ç¿ãýýñ ãàäààä îð÷íîî ¿íýëýõäýý ºìíºõººñ ººðººð õàíäàõûã àðãàã¿é øààðäàõ áîëëîî.

Ìîíãîë Óëñ ØХАБ-ûí òàëààð áàðèìòëàõ ººðèéí гэсэн тодорхой áàéð ñóóðüòàé áîëíî. ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ûí ç¿ãýýñ ýíý áàéãóóëëàãàä Ìîíãîë Óëñûã èäýâõòýé îðîëöóóëàõ ñîíèðõîëòîé áàéãààãàà удаа дараа èëýðõèéëæ áàéñàí áîëîâ÷ манай орон ØХАБ-ûí õºãæèë, òºëºâèéã àíõààðàëòàé àæèãëàæ, õàðçíàæ байгаа юм. Ýíý íü þóíû ºìíº ýíý áàéãóóëëàãà á¿ðýí òºëºâøººã¿é, ¿¿ñýí áàéãóóëëàãààõ øàòàíäàà ÿâàà òóë ò¿¿íèé õºãæëèéí õàíäëàãûã òîäîðõîéëîõîä òîäîðõîé öàã õóãàöàà õýðýãòýé áàéãààòàé õîëáîîòîé þì. Íºããººòýéã¿¿ð, ýíý áàéãóóëëàãûã ãîë÷ëîí öýðýã, óëñ òºðèéí áîëîí àþóëã¿é áàéäëûí ºíöºãººñ õàðàõ ÿâààë áóñàä îðíû õóâüä íýëýýä ò¿ãýýìýë áàéãààòàé ÷ ááñ õîëáîîòîé áîëíî.

¯¿íèé çýðýãöýý ØХАБ-ûí ¿éë àæèëëàãààíû ÷èãëýë, õàíäëàãà ºðãºæèõ òºëºâòýé áàéãààã õàðãàëçàí ýíý áàéãóóëëàãûí òàëààð áàðèìòëàõ áîäëîãî, áàéð ñóóðü, õàìòðàí àæèëëàõ ÷èãëýëýý ã¿íçãèéð¿¿ëýí áîëîâñðóóëàõ øààðäëàãà ãàð÷ áàéãàà юм. ØХАБ-ûí ºíººãèéí õºãæëèéí áàéäëààñ õàðâàë öààøèä óëñ òºð, àþóëã¿é áàéäëûí àñóóäëûí ñàöóó ýäèéí çàñãèéí õàìòûí àæèëëàãààã òýðã¿¿ëýõ ÷èãëýëèéí íýã áîëãîõ òºëºâòýé áàéíà. Ýíý áàéãóóëëàãûí õ¿ðýýíä ÿðèãääàæ ýõýëæ áóé ÷ºëººò õóäàëäààíû á¿ñ, à÷àà òýýâðèéí áîäëîãûí çîõèöóóëàëò, õºðºíãº îðóóëàëòûí òààòàé îð÷èí á¿ðä¿¿ëýõ, áàéãàëèéí ãàìøèãòàé õàìòðàí òýìöýõ, îëîí óëñûí òåððîðèçì, õèë äàìíàñàí ãýìò õýðýã, õàð òàìõèéí íàéìààíû ýñðýã òýìöýõ çýðýã àñóóäàë íü ìàíàé óëñûí àøèã ñîíèðõîëòîé çàéëøã¿é õîëáîãäîæ áàéãàà þì.

Ýäãýýð ¿éë ÿâöàä õàìðàãäàëã¿é ¿ëäâýë á¿ñ íóòãèéí õàìòûí àæèëëàãàà, èíòåãðàöèéí ¿éë ÿâöààñ õîöðîõ, á¿ñ íóòãèéã õàìàðñàí òîìîõîí òºñë¿¿äèéí ãàäíà ¿ëäýõ ñºðºã òàë áàéãààã бас тооцох ёстой áîëíî. Өөрөөр хэлбэл, энэ байгууллагын аюулгүй байдлын хамтын болон эдийн засгийн хамтын ажиллагааны цаашдын өрнөлт нь Монгол Улс энэ байгууллагад элсэн орох гарцаагүй нөхцөл байдлыг хэзээ нэгэн цагт бий болгож магадгүйг анхаарах нь зүйтэй юм.

Монгол Улс нь ШХАБ-тай хамтран ажиллахдаа дараах үндсэн хүчин зүйлсийг тулгуур болгон анхаарч байна:

- Хоёр хөрштэйгөө ижил тэнцүү төвшинд харилцаж эдийн засгийн хэт хараат байдлаас аажмаар гарах оролдлого хийх;
- АНУ, Европын холбоо, Японтой ойр дотно түншилж, тэдний дэмжлэг тусламжийг авах;
- ШХАБ-д гишүүнээр бус харин ажиглагчийн байр сууринаас хандах.

Монгол бол ШХАБ-ын хоёр гол орон болох Хятад, ОХУ хоёрын дундах Америктай сайн харилцаатай цорын ганц орон гэдгийг хоёр хөрш маань сайн ойлгож харж байгаа.. Тиймээс энэ хоёр орны хооронд цэрэг- улс төрийн ямар нэг эвсэлд хамаарах завсрын орон зай бий болохоос хоёр хөрш маань ихээхэн болгоомжлох нь зүй ёсны асуудал юм. Тухайлбал: АНУ Монгол улсад хэт найрсаг хандаж цаашдаа цэргийн салбарын хатын ажиллагаагаа өргөжүүлж болзошгүй хэмээн тэд сэрэмжилж байгаа. Үүнээс хамгаалахын тулд Монголыг тус байгууллагад аргадаж эсвэл албадаж элсүүлэн байгууллагынхаа дүрмээр Монгол улсыг чиглүүлэх бодлого баримталж болохыг үгүйсгэж болохгүй юм. Үүний зэрэгцээ Монгол Улсын бие даасан олон тулгуурт гадаад бодлогод хүндэтгэлтэйгээр хандан асуудлыг хурцатгахгүй байх нь бас энэ хоёр орны эрх ашигт нийцсэн бодлого гэдгийг тэд баримталж байгааг олон зүйлт дээрээс ойлгож болохоор байгаа юм.

Ийм ч учраас дээр дурдсан Монгол Улсын хувьд ШХАБ-д гишүүнээр элсэх эсэх нь хоёр талтай асуудал юм. Элсэн орж гишүүн болсон тохиолдолд эдийн засгийн тусламж дэмжлэг хангалттай хэмжээгээр хүртэх боломжтой. Тухайлбал одоо үүсээд байгаа нефтийн бүтээгдэхүүн болон байгалийн хийн хараат байдлаасаа салах, дэд бүтцийн асуудлаа шийдвэрлэх бүрэн боломжтой мэт. Нөгөө талаас АНУ, Япон тэргүүтэй улс орнуудын эсрэг чиглэсэн эвсэлд элсэн орсон гэсэн утгаараа манай аюулгүй байдал, тусгаар тогтнолд ямар нэгэн хэмжээгээр нөлөөлөх асуудал үүсэх магадлал бас байгаа юм. Нэг ёсондоо хоёр том гүрний хараат, тэгээд барууны гэгдэх орнуудын эсрэг чиглэсэн агуулга бүхий гадаад бодлоготой жижиг буурай орон болж хувирч болох талтай болно.

Ер нь ямар нэгэн орон улс төр-цэргийн эвсэл шинж чанартай олон улсын байгууллагад элсэнэ гэдэг нь аль нэг тал руу нь орж нөгөө талын эсрэг чиглэж байгаа хэрэг юм. Ингэвэл манай улсын сүүлийн жилүүдэд тууштай баримталж буй эвсэлд үл нэгдэх, төвийг сахисан маягийн бодлого алдагдаж болзошгүй болно. Олон улсын байдал ээдрээтэй байгаа энэ үед ШХАБ-д элсэх нь тусгаар тогтнолд

эрсдэл дагуулах магадлалтай ихтэй боловч шууд эрс татгалзсан хариу өгөх нь бас хоёр хөршөө таалагдахгүй алхам болж болзошгүй юм.

Хэрэв ийм байдал үүсвэл хоёр хөрш орон маань хамтран манай улсын эсрэг ил биш ч гэсэн эдийн засаг болоод улс төрийн хориг саад явуулж болзошгүй юм. Ийм шинж тэмдэг ч  олон байгаа.

Иймээс асуудлаас хамгийн сайныг сонго гэвэл ажиглагчийн статусаар аль болон удаан явж цаг хугацааг барих явдал болоод байгаа юм.

Гэхдээ хоёр хөрштэйгөө найрсаг харилцаж байна гээд аль нэг улсыг нь хэт дагах нь бас буруу юм. Одоогоор манай улсын эдийн засаг ихээхэн хэмжээгээр Хятад улсаас хамааралтай болоод байгаа. Уул уурхай дагасан түүхий эдийн нийлүүлэгч нь Монгол Улс хэрэглэгч нь Хятад улс гэдэг нь хэн бүхэнд тодорхой зүйл юм. Үүнээс үүдэн эдийн засгийн салбартаа энэ улсаас хараат бус байдлыг бий болгох явдал ихээхэн чухал болоод байна.

Энэ бүхнийг нэгтгэн тунгааж үзэхэд энэ цаг үед бид ШХАБ-д бүрэн эрхт гишүүнээр элсэх асуудалд өгөх тийм, эсвэл үгүй, мэдэхгүй гэсэн гурван сонголттой л үлдэж байна. Аливаа цэрэг-улс төрийн шинж чанартай эвсэл хөдөлгөөнд элсэнэ гэдэг нь олон улстай харилцах харилцаа хумхигдаж хорвоогоос тодорхой хэмжээгээр таслагдана гэсэнтэй төсөөтэй үг. Бид үүнийг сайн мэднэ. ШХАБ-аас бидэнд авах ч зүйл бий гээх ч зүйл бий. Ингээд эцсийн дүндээ гишүүн нь бус харин ажиглагчийн байр сууринаас идэвхтэй оролцох нь манай улсад тустай байх болно гэсэн байр суурийг Монгол Улсын Засгийн газар тууштай баримталсаар байгаа юм. Энэ нь нөгөө талаасаа Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлогын үндэс зэрэг үндсэн баримт бичгүүдэд тусгалаа олсон гол үзэл санаа, түүний дотор аливаа эвсэлд үл нэгдэх зарчимд тулгуурласан бодит бодлого юм.

Ийм ч учраас бүс нутгийн цэрэг, стратегийн хамгийн том байгууллага болоод буй ШХАБ-д Монгол Улсыг бүрэн эрхт гишүүн болгох асуудал манай улсын бодлогын дагуу удаа дараа хойшлогдсоор байгаа бөгөөд үүнийг ч бусад орон ойлгож байгаа болно .

Уг нь 2012 онд тус байгууллагын гишүүн орнуудын удирдагчдын Астанад болсон хурлаар манай улс Энэтхэг, Пакистан, Иран улсын хамтаар ШХАБ-ын

ажиглагчийн статусыг бүрэн эрхт гишүүн болгох санал дэвшүүлсэн юм. Үүний өмнөх Ташкентын уулзалтаар ч энэ хамтын нийгэмлэгийн гишүүдийг олшруулахаар шийдвэрлэсэн байдаг. Эдгээр улсыг жинхэнэ гишүүнээр элсүүлэх өндөр магадлалтай байсан ба ОХУ, БНХАУ-ын удирдагчид ч сайшаасан байсан.

Гэвч ШХАБ-ын 2013 онд Бээжинд болсон уулзалтаар хоёр хөрш манай улсыг төдийлөн дэмжихгүй нь тодорхой болсон юм. Учир нь Төв Ази, Ойрх Дорнодод болж буй улс төрийн хурцадмал байдал, АНУ-ын цэргийн стратегийн бодлого тэлж байгаатай холбогдуулж Москва, Бээжингийн сонголт цэргийн хүч чадалтай улсууд руу түлхүү чиглэх болоод байгаа юм. Тодруулж хэлбэл, ОХУ-ын хувьд Энэтхэгийг, Хятадын тал Пакистаныг ШХАБ-д элсүүлэх илүү сонирхолтой байсан бөгөөд үүнийгээ ч хэрэгжүүлсэн болно.

ОХУ-ын Гадаад харилцааны сайд Сергей Лавров “Синьхуа” агентлагт өгсөн ярилцлагадаа “Манай улсын хувьд ШХАБ-ын гишүүдийн хүрээг өргөжүүлэхийг тууштай дэмжиж байна. Бидэнд өөр сонголт байхгүй. Хамтын нийгэмлэг олон гишүүнтэй болсноор бидний зорилго, чиглэл илүү тодорхой болно” гэжээ.

Энэ бодлогынх нь хүрээнд авч үзвэл Энэтхэг улс Төв Азид үр нөлөөтэй байхыг сонирхож байна. Ингэхдээ тус улс терроризмтой хийх тэмцлийг юуны түрүүнд сонирхож байгаа юм. Эл асуудал Орос, Хятадын дэмжлэгийг тодорхой хэмжээгээр хүлээж чиг байгаа юм. Мөн Пакистаны тогтворгүй байдал Төв Азийн орнуудыг түгшүүлсээр байгаа, түүнчлэн цөмийн зэвсгийн материал Пакистаны нутаг дэвсгэрээс гадагш гарч болзошгүй зэрэг нь анхаарал татсан асуудал болоод байгаа юм. Пакистаныг ШХАБ-д элсүүлсэн нь эдгээр асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болно гэж Орос, Хятад аль аль нь үзэж байгаа бололтой байдаг.

Хамгийн сонирхолтой нь Энэтхэг, Пакистаны хоорондын хүнд түвэгтэй харилцаа эдгээр улсыг уг байгууллагад элсүүлэхэд саад тотгор болохгүй гэж шинжээчид үзсэн явдал юм. ШХАБ-ын гишүүн орнууд хоорондын бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх нь энэхүү байгууллагын зорилго оршиж байгаа гэдэгтэй энэ нь холбоотой бололтой байдаг. Тэгэхээр энэ хандлага Монгол Улсад чиг хамааралтай байж болох юм.

Үүнээс гадна ойрын ирээдүйд ШХАБ-ын гишүүн бүх улсыг түгшүүлж байгаа Афганистан улс ажиглагчаар элсэх, Турк улс яриа хэлэлцээ хийх түншийн статустай болж магадгүй байгаа юм. Энэ бүхэн нь эцсийн дүндээ Монгол Улсыг

ШХАБ-д бүрэн эрхт гишүүнээр элсүүлэх асуудлыг хэлэлцэхийг хойшлуулах шалтгаан болж байгаа бөгөөд энэ нь ч манай улсад ашигтай байж болох талтай юм

**Монгол Улс, ЕАБХАБ-ын харилцаа.**

**ЕАБХАБ-ын үйл ажиллагааны мөн чанар, учир шалтгаан.** Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага нь Хельсинкийн процесс, бага хурлаас эх авсан Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны талаарх Зөвлөгөөн (conference) хэмээх олон талын дипломат форумын үндсэн дээр, түүний үргэлжлэл болж 1994 онд байгуулагдсан юм.

Энэ байгууллага аюулгүй байдлын асуудлууд эрхэлдэг бөгөөд түүний үндсэн гурван хэмжүүр буюу улс төрийн , эдийн засаг-экологийн, хүний эрхийн/ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд, цэргийн салбарт нээлттэй, ил тод байдлыг тогтооход анхаарч, зэвсэглэлийг хянах / зэвсэг хураах/ болон итгэлцлийг бэхжүүлэх дэглэмийг сахин бататгах зорилготой бөгөөд аюулгүй байдлын салбарыг шинэчлэх, энгийн зэвсгийг хадгалах, хэрэглэх явдлыг аюулгүй болгох хүртэл үйл ажиллагаа явуулдаг байна. Эдийн засгийн аюулгүй байдалд онцгой ач холбогдол өгч эдийн засаг-экологийн удирдлага, авлигатай тэмцэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, хаягдлын асуудлыг зөв зохицуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлаар ажилладаг. Хүний эрхийн **салбарт** ардчилсан тогтолцоог төлөвшүүлэх, шударга, ил тод сонгууль явуулах, хүний үндсэн эрх, эрх чөлөө болон хэвлэл-мэдээллийн эрх чөлөөг хангах, үндэсний цөөнхийн эрх, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх гэхчлэн чиглэлээр гишүүн орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлж байна.

Аюулгүй байдалд эрсдэл учруулагч улс үндэстэн дамнасан процессууд, тухайлбал цаг уурын өөрчлөлт, терроризм, экстремизм, зохион байгуулалттай гэмт хэрэг, кибер гэмт хэрэг, хар тамхи болон зэвсгийн нууц наймаа, хүний наймаатай тэмцэх болон миграци, дүрвэгсдийн асуудлаар идэвхтэй ажилладаг. Түүнчлэн улс хоорондын харилцааг хөгжүүлэн бэхжүүлэх, төр, хувийн сектор, иргэний нийгэм хоорондын хамтын ажиллагаа хүртэл бусад олон чиглэлээр хамтын ажиллагаа явуулж иржээ.

ЕАБХАБ нь олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, Газрын дундад тэнгис боон Ази дахь түнш улсуудтайгаа нягт хамтран ажиллахыг эрмэлздэг болой.

Хүйтэн дайнаас хойших хүнд хэцүү жилүүдэд Төв болон Зүүн Европт өрнөсөн ардчилсан үйл явцыг гүнзгийрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсний зэрэгцээ ялангуяа Төв Азид шинэ шинэ сорилтуудтай тулгарсан боловч байдлыг тогтворжуулах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагаа хөгжүүлэх чиглэлээр амжилттай ажиллаж ирсэн байна.

Эдүгээ энэ байгууллага Европ-Атлантын бүтэц байхаа больж ЗХУ задарсны дараа Төв Азийн шинэ улсууд, хожим өөр улсууд элссэнээр илүү өргөн буюу тив дамнасан, Евразийн бүтэц / 57 гишүүнтэй/ болон хувирчээ. Гэтэл цаг хугацааны эрхээр олон улсын байдал эрчимтэй өөрчлөгдөж тэр хэрээр уг байгууллагын үүргийн тухай ойлголт өөрчлөгдөж, олон салаа болсноор үйл ажиллагаа нь ихээхэн бэрхшээлтэй учрах болсон байна. Үүрэг, зорилго, зорилт, стандартын асуудлаарх байр суурь зөрөлдөх болж, асуудлыг зөвшилцлийн аргаар шийдвэрлэх зарчим нь ч ганхаж эхэлсэн аж. Үүнтэй холбогдуулан тус байгууллагыг “шинэ нөхцөл байдалд зохицож чадахгүй байна”, “системийн, функцийн, магадгүй ертөнцийг үзэх үзлийн гүн гүнзгий хямралд орсон “ * хэвээр байна гэж гишүүн орнуудын улс төрчид ч, судлаачид ч дүгнэх болжээ. Үүний шалтгаан олон янз бөгөөд тайлбар нь ч бас эсрэг, тэсрэг олон янз агаад а/ үйл ажиллагаа нь доголдож, б/гишүүн улсууд хоорондын итгэлцэл хямарсан явдал гол шалтгаан ** гэж тооцох нь нэлээд дэлгэрэнгүй байгаа аж. ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бришамбо-гийн тэмдэглэн хэлснээр “ Байгууллагын гишүүд хоорондын үл итгэлцэл нь...хямралд шуурхай хариу барих, гарч буй аюулуудад дасан зохицох бололцоог хумьсан юм. Оролцогч улсуудын дунд нэгдмэл зорилго байхгүй байгаа нь ЕАБХАБ дээд хэмжээний уулзалтаа 11 жил хийж чадаагүйгээр илэрсэн”*** байна. Эдүгээ Крым, Украйны асуудал уг байгууллагын эв түнжинг эвдэгч гол “алим” болоод байна.

Сүүлийн жилүүдэд ЕАБХАБ-д шинэтгэл хийх тухай яриа, мэтгэлцээн энэ байгууллагын бүхий л түвшинд гарч байгаа боловч хэрхэн хийх талаарх байр сууриуд өөр хоорондоо ихээхэн ялгаатай байгаа аж. Шинэтгэл нь байгууллагын үйл ажиллагааны тогтсон зарчмууд, хэм хэмжээ, стандартуудаас авхуулаад бүтцийг хүртэл хамарч газар зүйн болон сэдвийн илүү тэнцвэртэй хуваарь, улс

орнуудын хооронд илүү түншийн харилцааг буй болгох ёстой гэж байна. Үйл ажиллагааны бүтцийн өөрчлөлтийг дагаад олон улсын бүхэл бүтэн том байгууллагыг, түүний дотор Нарийн бичгийн дарга нарын бүтцийг өөрчлөх учиртай гэж байгаа юм. Юуны өмнө глобал аюулгүй байдлын түвшинд гарч буй өөрчлөлтүүдэд байгууллагын шинж чанар, үйл ажиллагааг зохицуулан интеграцчилах, энэ үүднээс Европын болоод Евразийн аюулгүй байдлын шинэ үзэл баримтлал боловсруулж, гэрээ байгуулах шаардлагатай гэцгээх боловч хэн, хэзээ, хэрхэн хийх талаар улс орнуудын байр суурь, санаа бодол хоорондоо дэндүү зөрөөтэй, мухардалд орсон хэвээр байна.

**Монгол Улсын оролцоо, цаашдын хандлага.** Бүс нутгийн хэмжээнд төдийгүй дэлхий дахинаа ЕАБХАБ-ын гүйцэтгэж байгаа үүрэг, нөлөөллийг харгалзсаны үндсэн дээр манай улс олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо, яриа хэлэлцээний механизмуудад нэгдэн орох гадаад бодлогын зорилтынхоо хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулсны үр дүнд 2004 онд Болгарын нийслэл Софи хотноо болсон тус байгууллагын Сайд нарын Зөвлөлийн 12 дугаар хуралдааны үеэр ЕАБХАБ-ын Хамтын ажиллагааны түншээр Азийн тав дахь улс болон нэгдсэн байна.

Улмаар 10 гаруй жилийн турш Монгол Улс ажиглагчийн статустай явж, энэ том үйл явцын нэг хэсэг болохын тулд маш их чармайлт гаргаж ажилласны үр дүнд 2012 оны 11 дүгээр сарын 21-нд оролцогч орон буюу 57 дахь буюу Зүүн Азийн бүс нутгаас анхны гишүүн орон нь болсон.

Анх 2006 оны 10 дугаар сард ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга М.П.Бришамбо манай улсад албан ёсоор айлчилж өргөн хүрээтэй асуудлаар санал солилцсон байна. Энэ нь тус байгууллагаас манай гадаад, дотоод бодлого, байдлыг илүү танин мэдэх, хоёр талын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ. Улмаар цаашдын харилцааг идэвхжүүлэхэд нөлөөлсөн бөгөөд энэ нь 2010 оны 3 дугаар сард ерөнхий сайд С.Батболд Австрид айлчлах үеэрээ ЕАБХАБ-д зочилж энэ байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга тай уулзах үеэр тодорхой харагдсан байдаг.

Манай улс эхнээсээ л ЕАБХАБ-ын үйл ажиллагаатай нарийвчлан танилцаж, Дээд хэмжээний уулзалт, Сайд нарын Зөвлөлийн болон Байнгын Зөвлөлийн хуралдаан, Эдийн засгийн чуулга уулзалт, Хүний аюулгүй байдлын асуудлаарх

уулзалт, Хамтын ажиллагааны түнш орны зохион байгуулдаг бага хурал зэрэг арга хэмжээнд оролцон хамтарч ажиллах чиглэлүүдээ тодорхойлж үр бүтээлтэй хамтран ажиллаж ирсэн.

ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга 2006, 2012 онд манай улсад айлчилж төр, засгийн тэргүүн, зарим сайд нартай уулзаж хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар, тухайлбал, Монгол Улс тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцон хил хамгаалах менежмент, цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, хүн наймааны эсрэг тэмцэх чиглэлээр хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх талаар санал солилцон манай хүчний байгууллагын ажилтнууд, судлаачдад ЕАБХАБ-аас явуулж буй үйл ажиллагааны талаар лекц уншиж, тэдний сонирхсон асуултад хариулсны дээр цагдаагийн зарим байгууллагын үйл ажиллагаатай танилцсан нь ЕАБХАБ-тай тогтоосон хамтын ажиллагааг урагшлуулахад түлхэц үзүүлсэн байна.

Манай улс ЕАБХАБ-тай хамтран 2007 оноос хойш Улаанбаатар хотноо “ЕАБХАБ болон түүний Азийн түнш орны хооронд хамтын аюулгүй байдлыг бэхжүүлэх нь” сэдэвт бага хурал, “Хүний наймааны эсрэг шинжээчдийн олон улсын бага хурал”, “Аюулгүй байдлын асуудалд цогцоор хандаж, нийтлэг сорилтуудыг шийдвэрлэхэд ЕАБХАБ болон Азийн түншүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт ОУБХ, “Гал түймрийн удирдлагын асуудлаар байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь” сэдэвт дугуй ширээний уулзалт, “Хууль сахиулахуйн инноваци” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, “ЕАБХАБ-ын хилийн аюулгүй байдал менежмент” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан байна.

Мөн 2011 онд “ЕАБХАБ- Монгол-2011 он” бага хурлыг Улаанбаатар хотноо зохиож цаашид хэрэгжүүлж болох арга хэмжээний талаар тодорхой зөвлөмж, санал гаргасан байдаг. Эдгээр зөвлөмж, саналд хэд хэдэн чухал асуудал тусгагдсаны дотор өөрийн шинжээчдийг аюулгүй байдлын чиглэлээр зохиогддог ЕАБХАБ-ын бүс нутгийн хурал, семинар, сургалтын хөтөлбөрт түлхүү оролцуулах, ЕАБХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газарт болон бусад төвд өөрийн шинжээчдийг дадлагажуулах боломжийг ашиглахыг зөвлөсөн нь өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бүс нутгийн хамгийн том байгууллагад нэгдсэн манай улсын хувьд ач холбогдолтой юм.

Түүнчлэн ЕАБХАБ-ын Дарга улс-Ирландын БТ О.Олири, ЕНБД Л.Занниер тэргүүтэй шинжээчдийн хэсэг 2012 оны 6 дугаар сард, ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн Ерөнхийлөгч Р.Миглиорий 2013 оны 3 дугаар сард тус тус Монголд айлчилж, 2013 оны 5 дугаар сард ажиглагчдын баг нь анх удаа Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийг ажигласан. ЕАБХАБ-ын Ардчилсан байгууллагууд, хүний эрхийн албаны баг манай УИХ-ын 2016 оны сонгууль, түүнчлэн 2017 оны ерөнхийлөгчийн сонгуулийг тус тус ажигласан болно.

Монгол Улс ЕАБХАБ-ын Аюулгүй байдлын хамтын ажиллагааны форумыг 2015 оны эхний 4 сард даргалсан бөгөөд 5 дугаар сард УБ хотноо болсон Онлайн эрх чөлөөний эвслийн Сайд нарын бага хуралд ЕАБХАБ-ын Хэвлэлийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн төлөөлөгч Д.Миятович оролцож, манайд ажлын айлчлал хийсэн. УИХ, ГХЯ хамтран ЕАБХАБ-ын Парламентын Ассамблейн намрын хуралдааныг 2015 оны 9 дүгээр сард УБ хотноо хүлээн авч зохион байгуулсан байна.

Тус хуралд дэлхийн 60 гаруй орны парламентын төлөөлөл оролцон, Монголд хуран чуулсан нь манай орны нэр хүндийг олон улсын тавцанд өндөрт өргөсөн чухал үйл явдал болсон юм.

Манай улс ЕАБХАБ-ын үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлийн хүрээнд, ялангуяа эдийн засаг, байгаль орчин, хүний аюулгүй байдлын асуудлуудад түлхүү анхаарч, эдгээр чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг чухалчилж байгаа** аж. Үүний зэрэгцээ  энэ байгууллагын үйл ажиллагааны болон бүтцийн шинэтгэлийн асуудал, Евро-Атлантын болон Евразийн аюулгүй байдлын шинэ концепци боловсруулах зэрэг ирээдүйг харсан яриа хэлэлцээнд өөрийн эрх ашгийн үүднээс идэвхтэй оролцож байх нь зүйтэй байна.

Ардчилал, зах зээлийн нийгэмд шилжиж орж байгаа Монгол Улсын хувьд аюулгүй байдлыг улс төр дипломатын аргаар хангах,  тогтвортой хөгжих, байгаль орчныг хамгаалах, сайн засаглал, сонгуулийн ардчилал, жендерийн тэгш байдлыг хангах зэрэг олон томхон зорилтыг шийдвэрлэхэд Европын улсуудын арга туршлага, тэднийг эгнээндээ нэгтгэдэг ЕАБХАБ-ын ажил хэрэгч хамтын ажиллагаа бодитой дэмжлэг үзүүлж болох юм

**Монгол Улс, НАТО-ийн харилцаа.**

**НАТО-гийн тухай.** Умард Атлантын Гэрээний Байгууллага буюу НАТО нь дэлхийн хоёрдугаар дайны дараа ЗХУ-ын зүгээс учруулж болзошгүй аюул занал, коммунизмыг тогтоон барих зорилгоор анх 1949 онд байгуулагдсан. Уг гэрээнд АНУ, Канад, Их Британи,Франц, Бельги, Нидерланд, Люксембург, Исланд, Итали, Норвеги,Португал улс гарын үсэг зурж, хожим 1952 онд Грек, Турк, 1955 онд ХБНГУ, 1982 онд Испани нэгдэн орсон юм. Социалист систем задарч Варшавын гэрээний байгууллага татан буугдсанаар Чех, Унгар, Польш НАТО-ийн гишүүн болж, хожим буюу 2004 оноос Болгар, Эстони, Латви, Литва, Румын, Словак, Словени, 2008 онд Албани, Хорват улс тус тус элссэнээр нийт 28 гишүүн улстай болоод байв. НАТО-гийн зүүн зүгийн тэлэлтийг ОХУ эрс эсэргүүцэж ирсэн бөгөөд эдүгээ харилцан итгэлцэл, хамтын ажиллагаа нь ихээхэн доройтоод байна.

Умард Атлантын Гэрээний удиртгал хэсэгт гишүүн улсуудын нутаг дэвсгэрт тогтвортой байдал, сайн сайхныг хөхиүлэн дэмжих үүднээс ардчилал, хувь хүний эрх чөлөө, нийтлэг өв, соёл иргэншлийг сахин хамгаалах зорилгыг тунхагласан. Гэрээний 5 дугаар зүйлд тус байгууллагын аль нэг гишүүний эсрэг үйлдсэн зэвсэгт түрэмгийллийг бусад бүх гишүүн орны эсрэг өдүүлсэн түрэмгийлэл хэмээн үзэж хариу арга хэмжээ авах тухай заасан байдаг.

1991 онд Европ тивд яриа хэлцээ, хамтын ажиллагааг дэмжих шинэ стратеги баталж, Умард Атлантын Хамтын ажиллагааны Зөвлөл байгуулагдан, 1994 онд Энхийн төлөө Түншлэл хөтөлбөр эхэлснээр НАТО-ийн үйл ажиллагааны хүрээ өргөжиж, үндсэн зорилго нь гишүүн орнуудын эрх чөлөө, аюулгүй байдлыг улс төр, цэргийн арга хэрэгслээр хангах явдал болж хувьсан өөрчлөгдсөн гэж үзэж болно. Уг хөтөлбөрт эдүгээ 22 улс хамрагдаж буй бөгөөд бараг бүх салбарыг хамарч байна. Тухайлбал, батлан хамгаалахын шинэчлэл, бодлого төлөвлөлт, цэрэг-иргэний харилцаа, боловсрол ба сургалт, цэргийн хамтын ажиллагаа, хээрийн сургууль, онцгой байдлын төлөвлөлт болон гамшгийн бэлэн байдал, шинжлэх ухаан ба хүрээлэн буй орчны асуудлаарх хамтын ажиллагаа зэргийг дурдаж болно.[26]

**Монгол Улс, НАТО-ийн харилцааны товч түүх.** Монгол Улс ººðèéí àþóëã¿é áàéäëûã óëñ òºð, äèïëîìàòûí àðãààð õàíãàõ áîäëîãî, ¿éë àæèëëàãààíûõàà õ¿ðýýíä ÍÀÒÎ-òîé õàìòûí àæèëëàãàà òîãòîîí õºãæ¿¿ëýõèéã çîðüæ 1995 оноос эхлэн

---

[26] NATO, The Partnership for Peace programme,http://www.nato.int/cps/en/natolive/topics_50349.htm

НАТО-ийн албаны хүмүүстэй анхны албан бус уулзалт хийж эхэлсэн бөгөөд улмаар 1998 îíîîñ íèëýýä ñàíàà÷èëãàðàé àæèëëàæ èðñýí байна. Гэхдээ энэ харилцаа нь эхнээсээ албан ёсны гэхээсээ Монгол Улс, НАТО-ийн тодорхой албан тушаалтнуудын уулзалт, тохиролцооны үр дүн хэлбэрээр хэрэгжиж иржээ.

НАТО нь Атлантын далайн хоёр эргийн улсууд харилцан бие биеийнхээ аюулгүй байдлыг хангахаар байгуулсан олон улсын гэрээний байгууллага юм. Гэтэл Зүүн Хойд Азид байршилтай, хөгжлийн хувьд буурай Монгол оронтой НАТО-ийн зүгээс харилцаагаа хөгжүүлэх ямар ашиг сонирхол байна вэ?, нөгөө талаасаа Монгол Улс НАТО-той албан ёсны харилцаа тогтоосноор манай орны аюулгүй байдлын болон хөгжлийн стратегид ямар нааштай өөрчлөлт гарч болох вэ? гэсэн хоёр асуулт байнга тавигдаж ирсэн

Өөр нэг тэмдэглэх зүйл бол АНУ-тай аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хүрээнд тогтоосон хамтын ажиллагаа нь албан бусаар боловч дотроо НАТО-той харилцах асуудлыг байнга агуулж ирсэн бөгөөд чухамхүү АНУ-ын манай улсыг дэмжих бодлого нь НАТО-тай харилцах харилцааны гол хөшүүрэг болж байгаа юм.

Ийнхүү 1998 оноос хоёр тал харилцан албан болон албан бус төвшинд яриа хэлэлцээр идэвхтэй хийж ирсэн юм.Эхний ээлжид Монгол Улс хөрш хоёр гүрэн,Төв Азийн байдал, тус бүс нутаг дахь нөхцөл байдал, Энхийн төлөө түншлэлийн явцыг харзнан шууд НАТО-той бус, харин НАТО-гийн гишүүн орнуудтай хоёр талын харилцаагаа идэвхтэй хөгжүүлэхэд анхаарч ирсэн байна. Үүний зэрэгцээ манай улс НАТО-гийн Энхийн төлөө түншлэлийн үйл явцыг анхааралтай ажиглаж элсэн ороход тулгарах бэрхшээлийг ч тооцон судалж байсан юм. Тухайн үедээ Монгол Улс Энхийн төлөө түншлэлд элсэх эрмэлзэлтэй байсан боловч тодорхой дэмжлэг аваагүй бөгөөд манай улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны Зөвлөл /ЕАБХАЗ/-ийн гишүүн улс биш байсан нь энэ асуудал шийдвэрлэгдээгүйн гол шалтгаан болсон байдаг.

Энхийн төлөө түншлэлд элсэх урилгыг хөтөлбөрт дөхөм үзүүлэх эрмэлзэл чадавх бүхий Умард Атлантын хамтын ажиллагааны Зөвлөл /УАХАЗ/-ийн бүх гишүүн улс, ЕАБХАЗ-ын бусад гишүүн улсад хандан гаргасан билээ. Манай улс нэгэнт ЕАБХАЗ-ийн гишүүн орон биш байсан тул Энхийн төлөө түншлэлд нэгдэн орох урилгыг бидэнд ирүүлээгүй болно.

Иймээс тухайн үеийн Монгол Улсын Гадаад харилцааны яам “Энхийн төлөө түншлэл-Монгол Улс” гэсэн томьёоллоор дараах 5 чиглэлд НАТО-той харилцахыг санал болгосон байдаг. Үүнд:

- Мэдээлэл солилцох
- Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үеийн сургалт
- Монголын офицерын бие бүрэлдэхүүний гадаад хэлний сургалт
- Монголын Зэвсэгт Хүчний анги нэгтгэлүүдийг энхийг сахиулах ажиллагаанд сургах
- Шинжлэх ухаан технологийн судалгаа

НАТО-гийн талаас “Энхийн төлөө түншлэл-Монгол Улс” гэсэн хувилбарыг албан ёсоор зөвшөөрч хүлээн аваагүй боловч санал болгосон 5 чиглэлийг судалж үзэхээ мэдэгдсэн байна. Ингэж эхэлсэн харилцаа нь 2000 онд Монгол Улсын Зэвсэгт хүчний баг НАТО-ийн Энхийн төлөө түншлэлийн хүрээнд явагддаг ЦЕНТРАЗБАТ хээрийн сургуульд оролцсоноор бодит биеллээ олж эхэлсэн билээ. Үүний дараа 2003 оны 2-р сард манай Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн Бельгийн вант улсын цэргийн багтай хамтран энхийг  сахиулах хүчний хээрийн сургуулийг эх орондоо зохион явуулснаас эхлэн энэ чиглэлийн үйл ажиллагаа ихээхэн идэвхжиж улам олон төрөл, хэлбэртэй болон өргөжсөн болно.

Түүнчлэн Иракт үүрэг гүйцэтгэсэн манай энхийг сахиулах баг НАТО-ийн гишүүн Польшийн дивизийн командлалд харьяалагдаж байсан бөгөөд Афганистанд ч НАТО-ийн гишүүн орнуудтай хамтран ажиллаж байна.

1998 онд Монгол Улсын ҮАБЗ-ийн төлөөлөгчид анх НАТО-д айлчлан хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцсэн бөгөөд үүнээс хойш Монгол Улсын Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд, Батлан хамгаалахын сайдын хэмжээнд удаа дараагийн уулзалт ярилцлагууд хийгдэж ирсэн байдаг.

ÍÀÒÎ-ãèéí òàëààñ 2001 îíä ÍÀÒÎ-ãèéí äýðãýäýõ Îëîí Óëñûí àþóëã¿é áàéäëûí çºâëºõ¿¿äèéí ãàçðûí çàõèðàë íî¸í Ãàððè Æîíñîí ìàíàé улсад анх албан ёсоор àéë÷èëæ ñàíàë бодлоо солилцсоноос хойш олон тооны уулзалтууд хийгдсэн.

Ингээд манай улс НАТО-тай харилцаа тогтоох бололцоог ерээд оны дундаас эхлэн тандаж эхэлсэн бол  2000 оноос эхлэн тодорхой зорилго дэвшүүлж

Афганистан дахь аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүчний ажиллагаа (ISAF), Косово дахь (KFOR) ажиллагаанд цэргийн багаа илгээсэн нь бодитой хамтын ажиллагаа эхлэн хөгжүүлэх анхны боломжууд байсан юм. Улмаар харилцааг албажуулах алхмууд хийснээр 2012 онд Монгол Улс, НАТО хоорондын “Түншлэл, хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр” байгуулж НАТО-гийн түнш орны статустай болсон. Чингэснээр НАТО-гийн “Дэлхий даярах түншлэл” /Partners across the Globe or PatG/-ийн гишүүн бусад орон болох Австрали, Шинэ Зеланд, Япон, Өмнөд Солонгостой ижил түвшинд очсон.

Энэ хөтөлбөр нь тус эвслийн шинэ үзэл баримтлалын хүрээнд байгуулсан анхны түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр болсноороо онцлогтой. Хөтөлбөрийн дагуу хоёр тал 1/ сургалт, судалгаа, 2/ шинжлэх ухаан, технологи, 3/гамшигтай тэмцэх, 4/ энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр тодорхой хамтран ажиллах боломжтой болсон. Жишээлбэл, манай тал НАТО-гийн “Энхийн төлөө шинжлэх ухаан” /The NATO Science for Peace and Security Programme/хөтөлбөрт 2011 оноос оролцож эхэлсэн бөгөөд ШУА-ийн шугамаар хоёр төсөл хэрэгжүүлж байна.

Монгол Улс дээр дурдсанчлан 2005-2007 онд НАТО-гийн Косово дахь энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцсон бөгөөд 2010-2015 онд Афганистан дахь НАТО-гийн тэргүүлсэн Олон улсын аюулгүй байдлыг хангахад туслалцаа үзүүлэх ажиллагаанд тус тус оролцсон. Улмаар 2015 оноос “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд АНУ-тай Кабулын бүсэд, ХБНГУ-тай Умард командлалын удирдлагын дор тус тус хамтран оролцож байна.

Афганистан дахь НАТО-гийн тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн байлдааны ажиллагаанд шууд оролцдоггүй, баазын хамгаалалтын үүрэг гүйцэтгэдэг. Засгийн газрын хуралдаанаас уг ажиллагаанд үргэлжлүүлэн оролцохыг дэмжиж, асуудлыг ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвлөмж гаргуулсан. Монгол Улс цаашид НҮБ-ын мандаттай ажиллагаанд түлхүү оролцох чиглэл баримталж байгаа. Афганистан дахь НАТО-гийн тэргүүлсэн “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд нийт 4579 цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэсэн байна.

2000 îíä ÍÀÒÎ-ãèéí Çºâëºë ìàíàé óëñòàé õàðèëöàõ àñóóäëûã çîðèóä õýëýëöýýä ”Ìîíãîë Óëñûí ñàíàë áîëãîñíû äàãóó áàéãàëü îð÷èí, øèíæëýõ óõààí, èðãýíèé õàìãààëàëò

áîëîí ýíõèéã ñàõèóëàõ ñàëáàðò õàìòðàí àæèëëàæ áîëîõ òóõàé”  øèéäâýð ãàðãàñàí байдаг. 2001 îíä Åðºíõèé ñàéä Í.Ýíõáàÿð Åâðîïûí Õîëáîîíä àéë÷ëàõäàà ÍÀÒÎ-ãèéí Åðºíõèé íàðèéí áè÷ãèéí äàðãà  Æ.Ðîáåðòñîíòîé óóëçàæ õî¸ð òàëûí õàìòûí àæèëëàãààãàà ÍÀÒÎ-ãèéí “Non-triplå” îðíóóä (õàìòûí àæèëëàãààíû ìåõàíèçìã¿é)-ûí àäèëààð õàðèëöààã õÿçãààðëàõã¿éãýýð òîäîðõîé àðãà õýìæýýí¿¿äèéã òóõàé á¿ð òîõèðîëöîõ (case-by-case) çàð÷ìààð õýðýãæ¿¿ëæ áàéõààð òîõèðîëöñîí нь үндсэндээ ажил хэрэг болсон байна.

Ìîíãîë Óëñààñ ÍÀÒÎ-òàé õàðèëöàõ àñóóäëûã çîõèöóóëàõ ¿¿äíýýñ õîëáîãäîõ ÿàì, ãàçðóóäòàé çºâøèëöñºíèé ¿íäñýí äýýð Ãàäààä хэрãèéí ñàéä 2002 îíä òóøààë ãàðãàí “ÍÀÒÎ-òàé õàðèëöàõ àñóóäëûã ýðõëýí çîõèöóóëàõ õýñýã”-èéã эдгээр байгууллагын төлөөлөгчдийн îðîëöîîòîéãîîð áàéãóóëàí àæèëëàæ эхэлсэн болно.

НАТО-той улс төрийн зөвлөлдөх уулзалтыг 2 жил тутам зохион байгуулахаар тохиролцож, 2014, 2016 онд Брюссель хотноо зохион байгуулсан, сүүлчийн уулзалт 2019 оны  дугаар сард Улаанбаатар хотноо болсон байна.. Мөн манай тал НАТО-гийн дээд хэмжээний уулзалтад урилгын дагуу оролцож иржээ.

/НАТО-гийн Дээд хэмжээний уулзалтад оролцсон байдал:

- 2010 он. Португал Улс, Лисбон хот – Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж анх удаа оролцсон.
- 2012 он. АНУ, Чикаго хот – Монгол Улсаас БВУ-д суугаа Элчин сайд А.Баттөр тэргүүлэн оролцсон.
- 2014 он, ИБУИНВУ, Кардиф хот – Батлан хамгаалахын дэд сайд А.Баттөр тэргүүлэн оролцсон.
- 2016 он, Польш Улс, Варшав хот – Монгол Улсаас БВУ-д суугаа Элчин сайд Х.Даваадорж тэргүүлэн оролцсон байна. /

Ээлжит дээд хэмжээний уулзалтыг 2018 оны 7 дугаар сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулсан.  Тус  уулзалтыг Умард Атлантын Зөвлөлийн зөвхөн гишүүн орнууд, мөн НАТО-гийн түнш болон “Шийдвэртэй дэмжлэг” ажиллагаанд оролцогч орнууд гэсэн хоёр хувилбараар зохион байгуулсан байна.

Сүүлийн хэдэн жилд Монгол Улс, НАТО-гийн харилцаа идэвхтэй хөгжиж, Монгол Улсын Батлан хамгаалахын сайд тэргүүтэй төлөөлөгчид 2010 оны 3 дугаар сард НАТО-гийн төв штабт айлчилсан. 2010, 2011 онд Лондон, Бонн хотноо

болсон Афганистаны асуудлаарх олон улсын бага хуралд манай улс оролцсон. Монгол Улсын төрийн тэргүүн Лиссабон хотноо 2010 оны 11 дүгээр сард болсон Афганистаны асуудлаарх НАТО-гийн дээд түвшний уулзалтад анх удаа оролцсон билээ.

2011 оны 5 дугаар сард НАТО-гийн Аюулгүйн байдлын бодлого, түншлэлийн харилцаа эрхэлсэн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Ж.Аппатурай тэргүүтэй төлөөлөгчид манай улсад айлчилж, дээрх хөтөлбөрийн талаар яриа хэлэлцээ эхлүүлсэн. Мөн НАТО-гийн Олон улсын цэргийн штабын Ерөнхий захирал, дэслэгч генерал Ю.Борнманн тэргүүтэй төлөөлөгчид 2011 оны 9 дүгээр сард манай улсад айлчилж, олон улсын энхийг дэмжих болон эвслийн цэргийн ажиллагаа, цэргийн сургалтын  талаар санал солилцсон юм.

2005-2007 онд манай цэргийн 2 баг НАТО-гийн удирдлага дор Косовод энхийг сахиулах ажиллагаанд оролцож  байсан юм. НАТО-гийн удирдлага, гишүүн орнуудын дэмжлэг хүлээсний дүнд 2010 оны 3 дугаар сард НҮБ-ын мандаттай, НАТО-гийн тэргүүлсэн Афганистан дахь Аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүчний ажиллагаа (ISAF)-нд цэрэг илгээгч 45 дахь улс болсон. билээ

**Монгол Улс НАТО-той харилцахын ач холбогдол.** НАТО-гийн хувьд Монгол Улс түүний аюулгүй байдалд нөлөөлөхүйц шууд ашиг сонирхол бүхий улс орон биш юм. Харин улс төр, эдийн засаг, нийгмийн, түүний дотор батлан хамгаалах салбарын шинэчлэлийг ардчилсан орнуудын жишгээр амжилттай хэрэгжүүлж буй улсын хувьд социализмын дараах орнууд, ялангуяа Төв Азийн орнуудад үлгэр болох тод жишээ гэдгээрээ НАТО-ийн анхаарлыг татаж байгаа болох нь олон зүйл дээрээс харагдаж байна.

Монгол улсын оршин тогтнодог Зүүн Хойд Азид болон шууд хил залгадаг Төв Азид өнөөгийн байдлаар олон улсын аюулгүй байдал харьцангуй тогтвортой байгаа юм. Гэвч энэ бүс нутагт НАТО болон Европын орнуудын санааг зовоож байгаа тогтворгүй байдлыг үүсгэх багагүй тооны хүчин зүйлс байгааг тэмдэглэх хэрэгтэй. Эдгээр хүчин зүйлийг саармагжуулах, болзошгүй аюулаас, түүний дотор Солонгосын хойгийг тойрсон сөргөлдөөн хяналтаас гарах, ОХУ, БНХАУ-ын  дотоод байдал, тэдгээрийн хоорондын харилцаанд хурцадмал байдал бий болохоос урьдчилан сэргийлэх зэрэг олон асуудал дээр НАТО болон түүний бүрэлдэхүүнд

багтдаг зонхилох орнуудын ашиг сонирхолтой Монгол Улсын ашиг сонирхол нийлж байгаа юм.

Ер нь 1990 оноос хойш Монгол Улсын явуулж буй гадаад бодлогын гол агуулга нь өөрийн аюулгүй байдлын ашиг сонирхлыг олон тулгуурт гадаад бодлого, хөрш хоёр том гүрэнтэйгээ бүх салбарт найрсаг, хамтын ажиллагааг хөгжүүлэх, үүний зэрэгцээ олон улсын харилцааны хүрээнд гуравдагч хөршийн бодлогыг хүчтэй хөшүүрэг болгох замаар буюу бүс нутагт нэгэнт тогтсон олон улсын байгууллага, бүтцээр дамжуулан хангахыг эрэлхийлж байгаа явдал юм. Энэ агуулгаараа НАТО-г манай ашиг сонирхлыг ханган баталгаажуулах чухал хүчин зүйл, гуравдагч том хөрш хэмээн үзэж болох талтай байна.

Манай хувьд НАТО-той харилцахад зайлшгүй харгалзан үзэх асуудал бол Орос, Хятадын хүчин зүйл юм. Товчдоо хэлэхэд одоогоор ОХУ нь НАТО-той хамтын ажиллагааны онцгой гэрээтэй бөгөөд хэдийгээр үйл ажиллагаанд нь төдийлөн оролцдоггүй боловч НАТО-ийн Энхийн төлөө түншлэлийн гишүүн орон юм. Монгол Улс НАТО-той албан ёсны харилцаатай болоход ОХУ-ын зүгээс хэрхэн хандах нь тусгайлсан судалгаа шаардах том асуудал бөгөөд эхний удаад хэлэхэд бид энэ зорилгоо тэдэнд хэрхэн зөв тайлбарлаж ойлгуулахаас их зүйл шалтгаална гэж бодож байна.

БНХАУ-ын тухайд бидний явуулсан олон судалгаа уг орны албаны хүмүүс болон судлаачидтай хийсэн удаа дараагийн уулзалтуудын явцад санал бодлоо солилцсон байдалдаа дүгнэлт хийж үзэхэд Монгол Улсыг НАТО-той тодорхой хэмжээгээр хамтран ажиллахад одоогоор шууд эсэргүүцсэн байр суурь Хятадын талд  үгүй байгаа нь ойлгогддог юм. Манай улс НАТО-той хамтран ажиллалаа гэхэд түүний жинхэнэ гишүүн болох асуудал тавигдахгүй гэж тэд ойлгодог, БНХАУ-ын хувьд Монгол НАТО-ийн харилцаа нь Хятадын аюулгүй байдалд нь нөлөөлөх сүрхий хүчин зүйл болж чадахгүй гэсэн байр суурьтай байдаг болох нь олон зүйл дээр мэдрэгддэг болно.

Монгол Улс НАТО-той харилцаж байгаа өнөөгийн байдлыг ерөнхийд нь дүгнэвэл 1998 онд манай талаас дэвшүүлэн тавьсан “Энхийн төлөө түншлэл-Монгол Улс” томьёолол эрх зүйн хүрээнд баталгаажаагүй боловч амьдрал дээр бодитой хэрэгжиж байгаа гэж хэлж болохоор байна. Бүхэлд нь авч үзвэл ÍÀÒÎ-òîé õàðèëöààãàà õºãæ¿¿ëýõ òàëààðõ ìàíàé áîäëîãûí ìºí ÷àíàð íü  Ìîíãîë Óëñ ÍÀÒÎ-òàé

õàìòðàí àæèëëàõ óëñ òºð, ýðõ ç¿éí ¿íäñèéã îíîâ÷òîé á¿ðä¿¿ëýõ, õºðø õî¸ð óëñûí эргэлзээ, ä¿ðã¿éöëèéã òºð¿¿ëýõã¿éãýýð НАТО-ийн "Ýнхийн тºлºº т¿ншлэл" хºтºлбºрийн зарим арга хэмжээнд оролцоход орших тодорхой үр дүнд хүрч байгаа нь харагдаж байна.

2000 îíä ÍÀÒÎ-ãèéí Çºâëºë ìàíàé óëñòàé õàðèëöàõ àñóóäëûã çîðèóä õýëýëöýýä ”Ìîíãîë Óëñûí ñàíàë áîëãîñíû äàãóó áàéãàëü îð÷èí, øèíæëýõ óõààí, èðãýíèé õàìãààëàëò áîëîí ýíõèéã ñàõèóëàõ ñàëáàðò õàìòðàí àæèëëàæ áîëîõ òóõàé” øèéäâýðèéã ãàðãàñàí. 2001 îíä Åðºíõèé ñàéä Í.Ýíõáàÿð Åâðîïûí Õîëáîîíä àéë÷ëàõäàà ÍÀÒÎ-ãèéí Åðºíõèé íàðèéí áè÷ãèéí äàðãà Æ.Ðîáåðòñîíòîé óóëçàæ õî¸ð òàëûí õàìòûí àæèëëàãààãàà ÍÀÒÎ-ãèéí “Non-triplå” îðíóóä (õàìòûí àæèëëàãààíû ìåõàíèçìã¿é)-ûí àäèëààð õàðèëöààã õÿçãààðëàõã¿éãýýð òîäîðõîé àðãà õýìæýýí¿¿äèéã òóõàé á¿ð òîõèðîëöîõ (case-by-case) çàð÷ìààð õýðýãæ¿¿ëæ áàéõààð òîõèðîëöñîí нь үндсэндээ ажил хэрэг болсон байна.

Үүний зэрэгцээ Ìîíãîë Óëñààñ ÍÀÒÎ-òàé õàðèëöàõ àñóóäëûã çîõèöóóëàõ ¿¿äíýýñ õîëáîãäîõ ÿàì, ãàçðóóäòàé çºâøèëöñºíèé ¿íäñýí äýýð Ãàäààä Õýðãèéí ñàéä 2002 îíä òóøààë ãàðãàí “ÍÀÒÎ-òàé õàðèëöàõ àñóóäëûã ýðõëýí çîõèöóóëàõ õýñýã”-èéã эдгээр байгууллагын төлөөлөгчдийн îðîëöîîòîéãîîð áàéãóóëàí àæèëëàæ эхэлсэн юм.

**Монгол Улс, НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр.** Монгол Улс дэлхий дахины аюулгүй, тогтвортой байдлыг хангахад НАТО-ийн оруулж буй хувь нэмэр, өсөн нэмэгдэж байгаа үүргийг харгалзан сүүлийн жилүүдэд энэ байгууллагатай тогтоосон хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, түүний дотор НАТО-той хамтран ажиллах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, холбогдох гэрээ, хөтөлбөр байгуулах чиглэлээр нэлээд анхааран  ажиллаж ирсэн юм.

Үүний дүнд НАТО-гийн Умард Атлантын зөвлөл “Монгол Улс, НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр”-ийг 2012 оны 3 дугаар сарын 19-ний өдөр баталснаар манай улс Австрали, БНСУ, Япон, Шинэ Зеланд зэрэг улс орны адил НАТО-гийн түнш орны статустай болсон байна.

Энэхүү түншлэл нь энх тайван, ардчилал, хүний эрх, хуульт ёс, олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх нийтлэг эрмэлзэлд үндэслэн, хоёр талын ашиг сонирхлын хүрээнд зөвлөлдөх, хамтран ажиллах замаар харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх зорилготой юм.

2011 оны 4 дүгээр сард Берлин хотноо болсон НАТО-гийн гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалтаар НАТО-гийн түншлэлийн шинэ үзэл баримтлалыг баталсан. Монгол Улс, НАТО-гийн түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр нь энэхүү шинэ үзэл баримтлалын хүрээнд байгуулсан анхны түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр болсноороо онцлогтой.

Тус хөтөлбөрийн хүрээнд Монгол Улс одоо тулгарч буй болон шинээр үүсэж буй аюулгүй байдлын нийтлэг сорилтуудыг даван туулах, хямралаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг зохицуулах механизмыг бий болгох, мэргэжилтэн солилцох, боловсрол, сургалт, дадлага зохион байгуулах чиглэлээр НАТО-той хамтран ажиллах боломж бүрдэж байна.

Тусгайлан тэмдэглэхэд, “НАТО-гийн харилцагч, түнш орны статус нь газар зүйн хувьд Умард Атлантын бүс нутгаар хязгаарлагдсан цэрэг-улс төрийн уг эвслийн жинхэнэ гишүүнчлэлтэй ямар нэг холбоогүй бөгөөд улс төрийн хувьд чиг, гадаад бодлогын хувьд чиг, батлан хамгаалах, ер нь өргөн утгаараа аюулгүй байдлын бодлогын хувьд НАТО-гийн гишүүнийх шиг үүрэг хариуцлага хүлээхгүй, тусдаа бүтцэд хамаардаг гэж ойлгогддог юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улс цэрэг-улс төрийн шинжтэй ямар нэгэн эвсэлд нэгдэхгүй гэсэн зарчмын байр суурь, үзэл баримтлалтай энэ нь зөрчилдөхгүй байгаа гэсэн үг . Ийм учраас Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгалаа олсон энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогын суурь зарчимтай НАТО-той тогтоож буй түншлэлийн харилцаа үндсэндээ харшлахгүй байгаа бөгөөд харин чиг энэ бодлогыг хэрэгжүүлэх нэгэн чухал арга зам байж болох юм гэж манай ихэнх судлаач үзэж байгаа юм.

**Өнөөгийн байдал, цаашдын хандлага.**

НҮБ нь улс төрийн байгууллага учир дэргэдээ цэргийн хүчин үгүй юм. Ийм учраас Peace Enforcement буюу энхийг албадан тогтоох тухай НҮБ-ийн тогтоолыг сонирхогч гишүүн улсууд цэрэг хандивлан олон улсын хүчнийг зохион байгуулах замаар тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилго бүхий тодорхой үүргүүдийг гүйцэтгэдэг.

Peacemaking буюу энхийг сахиулах ажиллагаа ч энэ зарчмаар явагддаг. НАТО цаашдаа ашиг сонирхол нь илэрхий хөндөгдөх зэргэлдээ бүс нутагтаа энхийг албадах, энхийг сахиулах гол хүчин болох хандлагатай байна. Үүний тод жишээ бол 1999 оны Косовогийн дайн, одоо үргэлжилж байгаа Афганистаны хэрэг явдал юм. Энхийн төлөө түншлэл байгуулагдсан үеэсээ эхлэн НАТО нь НҮБ-ын зүгээс хэрэгжүүлж байсан зэвсэгт мөргөлдөөнөөс сэргийлэх, хямралыг зохицуулах ажиллагааны идэвхтэй хэрэгсэл болж ирсэн байна.

Энхийн төлөө түншлэлийн практик ач холбогдол нь НАТО-ийн болон энэ түншлэлийн цэргийн хүчийг хамтарсан ажиллагаанд бэлтгэх гол хэрэгсэл болоход оршиж байгаа болох нь улам бүр тодорхой болсоор байна. Энэ нь IFOR /SFOR болон KFOR ажиллагаанд олон улсын цэргийн хүчнүүдийн нэгдсэн ажиллагаа амжилттай болоход Энхийн төлөө түншлэлийн хувь нэмэр их байснаар ойлгогдож байгаа юм.

Өөр нэг асуудал бол Төв Азид олон улсын аюулгүй байдлыг хангахад НАТО, түүний Энхийн төлөө түншлэл болон ШХАБ-ын аль нь илүү үр дүнтэй ажиллаж чадах вэ ? гэдгийг тандан үндэслэлтэй дүгнэлт хийх нь Монгол Улсын хувьд ихээхэн чухал зүйл юм.

Ирээдүйд Төв Азид гарч болзошгүй мөргөлдөөнийг таслан зогсооход НАТО, түүний Энхийн төлөө түншлэл нь ШХАБ-аас ч илүү оройлох үүрэг гүйцэтгэж болох талтай нь одоогоос ажиглагдаж байгаа. Балканы хойгт явуулсан ажиллагаандаа дүгнэлт хийж Энхийн төлөө түншлэлийн орнуудын хүрээнд ирээдүйд НАТО тэргүүлсэн “Энхийн төлөө түншлэлийн орнуудын оперативын ажиллагаа” хэмээх номлолыг боловсруулж байгаа нь үүний нэг нотолгоо юм.

Сүүлийн жилүүдэд ШХАБ үйл ажиллагаагаа ихээхэн идэвхжүүлж байгаа. Гэвч НАТО түүний Энхийн төлөө түншлэлтэй харьцуулбал түүний нэгдсэн зохион байгуулалтад орох чадвар сул, санхүүгийн эх үүсвэр тийм ч сайн биш, дээр нь олон улсын аюулгүй байдлын цөөнгүй асуудлуудаар энэ байгууллагын жинхэнэ болон ажиглагч гишүүн орнуудын үзэл баримтлал ихээхэн зөрөөтэй байгаа зэрэг нь уг байгууллага бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хүчтэй нөлөө үзүүлэх чадавхтай болтол ихээхэн хугацаа хэрэгтэй болохыг харуулж байгаа юм. Нөгөө талаас ШХАБ нь эцсийн дүндээ ОХУ, БНХАУ гэсэн хоёр их гүрний харилцаа, ашиг сонирхлын нийцлээс илт хамаарах бүтэцтэй гэдгийг бид сайн ойлгож байгаа.

Хэдийгээр ШХАБ нь Төв Азийн бүс нутаг дахь АНУ болон өрнөдийн нөлөөг тэнцвэржүүлэх Хятад Оросын хэрэгсэл гэгддэг боловч сүүлийн жилүүдэд болсон олон хэрэг явдал, түүний дотор Афганистан дахь террорист заналхийл гэх мэт олон асуудал дээр гишүүн улсууд нь нэгдмэл бус байр суурьтай байсан нь түүний энэ талын чадавх ихээхэн сул болохыг нотолж байгаа юм.

Энэ бүхэн нь Монгол Улс НАТО-той хамтран ажиллах асуудалд дээрээ тодорхой ахиц гаргахын тулд ШХАБ-ын талаар үндэслэлтэй дүгнэлттэй байх шаардлагатайг харуулж байна. Үүнийг тодорхой болгох үүднээс зөвхөн нэг харьцуулалтыг авч үзье.

**Харьцуулалт:**

| НАТО-ийн Энхийн төлөө түншлэл | <u>ШХАБ</u> |
|---|---|
| Нэгдсэн зохион байгуулалт сайтай | Нэгдсэн зохион байгуулалт сул |
| Санхүүгийн баттай эх сурвалжтай | Санхүүгийн ядмаг эх сурвалжтай |
| Бие даан энхийг сахиулах туршлагатай | Бие даан энхийг сахиулах туршлагагүй |

Ойрын 10-15 жилийн хугацаанд НАТО Төв Азид хүчтэй тоглогч, тогтвортой байдлын нэг гол хүчин зүйл байх нь тодорхой байна. Ийм учраас Монгол Улс Төв Азийн чиглэл дэх бодлого, түүнчлэн гуравдагч хөршийн бодлогодоо НАТО-той хамтран ажиллах чиглэлийг идэвхжүүлэх нь зүйтэй мэт санагдаж байна. Энэ талаар багагүй туршлага хуримтлагдаад байгаа бөгөөд 1998 онд Монгол Улсын Засгийн газраас санал болгож байсан “Энхийн төлөө түншлэл-Монгол улс” гэж томьёолсон бодлого хэдийгээр манай улс уг хөтөлбөрийн гишүүн болж чадаагүй ч хоёр талын ялангуяа АНУ-ын хүчин чармайлтын үр дүнд үндсэндээ амжилттай хэрэгжиж байна гэж үзэж болохоор байна.

Үүний тод илэрхийлэл нь өмнө дурдсан 2012 оны 3 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан “Монгол Улс, НАТО хоорондын түншлэл, хамтын ажиллагааны тусгай хөтөлбөр” юм.

Монгол улс хэдийгээр НАТО-ийн ямарваа байгууллагын гишүүн биш, түүний бүтцэд нэгдэн ордоггүй боловч олон улсын аюулгүй байдлын салбарт мэдээлэл солилцох, Монголын цэргийн болон төрийн албан хаагчдыг Европын аюулгүй байдлын судалгааны Ж.Маршаллын нэрэмжит төвд суралцуулах, Монголын Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарыг энхийг сахиулах ажиллагааны сургалтад хамруулах, энэ чиглэлээр болон гамшиг ослын үеэр ажиллах үйл ажиллагааны хамтарсан хээрийн сургууль дадлага хийх, хамтарсан судалгааны ажил явуулах, эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах зэрэг олон арга хэмжээ амжилттай хэрэгжиж үндсэндээ хэвшил болоод байна. Эдгээр нь дээрх хөтөлбөрийн хүрээнд улам өргөжих, өөр бусад хэлбэртэйгээр явагдах бололцоотой юм.

Нөгөө талаасаа НАТО-той харилцах харилцаа нь Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэх, улмаар манай улсын нэр хүндийг олон улсын тавцанд өсгөх, аюулгүй байдлаа хангахад тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгч байгаа, сүүлийн үед Монгол Улсын талаар идэвхтэй гэж хэлж болох бодлого явуулах болсон хоёр хөршийнхөө ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх зорилго бүхий гуравдагч хөршийн бодлогын нэг чухал хүчин зүйл болон хувирч байгаа нь улам бүр ойлгогдох болж байна.

Үүний зэрэгцээ сүүлийн үед Украйнд болж буй үйл явдал бидний анхаарлыг зүй ёсоор татах ёстой зүйл бөгөөд гол нь энэ хэрэг явдал хэрхэн төгсгөл болох, үүний дараагаар НАТО, ОХУ-ын хоорондын харилцаанд ямар өөрчлөлт гарахаас олон зүйл шалтгаалах болно. Мэдээж хэрэг ОХУ-ын зүгээс НАТО-д хандах хандлага ихээхэн өөр, магадгүй дайсагнасан шинж чанартай болох нь одоогоор тодорхой байгаа бөгөөд энэ нь тодорхой хэмжээгээр НАТО-той хамтран ажилладаг, хил залгаа бусад орны, түүний дотор Монгол улсын хувьд сөрөг үр дагавартай байх нь ойлгомжтой зүйл юм.

### 2.2. Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдол

#### 2.2.1. Монгол Улсын геополитикийн ач холбогдлын мөн чанар, учир холбогдол

Монгол Улс нь “дотоод Ази” буюу “inner Asia”-ийн өндөрлөгт байршилтай бөгөөд ерөнхий газар зүй, түүний дотор түүхийн газар зүйн хувьд Төв Азид, улс

төрийн газар зүйн хувьд Зүүн хойд Азид хамаардаг. Цөөн хүн амтай боловч 1.5 сая км. хавтгай дөрвөлжин нутагтайн хувьд дэлхийд 18 дугаарт эрэмбэлэгддэг. Зөвхөн Орос, Хятад хэмээх дэлхийн хоёр том гүрний дунд оршин тэдэнтэй хиллэдгээрээ гео-улстөр, гео-эдийн засгийн онцгой байршилтай хэмээн түүний олон улсын геополитикийн ач холбогдлыг товчлон тодорхойлдог. Гэвч эдгээр нөхцөлийн зэрэгцээ энэ улс хэрхэн “хашлага давах”, далайд гарцгүй байдлынхаа сөрөг талыг хэрхэн эерэгдүүлэх,  даяаршил, бүс нутгийн болоод бүх дэлхийн интеграцид яаж нэгдэн нийлэх, ингэх чадвартай эсэхээс геополитикийнх нь ач холбогдлын нь өсөлт, бууралт шууд хамаарах нь тодорхой байна.

Олон улсын харилцаа, геополитикийн үүднээс Монголыг “халхавч” (buffer) болон “түшиц”  (fulcrum) орон зайн ойлголтын аль алинд нь хамааруулан үзэж болох бөгөөд судлаачид манайхыг юуны өмнө хоёр хөршийнхөө хувьд “жийргэвч”, “халхавч” буюу “бамбай” орон зай хэмээн газар зүйн болон улс төр, аюулгүй байдлын гэсэн хоёр түвшинд авч үздэг байна.

Газар зүйн утгаар Монгол Улс нь хэвтээ , босоо тэнхлэгээрээ Хятад, Оросын чухал бүс болох Хятадын Умард бүс болон Оросын Сибирийн бүсийг тусгаарлаж, тэдний харилцааны  сайн , муу аль ч үед газар зүйн бамбайн үүргээ гүйцэтгэсээр ирсэн. Ялангуяа тэдний хоорондын хүчний тэнцвэр алдагдаж, геополитикийн зөрчил, маргаан хурцадсан нөхцөлд ийм бамбайн үүрэг зайлшгүй тооцоонд ордог учиртай билээ. Улс төрийн хувьд XX зууны турш Монгол-Орос-Хятад гэсэн гурвалжны хүрээний харилцаа хэрхэн хувьсаж ирсний түүхэн сургамж нэн тодорхой байдаг. Орос-Хятадын харилцаа эрс муудаж сөргөлдөх үед Монгол улс ЗХУ-ыг аялдан дагаж бүрэн хэмжээгээр “дагуул” улс буюу Хятадын эсрэг “түшиц” газар нь болж байсан түүх эдүгээ төдийлөн холдоогүй байна. Харин 1990-ээд оноос Монгол Улс эвсэлд үл нэгдэх буюу “төвийг сахих” маягийн бодлого явуулж ирснээр нөхцөл байдал эрс өөрчлөгдсөн юм. Монгол Улс хоёр хөршийнхөө аль нэгтэй эвсэж, нөгөөгийн эсрэг дайсагнахгүй, гуравдагч орны цэргийн баазыг байрлуулахгүй, аль нэг улсын цэргийн хүчийг өөрийн нутаг дэвсгэр дээгүүр дайруулан өнгөрүүлэхгүй, цөмийн зэвсгээс ангид байх зэрэг үүрэг авч түүнийгээ олон улсын эрх зүйн хувьд баталгаажуулж ирсэн нь  хөрш хоёр орны болон бүс

нутгийн аюулгүй байдалд чухал үзэгдэл болж, бамбайн улсын “Монгол загварыг” бий болгосон гэж үзэж болно.[27]

Манай улс ОХУ-тай 3543 км урт хилээр зааглагдаж, Сибирийн цэрэг-аж үйлдвэрийн том төвүүд, сибирь дамнасан төмөр зам, Сибирь-Алс дорнодын эрчим хүчний шугамын өмнө хэсэгт оршин, ОХУ-ын Алс дорнод, Ази, Номхон далайн чиглэлийн бодлого, стратегийн чухал өмнөд халхавч орон зай болж ирсэн байна.

Харин Монгол Улс, БНХАУ-ыг 4676 км урт хил зааагладаг (энэ нь Хятадын хуурай газрын хилийн тавны нэг юм) бөгөөд хилийн шугамаас урагш 700 км-ын дотор Хятадын “гурван умард бүсийн” гол улс төр, эдийн засгийн төвүүд , сансрын болоод цөмийн туршилтын баазууд оршдог учраас Хятадын аюулгүй байдлын чухал умард халхавч болохын зэрэгцээ хойд болон баруун хойд чиглэлээр хөгжих боломжийг нь баталгаажуулагч стратегийн чухал орон зай болдог юм.

Үүний хамт Монгол Улс Зүүн Хойд Азийн тогтвортой, аюулгүй байдлын асуудлаар идэвхтэй бодлого баримталж бүс нутгийн орнуудтай хоёр болоод олон талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлж олон улсын харилцааны бүс нутгийн системд өөрийн гэсэн байр суурьтай болсноор бүс нутгийн хэмжээний “халхавч”, “жийргэвч” улс болж байгааг судлаачид тэмдэглэж байна. Нөгөөтээгүүр, их гүрнүүд, стратегийн тоглогч хоорондын өрсөлдөөн гүнзгийрч, нэн ялангуяа АНУ, Хятад, Оросын өрсөлдөөн шатлан өргөжиж буй өнөө үед Монгол улсын геополитикийн ач холбогдол эрс өсөж, олон улсын стратегийн чухал “зангилаа улс” буюу “түшиц” газар болж хувирах нөхцөл бүрдэж эхэлж байна гэж олон судлаач үзэж байна.

Геополитикийн зангилаа бүс буюу зангилаа улсын тухай нэрт геополитикч З.Бжезинский өөрийн нэг номдоо тодорхой өгүүлсэн байдаг. Тухайлбал, “fulcrum” буюу зангилаа улс нь

- нэгдүгээрт, эмзэг газар зүйн байршилтай бөгөөд энэ нь геостратегийн тоглогчдын үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхээр,

---

[27] Д.Баярхүү. Евразийн геополитик...

- хоёрдугаарт, геостратегийн тоглогчид тэр улсад орох эсэхээ шийдвэрлэж болохоор,
- гуравдугаарт, бүс нутагтаа “халхавч” байж чадахаар,
- дөрөвдүгээрт, зэргэлдээх геостратегийн тоглогчид энэ зангилаад улс төр, соёлын нөлөө үзүүлэх бололцоотой байх учиртай аж.[28]

Үүнд үндэслэн олон улсын шинжээч, судлаачид орчин үед Монголын геополитикийн ач холбогдол улам өсөн нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэцгээдэг болж байна. Тэд Монголын гадаад бодлого, гадаад харилцааны өнөөгийн байдал, төлөвийг  шинжлэн дүгнэх замаар Монголыг түшиц газар буюу зангилаа улс болгох сонирхол бүхий улс, бүлэглэлүүдийн хүрээг тодорхойлох боломжтой бөгөөд ийм геостратегийн тоглогчдод юуны өмнө хөрш хоёр улс уламжлал ёсоор орох бөгөөд улмаар АНУ, Япон, Өмнөд Солонгос, Энэтхэг, Турк, Европын холбоог тооцож болох юм гэж үзэж байна.

Хятадын судлаач Б.Хөгжилт Монгол Улсын “жийргэвч”-ийн үүргийн хувь заяаны талаар бичихдээ: “ улс төр, цэргийн хувь дах бамбайн байр суурь, үүрэг нь хувиршгүй мөнхийн юм биш. Тэр нь Монгол Улсын гадаад бодлого нь гадаад орчноос ихээхэн хамааралтайн хэрээр гадаад орчны нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөлт үүсэх боломж ч бий.  Монгол Улс нь хоёр хөрш Хятад, Оростой харьцуулахад дэндүү бага учир Хятад, Оросын хүчний тэнцвэр алдагдаж, геополитикийн зөрчил , маргаан хурцдах, эвлэршгүй болох буюу бүс нутаг, олон улсын дэглэмд эрс өөрчлөлт гарах тохиолдолд энэ улсын эвсэлд үл нэгдэх, тэнцвэртэй, төвийг сахих маягийн бодлогын гадаад нөхцөл алдагдаж, гадаад бодлогын үзэл баримтлалдаа өөрчлөлт оруулах шаардлага үүсэх, цаашлаад түүхэн цаг хугацаанд нэг талыг барьж байсан, эвсэлд нэгдэж байсан зэрэгтээ буцаж очих магадлал онолын хувьд байгааг үгүйсгэхийн аргагүй” гэсэн нь анхаарах ёстой зүйл юм.

Түүнчлэн тэр бээр энэ санаагаа гүнзгийрүүлж, манай “гуравдагч хөршийн бодлоготой” уялдуулан: “... Монголын хэрэгжүүлж байгаа “гуравдагч хөршийн бодлого нь Америкийн бүх бөмбөрцгийн стратегийн хоёр их өрсөлдөгч болох Орос, Хятадыг ойр хавиас хамтад нь хянан хумих бодлогод боломжийн орон зай бөгөөд Монгол, Америкийн харилцаа эрчимжихийн хэрээр Америкаас Монголыг

---
[28] З.Бжезинский. Великая шахматная доска.”Международные отношения”. Москва, 2002

өөрийн “нөлөөний” орон болгох гэсэн оролдлого ер нь тасраагүй. Хэрэв Зүүн хойд Азийн дэглэмд эрс өөрчлөлт гарч, Монгол нь үнэхээр Америкийн буюу түүгээр толгойлуулсан холбоотнуудын “нөлөөний” буюу түшиц газар болбол, дээр дурдсанчлан Монголын онцгой геополитикийн байршлаас шалтгаалсан, хоёр хөрш рүү чиглэсэн, улс төр, цэргийн аюул занал бий болж, зарим тохиолдолд төсөөлөхийн аргагүй хэмжээнд хүрч болох юм.

Энэ нь Оросын хувьд АНУ-ын зүгээс түүний Сибирь, Алс Дорнодын чухал бааз, шугам сүлжээг цаг ямагт хяналтад байлгаж, түүний стратегийн орон зайг шахан хумихын зэрэгцээ, шаардлагатай үед тэдгээрт цохилт хийн тасдан авах, Оросын Алс Дорнодын болон Ази-Номхон далайн бодлогыг нь сөрөн зогсоож болох юм. Хятадын хувьд мөн адилаар түүний “гурван умард бүсийн” чухал бааз, шугам сүлжээг цаг ямагт хяналтад байлгаж, стратегийн орон зайг нь хумьж шахахын зэрэгцээ шаардлагатай үед баруун тийш гарангуут Шинжаан болон дотор бүсийн харилцааг тусгаарлаж, зүүн тийш хөдлөнгүүт Зүүн Хойд бүс болон дотор бүсийн зам шугамыг нь тасдан, Хятадын Төв Ази болон Умард чиглэлийн хөгжлийн бодлогыг сөрөн зогсоох болно. Энэхүү байдал нь Хятадын Зүүн Өмнөд далай тэнгисийн орон зай шахалтад орсон нөхцөлд бүр ноцтой болох юм.”гэжээ. Тэр бээр цаашлан “орчин үеийн хэсэг орон зайн дайнд моторжсон том армийн бүлэглэлийн дайны онол нэгэнт цагаас хоцорсон ч дохионы мэдээллийн тандах болон пуужингийн стратегийн сүрдүүлэг хийх талаарх Монгол Улсын байршлын ач холбогдол буурсан биш харин ч нэмэгдсээр байна” гэж тэмдэглээд дээрх “нэн ноцтой байдлын” тухай таамаглал нь эдүгээ зөвхөн онолын хувьд магадлалтай, харин Монголын гадаад бодлогын үзэл баримтлал, энэ улсын гол үзэл бодол өөрчлөгдсөн цагт л “сая байж болно” хэмээн сэрэмжлүүлсэн байна[29]. Хятадын шинжлэх ухааны удирдлагын онцлогийг харгалзан үзвээс судлаач Хөгжилтийн дээрх санаа, үнэлэлт дүгнэлт нь энэ улсын албан ёсны байр сууриас нэг их хол тусаагүй гэж үзэж болох юм.

АНУ болон түүний өрнө, дорнын холбоотнууд Монголын “гуравдагч хөршийн бодлого”-ыг үндсэндээ бүрэн хүлээн зөвшөөрч дэмждэг. Ингэхдээ харилцаагаа манай хоёр хөршийн эсрэг ашиглахгүй хэмээн мэдэгдэж, Монгол-Хятад, Монгол-

---

[29] Б.Хөгжилт. Монгол Улсын геополитик, геоэдийн засгийн байр суурийн тухай шинжилгээ. МУИС-ОУХНУС. Олон улсын харилцаа сэтгүүл. 2016 №1/32 (458)

Оросын харилцаа тэнцвэртэй, тогтвортой байхын чухлыг тэмдэглэн, энэ нь Монгол Улсын аюулгүй байдал, хөгжил дэвшилд төдийгүй бүс нутгийн тогтвортой, аюулгүй байдалд шууд учир холбогдолтой болохыг онцолж байдаг боловч энэ нь З.Бзежинскийн номнол Евразийн нэгэн "зүрхэн хэсэгт" үйлчлэхгүй байгаа гэсэн үг бус гэж зарим судлаачид шулуухан хэлдэг болно.

Тайваны нэгэн судлаач эрдэмтэн: "Монголын талаарх АНУ-ын стратегийн санаа бодол тов тодорхой... АНУ-ын хувьд Монгол нь Хятадыг тогтоон барих стратегийн бааз, Хятадыг тайван замаар өөрчлөх үйл явцын катализатор, хятадын хилийн байдлыг амаргүй байлгах хөзөр нь байж болох талтай[30] гэж дүгнэсэн бол ОХУ-ын судлаач, монголч эрдэмтэн В.Грайворонскийн үзэж байгаагаар: "Төв Азийн гүнд, бодит эсвэл болзошгүй өрсөлдөгч, дайсан хэмээн АНУ-ын үздэг Орос ба Хятадын дундах газар зүйн болон геополитикийн байрлалтай тул Вашингтоны хувьд Монгол Улс геополитикийн болон стратегийн онцгой ашиг сонирхолтой гэдэг нь тодорхой. АНУ-ын хувьд тус орон нь Орос, Хятад, Төв Азийн улс орнуудад өрнөж буй улс төр, эдийн засгийн үйл явцыг эвтэйхэн, тасралтгүй ажиглах түшиц газар, өөрийн гадаад бодлогыг идэвхтэй явуулах, Монгол болон бүс нутагт америкийн үнэт зүйлс, ардчилал ба хөгжил дэвшлийн арга замын талаарх төсөөллөө түгээх, Зүүн Ази дахь өөрийн байр сууриа бэхжүүлэхэд тохиромжтой нутаг дэвсгэр юм. Тэр бээр цааш нь Монголын гадаад харилцааны бодлогын талаарх Оросын байр суурийг илэрхийлж энэхүү бодлого нь "... Орос, Хятадын нөлөөллийг тодорхой хэмжээгээр тэнцвэржүүлэх чадвар бүхий улс орон, бүлэг улс орон зэрэг томоохон, нөлөө бүхий, гуравдагч /Орос ба Хятадаас бусад/ гадаад хүчин байхаар заасан. Энэ асуудал нь Орост ч тэр, Хятадад ч тэр тодорхой болгоомжлол, сэтгэл зовнил төрүүлж байгаа нь ойлгомжтой. Оросын хувьд бүр ч их...хэмээсэн байна[31].

Дээрх зүйлүүдийг нэгтгэн дүгнэж үзэхэд сүүлийн үед том гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлын өрсөлдөөний шинэ төв хэмээн нэрлэгдэх болсон Монгол Улс болон түүний эргэн тойронд бий болсон геостратегийн орон зай нь хуучин ЗХУ-ыг задран тарсны дараа буюу 1990-ээд оноос бүрдэж эхэлсэн байна. Үүний гол учир шалтгаан нь манай улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашин, төр, нийгмийн тогтолцооны өөр өөр системүүдийн зах нийлсэн

[30] *Mei-hua lan, Associate-professor, National Chengchi University, Taiwan. /XX зуны Монгол... /
[31] В.В.Грайворонский. Концепция внешней политики Монголии в действии: отношения с Россией, КНР, США и Японией. /XX зууны Монгол... н. 231 /

заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын уулзварт оршдогт байгаа юм. Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших түүний геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Хэдийгээр газар зүйн байршлын хувьд дэлхийн хоёр том улсын дунд түгжигдмэл байдалтай оршдог, үүний дээр олон улсын эдийн засгийн тогтолцоонд бүрэн хэмжээгээр нэгдэн ороход нь ихээхэн саад болж буй дэд бүтцийн орчин үеийн сүлжээ гэхээр юм бараг үгүй боловч энэ орон Зүүн хойд Азид өрнөж буй геополитикийн хүчтэй өрсөлдөөнд бололцооныхоо хэрээр ухаалгаар оролцож, харьцангуй бие даасан тоглогч болон гарч ирж байгааг олон орны судлаачид тэмдэглэж байгаа болно.

Энэ нь юуны өмнө бусад оронтой харьцуулахад дөнгөж саяхнаас олборлож эхэлсэн манай орны нүүрс устөрөгчийн агуу их нөөцтэй холбоотой нь ойлгомжтой юм. Мөн алт, зэс, уран, ховор металл болон байгалын бусад баялгийн нөөц үүнээс ч багагүй анхаарал татаж байгаа нь тодорхой юм. Үүн дээр нэмээд үндсэндээ тоталитар дэглэмтэй дэлхий хоёр том гүрний дунд хавчигдан оршиж байгаа боловч ардчиллыг хөгжүүлэх талаараа социализмын дараах орнуудад, ялангуяа Азийн улсуудад үлгэр жишээ болж байгаа болон дэлхий нийтийн хувьд тогтворгүй байдлын нэг үндэс болоод байгаа лалын ертөнцтэй хил залгаа оршдог нь манай орныг том гүрнүүдийн зүгээс Зүүн хойд болон Төв Азид явуулж буй геостратегийн бодлогынхоо төвд байлгах зайлшгүй ашиг сонирхлыг үүсгэж байна.

Эдгээрийн улмаас Монгол Улс өнөөдөр дэлхийн хамгийн том гурван гүрэн АНУ, БНХАУ, ОХУ, Зүүн Хойд Азийн өөр хоёр хүчирхэг улс Япон, Өмнөд Солонгос, түүнчлэн энэ бүс нутгийн төлөөх геополитикийн өрсөлдөөнд оролцож буй идэвхтэй тоглогчдын нэг болох Канадын геополитик, геостратеги, гео эдийн засгийн ашиг сонирхлын өрсөлдөөний уулзварт орших боллоо. Үүнээс гадна Монгол Улсын Хойд Солонгос болон Тайвантай харилцахдаа баримталж байгаа найрамдалт байр суурь нь том гүрнүүдийн зүгээс Зүүн хойд Ази дахь геостратегийн бодлогодоо анхаарах өөр нэг зайлшгүй учир шалтгаан болж байгаа нь тодорхой юм.

### 2.2.2. Монгол Улсын геополитикийн аюулгүй байдлын асуудал

Аливаа жижиг улсын геополитикийн аюулгүй байдал нь түүний үндэсний

соёл иргэншлийн шинж чанартай нягт уялдаатай байдаг. Ер нь аливаа үндэстний геополитикийн гэж хэлж болох аюулгүй байдлын мөн чанар нь дараах хэдэн чадавхыг өөртөө агуулж чадаж байгаа эсэхээс ихээхэн хамаардаг болно. Үүнд:

- хүн амын тоо, чанар, төрөлх хэл, соёл, уламжлал зэрэг түүхэн мөн чанар, оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, өвөг дээдсээс уламжлан ирсэн үр удам, төрөлх газар нутгаа хамгаалах чадавх;

- түүхийн ямар ч нөхцөл байдалд үндэстний онцлох шинж чанараа хадгалах, дахин сэргээх чадавх;

- өөрийн орны геоподлитикийн давуу шинж чанар, уламжлалаа баяжуулан хөгжүүлэх, оюун санаа, соёл иргэншлийн өвөрмөц шинж чанараа бусдаар хүлээн зөвшөөрүүлэх чадавх.

Энэ нь бидний хувьд бол монголоороо үлдэх, монголоороо дахин сэргэх, монголоороо хөгжих гэсэн утгатай дүйцэх ойлголт юм. Ингэхдээ зөвхөн монгол гэдэг нэрээрээ биш өвөг дээдсээсээ өвлөн үлдээсэн дотоод мөн чанар, амьдрах арга ухааныг ухааран ойлгоход ихээхэн учир агуулагдаж байгаа бололтой. Аливаа үндэстний дотоод мөн чанар нь ард түмний ёс суртахууны болон үйл хөдлөлийн загварын үндэс болох үндэстний өвөрмөц шинж чанарыг өөртөө агуулж байдаг соёл иргэншлийн дархлаагаар илэрхийлэгддэг нь тодорхой юм. Бид энэ дархлаагаа хамгаалах бодлого, үйл ажиллагаагаа “хар хайрцгийн бодлого” гэж нэрлэх нь бий. Энэ нь үндэстний элитийн болон үндэстний ухаантнуудын эрхэм чухал үүрэг байдаг бөгөөд хэрэв үүнийгээ алдах юм бол үндэстэн мөхөж сөнөдөг зүй тогтолтой байдаг.

Ямар ч соёл иргэншил, түүнд хамрагдаж буй үндэстэн ястан бүр өөрийн үнэт зүйлсийн тогтолцоогоо бусад үндэстнүүдэд тараан дэлгэрүүлэх эсвэл түүнийхээ зарим зүйлийг өөрийн ашиг сонирхлын үүднээс хүчээр тулгахыг оролддог нь хүн төрөлхтний хөгжлийн зүй тогтол юм. Үүнтэй холбоотойгоор шинээр бүрэлдэн бий болж буй геополитикийн шинэ нөхцөл байдал нь Монгол үндэстний соёл иргэншлийн дархлаанд буюу хар хайрцгийнхаа бодлогод юуг хамааруулж ойлгох, түүнийгээ бидний эргэн тойронд байгаа бусад том соёл иргэншлийн үнэт зүйлсийн түрэлтээс хэрхэн хамгаалахын зэрэгцээ хил залгаа нутаг, түүнчлэн өөр бусад оронд амьдран сууж буй монгол үндэстнүүдтэйгээ соёл, иргэншлийн харилцаа

холбоотой байхыг чухалчлах талаар бид эргэн санаж, нухацтай бодох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Монгол соёл иргэншил бусдад колоничлогдож, дайнд нэрвэгдэж, харийнханд эзлэгдэж, элдэв аюулд өртөж байсан боловч өөрсдийн уламжлалт үнэт зүйлс, амьдрах эрч хүч, соёл иргэншлийн дархлаагаа үндсэндээ хадгалж чадсаар ирсэн юм. Үүнд л манайх шиг жижиг үндэстэн улс өнөөдөр ч оршин тогтнож, өөдөлж, хөгжсөөр байгаагийн нууц агуулагдаж байгаа бололтой. Монгол үндэстний соёл иргэншил нь дэлхий дээр эртийнд тооцогдох бөгөөд олон мянган жилийн турш өөрийн эрч хүчээ хадгалсаар байгаа нь үүний нэг нотолгоо болж байна.

Үүнтэй холбогдуулан ОХУ-ын Геополитикийн академийн ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, профессор, хурандаа генерал Л.Г.Ивашовын бидний тухай бичсэн нэг санааг дурдахыг хүсэж байна. Тэр бээр хэлэхдээ “1990-ээд оны эхнээс Монгол Улсыг тойрсон монгол хэлтэн үндэстнүүд Нармай Монгол Улсыг байгуулах үзэл санааны дор нэгдэж эхэлж байгаа талаар гадаадын ялангуяа, ОХУ, БНХАУ-ын судлаачдын дунд ихээхэн яригдах болсон нь үнэн юм. Мэдээж хэрэг ийм улс байгуулагдах, тэр тусмаа Орос, Хятадын газар нутгаас тасдан авч бий болох нь юу л бол. Гэхдээ дэлхийн геополитикийн бүтцэд гарч эхэлж буй өөрчлөлт, үүний дотор Хятадын асар том хүчирхэг соёл иргэншлийн тэднийг залгиж болох аюулыг соргогоор мэдэрсэн Чингис хааны үр сад Орос, Хятад, Европ, Австрали гээд дэлхийн бусад бүх оронд амьдарч буй монголчуудынхаа дэмжлэгийг олохыг чармайж байна. Яагаад вэ, гэвэл аливаа нэг соёл иргэншлийн хүрээний гадна, тэр тусмаа хил залгаа байж өөрийн оршин тогтнох эрх, тусгаар тогтнолоо хадгална гэдэг ямар хүнд хэцүү зүйл гэдгийг тэд хэнээс ч илүү мэдэх хүмүүс юм” гэсэн байдаг.

### 2.2.3. Монголын талаарх их гүрнүүдийн геостратегийн бодлого.

Монголын талаарх БНХАУ-ын геостратегийн бодлого: мөн чанар, учир шалтгаан.

БНХАУ нь өөрийн эдийн засгийн хөгжил, аюулгүй байдлын стратегиа амжилттай хэрэгжүүлэхийн тулд гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, энэ зорилгоор дэлхийн бусад том гүрэнтэй ажил хэрэгч харилцааг эрхэмлэж, хил

залгаа хөршүүдтэйгээ, түүний дотор Монгол Улстай аль болох тогтвортой хамтын ажиллагаатай байхыг чармайж байгаа юм. Түүний хувьд өөрийн нөлөөг гадагш тэлэх, эрчим хүчнийхээ асуудлыг шийдвэрлэх өргөн боломжийг олгож болох хамгийн ойрын хөрш бол Монгол Улс гэж олон орны судлаачид бичдэг болно. Стратегийн чухал ач холбогдолтой байршлын зэрэгцээ хүн ам бараг оршин суудаггүй Монголын уужим тал нутаг нь Хятадын хувьд иргэдийнхээ зарим хэсгийг ирээдүйд нүүлгэн шилжүүлэх орон зай гэж ойлгогдож болох юм хэмээн цөөнгүй тооны судлаачид тэмдэглэсээр ирснийг бид бас санаж байх учиртай.

Õÿòààäûí ýäèéí çàñãèéí ýð÷èìòýé ºñºëò íü  түүний геополитик, гео-эдийн засгийн бодлогын хувьсал, хөгжлийн гол үндэс нь болж байна. ÀÍÓ, ÎÕÓ-ûí геостратегийн íºëºº Àçèä çàðèì òàëààð ñóëàð÷ ò¿¿íèé îðîíä ýäèéí çàñãèéí òîãòâîðòîé, ýð÷èìòýé õºãæèëä òóëãóóðëàñàí Õÿòàä óëñûí îðîëöîî өсөх болов. Ýíý íü Õÿòàääàä áàéíãûí äàðàìò ¿ç¿¿ëæ áàéñàí ÇÕÓ çàäðàí òàðñíààð áîëîí ëàëûí åðòºíö á¿õýëäýý ÀÍÓ, ÎÕÓ-ûí ýñðýã áàéð суурьт шилжиж áàéãààãààð íºõöºëäºõ áºããä ¿¿íýýñ ¿¿äýí Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò ººðòºº àøèãòàé ýäèéí çàñàã, öýðýã-óëñ òºðèéí áàéð ñóóðü ýçëýõ áîëîìæîî Õÿòàääàä нэмэгдэж байна. Ийм орон зайн тэлэлт  Монгол Улсыг ч хамрах болсны анхны шинж тэмдгүүд мэдрэгдэж эхлээд байгаа билээ.

Монгол Улсын хувьд Хятад бол манай бүтээгдэхүүний хамгийн ойр бөгөөд багтаамжтай зах зээл, импортын хямд эх булаг болж байгаа ч тэр нь манай улс Хятадын улсын төрийн бодлогын золиос болох боломжийг нэмэгдүүлсээр байна. Энэ бол Хятадын хувьд геополитикийн нэг том хөшүүрэг мөн.

Харин Хятадын хувьд манай улс бол Оростой хиллэх газарзүйн байршлаараа түүнд зөөлөвч болж байгаа боловч Монголд нөлөөллөө тогтоох  нь Евразийн геополитикийн нэн чухал хаалга болно. Зарим геополитикч нар Монгол Улсыг Хятадын нөлөөллийн бүсэд багтааж байгаа нь ч санамсаргүй хэрэг биш билээ.

Түүх, улс төр, эдийн засаг, сэтгэл зүй, үндэс угсаа зэрэг гадаад, дотоод бодлогын хүчин зүйлүүдийг хамарсан Хятадын геополитикийн чухал чиглэлийн нэг бол яах аргагүй Монгол мөн. Энд зөвхөн Хятад-Монголын харилцаа бус мөн БНХАУ-ын геополитикт бүхэлд нь нөлөөлөх эгзэгтэй асуудлууд цөөнгүй бий. Бээжингийн зүгээс Монголын талаар ямар бодлого баримталж байгаагаас

тодорхой бүс нутаг болон улс орнууд, ялангуяа Төв Азийн улс орнуудтай харилцах Хятадын бодлогын үр дүн тодорхой хэмжээгээр шалтгаалж байгаа юм.

Цэрэг-улс төр, эдийн засгийн чадавх, хүн амын тооны хувьд эрс ялгаатай энэ хоёр улс өөр хоорондын харилцаандаа тус бүртээ ашиглаж буй стратеги нь Хятад-Монголын харилцааны өвөрмөц онцлогууд дундаас хамгийн их сонирхол татах зүйл болоод байна.

БНХАУ-ын зүгээс баримталж буй бодлогын үндэс бол “зөөлөн хүчний” гэж нэрлэгддэг стратеги. Харин Улаанбаатар “хатуухан сул талын” стратеги ашигладаг. Энэ нь монголчуудын хэлдгээр “зөөлөн нь хатуугаа иднэ”, эсвэл “чулууг чулуу дийлдэггүй. Чулууг ус л дийлдэг” гэсэн агуулга бүхий стратеги мөн. Үүний мөн чанар нь өөрт байгаа сул талуудаа ухаалгаар ашиглан илүү хүчирхэг хөршүүдийн зүгээс явуулж буй хүч давамгайлах бодлогыг үр дүнгүй болгох явдал юм. Энэхүү эсрэг тэсрэг хоёр стратеги хэрхэн амжилттай хэрэгжиж болдгийг Хятад, Монгол хоёрын харилцаа харуулж байгаа. Хүчирхэг гүрэн ба сул дорой хөрш улс өөр хоорондоо хэрхэн харилцаж, энх тайвнаар зэрэгцэн оршихыг ойлгоход Хятад-Монголын харилцааны судалгаа ихээхэн тустай зүйл болоод байгаа юм.

Өнөөдөр Монголын талаар баримталж буй Хятадын геостратегийн бодлого нь манай улсын бие даасан байдлыг хүндэтгэх үндсэн дээр найрсаг харилцаагаа “иж бүрэн стратегийн түншлэлийн” түвшинд хөгжүүлэх, эдийн засгийн тогтвортой хөгжлийн замд учирч буй бэрхшээлүүдийг даван туулахад бидэнд туслах, үүний зэрэгцээ байгалийн болон бусад түүхий эдийн нөөцийг ашиглах салбарт өөрийн оролцоогоо идэвхтэй нэмэгдүүлэхэд оршиж байна.

Үүнийхээ зэрэгцээ, Хятад нь улсынхаа хойд хил орчимд аюулгүй байдлыг хангах, үндэстний цөөнхүүдээ Монгол Улсад болж буй үйл явдлын шууд болон дам нөлөөнөөс хамгаалах, түүнчлэн Тайваны болон Далай ламын талаар баримталж байгаа манай улсын бодлогыг өөрийнхдөө нийцүүлэхэд байнга анхаарч байна. Үүнээс гадна Монгол Улс батлан хамгаалах салбарт АНУ-тай идэвхтэй түншилж, ОХУ-тай цэрэг-техникийн хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсээр байгаа нь тэдний хувьд геостратегийн тулгамдсан асуудлуудын нэг болж байгаа нь мэдрэгддэг болно.

Үүний хамт, Õÿòàä улсаас хөрш áóñàä улс оронтой явуулж буй õàðèëöààíä орших зарим ¿ë îéëãîëöîë, түүний дотор газар нутгийн маргаан, түүнчлэн òóñ óëñûí дотоодод болж буй íèéãýì, óëñ òºðèéí áîëîí ¿íäýñòýí ÿñòíóóäûí õîîðîíäîõ çºð÷èë, сөргөлдөөний öààøäûí õàíäëàãà тодорхойгүй байгаа нь энэ улстай хамгийн урт хил залгаа ìàíàé îðíû õóâüä анхаарахгүй байж үл болох асуудлууд хэвээр байна.

<u>Монголын талаарх ОХУ-ын </u>геостратегийн <u>бодлого: мөн чанар, учир шалтгаан.</u>

ОХУ бол Монгол Улсын хувьд түүхэн сайн хөрш, ядрах цагт туслах сайн нөхөр, үнэнч анд хэмээн бараг нэгэн зууны туршид нэрлэгдэж ирсэн билээ. Гэвч хоёр талд хүний насны нэгэн үе солигдож "шинэ Орос", "өөр Монгол" үүсээд байна. Тэд бидний түүхэн уламжлалаас хөндий өсөж өндийж байна. Тиймээс тэс өөр харилцаа, бодлогыг дэмжих хандлагатай байна. Монголд улс төр, эдийн засаг, нийгмийн эцэс төгсгөлгүй шинэчлэл хийж, оросын хувьд найр тавьж найдах юм харагдахгүй байгаа бол монголчууд оросыг Евразийн түүхэн уламжлалаас улам бүр холдож, зөвхөн европын зүг харсан эзэнт гүрний геополитикийн бодлого хэрэгжүүлж байна хэмээн харж байна. Бас Орос-Хятадын геополитикийн тэнхлэгт Оросын хүлээж байгаа үүрэг Монголын хувьд ямар үнэ цэнтэй тусах вэ? – хэмээн санааширч байна. Бидний хооронд улс төрийн өндөр түвшний мэдэгдэл, нэрлэсэн стратеги байгаа ч бодит практик харилцаа сул байна. ОХУ-ын хувьд Монгол Улс хөгжиж, хүчирхэгжих нь түүний бүрэлдэхүүн дэх монголчуудыг өөртөө татах хортой үр дагавартай хэмээн харж байх шиг байна. Тиймээс Монголыг ОХУ-ын бүрэлдэхүүн дэх монгол үндэстнүүдээс доогуур хөгжилтэй байлгах сонирхолтой байна. Үүн дээр манай "гуравдах хөрш"-ийн бодлого даарь дээр нь давс асгаж байгааг ч үгүйсгэх аргагүй билээ.

Гэвч Монголыг нөлөөллийнхөө гадна орхивол юу болохыг оросууд бас сайтар ойлгож байгаа юм. Энэ нь Монгол Улс Орос-Хятад хоорондын геополитикийн орон зайд тусгаарлах үүрэг гүйцэтгэж буй энэ шинжлэх ухааны хэллэгээр бол "эрэг орчмын бүс нутаг" болж байгаатай гол нь холбоотой юм.

ОХУ нь Монголын талаар тусгайлан баримтлах геостратегийн чухал ашиг сонирхол бүхий орон гэдгийг хэн бүхэн мэднэ. Хэдийгээр өөрийн дотоод болон гадаад хүчин зүйлийн олон асуудалтай боловч Орос улс дэлхийн болон бүс нутгийн гол тоглогчдын шахалтад автагдан Монгол Улсад үзүүлж ирсэн нөлөөгөө

үндсэндээ бүрэн алдах болон манай орныг түүний оролцоогүйгээр олон улсын геополитикийн ашиг сонирхлын өөр орон зайд нэгдэн орохыг зөвшөөрөхгүй гэдэг нь ойлгомжтой зүйл юм.

Энэ нь юуны өмнө Монгол Улсын нөхцөл байдал түүний үндэсний аюулгүй байдалтай нягт холбоотой, түүний дотор манай улсын цэрэг-стратегийн чухал байршил нь олон жилийн турш Өмнөдөөс заналхийлж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх бамбай болж ирсэнтэй холбоотой юм. Монгол Улс нь үндсэндээ бүхэл бүтэн зууны турш түүний өмнөд хилийн 3500 гаруй км үргэлжилсэн хэсгийг батлан хамгаалж ирсэн, одоо ч хамгаалсаар байгаа нь түүхэн үнэн билээ.

Үүний зэрэгцээ Оросын улс төр, геостратегийн ашиг сонирхол нь тус улсын бизнесийн ашиг сонирхолтой төдийлөн нийцэхгүй байгааг бид бас тооцох учиртай. Үнэн чанартаа Оросын эдийн засгийн ашиг сонирхол нь манай орны байгалийн баялаг / ураны нөөцөөс бусад/ , үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбарт нэвтрэн орох гэхээсээ илүүтэйгээр зөвхөн Монгол, Оросыг биш ,мөн Өрнө, Дорныг холбох агуу том төслийнх нь нэг хэсэгт багтдаг манай нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрөх  тээврийн сүлжээний ирээдүйд оршиж байгаа нь олон зүйл дээрээс ойлгогддог юм

Оросын хувьд Монгол Улсын иргэдтэй тогтоосон бүтэн зууны түүхтэй, элгэмсэг харилцааг хадгалах, түүний дотор орос хэл үзэх явдлыг сэргээх, монголын хүн ардын дунд өөрийн улс, ард түмний тухай эерэг сэтгэгдлийг дахин бий болгох   нь түүний геостратегийн бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг байх ёстой тухай багагүй яригдах болоод байна.

ОХУ нь манай их хөрш. Одоогоор улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны бүх салбарт найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай орон юм. Монгол хүний сэтгэлд оросын ард түмний их ач тус, өгөөмөр сэтгэлийг хүндэтгэх, бүх зүйл дээр тэдэнд хандаж тусламж хүсэх, түшиг тулгуураа болгох сэтгэлгээ хүчтэй хадгалагдан үлдсээр байна.

Үүний зэрэгцээ сүүлийн óåä ÎÕÓ, Умард атлантын эвслийн нөлөө Азид тархахын ýñðýã èäýâõòýé ¿éë àæèëëàãààà явуулах болж ү¿íèé òóëä энэ эвслийн ýñðýã õîëáîîòîí áàéæ áîëîõ óëñ îðíûã ýðæ õàéõ, çàðèì óëñ îðîíä ÿëàíãóÿà õóó÷èí ÇÕÓ-ûí бүрэлдэхүүнд áàãòàæ áàéñàí óëñóóäàä ¿¿íäýý íýãäýõèéã õàòóó, çººëºí ÿíç áóðèéí

õýëáýðýýð òóëãàõ áàéäàë àæèãëàãäààæ эхэлсэн нь бидний анхаарлыг бас татаж байгаа болно. Ýíý íü õóó÷èí ñîöèàëèñò õàìòûí íºõºðëºëèéí ãýãäýæ áàéñàí óëñ îðíóóäàä, ò¿¿íèé äîòîð Ìîíãîë óëñàä ÿìàð íýã õýëáýðýýð õàìààð÷ áîëîõûã үгүйсгэх áàòàëãàà одоогоор байхгүй юм. ÍÀÒÎ-ãèéí ýñðýã ¿éë àæèëëàãààíààà Õÿòàä óëñûã ãîë õîëáîîòíîî áîëãîõîîð á¿õèé ë õ¿÷èí ÷àðìàéëòàà ãàðãààæ áàéãàà ýíý ¿åä ÎÕÓ-ûí Зүүн хойд Азид хэрэгжүүлж буй геостратегийн áîäëîãîä Ìîíãîë óëñ ÿìàð íýã òîãòîõîé áàéð ñóóðü ýçëýõ íü åðºíõèéäºº îéëãîìæòîé áàéãàà áîëíî. Ер íü Ìîíãîë óëñààñ áóñàä îðîíòîé òóóíèé äîòîð ÀÍÓ-òàé öýðãèéí ñàëáàðò õàìòðàí àæèëëàõ ÿìàð íýã àëõàì õèéãäýõýä Îðîñûí àëáàíû çàðèì õ¿í òóéëûí ýìçýã õàíäààæ õ¿ëýýæ àâäàãààñ энэ нь ерөнхийдөө ойлгогддог юм.

Олон улсын бодлогын хувьд ОХУ нь дэлхийн олон “туйлт” тогтолцоог төлөвшүүлэх, НАТО-гийн тэлэлтийг тогтоон барих стратегийнхаа хүрээнд Монголыг татаж оруулах, өөрийн “холбоотноо” дахин болгох үүднээс сүүлийн жилүүдэд хоёр талын харилцаанд улам илүү анхаарах болсон нь  илэрхий байна.

<u>Хоёр орны харилцааны талаарх ОХУ-ын зарим байр суурь.</u>

Оросын судлаачид 1990-ээд оноос эхэлсэн шилжилтийн үеийн эдийн засгийн уналтын улмаас Орос, Монгол хоёр улс системийн гүнзгий хямралд нэгэн зэрэг нэрвэгдэж үйлдвэрлэл, аж ахуй, худалдаа, эдийн засаг, соёл урлаг, шинжлэх ухаан зэрэг салбар дахь уламжлалт харилцаа холбоо ихээхэн алдагдаж зарим нь үндсэндээ тасарсан гэж дүгнэдэг.Тухайлбал, Монгол Улсад үзүүлдэг тусламжийн цар хэмжээ эрс хорогдож, энэ үйл явц эхэлснээс хойших 10 жилийн дотор гэхэд л хоёр улс хоорондын худалдааны нийт эргэлт 10 дахин буурсан гэсэн тоон үзүүлэлтийг тэд дурддаг юм.

Харин Монголын төр, нийгмийн шинэчлэлийн хамгийн хүнд үеэс эхлэн олон улсын банк,санхүүгийн байгууллагууд (ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк гэх мэт), АНУ, Япон, Герман, Бүгд Найрамдах Солонгос Улс болон бусад өндөр хөгжилтэй  зарим улс орон төрөл бүрийн тусламж, дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд ингэснийхээ үр дүнд өөрсдийн гэсэн  орон зай, байр суурь эзлэн, үр нөлөөгөө өргөтгөн бэхжүүлж чадсаныг ОХУ тийм ч таатай хүлээж авдаггүй нь тодорхой. Оросууд энэ нөхцөл байдлыг тэдний хувьд Зүүн Хойд Азид хэрэгжүүлж байсан геополитикийн бодлогын ноцтой алдаа болсон гэж дүгнэх нь багагүй тохиолддог болно.

2000-аад оны эхэн үеэс Орос улс системийн гүнзгий хямралаасаа гарч, түүний улс төр, эдийн засгийн байдал аажмаар сайжран, гадаад бодлогынхоо дорно зүгийн хандлагыг идэвхжүүлэхийн хирээр Орос, Монголын харилцаанд бий болсон хоосон орон зайг арилгах шаардлагыг аргагүйн эрхэнд ойлгох болсон юм. 2000 оны 11 дугаар сард Орос улсын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад албан ёсны айлчлал хийж Улаанбаатарын тунхаглалд гарын үсэг зурсан бөгөөд энэ нь тус хоёр улсын харилцааг идэвхжүүлж, түр доройтол, зогсонги байдлаас татан гаргаж шинэ шатанд хүргэх анхны томоохон алхам болсон гэж Оросын судлаачид бичиж байна.

Эдүгээ Орос улс үндэснийхээ аюулгүй байдлыг дотоод болон гадаад улс төрийн ашиг сонирхлоо үр дүнтэй хослуулах замаар хангахыг хичээж байна. Ингэхийн тулд Сибирь, Алс Дорнодын нутгаа түлхүү хөгжүүлж, Ази, Номхон далайн бүс нутагт өрнөж байгаа эдийн засгийн интеграцийн үйл явцад идэвхтэй оролцоход онцгой ач холбогдол өгөх боллоо. Үүнтэй уялдаатайгаар Орос улсаас АНД-н бүс нутагт баримталж байгаа гадаад бодлогод Монгол Улс чухал байр суурь эзлэх болж манай орныг стратегийн түншээ хэмээн нэрлэх болжээ.

Оросыг Монголтой нягт холбодог геополитикийн хүчин зүйлсэд дараах ойлголтуудыг хамааруулан үзэж байгаа нь тэдний явуулсан олон тооны судалгааны материалаас харагддаг юм. Үүнд.

- хуурай замаар 3,5 мянга км шахам үргэлжилсэн улсын хил;
- орос, монгол ард түмний хооронд улс төр, худалдаа, эдийн засаг, соёл иргэншил, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарт тогтсон найрамдалт харилцааны уламжлал;
- өнгөрсөн XX зууны 70 гаруй жилийн дотор нэг адил амаргүй хувь заяа, жаргал, зовлон, ялалт, ялагдал зэргийг зэрэгцэн амсаж өнгөрүүлсэн түүх;
- хоёр улс шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулаад үндсэндээ нэг чиглэл рүү, тухайлбал зах зээлийн эдийн засаг, ардчиллын зүг зэрэг хөгжин дэвшиж, хамтын ажиллагаагаа шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх нэгэн адил хүсэл эрмэлзэлтэй байгаа
- Монгол Улсын эдийн засгийн эргэлтэд оруулж эхлээд байгаа байгалийн асар их баялгаа олборлох, боловсруулах, тээвэрлэж зах зээлд хүргэхдээ хүссэн хүсээгүй ОХУ-ын шинжлэх ухаан, технологийн бааз, хамтарсан төмөр замд түшиглэхээс өөр арга байхгүй гэсэн хатуу итгэл зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд Оросын зарим томоохон төрийн өмчийн болон хувийн хэвшлийн компаниуд Монголтой хамтран ажиллах сонирхлоо хүчтэй илэрхийлэх болж, хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд саад тотгор болж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байгаа юм. Үүнд, гадаад худалдааны алдагдлыг багасган тэнцвэржүүлэх, бүтцийг нь сайжруулах, тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг арилгах, Монгол Улсад хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, тохиролцсон зүйлийн биелэлтийг хангах үүрэгтэй хоёр улсын яамд, албадын хоорондын зохицуулалтыг сайжруулах зэрэг асуудлыг тэд дэвшүүлэн тавьж байгаа болно.

Үүний зэрэгцээ оросууд манай хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд саад тотгор болж байгаа зарим асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байгаа юм. Үүнд гадаад худалдааны алдагдлыг багасган тэнцвэржүүлэх, бүтцийг нь сайжруулах, тарифын болон тарифын бус саад бэрхшээлийг арилгах, Монгол Улсад хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх, тохиролцсон зүйлийн биелэлтийг хангах үүрэгтэй хоёр улсын яамд, албан газрын хоорондын зохицуулалтыг дээшлүүлэх, хоёр улсын иргэд визгүй зорчих журмыг сэргээх зэрэг асуудлыг тэд дэвшүүлэн тавьж байгаа болно.

ОХУ нь манай их хөрш. Одоогоор улс төр, эдийн засаг, нийгмийн харилцааны бүх салбарт найрсаг харилцаа, хамтын ажиллагаатай орон юм. Монгол хүний сэтгэлд оросын ард түмний их ач тус, өгөөмөр сэтгэлийг хүндэтгэх, бүх зүйл дээр тэдэнд хандаж тусламж хүсэх, түшиг тулгуураа болгох сэтгэлгээ хүчтэй хадгалагдсан хэвээр байна.

Гэвч сүүлийн үед ОХУ, НАТО-г өргөтгөхийн эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэллээ. Үүний тулд НАТО-гийн эсрэг холбоотон байж болох улс орныг эрж хайх, зарим улс оронд ялангуяа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсуудад үүндээ нэгдэхийг хатуу, зөөлөн янз бүрийн хэлбэрээр тулгах байдал ч ажиглагдаж байгаа юм. Энэ нь хуучин социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан улс орнуудад, түүний дотор Монгол улсад ямар нэг хэлбэрээр хамаарч болохыг үгүй гэх баталгаагүй болно. ОХУ-ын өндөр албан тушаалын зарим хүний ярианд ийм санаа цухалзах болсон нь ч ажиглагдаж байгаа юм.

НАТО-гийн эсрэг үйл ажиллагаандаа Хятад улсыг гол холбоотноо болгохоор бүхий л хүчин чармайлтаа гаргаж байгаа энэ үед ОХУ-ын цэргийн бодлогод

Монгол улс ямар нэг тодорхой байр суурь эзлэх болох нь ерөнхийдөө ойлгогдож эхэлж байгаа болно. Ер нь Монгол улсын зүгээс бусад оронтой түүний дотор АНУ-тай цэргийн салбарт хамтран ажиллах ямар нэг алхам хийгдэхэд Оросын албаны зарим хүн туйлын эмзэг хандаж хүлээж авдгаас энэ нь харагддаг болно.

Түүнчлэн, Монголтой цэрэг-батлан хамгаалахын салбарт нягт хамтран ажиллах хүсэлтэйн зэрэгцээ манай улсыг улс төрийн холбоотон байлгах сонирхлоо дахин сэргээхийг оролдсон, эдийн засгийн ашиг сонирхлоо алдахгүй байхын тулд тулгасан, барьцаалсан үйл ажиллагаа явуулж болзошгүйг ойлгуулсан, янз бүрийн хэлбэрээр илэрхийлсэн, цаашдаа сөрөг үр дүн авчирч болзошгүй гэж хэлж болох зүйлүүд сүүлийн үед Оросын Засгийн газар болон түүний зарим төв байгууллагын төлөөллийн үг хэллэгээс ажиглагдаж эхэлснийг анхаарах нь зүйтэй болж байна.

Дээр дурдсан зүйлүүдийг нэгтгэн дүгнэж үзэхэд, ОХУ-ын төр, засгийн зүгээс Монгол Улсын хувьд найрсаг, сайн хөршийн уламжлалт харилцаагаа цаашид хөгжүүлэн “иж бүрэн стратегийн түншлэлийн” түвшинд хүргэх, бүх талын хамтын ажиллагааг төгөлдөржүүлэн, ялангуяа худалдаа, эдийн засгийн салбарт идэвхжүүлэн үр ашгийг нь дээшлүүлэх, олон улсын тавцан дээр хамтран ажиллах зэрэг чиглэлийг баримталж байгаа нь тодорхой байна.

Өөрөөр хэлбэл Монгол Улс өөрийн гадаад бодлогоо эвсэлд үл нэгдэх зарчимд тулгуурлан, олон улсын хамтын ажиллагааны хүрээнд, ОХУ, БНХАУ-ын зэрэгцээ АНУ болон дэлхийн нөлөө бүхий бусад гүрний оролцоотойгоор хэрэгжүүлэх чиг шугам баримталж байгааг ОХУ үндсэндээ хүлээн авч хүндэтгэн үзэж байна гэж дүгнэж болохоор байна.

Монголын талаарх АНУ-ын геостратегийн бодлого: мөн чанар, учир шалтгаан.

Бидний үзэж байгаагаар Монгол Улс АНУ-ын Евразийн геополитикийн бодлогод хэд хэдэн ач холбогдолтой юм. Юуны өмнө Монгол Улс Евроазийн гол тоглогч Орос болон Хятадын хооронд орших эрэг орчмын (rimland) улсын хувьд манай хоёр талд АНУ-ын геостратегийн бодлогоо нэвчүүлэх таатай орчин болж байна. Үүний улмаас Монгол Улсыг ардчиллын “арал” болгон хөгжүүлж, түүний олон улсын нэр хүндийг өргөх замаар манай хоёр хөршийн улс төр, хүн амын үзэл бодолд нөлөөлөх ач холбогдолтой юм. Нөгөө талаас, Монгол Улс хоёр хөршийн

соёл иргэншлийн аль алиныг нь ойлгож, түүнийг ямар нэгэн түвшинд мэддэг, түүхэн хувь заяа төстэйн хувьд Монгол бол америкийн Евроазийн геостратегийг боловсронгуй болгох таатай түшиц газар мөн. Ерөнхийдөө АНУ Монголын нутаг дэвсгэрийг түүний Евроазийн геополитикийн олон ургалч үзэл тогтоох түшиц газар болгохыг хүсэж байна. Бас энэ хүрээнд Монголыг найдаж болох стратегийн түнш мөн эсэхийг харзнаж байх шиг байна. Гэхдээ Монгол Улс нь АНУ-ын Төв болон Зүүн Азийн стратегийн чухал ач холбогдол бүхий ойрын түнш болон хувирсан нь одоо нэгэнт тодорхой зүйл болжээ.

Монгол Улсын аюулгүй байдлын тогтолцоог бүрдүүлэх ажил урсгалаараа биш харин ч геополитикийн бодит нөхцөл байдлыг тооцон АНУ-аас зохицуулсан геостратегийн бодлогын хүрээнд явагдаж байна гэж Орос, Хятадын зарим судлаачид үзэж байна. Хэдийгээр асуудлыг шууд ийм утгаар ойлгох нь бидний хувьд одоогоор учир дутагдалтай болович Төв болон Зүүн Азид болж буй геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлтийг дүгнэж үзвэл АНУ эдгээр бүс нутагт өвөрмөц гэж хэлж болох холбоотны шинэ орон зайг бий болгоход чиглэсэн геостратегийн бодлогыг хэрэгжүүлэхийг чармайж байгаа нь улам бүр тодорхой болсоор байна. Энэ нь НАТО шиг АНУ-ын хүчтэй хэрэгсэл АНД-н бүс нутагт өнөөг хүртэл бий болоогүйтэй холбоотой юм. Ийм учраас улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын, түүнчлэн ОХУ-ын нөлөөллийг хязгаарлахын тулд энэ бүс нутагт НАТО-той төсөөтэй, Япон, Өмнөд Солонгос, Монгол, Австрали, Канад болон өөр бусад зарим орныг багтаасан геополитикийн орон зайг бий болгох үйл явц эрч хүчээ авч магадгүй гэж нэлээд орны судлаачид үзэж байна. Үүний нэг тодорхой илрэл нь Ерөнхийлөгч Трампын засаг захиргаа Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалынхаа Энэтхэг-Номхон далайн стратегид Монголыг хамруулах болсон явдал гэж үзэж болно.

Монгол Улсад өөрийн байр сууриа бэхжүүлэх нь Зүүн хойд болон Төв Азид хэрэгжүүлэх АНУ-ын геостратегийн бодлогод хүчтэй дэмжлэг болох нь тодорхой. Ийм ч учраас АНУ-аас Монгол Улсын хувьд баримталж буй байр суурийн мөн чанар нь манай оронд ОХУ-ын стратегийн хяналтыг дахин сэргээхгүй байх, түүнчлэн Москва, Бээжин, Улаанбаатар адил тэгш эрхтэйгээр оролцсон улс төр, цэрэг, стратегийн шинэ холбоо байгуулагдахаас урьдчилан сэргийлэх явдал болох нь олон зүйл дээрээс ойлгогддог болно.

Үнэндээ ч АНУ 1990-ээд оны эхнээс Зүүн хойд Азид хэрэгжүүлж буй геостратегийн бодлогынхоо хүрээнд Монгол Улсын хувьд баримтлах байр сууриа ихээхэн нямбай тодорхойлсон байдаг. Эдгээрт Зүүн хойд Ази болон Евратлантын аюулгүй байдал, хамтын ажиллагааны талаарх яриа хэлэлцээнд оролцох, олон улсын энхийг сахиулах болон терроризмын эсрэг үйл ажиллагаанд цэргээ хандивлан идэвхтэй оролцох, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх үйл хэрэгт өөрийн гэсэн хувь нэмрийг оруулах, байгаль орчныг хамгаалах, түүнчлэн тайван замаар ардчиллыг тууштай, эрчимтэй хөгжүүлэх болон Канад, Япон, Өмнөд Солонгос, Австрали зэрэг өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудын хөрөнгө оруулалт, худалдааны ашиг сонирхлыг өөрийн орондоо бий болгох гэсэн манай улсын бүхий л чармайлтад АНУ байнгын дэмжлэг үзүүлж ирсэн, одоо ч үзүүлсээр байгааг хамааруулж болох юм.

Үүний зэрэгцээ АНУ-ын өөрийнх нь эдийн засаг, ялангуяа хөрөнгө оруулалтын ашиг сонирхолд хамааруулан үзэж болох зүйлийг Монгол Улсаас олж харахад тийм ч амаргүй байдгийг энд бас тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ.

ÀÍÓ-òàé òîãòîîñîí õàðèëöàà, ÿëàíãóÿà òåððîðèçìòàé òýìöýõ ÷èãëýëýýð õýðýãæ¿¿ëæ áóé áàòëàí õàìãààëàõ ñàëáàð õîîðîíäûí õàìòûí àæèëëàãàà íü Ìîíãîëä àðä÷èëëûã õºãæ¿¿ëýõ, çàõ çýýëèéí ýäèéí çàñãèéã áýõæ¿¿ëýõ, àþóëã¿é áàéäëûã õàíãàõ ÷óõàë à÷ õîëáîãäîëòîé, ìàíàé ãàäààä áîäëîãûí òýðã¿¿ëýõ ÷èãëýëèéí íýã áîëîí õóâèð÷ áàéíà.

Ингэж иим том гүрэнтэй үндсэндээ цэрэг, улс төрийн холбоотны түвшинд харилцаж нэг талаасаа түүний ашиг сонирхлыг Зүүн хойд Азийн бүс нутагт хамгаалагч, илэрхийлэгч болж байгаагаараа Монгол Улс АНУ-ын нөлөөллийг энэ бүс нутагт хязгаарлахын төлөө байдаг бусад их гүрэн, юуны өмнө хөрш зэргэлдээ хоёр орныхоо хувьд олон улсын улс төрийн эрсдэлийн нэг голомт болж байгаа нь хэн бүхэнд тодорхой зүйл болно.

¯¿íèé çýðýãöýý АНУ-тай тогтоосон олон талт, нягт хамтын ажиллагаа нь Монгол Улсын хувьд аюулгүй байдлын хувьд улс төрийн багагүй эрсдэлийг дагуулж байгаа боловч одоохондоо манай орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах нэг гол чухал хүчин зүйл болсоор байгааг тэмдэглэх хэрэгтэй юм. Ойрын ирээдүйд ч иим байдал тогтвортой үргэлжлэх нь үндсэндээ ойлгомжтой байгаа болно.

Эдүгээ Монгол Улс, АНУ хоёр харилцаагаа “стратегийн түншлэлийн” түвшинд хөгжүүлэхээр тохиролцоод байна. Хэдийгээр АНУ өөрийнх нь эдийн засаг, ялангуяа хөрөнгө оруулалтын ашиг сонирхолд хамааруулан үзэж болох зүйлийг манай талаас олж харахад тийм ч амаргүй байгаа боловч ийм тохиролцоо хийсэн нь түүний геостратегийн зорилго нэн тодорхой байгааг гэрчилж байна гэж үзэж болно.

Монгол-америкийн ”стратегийн түншлэл” нь íýã òàëààñ äýëõèéí õàìãèéí õ¿÷èðõýã, íºëºº á¿õèé ã¿ðíèé èâýýë äîð ýäèéí çàñàã, íèéãìèéí õºãæèë, àþóëã¿é áàéäëûí тулгамдсан çàðèì асуудлаа àìæèëòòàé øèéäâýðëýõ нэмэлт áîëîìæîîã манай талд îëãîæ áàéãàà ÷, íºãºº òàëààñ юуны өмнө хөрш хоёр орны болгоомжлох хандлагыг өсгөснөөр манай àþóëã¿é áàéäëûí ãàäààä îð÷íû áàñ íýã øèíý íºõöºë áàéäëûã үүсгэн, шинэ эрсдэлийг бий болгоод байна. Манай улсын гол “гуравдагч хөрш” –АНУ-тай явуулж буй харилцааны ийм “хоёрдмол” шинж байдал ойрын ирээдүйд ч тогтвортой үргэлжлэх нь үндсэндээ ойлгомжтой байгаа болно.

Дээр дурдсан зүйлүүдийг товч дүгнэхэд, ОХУ-БНХАУ-АНУ хэмээх гурвалжны дотоод орон зайд Монгол Улс “амьд гарах” арга замаа хэрхэн сонгон олж, түүнийгээ залж явахаас их юм шалтгаалах агаад үүнд “гурвалжны онол”, түүний хувьслын зүй тогтлыг эзэмших явдал нэн чухал ач холбогдолтой байх болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ.

## ТӨРИЙН ГАДААД, ДОТООД БОДЛОГЫН ГЕОСТРАТЕГИЙН АГУУЛГА

### 3.1. Гадаад бодлогын геостратегийн агуулга

### 3.1.1. Далайд гарцгүй бага орны геополитикийн онцлог

Бага буюу жижиг улсын гадаад бодлогын судалгаа манайд харьцангуй сүүлд хөгжиж эхэлсэн гэж үзэж болно. Эзэнт улсын уламжлал, сэтгэл зүйн инерц нөлөөлдөг байхыг үгүйсгэх аргагүй. Сүүлийн үед доктор Г.Төмөрчулуун, Д.Уламбаяр, Г.Баасанхүү нарын зэрэг эрдэмтэн судлаачид энэ сэдвийг илүү онцлон судалж , анхаарч ирсэн нь харагддаг. Ялангуяа .Г.Төмөрчулууны энэ асуудлаар 1999 онд бичсэн нэг сэдэвт бүтээл болон хожим шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан диссертацид нь бага улсын тодорхойлолт, ийм улсын бодлогын онцлог, түүнд нөлөөлөх гол хүчин зүйлүүд зэргийг эрдэм шинжилгээний түвшинд боловсруулж өөрийн улстай холбон тайлбарласан нь эдүгээ чухал хэрэглэгдэхүүн болж байна[32].

Бага улсын тухай авч үзэхдээ энэ тухай олон улсын нэгдсэн ойлголт бүрэн тогтоогүй байгааг анхаарах нь зүйтэй юм. Бага улсын үүсэл хөгжлийг XX зууны эхнээс үндсэнд нь 4 үе шатад хувааж авч үздэг бөгөөд сүүлчийнх нь "Хүйтэн дайн" эцэслэж хоёр туйлт систем задарсантай холбоотой гэж үздэг байна. 1985 онд Их Британийн хамтын нөхөрлөлөөс гаргасан илтгэлд бага улс гэж 1 сая буюу түүнээс бага хүн амтай улсыг хэлнэ гэсэн бол Дэлхийн банкны илтгэлд 1.5 сая хүн амтай гэсэн байдаг. Ийм тохиолдолд 45 улс энэ ангилалд багтаж буй. Харин Сингапурын санаачилгаар НҮБ-ын дэргэд байгуулагдсан Бага улсуудын чуулганаас 10 саяас доош гэж тодорхойлсноор 93 улс бага улс болж байна. Үүний зэрэгцээ хагас саяас доош хүн амтай улсыг микро улс ч хэмээн ангилах нь байдаг.

Гэвч хүн амын их, бага гэдэг нь зөвхөн тоон үзүүлэлт юм. Өрнөдийн эрдэмтдийн үзэж байгаагаар бол олон улсын систем нь давамгайллын өндөр түвшин буюу иерархи ноёрхож байдаг систем бөгөөд "улс орон", "хүч чадал" гэсэн хоёр ойлголт үүний гол агуулга болж байдаг. Карл Дойчийн ангилснаар бол улс орнуудыг А,Б,В буюу "их гүрэн", "дунд зэргийн гүрэн", "бага, буурай" гэсэн эрэмбэлэлд хуваадаг. Түүний тодорхойлолтоор бол "улс орны хүч чадал" гэдэг нь "мөргөлдөөнд ялах, аливаа бэрхшээлийг даван туулах" чадвар юм[33].[2] "Хүч чадлыг" тодорхойлох хувьсах ба үл хувьсах элементүүд байх бөгөөд М.Сингерийнхээр бол ийм 4 элемент нь:

---

[32]. Процесс принятия внешнеполитических решений в малых государствах / на примере Монголии/". Москва, Научная книга. 1999г

[33] . Karl W.Deutsch. The Analyses of International Relations. Engelwood Cliffs. Prentice-Hall, 1968

1. нийгмийн баялаг, нөөц / хүний болон материаллаг/,
2. зохион байгуулалт /албан ёсны ба албан бус/,
3. статус /төрөлхийн буюу олдмол/,
4. хүсэл эрмэлзэл /ухамсарласан ба ухамсарлаагүй/,-ажээ.

Д.Вайталын тодорхойлолтод хараат ба хараат бус хүчин зүйлс голлодог бөгөөд бага улс нь хязгаарлагдмал нөөцийн улмаас олон улсын бодлогод бие даан оролцож чаддаггүй, нэгдүгээр зэрэглэлийн улсын улс төрийн болоод цэргийн хүчний дайвар болдог гэсэн бол Р.Ротштайн энэ байдал нь ялангуяа их гүрнүүдийн ашиг сонирхлын мөргөлдөөний бүсэд оршдог бага улсын хувьд улам хүнд болохыг тэмдэглэсэн байдаг байна. Тэр бээр бага улс гэж "өөрийн хүчинд тулгуурлан аюулгүй байдлаа хангаж эс чадна гэдгээ ойлгодог, иймээс аюулгүй байдлаа хангахын тулд бусад улс, институт, үйл явцад тулгуурладаг" улсыг хэлнэ, үүнийг нь бусад улс мөн хүлээн зөвшөөрсөн байдаг гэжээ. Улмаар Ж.Росено, Ж.Соэр зэрэг эрдэмтэд 82 улсын 236 үзүүлэлтийг судалж үзээд дараах гурван хүчин зүйл чухал болохыг тогтоосон байна. Үүнд:

1. хүн амын тоо хэмжээ,
2. амьжиргааны түвшин / нэг хүнд ноогдох ДНБ/
3. улс төрийн системийн хэлбэр[34].

Үүний зэрэгцээ Метисений үзэж байгаагаар бага улсын гадаад орчин, хүрээлэл мөн чухал бөгөөд өөрөөс нь илүү хүчтэй хөрштэй бол түүний гадаад бодлогод "заавал айдас, сэрэмж, болгоомжлолын хүчин зүйл байдаг, тэр хөрш нь эдийн засгийн болон бусад талаар хүчтэй болохын хэрээр бага улсын аюулгүй байдал улам хэврэг" болдог. Империализмын тухай Галтунгийн онолоор бол их гүрнүүд нь тэдний хүслээс үл хамааран империалист шинж чанаруудыг өөртөө агуулж байдаг, өөрөөр хэлбэл их гүрэн хүссэн хүсээгүй үйл хэргээрээ бага улсуудад нөлөөлж, "дарамталж" байдаг байна. Олон улсын харилцааны реалист дэг сургуулийн үздэгээр аюулгүй байдлаа хангахын тулд "их гүрнүүд юу хүссэнээ, бага улсууд юу чаддагаа" хийдэг, их гүрнүүд хүчинд, бага улсууд эрх зүйд тулгуурладаг. Хүч чадал гэдэг ойлголтод гагцхүү цэргийн хүч бус, эдийн засгийн,

[34] R.F.Barston (ed.). The Other Powers: Studies in the Foreign Policies of Small States. London, Allen and Unvin., 1971

технологийн, соёл иргэншлийн зэрэг хүчний бүх хэлбэрүүд орно. Бага улсууд эрх зүйд тулгуурлана гэдэг утгаараа НҮБ зэрэг олон улсын байгууллагууд, олон талт хамтын ажиллагаанд илүү ач холбогдол өгч, олон улсын эрх зүйг бэхжүүлэх, ивээлд нь орохыг эрмэлздэг гэсэн байдаг юм.

Бага улсуудын гадаад бодлогод дараах зүйлүүд хязгаарлалт болдог гэж үздэг байна. Үүнд:

- олон улсын систем нь шатлал, зэрэглэлийн, эрх мэдлийн эрэмбийн зохион байгуулалттай бөгөөд цөөн хэдэн улс, эсхүл бүлэг улс давамгайлан манлайлж байдаг,
- олон улсын гэрээ, конвенц зэрэг нь тэгш эрхийг тунхаглах боловч хэрэг дээрээ эрх зүйн хэм хэмжээ, харилцан хүлээх үүрэг, хариуцлага зэрэг нь тэгш бус байх явдал давамгайлдаг,
- оюун санааны үнэт зүйлсийн бусдаас ялгагдах онцлог, өвөрмөц байдал,
- даяаршлын үйл явц бага, буурай орнуудад давуу талыг олгохоосоо илүү сөрөг нөлөө үзүүлэх нь их байна гэсэн ойлголт нэлээд өргөн байна.

Бага улсуудыг хязгаарладаг эдгээр хүчин зүйл Монголын хувьд ч бодитой үйлчилдэг агаад өөрийн өвөрмөц онцлогоос нь үүдсэн өөр бусад хязгаарлалт ч байгаа нь ойлгомжтой. Хүн ам, газар нутаг, цэрэг-улс төр, эдийн засгийн хувьд хоёр хөрштэйгөө асар их тэнцвэргүй, соёл иргэншлийн том ялгаатай нь Монголын хувьд сул тал, давуу талын аль аль нь болдог гэж судлаачид үздэг байна. Ийм хоёрдмол ач холбогдолтой зүйлийн нэг жишээ гэж Монголын "далайд гарцгүй байршлыг хэлж болно[35].

Монгол Улс далайд гарцгүй хөгжиж байгаа 32 орны (цаашид ДГХБО гэх) нэг бөгөөд нийтлэг бэрхшээлээ хамтын хүчээр шийдвэрлэж байх, хүчээ нэгтгэхийн чухлыг харгалзан НҮБ, олон улсын бусад холбогдох байгууллагын хүрээнд эвсэн бүлэглэх, өөрийн гэсэн бүтэц байгуулахад анхаарч ирсэн. Тухайлбал ЮНКТАД, Дэлхийн худалдааны байгууллагын хүрээнд ийм эрх ашгийн нэгдэл бий болгох чиглэлээр нэлээд оролдлого хийсэн нь багагүй ахиц амжилтад хүрсэн байдаг.

[35] www.unohrlls.org/

ДГХБО-ын талаарх Венийн үйл ажиллагааны хөтөлбөрийг[4] хэрэгжүүлэхэд гол тулгуур болох судалгааны чадавхыг нэгтгэн зохион байгуулалтад оруулах зорилгоор эдгээр улс оролцсон НҮБ-ын Олон улсын судалгааны төвийг /цаашид ОУСТ гэх/ үүсгэн байгуулах санаачилгыг манай улс 2006 онд албан ёсоор дэвшүүлсэн бөгөөд 2009 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын Монголд хийсэн айлчлалын үеэр тус төвийн шавыг тавьсан. 2014 оны 1 дүгээр сард ГХЯ болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран ДГХБО-ын ОУСТ-ийн үйл ажиллагааг эхлүүлэх төслийн баримт бичигт гарын үсэг зурснаар үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй.

ОУСТ-нь Монгол Улсад байрлах олон улсын засгийн газар хоорондын хоёрдох байгууллага гэдгээрээ чухал ач холбогдолтой бөгөөд түүнийг байгуулах тухай олон талт Хэлэлцээрийг доод зах нь 10 улс соёрхон баталснаар тус төвийн үйл ажиллагаа бүрэн хэмжээнд эхлэх учиртай байв. 2017 оны байдлаар уг Хэлэлцээрт 7 улс нэгдээд байсан бол /Армени, Лаос 2012 онд, Афганистан 2013 онд, Казахстан 2015, Буркино Фасо, Парагвай 2016 онд тус тус нэгдсэн/ хожим нь Киргиз, Балба, Бутан нэгдэж , 2018 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо албан ёсны нээлтээ хийжээ.

ОУСТ-ийн нээлтийн хурлаас гаргасан Мэдэгдэлд ДГХБО-дын хөгжлийг дэмжих үүднээс тэдний судалгааны чадавхыг сайжруулан, транзит тээвэртэй холбогдсон бодлогын асуудлуудыг шийдвэрлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, олон улсын худалдааг хөнгөвчлөх, бүс нутгийн интеграци, хамтын ажиллагааг дэмжих, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг өөгшүүлэх зэргээр тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох бүх улс, олон улсын байгууллагууд идэвхтэй хамтран ажиллахыг уриалсан. Түүнчлэн ДГХБО-дад нэн чухал ач холбогдолтой болж буй цаг уурын өөрчлөлт, цөлжилт, хөдөө аж ахуй, цахим эдийн засаг болон бусад асуудалд онцгой анхаарч шинжлэн судлахын чухлыг заасан байна[36].

Судалгааны төв эдүгээ ДГХБО-дад зориулсан тодорхой төслийн симуляцийн загвар боловсруулан түгээж байгаа нь сонирхол татаж байна. Тухайлбал, уг моделийг ашиглан Монгол Улс, ОХУ, БНХАУ хоорондын эдийн засгийн гурван коридорын үр ашгийн талаар судалгаа хийсэн нь манай талаас уг

---

[36] http://land-locked.org/

коридорын асуудлаар цаашид баримтлах бодлого, байр сууриа нягтлан тодотгоход нэн тустай болсон байна.

Монгол Улс “далайд гарцтай болох” нь манай нийгэм-эдийн засгийн хөгжлийн шаардлагаас урган гарсан гео-улс төр, гео-эдийн засгийн бодлогын нэгэн чухал чиглэл болох нь тодорхой. Энэ чиглэл бүхэлдээ ЗХА-ийн геополитикийн нэгдсэн орон зайд шигдэн хамаарна.

Тулгамдсан асуудлын тухайд бол манай улсын хувьд хөрш хоёр орны “хашлага давах”, чингэхдээ ЗХА-ийн чиглэлээр, энэ бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэн нийлэх, дэд бүтцийн сүлжээний салшгүй хэсэг нь болох замаар “далайд гарах” стратеги дагнаж байна. Энэ зорилгод гурван улсын эдийн засгийн коридорын “төсөл” нийцэж байх боловч түүнийг хэрэгжүүлэх бодит хэрэгцээ, сонирхол хөрш хоёр улсад аль хэр байна вэ гэсэн асуултад юуны өмнө оновчтой хариу өгөх шаардлагатай. Улмаар коридорыг зөвхөн “транзит орон зайн” утгаар хандаж хэрэгжүүлэх үү, монголын эдийн засаг хөрш хоёрын “түүхий эдийн хавсарга” болох учиртай юу, бие даасан эдийн засгийн хөгжлийн стратеги гэж юу вэ гэх зэрэг цөөнгүй асуудлыг нарийвчлан судалж бодлогоо нягталж, үйл ажиллагаагаа зохицуулах хэрэгтэй байгаа билээ

### 3.1.2. Гадаад бодлогын олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн агуулга.

Ìîíãîëûí Эзэнт ã¿ðýí çàäðàí óíàñíààñ õîéø îëîí çóóí жилийн дараа буюу 1990-ээд онд àíõ óäàà ìîíãîë÷óóä òºð óëñäàà æèíõýíý ¸ñîîð ýçýí áîëæ, ìàíàé òóñãààð òîãòíîë, ãàçàð íóòàãò õàðèéí øóóä заналхийлэл үгүй болсон юм. Äýëõèéí õî¸ð òóéëò òîãòîëöîîíû çºð÷èë áîëîí õóó÷èí ÇÕÓ, Õÿòàäûí õîîðîíä ¿¿ñ÷ áîëçîøã¿é áàéñàí çýâñýãò ìºðãºëäººíä òàòàãäààí îðæ ãàé ò¿éòãýð àìñ÷ ìýäýõýýð áàéñàí òýð ¿å íýãýíò ò¿¿õ áîëîí ¿ëäæýý. Ãýâ÷ ингэснээр Ìîíãîë Óëñûí àþóëã¿é áàéäàë íàéäâàðòàé õàíãàãäààæ, àëèâàà àþóëûí õºëä õýçýý ÷ íýðâýãäýõã¿é áîëëîî ãýñýí áàòàëãàà á¿ðýí ä¿¿ðýí áèé áîëîîã¿é áàéíà.

Хоёр зууны зааг дээр Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàã дахь îëîí óëñûí õàðèëöààíû øèíæ ÷àíàð ýðñ ººð÷ëºãäñºí ÷ àþóëã¿é áàéäëûí õàìòûí òîãòîëöîî á¿ðýëäýí áèé áîëîîã¿é, ÿíç á¿ðèéí ¿¿äýëòýé çºð÷èë, ñºðãºëäººí ¿ðãýëæèëñýýð байна. Манай нийгэм бүхэлдээ ардчилсан тогтолцоог хөгжүүлэн төлөвшүүлэх зорилгоо дэлхийн хамтын нийгэмлэгтэй хамтран ажиллахгүйгээр, тэдний тусламж дэмжлэггүйгээр оновчтой хэрэгжүүлэх чадвар мөхөс хэвээр байна. Ийм íºõöºëä Ìîíãîë Óëñûí

òóñãààð òîãòîíîë, á¿ðýí ýðõò ááéäëûã хангах, óëìààð ¿íäýñíèé ýðõ àøãàà óðüòàë болгосон, òîãòâîðòîé õºãæëèéí асуудлаа шийдвэрлэхэд чиглэсэн гадаад бодлого, àþóëã¿é ááéäëûí áèå äààñàí ¿éë àæèëëàãàà ÿâóóëàõ øààðäëàãà тулгамдсан хэвээр байгаа билээ. Ìîíãîë Óëñûí àþóëã¿é ááéäëûí ãàäààä îð÷íû îéëãîëòûã байнга шинэчилж байх, þóíû ºìíº õî¸ð èõ õºðø болон áóñàä óëñ îðîíòîé ÿàæ õàðèëöàõ, àþóëã¿é ááéäëàà õýðõýí áèå äààæ õàíãàõ зэрэг өргөн хүрээтэй асуудлуудыг хамарсан цогц үзэл баримтлал, уг үзэл баримтлалын байнгын хувьсал хөгжил шаардлагатай хэвээр байгаа нь ç¿éí õýðýã þì.

Манай ардчилсан хөгжлийн эхний болоод өнөөгийн үе шатны зорилтуудыг шийдвэрлэхэд 1994 онд боловсруулан баталж , 2011, 2014 онд тус тус шинэчилсэн “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” хэмээх баримт бичгүүд бүхэлдээ амжилттай үйлчилсэн гэж үзэж байна. Чухамхүү энэ баримт бичгүүдээс шинэ, ардчилсан Монгол Улсын гадаад бодлогын геостратегийн агуулгыг тодорхой олж харж болно.

2011 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд /цаашид ГБҮБ гэх/ манай улсын гадаад орчныг: “XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграци өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Хөгжлийн шинэ томоохон төвүүд тодорч, олон улсын харилцаанд тэдгээрийн үзүүлэх нөлөө өсөх хандлагатай байна.

Нөгөөтээгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал буурахгүй байна. Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болов” хэмээн товчхон боловч оновчтой тодорхойлсон байдаг.

Энэ үндсэн дээр гадаад, аюулгүй байдлын бодлогын зорилго, шинж чанар, зарчмыг тодорхойлоод, үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд, зонхилох чиглэлүүдийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

Зорилго: тусгаар тогтнол, бүрэн эрхт, аюулгүй байдлаа бататгахад таатай гадаад орчин бүрдүүлэх,

Арга зам: улс төр, дипломатын аргаар дэлхийн улсуудтай харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх,

Зарчим: нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг баримтлах,

Шинж чанар: үндэсний ашиг сонирхолд тулгуурласан, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт бодлого явуулах.

Бүрэлдэхүүн хэсэг: улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, соёл, хүмүүнлэгийн гадаад бодлого, гадаадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого гэсэн харилцан уялдаа бүхий үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Улс төрийн гадаад харилцааны бодлого тодорхойлогч шинжтэй байна.”...гэсэн бөгөөд гадаад харилцааны гол субъектүүдээ:

1. ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд тэдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлнэ. Чингэхдээ энэ хоёр улстай харилцаж ирсэн түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзах,

2. АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх,

3. Азийн бусад улстай хоёр талын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт хамтын ажиллагаанд оролцох, Зүүн Ази, Зүүн хойд Ази, Төв Азид стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжиж оролцох,

4. Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүү, худалдаа, эдийн засгийн байгууллагуудтай хамтын

ажиллагаагаа идэвхтэй үргэлжлүүлэх, дэлхийн засаглал дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах,

5. Хөгжиж байгаа улсуудтай хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллага, “77”-гийн бүлэг, Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн зэрэг олон талын хүрээнд хамтран ажиллах хэмээн эрэмбэлэн жагсаасан байна.[37]

ГБҮБ нь манай гадаад бодлого, харилцааны үндсийг тодорхойлсон, эрх зүйн императив шинж чанартай, цогц баримт болж чадсан бөгөөд түүхэн хэсэг хугацаанд бүрэн үйлчлэх чадвартай гэж үзэж болно. Үзэл баримтлалын заалтуудыг баримтлан үйл ажиллагаагаа ойрын болон дунд хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэхдээ геостратегийн гол чиглэлүүдийн эрэмбэ дарааг тухайн үеийн шаардлагад нийцүүлэн сонгож, зохицуулж байх, тодорхой улс оронтой харилцах арга тактикаа оновчтой сонгож ажиллах явдал манай дипломат алба, шийдвэр гаргагчдын өдөр тутмын үүрэг юм.

АНУ-ын олон улсын харилцааны нэрт онолч, геополитикч Ханс Моргентау аливаа гадаад бодлого, дипломат үйл ажиллагааны үндсэн шалгуурыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. “Дипломат бодлогыг боловсруулахдаа өөрийн хүч чадавх, бололцоонд тохируулан зорилтоо тодорхойлох ёстой,

2. Дипломат бодлогыг төлөвлөхдөө нөгөө улсынхаа зорилтыг зөв таньж тодорхойлох ёстой,

3. Дипломат бодлогыг боловсруулахдаа хоёр улсын зорилт хоорондоо хэр зэрэг нийлж авцалдаж байгааг нягтлан үзэх ёстой,

4. Дипломат бодлогыг хэрэгжүүлэхэд дээрх гурван зүйлд тулгуурлан өөрийн зорилтыг ажил хэрэг болгох арга замыг ончтой сонгох ёстой гэжээ[38].

---

[37] ГХЯ.Дипломатын академи. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил.УБ.,2014

[38] Hans J.Morgenthau. Politics among Nations: The Struggle for Power and Peace.5$^{th}$ edition, NY.,1972

Эдгээр шаардлага, шалгуурыг үндэс болгон үйл ажиллагаагаа хөтлөх, эргэсэн холбоог бодитойгоор, шударгаар хангаж байх явдал юу юунаас чухал байна.

### 3.1.3. Гуравдагч хөршийн бодлого

**Мөн чанар, учир шалтгаан.**

1911 оны үндэсний хувьсгалаас хойших бүхий л үеийн турш Монгол улс гадаад харилцаагаа тэлэх, хөрш хоёрын "дарамтыг" нимгэлэх гуравдагч хүчнийг эрэлхийлж ирсэн түүхтэй. Энэ түүхэн замналд 1990 оны ардчилсан хувьсгал чанарын цоо шинэ үе шатыг нээсэн юм. 2010 онд шинэчлэн баталсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй, ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ" хэмээн заасан. Түүнчлэн 2011 онд шинэчлэгдсэн Гадаад бодлогын үзэл баримтлалын зүйл 14.2 –т "АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорны улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх" гэж заасан байдаг. Энэ нь "гуравдагч хөрш" хэмээх томьёолол манай гадаад бодлогыг тодорхойлогч +албан ёсны, үндсэн баримт бичгүүдэд анх удаа орсон явдал юм. Гэвч "Гуравдагч хөршийн бодлого", "гуравдагч хөрш"-ийн тухай нэгдсэн ойлголт эдүгээ тэр бүр жигдрээгүй, төлөвшиж дуусаагүй, эл асуудлыг гүнзгийрүүлэн судалж боловсруулах шаардлага хэвээр байна.

"Гуравдагч хөрш" хэмээх энэ нэр томьёоны үүслийг 1990 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкерийн манай улсад хийсэн айлчлалтай холбон үздэг. Тэр бээр ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнтэй хэлэлцээ хийх үеэрээ танайх "...хоёр хөрштэй. АНУ тэдний аль нэгтэй харилцахдаа танай харилцаанд сэв суулгахыг боддоггүй. Танай улс АНУ-ыг оролцуулаад гурван том улстай сайн хөршийн харилцаатай байж болох юм" хэмээсэн байдаг[39]. Энэ 80-90-ээд оны зааг нь Берлиний хана нурж, хүйтэн дайн эцэс болон социалист систем задрах процесс гүнзгийрэхийн хэрээр Монголын гадаад бодлогыг зохицуулан өөрчлөх, шинэчлэх асуудал хурцаар тавигдах болсон үе юм. Монголын нийгмийг үндсээр нь өөрчлөхөд хоёр хөршөөс өөр бусад түншийн тусламж дэмжлэг нэн шаардлагатай,

---

[39] Гадаад харилцааны төв архив. ГХЯ

зайлшгүй байлаа. Тийм ч учраас “гуравдагч хөрш” буюу түншийн тухай үзэл санаа манай төрөл бүрийн бүхий л гадаад арга хэмжээ, яриа хэлэлцээний үеэр байнга цохон тэмдэглэгддэг, хамтарсан баримт бичгүүдэд тусгалаа олдог болсон төдийгүй манай нийт улс төр, дипломатын хэллэг, гадаад бодлогын сэтгэлгээнд эдүгээ баттай байр сууриа эзлээд байна.

“Гуравдагч хөрш” хэмээх энэ нэр томьёо нь манай гадаад харилцаанд“...хоёр хөршөөс гадна өрнө, дорнын хөгжингүй орнуудын байр суурь, үүрэг ихээхэн өссөнтэй холбогдон гарч ирсэн ойлголт... Өөрөөр хэлбэл аль нэг улсыг тухайлан хэлсэн бус ерөнхий геополитикийн утга илэрхийлсэн ойлголт юм” гэж манай дипломат албаныхан тайлбарладаг[40]. Харин манай түүхч эрдэмтэд “гуравдагч хөршийн бодлого” бол шинэ зүйл биш, XX зууны эхээр монголчууд тусгаар тогтнолоо байлдан олж, баталгаажуулахын төлөө тэмцэж байсан үеэс эхтэй гэж үздэг. Тухайлбал, Доктор Ц.Батбаяр “Олноо өргөгдсөн Монгол улсын гадаад харилцаа” номдоо “...хэврэгхэн тусгаар тогтнолоо бусад гүрнээр хүлээн зөвшөөрүүлэх гэсэн хэд хэдэн зоримог алхмыг 1910-аад оны эхний хагаст хийсэн...эдгээр оролдлогууд нь Монгол улс гадаад орон зайгаа тэлэх, гадаад харилцаандаа Орос, Хятадаас гадна гуравдах нөлөө бүхий гүрнийг татан оролцуулах гэснээрээ тун их онцлогтой юм” гэж дүгнэсэн[41]. Доктор Т.Төмөрхүлэг “Монголын асуудал Орос, Хятадтай учир холбогдсон нь” хэмээх бүтээлдээ: “Тэр үес тусгаар тогтнолоо тунхагласан Монгол улсыг өрнөдийн гүрнүүд хүлээн зөвшөөрч харилцаа тогтоох улс төрийн нөхцөл, олон улсын хууль зүйн орчин бүрдээгүй байсан... энэ нь цаг хугацаа, орон зайн асуудал байв” хэмээн тэмдэглэсэн байна[42].

“Гуравдагч хөрш”-ийн асуудлыг түүхэн талаас нь ч, эдүгээгийн агуулга, хүрээ, зорилго, ач холбогдол талаас нь ч гайгүй нухацтай судалж нийтэлсэн эрдэмтэд гэвэл доктор Ц.Батбаяр, Х.Олзвой, Р.Болд, Г.Төмөрчулуун, Д.Уламбаяр, Д.Баярхүү, Ж.Бор нарыг нэрлэж болно.

Х.Олзвой, Д.Уламбаяр нар “гуравдагч хөрш” хийгээд “гуравдагч хөршийн бодлого” хэмээх ухагдахуун нь Монгол зэрэг хоёр их гүрний дунд орших, цэрэг-эдийн засгийн чадамж сул, хүн ам бага улсад юуны түрүүн хамаарах, үндэсний аюулгүй байдлаас үүдэн гарсан, гадаад бодлогын асуудалтай холбоотой. Гэхдээ

---

[40] МУ-ын гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм. 1911-2011. Улаанбаатар 2011
[41]Ц.Батбаяр “Олноо өргөгдсөн Монгол улсын гадаад харилцаа”
[42] Т.Төмөрхүлэг. “Монголын асуудал Орос, Хятадтай учир холбогдсон нь”. УБ., 2014

олон улсын харилцаа, дипломатын түүхэнд “гуравдагч хүчнийг” хайсан баримтуудаас харахад зөвхөн хоёр улстай хиллэдгээс шалтгаалан гардаг ойлголт, бодлогын асуудал гэж хараахан болохгүй юм”[43] хэмээн уг ухагдахууныг өргөтгөн олон улсын мөн чанарыг нь тэмдэглэсэн байдаг. Улмаар Д.Уламбаяр “гуравдагч хөршийн бодлого” гэдгийг “аливаа жижиг улсын газарзүйн байрлалтай нөхцөлдөж, хоёр их хүчний хооронд шахагдахад өмгөөлж хамгаалах гуравдагч хүчнийг эрэн хайсан дипломат бодлогоос үүдэн гарсан цэрэг-стратеги, геополитикийн холбогдол бүхий олон улсын харилцаа, улс төрийн шинжлэх ухааны ойлголт” хэмээн тодорхойлоод “гуравдагч хөрш” нь :

а/ тус бүс нутагт өөрийн цэрэг-улс төр, эдийн засгийн томоохон ашиг сонирхолтой байх,

б/ улс төр-дипломатын аргаар дэмжиж, эдийн засгийн тусламж үзүүлдэг, цэрэг-улс төр, эдийн засгийн хүчин чадавхтай, ардчилсан дэглэмтэй, олон улсын харилцаанд нөлөө үзүүлж чадахуйц глобал бодлого явуулж буй улс гүрнүүд” хэмээн шалгуур үзүүлэлт буюу критери тогтоох оролдлого хийжээ.

Улмаар, “гуравдагч хөршийн бодлогын” субъектүүд нь дээрх “үзэл баримтлалуудаас харвал... **нэгд**, өндөр хөгжилтэй, **хоёрт,** ардчилсан улс, холбоо гэж ойлгогдож байгаа юм. ...илүү өргөн утгаар нь авч үзвэл...НҮБ ч орох учиртай” гээд “Хойд Америкт: АНУ, Канад, Зүүн хойд Азид: Япон, БНСУ, Европ тивд: Европын холбоо, түүний нөлөө бүхий гишүүн орнууд, лалын ертөнцөөс: түүх, хэл, соёлын гүн хэлхээ холбоотой...Турк, физик газарзүйн талаасаа хамгийн ойр...Казахстан, “оюун санааны хөрш”...Энэтхэг улсыг хамруулж” бүсчлэн авч үзжээ[44].[6]

1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалыг шинэчлэн найруулах ажилд 2010 онд гар бие оролцож явсан, элчин сайд асан, доктор Б.Батхишигийн дуртгалаас үзвэл тэр үед “...Гуравдагч хөршийн бодлого гэж их ярьдаг болович энэ чинь яг юу гэсэн үг вэ гэхээр хэдхэн юм хэлээд таг болдог, эсвэл үүнийг яг таг

[43] Х.Олзвой. “ОУХ дахь гуравдахь түншлэлийн зарим асуудал”. МУ-ын үндэсний аюулгүй байдал ба гуравдахь түнш орнууд: өнөө, ирээдүй. УБ.,2002

[44] Д.Уламбаяр.Монгол Улсын “гуравдагч хөршийн” бодлого:Онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудалд. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.УБ.,2014

тодорхойлох аргагүй гэж бултдаг...” байсан учраас түүний санаачилгаар ГХЯ дараах байдлаар тодорхойлж байсан аж. Үүнд: “ Гуравдагч хөршийн бодлого бол:

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийг зөвхөн хоёр их хөршийнхөө төдийгүй дэлхийн ба бүс нутгийн нөлөө бүхий улсуудын туслалцаа, дэмжлэгтэйгээр хангах бодлого,
- Аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилсэн бодлого,
- Энэ нь газар зүйн бус, улс төр, эдийн засаг, гадаад бодлогын буюу геополитикийн ойлголт юм.
- Энэ нь аль нэг гуравдах орныг бус, харин өрнө, дорнын нөлөө бүхий улс орнуудыг хамтруулан манай гадаад харилцааны нэг гол субъект болгон авч үзэж байгаа хэрэг юм ...” гэжээ[45].

Хэдийгээр энэ тодорхойлолт “гуравдагч хөршийн бодлогын” субъектүүдийг зөвхөн “нөлөө бүхий орнуудаар” хязгаарласан боловч энэ бодлогын үндсэн шинж чанарыг агуулсан гэж үзэж болохоор байна.

“Гуравдагч хөршийн бодлогын” субъектийн тухайд бол Гадаад бодлогын үзэл баримтлалд “гуравдагч хөрш” хэмээн цөөн хэдэн улсыг нэр заасан боловч жагсаалтыг нээлттэй орхисон, энэ нээлттэйг Д.Уламбаяр ашиглан хэд хэдэн улсыг нэмж дурдсан, ер нь нэр заан дурдах хэрэгтэй байсан үгүй талаарх маргаан одоо ч хэвээр байгааг тэмдэглэе. Доктор Д.Ганбат мөн “өндөр хөгжилтэй, ардчилсан орнууд”-ыг “гуравдагч хөрш” гэхийн зэрэгцээ “гуравдагч хөрш” бол Монгол Улсын хувьд батлан хамгаалах гэхээсээ илүү “улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн” утга агуулсан бодлогын ач холбогдолтой хоёр талын болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг илэрхийлж буй гэсэн байдаг[46]. Зарим дипломат, судлаачдынхаар бол аль нэг улсыг “гуравдагч хөрш” хэмээн тооцохдоо харилцааны түвшин, чанарыг харгалзах учиртай бөгөөд нөгөө талтайгаа ойлголцон тохиролцсон байх шаардлагатай. Тухайлбал, “албан ёсны” түншлэлийн харилцаатай улсуудыг хэлнэ гэнэ. Энэ тохиолдолд “стратегийн түншлэлийн” харилцаатай Япон, Энэтхэг, АНУ , “иж бүрэн түншлэлийн” харилцаатай БНСУ,

---

45 Б.Батхишиг “Арван хоёр жил Элчин сайд”. УБ.,2017

46 Д.Ганбат. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, анхаарах зарим асуудал. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.УБ.,2014

Герман, Түрк,  “өргөн түншлэлийн” харилцаатай Канад, Австралийг одоогоор “гуравдагч хөрш” хэмээн үзэх болж байна.

Түншлэл буюу “partnership” хэмээх нэр томьёо бизнес, аж ахуйн харилцаанд голдуу хэрэглэгддэг байснаа хүйтэн дайн эцэс болсноос хойш улс хоорондын харилцаанд хүч түрэн орж эдүгээ өргөнөөр хэрэглэгдэх болсон юм. Олон улсын харилцааны онолчид ерөнхийдөө “аливаа тодорхой зорилгоор харилцан хариуцлага хүлээж , хамтран ажиллахыг”  түншлэлийн харилцаа гэж тодорхойлж тогтоод байгаа гэж болно. Өөрөөр хэлбэл түншлэлийн харилцаа нь харилцан ашигтай байхын зэрэгцээ аль аль түнш нь асуудал шийдвэрлэхдээ нөгөөхийнхөө ашиг сонирхлыг харгалзаж, уялдуулж байх хариуцлага хүлээнэ гэж ойлгодог ажээ. Харин “стратегийн” хэмээх тодорхойлолтын хувьд авч үзвэл  латинаар “ strategia” гэх энэ үгийг эртний грекүүд цэрэг дайны урлагт хэрэглэж эхэлсэн бөгөөд хожим улс төрийн салбарт өргөнөөр хэрэглэгдэх болж “ухаалаг удирдлага”, “удирдахуйн ухаан”  гэж ойлгодог, чингэхдээ урт удаан хугацаагаар, ирээдүйг төсөөлөх, үйл явдлыг урьдчилан харах үндсэн дээр үйлдлээ төлөвлөхийг багтаан хэлдэг байна.

Энэ хоёр ойлголтын хослол буюу “стратегийн түншлэл” гэдэг нь :

1. Урт удаан хугацаагаар,
2. Өргөн хүрээтэй асуудлаар,
3. Аль аль талдаа  ашигтайгаар хамтран ажиллахыг хэлдэг.

Францын нэгэн судлаачийн бичсэнээр бол “талууд ойр, нягт хамтран ажиллах зорилгоор явуулж буй харилцааны систем” ч гэж товчхон тодорхойлж болно. Улмаар  Оросын  судлаач И.А.Новиковын үзэж байгаагаар  ”стратегийн түншлэл”-д норматив буюу хэм хэмжээ тогтоох үүднээс хандвал дараах шалгуур үзүүлэлтүүд буюу зарчмын шаардлага байж болох аж. Үүнд:

- Түншүүд хамтран ажиллах сонирхолтой байх,
- Хүч чармайлтаа нэгтгэн зохицуулж байж л хэрэгжүүлж болох стратегийн чухал зорилгуудтай байх,
- Түншүүдийн улс төрийн системийн үнэт зүйлүүд адилхан байх,
- Хамтын ажиллагааны талбар өргөн, салбар олон байх,
- Х/а-ны агуулга, түүнийг хэрэгжүүлэх механизмыг тодорхойлсон эрх зүйн үндэс бүрэлдсэн байх,

- Стратегийн түншлэлийг хэрэгжүүлэх механизм нь хэвшин тогтсон байх,
- Харилцаа нь удаан хугацааны шинж чанартай байх,
- Бие биеэ хүндэтгэж, харилцан дэмжиж,эрх ашгаа харилцан харгалздаг байх ,
- Түншлэлийн үр ашгийг нийгэм бүхэлдээ хүртэх [9],- зэрэг болно[47].

Дээрх жишгээр манай дипломат албаныхан, эрдэмтэн судлаачдын дунд түншлэлийн харилцааны янз бүрийн хэлбэр, түвшнийг илэрхийлсэн нэр томьёог логик агуулгатай болгох оролдлого удаа дараа гарч байсан боловч маргаангүй дүн эдүгээ хүртэл гараагүй байна гэж хэлж болно. Гэхдээ доктор Б.Батхишигийн дээр дурдсан номд өгүүлснээр :

“Стратегийн түншлэлийн харилцаа нь:

- Хоёр улсын хоорондын харилцааны хамгийн өндөр түвшнийг илэрхийлнэ. Урт хугацааны тогтвортой харилцаа байна.
- Улс төрийн итгэмжилсэн харилцааг тогтоож, өндөр, дээд хэмжээний айлчлалын давтамжийг ойртуулна.
- Бие биеийнхээ аюулгүй байдлыг хангах асуудлыг хамарсан харилцаа юм.
- Олон улсын болон бүс нутгийн томоохон асуудлаар бодлогын зохицуулалт, хамтран ажиллах механизм шаардах харилцаа юм.
- Хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, нэмэгдүүлэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах зэргээр эдийн засаг, худалдааны урт хугацааны тогтвортой харилцаа, харилцан хамааралтай болно.
- Батлан хамгаалах болон цэргийн салбарт бие биедээ зэвсэг, техникийн туслалцаа үзүүлэх, цэргийн мэргэжилтэн бэлтгэхэд туслах зэргээр хамтран ажиллана.
- Соёл, боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа гүнзгийрнэ г.м.

Иж бүрэн түншлэлийн харилцаа нь:

- Улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн байна.

---

[47] И.А. Новиков. Стратегическое партнерство как феномен международной политики. Вестн. Волгогр. гос. ун-та. Сер. 4, Ист. 2010. № 1 (17)

- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр байгуулж ажиллана.
- Хөрөнгө оруулалтыг харилцан дэмжинэ.
- Боловсрол, шинжлэх ухаан, технологи, соёл, эрүүл мэнд зэрэг нийгэм, хүмүүнлэгийн салбарт идэвхтэй хамтран ажиллана.
- Батлан хамгаалах салбарт мэдээлэл, туршлага солилцох, мэргэжилтэн бэлтгэх зэргээр хамтран ажиллана.
- Хоёр улсын харилцан итгэлцлийг бэхжүүлэхийг эрмэлзэнэ.

Өөрөөр хэлбэл, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын зэрэг бүхий л салбарт харилцаа, хамтын ажиллагаагаа хөгжүүлж буй учир иж бүрэн түншлэл хэмээн нэрлэж байна.

Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаа нь:

Улс төрийн харилцаа өндөр, дээд түвшинд хүрсэн байна... гээд ...улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарыг биш, харин харилцан сонирхсон хэд хэдэн салбарыг онцлон хамардгаараа иж бүрэн түншлэлээс ялгаатай, зэрэглэлийн хувьд түүнээс доогуур түвшний харилцаа юм.

Түншлэлийн харилцаа нь:

Хоёр улс хамтран ажиллах эхний түвшин бөгөөд ердийн дипломат харилцаатай харьцуулахад байнгын шинжтэй, цаашид аль ч салбарт хамтран ажиллах өргөн боломж нээгдэж байгаагаараа онцлог..."[48] хэмээн тодорхойлсон нь эдүгээ манай практик дээр харьцангуй тууштай ашиглагдаж байна гэж болно.

Дээрх тодорхойлолт нь зорилгодоо илүү ойртсон боловч бас л учир дутагдалтай гэж үзэж болохоор юм. Юуны өмнө түншлэлүүдийн элемент хоорондын уялдаа, шатлал цэгцтэй гарч хараахан чадсангүй. Нэг хэлбэрийн түншлэлээс нөгөө нь ялгагдах зарим шалгуур нь маргаан дагуулах байдалтай, мөн "иж бүрэн стратегийн түншлэл", "өргөтгөсөн иж бүрэн түншлэл" ч гэж эдүгээ шинээр буй болоод байна.

2019 онд Гадаад харилцааны яам түнш орнуудаа дараах маягаар ангилсан. Үүнд:

[48] Б.Батхишиг "Арван хоёр жил Элчин сайд". УБ.,2017

- Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай 2 улс (ОХУ, БНХАУ)
- Стратегийн түншлэлийн харилцаатай 3 улс (АНУ, Япон Энэтхэг)
- Иж бүрэн түншлэлийн харилцаатай 3 улс (БНСУ, Герман, Турк)
- Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаатай 2 улс (Канад, Австрали) [49].

Эндээс үзвэл, нэгэнт эдгээр 10 улс "ийм статустай"-гаа хүлээн зөвшөөрсөн ахул тэднийг л "гуравдагч хөрш" гэж үзэх үү, бусад түнш улсууд нь харилцааны "зөвхөн эхлэлийн" байдалтай учраас "гуравдагч хөрш" бус гэж үзэх үү, манай улс гишүүн нь болсон олон талт хамтын ажиллагааны механизмууд ямар "статустай" гэх зэрэг асуултууд гарч ирэх нь зүй ёсны билээ. Ер нь манай талын хувьд түншлэлийн хэлбэрийг харилцааны хүрсэн түвшин гэхээсээ зорилгын хэмжээнд тодорхойлж, юуны өмнө улс төр-сурталчилгааны үүднээс, субьектив хандаж буйг ажиглаж болно. Жишээлбэл, манай урд хөрш БНХАУ-тай хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа хэрхэн хоёр жилийн дотор "стратегийн түншлэлээс" "стратегийн иж бүрэн түншлэлд" шилжсэнийг ойлгоход амаргүй юм. Иймд түншлэлийн тухай ойлголтыг онол-арга зүйн хувьд цаашид гүнзгийрүүлэн боловсруулах шаардлагатай байгаа юм.

Судлаачдын үзэж байгаагаар "гуравдагч хөршийн" "улс төрийн чиглэл нь тодорхойлогч шинжтэй" боловч эдийн засгийн бүрэлдэхүүн нь манайх шиг жижиг орны хувьд онцгой ач холбогдолтой байж болох юм. Шилжилтийн үеийн бэрхшээлийг даван туулахад юуны өмнө хөгжингүй орнуудын тусламж шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн. Эдүгээ ч, цаашид ч эдгээр орны хөрөнгө оруулалт, тэргүүний техник технологи манай эдийн засгийн хөгжил дэвшлийг урагшлуулан чирэгч чухал хүчин зүйл хэвээр байна. Манай орны стратегийн байршил, байгалийн баялаг нь олон улс, үндэстэн дамнасан бүлэглэлүүдийн геополитик, гео-эдийн засгийн сонирхлыг татаж, энэ нь хөрш хоёр орны ашиг сонирхолтой давхцаж ихээхэн боломжийг нээхийн зэрэгцээ томоохон шинэ шинэ эрсдэлийг дагуулж байгаа нь тодорхой. Ийм нөхцөлд эдгээр сонирхлыг тэнцвэржүүлэх эдийн засгийн ухаалаг, дипломат бодлого, цаашилбал "хямралаас урьдчилан сэргийлэх", "хямралыг зохицуулах" арга ухааныг эзэмших явдал "гуравдагч хөршийн бодлогын" нэг салшгүй хэсэг мөн гэж үзэж байна.

[49] Гадаад харилцааны төв архив. ГХЯ

Доктор Ж.Баясахын бүтээлүүдээс үзвэл  Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын “тулгийн гурван чулуу” нь Орос, Хятад, “гуравдагч хөршүүд” бөгөөд үүнээс энэ сүүлчийн нэг “чулууг” нь нөгөө хоёртой нь тэнцвэржүүлэх зорилгоор хөгжүүлэхийг “гуравдагч хөршийн бодлого” гэнэ гэж ойлгогдож байдаг. Өөрөөр хэлбэл олон улсын харилцаан дахь хүчний тэнцвэрийн тухай сонгодог ойлголт уг бодлогын мөн чанар нь юм гэж хэлэх гээд байдаг юм. Судлаач Д.Баярхүү  энэ 2019 оны эхээр нийтэлсэн өгүүлэлдээ Монгол Улс “гуравдагч хөршийн” эрэлд гарсан түүхийг мөшгөж, үечлэх оролдлого хийхийн зэрэгцээ Хятад, Оросын байр суурийг тодотгож, Евразийн процесс, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага зэрэгтэй холбон өгүүлсэн байна[50].

Дээр өгүүлснээс үзвэл “Гуравдагч хөршийн бодлогын” зорилго, агуулгын хувьд нэгдсэн ойлголт бүрэлдэх чиглэлээр багагүй ахиц гарсан гэж үзэж болохоор байна. Харин уг бодлогын субъектүүдийн хувьд а/ өндөр хөгжилтэй, нөлөө бүхий ардчилсан улс гүрнүүдээр хязгаарласан, б/ НҮБ болон Европын холбоо зэрэг олон улсын олон талт субъектүүдийг оролцуулан өргөтгөсөн, в/ хөрш хоёроос бусад нь бүгдээрээ хэмээн өргөтгөн авч үзсэн, ийм  гурван хандлага ажиглагдаж байна. Үүний зэрэгцээ “гуравдагч хөрш” орнуудын цөмийг бүрэлдүүлэгч “түншлэл”, түүний хэлбэрүүд нь категорийн хувьд цэгцрээгүй хэвээр байна.

“Гуравдагч хөршийн бодлого”, түүний субъектүүд, хэрэгжилт, бусдын хандлагыг гадаадын судлаачид хэрхэн үнэлж, үзэж байгаа нь сонирхолтой агаад чухал юм. Энэ утгаар нэлээд урт хэд хэдэн эшлэл авч буйг болгооно буй заа. Жишээлбэл, Энэтхэгийн эрдэмтэн судлаач Шарад Сони мөн л “гуравдагч хөршийн бодлогын” хувь заяаны талаар санаа зовниж,  “Орос, Хятадыг сөрж тэнцвэржүүлэх гуравдагч хөршүүдийн үүрэг бодитой болох яагаа ч үгүй хэвээр байна. Жишээлбэл, ямар ч тохиолдолд АНУ Монголын хоёр хөрш шиг тийм их үүрэг гүйцэтгэж чадахааргүй дэндүү хол байна. ... гэхдээ хоёр болон гуравдагч хөршүүдтэйгээ сүүлийн жилүүдэд харилцаж ирсэн туршлагаа анзаарахгүй, хайхрахгүй байж огт болохгүй. Монголын геополитикийн “ацан шалаа” нь ...хоёр хөршөөсөө дэндүү хамааралтай байгаагаа багасгаж бусадтай харилцаагаа тэлж чадвал бүдгэрэн арилах болно. Зөвхөн чингэсэн тохиолдолд л Монголын хувьд, түүний улс төр, эдийн засаг стратегийн орчинд “гуравдагч” хөршүүдийн гүйцэтгэх

[50] [50] PAX MONGOLICA” :Монгол энх төр. Vol.4  2018 №1 (9) 13.Sharad K.Soni. The geopolitical dilemma of small states in external relations: Mongolia’s tryst with “immediate” and “third” neighbours. /XX зууны Монгол... /

үүрэг нааштай болж эргэх юм[51]" – гэсэн бол Тайваны нэгэн судлаач манай "гуравдагч хөршийн бодлогын" мөн чанарыг "Бүтээлч, ухаалаг, уян хатан" гэж үнэлэхийн хамт " Монгол Улс АНУ-г гуравдагч хөршөөрөө сонгохдоо юуны өмнө "амь гарах, амиа авч гарах" шаардлагыг харгалзсан бөгөөд аюулгүй байдлын асуудал бол өөр хэрэг байсан. Монгол-АНУ-ын харилцаа нааштайгаар хөгжиж байгаа нь Хятад, Оросын нөлөөний хүрээнд Монгол Улс /бүрэн/ орохоос сэргийлээд зогсохгүй АНУ болон Өрнөдийн бусад гүрнүүдээс улс төрийн дэмжлэг, цэргийн хамтын ажиллагаа, эдийн засгийн тусламж авч байх замыг нээж өгч байгаа юм. Түүнчлэн, олон улсын тавцанд Монголын эзлэх орон зайг өргөтгөж, түүний статус, нэр нөлөөг өсгөж байна."-хэмээн уг бодлогын үүсэл гарал, үр дүнг базан гаргасан байна. "Гуравдагч хөршүүд", тухайлбал АНУ-ын сонирхлыг: "АНУ стратегийн үүднээс Монголыг хэрхэн харж байгаа нь нэн тодорхой. …АНУ-гийн хувьд Монгол нь Хятадыг тогтоон барьж байх стратегийн бааз, Хятадын тайван хувьслыг өдөөгч, Хятадын хил хязгаарыг тохьгүй болгож тоглох хөзөр болж чадах юм."-хэмээн тодорхойлох оролдлого хийжээ[52].

"Гуравдагч хөршийн бодлогыг" хоёр хөрш маань төдийлөн "таашаадаггүй" нь ойлгомжтой[53]. Үүнийг Оросын монгол судлаач эрдэмтэн В.Грайворонский илэрхийлэхдээ: "Монголын "гуравдагч хөршийн" бодлогод хэд хэдэн чухал агуулга байгааг бид ялган харж болох байна. Нэгдүгээрт, Орос, Хятадын нөлөөний эсрэг жин дарж тодорхой үйлчилж чадахуйц ямар нэгэн гадны, томоохон бөгөөд нөлөөтэй гуравдагч хүчин, нэг улс ч юм уу, нэг бүлэг улс ч юм уу байх учиртай гэж бүр нэрээс нь анхлан ойлгогдож байгаа юм. Энэ агуулга нь , мэдээж хэрэг, Оросын болоод Хятадын санаа сэтгэлийг тодорхой хэмжээгээр зовоож, сэрд хийлгэхээс өөр аргагүй. Ялангуяа Орос улсын хувьд... " гээд эдийн засгийн хөгжлийн ач холбогдлыг нь ч мөн онцолсон байна[54] .

Өөр нэг судлаач Орос уг бодлогын "үзэл суртлын" үндсийг онцлон: "... "гуравдагч хөрш" хэмээх ойлголтод ...зөвхөн ардчилсан хамтын нийгэмлэгийн гишүүд гэж уламжлан тамгалагдаж ирсэн Өрнөдийн орнууд, тэдний холбоотнууд багтдаг. Үүнээс үзвэл Монголын бүс нутгаасаа гадуурх улсуудтай явуулж буй улс

---

[51] Mei-hua lan, Associate-professor, National Chengchi University, Taiwan. /XX зуны Монгол...
[52] Б.Баасансүрэн. Орос, Хятадын завсар дахь Монгол Улс. Их эрсдэл сорилтууд, эвтэй боломжууд. УБ 2014/
[53] Б.Баасансүрэн. Орос, Хятадын завсар дахь Монгол Улс. Их эрсдэл сорилтууд, эвтэй боломжууд. УБ 2014
[54] В.В.Грайворонский. Концепция внешней политики Монголии в действии: отношения с Россией, КНР, США и Японией. /XX зууны Монгол... н. 231 /

төрийн харилцаанд бүр анхнаасаа үзэл суртлын хүчин зүйл том үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд “гуравдагч хөрш” хэмээх энэ ойлголт өөрөө улс төр-үзэл суртлын концепц болсон...” хэмээн дүгнэжээ. Чингээд “... үүнээс үүдэн, Орос, Хятадын удирдлага монголын чиглэлийн бодлогодоо өөр өөрийн зорилгоо мөшгөн, “гуравдагч хөршийн” хүчин зүйлийг харгалзаж байхаас өөр аргагүй ” гэсэн байна[55].

**Тулгамдсан асуудал, цаашдын хандлага.**

Олон улсын аюулгүй байдал, геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлтийн үйл явцтай холбогдон 1980-аад оны сүүлээс Монгол Улсын гадаад харилцааны салбарт багагүй дутагдал оршиж байгааг анх удаа хурцаар шүүмжилж эхэлсэн билээ. Үүнд: нэгд, улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, хоёрт, гадаад улс төр, гадаад эдийг засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулж сураагүй болох, гуравт, олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах явдал дутагдалтай, голдуу тунхаглах, лоозогнох шинжтэй байгааг шүүмжлээд үзэл суртал, бусад ялгааг шалтаг болгохгүйгээр өндөр хөгжилтэй Өрнө, Дорнын орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит байдалд нийцсэн олон улсын харилцааны ирээдүйтэй хандлага болохыг олон хүн цохон тэмдэглэж байсан юм.

Монгол Улс 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон нь Өрнө, Дорнотой өргөн харилцаа тогтоон хөгжүүлэх шинэ боломжийг нээсэн хэдий ч, үүнийг бүрэн ашиглаагүйгээр зогсохгүй хүйтэн дайны улмаас НҮБ-ын индэр эсрэг тэсрэг хоёр системийн үзэл суртлын талбар болж, Монгол Улс ч түүнд татагдан оролцож нэг талыг нь барьж байсан юм. Харин улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаагаа бүх салбарт иж бүрэн хөгжүүлэх боломж жинхэнэ утгаараа “Хүйтэн дайны” төгсгөл үед гарч ирсэн болно. Ийнхүү Монгол Улс үндэсний эрх ашгийг дээдэлсэн, олон тулгуурт, нээлттэй, бие даасан гадаад бодлого явуулж эхэлснээр Өрнө, Дорнын олон улс оронтой түншлэлийн цоо шинэ харилцааны замд шилжсэн билээ.

Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäàë íü îëîí óëñûí íºõöºë, íýí ÿëàíãóÿà õºðø õî¸ð îðíû õ¿÷íèé áîëîí ýðõ àøãèéí òýíöâýðò áàéäëààñ èõýýõýí õàìààð÷ èðñýíèéã ò¿¿õ

[55] В.Родионов. “Третий сосед” Монголии: фактор идеологии. /XX зууны Монгол... /

õàðóóëààã. Ýíý õ¿÷èí ç¿éë öààøèä ÷ õàäãàëàãäàõ íü îéëãîìæòîé áîëîâ÷ ñ¿¿ëèéí æèë¿¿äýä áîëæ áóé õýðýã ÿâääë “ãóðàâäàã÷ õºðø” ãýäýã öîî øèíý îéëãîëòûã áèé áîëãîñîí áºãººä ¿¿íèé ¿ð äàãàâàð íü ÿìàð áàéõ òàëààð îëîí ÿíçûí òààìàãëàë äýâøèãäýæ ýõýëëýý. ¯¿íèé çýðýãöýý îëîí óëñûí õàðèëöàà, ò¿¿íèé äîòîð Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò øèíýýð á¿ðýëäýí áèé áîëæ áóé геополитикийн нөхцөл байдал íü ººð шинэ õ¿÷èí зүйлсийг ÷ ãàðãààæ èðýõèéã ¿ã¿éñãýæ áîëîõã¿é áàéíà.

Монгол Улсын гадаад харилцаанд буй болсон гуравдагч хөршийн гэгдэх энэ шинэ хүчин зүйл нь хоёр хөршөөс гадна АНУ, Япон, Өрнөд Европын зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд, олон улсын байгууллагууд тодорхой үүрэг гүйцэтгэх болсонтой уялдаатай юм. Үүний үндсэн уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц байсан бөгөөд тэдгээр орон ч манай улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, нөгөө талд урд, хойд хоёр хөршид маань болон социализмаас салсан бусад оронд шилжилтийг амжилттай даван туулж болохын жишээ болгон харуулах давхар зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Ер нь “гуравдагч хөрш”, “гуравдагч түнш, түншлэл” хэмээх нэр томьёо нь 1990-ээд оны эхнээс манай олон улсын харилцааны хэллэгт бодлогын шинжтэй, шинэ агуулга, хэлбэртэйгээр хүчтэй нэвтрэн орж ирсэн болно. Өнөөдөр “стратегийн түншлэл”, “энхийн төлөө түншлэл” “иж бүрэн түншлэл” “түншлэл хамтын ажиллагаа” “хөгжлийн түншлэл” “гуравдагч хөрш” гэх мэт нэр томьёо нь олон улсын харилцааны баримт бичгүүд, эрдэмтэн судлаачдын бүтээл зэрэгт өргөн дэлгэр тусгагдаж, мөн улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн судлаачид энэ нэр томьёог өөр өөрсдийн ашиг сонирхлын үүднээс нарийн шигтгээ оруулан, үйл явцын өрнөлтөд тохируулан тайлбарласаар байна.

Өнөөгийн  нөхцөлд аливаа улс орны оршин тогтнох, хөгжин цэцэглэх үйл явц, геополитикийн ашиг сонирхол нь зөвхөн цэрэг-стратегийн асуудалтай холбогдолтой төдийгүй, худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэх, ялангуяа ядуурлыг бууруулах зорилттой уялдан улс орнуудын хоёр болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, мэдээллийн үр шимийг солилцох зэрэг олон шаардлагаас урган гарах болсон. Энэ нь Гуравдагч хөршийн тухай ойлголтыг эрс тэлж байгаа нэг чухал хүчин зүйл юм.

Энд тэмдэглэхэд: Монгол Улсын баримталж буй Гуравдагч хөршийн бодлого нь хамтын үнэт зүйлсийг эрхэмлэх гэсэн үндсэн үзэл санаанд тулгуурлаж байгаа юм. Баримт бичгүүдэд томьёолсон “хамтын үнэт зүйлс” гэдэг нь ардчилал, чөлөөт зах зээл, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ гэсэн утгатай байхад “Стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурлана” гэдэг нь хоёр орны нийтлэг эрх ашиг адил төстэй бөгөөд урт удаан хугацаанд үргэлжилнэ, “иж бүрэн түншлэлийн удирдах зарчим” гэдэг нь бие биеэ харилцан хүндэтгэсэн, эрх тэгш түншлэлийн гол зарчмуудад тулгуурлах тухай асуудал юм. Харин “иж бүрэн түншлэл” хэмээх ухагдахуун нь улс төр, худалдаа-эдийн засаг, хөрөнгө оруулалт, нийгэм, хүмүүнлэг, соёл боловсрол, шинжлэх ухаан-техник, технологи, байгаль орчныг хамгаалах, олон улсын терроризмын эсрэг тэмцэл, батлан хамгаалах, аюулгүй байдал, бүс нутаг болон олон улсын хэмжээний асуудлыг хамарсан өргөн ойлголт юм.

Ер нь Гуравдагч хөршийн тухай асуудлыг зөвхөн аюулгүй байдал, улс төрийн асуудлын хүрээнд хязгаарлан ойлгож болохгүй юм. Зарим улс орон түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвшин тогтох үйл явц өрнөж байгаа өнөө үед ямарваа түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинж байх ёсгүй гэж үзэж байна. Үүнтэй холбоотойгоор даяаршлын үед түншлэлийн эдийн засгийн агуулга нь улам өргөжин тэлж байгаа юм.

Олон улсын харилцааны онолд Гуравдагч хөршийн тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон зүйл одоогоор байдаггүй болно. Үүнээс үүдэн 1990-ээд оноос Монгол Улсын гадаад бодлогод гарсан шинэ чиглэл буюу манай Гуравдагч хөршийн бодлого нь олон улсын харилцааны онол, практикт түрэн орж ирсэн нэг өвөрмөц асуудал болоод байгаа нь үнэн юм. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, хөршийн тухай уламжлалт ойлголт дэлхий даяар шинэчлэгдэж байгаатай ч энэ нь бас нягт холбогдож байгаа болно. Хэдийгээр Монгол Улс Гуравдагч хөршөө эрж хайж эхэлсэн үйл явц бүр XX зууны эхээр үүссэн түүхтэй боловч энэ үйл явцыг цэгцтэй ойлгох, томьёолох талаар нухацтай оролдлого хийгдэж байгаагүй юм. Ийм ч учраас Гуравдагч хөршийн тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон шинжлэх ухааны үндэслэлтэй томьёолол одоогоор манайд ч бас хараахан гараагүй байна.

“Аливаа улсын гадаад бодлого нь оршин буй газар зүйгээрээ тодорхойлогдоно” гэж Наполеон Бонапарт хэлжээ. Энэ бол жижиг, бага улсад ихээхэн хамаатай үг юм. Улс гүрэн бүгд нэг нь нөгөөтэйгөө айл хөрш болж зэрэгцэн оршдог. Германы геополитикч, профессор Фридрих Ратцелийн (Friedrich Ratzel 1844-1904) “Хөршөө сонгодоггүй” гэж хэлсэн нэгэн үг буй. Энэ бол зөвхөн хил залгасан орны тухайд өгүүлж буй зүйл юм. Харин сайн хөршийн харилцааны тухайд бол түүнийг заавал зэргэлдээ гэхгүй алс холын аль ч оронтой тогтоож болно. Энэ утгаараа газар зүйн хөрш нь хаяа нийлсэн хэдэн ч орон байж болох боловч харин хил залгаагүй хөршөө бол өөрсдөө сонгож болоход хамаг учир нь оршиж байгаа юм.

АНУ-ын олон улсын харилцааны онолч, геополитикч, нэрт профессор Ханс Моргентау аливаа гадаад бодлого, дипломат үйл ажиллагааны үндсэн шалгуурыг дараах байдлаар тодорхойлсон юм. Үүнд:

1. “Дипломат бодлогыг боловсруулахдаа өөрийн хүч чадавх, бололцоонд тохируулан зорилтоо тодорхойлох ёстой,

2. Дипломат бодлогыг төлөвлөхдөө нөгөө улсынхаа зорилтыг зөв таньж тодорхойлох ёстой,

3. Дипломат бодлогыг боловсруулахдаа хоёр улсын зорилт хоорондоо хэр зэрэг нийлж авцалдаж байгааг нягтлан үзэх ёстой,

4. Дипломат бодлогыг хэрэгжүүлэхэд дээрх гурван зүйлд тулгуурлан өөрийн зорилтыг ажил хэрэг болгох арга замыг ончтой сонгох ёстой” гэжээ.

Энэ нь Монгол Улсын Гуравдагч хөршийн бодлогын онол, үзэл баримтлалыг боловсруулахад тулгуурлах судалгааны чухал арга зүй байж болох юм.

Ер нь олон улсын харилцаа, дипломатын түүхэнд Гуравдагч хөршийг хайсан баримтуудаас харахад энэ нь зөвхөн хоёр улстай хиллэдгээс шалтгаалан гардаг ойлголт, бодлогын асуудал бас биш юм. Хоёр улстай хиллэдэг гэдэг нь асуудлын мөн чанарыг сонгодог утгаар нь илэрхийлж буй хэрэг. Гэтэл олон улсын харилцааны түүхээс харахад аливаа Гуравдагч хөрш гэдэг нь өргөн утгаараа “нөлөө бүхий гуравдагч хүчин” гэдэг өөр нэг ойлголттой нягт уялддаг бөгөөд энэ нь хил залгаа байршлын зэрэгцээ тухайн үеийн олон улсын харилцааны чиг

хандлага, онцлог, их гүрнүүдийн хүчний харьцаа, эрх ашигтай нягт уялдаатай, улс хоорондын харилцааны улс төр, эдийн засаг, цэрэг-стратегийн олон талт агуулга бүхий ойлголт юм.

Дээр дурдсан зүйлүүдийг нэгтгэж үзэхэд Гуравдагч хөршийн бодлого гэдэг нь зөвхөн газар зүйн тухай ч бус, тухайлсан нэг ч улсын тухай ч бус, харин улс төр, эдийн засаг, аюулгүй байдал, геополитикийн хүрээг хамарсан олон улсын харилцааны онолын цогц ойлголт бөгөөд Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн тогтолцоог тууштай дэмжигч Өрнө, Дорнын ардчилсан орнуудын бүлэг болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт гэж тодорхойлж болохоор байна.

Харилцан хамаарал гүнзгийрч, олон улсын харилцааны өөрчлөгдөн буй даяаршсан дэлхий ертөнцөд аливаа бага, жижиг улс орны оршин тогтнох, хөгжин дэвжих, үндэсний аюулгүй байдлаа хангах нь дан ганц цэрэг-стратегийн асуудалтай холбогдохгүй, харин худалдаа хөрөнгө оруулалт, зээл, тусламж, эдийн засгийн өсөлт, экологи, тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах, ардчилал, сайн засаглал, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, шинжлэх ухаан-технологи, мэдээллийн технологийн үр нөлөөлөл, далайд гарцгүй байршил болон улс орнуудын хоёр болон олон талт хамтын ажиллагаа зэрэгтэй уялдаж өргөн утгыг агуулах болсон байна.  Гуравдагч хөршийн бодлого нь юуны өмнө үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн эрх ашгийн тухай асуудал юм. Хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж буй өнөө үед бага жижиг улсын аюулгүй байдал, тусгаар тогтнол нь гадаад эдийн засгийн харилцаа, түүнээс гарах үр өгөөжтэй амин чухал холбоотой болж байна. Энэ утгаараа Гуравдагч хөршийн бодлогын мөн чанар нь “Гадаад харилцааг эдийн засагжуулах” гэсэн ойлголттой ч уялдах учиртай юм. “Монгол улсын дипломат үйл ажиллагааны эдийн засгийн агуулгыг нэмэгдүүлэх нь чухал байна” гэж олон хүн хэлдэг нь нь үүнийг бас нотолж байгаа болно.

Түүнчлэн Гадаад харилцааны яамнаас эрхлэн гаргасан “Гадаад бодлогын Хөх ном”-д “Монгол оронд тохиож болох нийгмийн тогтворгүй байдал, улс төр-эдийн засгийн хямрал, улс төрийн засаглалын гэнэтийн өөрчлөлт, байгалийн гамшиг  бэрхшээл, далайд гарцгүй байдал зэрэг сөрөг хүчин зүйлийг даван туулахад  гуравдагч хөршийн тухай үзэл баримтлал чухал үүрэгтэй гэсэн санааг ч бодолцох учиртай” гэсэн байна.

Эдгээрээс харахад Монгол Улс Гуравдагч хөршийн бодлогын хүрээнд Өрнө, Дорнын голлох ардчилсан орнуудтай тогтоосон түншлэлийн шинэ харилцаа нь дараах үндсэн шинж чанарыг агуулж байгаа нь ойлгогдож байгаа юм. Үүнд:

- Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс, ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаа, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлсэн;
- Хоёр улсын төр, засаг харилцааг иж бүрэн хөгжүүлэх эрмэлзэл төгс; (тухайлбал газар нутаг, өр авлагын маргаангүй, олон улсын терроризм, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх болон пуужингаас хамгаалах хөтөлбөр зэргийн талаар ижил байр суурьтай);
- Талуудын харилцаа нь улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, соёл боловсрол, байгаль хамгаалал, хүмүүнлэг, батлан хамгаалах, аюулгүй байдлыг бүрэн хамарсан буюу хамрах төлөв байдалтай;
- Хоёр талын эдийн засгийн бүтэц нь харилцан бие биеэ нөхөх боломжтой;
- Бизнесийн хүрээнийхэн, төрийн бус байгууллага, иргэд хоорондын харилцааны түвшин идэвхтэй хөгжиж байгаа;
- Хоёр улсын ард түмний бие биеэ харьцангүй өндөр түвшинд танин мэдсэн;
- Олон тулгуурт, нээлттэй, бие даасан, үндэсний эрх ашигт нийцсэн гадаад, дотоод бодлого явуулдаг, түүнийгээ харилцан хүндэтгэсэн;
- Бүс нутгийн болон олон улсын харилцааны асуудлаар ижил буюу төстэй байр суурь баримталсан;
- Бүс нутгийн болон олон улсын байгууллагад бие биеэ харилцан дэмжсэн зэрэг олон хүчин зүйлүүдийг оруулж болох юм.

Үүнтэй уялдуулан хоёр их гүрнээр хүрээлэгдсэн Монгол улс Гуравдагч хөрштэй байж тэдгээртээ түншийн харилцааг тогтоон хөгжүүлэх дотоод нөхцөл шаардлагыг дараах байдлаар томьёолж болохоор байна. Үүнд:

- Эдийн засгийн талаар хоёр хөрш орноос хараат байдал арилаагүй;
- Ашигт малтмалын асар их нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулахад зөвхөн хоёр хөршдөө тулгуурлах нь учир дутагдалтай байгаа;
- Импорт голлосон эдийн засаг зонхилсон хэвээр байгаа;

- Үндэсний үйлдвэрлэл, дэд бүтэц, технологийн хөгжлийн түвшин доогуур, өрсөлдөх чадвар сул;
- Экспорт нь цөөн тооны түүхий эд, мал аж ахуйн гаралтай (зэс, алт, нүүрс, ноолуур) бүтээгдэхүүнд тулгуурласан, дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлтөд шууд өртдөг;
- Өрнөдөд Монгол Улс улс төр, эдийн засгийн хос шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй орны жишээ болж харагддаг боловч “сайн засаглал”, “тогтвортой хөгжил” бүрэн гүйцэд зүгширч төлөвшөөгүй, ихээхэн хэврэг бөгөөд эмзэг байгаа;
- Улсын төсвийн дийлэнх хувь нь захиргааны зардал, халамжийн чиглэлд зориулагддаг;
- Далайд гарцгүй газар зүйн байршилтай;
- Гадаадын зээл тусламжид найдсан буюу түшиглэсэн хэвээр;
- Унаган байгальтай гэх боловч эрс тэс уур амьсгалтай, цөлжилт хуурайшилт, байгаль орчны бохирдол гамшгийн хэмжээнд дөхөж очсон;
- Цөмийн зэвсэгтэй их гүрнүүдийн дунд оршдог зэрэг нөхцөл байдлуудаар тодорхойлж болмоор байгаа болно.

Хэдийгээр Монгол Улсын Гуравдагч хөршийн бодлого тодорхой хэмжээгээр амжилтад хүрч, гадаад дотоодод хүлээн зөвшөөрөгдөж эхэлсэн боловч энэ талаар явуулсан онолын болон хавсарга судалгаа үндсэндээ байхгүй, тулгуур ойлголтууд нь цэгцтэй томьёологдоогүй байна. Одоогоор гуравдагч хөршийн асуудлын онолын сэтгэлгээний түвшин удаа дараагийн эрдэм шинжилгээний бага хурал, уулзалт, ярилцлагууд дээр эрдэмтэд, судлаачид, мэргэжлийн хүмүүс өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх хэмжээнд л байгаа нь тулгамдсан гол асуудал болж байна. Энэ нь Гуравдагч хөршийн бодлогын асуудлаар тусгайлсан томоохон нэгдсэн судалгаа явуулах үндсэн дээр түүхэн уламжлал, өнөөгийн байдал, цаашдын хандлагыг нь нээн гаргах, энэ ойлголтын шинжлэх ухааны болон олон улсын харилцааны агуулгыг нийтээр хүлээн зөвшөөрөх хэмжээнд тодорхойлон боловсруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байгаа юм.

Түүнчлэн үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын эрх зүйн хэм хэмжээг зохицуулж байгаа үзэл баримтлал, хөтөлбөр, цаашлаад Монгол Улсын хууль тогтоомжуудад Гуравдагч хөршийн бодлогын эрх зүйн агуулгыг албан ёсоор томьёолсон тодорхойлолт одоогоор байхгүй байгаа тухай өмнө өгүүлсэн. Энэ нь

төрийн бодлого, түүний дотор гадаад харилцааны энэ чухал шинэ чиглэлийн харилцаа эрх зүйн талаасаа одоог хүртэл зохицуулалтгүй явж байгааг харуулж буй бөгөөд ер нь үүнтэй уялдаатайгаар нэлээд тооны бэрхшээлтэй буюу тулгамдсан асуудлууд үүсээд байгаа юм. Гуравдагч хөршийн бодлого нь зөвхөн Гадаад бодлогын бүрэлдэхүүн хэсэг, түүний нэг гол чиглэл биш болоод байна. Энэ бодлого нь бусад салбарын, түүний дотор үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалахын болон эдийн засаг, нийгмийн бодлогуудад хүчтэй нөлөө үзүүлж эхлээд байна. Гэтэл эдгээр салбарын бодлого, үйл ажиллагаанд энэ ойлголтыг эрх зүйн болон шинжлэх ухааны талаас нь цэгцтэй тусгасан, нийтлэг байдлаар тодорхойлсон зүйл бас алга байгаа юм.

Монгол улсын Гуравдагч хөршийн бодлогын тухайд Өмнөд, Умард хөршүүд тааламжгүй байр суурь албан ёсоор илэрхийлж байгаагүй бөгөөд харин хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд болон олон улсын харилцаа, геополитик, стратеги судлалын салбарын хүмүүс өөрсдийн санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж иржээ. Эдгээр хүмүүсийн үзэл бодол нь ерөнхийдөө байдлыг ойлгож байгаа талдаа гэж хэлж болохоор байгаа боловч асуудлыг өөрсдийн орны геополиткийн ашиг сонирхол, геостратегийн бодлогын байр сууринаас дүгнэсэн, бүхэлдээ болгоомжилсон, эргэлзсэн байдалтай байгааг тэмдэглэх нь зүйтэй юм. Ялангуяа сүүлийн жилүүдэд Монгол Улсын байгалийн асар их баялаг дэлхий нийтэд нээлттэй болж, үүнээс үүдэн том гүрнүүдтэй хамтран ажиллах, тэдгээрийн хөрөнгө оруулалтыг татах асуудалдаа бид Гуравдагч хөршийн бодлогын гол үзэл санаанд тулгуурласан байр сууринаас хандаж эхэлмэгц хөрш орнуудын зүгээс манай энэ бодлогод таагүй хандах байдал ажиглагдаж эхэлж байгаа нь анхаарал татсан асуудал болж байна.

Үүний зэрэгцээ ашигт малтмалын орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэ ажлыг бусад том орны зүгээс сонирхох нь эрс нэмэгдэж, энэ утгаараа хөрш хоёр орон хоорондоо болон өөр бусад оронтой зөрчилдөх, сөргөлдөх байдал ч ажиглагдаж эхэллээ. Бидний гуравдагч хөршүүд гэж нэрлэж байгаа орнууд ч ямар нэг байдлаар хоорондоо өрсөлдөх байдалтай болсон нь ажиглагдаж байгаа юм. Энэ нь тэд Монголын гуравдагч гол хөрш байх байр суурьт өөрсдийгөө аваачихыг эрмэлзэх, үүгээрээ дамжуулан манай уул уурхайн салбарт давуу байдлаа тогтоохыг чармайх байдлаар илэрхийлэгдэж байгаа болно. Ийм өрсөлдөөн зөвхөн уул уурхайн салбарт ч байгаа юм биш. Гуравдагч хөрш орны

хувьд Монголын улс төрийн байгуулалт, соёл иргэншлийн хүрээнд, цаашилбал цэрэг-стратегийн салбарт холбоотон болохыг зарим том гүрэн ихээхэн эрмэлзэж байгаа нь улам бүр тодорхой болсоор байна.

Эцсийн дүндээ энэ бүхэн нь Монгол Улсын Гуравдагч хөршийн бодлого нь хөгжлийг түргэсэгч, аюулгүй байдлыг хангагч нэг гол хүчин зүйлийн зэрэгцээ бий болсон шинэ нөхцөл байдалд бас тодорхой хэмжээгээр сөргөлдөөнийг үүсгэгч, магадгүй шинэ зөрчил сөргөлдөөнийг дагуулагч хүчин зүйл болон хувирч болзошгүйг харуулж байна.

Монгол улс гадаад бодлого, Гуравдагч хөршийн бодлогыг хэрэгжүүлэхдээ Стратегийн гурвалжны нөлөөг сайтар ажиглан анхаарч байх нь бас чухал болж байна.Олон улсын харилцааны түүхэнд АНУ, Орос, Хятадын харилцааны хамаарлыг стратегийн гурвалжин гэж томьёолдог. Ийм гурамсан холбоо байгуулахаар тохиролцсон ч юм биш. Тохиролцох магадлал ч хомс. Харин энэхүү гурвалжны аль нэг үзүүр рүү хүндийн жин хэвийвэл аяндаа нөгөө хоёр нь тун амархан  хэл амаа олдог, эсвэл битүүхэн ойлголцож байдаг түүхтэй билээ.

Стратегийн гурвалжны аль нэг өнцгийн сүүдэр тусдаггүй орон зай гэж бөмбөрцөг дээр байхгүй. Тэрхүү үүлэн сүүдэр дор мөнөөх их гүрүүдийн геостратегийн ашиг сонирхол байдаг. Өнөөдрийн Араб дахины үйл явдлын халуун цэгүүдийн үйл явдлыг сайтар тунгаавал мөнөөх гурван их гүрний ашиг сонирхол, учир холбогдол илүү тод харагдах жишээтэй юм.

Бээжин, Вашингтон, Москва  хотыг дэлхийн газрын зураг дээр шулуун шугамаар холбон зурвал мөнөөх стратегийн гурвалжин хэмээх талбар үүсэх бөгөөд Монгол улс бүхлээрээ үүний дотор нь багтаж харагдах болно. Ийм учраас төр засгаас том гүрнүүдийн геополитикийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх, энэ чиглэлээр тодорхой алхмуудыг хийхдээ ихээхэн ухаалаг, ул үндэстэй хандаж байх, багагүй хөрөнгө хүч зарцуулах шаардлага улам бүр нэмэгдсээр байна.

Гуравдагч хөршийн бодлого нь хоёр хөршөөс Монгол Улсад үзүүлж болох эерэг нөлөөллийг дэмжих, сөрөг хүчин зүйлсийг саармагжуулах замаар олон улсын харилцааны тэнцвэрийг буй болгоход чиглэх ёстой юм. Иймээс энэ бодлогын мөн чанар нь Монгол Улсын гадаад бодлого, түүний шийдвэр гаргах

ажиллагааны шинжлэх ухааны онол арга зүйн үндсийг улам бүр боловсронгуй болгох шаардлагад тулгуурлах нь чухал болж байна. Бага жижиг улсын хөгжил дэвшил, аюулгүй байдлын баталгаажилтын чухал эх сурвалж нь идэвхтэй гадаад бодлого, дипломат ажиллагаа байдаг билээ.

### 3.1.4. Солонгосын хойгийн асуудлаар баримталж буй бодлого.

**Мөн чанар, учир холбогдол.**

Äýëõèéí II äàéíû òºãñãºëººñ ýõëýýä ºíººã õ¿ðòýë ¿ðãýëæèëæ áóé Ñîëîíãîñûí õîéãèéí õÿìðàë íü äýëõèéí óëñ ã¿ðí¿¿äèéã õóâààí ººðèéí àøèã ñîíèðõîëä íèéöñýí óëñ òºð, íèéãìèéí áàéãóóëàëûã òîãòîîõîîð òîõèðñîí õîëáîîòîí ã¿ðí¿¿äèéí òîõèðîëöîîíû ¿ð ä¿íä áèé áîëñîí Ñîëîíãîñûí õîéãèéí õóâààãäìàë áàéäàëòàé õîëáîîòîé þì. Ýíý õóâààãäìàë áàéäàë íýã ¿íäýñòýí õîîðîíäîî äàéòàõàä õ¿ðãýæ óëìààð ò¿¿íä äýëõèéí óëñ îðíóóä òàòàãäàí îðæ äýëõèéí II äàéíû äàðààõ òîìîîõîí á¿ñ íóòãèéí äàéí áîëñîí áèëýý.

1953 îíîîñ õîéø õî¸ð Ñîëîíãîñ ¿íäñýíäýý äàéíû áàéäàëòàé îðøèæ, ýíõ òàéâàíû ãýðýý áàéãóóëàõ óäààí æèëèéí îðîëäëîãî ìóõàðäìàë õýâýýð áàéíà.

Ñîëîíãîñûí õîéãèéí õÿìðàë óðò óäààí õóãàöààíä ¿ðãýëæèëæ, çàðèì ¿åä õóðöàäìàë áàéäàëä îðæ áàéñàí ãîë øàëòãààí íü íýãä¿ãýýðò ÀÍÓ, ò¿¿íèé õîëáîîòîí ßïîí, ªìºä Ñîëîíãîñûí ç¿ãýýñ Ïõåíüÿíû òàëààð ÿâóóëæ èðñýí õàòóó, äàéñàãíàñàí áîäëîãî, õî¸ðäóãààðò Àìåðèêèéí öýðãèéí õ¿÷èí ªìºä Ñîëîíãîñò áàéðëàæ, öºìèéí çýâñýã õýðýãëýõýýð ñ¿ð äàëàéëãààæ áàéñàí ÿâäàë ãýæ ¿çýæ áîëîõ þì.

Èéíõ¿¿ ãàäààä òàëààñàà äàéñàãíàñàí õ¿ðýýëýëä, äýëõèéí õàìòûí íèéãýìëýãýýñ òóñãààðëàãäñàí, ãàíöààðäìàë îð÷èíä áèå äààí õºãæèõ ¿çýë áàðèìòëàë õýðýãæ¿¿ëæ èðñýí ÁÍÀÑÀÓ ººðèéã ºº õàìãààëàõ, øààðäëàãà ãàðâàë õàðèó öîõèëò ºãºõ õýðãñýëòýé áàéõ çîðèëãîîð öºìèéí õºòºëáºð õýðýãæ¿¿ëæ ýõýëñýí ò¿¿õòýé.

Ïõåíüÿí ýõýíäýý öºìèéí ýð÷èì õ¿÷èéã ýíõèéí çîðèóëàëòààð àøèãëàõ õºòºëáºð õýðýãæ¿¿ëæ áàéãààãàà çàðëàí öºìèéí çýâñýãèéí áîëîâñðóóëàëòàà íóóæ èðñýí áîëîâ÷ ÀÍÓ-ûí ºíººãèéí çàñàã çàõèðãààíààñ ÁÍÀÑÀÓ ðóó õàíäñàí õàòóó áîäëîãî õýðýãæ¿¿ëýõ áîëñîí ¿åòýé äàâõöóóëàí öºìèéí çýâñýã ýçýìøñíýý çàðëàñàí áàéäàã. ¯¿íýýñ ãààíà àëñûí òóñãàëòàé ïóóæèíãèéí óäàà äàðààãèéí òóðøèëò ÿâóóëæ, ýöýñò íü öºìèéí äýëáýðýõ òºõººðºìæ òóðøñàíààð õÿìðàë óëàì õóðöäààâ.

ÁÍÀÑÀÓ-ûí öºìèéí õºòºëáºðèéã íýã òàëààñ ººðèéãýý õàìãààëàõ, ñºðãºëäºã÷ òàëä øàõàëò ¿ç¿¿ëýõ, ºíººãèéí óëñ òºðèéí äýãëýìýý õàäãàëàõ, áàéð ñóóðèéã íü áýõæ¿¿ëýõýä ÷èãëýñýí óëñ òºðèéí çîðèëãîòîé àëõàì, íºãºº òàëààñ ÀÍÓ, ò¿¿íèé õîëáîîòíóóäòàé õèéõ ÿðèà õýëýëöýýíä àøèãëàõ ¿ð àøèãòàé "òîãëîîìûí õºçºð" ãýæ ¿çýæ áîëîõ òàëòàé.

Зүүн хойд Ази, Солонгосын хойгийн аюулгүй байдлын асуудал эдүгээ бүх нийтийн, түүний дотор манай улсын онцгой анхаарлыг татаж байгаа билээ. Монгол улсын  аюулгүй байдал энэ дэд бүс нутгийн аюулгүй байдлын салшгүй нэг хэсэг юм.

Солонгосын хойгийн асуудал нь дэлхийн II дайнаас хойш шийдэгдээгүй үлдсэн цөөн зүйлийн нэг бөгөөд  олон жилийн турш хамгийн ярвигтай, байдлыг байнга тогтворгүйжүүлэгч хүчин зүйл болж ирсэн байдаг. Эдүгээ Хойд Солонгос цөмийн зэвсэгтэй болсноор сүйрлийн аюул нийт Зүүн Хойд Азийн улс орнуудад илүү бодитойгоор заналхийлэх болжээ. Энэ бүс нутаг дахь хүчний харьцаа өөрчлөгдөж, бүс нутгийн улс орнуудын "хүчинд дулдуйдах" бодлого даамжирч, цаашдын хөгжлийн төлөв  нь улам бүр тодорхойгүй болов. Ийм хувьсал нь Монгол Улсаас Солонгосын хойгийн асуудлаар баримталж ирсэн байр суурь, Зүүн Хойд Азид гүйцэтгэх үүргийг буурьтайгаар эргэн харахыг шаардаж байгаа нь ойлгомжтой.

Манай улс БНАСАУ-тай анх 1948 онд дипломат харилцаа тогтоосноосоо хойш дөч гаруй жилийн турш Умард Солонгосын байр суурь, Солонгосын хойгийн асуудлаарх социалист хамтын нөхөрлөлийн орнуудын нэгдсэн бодлогыг тууштай дэмжиж, баримталж ирсэн юм. "Хүйтэн дайн" эцэслэж,  ардчилал, зах зээлийн эдийн засгийн баримжаа авснаар байдал үндсээрээ өөрчлөгдсөн нь тодорхой. 1990 онд Өмнөд Солонгостой харилцаа тогтоосноор манай Зүүн Хойд Азийн бүс нутаг дахь дахь байр суурь урьд өмнөхөөс илүү бодитой, "харагдахуйц" болж, Умард, Өмнөдийн хооронд "тэнцвэр барих" зэрэг илүү ур чадвар шаардсан бодлого явуулах замаар энэ бүс нутгийн улс гэсэн "identity"-гаа олж бататгах урьдчилсан нөхцөлийг бүрэлдүүлсэн байдаг.

Манайд солонгос судлал  уламжлал сайтай, энэ чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн, судлаач цөөнгүй бий.  Юуны өмнө Б.Лхагваа, П.Үржинлхүндэв, Д.Уламбаяр, Ж.Баттөр гэхчлэн дурдаж болно. Монгол-Солонгосын харилцааны

түүх, манайхаас Зүүн Хойд Азид явуулж ирсэн, явуулж байгаа бодлогын судалгааны өгүүлэл, нийтлэлүүд олноор гарч байдаг. Сүүлийн үед гарсан бүтээл дотроос Б.Лхагваагийн "Нэгдсэн Солонгос айсуй. Шинэ баримт, мэдээ, мэдээлэл, цогц ойлголт" нэрийн дор Стратегийн судалгааны хүрээлэнгээс эрхлэн гаргасан ном, П.Үржинлхүндэвийн "Ойр дайдын оронтой түншилсэн түүхээс..." нэр бүхий 2019 онд хэвлэн гаргасан номыг тус тус онцолж болно.

Б.Лхагваагийн үзэж байгаагаар 1990 оноос хойш монгол-солонгосын харилцаа, солонгосын хойгийн асуудлаарх манай байр суурьт дараах өөрчлөлтүүд гарчээ. Үүнд:

Нэг. Дээр дурдсан хэд хэдэн шалтгааны улмаас монгол-солонгосын харилцааны гол чиглэл "Умардаас Өмнөд рүү шилжсэн. Энэ бол гол өөрчлөлт. Түүгээр ч зогсохгүй БНСУ-ын "нарны элч" бодлогыг дэмжсэнээр Умард Солонгос 1999 оны 8-р сард Улаанбаатар дахь ЭСЯ-аа хааж байгаад 2002 онд эргэж нээсэн." Хэдийгээр сүүлийн үед хоёр талын харилцаа зарим чиглэлээр сэргэх хандлагатай байгаа боловч Умардын "эрх баригчид Зүүн Хойд Азийн аюулгүй байдал, хамтын ажиллагаанд саад тотгор учруулсаар ахул... түүнчлэн хоёр орны улс төр, эдийн засгийн системийн ялгаа хэвээрээ байх бол харилцаа хязгаарлагдмал, хэтийн төлөв нь бүрхэг байдлаар үргэлжлэх байх. Харин тэр чинээгээр Монгол, Өмнөд Солонгосын харилцаа нягтарч өргөжнө"

Хоёр. Монгол Улс, Умард Солонгос хоёр 2002 онд "Найрамдалт харилцаа, хамтын ажиллагааны шинэ протокол" байгуулсан хэдий ч харилцаа ердөө л "уламжлалаа" хадгалах ерөнхий чиглэлийн хүрээ, түвшинд үргэлжилж байна. Харин Өмнөд Солонгостой "нийгмийн эрхэмлэх үнэт зүйлс, зарчим, зорилго, чиг хандлага нэг"-ийн улмаас "иж бүрэн түншлэлийн харилцаа" хөгжүүлж байна... Эндээс Солонгосын хоёр талтай харилцаж буй манай улсын харилцааны түвшин, цар хэмжээ, жин, байр суурийн ялгаа харагдаж байна."

Гурав. Өнгөрсөн 20 гаруй жилийн туршлагаас үзвэл манай тал Умардтай харилцахдаа "хоёр талын харилцааны зэрэгцээ бүс нутгийн аюулгүй байдал, дэлхий...нийтийн эрх ашиг зэргийг давхар харгалзаж" ирсэн. Харин Умардын хувьд Монгол Улстай "зөвхөн өөрийн эрх ашиг, хэт бие даасан бодлогыг урьтал болгох, ганцаардмал байдлаас болон Хятадын хэт хамаарлаас ангид байгаа мэт суртал ухуулгын шинжтэй бодлогодоо хань татах, хэмжээ нь их биш боловч

материаллаг тусламж авах чиг шугам барьж...цэвэр хоёр талын шугамаар харилцахыг чухалчилж” ирсэн гэж үзэж болохоор байна. “Энэ бол тус хоёр орны харилцааны бас нэг онцлог” юм.

Б.Лхагваагийнхаар бол Солонгосын асуудлаарх монголын байр суурь “их тодорхой”. Тэр бээр “Бүс нутгийн аюулгүй байдал бол Монгол Улсын хөгжлийн хөтөлбөрийг хангах гол нөхцөлийн нэг” гэдэг үүднээс ханддаг. Тийм ч учраас Умардаас цөмийн туршилт хийж, пуужин хөөргөх бүр “харамсал” илэрхийлж ирсэн байдаг. Солонгосын нэгдлийг энхийн замаар хангахад чиглэсэн бүхий л санал санаачилга, алхмыг дэмждэг “бүс нутгийн цорын ганц улс” гэж зарим судлаачид үздэг гэсэн байна.

Манай улс 1990-ээд оны сүүлчээс Зүүн Хойд Азийн байдлыг тогтворжуулах, солонгосын асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх үүднээс идэвхтэй байр суурь эзлэхийг эрмэлзэх болж, чингэхдээ:

- холбогдох талуудын хооронд зуучийн үүрэг гүйцэтгэх бололцоог эрэлхийлэх,
- олон талт яриа хэлэлцээний механизм бий болгох чиглэлээр тус тус санаа тавьж ажиллаж ирсэн болно.

Зуучлалын тухайд: Өнгөрсөн хугацаанд Умардаас зугтан дүрвэсэн цөөн тооны иргэдийг Өмнөдөд шилжүүлж, мөн цөөн тооны гэр бүлийг нэгтгэхэд тус дэм үзүүлсэн. Мөн Умардын болон Японы албаны хүмүүс хоорондын уулзалтыг 2006 онд Улаанбаатар хотноо хийх бололцоог олгосон. Үүнээс өөр зуучлал гэх гавьтай үйл явдал эдүгээ хүртэл тохиогоогүй байна гэж болно.

Зуучлалын тухай ярихдаа бид юу ярьж, ярих гэж байгаагаа сайтар ухварлаж байх нь зүйтэй биз. Зуучлахад зөвхөн газар зүйн хүчин зүйл, эсхүл тухайн бүс нутгийн орнууд, сөргөлдөгч талуудтай “сайн” харилцаатай байх нь хангалтгүй юм. Зуучлах гэдэг ойлголт нь дундын нутаг дэвсгэр олгох гэхээс /энэ нь зүгээр туслах, дэмжих хэмжээ/ илүү өргөн ойлголт, уг үйл явц, процесст нь тодорхой хэмжээгээр оролцож, нөлөө үзүүлж, үр дүнд хүргэхийг хэлнэ гэж болно. Зуучлахад наад зах нь дараах нөхцөлийг хангасан байх учиртай. Үүнд:

- зуучлуулагч талуудын аль алины нь итгэлийг хүлээсэн байх, итгэл үзүүлэх хэмжээний “сайн” харилцаатай байх,

- яриа хэлэлцээнд зөвхөн “дээвэр”-ийн идэвхгүй үүрэг бус, идэвхтэй эвлэрүүлэх, зөвшилцүүлэх үүрэг гүйцэтгэх,-чингэхийн тулд уг асуудлыг гүнзгий мэдэж, эзэмшсэн байх, яриа хэлэлцээний ур чадвартай байх,
- ийм чадвартайг нь зуучлуулагчид хүлээн зөвшөөрсөн байх хэрэгтэй гэх мэт.

Нэг үгээр хэлбэл зуучлагчийн үүрэг гүйцэтгэхэд олон янзын хувьсах, үл хувьсах хүчин зүйлийн нэгдэл бүрэлдэх шаардлагатай гэдгийг бид ойлгох ёстой билээ.

Солонгосын хойгийн асуудал мухардмал байдлаасаа гарах үйл явц 2018 оны эхнээс гэнэт эрс сэргэн идэвхэжсэний үнэн учир шалтгааныг дүгнэх цаг эдүгээ болоогүй байна. Гэхдээ үүнийг сайтар судалж улс төрийн дүгнэлт хийх, сургамж авах шаардлага монголын талд ч тулгарч байгаа юм.

“Улаанбаатарын яриа хэлэлцээний” тухайд: 2013 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотноо болсон Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн Сайд нарын 7 дугаар бага хурлын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч “Зүүн хойд Азийн асуудлаарх Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилгыг албан ёсоор дэвшүүлсэн байдаг. Түүнээс хойш ГХЯ, ССХ хамтран жил бүр ийм нэрийн доорх олон улсын хурлыг зохион байгуулж ирсэн бөгөөд өнгөрсөн 2017 онд дөрөвдөх удаагаа хуралдуулсан болно. Уг нь ийм уулзалт ярилцлага хийх санаачилга анх Стратегийн судалгааны хүрээлэнгээс бүр 2007 оны үеэс гаргаж холбогдох хүмүүст хандаж байсан түүхтэй юм.

“Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном-2016”-д өгүүлэхдээ: манай улс нь”... дэлхийн улс орнуудтай аливаа маргаантай асуудалгүй, дэлхийн геополитик, гео-эдийн засгийн өнөөгийн зөрчилдөөнтэй байдлын шууд нөлөө бага орны хувьд бүс нутгийн болон түнш орнуудын нийтлэг эрх ашгийн төлөө өөрийн хувь нэмрээ оруулах бүрэн боломжтой орны нэг юм. Ази, Номхон далайн бүс нутаг, түүний дотор Солонгосын хойгийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах нь манай гадаад бодлогын чухал зорилт болохын хувьд энэ чиглэлээр Монгол Улс санаачилгатай ажиллаж өөрийн хувь нэмрийг оруулах зорилт тавьж “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилга дэвшүүлж тэр нь эдүгээ бүс нутгийн орнуудыг оролцуулсан олон талт яриа хэлэлцээний нэг механизм болоод байна” гэж дүгнэсэн байна.

Үүнээс үзвэл, 2013 онд манай талаас төрийн тэргүүний хэмжээнд зарлан эхэлсэн “Улаанбаатарын яриа хэлцээ” хэмээх үйл явц нь дээр дурдсан хоёр зорилтын давхцалын илрэл болсон нь ойлгомжтой. Гэхдээ зарим судлаачдын үзэж байгаагаар “Улаанбаатарын яриа хэлцээ” нь эхнээсээ бууртай судалгаанд суурилж боловсрон бэлтгэгдээгүй, олон талын бодит шаардлага, тохиролцооны үндсэн дээр гэхээсээ юуны өмнө манай өөрийн улс төр, сурталчилгааны зориулалтаар бий болсон санаачилга бөгөөд тийм ч учраас олон талт яриа хэлэлцээний “үр дүнд чиглэсэн” (result-oriented) механизм болж хараахан чадаагүй хэвээр байна.

Шалтгааныг нь тайлбарлахын тулд хэдэн угсраа асуултыг бид өөрсдөдөө тавих нь зүйтэй биз. Үүнд: Гадаад бодлогын “чухал зорилтоо” мөшгөж өөрийн “хувь нэмрийг” оруулах үүднээс санаачилгатай ажиллах гэдэг нь санал санаачилга дэвшүүлэхийг л хэлэх үү? Тодорхой санал дэвшүүлэхдээ шууд сонирхогч талуудынхаа байр суурийг хангалттай судалсан юм уу? Яагаад зарим тал нь одоо хүртэл ”бүрэн гүйцэд хүлээн зөвшөөрөөгүй”* байна вэ? “Улаанбаатарын яриа хэлцээ”-д оролцогчдын хүрээ, түвшин ямар вэ? Хэлэлцэх хэргийн хүрээ тодорхой юу? Гол “хэргийн эзэн” маань хэрхэн оролцож байна вэ? Энэ процессыг амьд байлгахад давтамж нь хангалттай юу? Ер нь 1.5 сувгийн чадамж юу вэ, ийм суваг ямар нэг хэмжээгээр л бий болсноор манай зорилтыг хангаж зөвтгөх үү? Эцэст нь уг процессыг цаад түншүүд чинь эдүгээ чухам юу гэж хэрэг дээрээ үзэж байгааг судалж тогтоосон уу? г.м.

Зөвхөн эдгээр асуултын хариуг гүнзгийрүүлэн судалж бэдрэх бус, санаандаа энгийнээр эрэлхийлэн эргэцүүлэхэд л учир шалтгаан нь ойлгогдож болох юм.

Манайхан “Улаанбаатарын яриа хэлцээ”-г санаачилж дэвшүүлснээ Монгол улсын гадаад бодлогын Ази, Номхон далайн чиглэлийн уламжлал, залгамж чанараар үе үе тайлбарладаг. Тухайлбал, 1980-аад оны эхээр дэвшүүлж байсан ”Ази, Номхон далайн орнуудын хооронд хүч үл хэрэглэх тухай конвенц” байгуулах санаачилга, хожим удаа дараа санан, сануулж байсан олон талт яриа хэлэлцээний механизм, “Азийн форум” буй болгох санал зэргээр жишээлдэг. Ийм санал, санаачилга, санаанууд нь тухай, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан бодит ажил хэрэг болж байсан нь үгүй. Харин энэ удаагийн санаачилгаа дэвшүүлэхдээ түүхэн сургамжаа хайхраагүйн дээр зөвхөн “улс төр-суртал нэвтрүүлгийн зорилготой”

хэмээн түншүүдээрээ үнэлүүлэхийн сөрөг дагаврыг тооцоолсонгүй юу даа” гэх асуулт зүй ёсоор урган гарч байна[56].

**Тулгамдсан асуудал, цаашдын хандлага.**

Монгол Улс, Умард Солонгосын харилцаанд оршиж буй гол тулгамдсан асуудал бол энэ улсын хэрэгжүүлж буй цөмийн зэвсэг бүтээх хөтөлбөрт манай орон хэрхэн хандаж буй явдал юм.

Àçè òèâä öºìèéí çýâñýã ýçýìøñýí óëñûí òîî íýãýýð íýìýãäñýí íü á¿ñ íóòãèéí áîëîí îëîí óëñûí òîãòâîðòîé áàéäëûã áýõæ¿¿ëýõ, öºìèéí çýâñãèéã á¿õ íèéòýýð á¿ðýí õîðèãëîõ, ¿ë äýëãýð¿¿ëýõýä ÷èãëýñýí äýëõèé íèéòèéí õ¿ñýë ýðìýëçýëä òîìîîõîí öîõèëò áîëñíû çýðýãöýý çàðèì îðíóóäûí ç¿ãýýñ öºìèéí çýâñãýýð õººöºëäºõ ñàíààðõàëûã ººãø¿¿ëñýí ñºðºã ¿ð äàãàâàðûã àãóóëñàí ¿éë ÿâààë áîëîîî ãýæ áèä ¿çäýã.

Монгол Óлс Солонгосын хойгийн асуудлыг тойрсон үйл явцыг анхааралтай ажиглаж, цөмийн õÿìðàëûí асуудлыг эв зүйгээр яриа хэлэлцээний замаар шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлэх чиг шугам баримталж ирлээ.

ÇÕÀ-èéí á¿ñ íóòãèéí ýíõ òàéâàí, àþóëã¿é áàéäëûã áàòàòãààí áýõæ¿¿ëýõýä Ñîëîíãîñûí õîéãèéí òîãòâîðòîé áàéäëûã õàíãàõ ÿâààë íýí ÷óõàë ãýäãèéã ýðõýìëýí Ìîíãîë Óëñ á¿ñ íóòãèéí óëñ îðíóóäûí íýãýí àäèë Ñîëîíãîñûí õîéã öºìèéí çýâñãýýñ àíãèä áàéõ ¸ñòîé ãýæ ¿çäýã. Ìîíãîë Óëñ Óìàðä Ñîëîíãîñûí öºìèéí õºòºëáºðèéí àñóóäëûã çóðãààí òàëò õýëýëöýýíèé õ¿ðýýíä øèéäâýðëýõ, ÁÍÀÑÀÓ-ûã àëü áîëîõ îëîí òàëò ÿðèà õýëöýý, õàìòûí àæèëëàãààíä “òàòàí îðîëöóóëàõ”, ãàíöààðäóóëàõã¿é áàéõ áîäëîãî áàðèìòàëæ áàéíà.

Манай талаас Хойд Солонгостой òîãòîîñîí харилцаа холбоогоо идэвхжүүлж, улс төрийн түвшин дэх яриа хэлэлцээг тогтмолжуулах чиглэл баримтлахдаа энэ орны цөмийн зэвсгийн хөтөлбөрийн асуудлыг тусад нь авч үзэж буй нь дээр дурдсан бодлогын илрэл юм. Харилцааны эдийн засгийн агуулгыг өргөжүүлж, дэд бүтэц, хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагааг тодорхой төслийн хэлбэрт оруулан хөгжүүлэх, түүндээ гуравдагч улс орныг татан оролцуулах чиглэл баримтлах нь илүү үр дүнтэй болно гэж үзэж байна.

---

[56] Н.Доржсүрэн. МУ хэрхэн ЗХА-ийн уламжлалт аюулгүй байдлын хамтын ажиллагааны нэг хэсэг болох вэ. Стратегийн судалгаа №71 (3/2015)

Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангижруулах асуудлыг шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах зорилгоор Монгол улс хэд хэдэн саналыг гаргасан юм. Тухайлбал, хэдийгээр Монгол улс Зургаан талт хэлэлцээрт оролцдоггүй ч, уг хэлэлцээрийн хүрээнд Умард Солонгос, Япон улсын хоёр талт уулзалтыг хэд хэдэн удаа Улаанбаатар хотод зохион байгуулсан бөгөөд цаашид ч мөн аюулгүй байдал болон энх тайвны төлөөх уулзалтуудыг зохион байгуулах хүсэлтээ илэрхийлсээр байна.

Хоёр Солонгостой сайн харилцааг хөгжүүлж ирсний хувьд Монгол улс Солонгосын хойгийн цөмийн аюулгүй байдлын асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах бодлого, үйл ажиллагаагаа цаашид ч үргэлжлүүлэх нь тодорхой юм. Монгол улсын ОХУ, БНХАУ-тай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийн аюулгүй байдалтай холбогдол бүхий зүйл, заалтуудтай төсөөтэй асуудлуудыг мөн Умард Солонгостой байгуулсан гэрээ, хэлэлцээрүүддээ тусгасан байдаг. Эдгээртээ тулгуурлан бүс нутгийн аюулгүй байдлын асуудалд Монгол улс зуучлагчаар оролцож байсан удаатай юм.

Ìîíãîë Óëñûí Åðºíõèéëºã÷ Ìîíãîë Óëñûí Åðºíõèé ñàéä, íàð ÁÍÑÓ, ÁÍÀÑÀÓ -ä àéë÷ëàõäàà ýäãýýð óëñûí óäèðäëàãàòàé óóëçàæ, öºìèéí õºòºëáºðèéí àñóóäëûã ýâ ç¿éãýýð çîõèöóóëàõûí à÷ õîëáîãäëûã öîõîí òýìäýãëýõèéí ñàöóó ìàíàé óëñ Ñîëîíãîñûí õîéãèéí òîãòâîðòîé áàéäëûã áýõæ¿¿ëæ, á¿ñ íóòãèéí õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõèéí òºëºº áàéãààãàà байнга илэрхийлсээр байгаа áèëýý.

Хойд Солонгосын цөмийн хөтөлбөрийн асуудлыг шийдвэрлэх үндсэн механизм нь Зургаан талт уулзалт гэж олон улсад үзсээр байгаа. Ýíý ÿðèà õýëýëöýý цаашид Ìîíãîëûí Çàñãèéí ãàçðààñ ñàíàë áîëãîî Í¯Á-ûí èíäýðýýñ äýâø¿¿ëñýí Зүүн хойд Азийн аюулгүй байдлын яриа хэлэлцээний механизм хэлбэрээр хөгжих бололцоо ч гарч болох юм.

Ìîíãîë Óëñ Ñîëîíãîñûí õîéãèéí öºìèéí çýâñãèéí àñóóäëààðõè 6 òàëò ÿðèà õýëýëöýýã ýõíýýñ íü äýìæèæ èðñýí. Ìîíãîë Óëñ õýäèéãýýð çóðãààí òàëò ÿðèà õýëýëöýýíä îðîëöäîãã¿é ÷ á¿ñ íóòãèéí óëñ îðíóóäòàé, ò¿¿íèé äîòîð õî¸ð Ñîëîíãîñòîé õî¸óëàíòàé íü íàéðñàã õàðèëöààòàé, ìºí ÁÍÀÑÀÓ-ûí íýãýí àäèë áàãà îðîí áîëîõûí õóâüä öºìèéí õºòºëáºðèéí àñóóäëûã çîõèöóóëàõ ¿éë ÿâöàä áîëîìæèéí õýðýýð õóâü íýìýð îðóóëàõ ýðìýëçýëòýé áàéäàã.

Солонгосын хойгийн цөмийн хөтөлбөрийн асуудлаарх 6 талт хэлэлцээний ажлын хэсгийн зарим хуралдааныг өөрийн орондоо зохион байгуулах саналыг Монгол Улс байнга дэвшүүлж байгаа бөгөөд манай саналын дагуу Япон, БНАСАУ-ын харилцааг хэвийн болгох хэсгийн анхны óóëçàëò 2007 оны 9 дүгээр сард Улаанбаатарт болсон тухай өмнө өгүүлсэн. Õóäèéãýýð ýíý óóëçàëò òîãîðõîé ¿ð ä¿íä õ¿ðýýã¿é ÷ ãýñýí ìîíãîëûí îðîëöîîòîé ÿðèà õýëýëöýýíèé ýõëýë тавигдсан нь ихээхэн à÷ холбогдолтой зүйл болсон юм. Үүнтэй ижил төсөөтэй арга хэмжээнүүдийг цаашид ч хүлээн авч хийхэд манай тал бэлэн гэдгийг 6 талт хэлэлцээнд оролцогч талуудад мэдэгдээд байгаа.

Хэдийгээр с¿¿ëèéí ¿åä Ñîëîíãîñûí õîéãèéí öºìèéí õÿìðàëûã çîõèöóóëàõ ¿éë ÿâöàä зарим нэг ахиц гарч, АНУ-ын болон БНСАУ-ын ерөнхийлөгч нар нүүр тулан уулзаж, хоёр Солонгосын удирдагчид зарим нааштай тохиролцоонд хүрсэн боловч ихээхэн саад, бэрхшээл хадгалагдсаар, яриа õýëýëöýýíä îðîëöîã÷ ñºðºã òàëóóäûí áàéð ñóóðü хатуу хэвээрээ байгаад Ìîíãîë Óëñ санаа зовсоор байгаа юм. Ингэхдээ Умард Солонгосын удаа дараагийн цөмийн туршилт, пуужингийн хөөргөлт болон АНУ, Өмнөд Солонгосын байнгын хамтарсан цэргийн сургуулиуд дахин сэргэж болзошгүй магадлал хадгалагдсаар байгааг бид бас мэдэрсээр байна.

**Умард Солонгостой харилцахад тусгайлан анхаарах зарим асуудал.** Өнөөдөр Умард Солонгосын эсрэг авсан НҮБ-ын хориг арга хэмжээтэй холбогдуулан НҮБ-ын гишүүн орнууд тус улсад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, мөн мөнгөн гүйлгээ хийхээс татгалзах үүрэгтэй. Хамгийн сүүлийн жишээ гэхэд Умард Солонгосын гадаад худалдааны банкны бүх дансыг Хятад улс хааж, санхүүгийн гүйлгээг нь зогсоосон. Иймээс өөрийн үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй хүчин зүйл гэдгийн үүднээс Солонгосын хойгийн асуудалд хандах болон Умард Солонгостой харилцахдаа дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй байж болох юм. Үүнд:

Нэгд, Умард Солонгос өнөөдөр хүнд байдлаас гарах бүхий л байдлыг эрэлхийлж байна. Ялангуяа, тус улсаас Иран улсад цөмийн болон пуужингийн технологио цаашид ч экспортолж болзошгүй гэсэн таамаглалыг шинжээчид дэвшүүлээд байна. Тухайлбал, АНУ-ын Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх болон аюулгүй байдлын хорооны нарийн бичгийн даргын хэлснээр “Умард Солонгос, Иран хоёр цөмийн зэвсэг үйлдвэрлэхэд шаардлагатай технологи болон эд ангийг

нийлүүлэх гарцыг аль хэдийнээ бий болгосон" гэжээ. Тиймээс Умард Солонгос цаашид "Зөв алхам" хийнэ хэмээн найдахад эрт байна.

Хоёрт, Монгол улс, БНАСАУ-ын дипломат болон батлан хамгаалах салбар дахь хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа нь олон улсын тавцан дахь Монгол Улсын нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Ялангуяа, энэ салбар дахь хоёр талын хамтын ажиллагаанд цаашид болгоомжтой хандах нь зүйтэй. Учир нь хоёр талын батлан хамгаалах салбарынхны айлчлалын давтамж сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь олон улсын нийгэмлэгийн зүгээс Умард Солонгосын дэглэмийг "дэмжигч улс" гэсэн нэрийг бүрдүүлж болзошгүй юм. Нөгөөтээгүүр, тус улстай харилцах нэг том хөшүүргээ алдаж болзошгүй тул Монгол Улс БНАСАУ-тай батлан хамгаалах салбарын харилцааг бүр мөсөн үгүй хийж бас болохгүй юм.

Гуравт, Монгол улсад ажиллаж буй Умард Солонгосын ажилчдын мөнгөний эргэлтийг ил тод болгож, хяналтыг сайжруулах шаардлагатай юм. Өнөөдрийн байдлаар манай улсын барилга, хөнгөн үйлдвэр, дэд бүтцийн салбарт Умард Солонгосын олон зуун иргэн ажилласаар байгаа бөгөөд энэ тоо цаашид өсөж болох юм. Тэдний цалингийн ихэнх хувь засгийн газартаа очдог. Иймээс тэдний мөнгөний урсгалыг ил тод байлгах талаар Умард Солонгосын талтай ярилцах нь зүйтэй юм.

Дөрөвт, Умард Солонгосын зүгээс хуурамч мөнгө Монгол Улсын хилээр оруулж ирж болзошгүй байдал бодитой байгаа юм. Жишээлбэл, 2001 онд 100 долларын хуурамч мөнгөн дэвсгэртийг Монгол Улсын хилээр оруулахыг завдсан хэрэг гарч байсан түүхтэй. Ийм зүйл дахин тохиолдож болзошгүй тул Умард Солонгосын зүгээс мөнгө угаах, хуурамч мөнгөн дэвсгэрт оруулж ирэх эрсдэлийг тооцож байх нь зүйтэй.

Эцэст нь нэг зүйлийг тэмдэглэхэд, Монгол Улс хоёр Солонгосын хооронд болон бусад холбогдох улс орны хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэх боломжтой эсэх тухай асуудлаар судлаачид өөр хоорондоо ялгаатай байр суурийг илэрхийлэх нь байдаг. Удаа дараа явуулсан судалгааны явцад энэ нь тодорхой хэмжээгээр бололцоотой болох нь олон зүйл дээрээс харагдсан болно. Учир нь Солонгосын хойгт үүсээд буй өнөөгийн нөхцөл байдлаас, гол нь 6 талт хэлэлцээ үндсэндээ мухардалд орсонтой холбоотойгоор Умард, Хойд Солонгосын аль аль нь өөр

хоорондынхоо дипломат яриа хэлэлцээнд илүү “ажил хэрэгч” идэвхтэй хандахыг оролдох, ингэхдээ дээрх хэлэлцээнээс өөр бусад арга замыг эрж хайх, түүний дотор 6 талт хэлэлцээрийн бус улс оронтой түлхүү харилцахыг эрмэлзэх байдал сүүлийн үед ажиглагдах болоод байгаа юм.

Ийм учраас Монгол Улс цаашид Зүүн Хойд Азид энх тайван, аюулгүй байдал, хамтын ажиллагааны механизмыг бүрдүүлэх чиглэлд идэвхтэй оролцох хүрээнд Солонгосын хойгийн асуудлыг энх тайвны аргаар шийдвэрлэхэд дөхөм үзүүлэх зорилго бүхий, сөргөлдөөнд оролцож буй бүх талд зөвөөр ойлгогдох, өөрийн гэсэн тусгайлсан бодлого, хөтөлбөр боловсруулах нь зөв байж болох юм.

### 3.1.5. Цөмийн аюулаас ангид байх бодлого

**Мөн чанар, учир шалтгаан.**

Монгол Улсын гадаад аюулгүй байдлыг хангах чиглэлээр 1990-ээд оны эхнээс авч эхэлсэн дорвитой арга хэмжээний нэг нь тус улсыг цөмийн аюулаас хамгаалах, ийм төрлийн зэвсгээс ангид статустай /цаашид ЦЗАС гэх/ болгож, баталгаажуулах явдал байсан юм.

Манай улсын хувьд ч, олон улсын аюулгүй байдлын онол, практикийн хувьд ч цоо шинэ, өвөрмөц шийдэл дэвшүүлж, жишиг үзүүлсэн энэхүү олон талт, уйгагүй үйл ажиллагааны 20 гаруй жилийн түүхийг түүний гол санаачлагч, доктор Ж.Энхсайхан 2015 онд нийтлүүлсэн “Монголын цөмийн ирээдүй” хэмээх номдоо болон бусад бүтээлдээ дэлгэрэнгүй мөшгөн харуулсан байна[57].

Уг санаачилга нь 80-90-ээд оны зааг дээр, нэг талаас олон улсын харилцааны нөхцөл байдал эрс өөрчлөгдөж, нөгөө талаас Монгол Улсын гадаад бодлогоо цоо шинээр томьёолон явуулах болсонтой шууд холбоотой юм. Манай улс цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд оршдог жижиг улсын хувьд аюулгүй байдлаа юуны өмнө улс төр-дипломатын аргаар хамгаалах учиртай бөгөөд дэлхийн бодлогыг тодорхойлогч, цөмийн гүрнүүдийн аль алинтай нь тэнцвэртэй харилцаж, тэдний маргаан зөрчилд оролцохгүй, нутаг дэвсгэрээ хэн нэгний нь

[57] Урианхан Ж.Энхсайхан., Монголын цөмийн ирээдүй... УБ, 2015
Др.Ж.Энхсайхан.,МУ-ын цөмийн зэвсгээс ангид статусын баталгаажуулалт, түүний олон улсын ач холбогдол. Монгол Улсын ҮАБ-ын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ, 2014
Enkhsaikhan J., Establishing a NEA-NWFZ: an idea whose time has come? UB dialogue on NEA Security. International conference. UB, September 2014

эсрэг ашиглуулахгүй байх замаар өөрийн гэсэн "цөмийн шүхэртэй" болох эцсийн зорилгыг эхнээсээ агуулсан гэж үзэж болно. Монголын шинэ гадаад бодлогыг тодорхойлсон анхны баримт бичиг буюу 1990 оны 8 дугаар сарын 14-ны Ардын Их хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор батлагдсан "БНМАУ-ын гадаад бодлогын ойрын үеийн чиг баримтлалд" өөрийн "аюулгүй байдлын... олон улсын баталгаа бий болгох, цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх, гадаадын цэрэг зэвсгийг нутаг дэвсгэртээ үл байрлуулах, нутаг дэвсгэр, хий мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх ... цөмийн болон үй олноор хөнөөх бусад зэвсгээс ангид байлгах чиг шугам баримтлахыг" заасан нь бодлогыг тодорхойлж хожмын статусын зарим зүйлийг агуулсан байдаг.

Монгол Улсын гадаад орчны өөрчлөлт,цаашдын төлөв, ялангуяа цөмийн эрин үеийн шаардлага, сорилтыг үнэлэх үндсэн дээр томьёолсон дээрх заалтын дагуу анх 1992 оны 9 дүгээр сард МУ-ын Ерөнхийлөгч НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганы индэр дээрээс Монгол Улсын нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс болгохоо зарлаж, түүнийгээ олон улсын хэмжээнд баталгаажуулахаа мэдэгдсэн билээ. Тэр цагаас хойш уг зорилгоор авч хэрэгжүүлсэн алхам, хүрсэн үр дүнг дараах хэдэн үндсэн үед хуваан авч үзэж болмоор байна. Үүнд:

- 1992-1998 онууд. Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх бодлогыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх үе.

- 1999-2012 онууд. Цөмийн зэвсгээс ангид статусаа улс төрийн хувьд баталгаажуулсан үе.

- 2012-оос хойш. Олон улсын эрх зүйн хувьд баталгаажуулах үе.

Нэг. Монгол улс дангаараа цөмийн зэвсэггүй "бүс" болох санаачилга анхнаасаа ихээхэн бэрхшээлтэй тулгарах нь тодорхой байсан юм. Нэг талаар, цөмийн зэвсэг бүхий их гүрнүүд, өөрөөр хэлбэл НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын гишүүн буюу Их 5 цөмийн зэвсгийн бүхий л асуудлаарх монополь эрхээ хадгалахын төлөө хүчтэй тэмцэж байсан үе. Их 5-ын ил, далд дэмжлэг, зөвшөөрөлгүйгээр цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэхтэй холбогдох ямар ч асуудал урагшилдаггүй байв. Нөгөөтээгүүр, практик дээр цөмийн зэвсэггүй хэд хэдэн бүс бий болоод байсан боловч "бүс" гэж газар нутгийн хувьд хил залгаа бүлэг улсыг ойлгодог байсан нь дийлэнх улсууд уг санаачилгыг эхний үед улс төр, суртал нэвтрүүлгийн алхам мэт үзэж, "сонирхохгүй" байсан гэж болох юм.

Гэвч монголын тал давшингүй хэр нь уян хатан байр суурь баримталж, тууштай ажилласны үр дүнд санаачилгаа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлж чадсан байна. Үүнийг ГХЯ-ны архивын материалууд, судлаачдын нэжгээд бүтээлээс тодорхой харж болно. Эдгээрээс мөшгөн үзвэл монголын тал:

а/ юуны өмнө Их 5-ын дэмжлэгийг авах (саналаа хүргэх, ойлгуулах, улмаар хүлээн зөвшөөрүүлэх зэрэг угсарсан арга хэмжээ авах замаар);

б/ үүнтэй зэрэгцүүлэн олон улсын илүү өргөн хүрээний дэмжлэг авах (хоёр болон олон талын шугамаар ) зорилгоор аль болох боломжийг ашиглан ажиллажээ.

1993 онд ОХУ-тай, 1994 онд БНХАУ-тай тус тус найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулахаас эхлээд /Монгол-Оросын гэрээний 4 дүгээр зүйлд: “ Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг ОХУ хүндэтгэнэ.” Монгол-Хятадын гэрээний мөн 4 дүгээр зүйлд :”Хэлэлцэн тохирогч талууд бие биеийн... аюулгүй байдалд хохирол учруулах ямар нэгэн гэрээ, хэлэлцээрийг гуравдагч оронтой байгуулахгүй, аль ч тал нөгөө талын... аюулгүй байдлыг хохироохоор өөрийн нутаг дэвсгэрийг гуравдагч улсад ашиглуулахгүй”- гэсэн байдаг. /

1995 оны NPT-г хянах олон улсын бага хуралд бэлтгэх хүрээнд АНУ,Англи, Францаар нааштай мэдэгдэл гаргуулах, 1995 болон 1998 онд Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний дээд хэмжээний бага хурлаар дэмжүүлэх, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хүрээнд Их 5-ын хамтарсан мэдэгдэл гаргуулахаар хөөцөлдөн, тэдэнтэй хамт нэг ширээнд сууж хэлэлцдэг болж, Зэвсэг хураах комиссоор асуудлыг хэлэлцүүлэхээр тэмцэлдэн, Европын холбооны зуучлалыг хүртэн “бүсээ” “статус” болгож, эцэст нь 1998 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаар 53/77 D тоот тогтоол гаргуулах хүртэл адармаатай агаад амаргүй таван жилийг туулсан байна.

“Монгол Улсын олон улсын аюулгүй байдал, цөмийн зэвсэггүй статус” гэсэн гарчиг бүхий энэхүү тогтоол “Монгол Улс цөмийн зэвсэггүй байх статусаа тунхаглан зарласныг сайшаан хүлээн авч байна” хэмээн заасан нь дэлхийн хамт олон, түүний дотор цөмийн зэвсэгтэй их гүрнүүд манай энэ статусыг бүрэн хүлээн

зөвшөөрч , аюулгүй байдлыг хангах, тухайлбал цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийн хэрэгжилтэд шинэ “үзэгдэл” буй болсны бодит нотолгоо болсон юм.

Доктор Ж.Энхсайхан Монгол Улс ЦЗАС-тай болсны ач холбогдлыг дараах 6 үзүүлэлтээр тайлбарласан байдаг. Үүнд:

1/ Манай ЦЗАС нь нэгэнт олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тул цөмийн зэвсэгтэй улсууд, юуны өмнө Их 5 цөмийн зэвсгээ Монгол руу онилох учиргүй/ёсгүй гэсэн үг.

2/НҮБ-ын Ерөнхий ассамблей 1998 онд гаргасан тогтоолоороо манай ЦЗАС-ыг бэхжүүлэх талаар цаашид ч хамтран ажиллахыг бүх гишүүн орнуудад уриалсан.

3/Уг тогтоол нь манай аюулгүй байдлын асуудалд зөвхөн цөмийн аюулын өнцгөөс хандаагүй, илүү өргөн, аль болох иж бүрэн утгаар авч үзсэн. Тухайлбал, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эдийн засаг, экологийн аюулгүй байдал, бие даасан гадаад бодлогоо бататган бэхжүүлэх талаар арга хэмжээ авахад нь Монгол Улстай хамтран ажиллахыг гишүүн орнууд, НҮБ-ын холбогдох байгууллага, нэгжүүдэд хандан уриалсан.

4/Манай улсын гадаад аюулгүй байдлын асуудлыг Ерөнхий ассамблейн хэлэлцэх хэргийн төлөвлөгөөндөө байнга байлгаж, Ерөнхий нарийн бичгийн даргын илтгэлийг тогтмол хэлэлцэж байх үүд хаалга нээгдсэн.

5/Цөмийн зэвсгээс ангид байх бодлогоо тууштай явуулж байх нь “зөөлөн хүчний” бодлогын нэг чухал илэрхийлэл болж, тус улсын нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн.

6/Дангаараа ЦЗАС-тай болсон анхны улс болж, бусдад үлгэр жишээ үзүүлсэн байна.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоол нь улс төр-ёс суртахууны шинж чанартай, олон улсын эрх зүйн хувьд заавал биелүүлэх хэм хэмжээ болдоггүй тул ЦЗАС-аа эрх зүйн хувьд баталгаажуулах явдал гол зорилт болон хэвээр үлдсэн юм.

Хоёр. XX зуун дуусаж шинэ мянган эхлэх үе нь улс бүхэн дэлхий дахины байдлыг цэгнэн өөр өөрсдийн бодлогыг тодотгох үе байсан гэж болно. Манай улсын хувьд ч мөн ийм зорилт тулгарсан бөгөөд энэ хүрээнд ЦЗАС-аа олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэх явцад гарсан ахиц, хуримтлагдсан туршлага, ойрын төлөв байдлыг дүгнэх үндсэн дээр өөрийн, үндэсний хэмжээнд хуульчлах шаардлага гарсан байдаг. Энэхүү шаардлагыг 2000 оны 2 дугаар сард УИХ-аар хэлэлцэн баталсан "Цөмийн зэвсгээс ангид байх тухай" хууль, хууль гарсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 19 дүгээр тогтоол хангасан юм.

Уг хуульд "цөмийн зэвсэггүй статус гэж цөмийн зэвсгээс ангид байх эрх зүйн байдлыг", "цөмийн зэвсэг гэж цөмийн хянагдашгүй эрчим хүч гаргаж дайны зориулалтаар ашиглаж болох цөмийн аливаа төрлийн тэсрэх төхөөрөмжийг" тус тус ойлгоно гээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улсад хориглох үйлдлүүдийг нарийвчилж статусын негатив агуулгыг тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх буюу бусад аргаар олж авах, эзэмших, хяналтдаа байлгах,
2. Цөмийн зэвсгийг байрлуулах буюу аливаа хэрэгслээр тээвэрлэх,
3. Цөмийн зэвсгийг турших буюу хэрэглэх,
4. Цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устгах,
5. Цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн цөмийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон бусад эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно гэжээ.

Үүний зэрэгцээ цөмийн эрчим хүч, технологийг "гагцхүү энхийн зорилгоор" ашиглах, энэ хуулийг олон улсын эрх зүйн хэм хэмжээ, хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэхийг зааж, хэрэгжилтэд хяналт тавих дотоод, гадаадын этгээд, тэдний эрх үүрэг, зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага зэргийг тодорхой тусгасан байна.

ЦЗАС-ын тухай хууль гарснаар уг асуудлыг олон талаас нь харж холбогдох хэм хэмжээг кодчилох зүтгэлийн тодорхой үр дүн болсон гэж үзэж болно. Энэ

хууль дараах хэдэн зорилгыг биелүүлсэн гэж доктор Ж.Энхсайхан мөн дүгнэжээ. Үүнд:

1/ манай улс цаашид ямар ч нөхцөлд нутагтаа цөмийн зэвсэг байрлуулахыг зөвшөөрөхгүйгээ хуульчилсан,

2/ зэвсэг хураах, түүний дотор цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх дэглэмийг бэхжүүлэх үйлсэнд хувь нэмэр оруулахын төлөө хүч чармайлтаа олон улсын хэмжээнд үнэлүүлэх,

3/ цаашид ЦЗАС-ыг урагшлуулах, олон улсын баталгаа олж авах талаар яриа хэлэлцээ хийхэд чухал хүчин зүйл, “хөшүүрэг” болсон байна.

Олон улсын баталгаа, тухайлбал Их 5-аар баталгаа гаргуулах яриа хэлэлцээ 1999 оны 10 дугаар сард ОХУ энэ чиглэлээр ажиллахад бэлэн байгаагаа мэдэгдсэнээр эрчимжсэн аж. Энэ үндсэн дээр монголын тал баталгаанд тусгаж болох заалтуудын талаар саналаа боловсруулж “Монголын гадаад аюулгүй байдлын асуудлаар гаргах баримт бичигт тусгаж болох үндсэн санаа” хэмээх баримт бичиг боловсруулан Их 5-д уламжилжээ. Энэ ганц хуудас саналд 53/77 D тогтоолын гол заалтуудыг гэрээний хэлбэрт оруулах, МУ статусаа болон гадаад аюулгүй байдлаа бэхжүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, шаардлагатай бол эдгээр асуудлаар зөвлөлдөж байхаар заасан байв.

АНУ болон түүний холбоотнууд монголын тал статусаа олон улсын гэрээгээр баталгаажуулах нь эрсдэлтэй “үлгэр жишээ” үүсгэнэ гэж үзсэн хэвээр тул хүлээн авах боломжгүйгээ мэдэгдээд, харин Их 5 хамтарсан мэдэгдэл гаргах болсноо мэдэгджээ. Үүний дагуу 2000 оны 10 дугаар сарын 5-ны өдөр Их 5-ын гаргасан хамтарсан мэдэгдэлд манай статусыг баталгаажуулахад чиглэсэн хэд хэдэн чухал заалт орсон байна. Үүнд, Их 5 Ерөнхий ассамблейн 53/77 D-г хэрэгжүүлэх шийдвэр төгс байгаагаа нотлохын зэрэгцээ Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх гэрээнд нэгдэж орсон цөмийн зэвсэггүй улсуудын эсрэг цөмийн зэвсэг хэрэглэхгүй, чингэхээр далайлгахгүй, цөмийн аливаа түрэмгийлэлд өртөх, тийм зэвсэг хэрэглэх заналхийлэлд өртвөл ...тусламж үзүүлэх арга хэмжээ нэн даруй авч хэрэгжүүлэх шийдвэр төгс байна гэж 1995 онд хийсэн тэдний амлалт Монгол Улсад хамаарна гэж мэдэгджээ. Орос, Хятад хоёр энэ асуудлаар Монгол Улсын өмнө хүлээсэн үүргээ нотолж байгаагаа мөн мэдэгдэв.

Их 5-ын мэдэгдэл мөн л манай талын зорилгод бүрэн нийцээгүй боловч түүнд хүрэх чиглэлээр хийсэн бас нэгэн тодорхой алхам болсон юм. Тийм ч учраас манай тал статусаа олон улсын эрх зүйн хувьд баталгаажуулах хүчин чармайлтаа тууштай үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Статусаа баталгаажуулахын төлөө Их 5-тай хийж буй яриа хэлцээ 2001 оноос хойш нэг сэргэж, нэг мухардаж явсаар эдүгээг хүрээд байна.

**Тулгамдсан асуудал, цаашдын хандлага.**

Улс орныхоо аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах нь Монгол Улсын гадаад бодлогын гол зорилт билээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улс 1992 онд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, үүнийгээ үндэсний хэмжээнд болон олон улсын эрх зүйн гэрээ хэлэлцээрээр баталгаажуулах талаар олон арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн өмнө тодорхой өгүүлсэн.

1992 онд Монгол Улсын анхны Ерөнхийлөгч П.Очирбат НҮБ-ын индэр дээрээс "Монгол улсын нутаг дэвсгэрийг цөмийн зэвсэггүй бүс болгоно" хэмээн албан ёсоор зарлан тунхагласнаас хойш 26 жил өнгөрлөө. Энэ хугацаанд нэг улс дангаараа цөмийн зэвсэггүй бүс байгуулж болох тухай дэвшүүлсэн манай энэ санаачилгыг дэлхийн олон улс орон, түүний дотор НҮБ болон цөмийн зэвсэг бүхий их гүрнүүд ойлгон хүлээн авч дэмжсэний зэрэгцээ цөмийн зэвсэггүй дэлхий бий болгохын төлөө олон улсын чармайлтад бидний оруулж буй бодитой хувь нэмэр гэж үнэлсэн болно. Гэхдээ энд бас зарим нэг тулгамдсан асуудал байгаа юм

Зүүн хойд Азид хамаарах манай хоёр их хөрш БНХАУ болон ОХУ цөмийн зэвсэгтэй их гүрнүүд билээ. Дэлхийн цөмийн зэвсэг бүхий өөр нэг хүчирхэг гүрэн АНУ-ын хүчтэй нөлөө энэ бүс нутагт хадгалагдсаар байна. Япон улс нь цөмийн довтолгоонд өртөж байсан дэлхийн цорын ганц улс бөгөөд цөмийн зэвсгээс ангид байх 3 зарчмыгягштал мөрддөг гэдгээрээ бусад орноос ихээхэн ялгардаг. Гэвч Японы газар нутаг дээр АНУ-ын цохилтын хүчний том бүлэглэл байрласаар байгаа бөгөөд Хүйтэн дайны үед түүний газар нутаг дээр цөмийн зэвсэг нууцаар байрлаж байсан тухай албан ёсны мэдээ тархсан нь энэ орны байр суурьд нэлээд хянамгай хандах үндэслэлийг бий болгосон юм. Өмнөд Солонгос нь АНУ-ын цэргийн оролцооны хувьд Япontой төсөөтэй нөхцөл байдалд байгаа нь тодорхой юм.

Монгол улсын тухайд бол Зүүн Хойд Азид өөрийгөө цөмийн зэвсэггүй бүс гэж зарласан цорын ганц орон болоод байна.

Зүүн хойд Азид заналхийлж буй цөмийн аюулын гол голомт нь 20 гаруй жил үргэлжилж байгаа Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр, түүнээс үүдэн гарч буй бүс нутгийн улс орнуудын хооронд бий болсон хямралт байдал болж байна.

Бүс нутгийн орнууд АНУ-ын оролцоотойгоор 6 талт хэлэлцээрийн замаар Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэх, улс төр, эдийн засгийн салбарт ойртон нягтрах, түүний дотор хамтын аюулгүй байдлын нийтлэг зүйлийг бий болгохыг чармайж байгаа боловч одоогоор төдийлөн үр дүнд хүрээгүй байна. Сүүлийн жилүүдэд уг хэлэлцээр мухардмал байдалд орж Хойд Солонгос цөмийн туршилт хийж эхэлсэн. Үүнээс үүдэн Өмнөд Солонгос, Япон улсууд АНУ-тай хамтран Хойд Солонгосын тэрхүү бодлогын эсрэг хариу арга хэмжээ авах, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутагт пуужингийн довтолгооноос хамгаалах систем байгуулах, тэр ч байтугай эдгээр орнууд цөмийн зэвсэгтэй болох талаар алхам хийж магадгүй гэсэн таамаглал дэлгэрэх болсон нь энэ бүс нутагт цөмийн зэвсгээр хөөцөлдөх явдал газар авч улмаар харилцан үл итгэх уур амьсгал буй болж болзошгүй байна.

Ер нь Япон, Хойд Солонгосын цөмийн технологийн чадамж их бөгөөд яах ч аргагүй нөхцөл байдал үүсвэл цөмийн зэвсгийг богино хугацаанд бүтээн хийх бодитой бололцоотой орнууд гэж олон улсын шинжээчид үздэг болно.

Хойд Солонгосын цөмийн зэвсгийн хөтөлбөрийн асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн тохиолдолд бүс нутгийн хэмжээнд зэвсгийг хорогдуулан хураах асуудлыг хэлэлцэх таатай нөхцөл бүрдэх, мөн Япон, Монгол, хоёр Солонгос улсын оролцоо бүхий Зүүн хойд Азийн цөмийн зэвсгээс ангид бүс байгуулах таатай нөхцөл болох талтай юм гэж бид үзэж байна.

Монголын судлаачид бүс нутагт зэвсэглэлээр хөөцөлдөх явдлыг эцэс болгох, одоогоор цөмийн зэвсэггүй байгаа улс орнуудыг цөмийн зэвсгээс ангид байлгах, цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах талаар эрдэмтэн судлаачдын санаачилгыг бүх улс орнууд дэмжих хэрэгтэй гэсэн байр суурийг байнга илэрхийлж байдаг юм.

Дэлхийн хоёр туйлт тогтолцооны зөрчил болон хуучин ЗХУ, Хятадын хооронд үүсэж болзошгүй байсан цөмийн дайнд татагдан орж гай түйтгэрийн гашуун зовлон амсаж мэдэхээр байсан тэр үе нэгэнт түүх болон үлджээ. Гэвч ингэснээр Монгол Улсын цөмийн аюулгүй байдал найдвартай хангагдаж, бидний газар нутаг, хүн ард цөмийн аюулын хөлд хэзээ ч нэрвэгдэхгүй боллоо гэсэн төгс баталгаа бас бүрэн дүүрэн бий болоогүй байна.

Ази, Номхон далайн бүс нутагт олон улсын харилцааны шинж чанар эрс өөрчлөгдсөн ч аюулгүй байдлын хамтын тогтолцоо бүрэлдэн бий болоогүй, янз бүрийн үүдэлтэй зөрчил, сөргөлдөөн үргэлжилсээр, байгаа нөхцөлд цөмийн аюулгүй байдлаа хангах бие даасан бодлого, үйл ажиллагаа явуулах тийм шаардлага тулгарсан, туйлын хариуцлагатай цаг үед бид амьдарч байна.

Улсын аюулгүй байдалд цэргийн хүчээр гаднаас шууд нөлөөлөх заналхийлэл учраагүй цоо шинэ нөхцөл байдал үүссэн нь нэг талаас тайвширч болох мэт сэтгэгдэл төрүүлэх боловч, нөгөө талаас сэтгэл амрах орчин бүрдээгүй, харин ч шинэ түгшүүрүүд бий болох нэг үндэс болж байна. Эдгээрийн нэг нь Зүүн хойд Азид цөмийн зэвсгийн аюул урьдын адил оршсоор байгаа явдал юм. Энд том гүрнүүд цөмийн хөтөлбөрөө үргэлжлүүлсээр, зарим нь цөмийн зэвсэг хэрэглэсэн дайн байж болохыг цэргийн номлолдоо илээр тусгах боллоо. Түүнчлэн Солонгосын хойгийн цөмийн зэвсгийн асуудал эцэслэн шийдвэрлэгдээгүй байгаа нь түгшүүрийн нэг голомт болсоор байна.

Хэрэв Ази, Номхон далайн бүс нутагт, түүний дотор Зүүн хойд Азид цөмийн зэвсгээр хөөцөлдөх асуудал газар авах юм бол далайд гарцгүй Монгол Улс үүнд ямар нэг хэмжээгээр татагдан орж болзошгүй тул түүнээс сэргийлэх бодлого явуулах хэрэгтэй нь хэн бүхэнд ойлгомжтой асуудал юм.

Ийм учраас газар нутгийн байршил, геополитикийн нөхцөл байдлаас үүдэн Монгол улс цөмийн асуудалд маш нухацтай хандаж ирсэн бөгөөд цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээ болон бусад бичиг баримтыг батлах үеэс эхлэн зэвсэглэл хураах, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх, цөмийн эрчим хүчийг зөвхөн энхийн зорилгоор ашиглах зэрэг асуудлыг бид тууштай дэмжсээр ирсэн.

Хүйтэн дайны үед ЗХУ-ын холбоотны хувьд Монгол улс цөмийн зэвсэг бүхий Зөвлөлтийн цэргийг нутагтаа байрлуулж шинэхэн цөмийн гүрэн болох БНХАУ-ын эсрэг эвсэлд нэгдэж байсан. Өөрөөр хэлбэл 1960-аад оноос 1980-аад оны сүүлч

хүртэл үргэлжилсэн Зөвлөлт-Хятадын сөргөлдөөний үед Монгол улс цөмийн дайны талбар болох байнгын аюулын дор оршиж байсан гэсэн үг юм. Аз тохиож Зөвлөлт-Хятадын харилцаа сайжирч, зөвлөлтийн цэрэг 1992 оноос Монголын газар нутгаас гарч эхэлснээр энэ аюулаас ангижирсан билээ.

Үүний зэрэгцээ цөмийн аюул бүрэн арилсан гэж хэлж болохгүй юм. Дэлхийн хэмжээнд хийгдсэн цөмийн туршилтын 27 орчим хувь Монголын хилийн ойр зэргэлдээ газар нутагт явагдсан байдаг. Үүний байгаль орчны болон хүн амын эрүүл мэндийн үр дагавар одоо болтол тогтоогдоогүй байна. Мөн өнөөдөр ОХУ болон БНХАУ-ын 20 гаруй цөмийн байгууламжууд, тэр дундаа цөмийн зэвсгийн болон цөмийн хаягдлын хадгалах байгууламжууд Монголын хилийн ойр орчим газар нутагт байрладаг.

Энэ бүх учир шалтгааныг тунгаан бодсоны эцэст Монгол улсын төр засаг цөмийн зэвсгээс ангид байх асуудлыг төрийн бодлогын түвшинд тавьж 1992 онд өөрийн газар нутгаа цөмийн зэвсгээс ангид бүс боллоо гэдгээ НҮБ-ын индэр дээрээс нэр төртэй зарласан юм.

Монгол улс газар нутгаа цөмийн зэвсгээс ангид бүс болгон зарласныг дэлхийн улс орнууд болон хоёр хөрш их гүрэн эхнээс нь зарчмын хувьд дэмжсэн. Чингэснээр тэд Монгол Улсаас хөрш хоёр орны болон цөмийн зэвсэгтэй бусад гүрний цөмийн стратегийн холбогдолтой элдэв тооцоо төлөвлөгөөнд татагдан орохгүй байж, төвийг сахих бодлого баримтлах болсныг хүлээн зөвшөөрсөн хэрэг байв. 1998 оны 12 дугаар сард Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей “Монгол улсын олон улсын аюулгүй байдал болон цөмийн зэвсгээс ангид статусын” тухай тогтоолыг санал хураалгүйгээр баталсан. Энэхүү тогтоолоор Монгол улс газар нутгаа цөмийн зэвсгээс ангид бүс болгон зарласныг Ерөнхий Ассамблейн гишүүн улс орнууд болон Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн 5 оронд мэдэгдэж хамтран ажиллах, дэмжихийг уриалсан байдаг. Үүнээс хойш Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хууль ёсны болгох манай хүчин чармайлт алгуур боловч урагшилсаар байна.

Үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн дотроос 2000 оны 2 дугаар сард Монгол Улсын Их хурал цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийг хэлэлцэн баталсан нь түүхэн чухал үйл явдал болсон тухай би дээр

хэлсэн. Тэр оныхоо 10 дугаар сард Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн улс орон Монголын аюулгүй байдлын баталгаа болгож НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хамтарсан мэдэгдэл хийсэн нь манай санаачилгыг дэлхийн нийгэмлэг хүлээн зөвшөөрөх болсны том илэрхийлэл байлаа.

2001 оны 9 дүгээр сард Монгол улс, НҮБ болон Аюулгүйн Зөвлөлийн байнгын 5 гишүүн орнуудын төрийн бус байгууллагын төлөөлөгчид албан бусаар уулзаж цөмийн зэвсгээс ангид байх Монголын статусыг олон улсын хэмжээнд хуульчлан баталгаажуулах арга замын талаар ярилцаж зөвлөмж гаргасан байдаг. Тэрхүү зөвлөмжид Монгол Улсын Засгийн газрыг цөмийн зэвсэг бүхий хоёр их хөрштэйгөө хамтран гурван талт гэрээ байгуулах, эсвэл Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн 5 оронтой олон талт гэрээ байгуулахыг зөвлөмж болгосон юм.

Монголын Засгийн газар энэхүү зөвлөмжийн дагуу хоёр хөршийнхөө засгийн газарт хандан Монгол Улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулсан гурван талт гэрээ байгуулахыг санал болгосон. Тийм гэрээ байгуулснаар хөрш хоёр орон энэхүү статусыг хүндэтгэн үзэх амлалт өгч улмаар Монгол Улсын уг статусыг олон улсын гэрээгээр баталгаажуулах үүрэг авах юм. Хоёр хөрш орон маань ийм гэрээ байгуулах асуудалд зарчмын хувьд эерэг хандсан бөгөөд түүнд тусгаж болох өөрсдийн санаа бодлыг бидэнтэй хуваалцсан болно. Түүнийг нь харгалзан Монгол улс гэрээний төслийг боловсруулж 2007 оны 9 дүгээр сард хоёр хөршдөө уламжилж, 2009 оны 3, 9 дүгээр саруудад төслийнхөө талаар тэдэнтэй зөвлөлдөөд байна.

Уг гэрээний төсөлд цөмийн зэвсэгт хандах гурван улсын уламжлалт байр суурийн зэрэгцээ бий болсон шинэ нөхцөл байдалд хоёр их гүрний дунд орших Монголын онцгой нөхцөлийг харгалзсан тусгай зүйлүүд ч тусгагдсан болно. Түүнчлэн төсөлд талуудын Монголын цөмийн зэвсэггүй статусыг бэхжүүлэхэд хамтран ажиллах үүрэг хариуцлагыг тодорхой тусгасан байгаа. Цөмийн зэвсгээс ангид бусад бүсийн адил уг гэрээний төсөлд цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах, цөмийн материалыг хамгаалах, хяналт, шалгалт явуулах болон маргааныг шийдвэрлэх талаар тодорхой заалтууд тусгагдсан. Мөн уг төслийн хавсралт болгож цөмийн зэвсэгтэй бусад 3 гүрэн болох АНУ, Их Британи, Франц зэрэг орноос Монгол Улсын уг статусыг хүндэтгэж гурван талт гэрээг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх тухай заалт бүхий нэмэлт протокол орсон байгаа юм.

Цөмийн зэвсгээс ангид байхын төлөө Монгол Улсын тууштай бодлого, түүний дотор Монгол Улсын бие даасан, цөмийн зэвсэггүй статусыг олон улсын дэмжлэгээр баталгаажуулахын төлөөх Монгол Улсын хүчин чармайлт эцсийн дүндээ тодорхой амжилтад хүрсэн юм. 2012 оны 8 сарын 23-нд Женевт болсон цөмийн зэвсэгтэй 5 гүрний элчин сайд нарын уулзалт ярилцлагын дүнд эдгээр орны засгийн газрууд манай цөмийн зэвсэггүй статусыг албан ёсоор хүлээн зөвшөөрч, хамтарсан тунхаглал гаргаж баталгаа олгохоор болж ойрын үед НҮБ дахь Байнгын төлөөлөгчид нь энэ тухай тунхаглалд гарын үсэг зурж дэлхий нийтэд зарлан мэдэгдэх болно. Энэ тунхаглалын гол агуулга нь 2002 онд батлагдсан Цөмийн зэвсгээс ангид байх тухай Монгол Улсын хуулийг цөмийн зэвсэг бүхий 5 гүрэн бүгд хүндэтгэн хүлээн зөвшөөрөх бөгөөд, мөн цөмийн зэвсэггүй Монгол Улсын бие даасан статуст сөргөөр нөлөөлж болох аливаа үйл ажиллагаа, арга хэмжээний эсрэг нэгдсэн байр суурьтай байх болно гэдгээ зарлан мэдэгдэх явдал юм

Монгол Улс анх санаачлан дэвшүүлсэн, нэг улс бие даан цөмийн зэвсэггүй бүс нутаг байгуулах тухай ойлголтыг дэлхийн улс орнууд өргөнөөр хүлээн зөвшөөрч дэмжих боллоо. Ийм учраас манай орны цөмийн зэвсэггүй статусыг бататгах ажлыг улам гүнзгийрүүлэн, олон улсын цөмийн зэвсэггүй бүсүүдийн сүлжээнд бүрэн эрхт гишүүнээр орох нь нэг талаас нэг улс цөмийн зэвсэггүй бүс байгуулж болохыг олон улсын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд албан ёсоор хүлээн зөвшөөрүүлсэн, нөгөө талаас энхийг эрхэмлэсэн Монгол Улсын гадаад бодлогын том амжилт, манай нэр хүндийг олон улсын тавцан өргөсөн чухал үйл явдал болох учиртай юм. Энэ нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны том амжилт болохын зэрэгцээ Зүүн Хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын тогтолцоог бий болгох олон улсын чармайлтад бидний оруулах нэг гол хувь нэмэр болно гэж бид ойлгож байна.[58]

**Цөмийн эрчим хүчний аюулгүй байдлын бодлого.**

Монгол Улс 1992 онд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлаж, үүнийгээ үндэсний хэмжээнд болон олон улсын эрх зүйн гэрээ хэлэлцээрээр баталгаажуулах талаар тууштай, дэс дараатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ирсэн.

[58] Проф.Д.Мягмар. ,ЦЗҮД гэрээ ба МУ-ын цөмийн зэвсгээс ангид статус. Геополитик судлал №1.2016

Өнгөрсөн 26 жилд манай улсын энэ санаачилгыг дэлхийн улс орнууд улам бүр хүлээн зөвшөөрч дэмжих болж Зүүн Хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын тогтолцоог бий болгох олон улсын чармайлтад оруулж буй тодорхой хувь нэмэр гэж үнэлэх боллоо. Энэ нь энхийг эрхэмлэсэн Монгол Улсын гадаад бодлогын том амжилт, манай орны нэр хүндийг олон улсын тавцанд өргөсөн чухал ач холбогдолтой үйл явц юм.

Монгол Улсын Засгийн газар анх 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө цацраг идэвхт ашигт малтмалыг эдийн засгийн эргэлтэд оруулах, цөмийн эрчим хүч, цөмийн технологийг ашиглаж эхлэх асуудлууд тусгасан[59]. Үүний дараагаар УИХ, Засгийн газраас "Цөмийн энергийн тухай хууль", "Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого" зэргийг батлан гаргасан билээ.

Үүний зэрэгцээ энэ асуудалтай холбогдон цөмийн түүхий эдийг олборлох, экспортлох, цаашлаад атомын цахилгаан станц барьж байгуулах, цөмийн түлш импортлох, цөмийн эрчим хүч үйлдвэрлэх үйл ажиллагаанд тавигдах олон улсын хяналтын тогтолцоонд хамрагдах, түүнчлэн элдэв үүдэлтэй технологийн осол, аваар гарах, цөмийн түлшний шаар, цацраг идэвхт хаягдал хүн ам, байгаль орчинд хор нөлөө үзүүлэхээс сэргийлэх, хамгаалах буюу цөмийн энергийн аюулгүй байдлыг хангах асуудлыг эхнээс нь цэгцтэй, төрийн бодлогын түвшинд төлөвлөн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна[60].

Ийм учраас цөмийн энергийг энхийн зориулалтаар ашиглах үед бидэнд тулгарч болох зарим сорилт, аюул, тэдгээрээс сэргийлэх асуудлын талаар цөөн хэдэн зүйлийг та бүхэнд танилцуулахыг хүсэж байна.

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээнд зэвсэг хураах, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэхээс гадна цөмийн эрчим хүчийг энхийн зорилгоор ашиглах тухай тодорхой асуудлууд тусгагдсан байдаг нь дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх олон улсын эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа юм. .

---

59 Др.Ж.Энхсайхан.,МУ-ын цөмийн зэвсгээс ангид статусын баталгаажуулалт, түүний олон улсын ач холбогдол. Монгол Улсын ҮАБ-ын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ, 2014

60

- Enkhsaikhan J., Establishing a NEA-NWFZ: an idea whose time has come? UB dialogue on NEA Security. International conference. UB, September 2014
- Урианхан Ж.Энхсайхан., Монголын цөмийн ирээдүй... УБ, 2015

Цөмийн энерги нь эрчим хүчний харьцангуй шинэ эх үүсвэрийн нэг бөгөөд хүн төрөлхтнийг тодорхой урт хугацааны турш байгаль орчинд харьцангуй хал багатай эрчим хүчээр хангах боломж олгож байгаагаараа улс орнуудын анхаарлыг улам бүр татах боллоо. Тиймээс эрчим хүчний аюулгүй байдлаа хангах буюу энергийн найдвартай эх үүсвэртэй байх шаардлагын үүднээс цөмийн энергийг сонгох нь улам бүр түгээмэл болж байна. Үүний зэрэгцээ цөмийн түлш үйлдвэрлэх үйл ажиллагаа нь хууль бусаар  цөмийн зэвсэг үйлдвэрлэх оролдлого болон технологийн хийгээд хүний хүчин зүйлээс үүдэн гарч болох  олон эрсдэлийг араасаа дагуулж байдаг юм.

Цөмийн эрчим хүчний гол түүхий эд бол уран. Уран нь дэлхийд нэлээд түгээмэл байдаг бөгөөд геополитикийн хувьд бусдад аюул багатай улс орнуудад ч бас бий. Ураны өөрийн өртөг цөмийн түлш ашиглан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх нийт зардлын багахан хувийг эзэлдэг учир атомын цахилгаан станц эзэмшигчийн хувьд түүний үнийн хэлбэлзэл тийм ч их бэрхшээл үүсгэдэггүй юм. Түүнчлэн хэдэн жилийн турш хэрэглэх ураны стратегийн нөөц бүрдүүлэх нь хялбар бөгөөд санхүүгийн хувьд ч төдийлөн бэрхшээлтэй асуудал биш байдаг.

Цөмийн түлш үйлдвэрлэх үе шат бүр нь ханган нийлүүлэлтийн аюулгүй байдлын хувьд харилцан адилгүй зэрэглэлтэй байдаг. Ханган нийлүүлэгчид элбэг байдаг учир үйлдвэрлэлт, тээвэрлэлт нь нийлүүлэлтийн аюулгүй байдлын хувьд баталгаатай, өрсөлдөхүйц үнэ тогтоох бололцоотой байдаг бол баяжуулалт, дахин боловсруулалт нь ханган нийлүүлэгчид цөөн  бөгөөд өрсөлдөөн ч үр ашиг багатай байдаг. Тийм боловч цөмийн эрчим хүч хэрэглэдэг улс орнууд ханган нийлүүлэлтийн тасралт, эрсдэлтэй тулгарсан жишээ одоогоор байхгүй байна.

Олон стандартын реактор ажиллуулдаг улс орнуудад заримдаа аюулгүй байдлын ерөнхий шаардлага, аюулгүйн дүрмийн зохицуулалтад өөрчлөлт гарсантай холбогдон атомын цахилгаан станцуудаа шинэчлэх, засвар хийхийн тулд тэдгээрийг хаах хүртэл арга хэмжээ авах шаардлага үүсэж байсан ч эдгээр улс орон эрчим хүчний нийлүүлэлтийн найдвартай болон баталгаатай байдлаа алдагдуулалгүйгээр аюулгүй байдлын өндөржүүлсэн стандартыг хангах асуудлыг шийдвэрлэж  ирсэн юм.

Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээний хэрэгжилтийг хангах болон төрөл бүрийн үүдэлтэй хорлон сүйтгэх үйл ажиллагаа гарахаас сэргийлэх үүднээс олон

улсын байгууллагууд цөмийн түлшний зах зээлд төрөл бүрийн хяналт тогтоох замаар түүний чөлөөт байдлыг тодорхой хэмжээгээр хязгаарладаг. Гэхдээ Олон улсын атомын энергийн агентлагаас хэрэгжүүлж буй хяналтын үйл ажиллагаа нь тодорхой дүрэм журамтай бөгөөд улс орнууд цөмийн энергийг энхийн зориулалтаар ашиглах асуудлыг зохицуулсан өөрсдийн хууль дүрмээ энэ дүрэм журамтай нийцүүлэн боловсруулах замаар цөмийн материалын худалдааг хоорондоо чөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой юм.

Реакторын түлшний ханган нийлүүлэлт, ашиглалтын найдвартай байдлыг хангах, хэрэглэсэн түлшийг хадгалах, эцэст нь цөмийн хаягдлыг булшлах асуудлыг шийдвэрлэх нь цөмийн түлшний үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн асуудлууд юм. Сүүлийн жилүүдэд цөмийн түлшний үйлдвэрлэлийн бүх нийтийг хамарсан олон талт хяналтын тогтолцоо бий болгох замаар цөмийн материалыг хорлон сүйтгэгчдийн гарт орох болон хяналтгүй тархахаас сэргийлэх талаар олон санал гарсаар байгаа билээ.

Цөмийн түлшний үйлдвэрлэлийг олон талт хяналтад хамруулах санаа нь шинэ зүйл биш юм. Цөмийн эриний эхэнд буюу бүр 1946 онд Барух, Громыко нарын төлөвлөгөөнд энэ асуудал анх тусгагдаж байсан бөгөөд хэзээ ч орхигдож байгаагүй юм. Уг төлөвлөгөөний гол санаа нь цөмийн түлшний үйлдвэрлэлийг нэг улсын бус буюу хэсэг бүлэг улс эсвэл олон улсын байгууллагын хяналтад байлгах явдал юм. Олон талт хяналтын гол зорилго нь цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийг олон улсын аюулгүй байдлыг хангах зорилттой уялдуулан зохицуулах, үүний тулд цөмийн түүхий эдийн хяналтгүй тархалтыг гаргуулахгүй байх, түүнийг хулгайлах, хорлон сүйтгэх болон зэвсгийн зориулалтаар ашиглахыг оролдох явдлыг таслан зогсоох зорилго бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршиж байгаа юм. Олон талт хяналт нь улс орнуудад цөмийн объектууддаа хяналт тавихад нь тодорхой тус дөхөм болохын дээр энэ үндсэн дээр тэдгээрээс дээрх зорилгоор гаргах зардлыг нь ихээхэн хэмжээгээр багасгах боломж олгох ач холбогдолтой юм. Түүнчлэн энэ нь улс орон хоорондын итгэлцлийг нэмэгдүүлэх хүчтэй хэрэгсэл бөгөөд эцсийн дүндээ өндөр технологи бүхий эрсдэл ихтэй энэ салбарт аюулгүй байдлыг хангах бодит нөхцөлийг бүрдүүлэх зорилготой юм.

Цөмийн түлшний үйлдвэрлэлийг олон талт хяналтад хамруулах асуудлыг Олон улсын атомын энергийн агентлагийн / цаашид ОУАЭА гэх / ерөнхий захирал Мохамед Эл Барадей 2003 оны “Экономист” сэтгүүлд нийтлүүлсэн “Аюулгүй

дэлхийн зүгт” гэсэн өгүүлэлдээ анх нэлээд тодорхой хөндсөн байдаг. Түүний өгүүллийн гол санаа нь ураны хүдрийг баяжуулах болон дахин боловсруулах үйл ажиллагаанд тавих олон улсын хяналтыг чангатгах, түүнчлэн хэрэглэсэн түлш болон цацраг идэвхт хаягдлыг хэрхэх асуудлыг мөн ийм хяналтын дор шийдвэрлэж байх явдал юм.

2004 онд энэ асуудлыг судлах олон улсын шинжээчдийн групп байгуулагдсан бөгөөд уг групп нь 2005 онд “Олон талт цөмийн хандлага” (Multilateral Nuclear Approaches. MNA) гэсэн илтгэлийг боловсруулан тараасан юм. Үүнээс хойш улс орнуудын засгийн газар, цөмийн салбарынхан, олон улсын байгууллагуудын зүгээс 12 орчим томоохон санал гарсан байдаг.

1. Цөмийн түлшний нөөц бүрдүүлэх санал /2005 оны 9 сар/: ОУАЭА-ын 49 дахь Ерөнхий хурлаар Америкийн нэгдсэн улс баяжуулалт болон дахин боловсруулалтыг зогсоосон улс оронд нийлүүлэх цөмийн түлшний баталгаа болгох үүднээс 17 тонн өндөр баяжуулсан ураныг бага баяжуулалттай болгохоо амласан.

2. Дэлхийн цөмийн энергийн дэд бүтэц байгуулах санал /2006 оны 1 сар/ Оросын холбооны улс дэлхийн цөмийн энергийн дэд бүтэц /GNPI/ байгуулах санал дэвшүүлсэн. Уг дэд бүтэц нь цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог аливаа улс оронд цөмийн эрчим хүч ашиглах тэгш эрх олгох зорилготой юм. Энэхүү саналыг улс орнуудад ялгавартай хандахгүй байх зарчимд тулгуурлан цөмийн түлшний үйлдвэрлэл, түүний дотор, уран баяжуулах үйлчилгээ үзүүлдэг олон улсын төвүүдийг ОУАЭА-ын хяналт, удирдлагын дор байгуулж ажиллуулах замаар хэрэгжүүлэх зорилготой болно.

3. Дэлхийн цөмийн энергийн түншлэл /2006 оны 2 сар/ Дэлхийн цөмийн энергийн түншлэл /GNEP/-ийг АНУ тэргүүтэй цөмийн технологи өндөр хөгжсөн улс орнууд нэгдэж консорциум хэлбэрээр байгуулах санал дэвшүүлээд байна. Энэхүү консорциум нь баяжуулалт болон дахин боловсруулалтад хөрөнгө оруулалт хийхээсээ татгалзсан улс орнуудад цөмийн түлш найдвартай нийлүүлэх зорилготой юм.

4. Дэлхийн цөмийн нийгэмлэгийн санаачилга /2006 оны 5 сар/ Энэ нийгэмлэг нь уран баяжуулах үйлчилгээ үзүүлэх 3 шатлал бүхий механизм бий болгохыг санал болгосон. Энэ санаачилгын гол зорилго нь одоогийн дэлхийн зах зээлийн

эрэлт хэрэгцээ, ОУАЭА болон засгийн газруудынхаа өмнө үүрэг хүлээсэн баяжуулах компаниудын ханган нийлүүлэх хамтарсан баталгаа болон эдгээр улс орны засгийн газрын мэдэлд байгаа баяжуулсан ураны нөөцийг ашиглан нийлүүлэлтийн аюулгүй байдлыг хангах явдал юм.

5. Цөмийн түлш найдвартай ханган нийлүүлэх олон талт үзэл баримтлал /2006 оны 6 сар/: Цөмийн түлшний баяжуулалт явуулдаг хэсэг улс /АНУ, Англи, ОХУ, Герман, Франц, Голланд зэрэг/ 2 шатлал бүхий ханган нийлүүлэх баталгааг санал болгосон. Эдгээр улс орнууд цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээг биелүүлдэг улс оронд цөмийн түлш баталгаатай нийлүүлэх бөгөөд ханган нийлүүлэлт тасалдсан тохиолдолд бие биеэ нөхөх юм. Энэ үйл ажиллагаа тасалдсан тохиолдолд бага баяжуулалттай ураны нөөцийг нөхөн сэргээх асуудлыг хамтран шийдвэрлэх болно.

6. ОУАЭА-ын нөөцийн зохицуулалтын систем /2006 оны 9 сар/: Өмнөх саналын нэмэлт заалт болгож Япон улс цөмийн түлшний нөөцийн мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах санал дэвшүүлсэн. Энэхүү мэдээллийн нэгдсэн сүлжээг ОУАЭА удирдах бөгөөд гишүүн орнуудын сайн дурын үндсэн дээр өгсөн ураны орд газар, нөөц, боловсруулалт, баяжуулалт, түлшний үйлдвэрлэл зэргийн тухай мэдээллийг хуримтлуулж боловсруулалт хийн түгээх юм.

7. ОУАЭА-ын Цөмийн түлшний банк /2006 оны 9 сар/: Цөмийн аюул заналаас сэргийлэх санаачилга ОУАЭА-д хандан бага баяжуулалттай ураны нөөц бүрдүүлэхэд туслалцаа үзүүлэх санал дэвшүүлсэн. Энэ нөөцийг ханган нийлүүлэлт тасалдсан тохиолдолд ашиглах юм.

8. Баяжуулалтын баталгаа санал /2006 оны 9 сар/ Саяхан Цөмийн түлшний баталгаа нэрээр өөрчлөгдсөн уг саналыг Их Британи улс дэвшүүлсэн бөгөөд цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх гэрээг биелүүлдэг улс оронд өөрийн улсын баяжуулсан түлшээ ханган нийлүүлэхээ амласан. Мөн өмнө нь өгсөн экспортын баталгаагаа нотолсон байна.

9. Уран баяжуулах олон улсын төв /2007 оны 1, 5 сар/ Дэлхийн цөмийн эрчим хүчний дэд бүтэц байгуулах хүрээнд ОХУ Ангарск хотдоо уран баяжуулах олон улсын төв байгуулах санал дэвшүүлсэн. Уг төв нь Ангарск хотын Электролиз Химийн цогцолборт байрлах бөгөөд оролцогч улс орнуудад баяжуулсан уран нийлүүлэх баталгаа бүрдүүлж өгөх юм. Мөн ханган нийлүүлэх болон экспортын

хяналтыг үр дүнтэй болгох зорилгоор бага баяжуулалттай уран хадгалах байгууламж бий болгох саналтай байгаа болно.

10. Олон талын хяналт бүхий баяжуулах төв байгуулах төсөл /2007 оны 5 сар/ ХБНГУ олон талын хяналт бүхий уран баяжуулах төв байгуулах санал дэвшүүлсэн. Уг төв нь худалдаа хийх эрхийн хувьд ОУАЭА-ын удирдлага дор ажиллах бөгөөд зах зээлд шинэ нийлүүлэгч болох юм. Хэрэглэгчид энхийн зорилгоор ашиглах цөмийн түлшийг маш хатуу хяналт дор авч болох юм.

11. Цөмийн түлшний үйлдвэрлэлийг олон талын хяналтад оруулах санал /2007 оны 5 сар/: Австри улс 2 шатлал бүхий олон талын хяналтын механизм санал болгосон. Эхний шатлал нь ОУАЭА-ын хяналтыг илүү ил тод болгох, дараагийн шатлал нь цөмийн түлшний нийлүүлэлтийг Цөмийн түлшний банкны удирдлага дор явуулахад орших юм. Мөн цөмийн технологийн үнэ өртөг өндөртэй хяналтад оролцох боломцоог илүү нээлттэй болгох явдал юм.

12. Цөмийн түлшний үйлдвэрлэлийн албан бус баримт бичиг /2007 оны 6 сар/ Европын холбоо цөмийн түлшний нийлүүлэлтийн олон талт механизмыг тодорхой шалгуур үзүүлэлтүүдтэй болгох зорилгоор дэвшүүлсэн санал. Үүнд: цөмийн зэвсгээс ангид байх, ханган нийлүүлэх баталгаа, тэнцүү эрх үүрэгтэй байх, зах зээлийн хувьд төвийг сахисан байх зэрэг асуудлуудыг хамааруулах юм.

Хэдийгээр эдгээр санал, төслүүд хэтийн зорилго, хамрах хүрээ, төлөвлөгөө болон хэрэгжүүлэхэд шаардлагатай цаг хугацааны хувьд өөр өөр боловч ихэнх нь цөмийн түлшний ханган нийлүүлэлтэд хяналт тавих асуудалд гол анхаарлаа хандуулж байна гэж мэргэжилтнүүд үзэж байна. Харин ОХУ-ын Дэлхийн цөмийн эрчим хүчний дэд бүтэц байгуулах санал, АНУ-ын Дэлхийн цөмийн энергийн нөхөрлөл байгуулах санал, Австри улсын 2 шатлал бүхий олон талт хяналтын механизм байгуулах санал нь баяжуулалт, нийлүүлэлт, дахин боловсруулалт зэрэг бүх төрлийн үйлчилгээг хамрах зорилготой болох нь тодорхой байгаа юм.

Мэргэжилтнүүдийн бодлоор жижиг санал, төслүүд богино хугацаанд хэрэгжих боломжтой учир давуу талтай юм. Гэвч тэдгээр жижиг төслүүд үйлчлүүлэгч улс орнуудын хувьд өгөөж багатай, нийлүүлэгч улс орнуудын хувьд монополь байдлаа хадгалах гэсэн нууц стратегийн бодлого байж болох талтай гэсэн болгоомжлол төрүүлдэг болно. Том санал, төслүүд үнэхээр олон талт учир үйлчлүүлэгч улс орнуудад илүү өгөөжтэй. Гэвч тэдгээрийг хэрэгжүүлэхэд дэд

бүтцийн том бүтээн байгуулалт болон улс төр, эрх зүй, эдийн засгийн түвэгтэй олон асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй болох бөгөөд ингэснээр цаг хугацаа ч их шаардах болно.

Цөмийн энергийн аюулгүй байдлыг хангахын тулд дагаж мөрдөх механизм:

- Цөмийн аюулгүй байдлын конвенц /CNS/
- Ашигласан цөмийн түлш, цацраг идэвхт хаягдалтай харьцах үед аюулгүй байдлыг хангах тухай нэгдсэн конвенц (JC)
- Цөмийн аваар осол ба цацраг идэвхт онцгой байдлын үед шуурхай мэдээлэх тухай конвенц
- Цөмийн аваар осол ба цацраг идэвхт онцгой байдлын үед туслалцаа үзүүлэх тухай конвенц
- Цөмийн хор хөнөөлийн иргэний хариуцлагын тухай Венын конвенц
- Цөмийн эрчим хүчний салбарт гуравдагч талын өмнө хүлээх хариуцлагын тухай Парисын конвенц

Хамтран ажиллах олон талт санаачилгууд:

- Дэлхийн цөмийн эрчим хүчний түншлэл / GNEP)/
- ОУАЭА-ын Цацраг идэвхт материалтай харьцах болон хадгалалтын үеийн аюулгүй байдлын дүрэм, мөн Цацраг идэвхт материалын импорт, экспортын тухай нэмэлт дүрэм

Хамтран ажиллах байгууллагууд:

- Олон улсын атомын энергийн агентлаг
- Олон улсын цөмийн аюулгүй байдлын болон оролцооны хөтөлбөр
- Иргэний цөмийн байгууламжуудын үйл ажиллагааны сургалтын хөтөлбөр

Сүүлийн жилүүдэд дэвшигдэж буй Ази, Номхон далайн бүс нутагт цөмийн эрчим хүчний аюулгүй байдлыг хангах зарим санал:

- Бүс нутагт юуны өмнө АСЕАН-ны орнуудыг хамарсан“Баяжуулалт болон дахин боловсруулалтын бие даасан чөлөөт бүс” байгуулах асуудлыг судлах. Уг бүсийг байгуулснаар цөмийн зэвсэг бүтээх хөтөлбөрийг иргэний эрчим

хүчний хөтөлбөрөөр далдлан эхлүүлэхээс сэргийлэх бололцоо гарч болох талтай гэж үзэж байна.

- Цөмийн энергийн мэргэжилтнүүдийн олон улсын группүүдийг байгуулах тэдгээрийн үйл ажиллагааг итгэлцэл, ил тод байдлыг дэмжих, туршлага хуваалцах үүднээс сурталчлах. Эдгээр группийн үйл ажиллагаа нь Ази Номхон далайн бүс нутагт олон талын хяналт бүхий түлшний үйлдвэрлэл бий болгох асуудлыг судлахад үндсэндээ чиглэх бололтой байна.
- EURATOM болон ABACC-тай төстэй бүс нутгийн цөмийн аюулгүй байдлын баталгааны механизм буюу Ази Номхон далайн атомын энергийн нийгэмлэг байгуулах. Энэ саналыг Ази-Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны зөвлөл /CSCAP/-өөс гаргасан. Уг байгууллага нь ОУАЭА-ын үйл ажиллагаатай давхцахгүй бөгөөд харин түүний ажлын ачааллаас хөнгөлөх зорилготой юм гэсэн мэдэгдлийг CSCAP тараагаад байгаа болно.
- Цөмийн түүхий эд эзэмших асуудлыг бүс нутгийн хэмжээнд шийдвэрлэх эрх бүхий олон улсын цөмийн эрчим хүчний захиргааны байгууллага бий болгох, ОУАЭА-ын зүгээс бүс нутагт хэрэгжүүлж буй аюулгүй байдлын механизм бүрдүүлэх үйл ажиллагааны зардлаас хуваалцах, бүс нутагт цөмийн түлшийг төвлөрсөн журмаар үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх болон цөмийн аюулгүй байдлын нэгдсэн судалгааг хөгжүүлэх асуудлыг олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулах.
- Бүс нутагт цөмийн эрчим хүчний холбогдолтой осол аваар гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах, яаралтай хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах.
- Цөмийн технологийн хувьд өндөр хөгжсөн орнуудын зүгээс хөгжиж буй улс орнуудад цөмийн эрчим хүчний үндэсний стратеги боловсруулахад нь дэмжлэг үзүүлэх явдлыг дэмжих. Ингэхдээ нөөц бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах, цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэхтэй холбогдол бүхий эрсдэлүүдийг тооцох, цөмийн түлшний нийлүүлэлт, ашигласан түлшийг хадгалах, булшлах зэрэг асуудлуудад онцгой анхаарах.
- Үр ашигтай туршлага солилцох, сургалт явуулах зорилгоор бүс нутгийн мэдээлэл цуглуулах болон мэдээлэл түгээх төв байгуулах асуудлыг судлах.
- Ашигласан, цацраг идэвхт цөмийн түлш болон хаягдлыг хадгалах бүс нутгийн төвлөрсөн агуулах байгуулах.
- Цөмийн энергийн салбарт ажиллах өндөр мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх асуудлаар олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, цөмийн

эрчим хүчний холбогдолтой осол аваар гарсан үед яаралтай арга хэмжээ авах бүс нутгийн хамтын ажиллагааны механизм бүрдүүлэх.

- Цөмийн хэрэглэсэн түлш болон хаягдалтай харьцах олон улсын техникийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх.
- Цөмийн байгууламжуудын аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтарсан судалгаа явуулах болон мэдээлэл солилцох үйл ажиллагааг өргөжүүлэх, хэрэглэсэн түлшний болон хаягдлын менежментийн нэгдсэн стандарт бий болгох, мөн энэ чиглэлээр гарсан шинэ санаа, технологийг турших бүс нутгийн байгууллагуудыг бий болгох зэрэг болно.

### 3.1.6. Эвсэлд үл нэгдэх бодлого

**Мөн чанар, учир холбогдол.**

Ìîíãîë óëñ ýâñýëä ¿ë íýãäýõ хөдөлгөөнийг (цаашид ЭҮНХ гэх)ýõíýýñ íü äýìæèæ èðñýí áºãººä 1970-ààä îíîîñ óã õºäºëãººíèé õóðàë, чуулганд байнга оролцож ирсэн байна. 1986 îíîîñ óã õºäºëãººíèé äýýä õýìæýýíèé õóðàëä àæèãëàã÷ààð îðîëöîæ 1989 îíä ò¿¿íèé ãèø¿¿í íü áîëñîí юм. Õºãæèæ áàéãàà îðíóóäòàé íàéðñàã õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õî¸ð òàëûí õ¿ðýýíýýñ ãààíà ÝҮНХ, түүний «77»-èéí á¿ëýãò õàðèëöàí àæèëëàõ çàìààð õýðýãæ¿¿ëýõèéã Ìîíãîë Óëñûí ãàäààä áîäëîãûí ¿çýë áàðèìòëàëä íýã ÷óõàë çîðèëò áîëãîí çààñàí байдаг.

Дэлхийн II äàéíû äàðàà ¿¿ññýí Ýâñýëä үл нэгдэх хөдөлгөөнд (цаашид ÝҮÍÕ гэх) îäîî 120 орчим óëñ îðîëöîæ áàéíà. Ү¿íèé äèéëýíõ îëîíõè íü янз бүрийн цаг үед êîëîíèéí äàðëàëààñ чөлөөлөгдсөн орнууд áàéãàà þì.

Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн нь олон улсын тулгамдсан асуудлаар баримталж буй байр сууρь, ашиг сонирхлоо хамтран хамгаалахад чиглэсэн хөгжиж байгаа орнуудын хамтын ажиллагааны нэгэн механизм юм. ЭҮНХ нь анх 1961 онд 25 гишүүнтэй байгуулагдсан бол эдүгээ дэлхийн 120 улсыг эгнээндээ гишүүнээр нэгтгээд байна. Мөн БНХАУ, Бразил, Аргентин, Армени, Украйн, Казакстан зэрэг 17 улс, НҮБ, Дэлхийн энх тайвны зөвлөл, Африкийн холбоо, Арабын орнуудын холбоо, Лалын хамтын ажиллагааны байгууллага, Ази, Африкийн эв нэгдлийн байгууллага зэрэг олон улсын болон бүсийн 11 байгууллага үйл ажиллагаанд нь

ажиглагчаар оролцдог. ЭҮНХ-ий гишүүн орнууд нь НҮБ-ын гишүүдийн гуравны хоёрыг, дэлхийн нийт хүн амын 55 хувийг бүрдүүлдэг байна[61].

**ЭҮНХ-ий түүхээс.** “Эвсэлд үл нэгдэх” гэсэн нэр томьёог анх Энэтхэгийн улс төрч, дипломат В.К.Кришна Менон 1953 онд НҮБ-д хэлсэн үгэндээ дэвшүүлсэн байдаг. Улмаар Энэтхэгийн Ерөнхий сайд Ж.Неру 1954 онд Шри Ланкийн Коломбо хотноо болсон Азийн орнуудын Ерөнхий сайд нарын бага хурал дээр Хятад, Энэтхэгийн харилцааны асуудлаар хэлсэн үгэндээ энэхүү нэр томьёог мөн хэрэглэсэн байна.

БНХАУ-ын Ерөнхий Сайд Жоу Эньлай, Энэтхэгийн Ерөнхий сайд Ж.Неру нар энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг ( “Панча Шила”) томьёолон гаргаж, 1954 оны 4 дүгээр сарын 29-нд хоёр орны хооронд байгуулсан худалдааны хэлэлцээртээ (удиртгал хэсэгт нь) тусгасан ажээ. Үүнд:

- Бие биеийн газар нутгийн бүрэн бүтэн байдал, бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэх,
- Бие биеийн эсрэг түрэмгийлэл үйлдэхгүй байх,
- Бие биеийн дотоод хэрэгт хөндлөнгөөс үл оролцох,
- Тэгш эрхтэй байх, харилцан ашигтай байх,
- Энх тайвнаар зэрэгцэн орших гэсэн 5 зарчим багтана.

Эдгээр зарчим нь чухамдаа ЭҮНХ-ийг байгуулах үйл явцын эхлэлийг тавьсан гэж үздэг.

Хөдөлгөөний үүсэл хөгжилд 1955 онд Индонезийн Бандунг-т болсон Ази-Африкийн орнуудын бага хурал чухал байр сууръ эзэлдэг. Индонезийн Ерөнхийлөгч Сукарногийн санаачилгаар зохион байгуулсан тэрхүү бага хуралд Ази, Африкийн 29 улсын төр, засгийн тэргүүн оролцсон бөгөөд тухайн үеийн коммунист, капиталист хоёр системийн хоорондын тэмцэл, ялангуяа хөгжиж буй орнуудыг өөрсдийн цэрэг, улс төрийн эвсэл бүлэглэлд татан оруулах тэдний бодлогыг хамтын хүчээр сөрөн зогсох, колоничлол, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах, шинээр тусгаар тогтносон улсуудын бие даасан байдлыг бэхжүүлэх, шинэ колоничлолыг эсэргүүцэх зорилтуудыг дэвшүүлж, Дэлхийн энх

[61] *Ж.Бор. Дэлхийн дипломатын нэвтэрхий толь бичиг. УБ, 2018

тайван, хамтын ажиллагааг бэхжүүлэх Тунхаглалыг баталжээ. Бандунгийн бага хурлаас “Панча Шила”-гийн зарчмуудыг дэлгэрүүлэн баяжуулж, дэлхийн энх тайван, хамтын ажиллагааны 10 зарчмыг баталж гаргасан ба тэдгээр нь ЭҮНХ-ий үндэс суурь болсон байна. Үүнд:

- Хүний үндсэн эрх болон НҮБ-ын зорилго, зарчмуудыг хүндэтгэх,
- Бүх улс үндэстний бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх,
- Үндэсний тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөнүүдийг хүлээн зөвшөөрөх,
- Янз бүрийн арьс өнгөтэй бүх улс түмний хийгээд том, жижиг бүх улс үндэстний эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрөх,
- Бусад улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс хүч түрэн орох, оролцох явдлаас түдгэлзэх,
- Аливаа улс үндэстэн НҮБ-ын Дүрмийн заалтуудад нийцүүлэн өөрийгөө дангаараа буюу хамтын хүчээр хамгаалах эрхийг хүндэтгэх,
- Аливаа улсын газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс төрийн тусгаар тогтнолын эсрэг түрэмгийллийн үйлдэл хийх, эсхүл хийхээр заналхийлэх, эсхүл хүч хэрэглэхээс татгалзах,
- Олон улсын маргаантай асуудлыг НҮБ-ын Дүрмийн заалтуудад нийцүүлэн энх тайван замаар шийдвэрлэж байх,
- Бие биеийн ашиг сонирхол, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих,
- Шударга ёс, олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийг хүндэтгэх зарчмууд багтана.

Хөдөлгөөнийг үүсгэн байгуулахад тухайн үеийн Югославын Ерөнхийлөгч Й.Б.Тито, Энэтхэгийн Ерөнхий сайд Ж.Неру, Египетийн Ерөнхийлөгч Г.А.Насер, Ганын Ерөнхийлөгч К.Нкрума, Индонезийн Ерөнхийлөгч Сукарно нар гол үүрэг гүйцэтгэсэн. Тэд бүгд “Хүйтэн дайны” үед өөр хоорондоо ширүүн тэмцэл өрнүүлж байсан өрнөд, дорнодын хоёр бүлэглэлийн дунд хөгжиж буй орнууд төвийг сахих чиг шугам баримтлахыг уриалдаг байсан.

Й.Б.Тито-гийн санаачилгаар *Эвсэлд нэгдээгүй орнуудын төр, засгийн тэргүүн нарын бага хурлыг* Бандунгийн бага хурлаас 6 жилийн дараа буюу 1961 оны 9 дүгээр сард Белград хотноо зохион байгуулжээ. Тус бага хуралд бэлтгэх хурлыг 1961 оны 6 дугаар сарын 5-12-нд Каир хотноо зохион байгуулж, эвсэлд

нэгдээгүй орнуудын зорилго, зарчим, бодлогыг хэлэлцэж, гишүүнчлэлийн дараах шалгуурыг баталсан байдаг. Үүнд:

- Гишүүн байх орон улс төр, нийгмийн өөр өөр тогтолцоо бүхий улс орнуудтай зэрэгцэн орших, эвсэлд үл нэгдэх зарчимд үндэслэсэн бие даасан бодлого явуулдаг байх,
- Үндэсний тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөнийг дэмждэг байх,
- Их гүрнүүдийн сөргөлдөөний хүрээнд бий болсон цэргийн эвсэл холбооноос ангид байх,
- Хэрэв их гүрэнтэй цэргийн хэлэлцээртэй байвал тэр нь их гүрнүүдийн сөргөлдөөний хүрээнд бус харин батлан хамгаалах зориулалттай байх,
- Хэрэв их гүрний цэргийн баазыг газар нутагтаа байрлуулсан бол тэр нь их гүрнүүдийн сөргөлдөөнтэй холбоогүй байх - зэрэг болно.

*Жич тайлбар*: Эхний үед “эвсэлд нэгдээгүй орнууд” гэж ярьж, бичиж байсан бол 1976 онд Коломбод болсон 5 дугаар бага хурлын үеэр “Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөн” гэсэн нэр томьёог анх хэрэглэсэн ба оролцогч орнуудыг ЭҮНХ-ий гишүүн орнууд гэх болсон байна.

**Бүтэц, зохион байгуулалт.** ЭҮНХ нь өвөрмөц бүтэц, зохион байгуулалттай бөгөөд байнгын Нарийн бичгийн дарга нарын газар гэж тусдаа байдаггүй. Хөдөлгөөний хувьд шийдвэр гаргах гол байгууллага нь 3 жил тутам болдог Дээд хэмжээний уулзалт юм. Дээд хэмжээний уулзалтаас баталж гаргасан төгсгөлийн баримт бичиг нь олон улсын харилцааны тулгамдсан болон шинээр үүссэн асуудалд шинжилгээ, дүгнэлт хийж хөдөлгөөний байр суурийг тодорхойлдог.

Дээд хэмжээний уулзалтаар хөдөлгөөнийг дараагийн гурван жилийн хугацаанд даргалах улсыг сонгож, улмаар эрхийг шилжүүлэх ёслол болдог. Даргалагч улсад чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь тус дөхөм үзүүлэх үүднээс ЭҮНХ-ий хүрээнд хэд хэдэн бүтэц, механизмыг бий болгосон байдаг. Тухайлбал, Гадаад хэргийн сайд нарын уулзалт, гадаад хэргийн сайд нарын онц тусгай уулзалт, Аргачлалын асуудлаарх сайд нарын түвшний хорооны уулзалт, Зохицуулах товчооны сайд нарын уулзалт, мөн гишүүн орнуудын хамтын ажиллагааг соёл, боловсрол, эрүүл мэнд, хүний нөөц, мэдээлэл харилцаа, шинжлэх ухаан, технологи зэрэг салбарт хөгжүүлэх үүднээс тухайн салбарын сайд нарын болон мэргэжилтний уулзалтыг тухай бүр зохион байгуулдаг.

1961 онд Белградад болсон Эвсэлд нэгдээгүй орнуудын төр, засгийн тэргүүн нарын анхдугаар бага хурлаас хойш дээд хэмжээний уулзалтыг нийт 17 удаа зохион байгуулаад байна. ЭҮНХ-ний Дээд хэмжээний 17 дугаар уулзалтыг 2016 онд Венесуэлийн Маргарита аралд зохион байгуулсан.

Хөдөлгөөний үйл ажиллагааны нэг чухал механизм бол өмнө нь дарга байсан, одоо дарга байгаа болон ирээдүйд дарга болох улсын гурвал буюу Тройка юм. Энэ нь олон улсын тулгамдсан асуудлаар хөдөлгөөнөөс баримтлах байр суурийг шуурхай боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Хөдөлгөөний өдөр тутмын үйл ажиллагааны зохицуулалтыг Нью-Йорк хотод НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч нарын түвшинд ажлаа явуулдаг ЭҮНХ-ий Зохицуулах товчоо хариуцан хэрэгжүүлнэ. Товчооны хурлууд сар бүр болдог бөгөөд хөдөлгөөний дарга улсын Байнгын төлөөлөгч удирддаг. Мөн НҮБ-ын өөрчлөлт, шинэчлэл, Энхийг сахиулах ажиллагаа, хүний эрх, зэвсэг хураах зэрэг асуудлаарх Ажлын хэсгүүд, Эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлаарх сайд нарын хороо, Палестиний асуудлаарх хороо, ЭҮНХ ба 77-гийн бүлгийн хамтарсан зохицуулах хороо зэрэг хөдөлгөөний хүрээнд байгуулагдсан нэгжүүд ажлаа Зохицуулах товчоонд илтгэнэ. НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд байнгын бус гишүүнээр сонгогдсон хөдөлгөөний гишүүн улсууд ЭҮНХ-ний албан бус бүлэг (caucus) байгуулж хамтран ажилладаг ба Зохицуулах товчоонд үйл ажиллагааныхаа талаар мэдээлж байдаг.

Эдгээрээс гадна Женев, Вена, Парис, Найроби, Гааг дахь НҮБ-ын байгууллагуудын дэргэд үйл ажиллагаагаа зохицуулах бүтцүүд ажилладаг байна.

ЭҮНХ-ний шийдвэрүүд нь нийтийн зөвшилцөлд үндэслэн гарна. 1996 онд Картагена хотноо болсон ЭҮНХ-ний Аргачлалын асуудлаарх сайд нарын түвшний хорооны уулзалтаар нийтийн зөвшилцлийн зарчмыг дахин нотолсон юм. ЭҮНХ зөвшилцлийг санал нэгтэй шийдвэрээс салгаж ойлгодог бөгөөд зарим асуудлаар хөдөлгөөний олонхын байр суурийг эсэргүүцсэн орнууд холбогдох баримт бичигт тайлбар хийх нь байдаг. Эдгээр тайлбарыг баримт бичгийн төгсгөлд хавсаргана.

Сүүлийн үед зарим улс гадаад бодлогынх нь зорилго, зарчимд нийцэхгүй заалт, үг хэллэг хөдөлгөөний баримт бичигт тусгагдсан хэмээн тухайн бүлэг, хэсгийг бүхэлд  хүлээж авахгүй тухайгаа тайлбар хийж байгаа. Энэ нь тухайн улс баримт бичгийг бүхэлд нь хүлээж аваагүй мэт ойлгоц төрүүлж байгаа тул чухам

ямар зүйл заалттай санал нийлэхгүй байгаагаа тод заах хэрэгтэй гэсэн шаардлагыг зарим гишүүн орон тавьж байгаа юм.

**Үйл ажиллагааны чиглэл, хүрээ.** ЭҮНХ нь үүсэн байгуулагдсанаасаа хойш дээр дурдсан үндсэн 10 зарчимд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж ирсэн бөгөөд гишүүн орнуудаа их гүрнүүдийн сөргөлдөөнд татагдан оруулахгүй байхад анхаарч, олон улсын харилцаанд бие даасан чиг хандлагыг бий болгон бэхжүүлэхийг гол зорилгоо болгож ирсэн.

1970 онд Лусакад болсон ЭНО-дын төр, засгийн тэргүүн нарын 3 дугаар бага хурлаас аливаа маргаантай асуудлыг энх тайвнаар шийдвэрлэж байх, том гүрнүүдийн цэргийн эвсэл, гэрээ хэлэлцээрт нэгдэхээс түдгэлзэж байх, гадаад улсын нутаг дэвсгэрт цэргийн бааз байгуулахыг эсэргүүцэх явдлыг хөдөлгөөний зорилгод нэмж тусгасан байна.

ЭҮНХ нь үзэл суртал, улс төрийн өөр өөр чиг баримжаатай, хөгжлийн хувьд янз бүрийн түвшинд байгаа улс орнуудыг эгнээндээ нэгтгэдэг хэдий ч олон улсын энх тайван, аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх зорилгын хүрээнд нэгдмэл байж ирсэн. Одоо ч дээрх зарчмын чиг шугамаа хадгалан баримталж байгаа. Үүний сацуу олон улсын эдийн засгийн харилцааг өөрчлөн байгуулахад онцгойлон анхаарч ажиллаж байна. 1970-1980-аад оны эхээр хөгжиж байгаа болон өндөр хөгжилтэй орнуудын худалдаа, эдийн засгийн харилцааг өөрчлөн байгуулах үүднээс "Олон улсын эдийн засгийн шинэ дэг журам" тогтоох асуудлыг хүчтэй тавьж ирсэн. Мөн "Дэлхийн мэдээлэл, харилцаа холбооны шинэ дэг журам" тогтоох тухай ч ярьж, энэ салбарт гишүүн орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх үүднээс 1975 онд Эвсэлд нэгдээгүй орнуудын мэдээллийн агентлагуудын холбоог байгуулсан ба түүнийгээ 2005 онд байгаа Эвсэлд нэгдээгүй орнуудын мэдээллийн сүлжээ болгон өөрчлөн байгуулсан.

ЭҮНХ-ий Дээд хэмжээний ээлжит уулзалтаас Төгсгөлийн баримт бичиг, Тунхаглал, зарим тодорхой асуудлаар мэдэгдэл зэрэг баримт бичиг баталж гаргадаг. Тунхаглал нь хөдөлгөөний зүгээс (дараагийн 3 жилд) баримтлан явуулах үйл ажиллагааны ерөнхий чиглэл, хүрээг тодорхойлно. Төгсгөлийн баримт бичиг нь гишүүн орнуудаас олон улсын болон бүс нутгийн тулгамдсан асуудлууд, НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд баримтлан явуулах бодлого, байр суурь, эдийн засгийн хөгжил, нийгмийн болон хүний эрхийн асуудлууд, зарим улс

оронд үүссэн нөхцөл байдлын талаар байр сууриа илэрхийлсэн үндсэн баримт бичиг юм. Төгсгөлийн баримт бичиг нь үндсэн 3 бүлэгтэй бөгөөд маш олон асуудлыг тусгасан байдаг. Хамгийн сүүлд 2016 онд Венесуэлийн Маргарита аралд болсон ЭҮНХ-ийн Дээд хэмжээний 17 дугаар уулзалтаас баталж гаргасан Төгсгөлийн баримт бичиг гэхэд л нийт 919 заалттай 206 хуудастай байна.

**ЭҮНХ-ний өнөөгийн нөхцөл байдал**. Өнөөгийн олон туйлт зөрчил сөргөлдөөний ертөнцөд ЭҮНХ нь хөгжиж буй орнуудын эрх ашгийг хамгаалдаг улс төрийн нөлөөтэй нэг том хүч болсон хэвээр байна.

"Хүйтэн дайн" төгссөнөөр ЭҮНХ-ний оршин тогтнох учир шалтгаан арилсан, мөхөх цаг нь ирлээ гэж үзэх явдал нэг хэсэг газар авч байсан. АНУ-ын Конгрессын захиалгаар (2005 онд) бэлтгэсэн "НҮБ-ын шинэчлэл, АНУ-ын эрх ашиг" сэдэвт судалгаанд ЭҮНХ-ийг "Хүйтэн дайны үлдэгдэл бөгөөд эдийн засгийн хөгжил, хүний эрх, ардчиллыг бэхжүүлэх үйл явцад томоохон саад тотгор болж байна" гэж дүгнэсэн[62] нь нэг талаас хөдөлгөөнийг хурц шүүмжилсэн хэрэг боловч, нөгөөтээгүүр түүний олон улсын харилцаанд үзүүлж буй жин нөлөөг тодорхой хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн үнэлгээ гэж үздэг.

"Хүйтэн дайн"-ы дараах шинэ нөхцөл байдалд хөдөлгөөний зүгээс үйл ажиллагаандаа баримтлах зарчим, ажлын арга хэлбэрийг нарийвчлан тодорхойлохын чухлыг гишүүн орнууд нийтээр онцлон тэмдэглэж ирсэн. ЭҮНХ-нийг хөгжиж буй орнуудын улс төр, аюулгүй байдлыг хамгаалагч хүч байлгаж, тэдний хөгжлийн зорилтыг хангах, чингэхдээ олон талт дипломат үйл ажиллагааны гол төв болсон НҮБ-ыг тууштай дэмжих, түүний Дүрмийн зорилго, зарчмуудыг хамгаалан хөгжүүлэх, олон улсын хууль эрх, хэм хэмжээг дээдлэх явдлыг өөрийн зорилт болгон тавих хандлага улам бүр бэхжиж байна.

Сүүлийн жилүүдэд ЭҮНХ-ийг шинэчлэх, үйл ажиллагааны арга хэлбэрийг сайжруулан бэхжүүлэх чиглэлд багагүй анхаарч зарим тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа. Тухайлбал, 1996 онд Картагенад болсон ЭҮНХ-ний Аргачлалын асуудлаарх сайд нарын түвшний хорооны уулзалтаас хөдөлгөөний үйл ажиллагааны аргачлалын тухай Баримт бичиг, 2003 онд Куала Лумпурт болсон Дээд хэмжээний 13 дугаар уулзалтаас ЭҮНХ-ий өөрчлөлт шинэчлэлтийг үргэлжлүүлэх тухай Тунхаглал, 2006 онд Гавана хотноо болсон 14 дүгээр

[62] P.5 - "American interests and UN reform" report of the Task force on United Nations – United States Institute of Peace, Washington D.C., 2006

уулзалтаас Олон улсын өнөөгийн нөхцөл дэх ЭҮНХ-ий зорилго, зарчим, үүргийн талаарх Тунхаглалыг тус тус баталж гаргасан.

ЭҮНХ нь улс төрийн хувьд АНУ, Өрнөдийн орнуудтай зөрчил тэмцэлтэй, харилцааны шийдвэрлэгдээгүй асуудлуудтай БНАСАУ, Куба, Иран зэрэг улсууд, Сингапур, Чили зэрэг АНУ-ын холбоотнууд, Энэтхэг, Пакистан, Египет, Өмнөд Африк зэрэг дэлхийд нэр нөлөө нь өсөж буй, эдийн засаг хөгжлийн хувьд нэн буурайгаас хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнууд зэрэг янз бүрийн бүлэг улсуудаас бүрдсэн тул асуудал бүрээр нэгдмэл байр суурьт тэр бүр хүрч чадахгүй байх нь ойлгомжтой бөгөөд энэ нь хэвийн үзэгдэл гэж үздэг. Тиймээс ч гишүүн орнуудыг хувааж байгаа асуудалд биш, харин тэднийг нэгтгэж байгаа асуудалд анхаарлаа төвлөрүүлэх замаар хөдөлгөөний гишүүн орнуудын нэгдлийг улам бэхжүүлэх ёстой гэсэн хандлага илүү давамгайлж байгаа болно.

ЭҮНХ-ий үйл ажиллагаанд дарга улс чухал үүрэгтэй байдаг. Хөдөлгөөний бүх үйл ажиллагааг зангидах, түүний нэрийн өмнөөс үг хэлэх, хөдөлгөөнийг олон улсын хурал зөвлөгөөнд төлөөлөх, бодлогын баримт бичгүүдийн төслийг боловсруулах зэрэг нь даргаас нөр их хүч хөдөлмөр, ур чадвар шаардахын сацуу хөдөлгөөний байр суурийг тодорхойлоход нөлөөлөх боломж олгодгоороо онцлог. Тийм ч учраас ЭҮНХ-ний даргаар ямар улс ажиллаж буйгаас түүний нэр хүнд, төлөв байдал ихээхэн хамаарах байдал ажиглагддаг.

2016 оны 9 дүгээр сард Венесуэл улс ЭҮНХ-ий даргын буухиаг Иранаас аван даргаар ажиллаж байна. Тус улс 2016 оны 9 дүгээр сард Маргарита аралд ЭҮНХ-ийн Дээд хэмжээний 17 дугаар уулзалтыг зохион байгуулсан. ЭҮНХ-ийн Дээд түвшний 18 дугаар уулзалт 2019 онд Азербайжан улсад болно.

Ýâñýëä ¿ë íýãäýõ áîäëîãî ãýäýã íü ер нь àëèâàà нэг ýâñýë, холбоонд нэгдэхгүй  ãýñýí óòãàòàé áèø, õàðèí èõ ã¿ðí¿¿äèéí цэрэг, улс төрийн ºðñºëäºººíä õàìààðàëòàé эвсэлд оролцохгүй байх, үүний тулд  íèéòèéí àøèã òóñ, ÍÝÁ-ûí Ä¿ðìèéí çàð÷ìûã äýìæèí, èäýâõòýé õàíäàõ байр ñóóðèéã баримтлахад оршиж байна. Өөрөөр хэлбэл, ÝYÍÕ-ийн  ºìíºº òàâüñàí çîðèëãî íü îëîí óëñûí õàìòûí àþóëã¿é áàéäëûí тогтолцооны óëñ òºð, ýðõ ç¿éí ¿çýë áàðèìòëàëûã үндэслэлээ болгосон  ãýæ õýëæ болох юм.

ÝYÍÕ õýäèéãýýð олон улсын байгууллага áèø áîëîâ÷ ººðèéí ¿éë àæèëëàãààíû íýëýýä áîëîâñîðñîí ìåõàíèçìòàé, óëàì бүр өссөөр áàéãàà íºëºº á¿õèé õ¿÷ þì. Òºð,

çàñãèéí òýðã¿¿í íàðûí õóðàë íü 3 æèë òóòàì õóðàëäààã. Ãàäààä õýðãèéí ñàéä íàðûí õóðàë íü á¿òýí õààñí æèë òóòàìä áîëæ äýýä хэмжээний óóëçàëòûí áýëòãýëèéã õàíãàõ, øèéäâýðèéã íü áèåë¿¿ëýõ àæëûã õÿëýëöäýã. 74 îðíû òºëººëºã÷ººñ á¿ðäñýí çîõèöóóëàõ òîâ÷îî íü Íüþ-Éîðêò áàéðëàäàã áºãººä öàã ¿åèéí чухал àñóóäëûã õýëýëöýõýýñ ãàäíà НҮБ-ын Åðºíõèé Àññàìáëåéí ÷óóëãàíû ¿åýð ÝYÍÕ-íèé ãàäààä õýðãèéí ñàéä íàðûí óóëçàëòûã çîõèîí áàéãóóëàõ, Àþóëã¿éí зөвлөлийн ãèø¿¿í, ýâñýëä íýãäýýã¿é îðíóóäûí á¿ëýãòýé àæèë òºðëèéí харилцаатай байх àæëûã ã¿éöýòãýäýã.

ÝYÍÕ-ийн ãèø¿¿í îðíóóä ìàðãààíûã ýâ ç¿éãýýð øèéäâýðëýõ, çýâñýãëýëýýð õººöºëäºõèéã çîãñîîõ, çýâñãèéã á¿õ íèéòýýð îëîí óëñûí õàòóó õÿíàëòòàéãààð õóðààõ, öºìèéí áîëîí ¿é îëîîð õºíººõ áóñàä çýâñãèéã õîðèãëîõ óñòãàõ, îëîí óëñûí ýäèéí çàñãèéí øóäðàãà äýã æóðàì òîãòîîõ  çýðýã îëîí ÷èãëýëýýð ÍYÁ-ûí õ¿ðýýíä òîãòîîë ñàíàë, ñàíàà÷èëãûã äýâø¿¿ëæ, òýäãýýðèéã õýðýãæ¿¿ëýõèéí òºëºº ºðèéí ÷àðìàéëòûã èäýâõæ¿¿ëæ èðñýí байна. Ýíý õºäºëãººíèé äýýä áîëîí ºíäºð õýìæýýíèé óóëçàëòóóä, òýäãýýðèéí àêòóóä íü ýíõ òàéâàí, àþóëã¿é áàéäëûí òàëààð олон улсын эрх зүйд øèíý çàð÷èì, õýì õýìæýýã áîëîâñðóóëàí нэвтрүүлэхэд ¿íýòýé õóâü íýìýð îðóóëæ áàéãàà þì. ªºðººð õýëáýë, ÍYÁ-ûí Дүрмийн çàð÷èì, çîðèëãûã îëîí óëñûí õàðèëöààíä íýâòð¿¿ëýõ, олон улсын эрх зүйг õºãæ¿¿ëýõ õýðýãò ýíý õºäºëãººí ÷óõàë ¿¿ðýã ã¿éöýòãýæ áàéãàà болно. Îëîí óëñûí ýäèéí çàñãèéí õàðèëöààã òýãø ýðõ, øóäðàãà ¸ñ, õàðèëöàí àøèãòàé áàéõ ¿íäñýí äýýð ÿâóóëàõ íü á¿õ íèéòèéí àþóëã¿é áàéäàë, õºãæèë äýâøèëèéí ¿íäñèéã ýãíýãò áàòàòãàõ ãîë íºõöºë íü ãýæ ÝYÍÕ мөн ¿çäýã þì.

Ýâñýëä íýãäýýã¿é îðíóóäûí òºð, çàñãèéí òýðã¿¿í íàðûí удаа дараагийн уулзалтуудаас ãàðãàñàí áàðèìò бичгүүдэд äýýðõ çàð÷èì, çîðèëãûã байнга нотолдог бөгөөд олон улсын эрх зүйг á¿ðýí õ¿íäýòãýõ, õ¿í õ¿÷íèé íººöèéã õºãæ¿¿ëýõ, õ¿íèé á¿õ ýðõ, ¿íäñýí ýðõ ÷ºëººã õàìãààëàí òýòãýõ, төр, нийгмийн байгууллын ÿìàð á¿ðèéí тогтолцоо, íèéãýì áîëîí ñî¸ë çýðýãöýí îðøèõ ÿâäëûã õàíãàõ çîðèëãûã öîõîí òýìäýãëýñýí байдаг

**Монгол Улсын оролцоо.** Манай улс ЭҮНХ-д 1986 онд зочноор, 1988 онд ажиглагчаар оролцож, 1991 онд гишүүнээр элссэн[63].

Ìîíãîë óëñ ýâñýëä ¿ë íýãäýõ áîäëîãûã ýõíýýñ íü äýìæèæ èðñýí áºãººä 1970-ààä îíîîñ óã õºäºëãººíèé õóðàë чуулганд оролцож ирсэн байна. 1986 îíîîñ óã õºäºëãººíèé

63 ГХЯ. Монгол Улсын гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм.1911-2011. УБ, 2011

äýýä õýìæýýíèé õóðàëä àæèãëàã÷ààð  îðîëöîæ 1989 îíä ò¿¿íèé ãèø¿¿í íü áîëñîí юм. Õºãæèæ áàéãàà îðíóóäòàé íàéðñàã õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õî¸ð òàëûí õ¿ðýýíýýñ ãààíà ÝYHX, түүний «77»-èéí á¿ëýãò õàðèëöàí àæèëëàõ çàìààð õýðýãæ¿¿ëýõèéã Ìîíãîë Óëñûí ãàäààä áîäëîãûí ¿çýë áàðèìòëàëä íýã ÷óõàë çîðèëò áîëãîí çààñàí байдаг.

1986, 1989, 1992 онд болсон ЭҮНХ-ий Дээд хэмжээний 8, 9, 10 дугаар уулзалтад Гадаад хэргийн сайдын түвшинд оролцсон. 1995 онд Колумбийн Картагена хотноо болсон Дээд хэмжээний 11 дүгээр уулзалтад Гадаад харилцааны сайд Монгол Улсын Ерөнхийлөгчийн бие төлөөлөгчөөр, 1998 онд ӨАБНУ-ын Дурбан хотноо болсон Дээд хэмжээний 12 дугаар уулзалтад НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгч Ерөнхийлөгчийн тусгай төлөөлөгчөөр тус тус оролцсон. Харин 2003 онд Малайзийн нийслэл Куала Лумпур хотноо болсон ЭҮНХ-ий Дээд хэмжээний 13 дугаар уулзалтад Ерөнхий сайдын, 2006 онд Гаванад болсон 14 дүгээр уулзалтад Ерөнхийлөгчийн түвшинд, 2009 онд Египетийн Шарм Эль Шейх хотноо болсон 15 дугаар уулзалтад Шадар сайдын түвшинд, 2012 онд Ираны Тегеран хотноо болсон 16 дугаар уулзалтад Ерөнхийлөгчийн түвшин, 2016 онд Венесуэлийн Маргарита аралд болсон 17 дугаар уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгчийн бие төлөөлөгчийн түвшинд оролцсон болно.

Манай улс ЭҮНХ-ний гишүүн болж, үйл ажиллагаанд оролцох болсон нь бие даасан, нээлттэй, олон тулгуурт гадаад бодлого явуулах чигт хийсэн нэг чухал алхам байсан бөгөөд гадаад бодлогынхоо зорилтуудыг таниулах, урагшлуулах бас нэг сувагтай болсон юм. Чингэхдээ ЭҮНХ-ний зорилго, зарчмуудыг хүндэтгэн олон улсын харилцаанд түүний гүйцэтгэх үүргийг бэхжүүлэх талаар бусад гишүүн орнуудаас гаргаж буй хүчин чармайлтыг дэмжиж хамтран ажиллаж ирсэн.

Мөн гадаад бодлогын зорилтуудаа урагшлуулахад ЭҮНХ-ний зүгээс дэмжлэг туслалцаа авч ирсэн. Тухайлбал, НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд манай улсын санаачлан авч явдаг цөмийн зэвсэггүй статусаа бататган бэхжүүлэх, далайд гарцгүй хөгжиж буй орнуудын байр суурийг урагшлуулах, нүүдлийн соёл иргэншлийг судлах, хамгаалах, ардчиллыг төлөвшүүлэн бэхжүүлэх, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, нийгмийн хөгжилд хоршооллын гүйцэтгэх үүргийг дээшлүүлэх, хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах зэрэг асуудлаар холбогдох заалтуудыг ЭҮНХ-ний дээд болон бусад хурлын төгсгөлийн баримт бичигт тусгаж, хамтран ажиллаж иржээ.

Манай улсын эвсэлд үл нэгдэх бодлогын эрх зүйн үндэс нь Монгол Улсын хууль, тогтоомж, бодлогын зарим баримт бичигт тусгагдсан доорх зүйл, заалтуудаар тодорхойлогдож байна. Үүнд:

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр зүйлийн 3-т "Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ байрлуулах, дамжин өнгөрүүлэхээр улсын хил нэвтрүүлэхийг хориглоно"; анх 1994 онд УИХ-ын тогтоолоор батлагдаж 2011.02.10-ны 10 дугаар тогтоолоор шинэчлэгдсэн Гадаад бодлогын үзэл баримтлалын 11-д "Монгол Улсад гадны цэргийн аюул занал учраагүй нөхцөлд цэргийн аливаа холбоонд нэгдэхгүй, нутаг дэвсгэр, агаар мандлаа аль нэг улсын эсрэг ашиглуулахгүй байх, гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх чиг шугам баримтална"; 1998.01.08-нд батлагдсан Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Дайсагнагч талууд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулаагүй бол тэдгээрийн аль нэгний цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэхийг хориглоно" ; 2000.02.03-нд батлагдсан Цөмийн зэвсгээс ангид байх тухай хуулийн 4 дүгээр зүйлд "4.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хувь хүн болон хуулийн этгээд, гадаад улс цөмийн зэвсэгтэй холбогдсон дараах үйлдэл, үйл ажиллагааг явуулах, санаачлан хэрэгжүүлэх буюу хэрэгжүүлэхэд оролцохыг хориглоно: 4.1.1. цөмийн зэвсгийг боловсруулах, үйлдвэрлэх буюу бусад аргаар олж авах, эзэмших, хяналтдаа байлгах; 4.1.2. цөмийн зэвсгийг байрлуулах буюу аливаа хэрэгслээр тээвэрлэх; 4.1.3. цөмийн зэвсгийг турших буюу хэрэглэх; 4.1.4. цөмийн зэвсгийн гаралтай тусгай ангиллын цацраг идэвхт материал, шаар болон аюултай хог хаягдлыг булшлах буюу устгах. 4.2. Цөмийн зэвсгийн зориулалтаар ашиглахаар бэлтгэгдсэн буюу үйлдвэрлэгдсэн цөмийн зэвсгийн эд анги, бүрэлдэхүүн, хаягдал болон эд зүйлийг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглоно"; УИХ-ын 1998.05.15-ны 56 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн цэргийн бодлогын үндсийн II хэсэгт "Цэргийн хүч хэрэглэх болон хэрэглэхээр заналхийлэх нь маргаантай асуудлыг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийг хүлээн зөвшөөрөхгүй; өөр улсын эсрэг ямар ч тохиолдолд цэргийн хүчээ түрүүлж хэрэглэхгүй, цэргийн аюул, заналхийлэл бусдад учруулахгүй, бусдын зэвсэгт түрэмгийлэлд өөрөө өртсөнөөс бусад тохиолдолд дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй. НҮБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг, сайн санааны туслалцаа үзүүлэх,

зуучлах, эвлэрүүлэх талаар хүлээсэн үүргээ НҮБ-ын Дүрмийн дагуу биелүүлнэ. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн аюул, заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй. Монгол Улсын хуульгүйгээр гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлэхгүй, байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх бодлогыг чанд баримтална” гэж тус тус заасан байна[64].

**Тулгамдсан асуудал, цаашдын хандлага.**

Олон улсын аюулгүй байдлын эрх зүйд эвсэлд үл нэгдэх болон төвийг сахих бодлого, үйл ажиллагааны үед үүсэх харилцааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох асуудал байнга анхаарлын төвд байсаар ирсэн байна.

Ýâñýëä ¿ë íýãäýõ áîäëîãûã òºâèéã ñàõèõ áîäëîãîòîé àäèëòãààæ бас áîëîõã¿é юм. Òºâèéã ñàõèõ áîäëîãî äýýð ¿åýñ óëàìæëèëæ èðñýí áºãººä äàéíû ¿åä àëü ÷ òàëä îðîõã¿é, ººðèéãºº дайны хөлд ºðòººõã¿é áàéõ áàéð ñóóðèàñ ¿¿ñýëòýé þì. Өрөөр хэлбэл төвийг сахих áîäëîãî íü улс хоорондын бүх харилцаанд äóíäûã áàðèìòëàõ áàéð ñóóðü бас áèø юм. XIX çóóíû äóíäààñ òºâèéã áàéíãà ñàõèõ áîäëîãî á¿ðýëäýí òîãòñîí байдаг[i]. Энэ нь өөрөө íýðâýãäýýã¿é öàãò àëèâàà äàéíä îðîëöîõûã цаг ÿìàãò öýýðëýõ çàð÷èì äýýð ¿íäýñëýñýí байна. Òºâèéã áàéíãà ñàõèääã óëñóóä öýðãèéí ýâñýëä îðîëöîõã¿é, ýíõ àìãàëàí áàéõ áîäëîãî ÿâóóëäàã ó÷èð îëîí óëñûí àþóëã¿é áàéäëûã áýõæ¿¿ëýõ õýðýãò áàñ ÷óõàë ¿¿ðýã ã¿éöýòãýäýã. Àâñòðè, Швейцар, Туркмен зэрэг хэд хэдэн óëñ байнгын òºâèéã ñàõèõ áîäëîãî ÿâóóëäàã áºãººä òýäãýýðèéã ñòàòóñûã îëîí óëñûí áîëîí ¿íäýñíèé хэмжээний холбогдох àêòààð баталгаажуулсан байна. Жишээлбэл, Øâåéöàðûí ñòàòóñûã 1815 îíû îëîí óëñûí àêòààð, Àâñòðèéíõûã энэ улсын 1955 îíû Үндсэн õóóëèàð, Туркменистаныхыг 1995 оны НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоолоор тус тус баталгаажуулжээ.

Төвийг сахих гэдэг нь “neuter” (дундаж) гэсэн латин үгнээс гаралтай бөгөөд дайн байлдаанд оролцохгүй, энхийн цагт цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байхад чиглэсэн гадаад бодлогын статус юм. Төвийг сахих статус нь дайны үед төвийг сахих, байнга төвийг сахих гэсэн хоёр хэлбэртэй байдаг байна. Дайны үед төвийг сахисан улс нь дайн байлдаанд оролцохгүй, дайтагч талуудад туслахгүй, нутаг дэвсгэрээ ашиглуулахгүй, тэдгээртэй адил тэнцүү харилцах үүрэгтэй байдаг.

[64] Legalinfo.mn

Байнга төвийг сахисан улс нь дайн байлдаанд оролцохгүй байхаас гадна энхийн цагт бусад улсын эсрэг хүч хэрэглэхгүй, дайн эхлүүлэхгүй, цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй, гадаадын цэргийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх зэрэг үүрэг хүлээдэг. Төвийг сахисан улс гадны халдлагад өртвөл өөрийгөө хамгаалах болон бусад улс, НҮБ-аас тусламж хүсэх эрхтэй байдаг байна.

XIX зуунд төвийг сахих статусыг олон улсын гэрээгээр тогтоож байсан бөгөөд энэ нь дайны дараа энхийн хэлэлцээр байгуулж байсантай холбоотой. 1815 онд Венын их хурлын тунхаглалаар Швейцарт, 1831, 1839 оны Лондоны гэрээгээр Бельгид, 1867 оны Лондоны гэрээгээр Люксембургт, 1885 оны Берлиний гэрээгээр Конгод тус тус төвийг сахих статус олгосон (эдгээрээс Швейцар төвийг сахих статустайгаа үлдсэн). Харин Ватикан 1929 онд, Мальт 1983 онд тус тус Италитай гэрээ байгуулж төвийг сахих статустай болсон.

Швед 1834 онд төвийг сахихаа өөрөө тунхагласнаас хойш улс орнууд төвийг сахихаа дангаараа тунхаглан тогтоож байна. Лихтенштейн 1868 онд тунхаглал, Коста-Рика 1949 онд тунхаглал, Австри 1955 онд хууль, Камбож 1957 онд хууль, Лаос 1962 онд тунхаглал, Украин 1990 онд тунхаглал, Туркменистан 1995 онд хууль гаргаж тус тус төвийг сахихаа тунхагласан.

Дэлхийн хоёр дайнд хэд хэдэн улс төвийг сахиж оролцоогүй. Өнөөдрийн байдлаар Австри, Ватикан, Ирланд, Коста-Рика, Лихтенштейн, Мальт, Туркменистан, Финланд, Швед, Швейцар нь төвийг сахисан маягийн улс болно (гэхдээ Европын холбооны гишүүн болсон Австри, Ирланд, Мальт, Финланд, Шведийн төвийг сахих статус маргаантай асуудал болоод байна).

Дангаараа тунхагласан төвийг сахих статусыг бусад улс хүлээн зөвшөөрөх эс зөвшөөрөх нь тухайн орны асуудал байдаг. Тухайлбал Мексик 1930, Молдова 1994, Серби 2007, Гана 2012 онд төвийг сахихаа тунхагласан ч хөрш зарим орон нь хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мэдэгдсэн ажээ. Австри, Коста-Рика, Лихтенштейн, Шведийн хувьд ийм асуудал гараагүй, харин Туркменистан 1995 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоол гаргуулж хүлээн зөвшөөрүүлсэн.

Олон улсын эрх зүй нь төвийг сахих статусыг хүлээн зөвшөөрдөг. Дайны үед төвийг сахих статусыг олон улсын эрх зүйгээр, тухайлбал Хуурай замын дайны үед төвийг сахисан улс, этгээдийн эрх, үүргийн тухай 1907 оны Гаагийн V конвенц, Тэнгисийн дайны үед төвийг сахисан улсын эрх, үүргийн тухай 1907 оны Гаагийн

XIII конвенцээр зохицуулдаг. 1910 онд хүчин төгөлдөр болсон эдгээр конвенцэд ОХУ, БНХАУ, АНУ, Герман, Япон, Франц зэрэг 37 улс оролцдог.

Харин байнга төвийг сахих статусыг олон улсын эрх зүйгээр зохицуулаагүй, өөрөөр хэлбэл байнга төвийг сахих статуст юу хамаарах, хэрхэн тогтоох, бусад улсаар хүлээн зөвшөөрүүлэх шаардлагатай эсэхийг зохицуулсан олон улсын эрх зүйн баримт бичиг одоогоор байхгүй байна. Иймд байнга төвийг сахих статусыг улс орнууд өөрсдийн үзэмжээр өөр өөрөөр тодорхойлж тогтоодог ч энхийн цагт бусад улсын эсрэг хүч хэрэглэхгүй, дайн эхлүүлэхгүй, цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй, гадаадын цэргийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, гадныг халдлагад өртвөл өөрийгөө хамгаалах эрхтэй байх зэрэг нь нийтлэг зарчим болж байна. Дайны үеийн эрх, үүргийг нь Гаагийн V, XIII конвенцээр зохицуулдаг тухай дээр өгүүлсэн бөгөөд байнга төвийг сахихаа зарласан улс эхлээд эдгээрт нэгдэн орох шаардлагатай байдаг жишээтэй.

Ìîíãîë Óëñûí òºð çàñàã ÷ ¿¿íèéã àíõààðëûíõàà òºâä áàéëãààæ, эхний алхам болгож энхийг эрхэмлэсэн гадаад бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ õ¿÷íèé ¿éë àæèëëàãààíä îðîëöîõ àñóóäëûã òºðèéí öýðãèéí áîäëîãîîî òóñãààí Çýâñýãò õ¿÷íèé òàéâàí öàãèéí íýã  ¿¿ðýã áîëãîí õóóëü÷ëàí áàòàëãààæóóëæ, õýðýãæ¿¿ëæ ýõëýýä áàéíà.

### 3.2. Батлан хамгаалах бодлогын геостратегийн агуулга

#### 3.2.1. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа.

**Эрх зүйн үндэс.** Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа нь УИХ-аар 2015 онд батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичиг тусгагдсан “Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр, дипломатын аргыг урьтал болгох бөгөөд гадны зэвсэгт түрэмгийллийн эсрэг цэргийн хүчийг ашиглана” гэсэн гол үзэл санаанд тулгуурлан хэрэгжиж байгаа юм.

Ингэхдээ энэ харилцааг  Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлалаас урган гарсан дараах үндсэн зарчмуудад нийцүүлэн явуулж байна. Үүнд:

- Хөрш орнуудтай олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, бүс нутагт цэргийн итгэлцлийг бэхжүүлэх үйл явцад дэмжлэг үзүүлэх;
- Цэргийн хүч хэрэглэх болон хэрэглэхээр заналхийлэхийг зөрчил, маргааныг шийдвэрлэх арга зам гэж үзэхгүй бөгөөд аливаа хүчирхийлэл, түрэмгийллийг үл зөвшөөрөх;
- Олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох;
- Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд цэргийн аюул, заналхийлэл учирсан буюу учрах нь бодитой болсноос бусад тохиолдолд цэргийн аливаа эвсэл холбоонд нэгдэхгүй;
- Нутаг дэвсгэрээ хөрш болон бусад орны эсрэг чиглэсэн цэргийн үйл ажиллагаанд ашиглуулахгүй, үй олноор хөнөөх зэвсгээс ангид байлгах;
- Гадны зэвсэгт түрэмгийлэлд өртөхөөс бусад тохиолдолд дайн, зэвсэгт мөргөлдөөнд оролцохгүй байх;
- Хууль гаргахгүйгээр гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй байх;
- Үй олноор хөнөөх зэвсгийн тархалтыг хязгаарлах, олон улсын терроризмтой тэмцэх чиглэлээр Нэгдсэн Үндэстний Байгууллага, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх.

Үүний зэрэгцээ Монгол Улс Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, хүн ам, иргэдийн аюулгүй байдалд цэргийн хүчээр заналхийлсэн, зэвсэгт түрэмгийлэл үйлдсэн улс болон улс бус этгээд тэдний түрэмгийллийн хамсаатныг дайсан гэж үзэх бөгөөд үүнтэйгээ уялдуулан .дараах нөхцөл байдлыг өөрийн эсрэг чиглэсэн зэвсэгт түрэмгийлэл гэж үзэхээ мөн зарласан байдаг.

Эдгээр нь төрийн тусгаар тогтнол, газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хамгаалахын тул Зэвсэгт хүчнээ дангаараа, эсвэл НҮБ-ын дүрэмд заасны дагуу бусад улсын тусламжтайгаар хамгаалах эрх зүйн үндэслэлийг бүрдүүлж байгаа хэрэг юм. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр халдан довтлох, цөмрөн орох;
- Хилийн гаднаас улсын болон цэргийн объектод зэвсгийн хүчээр цохилт хийх;
- Гадаад улсын цэргийн хүчин Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах, дамжин өнгөрөхдөө энэ тухай Монгол Улсын хуулийг зөрчих;

- Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу газар ашиглаж байгаа_гадаадын этгээд ашиглаж байгаа газраа зэвсэгт түрэмгийллийн зорилгоор ашиглах, бусдад ашиглуулах;
- Тусгайлан бэлтгэгдэж, зэвсэглэсэн хүмүүсийг зохион байгуулалттайгаар Монгол Улсад нэвтрүүлэх, улмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт террорист ажиллагаа явуулах, нийтийг хамарсан үймээн самуун дэгдээх;
- Аль нэг улсын дотоодын зэвсэгт мөргөлдөөнд оролцогч талууд Монгол Улсын хилийг зөрчих, цөмрөн орох.

Гэхдээ гадны цэргийн аюул учирсан нөхцөлд зэвсэгт хүчин түрэмгийллийг саатуулан няцааж, улс орны удирдлагад улс төр, дипломатын идэвхтэй үйл ажиллагаа явуулах боломж бүрдүүлэх нь төрийн батлан хамгаалах бодлогын үндэс болдог юм.

**Үйл ажиллагааны үндсэн чиглэл, агуулга, арга хэлбэр.** Áàòëàí õàìãààëàõûí ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã Ìîíãîë Óëñûí ¯íäñýí õóóëü, Ìîíãîë Óëñûí Àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàë, Ãàäààä áîäëîãûí ¿çýë áàðèìòëàë, Òºðèéí öýðãèéí áîäëîãûí ¿íäýñ, áóñàä áàðèìò áè÷èã áîëîí òýäãýýðòýé íèéö¿¿ëýí ãàðãàñàí ýðõ ç¿éí àêòûí õ¿ðýýíä явуулж  байна. Ингэхдээ Ìîíãîë Óëñûí Àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëä òîäîðõîéëñîí ¿íäñýíèé ÿçãóóð àøèã ñîíèðõîë, Ãàäààä áîäëîãûí ¿çýë áàðèìòëàëä çààñàí òóëãóóð çàð÷ìóóäûã áàòëàí õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õýðýãæ¿¿ëýõýä óäèðäëàãà болгож байгаа юм.

Áàòëàí õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà íü Ìîíãîë Óëñûí òºðèéí ãàäààä áîäëîãûí á¿ðýëäýõ¿¿í õýñýã áºãººä õºðø áîëîí äýëõèéí áóñàä îðíóóäòàé õàðèëöàí îéëãîëöîë, öýðãèéí èòãýëöýë, íºõºðëºëèéã áýõæ¿¿ëýõ, Ìîíãîë Óëñûí Çýâñýãò õ¿÷íèé øèíý÷ëýëèéí çîðèëòûã õýðýãæ¿¿ëýõýä ÷èãëýñýí öýðãèéí áîëîí öýðã-òåõíèêèéí õàìòûí àæèëëàãààíààñ бүрддэг болно. Үүний дотор цэргийн õàìòûí àæèëëàãàà íü öýðãèéí àòòàøå õàðèëöàí ñóóëãàõ, öýðãèéí ìýðãýæëèéí àëáàí õààã÷äûã ñóðãàõ, õàðèëöàí àéë÷ëàë õèéõ, öýðãèéí ñàëáàðò õàìòðàí àæèëëàõ ãýðýý, ïðîòîêîë áàéãóóëàõ, õàìòàðñàí äààëãàâàð, ñóðãààëò çîõèîí áàéãóóëàõ, ìýäýýëýë ñîëèëöîõ ãýõ ìýò öýðãèéí èòãýëöëèéã áýõæ¿¿ëýõýä ÷èãëýñýí õî¸ð áîëîí îëîí òàëò ¿éë ажиллагааны хэлбэрээр явагдаж байна.

Öýðãèéí õàìòûí àæèëëàãààíä äýëõèéí îðíóóäàé õàðèëöàí îéëãîëöîë, öýðãèéí èòãýëöëèéã áýõæ¿¿ëæ, õàìòûí àæèëëàãààíû àðãà õýëáýðèéã õî¸ð áîëîí îëîí òàëûí ýðõ ç¿éí áàðèìò áè÷ãýýð áàòàëãààæóóëàí, õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõ çàìààð óëñ îðíû àþóëã¿é áàéäëûí ãàäààä òààòàé îð÷íîã á¿ðä¿¿ëýõ çîðèëòûã ýðõýì болгодог. Öýðýã-òåõíèêèéí õàìòûí àæèëëàãààíä òóñãàéëàí òîõèðîëöñîí ýðõ ç¿éí àêòûí õ¿ðýýíä  çýâñýã, áàéëäààíû òåõíèê àâàõ, àðèëæàõ, çàñâàðëàõ, øèíý÷ëýõ, òóõàéí çýâñýã, áàéëäààíû òåõíèêèéã àøèãëàõàä öýðãèéí àëáàí õààã÷äûã ñóðãàõ çýðýã ¿éë àæèëëàãàà багтаж байгаа юм.

Öýðýã-òåõíèêèéí õàìòûí ажиллагааны гол зорилго нь Çýâñýãò õ¿÷íèé çýâñýãëýë áàéãàà çýâñýã, áàéëäààíû òåõíèêèéã ñýðãýýí çàñâàðëàõ, øèíý÷ëýõ, äýâøèëòýò çýâñýã, áàéëäààíû òåõíèêèéã çýâñýãëýë íýâòð¿¿ëýõ явдал юм

Áàòëàí õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà нь одоогоор дараах хэлбэрүүдээр хэрэгжиж байна. Үүнд:

- öýðýã-óëñ òºðèéí áîëîí àþóëã¿é áàéäëûí;
- öýðýã-òåõíèêèéí áîëîí öýðãèéí àæ ¿éëäâýðèéí;
- öýðãèéí ìýðãýæëèéí áîëîâñðîë õ¿÷èí ñóðãàëòûí;
- îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ àæèëëàãààíû;
- îëîí óëñûí òåððîðèçìòýé òýìöýõ;
- èðãýíèé õàìãààëàëòûí;
- ìýäýýëýë, ñóäàëãààíû;
- øèíæëýõ óõààí, öýðãèéí ýðäýì øèíæèëãýýíèé;
- öýðãèéí àð òàëûí;
- öýðãèéí ýìíýëãèéí;
- öýðãèéí ñïîðò, ñî¸ë óðëàãèéí çýðýã õýëáýð¿¿ä áàéíà.

Эцсийн дүндээ Ìîíãîë Óëñûí áàòëàí õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà íü áàòëàí õàìãààëàõ íýãäìýë òîãòîëöîîã á¿ðä¿¿ëýõ, öýðãèéí áàéãóóëàëòûã îëîí óëñûí æèøèãò õ¿ðãýõ, òàéâàí öàãèéí áîëîí äàéíû ¿åä ã¿éöýòãýõ ¿¿ðýãòýý çîõèöñîí á¿òýö, çîõèîí áàéãóóëàëò á¿õèé öîìõîí, ÷àäâàðëàã, ìýðãýæëèéí ÷èã áàðèìæààòàé  Çýâñýãò õ¿÷èíòýé áàéõ ãàäààä òààòàé íºõöëèéã á¿ðä¿¿ëýõýä òóñ äºõºì болоход чиглэж байдаг болно.

Óëñ îðíû ýäèéí çàñãèéí бодит байдал, нөхцөл бололцоог харгалзан áàòëàí õàìãààëàõ çîðèëòóóäûã àìæèëòòàé øèéäâýðëýõýä áàòëàí õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã чиглүүлж байгаа бөгөөд ингэхдээ Áàòëàí õàìãààëàõ ÿàì íü Ãàäààä õýðãèéí áîëîí õîëáîãäîõ áóñàä ÿàìòàé ¿éë àæèëëàãààãàà íÿãò óÿëäóóëæ, зөвшилцөн ажиллаж байгаа юм.

Батлан õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöàà, õàìòûí ажиллагааг хэрэгжүүлэхдээ тодорхой улс орнуудын хувьд ялгаатай хандаж үүн дээрээ тулгуурлан ¿íäñýí чиглэлүүдийг òîäîðõîéëæ байгаа нь энэ харилцаа, хамтын ажиллагааны нэг онцлог юм. Үүнд:

- Òýðã¿¿ëýõ ÷èãëýë íü Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäàë øóóä áîëîí äàì íºëºº ¿ç¿¿ëæ áîëîõ óëñ îðíóóäòàé áàòëàí õàìãààëàõ ñàëáàðò ãàäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõ ÿâäàë юм.

- À÷ õîëáîãäîëòîé ÷èãëýë íü Ìîíãîë Óëñûí Çýâñýãò õ¿÷íèé øèíý÷ëýëèéí áîäëîãûã õýðýãæ¿¿ëýõýä äýìæëýã ¿ç¿¿ëýõ, áàòëàí õàìãààëàõ ñàëáàðò õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã ìàíàé óëñòàé õºãæ¿¿ëýõèéã õàðèëöàí ñîíèðõîæ áóé äýëõèéí áîëîí á¿ñ íóòãèéí íºëºº á¿õèé óëñóóäòàé õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõ çîðèëãîòîé байдаг.

- Ñîíèðõîë òàòàæ áóé ÷èãëýëä áàòëàí õàìãààëàõ ñàëáàðò õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã öààøèä õºãæ¿¿ëæ áîëîõ ýñâýë áàòëàí õàìãààëàõ ñàëáàðò õàðèëöàà àëáàí ¸ñîîð òîãòîîñîí áîëîâ÷ õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà òºäèéëºí àìæèëòòàé õºãæèõã¿é áàéãàà îðíóóäûã багтаадаг болно.

Эдгээрт үндэслэн батлан õàìãààëàõ ñàëáàðûí ãàäààä õàðèëöààíû ÷èãëýëèéã одоогоор äàðààõü áàéäëààð тодорхойлсон байгаа. ¯¿íä:

1. Òýðã¿¿ëýõ ÷èãëýëä: ÎÕÓ, ÁÍÕÀÓ, ÀÍÓ;
2. À÷ õîëáîãäîëòîé ÷èãëýëä: ÕÁÍÃÓ, ÁÍÑÓ, ÁÍÒÓ, ÁÍÝÓ, Êàíàä Óëñ, Áåëüãèéí Âàíò Óëñ, Èõ Áðèòàíè áà Óìàðä Èðëàíäûí Íýãäñýí Âàíò Óëñ, ßïîí, Øâåéöàðèéí Õîëáîîíû Óëñ, Èòàëè Óëñ;.
3. Ñîíèðõîë òàòàæ áóé ÷èãëýëä:  Èçðàèëü, Ôðàíö Óëñ, Òàéëàíäûí Âàíò Óëñ, Ñèíãàïóð Óëñ, Íèäåðëàíäûí Âàíò Óëñ,  Ôèíëàíä, Øâåä, Ïîëüø, Êàçàõñòàí, ÒÓÕÍ-

èéí çàðèì îðíóóä, Áàëáûí Âàíò Óëñ,  Âüåòíàì.

Эдгээрээс гадна Монгол Улсын төр, засаг батлан õàìãààëàõ ñàëáàðûí ãààäààä õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõ îíöãîé à÷ õîëáîãäîëòîé ÷èãëýë íü îëîí óëñûí áàéãóóëëàãóóäòàé õàðèëöàõ ÷èãëýë хэмээн үздэг болно. Îëîí óëñûí áàéãóóëëàãààòàé õàðèëöàõ ÷èãëýë íü холбогдох баримт бичгүүдэд çààñàí÷ëàí “Í¯Á, îëîí óëñûí öýðãèéí áàéãóóëëàãà”-òàé õàðèëöàà, õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõýä голлон чиглэж байгаа юм. Түүнчлэн олон óëñûí áàéãóóëëàãààòàé õàðèëöàõ ÷èãëýëä Í¯Á-ûí õîëáîãäîõ áàéãóóëëàãóóä, ÀÑÅÀÍ-û Á¿ñèéí ÷óóëãà, Îëîí óëñûí Óëààí çàãàëìàéí íèéãýìëýã, ÍÀÒÎ-ãèéí Ýíõèéí òºë°° ò¿íøëýë, Øàíõàéí õàìòûí àæèëëàãààíû áàéãóóëëàãà áîëîí á¿ñ íóòãèéí õýìæýýíä øèíýýð áàéãóóëàãääàæ áîëîõ, ìàíàé óëñûí ¿íäýñíèé ÿçãóóð àøèã ñîíèðõîëä íèéöñýí áàéãóóëëàãóóä хамаарч áîëíî гэж үздэг болно.

### 3.2.2. Олон улсын энхийг сахиулах ажиллагаа дахь Монголын оролцоо

### Мөн чанар, учир холбогдол.

Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг сахиулах олон улсын үйл ажиллагаанд (цаашид ОУЭСА гэх) оролцох болсон нь энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах, терроризмтой тэмцэх бүх нийтийн үйлсэнд хувь нэмрээ оруулахын зэрэгцээ өөрийн батлан хамгаалах боловсон хүчнээ сургах, дадлагажуулах, олон улсын хэмжээнд нэр хүндээ бататгах зэрэг олон талын ач холбогдолтой билээ. Олон улс , бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлын идэвхгүй хэрэглэгчээс хариуцлагатай оролцогч болж байгаагийн бас нэгэн илрэл юм.

Анх 2002 онд Конгод цэргийн 2 ажиглагч илгээснээр эхэлсэн энэ ажиллагаа үндсэн хоёр ( а. НҮБ-ын мандаттай, б/ НҮБ-аас гадуур ) чиглэлээр өсөн үргэлжилж эдүгээ манай гадаад бодлогын үйл ажиллагааны  салшгүй нэг хэсэг, монголын зэвсэгт хүчний стратегийн нэг чухал ололт болон хөгжиж байна. Өнгөрсөн хугацаанд Конго, Баруун Сахаар, Өмнөд Судан, Эритрей, Гүрж, Сьерра Леоне, Чад, Дарфур, түүнчлэн Ирак, Афганистан, Косовод цэргийн баг, ажиглагч г.м. давхардсан тоогоор нийт  15000 гаруй хүнээ илгээж оролцуулсан. НҮБ-д цэрэг хандивлагч орнуудын дунд 2016 оны 9 дүгээр сарын үзүүлэлтээр 30 дугаарт

жагсаж байв[65]. /зарим мэдээгээр манай улс идэвхтэй зэвсэгт хүчний хэмжээгээр дэлхийд 43-т орж байна.

Монгол Улсын батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний шинэчлэл нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуулийн хүрээнд явагдаж буй бөгөөд Монгол Улсын цэргийн баг, цэргийн алба хаагчид НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцох явдал ч мөн ялгаагүй Олон улсын эрх зүй, Монгол Улсын төрийн бодлого, үзэл баримтлалд хүрээнд хэрэгжиж байгаа түүхэн үйл явдал юм.

Монгол Улсын Èõ Хурлаас 1998 îíä áàòëàí ãàðãàñàí “Ìîíãîë Óëñûí Òºðèéí öýðãèéí áîäëîãûí ¿íäýñ” áàðèìò áè÷èãò Çýâñýãò õ¿÷íèé òàéâàí öàãèéí íýã ÷èã ¿¿ðãèéã “Í¯Á-ûí Ýíõèéã ñàõèóëàõ ажиллагаанд ¿¿ðýã ã¿éöýòã¿¿ëýõ” ãýæ òîäîðõîéëñîí áºãººä Çýâñýãò Õ¿÷íèé òóõàé Ìîíãîë Óëñûí õóóëüä Çýâñýãò õ¿÷íèé òàéâàí öàãèéí íýã ¿¿ðýã íü “Ýíõèéã ñàõèóëàõ îëîí óëñûí õàìòûí àæèëëàãààíä îðîëöîõ” õýìýýí òîãòîîæ ºãñºí áèëýý.

Ìîíãîë Óëñûí Çàñãèéí ãàçàð 1999 îíû 7 äóãààð ñàðûí 28-íû ºäºð “Ýíõèéã ñàõèóëàõ àæèëëàãààíä îðîëöîõ òóõàé” 115 дугаар òîãòîîë ãàðãàæ, óã òîãòîîëûí íýãä¿ãýýð çààëòàä Ýíõèéã ñàõèóëàõ àæèëëàãààíä Ìîíãîë Óëñààñ ñàéí äóðûí ¿íäñýí äýýð îðîëöîõ õ¿ì¿¿ñèéã á¿ðòãýæ ñîíãîëò õèéõ çàìààð Í¯Á-òýé áàéãóóëñàí õýëýëöýýð, Í¯Á-ûí ïðàêòèê, õîëáîãäîõ íºõöë¿¿äèéí äàãóó òýäíèéã ýíõèéã ñàõèóëàõ àæèëëàãààíä îðîëöóóëàõ àðãà õýìæýý àâàõ; õî¸ðäóãààð çààëòàä Í¯Á-ûí ýíõèéã ñàõèóëàõ àæèëëàãààíä ìàíàé òàëààñ îðîëöîõ ìýðãýæèëòí¿¿äèéí áýëòãýë, áýëýí áàéäëûã õàíãàõ, îëîí óëñûí õàìòûí àæèëëàãàà, äîòîîä íººö áîëîëöîîã ò¿øèãëýí ýíõèéã ñàõèóëàã÷äûí áààçèéã áýëòãýõ àæëûã çîõèîí áàéãóóëàõ òàëààð çààæýý.

Óëìààð Ìîíãîë Óëñûí Çàñãèéí ãàçàð 1999 îíû 9 ä¿ãýýð ñàðûí 27–íèé ºäºð “Í¯Á-ûí áàéíãûí õ¿÷íèé òîãòîëöîîíä õóâü íýìýð îðóóëàõ òàëààð Í¯Á-òàé õàðèëöàí îéëãîëöñîí òóõàé ñàíàìæ áè÷èã” байгуулснаар манай Зэвсэгт õ¿÷íèé öýðãèéí àëáàí õààã÷èä Í¯Á-ûí ýíõèéã ñàõèóëàõ àæèëëàãààíä ¿¿ðýã ã¿éöýòãýõ îëîí óëñûí ýðõ ç¿éí ¿íäýñ òàâèãäñàí þì.

Èéíõ¿¿ Í¯Á-ûí ýíõèéã ñàõèóëàõ áîëîí îëîí óëñûí бусад àæèëëàãààíä Çýâñýãò õ¿÷íèéã îðîëöóóëàõ òºðèéí áîäëîãî òîãòîëöîîãîîæ, îëîí óëñûí õýìæýýíèé ýðõ ç¿éí ¿íäýñ

65 МУ-ын гадаад бодлогын хөх ном – 2016. Гадаад харилцааны яам. УБ, 2017

á¿ðäýí, Çýâñýãò õ¿÷íèé çàðèì ñàëáàðûã ýíý ÷èãëýëýýð áýëòãýæ эхэлсэн нь öýðãèéí àëáà õààã÷äûã ýíõèéã ñàõèóëàõ áîëîí îëîí óëñûí àæèëëàãààíä îðîëöóóëàõòàé õîëáîãäñîí äîòîîäûí õàðèëöààã çîõèöóóëàõ õóóëü, ýðõ ç¿éí îð÷íûã á¿ðä¿¿ëýõ эхлэл тавигдсан байна.

2000 îíä Çýâñýãò õ¿÷íýýñ àíõ óäààãàà õèëèéí ÷àíàäää ñàëàà õ¿ðòýëõ á¿ðýëäýõ¿¿í Êàçàхñòàí óëñàä îëîí óëñûí ñàëààäûí õýýðèéí ñóðãóóëüä àìæèëòòàé оролцсоноор олон улсын энхийг сахиулах ажиллагааны туршлагаас суралцах боломж нээгдсэн байна.

Монгол Улсын Их хурлаас 2002 оны 5 дугаар сарын 17-нд “Öýðýã, öàãäààãèéí àëáà õààã÷èéã Í¯Á-ûí Ýíõèéã ñàõèóëàõ áîëîí îëîí óëñûí áóñàä àæèëëàãààíä îðîëöóóëàõ òóõàé” Ìîíãîë Óëñûí хуулийг батлан гаргаснаар Ìîíãîë Óëñ Í¯Á-ûí á¿ðýí ýðõõò ãèø¿¿íèé õóâüä äàÿí äýëõèéí ýíõ òàéâíûã áýõæ¿¿ëýõ ¿éëñýä öýðãèéí õ¿÷ õàíäèâëàõ çàìààð øóóä ãàð áèå îðîëöîõ áîëîìæ òºäèéã¿é ¿¿ðýã ã¿éöýòãýõòýé õîëáîîòîé äîòîîäûí õàðèëöààã çîõèöóóëàõ àñóóäàë øèéäâýðëýãäñýí юм.

2002 оноос мөрдөгдөж ирсэн уг хуулийг 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдөр “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” Монгол Улсын хууль болгон шинэчилсэн нь өнгөрсөн хугацаанд Монголын цэргийн бие бүрэлдэхүүн НҮБ, олон улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэж зохих туршлага хуримтлуулсны үр дүн болсон юм.

Хоёр зууны заагт хуучин зөвлөлтийн буурийг сахиж үлдсэн ОХУ, шинэ дутам тусгаар тогтносон улс орон, Япон, Ойрх Дорнодын зарим оронд террорист үйл ажиллагаа идэвхжих болж, 2001 оны 9 дүгээр сарын 1-нд АНУ-д террорист халдлага болсон нь дэлхийн хамтын нийгэмлэгийг “Нийтийн терроризм”-ийн эсрэг тэмцэлд босоход хүргэснээр 1998 оноос НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бэлтгэлээ хангаж эхэлсэн Монголын цэргийн хувьд олон улсын бусад ажиллагаанд оролцох боломжийг олгож өгчээ.

Терроризмын эсрэг дэлхий нийтийн тэмцэлд Монгол Улс нэгдэж, олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд цэргийн багаа илгээснээр хүн төрөлхтний нийтлэг эрх ашиг сонирхолд хувь нэмрээ оруулсан орчин үеийн Монгол цэрэг цоо шинэ үүрэг гүйцэтгэх хуудсыг нээсэн хэрэг юм. “Иракын эрх чөлөө ажиллагаа” нь цэргийн багаар олон улсын энхийг сахиулах үйл хэрэгт оролцсон анхны ажиллагаа байв.

Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд оролцсоны ач холбогдлыг олон улсын болон өөрийн улсын хувьд гэсэн хоёр төвшин, ялгаагаар авч үзэх нь арга зүй, танин мэдэхүй талаасаа оновчтой, ач холбогдлын агуулга, мөн чанарын гүнд нэвтрэхэд тустай юм.

Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд дэлхий дахины энхийн үйлсэнд хувь нэмрээ оруулах, зэвсэгт хүчирхийлэлд өртөн зовж туйлдсан улс орны ард түмэнд туслах, дэмжлэг үзүүлэх үүрэг биелүүлж байгаа нь олон улсын ач холбогдолтой юм. НҮБ болон Олон улсын Энхийг дэмжих ажиллагаанд Монгол Улс оролцож байгаа нь дэлхийн хэмжээний түүхэн үйл явдлын нэг хэсэг юм.

Монгол Улс, НҮБ-ын бүрэн эрхт гишүүн улсын хувьд НҮБ-ын дүрмээр хүлээсэн “...олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулахын тулд Аюулгүйн Зөвлөлийн шаардсанаар түүнд тусгай нэг буюу багц хэлэлцээрийн дагуу олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад шаардагдах зэвсэгт хүч гаргаж өгөх, тусламж үзүүлэх, ... ” үүргээ нэр төртэй биелүүлж байгаа явдлын олон улсын ач холбогдлыг манай цэрэг дайчид, залуу үеийнхэн сайтар гүнзгий ойлгож байх учиртай.

НҮБ-ын энхийн ажиллагаа болон Олон улсын бусад ажиллагаа, үйл хэрэгт Монгол Улс үлгэр дууриалалтай оролцож байгааг дараах хэдэн зүйлээр илэрхийлж болно. Үүнд:

Нэгдүгээрт, Монгол Улсын төр, засгаас НҮБ-ын энхийн ажиллагаа, Олон улсын бусад ажиллагаанд оролцох зоримог шийдвэр гаргаж, эрчимтэй ажиллагаа явуулсан нь хоёр их хөршийн хүрээлэлд түгжмэл байдалтай байсан гадаад бодлогоо өөрчилж, гурав дахь хөршийн бодлогыг тууштай хэрэгжүүлэхэд нөлөөлсөн нь бусдад дууриалалтай. Монгол Улсын Их Хурлаас “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг гаргаж, түүнд “Нэгдсэн Үндэсний Байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх..., энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх, ...” тухай заалтыг оруулсан юм. НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцож, бодит байдлаар цэрэг хандивласан жижиг улс цөөнгүй байна. НҮБ-ын 192 гишүүн улсууд байдаг. Эдгээрээс 120 гаруй улс нь цэрэг хандивлаж байна. НҮБ-д цэрэг хандивлах үйл явц нь олон улсын жишиг болжээ. Цэрэг хандивлагч улсуудын ихэнх нь жижиг улсууд юм. Монгол цэргүүд хилийн чанадад үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойших 18 жилийн хугацаанд манай энхийг сахиулагчид Ирак,

Афганистан, Судан, Сьерра Леон, Чад, Өмнөд Судан, Косово зэрэг дэлхийн халуун цэг болсон 10 гаруй оронд үүрэг гүйцэтгэж давхардсан тоогоор 2013 оны 6 дугаар сарын байдлаар 15000 цэргийн алба хаагч энхийг сахиулах ажиллагаанд оролцоод байна. Хүн амын тоотой нь харьцуулахад, энхийн ажиллагаанд оролцогсдынхоо тоогоор манай улс НҮБ –д цэрэг хандивлагч гишүүн улсууд дотор “Тэргүүн-20”-ын тоонд багтах хэмжээнд хүрээд байгаа нь том үзүүлэлт юм.

Хоёрдугаарт, НҮБ-ын энхийн ажиллагаа болон Олон улсын бусад ажиллагаанд оролцох монголын цэргийн багийн үндсэн бааз суурийг тавихад манай төр засаг, цэргийн командлалаас ихээхэн анхаарал тавьж, нэгдмэл бодлого, үйл ажиллагаа явуулж байгаа нь үлгэр дуурайлал үзүүлэх нэг үзүүлэлт юм. Зэвсэгт хүчний тухай хууль, “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” зэрэг хууль, удирдлагын баримт бичигт Зэвсэгт хүчнийг цомхон, чадварлаг болгох, энхийн цагт олон талт үүрэг гүйцэтгэх чадвартай байлгах бодлого баримтлахаа тусгаж, стратегийн зорилтынхоо нэг болгосон. Үүнийгээ бодит амьдралд хэрэгжүүлж, Зэвсэгт хүчнээ чадваржуулах үндсийг тавиад байна. Юун түрүүнд Батлан хамгаалахын их сургуулийн бүтцэд “Ахлагчийн сургууль” байгуулж, цэргийн анги салбарыг мэргэшсэн цэргийн албан хаагчдаар нөхөн хангаж эхэлсэн нь оновчтой шийдвэр байв. Энэ нь НҮБ-ын энхийн ажиллагаа ба энхийг дэмжих монголын цэргийн багийн үндсэн бааз суурь болж өгч байна. Мөн Зэвсэгт хүчний бүтцэд энхийг сахиулах, барилга инженерийн хэд хэдэн батальоныг байгуулаад байна. Зэвсэгт хүчний байгуулалтад Энхийг дэмжих хүчин тодорхой хувь эзлэх боллоо. Монгол Улсын Зэвсэгт хүчний Энхийг дэмжих батальонуудын сургалт бэлтгэл нь Ерөнхий зориулалтын цэрэг дотроо тэргүүлэх сургалт бэлтгэлтэйд тооцогдож байна.

Гуравдугаарт, дэлхий дахин даяаршиж буй өнөө үед олон улс, үндэстний үндсэн эрх ашиг, хувь заяа нэгдмэл шинжтэй болж байгаатай холбоотой гэж үзэж байна. Үүнээс гадуур Монгол Улсын  улс төрийн өнөөгийн эрх ашгийг авч үзэх боломжгүй юм. Үүнийг 2005 онд, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганаар дэлхий нийтээр “Их Монгол Улсыг байгуулсны 800 жилийн ойг тэмдэглэх тухай” тогтоол гаргасан явдал харуулж байгаа юм. Энэ тогтоолыг анхны санаачлагч, хамтран зохиогчоор 30 шахам улс  оролцсон байдаг. Үүнд: АНУ, ОХУ, ХБНГУ, Франц, Турк, Энэтхэг зэрэг том улсууд Австри, Болгар, Грек, Люксембург, Македон зэрэг Европын, Азербайжан, Бангладеш, Катар, Киргизстан зэрэг Азийн олон жижиг улсууд оролцсон байна. Энэ бол Монгол Улсын нэр төрийг том, жижиг

олон улс орон хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл боловч, цаад утгаараа дэлхий дахины энхийн үйлсэнд өнөөдөр Монгол Улсын оруулж хувь нэмрийг тэдгээр улсууд сайшааж буйн илрэл гэж ойлгохоор байна.

**Тулгамдсан асуудал, цаашдын хандлага.**

Монгол Улс НҮБ-ын ОУЭСА-д оролцох хүсэл эрмэлзлээ анх 1996 онд албан ёсоор илэрхийлсэн байдаг. Улмаар 1999 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан бөгөөд 2002 онд “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль” гаргаж, 2010 онд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль” болгон шинэчлэн найруулж баталснаар салбарын бусад эрх зүйн актуудын хамт энэ үйл ажиллагааны дотоод эрх зүйн орчныг эдүгээ бүрдүүлж байна. Энэхүү хуульд “энхийг дэмжих ажиллагаа” гэсэн ойлголтыг томьёолохдоо: “...олон улсын болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, зэвсэгт мөргөлдөөнийг таслан зогсоох, түүний хор уршгийг арилгах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн дагуу Аюулгүйн зөвлөлөөс гаргасан шийдвэрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын, эсхүл бүс нутгийн холбогдох байгууллага, аливаа улсын удирдлага, зохион байгуулалтын дор явагдаж байгаа олон үндэстний үйл ажиллагааг” хэлнэ гэсэн байна. Түүнчлэн ОУЭСА-д оролцогчдын хүрээг “...зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, тагнуул, онцгой байдлын болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын бие бүрэлдэхүүн” гээд тэдний гүйцэтгэх үүргийг дараах маягаар заасан байна. Үүнд:

- гал зогсоох гэрээний биелэлтэд хяналт тавих;
- мөргөлдөгч талуудыг тусгаарлах, зэвсэг хураах;
- зэвсэгт мөргөлдөөний хор уршгийг арилгах;
- инженерийн болон бүтээн байгуулалтын бусад ажил гүйцэтгэх;
- дүрвэгсдийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- эмнэлгийн болон хүмүүнлэгийн тусламж үзүүлэх;
- аюулгүй байдлыг хангах байгууллагын бие бүрэлдэхүүнийг сургах;
- Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тогтоосон бусад үүрэг,- гэж тодорхойлсон болно.

Бидний харж байгаагаар уг хуульд маргаан үүсгэх хоёр зүйл байгааг анхаарахгүй байж болохгүй юм. Үүнд:

1/ НҮБ-ын АЗ-ийн шийдвэрээр явагдаж буй үйл ажиллагаа юу, эсвэл аль нэг улс, эвслийн үйл ажиллагаа юу гэдгийг зааглах бололцоогүй, хоёрдмол байдлаар томьёолсон аж. Хоёр дахь хувилбарыг Иракын тохиолдолд сонгосон нь манай гадаад бодлогын “эвсэлд үл нэгдэх, төвийг сахих” зарчим, агуулгад харшилсан хэмээн одоо хүртэл маргаан дагуулсаар байгаа билээ.

2/ оролцогч “бие бүрэлдэхүүнийг” дээр дурдсан байгууллагуудын “ албан хаагч”, “цэргийн албан хаагч, зэвсэгт хүчний цэргийн баг” байна гэж тогтоон оролцогчдын хүрээ, статусыг хумьсан байдалтай байна.

ОУЭСА дахь манай оролцооны асуудал цаг хугацааны хүчин зүйлийн улмаас бараг судлагдаагүй хэвээр байгаа нь ойлгомжтой. Судлаач Ж.Мэндээгийн нийтлүүлсэн хэд хэдэн өгүүлэл эдүгээ гол эх сурвалж болж байна.[66]

Түүний үзэж байгаагаар ОУЭСА-д манай тал оролцдог болсон нь дараах ач холбогдолтой болсон аж. Үүнд:

<u>Улс төрийн хувьд:</u>

1. Манай улс НҮБ-ын хариуцлагатай гишүүн гэдгээ нийтэд харуулж, нэр хүнд, “visibility” буюу “харагдахуйц” нь өсөн нэмэгдсэн,

2. Өрнөдийн орнуудтай хоёр талын харилцаагаа сайжруулахад нөлөөлсөн,

3. ЕАБХАБ-д гишүүнээр элсэж, НАТО-гийн түнш орны статустай болоход ач тустай болсон.

---

66

- Mendee Jargalsaikhan & Thomas Bruneau, “Discovering Peacekeeping as a New Mission: Mongolia,” in T. Bruneau and F. Matei (eds.,) *The Routledge Handbook of Civil-Military Relations* (Routledge, 2012), pp.204-218.
- Mendee Jargalsaikhan & Thomas Bruneau, “Discovering Peacekeeping as a New Mission: Mongolia,” in T. Bruneau and F. Matei (eds.,) *The Routledge Handbook of Civil-Military Relations* (Routledge, 2012), pp.204-218.
- Mendee Jargalsaikhan, “Asymmetrical Military Socialization – Mongolia as a Case Study,” *Armed Forces & Society Journal*, 39:2 (April, 2013), 305-330.
- Mendee Jargalsaikhan, “Military Training Assistance Program (MTAP): Merging Interests of Canada and Mongolia,” *Canadian Military Journal,* No.1 (2009), 30-38.
- Mendee Jargalsaikhan & David Last, “Whole of Government Responses in Mongolia: From Domestic Response to International Implication,” *The Pearson Papers,* 11:2 (2008), 1-22.
- Mendee Jargalsaikhan, “Mongolia’s Peacekeeping Commitment,” *Discussion Paper,* National Defense Intelligence College, May 2007.

Эдийн засгийн хувьд олж буй ашиг нь “хязгаарлагдмал”, улсын төсөвт нэмэр болдоггүй, ЭСА-д ашиглаж буй зэвсэг, техникийг шинэчлэх, түүнд оролцогчдыг цалинжуулахад зарцуулагддаг.

Аюулгүй байдлын хувьд “шууд тусах” ашиг гэж ярихад амаргүй боловч НҮБ-ын системд болон өрнөдийн эвслүүдэд “харагдахуйц “болж, энэ нь хөрш хоёрын “цэргийн дарамтыг” сааруулах үр нөлөөтэй байж болох юм.

Институцийн хувьд, зэвсэгт хүчний операцын болоод тактикийн туршлага суух, цэргийн дипломатыг хөгжүүлэх, бодлого, номнол, стратегиа шинэчлэх, сургалтын тогтолцоогоо боловсронгуй болгох, улс төрийн болоод олон нийтийн дэмжлэгийг бэхжүүлэх зэрэгт ашиглах “хэрэгслийн” хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байна.[67]

ОУЭСА -ны эрэлт хэрэгцээ их байгааг харгалзан манай тал оролцоогоо цаашид өргөтгөхөд зарим бэрхшээл учирдаг агаад, туршлагаас үзвэл,юуны өмнө зэвсэглэлийн хомсдол байдаг аж. Ялангуяа тактикийн хөдөлгөөнт машин техник болон ойрын болон алс зайн агаарын тээврийн чадвар ихээхэн дутагддаг байна.Тийм ч учраас иймд маягийн дутагдлыг нөхөх чиглэлүүдэд түлхүү анхаарч байгааг ажиглаж болно. Юуны өмнө хүний нөөцийг хөгжүүлэхэд анхаарч буй бөгөөд “Таван толгойн” цэргийн баазад тулгуурлан “Хааны эрэлд” хээрийн цэргийн сургуулилалтыг жил бүр зохион байгуулж , энхийг дэмжих ажиллагааны бүс нутгийн сургалтын төв болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Түүнчлэн энгийн иргэн, цагдаагийн байгууллага, эмэгтэй албан хаагчдыг оролцуулж байх чадавхтай болох чиглэлээр ажиллаж байна. Эрэлт ихтэй гэж үздэг барилга инженерийн , цэргийн эмнэлгийн, химийн зэвсгийн гэх мэт нэгжүүдийг байгуулан бэлтгэхэд анхаарч байна. Энэ бүгд нь манай улс цаашид олон улсын ОУЭСА –д өөрийн гэсэн байр сууриа баттай эзэлж явахын чухал үндэс гэж үзэж болох юм.

### 3.2.3. Олон улсын терроризмтой хийх тэмцэл дэх Монголын оролцоо

### Мөн чанар, учир холбогдол.

---

[67] Ariunbold Dashjivaa, *Why has Mongolia Chosen to Participate in Peace Support Operations* (MA Thesis), Monterey, CA: Naval Postgraduate School, 2013). /

Терроризм гэж чухам юуг хэлэх вэ гэдэг талаар олон улсын хэмжээнд одоо хүртэл нэгдсэн нэг ойлголт бүрэлдэн тогтоогүй байгаа ажээ. АНУ-ын эрүүгийн хэргийн хуульд өгүүлснээр терроризм нь”...улс үндэстний доторх дэд хэсэг бүлэг (subnational groups) буюу далд агентуудаас байлдагч биш энгийн хүний (non-combatant) эсрэг улс төрийн зорилгоор буюу санаатайгаар хийсэн үйлдлийг” хэлдэг бол 2013 онд Матюсицийн* томьёолсноор дараах зорилго агуулдаг байна. Үүнд:

- Улс төр, шашин шүтлэг, үзэл суртлын юм уу нийгмийн зорилгын үүднээс хүч хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлэх,
- Төр засаг, төрийн бус этгээд эсвэл төр засгийнхаа өмнөөс нууцаар үйлдэгч байж болно,
- Бай болгон сонгосноосоо илүү өргөн хүрээг онилон хохироох буюу нийгмийн илүү өргөн давхаргыг онилох,
- “mala prohibita” (хуулиар хорьсон гэмт хэрэг) ч, “ mala in se” (угаасаа буруу буюу ёс суртахуунгүй гэмт хэрэг) ч мөн.

Терроризмын агуулгыг тогтоох оролдлого 1970-80-аад онд НҮБ-ын хүрээнд хүчтэй өрнөж, 2000 оноос “Олон улсын терроризмын тухай түгээмэл конвенц” боловсруулж, тохиролцох яриа хэлэлцээ эхэлсэн боловч одоо хүртэл гишүүн улс орны байр суурийн зөрөлдөөнөөс болж, нэгдсэн нэг ойлголтод хүрч чадаагүй хэвээр байна. Гол зөрөлдөөн бол үндэсний эрх чөлөө, өөртөө засан тохинохын төлөө тэмцэх буюу хүчирхийлэхийг террорист ажиллагаа гэх эсэх тухай асуудал юм. Харин хэлэлцээний явцад оролцогч талууд дараах үндсэн тодорхойлолт дээр санал нэгдсэнийг дор эшилье. Үүнд:

“Хэн нэгэн...ямар нэгэн аргаар, хууль бусаар буюу санаатайгаар:

а) Аль нэг хүнд үхэл, эсхүл махбодын хүнд гэмтэл учруулах,

б) нийтийн ба хувийн өмч, түүний дотор олон нийтийн газар, төр засгийн тоног төхөөрөмж, нийтийн унаа тээвэр, дэд бүтэц, эсхүл орчинд ноцтой хохирол учруулах,

в) дээр дурдсан өмч, байр, тоног төхөөрөмж, системд учруулсан хохирол нь эдийн засгийн томоохон алдагдалд хүргэсэн буюу хүргэхээр байвал, уг үйлдлийн

зорилго нь шинж чанараараа юм уу, эсхүл нөхцөл байдлаараа хүн амыг айлган сүрдүүлэх, эсхүл аль нэг төр засаг, олон улсын байгууллагыг ямар нэг үйлдэл хийх, эсхүл түдгэлзэхэд албадах” ...явдал бол терроризм мөн гэжээ.

Эдгээрийг аль нэг улсын зэвсэгт хүчин, эсхүл өөртөө засан тохинох хөдөлгөөнд хамааруулах эсэх дээр санал нэгдэж болохгүй байгааг дээр дурдсан билээ.

Монгол Улс “Есдүгээр сарын 11-ний” үйл явдлын дараа, Иракын эсрэг олон улсын эвслийн ажиллагаанд оролцож, терроризмын эсрэг олон улсын тэмцэл, эдүгээг хүртэлх үр дүнг харгалзан үзсэн нь ойлгомжтой. Монгол Улс анх 2004 оны 4 дүгээр сард “Терроризмтой тэмцэх тухай” хуулийг баталж, 2019 оны 10 дугаар сард “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх” нэртэйгээр шинэчлэн найруулж, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоов. Тэр бээр төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдээс хүлээх үүрэг, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь зохицуулж байна.

Уг хуулийн 3.1.1.-д “терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх ажиллагааг” хэлнэ; 3.1.2-т.“олон улсын терроризм” гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг” хэлнэ гэж тодорхойлоод “террорист ажиллагаа”, “террорист үйлдэл” гэж юу , юуг ойлгохыг нарийвчлан заасан байна.

Хуулийн 11.1-д Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, холбогдох төрийн байгууллагын зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэдээлэл солилцох чиг үүрэг бүхий орон тооны бус Терроризмтой тэмцэх зөвлөлийг Тагнуулын ерөнхий газрын даргаар ахлуулан байгуулсан. Энэ зөвлөл эдүгээ нийт 19 байгууллагын төлөөлөл багтсан бүрэлдэхүүнтэй, ажлын албатай, аймаг, нийслэлд салбар зөвлөлтэй нэгж юм.

Тус зөвлөлийн Ажлын албанаас дараах тоймтой ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Терроризмтой тэмцэх салбарт хамтран ажиллах тухай Монгол Улс, БНТУ, ОХУ, Казахстан, Киргиз Улсын засгийн газар хоорондын хэлэлцээр, ШХАБ-ын Терроризмтой тэмцэх бүс нутгийн бүтэц, ТТЗ-ийн хооронд терроризмтой тэмцэх, мэдээ мэдээлэл солилцох хамтын ажиллагааны протокол тус тус байгуулав.

-ТТЗ-өөс "Ази, Европын дээд түвшний арван нэгдүгээр уулзалтын аюулгүй байдал, хамгаалалтыг хангах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих эрх бүхий "Нэгдсэн удирдлагын төв"-ийг байгуулж хурлыг амжилттай зохион байгуулав.

- НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн Терроризмтой тэмцэх хорооноос ирүүлсэн зөвлөмжид түшиглэн "Монгол Улсын Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2017-2020, 2020-2024 онд хийж гүйцэтгэх нэгдсэн стратеги төлөвлөгөө" боловсруулан ажиллаж байна.

-"Монгол Улсын Терроризмын аюулын талаарх эрсдэлийн үнэлгээ", "АСЕМ-XI ДТУ-ын зочид төлөөлөгчид байрлах зочид буудлуудын эрсдэлийн үнэлгээ", "АСЕМ-ын гишүүн улс орнууд, тэдгээрийн төр, засгийн тэргүүн нарт чиглэсэн терроризмын эрсдэлийн үнэлгээ"-г тус тус боловсруулж ажилласан байна.

**Тулгамдсан асуудал, цаашдын хандлага**.

Хэдийгээр Монгол Улсад гаднаас шууд заналхийлсэн терроризмын аюул одоогоор төдийлөн ажиглагдахгүй байгаа боловч хүн төрөлхтөнд учирч болзошгүй энэ аюулын асуудлыг бид анхаарлын гадна орхиж бас болохгүй байгаа юм.

Монгол Улс олон улсын терроризмын эсрэг эвслийн идэвхтэй гишүүн, цэргээ хандивладаг орнуудын нэг учир ойрын ирээдүйд гадаадын, магадгүй дотоодын òåððîðèñò á¿ëýãëýë¿¿ä манай орныг ¿éë ажиллагааныхаа òàëáàð ãýæ үзэж болохыг үгүйсгэж болохгүй юм. Ó÷èð íü манай газар нутаг дээр оршдог зарим чухал îáúåêò, дэд бүтцийн байгууламж íü õèë äàìæñàí аюул учруулах, ãàìøèãò õ¿ðãýæ áîëîõ таатай нөхцөлийг бүрдүүлсэн байрлалтай байдаг. Террорист

халдлагад өртвөл аюулд хүргэж болох үйлдвэрлэл, дэд бүтцийн объектуудын харуул хамгаалалт болон аюулгүй байдлыг нь хангах бусад үйл ажиллагаа ихээхэн сул, мөн îëîí íèéòèéí àþóëã¿é áàéäëûã õàíãàõ ¿¿ðýãòýé çàñàã çàõèðãààà, õóóëü õýíàëòûí ìåõàíèçìóóäûí ажлын хариуцлагагүй, авлигад автагдсан байдал зэрэг нь ийм төрлийн òåððîðèñò ¿éë àæèëëàãàà ÿâóóëàõ таатай нөхцөлийг бүрдүүлж болох юм.

Îéðûí áîëîí àëñ õýòèéí õóãàöààíä олон улсын òåððîðèñò үйл ажиллагаа улам èäýâõæèæ, õýâ õýìæýý, öàð õ¿ðýý íü өргөжих нь тодорхой байгаагийн зэрэгцээ ºíºº ¿åä ийм үйл ажиллагаа íü çºâõºí óëñ òºðèéí çîðèëãîîä õ¿ðýõ õýðýãñýë áóñ, мөн ãýìò õýðãèéí бүлэглэлүүдийн эдийн засгийн салбарт явуулах тэмцэл, өрсөлдөөний нэгэн îíöãîé хэлбэр болон хувирах хандлага бас ажиглагдах боллоо. Энэ õàíäëàãà íü гадаадын хөрөнгө оруулагчид манай зах зээлийн төлөө хүчтэй өрсөлдөх болсон өнөө үед öààøèä óëàì õ¿÷ýý авч Монгол Улсад нэвтрэн орж ирэхгүй гэсэн баталгаа алга байна.

Дэлхий дахинд терроризм өсөн нэмэгдэж, үндэстэн улсын хил хязгаараар зааглагдахаа больж буй нь манай оронд ийм төрлийн аюул занал учирч болзошгүй магадлалыг улам бүр нэмэгдүүлэх боллоо. Үүний дотор манай хойд, урд хоёр хөршид терроризм өсөн нэмэгдсээр байгааг олон баримт, эдгээр оронд болж өнгөрсөн террорист халдлагууд нотлон харуулж байна. Зөвхөн ОХУ-д л гэхэд сүүлийн 10 жилд террорист халдлага 10, ийм халдлагад амь насаа алдагсдын тоо 20 дахин өссөн байна. Хятад улсад, түүний дотор манай улстай хил залгаа районуудад  ийм төрлийн үйл явдал гарах нь улам бүр нэмэгдсээр байна.

Олон улсын болон дотоодын террористуудын үйл àæèëëàãàà нь óëñ îðíû àìèí ÷óõàë объектууд болох дэд бүтэц, õ¿í àì îëíîîðîî òºâëºðñºí ãàçðóóä áîëîí àæ ¿éëäâýðèéí онцгой байгууламжуудад цохилт өгөхөд чиглэдэг тухай дээр тодорхой дурдсан. Эдгээр объектыг олон улсын судлаачид дараах байдлаар тодорхойлдог юм. Үүнд:

- Атомын цахилгаан станц, цөмийн хаягдлыг хадгалах агуулах, байгууламжууд;
- Төр, засаг, Зэвсэгт хүчин болон улсын чухал объектуудын удирдлагын байгууламжууд;

- Томоохон хот, ¿éëäâýðëýëèéí районы үйл ажиллагааг õàíãàààã ñèñòåì, дэд бүтцийн байгууламжууд;
- Химийн õîðò бодис, ìàòåðèàëûí àãóóëàõóóä;
- Áàêòåðëîãèéí àþóëòàé ìàòåðèàë àøèãëàäàã ëàáîðàòîðèóä;
- Хүн ам олноор оршин суудаг, цуглардаг газрууд гэх мэт.

Эдгээрээс одоогоор атомын цахилгаан станцаас бусад нь бүгд манай улсад байгаа юм. Үүний дотор манай улсын хүн амын 60 гаруй хувь нь хот, суурин газарт, түүний дотор 50 орчим хувь нь ганцхан нийслэл Улаанбаатар хотод амьдарч, террорист халдлагад өртөх хамгийн их магадлалтай объектууд үндсэндээ зөвхөн энэ хотод төвлөрсөн байгаа юм. Түүнчлэн атомын цахилгаан станц барьж байгуулах тухай асуудал төр, засгийн удирдлагын түвшинд хүчтэй яригдах болж, үүнийг дэмжсэн, магадгүй түлхэж ятгасан  гадаадын нөлөө байгаа болох нь улам бүр мэдрэгдсээр байна.

Дээр дурдсан зүйлүүдийг нэгтгэн дүгнэж хэлэхэд төр засгийн удирдлагын байгууллагуудын зүгээс улс орны дотоодод терроризмын аливаа хэлбэр үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн чиглэл, зорилготой, тусгайлсан  бодлого, үйл ажиллагааг боловсруулж хэрэгжүүлэх бодитой шаардлага нэгэнт бий болоод байгаа нь тодорхой байна. Түүнчлэн бусад орноос терроризмын нөлөө нэвтрэн орж ирэхээс сэргийлсэн бүхий л арга хэмжээг авах, түүний дотор улсын хилийн хамгаалалтыг бэхжүүлэх, Зэвсэгт хүчин болон хүчний бусад байгууллагыг терроризмын эсрэг тэмцэлд сургаж

бэлтгэх, манай улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудын үйл ажиллагаанд энэ чиглэлээр тавих хяналтын тогтолцоог бий болгох асуудал ч чухлаар тавигдаж байна.

Терроризмоос сэргийлэх бодлого, үйл ажиллагааны нэг чухал асуудал бол энэ чиглэлээр, түүний дотор бүс нутгийн чанартай экстремист болон террорист үйл ажиллагаануудаас урьдчилан сэргийлэх асуудлаар хөрш орнуудтайгаа идэвхтэй хамтран ажиллах явдал юм. Яагаад вэ, гэвэл хөрш орнуудад гарч болзошгүй террорист үйл ажиллагаа нь газар аван манай оронд нэвтрэн орж ирэхийг үгүйсгэж болохгүй болоод байгааг сүүлийн жилүүдэд эдгээр оронд гарсан олон хэрэг явдал нотлон харуулсаар байна.

Үүний зэрэгцээ бусад оронд болсон террорист үйл ажиллагааны эмгэнэлт үр дүн нь улс төр, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлуудыг хүч хэрэглэн шийдвэрлэхийг оролдох нь олигтой үр дүнд хүргэдэггүй бөгөөд харин ч нийгмийн дунд бухимдал, талцаа, цаашилбал террорист агуулгатай үймээн самуун үүсэх нэг нөхцөл болон хувирдаг болохыг улс төрийн бүх хүчин ойлгох ёстой цаг үе нэгэнт иржээ гэдгийг хэлэх нь зүйтэй байна. Үндэстэн ястан, өөр өөр шашин шүтэгчдийн хоорондын эв найрамдалтай, тогтвортой байдлыг хангах, үүнийхээ үндсэн дээр үндэсний аюулгүй байдлаа хангах нь зөвхөн, иргэдийн элбэг хангалуун амьдрал, шударга ёс, хууль дээдлэх дэг журам, харилцан ойлголцол ноёрхсон нийгэмд л бололцоотой зүйл гэдэг нь тодорхой болно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭСЛЭГЭЭ

### 4.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэслэгээ.

#### 4.1.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах шаардлага, үндэслэл

**Аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт.**

Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах шаардлагыг үүсгэж байгаа гол хүчин зүйл бол Монгол Улсын эргэн тойронд бий болсон олон улсын аюулгүй байдлын гадаад шинэ орчин юм.

Энэ нь Монгол Улсын геополитикийн аюулгүй байдал юуны өмнө õºðø õî¸ð îðíû манай улсын тухайд явуулах тэдний геостратегийí бодлогын òýíöâýðò áàéäëààñ èõýýõýí õàìààð÷ байдагтай холбоотой болно. Ýíý õ¿÷èí ç¿éë öààøèä ÷ õàäãàëàãäààõ íü îéëãîìæòîé áîëîâ÷ ñ¿¿ëèéí æèë¿¿äýä áîëæ áóé õýðýã ÿâààë “ãóðàâäààã÷ õºðø” хэмээгдэх АНУ-ын Монгол Улсын талаар баримталж буй геостратегийн бодлого ãýäýã øèíý хүчин зүйлийг áèé áîëãîñîí áºãººä ¿¿íèé ¿ð äàãàâàð íü ÿìàð áàéõ òàëààð îëîí ÿíçûí òààìàãëàë äýâøèãäýæ ýõýëëýý. Түүнчлэн Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò øèíýýð á¿ðýëäýí áèé áîëæ áóé олон үйл явц ººð øèíý õ¿÷èí зүйл ãàðãààæ èðýõèéã ¿ã¿éñãýæ áîëîõã¿é áàéíà.

Үүний зэрэгцээ, олон óëñûí õàðèëöààíû ºíººãèéí íºõöºëä àëü íýã óëñ îðîîñ Ìîíãîë Óëñûí òóñãààð òîãòîíîë, ãàçàð íóòãèéí á¿ðýí á¿òýí áàéäàë, òºðèéí áàéãóóëàëòàä öýðãèéí õ¿÷ýýð øóóä çàíàëõèéëýõ àþóë ¿íäñýíäýý áàéõã¿é ãýæ ¿çýæ болохоор байгаа нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

Гэхдээ Ìîíãîë Óëñàä ó÷èð÷ áîëîõ öýðãèéí àþóë çàíàëûã á¿ðìºñºí ¿ã¿éñãýæ ááñ áîëîõã¿é áºãººä ýíý íü õºðø çýðãýëäýý ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ын геополитикийн бодлоготой õîëáîãäîæ, òýäãýýðèéí õîîðîíä болон өөр бусад орон болон эдгээр улс хоорондын àëèâàà ìàðãààí, çºð÷èëäººí íü äàéí, çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýæ Ìîíãîë Óëñ ò¿¿íä ямар нэг хэлбэрээр òàòàãääàí îðæ áîëîõ ìàãàäëàëòàé óÿëäàí үүсэж байгаа þì.

Îðîñ, Õÿòàä õî¸ð óëñ íü ººð õîîðîíäîî äàéñàõàð, äàéòàõ ÿâääë ò¿¿õýíä îëîíòîé ãàð÷ áàéñíûã áèä ñàíàæ áàéãàà. Õ¿éòýí äàéíû ¿åä Îðîñ, Õÿòàäын геополитикийн сөргөлдөөн дээд цэгтээ хүрч òýäãýýðèéí õèë äýýð çýâñýã õýðýãëýñýí áóäëèàí ч ãàð÷ áàéñíûã áèä ìàðòààã¿é áàéíà.

Эдгээрээс гадна геополитикийн ¿¿äýëòýé шинэ àþóëûí ýõ ¿¿ñâýð òýäíèé ç¿ãýýñ ãàð÷ áîëîõûã ¿ã¿éñãýæ ááñ áîëîõã¿é áàéíà. ÎÕÓ, ÁÍÕÀÓ õî¸óë òºð, íèéãýì, ýäèéí çàñãèéí øèëæèëòèéíõýý ¿åä áàéãàà áºãººä ýäèéí çàñãèéí õ¿÷èí ÷àäàë, îðîí íóòãèéí çàñàã çàõèðãààíèé ýðõ ìýäëèéí õóâèàðëàëò äóóñààã¿é, òýäãýýðò íºëººëºõ ãýñýí салан тусгаарлах болон ãýìò õýðãèéí çîõèîí áàéãóóëàëòàé á¿ëãýëýë¿¿ä èäýâõòýé ¿éë àæèëëàãàà ÿâóóëæ áàéãàà òóõàé ìýäýýëýë èõýýõýí òàðààãäàæ áàéãàà.

Түүнчлэн эдгээр óëñûí õîîðîíä ýäèéí çàñãèéí õàðèëöàà ã¿íçãèéðýõ õýðýýð, ýíý çààñðààñ àøèã õîíæîî îëîõ ãýñýí çîõèîí áàéãóóëàëòòàé ãýìò õýðãèéí á¿ëãýëý¿¿ä Ìîíãîë Óëñûã ýä áàðàà, ìºíãº õºðºíãº, ò¿¿íèé äîòîð çýâñýã, ìàíñóóðóóëàõ áîäèñ, öºìèéí çýâñãèéí ýä àíãè, ò¿¿õèé ýä, áîõèð ìºíãº, ÷àíàðã¿é á¿òýýãäýõ¿¿íèéã òýýâýðëýí äàìæóóëàõ õàìãèéí òîõèðîìæòîé, áîãèíî çàì ãýäýã ¿¿äíýýñ áîäèòîéãîîð ñîíèðõîæ áîëîõ òàëòàé. Èíãýõäýý òýä ìàíàé óëñ òºðèéí áîëîí òºðèéí àëáàí õààã÷äûã õóäàëäàæ àâàõ, ãýìò õýðýãòí¿¿äèéã ýñ¿¿ëýõèéã îðîëîîõ, òýð íü ÿâààíäàà ¿íäýñòýí äàìíàñàí çîõèîí áàéãóóëàëòàé ãýìò õýðãèéí á¿ëãýëýë áîëîí ºðãºæèõ àþóëä õ¿ðãýæ áîëîõ þì. Óëààð òºðèéí, ÿëàíãóÿà õºðºíãº îðóóëàëò õèéõ ýõ ìýäëèéã õóâèàðëàõ, ýäèéí çàñãèéí òîìîõîí àñóóäëóóäûã øèéäâýðëýõ ¿éë àæèëëàãààíä íºëººëºõ ãýñýí îðîëäëîãî ÷ ãàð÷ байгаа тухай мэдээлэл бий.

Хоёр хөршөөс бие биеийн тухайд хилийн äýãëýìèéã çºð÷èõ ÿâääë àëü àëü òàëààñ áàãà çýðãýýð ãàð÷ áàéãàà õýäèé ÷ ýíý íü ¿íäñýí àþóëã¿é áàéäàëä íºëººëºõ õýìæýýíä õ¿ðòýë ÿðèãäààõ àñóóäàë áèø þì. ¯íèé çýðãýöýý äýëõèé íèéòýýðýý òîì ã¿ðí¿¿äèéí çàõ õÿçãààðò àìüäðàí ñóóãàà ¿íäñòíèé áîëîí øàøíû öººíõ¿¿äèéí ñàëàí

òóñãààðëàõ ¿çýë, ¿éë àæèëëàãàà îëîí óëñûí õýìæýýíä ºðãºæèõ õàíäëàãàòàé áàéãààã àíõààðàõã¿é îðõèæ áàñ áîëîõã¿é þì.

Õºðø îðíóóä ìààíü öºìèéí çýâñýãòýé áºãººä öºìèéí çýâñýã, öàöðàã èäýâõò áîäèñ, õàÿãäëàà õ¿í àìûí íÿãòðàë áàãàòàé ãàçàð áàéðøóóëàõ, òèéì ãàçðóóäààñ ÿíç á¿ðèéí òóðøèëò ÿâóóëàõ ìàãààäëàë ºíäºð. Èéì ãàçðóóä íü Îðîñûí Àëñ Дорнод, Õÿòàäûí Õîéò õýñã¿¿ä áºãººä òåõíîëîãèéí àëäàà, ñ¿éðýë ãàðàõ òîõèîëäîëä Ìîíãîë Óëñ öàöðàãèéí áîõèðäîëä îðîõ àþóë çàíàë áàéæ áîëîõ òàëòàé.

Õºðø îðíóóäûí õîîðîíäûí õàðèëöàà ìóóäàõ áîëîí òýäãýýðèéí äîòîîäîä óëñ òºð, íèéãìèéí òîãòâîðã¿é áàéäàë áèé áîëîõ íºõöºëä ýäãýýð óëñûí ãàçàð íóòãààñ, ÿëàíãóÿà хойд õºðøèéí áóðèàä, òóâà, урд хөршийн õàñàã, уйгур, ºâºð ìîíãîë÷óóäûí äîòðîîñ Ìîíãîë Óëñûí õèë äààâàí îëîíîîðîî ä¿ðâýí í¿¿æ èðýõ ¿çýãäýë ãàð÷ áîëîõûã ¿ã¿éñãýæ áîëîõã¿é þì.

**Дотоод нөхцөл байдлын өөрчлөлт.**

Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах шаардлагыг үүсгэж байгаа дараагийн нэг гол хүчин зүйл бол Монгол Улсын дотоодод бий болсон шинэ нөхцөл байдал юм.

Олон улсын геополитикийн нөхцөл байдал хурцдах хэрээр манай орны дотоод улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд олон шинэ эрсдэл, сорилт тулгарах болж, зарим нь лавшрах хандлагатай байна. Улс орны улс төр, нийгмийн байдал хурцадмал хэвээр, зөрчил сөргөлдөөн үргэлжилсээр, эдийн засгийн тэнцвэртэй хөгжил төдийлөн хангагдаж чадахгүй, сайн засаглал байгуулах ажил удаашралтай, ард түмний нэлээд хэсгийн амьдралын түвшин төдийлөн сайжрахгүй байгаа зэргээс улбаалан нийгэмд тогтворгүй, хуваагдмал байдал үүсэн бий болох шинж тэмдэг ажиглагдаж, байна.

Òºâ ñóóðèí ãàçàð, îðîí íóòàã  õîîðîíäûí õºãæëèéí òýíöâýðã¿é áàéäàë, íèéãìèéí òîäîðõîé á¿ëýã, õýñã¿¿äèéí îðëîãûí ÿëãàà õýò äààìæèðàõ íü õ¿í àìûí äóíä òîãòâîðã¿é áàéäëûã ¿¿ñãýæ óëìààð òºðèéí тогтвортой байдалд àþóë ó÷ðóóëæ áîëçîøã¿é þì. Ó÷èð íü ýíý õýò их ÿëãàà íü íýã òàëààñ ÷èíýýëýã õ¿ì¿¿ñ, íºãºº òàëààñ ÿäóó ç¿ä¿¿÷¿¿äèéí õîîðîíä çºð÷èë ¿¿ñãýõ, ò¿¿íèéã øèéäâýðëýõ çîðèëãîîð òºð çàñãààñ õýðýãæ¿¿ëýõ íèéãýì, ýäèéí çàñãèéí àðãà õýìæýý íü òºäèéëºí àìæèëòàíä õ¿ðýõã¿é áîë àðä ò¿ìíèé äóíä õóóëèéí áóñ àðãà õýðýãñëèéã õ¿ñýìæëýõ óóð àìüñãàëûã áèé áîëãîõ

àþóëòàé байдаг. Õýðâýý èéì áàéäàë ¿¿ñâýë óëñ òºðèéí òîãòâîðòîé áàéäàë àëäàãäàæ, óëìààð òºðèéí áàéãóóëàëä èòãýõ èòãýë ñóëàðõàä õ¿ðãýæ áîëíî. Ãýòýë ÷ºëººò ñîíãóóëèàð áàéãóóëàãääàã àðä÷èëñàí òîãòîëöîîò òºðèéí áàéãóóëàë íü Ìîíãîë Óëñûã áóñàä óëñ îðîíòîé ýðõ òýãø õàðèëöàà õºãæ¿¿ëýõ, àþóëã¿é áàéäëàà áýõæ¿¿ëýõýä òóëãóóð áîëæ áóé ãîë õ¿÷èí ç¿éë áèëýý.

Ìîíãîë Óëñ ¯íäñýí õóóëüäàà òºðèéí áàéãóóëàëòàà "ïàðëàìåíòèéí á¿ãä íàéðàìäàõ óëñ" ãýæ òîìú¸îëñîí íü òºðèéí äýýä ýðõ ìýäëèéã íýã, эсхүл õýñýã бүлэг õ¿íèé ýðõ ìýäýëä îëãîõîîñ çàéëñõèéñýí, òîì ã¿ðí¿¿äèéí õîîðîíä îðøèæ áàéãàà æèæèã îðíû õóâüä òºðèéí áîäëîãûã îëîí ò¿ìíèé ñàíàà áîäîë äýýð òóëãóóðëàí ÿâóóëæ áàéõ íºõöëèéã á¿ðä¿¿ëýõ çîðèëãîíû èëýðõèéëýë þì.

¯¿íèé çýðýãöýý ñ¿¿ëèéí ¿åä àðä ò¿ìíèé ç¿ãýýñ ïàðëàìåíòàä ÿìàð íýã õýëáýðýýð èòãýë àëäàõ áîëæ óëìààð Åðºíõèéëºã÷èéí çàñàãëàëûã õ¿ñýìæëýã÷äèéí òîî íýìýãäýæ áàéãàà íü íèéãìèéí òîìîîõîí çºð÷èëä ººíèéã ¿¿ñãýæ улс орны улс төрийн амьдралд хүчтэй нөлөөлж ìýäýõýýð áàéíà. ¯¿íòýé óÿëäààòàéãààð òºðèéí çàðèì ýðõ ìýäëèéã òºâ ººñ îðîí íóòàãò íóòàãò øèëæ¿¿ëýõ шаардлага нэмэгдэж, òºðèéí áóñ áàéãóóëëàãóóä, èðãýíèé õºäºëãºº í¿¿äèéí òºð, çàñàãò øàõàëò ¿ç¿¿ëýõ àðãà ìåõàíèçì ººð÷ëºãäºæ, õýìæýý äàëàéö íü ºñºõ õàíäëàãàòàé áàéíà.

Эдгээр хүчин зүйлийн улмаас геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах зайлшгүй шаардлага үүсгэж байгаа дараах хэд хэдэн нөхцөл байдал үүсээд байна: Үүнд.

**¯íäýñíèé үнэт зүйлсийн тухай ойлголтын өөрчлөлт**.

Аливаа бага улс, түүний дотор үндсэндээ нэг үндэстнээс бүрддэг орны хувьд геополитикийн аюулгүй байдлаа хангах үзэл баримтал, бодлого, үйл ажиллагаа нь үндэснийхээ үнэт зүйлс, улмаар үндэснийхээ язгуур эрх ашгийг тунгаан ойлгож ухамсарт үнэмшил болгон хөгжүүлэхтэй ихээхэн холбоотой байдаг. Ийм учраас төрөөс геополитикийн салбарт баримтлах бодлогын үндсийг боловсруулах асуудлыг авч үзэхийн тулд юуны өмнө бидний эрхэмлэн шүтэх ёстой үндэсний үнэт зүйлс, язгуур ашиг сонирхлыг өнөө үед хэрхэн ойлгож байгаад дүн шинжилгээ хийх, ер  хэрхэн ойлгох ёстойг тунгаан бодож, нээн илрүүлэх нь ихээхэн чухал юм.

Энэ нь улс орны геополитикийн аюулгүй байдлыг хангах çîðèëãîîð òºðººñ ÿâóóëàõ áîäëîãî, ¿éë àæèëëàãàà íü íýã òàëààñ Ìîíãîëûí èðãýäèéí ýðõýìëýýí ø¿òýõ ¿íäýñíèé ¿íýò ç¿éëñèéã ò¿¿õýí óëàìæëàë, ºíººãèéí øààðäëàãûí ¿¿äíýýñ çºâººð òîãòîõîéëñíîîð, íºãºº òàëààñ òýäãýýðèéã óëñ òºð, ýðõ ç¿é, íèéãýì, ýäèéí çàñàã, öýðãèéí çýðýã áîäèò ¿éë àæèëëàãàà, эдгээрийн эрх зүйн оновчтой зохицуулалтаар õàìãààëàõàä оршдогтой холбоотой þì. Энэ нь эцсийн ä¿íäýý ¿íäýñíèé ¿íýò зүйлсээ õàäãàëàí õàìãààëàõ íü ¿íäýñíèé ÿçãóóð ашиг сонирхол áàéäàã гэсэн үг юм.

Ñ¿¿ëèéí ¿åä ìîíãîëûí íèéãýìä õî¸ð òºðëèéí ¿íýò ç¿éë зэрэгцэн оршиж байгаа нь энэхүү судалгаанаас õàðàãäàæ áàéíà.

<u>Íýãä¿ãýýðò</u>. 1990-ýýä îíû ýõýýð “ïðîëåòàðèéí èíòåðíàöèîíàëèçì” èéí ýñðýã ñºðã¿¿ëýí ãàðãàæ èðñýí íèéò õ¿í òºðºëõòíèé ýðõýìëýõ ¿íýò ç¿éëñ îðîí. Ýíý îéëãîëò íü õ¿íèé íèéãìèéí îëîí ¿åèéí õºãæëèéí ÿâöàä õóðèìòëóóëñàí àðä÷èëàë, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëºº, çàõ çýýëèéí ýäèéí çàñàã, õóâèéí ºì÷, ãýð á¿ë, îðîí ãýð, ãàë ãîëîìò, øàøèí ø¿òëýã çýðãèéã õ¿íäýòãýõ ¿çýë áîäîëä òóëãóóðëàäãààðàà ÿàõ àðãàã¿é ýðõýì, íàíäèí ¿íýò ç¿éëñ þì.

¯¿íèé õàæóóãààð ìîíãîëûí íèéãìèéí ñ¿¿ëèéí æèë¿¿äèéí áîäèò àìüäðàëààñ õàðàõàä ìàðãààõ àðãàã¿é ýäãýýð ¿íýò ç¿éëñ íü áàðóóíû, түгний дотор христийн шашин бүхий îðíóóäàä õýâøèë áîëñîí ¿çýë áîäîë, íèéãýì, àìüäðàëûí òóõàé îéëãîëò, øàøèí ø¿òëýã, áèåý àâ÷ ÿâàõ çàð÷ìûã áèäýíä òóëãàí õ¿ëýýëãýõ õýëáýðèéã õîéíîîñîî äàãóóëæ ÿâàà íü áàñ àæèãëàãäàæ áàéíà.

Ãýòýë Ìîíãîë óëñ îëîí çóóíû òóðø õóðèìòëóóëñàí ýðõýìëýýí ø¿òýõ ººðèéí ãýñýí ¿íäýñíèé ¿íýò ç¿éëñòýé, áóðõíû øàøèíòàé, í¿¿äýë÷èí àðäûí áèå äààñàí ñî¸ë èðãýíøëèéí óëàìæëàë á¿õèé îðîí áèëýý. Èéìä òîãòîõîé ÷èãëýë çîðèëãîòîé, ñýõýý àâàõ çàâ çàéã¿é íýâòýð÷ áóé ãààäûí ãýæ áîëîõ äýýðõ íºëººëºë íü õýäèéãýýð õ¿í òºðºëõòíèé ýðõýìëýõ íèéòëýã óðèà ëîîçîí äîð õèéãäýæ áàéãàà ÷ ìîíãîëûí íèéãìèéí óëàìæëàëò ¸ñ ñóðòàõóóíòàé çºð÷èëäººí үүсгэж байна.

<u>Õî¸ðäóãààðò</u>. ¯¿íèé ýñðýã, õ¿í òºðºëõòíèé íèéòëýã ¿íýò ç¿éëñèéã ñºðã¿¿ëýí çºâõºí ”Ìîíãîëûí ¿íýò ç¿éëñ” ãýã÷èéã äýâø¿¿ëýí òàâèõ íü элбэг áàéíà. ¯çýë ñóðòëûí îëîí æèëèéí õ¿ëýýñýýñ ñàëñàí 1990-ýýä îíû ýõýýñ ýíý ¿çýë áàðèìòëàëûã ýðõýìëýã÷äèéí áîäëîãî, ¿éë àæèëëàãàà íü ýöñèéí ä¿íäýý í¿¿äëèéí ìîíãîëûí ñî¸ë èðãýíøëèéí îþóí ñàíààíû óëàìæëàë, áóðõàíû øàøèí, àõóé õºòëºõ àðãà óõààíûã ãîëëîõ, ¿¿í äýýðýý òóëãóóðëàí Ìîíãîëûí Èõ ã¿ðíèé ¿åèéíõòýé òºñººòýé òºð, íèéãìèéí õàòóó äýã

æóðìûã ¿íäýñëýë áîëãîñîí óëñ îðíûã áàéãóóëàõàä ÷èãëýæ áàéíà. Ýäãýýð õ¿ì¿¿ñ íü ¿¿íèéãýý èõ ã¿ðí¿¿äèéí îëîí ÿíçûí ñàíààðõëûí ¿ð íºëººãººð ìîíãîëûí àðä ò¿ìýí ººðèéí ºâºðìºö àõóé ñî¸ë, òºðò ¸ñíû óëàìæëàëàà àëäàõ òàëðóóãàà ÿâæ áàéíà ãýñýí ¿íäýñëýëýýð òàéëáàðëàæ áàéãàà áîëîí.

Ýäãýýðýýñ õàðàõàä çàõ çýýëèéí ýäèéí çàñàã, àðä÷èëàë, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëºº çýðýã íü ìîíãîëûí àðä ò¿ìíèé èðýýä¿éí õºãæèë, òºð óëñûí îðøèí òîãòíîõ öààøäûí çàìä õºòëºõ ãîë õ¿÷èí ç¿éë¿¿ä ìºí ÷ ìîíãîë ¿íäýñòíèé óëàìæëàë äýýð òóëãóóðëàñàí ººð бусад ç¿éë äóòàãäààæ áàéãàà íü óëàì á¿ð îëëîãäñîîð áàéíà.

¯¿íèé çýðýãöýý, çºâõºí í¿¿äëèéí ñî¸ë èðãýíøèë, àðäûí óëàìæëàëò çàí çàíøèë, àõóé õºòëºõ àðãà óõààí, бөө мөргөлөөс уламжлалтай мухар сүсэг болон дан ганц зарим талаар цаг үеэсээ хоцрох болсон бурхны øàøíûõàà òîãòîîë õÿçãààðëàãäààõ íü õ¿í òºðºëõòíèé õºãæèë äýâøèëèéí ò¿ãýýìýë çàìä õºë íèéë¿¿ëýõýä ìîíãîëûí àðä ò¿ìýíä òèéì ÷ èõ òóñ äºõºì áîëæ ÷àäàõã¿é íü áàñ òîäîðõîé áîëæ áàéíà.

ßìàð÷ áîëîâ Ìîíãîëûí íèéãìèéí ºíººãèéí áîäèò áàéäàë íü õóâü õ¿í, íèéãýì, òºð óëñûã õîðîîä íü õîëáîõ øèíý ¿çýë áîäîë, ¿íýò ç¿éëñèéí òîãòîëöîîã ç¿é ¸ñîîð øààðäààæ áàéãàà íü òîäîðõîé áºããºä ýíý íü үндэсний аюулгүй байдлын  салбарын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлэх àæëûí íýã ãîë àãóóëãà áàéõ ёстой íü îéëãîìæòîé áàéíà. Òýãâýë ýíý øèíý ¿íýò ç¿éë íü þó áàéõ âý?

Ñ¿¿ëèéí ¿åä Ìîíãîëûí óëñ òºð, íèéãìèéí àìüäðàëä áèé áîëîîä áàéãàà хямралт áàéäàë íü ýöñèéí ä¿íäýý àðä ò¿ìíèé ýðõýìëýí ø¿òýõ øèíý ¿íýò ç¿éë íü ¿íäýñíèé ýâ íýãäýë байх ёстой ãýäãèéã óëàì á¿ð òîäîðõîé болгосоор байна.

Үүнтэй холбогдуулан хэлэхэд, өнөө ¿åä Ìîíãîë Óëñûí ºìíº òóëãàð÷ áóé áýðõøýýë áîëãîîíûã ò¿¿íèé äîòîð õ¿íèé àþóëã¿é áàéäàë, àìæèðãààíû ò¿âøèíòýé õîëáîãäîë á¿õèé òóëãàìäñàí àñóóäàë á¿ðèéã ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ò¿âøèíä àâ÷ ¿çýõ, òýð áàéòóãàà ýäãýýðèéã óëñ òºðæ¿¿ëýí äýâýðãýõ  ÿââàë èõýýõýí ãàçàð àâàõ øèíæòýé áàéíà.

Ãýòýë ýäãýýð íü äýëõèé äàõèíä õ¿ëýýí çºâøººðºãäñºí ¿çýë áîäëûí ¿¿äíýýñ ¿íäñýíäýý óëñ îðíû õºãæëèéí àñóóäàë áàéäàã áºããºä улс орны хөгжилд тулгарсан áýðõøýýë саад áîëãîîíûã ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí àñóóäàë áîëãîí àâ÷ ¿çýõ íü èõýýõýí ó÷èð зүйл äóòàãäààëòàé þì.

X¿íñíèé ÷àíàðûí àñóóäàë, àìüäðàõ îð÷íû áîõèðäîë, íýí õàëäâàðò ºâ÷íèé òàðõàëò, ÿäóóðàë, эдгээрээс ¿¿äýëòýé íèéãìèéí áóõèìäàë, öàãàà÷ëàë, õ¿íèé íàéìàà, áàéãàëèéí ãàìøèãò ¿çýãäýë, äýëõèéí öàã óóðûí äóëààðàë, ¿íäýñòýí äàìíàñàí çîõèîí áàéãóóëàëòòàé ãýìò õýðýã, ìàíñóóðóóëàõ áîäèñûí çººâºð, öºìèéí ò¿¿õèé ýä, ìàòåðèàë õóëãàéëàõ, äàìæóóëàí õóäàëäààëàõ îðîëäëîãî ãýõ ìýò ºíººäºð ìîíãîëûí íèéãìèéí áóõèìäëûí ¿íäýñ áîëæ áóé цөөнгүй зүйл íü õ¿í òºðºëõòíèé õóâüä íèéòëýã зүйл áºãººä äýëõèéí õàìòûí íèéãýìëýãèéí íýãäñýí ÷àðìàéëò, óëñ îðîí á¿ðèéí çºâ óõààëàã ¿íäýñíèé õºãæëèéí áîäëîãîîð øèéäâýðëýãäýæ áîëîõ àñóóäàë þì.

Õàðèí óëàì á¿ð äàÿàðøèæ áóé ºíººãèéí åðòºíöºä ¿íäñýíäýý íýã ¿íäýñòíýýñ á¿ðäñýí, òîì õºðø¿¿äèéí äóíä ò¿ãæèãäìýë áàéäëààð îðøäîã, õºãæèæ áóé æèæèã îðîí áîëîõ Ìîíãîë Óëñûí õóâüд геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõ òºðèéí áîäëîãûã õºãæëèéí áîäëîãûí ò¿ãýýìýë àñóóäëóóäòàé õýò õóòãàëã¿éãýýð çºâõºí òóñãààð òîãòîîñîí ¿íäýñòýí óëñûí õóâüä îðøèí òîãòíîõ, ºâºðìºö ñî¸ë èðãýíøèë, õ¿í àìûí óäìûí ñàí, óãñàà ãàðâàëàà буюу өмнө дурдсанаар үндэсний язгуур эрх ашгаа õàäãàëàí õàìãààëæ, õîé÷ ¿åäýý ¿ëäýýõ àñóóäàëä ãîë àíõààðëàà õàíäóóëàõ ó÷èðòàé болох нь энэхүү судалгаанаас харагдаж байна.

Энэ нь геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулах, улмаар бусад үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжийг тодотгон шинэчлэх ажлын гол агуулга байж болох юм гэж үзлээ.

**¯íäýñíèé àøèã сонирхлын тухай өнөөгийн ойлголт.**

Àëèâàà óëñûí геополитикийн àþóëã¿é áàéäàë íü геополитикийн ãàäààä îð÷èí, үүнээс үүдэлтэй äîòîîä нөхцөл áàéäàë ãýñýí õî¸ð õ¿÷èí ç¿éëèéí íºëººëºë äîð á¿ðýëäýí áèé áîëäîã ç¿é òîãòîëòîé. ¯¿íèé äîòðîîñ геополитикийн ãàäààä îð÷íû íºë ººëºë íü òóõàéí óëñ îðíûã õ¿ðýýëñýí óëñ îðíóóäûí геостратегийн бодлого áîëîí ò¿¿íèé ººðèéíõ íü геополитикийн àøèã ñîíèðõîë õîîðîíäûí õàðüöààíû øèíæ ÷àíàðààñ ¿¿ñäýã áàéíà.

XXI çóóí даяаршлын ýðèí áîëîõ òºëºâòýé áàéãàà áºãººä óëñ îðíóóäûí ýäèéí çàñàã, òåõíîëîãè, ñî¸ë, óëñ òºðèéí õàðèëöàà óëàì á¿ð ºðãºæèí, íÿãò óÿëäààòàé áîëæ îðîí á¿ðò õºãæëèéí àñàð èõ áîëîìæ íýýãäýæ áàéíà. Äàÿàðøëûí ¿éë ÿâöààñ Ìîíãîë Óëñ õîë õºíäèé áàéæ ÷àäàõã¿é íü îéëãîìæòîé. Ãýâ÷ äàÿàðøèë óëñ îðíóóäûí геополитикийн àþóëã¿é áàéäàëä òîäîðõîé ýðñäýëèéã áèé áîëãîæ áàéãààã àíõààðàõã¿é áàéæ áàñ áîëîõã¿é þì. Òèéì ýðñäýëèéí òîîíä гео óëñ òºð, гео ýäèéí çàñàã, ñî¸ë èðãýíøèëèéí ãýõ ìýò ¿¿äýëòýé óëñ õîîðîíäûí õàðèëöààíû àøèã ñîíèðõëûí çºð÷èë, ñºðãºëäººí áàãòàæ

áîëîõ þì. Ãýõäýý àëèâàà óëñ îðîí çºð÷èë, ñºðãºëäººí áîëãîîìûã геополитикийн àþóëã¿é áàéäàëä íºëººëºõ õýìæýýíä àâ÷ ¿çäýãã¿é áºãººä çºâõºí ýäãýýðèéí ºðíºèò íü геополитикийн àøèã ñîíèðõîëä õàðøëàõ õýìæýýíä õ¿ðýõ òîõèîëäîëä òýäãýýðèéã ñýðýìæëýí çàéëóóëàõ áîëîìæ, àðãà õýìæýýã õýðýãæ¿¿ëäýã áàéíà.

Èéì ó÷ðààñ ýõëýýä óëñ õîîðîíäûí геополитикийн àøèã ñîíèðõîëûã îëîí óëñûí õàðèëöààíû øèíæ ÷àíàðààð íü àíãèëàí ¿зэх нь чухал юм.

**Ýñðýã òýñðýã àøèã ñîíèðõîë:** Ýíý á¿ëýãò óëñ õîîðîíäûí çºð÷èë ñºðãºëäººí ¿¿ñãýæ áîëîõ îãò ýâëýðýøã¿é, áèå áèåý ¿ã¿éñãýã÷ геополитикийн үүдэлтэй àøèã ñîíèðõîë áàãòäàã. Àëèâàà íýã óëñûí áóþó óëñ õîîðîíäûí ýâñýë, õîëáîîíû геополитикийн àøèã ñîíèðõîë íü íºãºº óëñ, ýâñýë, õîëáîîíûõîî ийм төрлийн àøèã ñîíèðõîëûã ¿ã¿éñãýõ òîõèîëäîëä òýäãýýðèéí õîîðîíä ýâëýðýøã¿é çºð÷èë, ñºðãºëäººí ¿¿ñäýã. Èíãýýä ýñðýã òýñðýãèéí ýíý çºð÷èëäººí íü ò¿¿íèéã õÿçãààðëàõ õ¿÷èí ç¿éë áàéõã¿é áóþó õàíãàëòã¿é òîõèîëäîëä çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýäýã áàéíà. ¯¿íýý õîëáîãäóóëàí õýëýõýä óëñ õîîðîíäûí àøèã ñîíèðõîëûí èéì çºð÷èëäººí íü ÿìàð á¿ðèéí àãóóëãààð ò¿¿íèé äîòîð ¿çýë ñóðòàëûí ýëãàà, çàõ çýýëèéí òºëºº òýìöýëäýýíýýñ ýõëýýä øàøíû ýâëýðýøã¿é ¿çýë áîäîë õ¿ðòýë ìàø îëîí õýëáýðýýð èëýðäýã áîëîí. ¯íèé íýã òîä æèøýý íü ñîöèàëèçì, êàïèòàëèçì ãýæ íýðëýãäýæ áàéñàí õî¸ð òîãòîëöîîíû çºð÷èë сөргөлдººí áàéëàà.

**Àíãèä àøèã ñîíèðõîë:** ¯íèé òîîíä õîîðîíäîî çºð÷èëäºõ áîëîâ÷, áèå áèåý ¿ã¿éñãýäýãã¿é геополитикийн үүдэлтэй àøèã ñîíèðõîë õàìààðäàã. Èéì àøèã ñîíèðõîë íü õýäèéãýýð ýñðýã òýñðýã ìàÿãèéí çîðèëãî, çîðèëòóóäûã õýðýãæ¿¿ëýõýä ÷ãëýäýã áîëîâ÷ ººð àøèã ñîíèðõîëûã øàõàí õÿçãààðëàõ áîëîìæûã ãîë áîëãîìãîã¿é. Àíãèä àøèã ñîíèðõîë íü ýñðýã òýñðýã àøèã ñîíèðõîëîîñ çºð÷èë ñºðãºëäººí ¿ã¿éãýýð áèø õàðèí òýäãýýðèéí ýð÷ õ¿÷, õîð íºëºº íü áàãà áàéäãààðàà ÿëãààòàé þì. Ãýõäýý çºð÷èë ñºðãºëäººí õóðöàäâàë ýíý íü геополитикийн ýñðýã òýñðýã àøèã ñîíèðõîë áîëîí õóâèðàõ òàëòàé áàéäàã. Îëîí óëñûí ïðàêòèêò òîõèîëääîã геополитикийн àíãèä àøèã ñîíèðõîëûí òîä èëýðõèéëýë íü òîãòîõîé á¿ñ íóòàãò гео улс төр, гео эдийн засаг, өөрийн соёл иргэншлийн íºëººëºë áèé áîëãîõûí òºëºº õºì ã¿í¿¿äèéí ºðñºëäººí áàéäàã.

**Çýðãýöýý àøèã ñîíèðõîë:** Ýíý á¿ëãèéí геополитикийн àøèã ñîíèðõîëûí õîîðîíä ýñðýã òýñðýãèéí çºð÷èë ñºðãºëäººí áàðàã áàéäàããã¿é. Õàðèí ÷ óëñ îðíóóä ìºí ÷àíàðòàà îéðîëöîî, àãóóëãûí õóâüä ¿íäñýíäýý геополитикийн íýã àøèã ñîíèðõîëûã ýðõýì áîëãîíîã îíöëîãòîé þì. Ãýõäýý àëèâàà óëñ îðîí ººðèéí геополитикийн àøèã ñîíèðõîëûã áèå äààí,

áóñäûí îðîëöîîã¿éãýýð øèéäâýðëýõèéã ýðìýëçäýãýýðýý ýíý á¿ëýã íü ÿëãàãäääàã. Ýíý íºõöºë áàéäàëä óëñ õîîðîíäûí õàðèëöààíä õóðöàäìàë áàéäàë áàðàã ¿¿ñäýãã¿é áîëîâ÷ õàìòðàí àæèëëàõ ÿâääë áàñ ñàéíã¿é áàéäàã. Геополитикийн зэрэгцээ àøèã ñîíèðõîë òîäîðõîé íºõöºëä õîîðîíäîî õîëäîõ áóþó îéðòîí íèéëýõ òàëòàé байдаг.

**Õàìòûí àøèã ñîíèðõîë:** Ýíý îéëãîëòîä õî¸ð áóþó õýñýã á¿ëýã óëñ îðíû òîäîðõîé àñóóäëààð геополитикийн салбарт áàðèìòëàõ áîäëîãî ¿éë àæèëëàãàà, ººðñäèéí геополитикийн àøèã ñîíèðõëûã õýðýãæ¿¿ëýõ àðãà, çîðèëò ¿íäñýíäýý á¿ðýí ä¿¿ðýí èæèë áàéõûã õàìààðóóëæ áîëîõ þì. Èéì íºõöºë áàéäàë òóõàéí óëñ îðíóóä, ººðñäèéí геополитикийн àøèã ñîíèðõëûã òóñ òóñäàà áèå äààí õýðýãæ¿¿ëýõ áîëîìîîã¿é áóþó áýðõøýýëòýé ¿åä èõýâ÷ëýí áèé áîëäîã áºãººä ¿¿íä îðîëöîã÷ óëñ îðíóóä á¿õ òàëààð õàìòðàí àæèëëàõ øààðäëàãûã ¿¿ñãýäýã áàéíà.

Геополитикийн шинэ нөхцөл байдалд дахь үндэсний àøèã ñîíèðõлын тухайд:

**Үндэсний ÿçãóóð àøèã ñîíèðõîë**. Одоо ìºðäºãäºæ áóé Үндэсний аюулгүй байдлын үзэл áàðèìòëàëä ¿íäýñíèé ÿçãóóð ашиг сонирхлыг “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана” хэмээн харьцангуй үндэслэлтэй зөв тодорхойлсон байна. Гэхдээ энэхүү төслийн ажлаар явуулсан судалгааны үр дүнд тулгуурлан энэ тодорхойлолтыг өнөө үед бий болсон геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан бага зэрэг цомхотгох, гэхдээ зарим тулгуур ойлголтын агуулгыг тодотгож, хэллэг найруулгын хувьд арай оновчтой болгон дараах байдлаар томьёолох нь зүйтэй санагдаж  байна. ¯¿íä:

“Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé ÿçãóóð àøèã сонирхолд төрийн тусгаар тогтнол, á¿ðýí ýðõò байдал, íóòàã äýâñãýðèéí á¿ðýí á¿òýí, óëñûí õèëèéí õàëäàøã¿é äàðõàí áàéäàë, монгол ñî¸ë èðãýíøèë, ¿íäýñíèé ýâ íýãäýë, монгол хүний удмын сан, угсаа гарвал, төр, уламжлалт шашнаа дээдлэх үзэл санаа áàãòàíà” хэмээн томьёолбол геополитикийн өнөөгийн шинэ нөхцөл байдалд илүү оновчтой болно гэж бодож байна.

**Үндэсний àìèí ÷óõàë àøèã ñîíèðõîë.** Ýíý àøèã ñîíèðõîëä ¿íäýñòýí óëñûí õóâüä îðøèí òîãòíîõ õóâü çàÿàíä øèéäâýðëýõ íºëºº ¿ç¿¿ëýõã¿é áîëîâ÷ ò¿¿íèé ÷àíàð ÷àíñààã

òîäîðõîéëîõòîé õîëáîîòîé õ¿÷èí ç¿éë¿¿ä õàìààðàõ þì. Энд ºâºã äýýãñýýñ ºâëºí ¿ëäýýñýí ìîíãîë ¿íäýñòíèé ºâºðìºö ò¿¿õ, ñî¸ë, òºðºëõ õýë, óàìûí ñàí, óãñàà ãàðâàë, õ¿ðýýëýí áàéãàà áàéãàëü îð÷èí çýðýã ìàø îëîí зүйлийг бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдалд хадгалан хамгаалах асуудал áàãòàõ áºãººä òýäãýýðèéí ¿íýëýìæòýé õîëáîîòîé îëîí õ¿÷èí ç¿éëèéã ººðòºº àãóóëààã áîëíî.

**Үндэсний ÷óõàë àøèã ñîíèðõîë.** Ýíý àøèã ñîíèðõîëûí òîîíä þóíû ºìíº өнөө үед бий болсон олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдалд óëñ îðíû íèéãýì, ýäèéí çàñàã, îþóí ñàíààíû òîãòâîðòîé õºãæèë, èðãýäèéí ýëáýã õàíãàëóóí, ýíõ àìãàëàí àìüäðàë, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëºº, íèéãìèéí äýã æóðàì, àþóëã¿é áàéäàë, ¿íäýñòýí ÿñòàí, øàøèí ø¿òëýãèéí çºð÷èëäººí, çîõèîí áàéãóóëàëòòàé ãýìò õýðãýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ, òàñëàí çîãñîîõ ÷àäàâõè ãýõ ìýò õ¿÷èí ç¿éëñèéã хамааруулж áîëîõ þì

## 4.1.2. Үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэл сорилт, аюул заналын таамаглал

Өмнөх бүлэг, дэд бүлэг, хэсгүүдэд авч үзсэндээ тулгуурлан Ìîíãîë Óëñûí эргэн тойронд бий болсон геополитикийн нөхцөл байдлаас үүдэн үндэсний аюулгүй байдалд ó÷èð÷ áîëçîøã¿é эрсдэл сорилтыг äàðààõ áàéäëààð тодорхойлж болохоор байна..

**Үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй олон улсын харилцааны үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилт.**

- Олон улсын аюулгүй байдлыг хангах өнөөгийн механизмууд, юуны өмнө НҮБ, ЕАБХАБ зэргийн үүрэг, ач холбогдлыг бууруулах гэсэн зарим том гүрний эрмэлзэл хүчтэй нэмэгдэж байна;

- Олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд бага орнуудыг аль болох оролцуулахгүй байх, тэднийг үл тоомсорлох хандлага газар авах боллоо;

- Улс хоорондын харилцаанд цэрэг-улс төрийн эвсэл холбоодыг бэхжүүлэх, юуны өмнө НАТО-г дорно зүгт тэлэх, Орос, Хятадын цэрэг-стратегийн хамтын ажиллагааг холбоотны хэмжээ рүү ойртуулан гүнзгийрүүлэх эрмэлзэл ажиглагдаж байна;

- Улс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр зэвсэгт хүчнээ ашиглах практик АНУ, Орос, Хятад, Турк гэх мэт орнууд болон НАТО-ийн тухайд хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна. Тэр ч байтугай үүнийгээ цэрэг-стратегийн номлолдоо тусгахыг чармайх болоод байна.

- Тэргүүлэгч зарим гүрний технологийн хөгжлийн хэт тасархай байдал улам нэмэгдэж, шинэ үеийн зэвсэг, байлдааны техник бүтээх чадавх нь ихсэж байгаа нь зэвсэглэлээр хөөцөлдөх чанарын шинэ үе шатыг авчирч, байлдааны ажиллагааны арга хэлбэрт зарчмын гэж хэлж болох өөрчлөлт оруулах магадлалтай болоод байна.

- Олон улсын терроризм дэлхий нийтийн хэмжээний, олон талт шинж төрхтэй болж байгаа бөгөөд бүх улс орны аюулгүй байдалд ноцтой аюул занал учруулж боллоо.

**У÷èð÷ áîëçîøã¿é àþóë заналын таамаглал**

Ìîíãîë Óëñûí àþóëã¿é áàéäëûí ãàäààä îð÷íû ººð÷ëºëò, ¿íäýñíèé àøèã ñîíèðõîëä íºë°°ëæ áîëçîøã¿é õ¿÷èí ç¿éëñèéã íýãòãýí ä¿ãíýæ ¿çýõýä îéðûí áîëîí äóíä õóãàöààíû èðýýä¿éä Ìîíãîë Óëñûí òóñãààð òîãòíîë, á¿ðýí эрхт áàéäàë, ãàçàð íóòãèéí á¿ðýí á¿òýí, улсын хилийн халдашгүй дархан áàéäàë, òºðèéí áàéãóóëàëòàä ãààíààñ öýðãèéí õ¿÷ýýð øóóä çàíàëõèéëýõ àþóë ¿íäñýíäýý áàéõã¿é áàéíà. Ìàíàé óëñûí îëîí óëñûí íýð õ¿íä ñ¿¿ëèéí æèë¿¿äýä èõýýõýí ºññºí, õºðø õî¸ð îðîíòîéãîî ýëäýâ ìàðãààíòàé àñóóäëàà îëîí óëñûí ýðõ ç¿é õ¿ðýýíä ýöýñëýí øèéäâýðëýñýí, ýíý õî¸ð óëñòàé òîãòîîñîí íàéðñàã õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà ºäð°°ñ ºäºðò ºðãºæèí õºãæèæ áàéãàà íü èéì ä¿ãíýëòýíä õ¿ðãýæ áàéíà.

¯¿íèé çýðýãöýý á¿ñ íóòãèéí õ¿ðýýíä ¿¿ñýí Ìîíãîë Óëñ òàòàãäààí îðæ áîëîõ ýñâýë өөр бусад ãàäààä õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí ¿¿ñ÷ áîëîõ äàðààõ àþóëóóä áîäèòîéãîîð оршиж áàéãàà нь бас õàðàãäàæ áàéíà.

**Á¿ñ íóòãèéí геополиткийн нөхцөл байдлаас үүдэн Ìîíãîë Óëñ òàòàãäààí îðæ áîëçîøã¿é аюул заналын таамаглал.**

- Îëîí óëñûí òåððîðèçì óëàì á¿ð õ¿ðýýãýý òýëæ Ç¿¿í õîéä Àçè, Òºâ Àçèéí á¿ñ íóòãèéã, ò¿¿íèé äîòîð Ìîíãîë Óëñûí íóòàã äýâñãýðèéã õàìðàõ;

- Óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé Õÿòàäûí ýäèéí çàñãèéí ýð÷èìòýé хөгжлийг даган Àçè òèâä öýðýã-óëñ òºðèéí нөлөөллөө ºðãºæ¿¿ëýõ энэ улсын эрмэлзлийг төрүүлэн ¿¿íèé óëìààñ ¿¿íòýé èæèë òºñòýé àøèã ñîíèðõîë á¿õèé ÎÕÓ áîëîí ÀÍÓ-òàé íîöòîé, ºðãºí õ¿ðýýòýé зөрчилдөхөд õ¿ðãýõ, ¿¿íä íü Ìîíãîë Óëñ òàòàãäàõ îðîõ;

- Õî¸ð Ñîëîíãîñ, Õÿòàä-Òàéâàíü, Ýíýòõýã-Ïàêèñòàí õîîðîíäûí ýñðýã òýñðýã áàéð ñóóðü, Êóðèëèéí àðëóóäûí òàëààðõ Îðîñ-ßïîíû ìàðãààí зэрэг нь óëñ õîîðîíäûí õàðèëöààíû òîãòâîðòîé íºõöºë áàéäàëä çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýõ. Ýíý íü á¿ñ íóòãèéã õàìàðñàí øèíæòýé áîëæ ºðãºæèë Ìîíãîë Óëñûã ÿìàð íýã õýëáýðýýð õàìðàõ;

- Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé НАТО-ийí öýðýã-óëñ òºð, ýäèéí çàñãèéí íºëººã õÿçãààðëàõ зорилго бүхий Øàíõàéí õàìòûí àæèëëàãààíû áàéãóóëëàãûí öýðýã-óëñ òºðèéí ýâñýë õýëáýðèéí ¿éë àæèëëàãàà ºðãºæèì ¿¿íèé ¿ð äàãâàðààð ÀÍÓ, Баруны орнууд нэг талаас áîëîí нөгөө талаас Орос, Хятадын õîîðîíä öýðýã, çýâñãèéí õ¿÷èéã òóëãóóð áîëãîñîí çºð÷èë, ñºðãºëäººí үүсэх, ¿¿íä Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðîõ;

- 2008 îíä òîõèîëäñîíòîé төсөөтэй íèéòèéã õàìàðñàí ýäèéí çàñãèéí õÿìðàë Àçè òèâ áîëîí Ç¿¿í Хойд Àçèä áèé áîëæ ýíý íü Ìîíãîë Óëñûí ýäèéí çàñàã, íèéãìèéí õºãæëèéã ñààðóóëàõ áóþó çîãñîîõ áàéäàëä îðóóëàõ;

- Õºðø çýðãýëäýý áîëîí áóñàä îðîíä ¿¿ññýí õÿìðàëòàé áàéäëààñ ¿¿äñýí õÿíàëòààñ ãàðñàí öàãàà÷ëàë, æèðèéí áîëîí çýâñýãëýñýí ä¿ðâýëòýä íýðâýãäýõ çýðýã áîëîí.

**Уламжлалт бус аюул заналын таамаглал.**

Олон улсын ээдрээтэй нөхцөл, улс төрийн тогтворгүй байдал, үндэсний эдийн засгийн хямрал, нийгмийн хуваагдал, түүний дотор шашин хоорондын

харилцааны зарим нэг зөрчил сөргөлдөөн зэрэг нь манай орны аюулгүй байдалд учрах гадаад, дотоод үүдэлтэй уламжлалт бус аюул заналын эх сурвалж болж байна. Үүнд:

Óëñ òºðèéí õ¿ðýýíä:

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгай байдлаа бий болгох гэсэн том гүрнүүдийн зөрчил сөргөлдөөн болон тэдгээрийн манай улсын тухайд явуулж буй тус тусын тодорхой  чиглэл, зорилго бүхий геостратегийн бодлогын нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн бодлогод саад бэрхшээл үүсэх, àëü íýã óëñ îðîí, óëñ òºð-öýðãèéí ýâñýë õîëáîî áóþó ¿íäýñòýí äàìæñàí òîì êîðïîðàöóóäààñ улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар õàðààò áàéäàëä орох;

- Олон улсын терроризм улам бүр газар авч байгаа болон манай улс терроризмын эсрэг барууны эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гадны хүчний  явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирэх;

- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад орнуудын зүгээс манай орны эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаагаа нэмэгдэх, энэ нь чиглэл, зорилготой, нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болох.

Ýäèéí çàñãèéí õ¿ðýýíä**:**

- Гадаадын хөрөнгө оруулалт, бусад улстай хийх худалдааг тэнцвэржүүлэх нэгдсэн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох;

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого, үйл ажиллагаанд алдаа, доголдол гарах, үүний улмаас эдийн засгийн салбарт тогтвортгүй байдал үүсэх, мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гарах, дампуурал орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл  сулрах ;

- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажаагүй гадны зээл тусламж нэмэгдэх, үнэт цаасны зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр çàñàã, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орох, улс орон âàëþòûí íººö ºº àëäàõ,

áàðüöààëóóëàõ, ãàäààä äîòîîäûí õºðºíãº îðóóëàëò эмх замбараагүй байдалтай болох, түүнчлэн çýýë, òóñëàìæûã çàìààñ íü çàâøèõ ÿâääë ãàçàð àâñàíààñ ¿¿äýí ãàäààä îðíóóä, ò¿¿íèé äîòîð òîì ã¿ðí¿¿ä ýíý òºðëèéí ¿éë àæèëëàãàà õýðýãæ¿¿ëýõýý çîãñîîõ.

<u>Íèéãìèéí õ¿ðýýíä:</u>

- Õóóðàì÷, õààãàëàõ õóãàöàà õýòýðñýí, õ¿íèé áèå îðãàíèçìä õîðòîé õ¿íñ, ýì òàðèà, õóâöàñ, ýä õýðýãëýë ãýõ ìýò ç¿éë¿¿ä ãààíààñ ихээр îðæ èðýõ, ãàäààä õàðèëöàà ºðãºæèæ õ¿í, ìàë, áàðàà á¿òýýãäõ¿¿íèé óðñãàë ÷ºëººòýé áîëîõ õýðýýð ýëäýâ õàëäâàðò ºâ÷èí òàðõàõ, ¿¿íèé äîòîð ÄÎÕ, шинэ вирусийн болон íýí õàëäâàðò áóñàä ºâ÷íººð ºâ÷ëºãñäèéí òîî ºñºõ;

- Óëñ îðíû õýìæýýíä, ¿íäýñòýí äàìæñàí ãýìò õýðãèéí á¿ëýãëýë¿¿ä áèé бол, ýð¿¿ãèéí íºõöºë áàéäàë õÿíàëòààñ ãàðàõ ìàíàé óëñûí íóòàã äýâñãýðèéã ìàíñóóðóóëàõ áîäèñ, ýëäýâ òºðëèéí çýâñýã, öºìèéí ò¿¿õèé ýä, ìàòåðèàë, õ¿í õóäàëäààëàõààð çººâºðëºõ, äàìæóóëàõ òàëáàð áîëãîõ îðîëäëîãî ãàðàõ, òýäãýýðèéí õîð óðøèã íü óëñ îðíû óëñ òºð, ýäèéí çàñãèéí áîäëîãîä íºëººëºõ õýìæýýíä хүрэх;

- Харт тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь олон улсын зохион байгууллалттай гэмт хэргийн хэлбэрт шилжих .

<u>Ñî¸ë èðãýíøëèéí õ¿ðýýíä:</u>

- Ìîíãîë Óëñûí ãàäààä õàðèëöàà ºðãºæèõ, íýýëòòýé áîëîõ õýðýýð áóñàä îðíû àìüäðàõ õýâ ìàÿã, ýðõýìëýõ ¿íýò ç¿éëñèéí õ¿÷òýé íýâòðýë гүнзгийрэх, ¿¿íýýñ ¿¿äýí ¿íäýñíèé ¿íýò ç¿éëñèéí ¿íýëýìæèä ýðãýæ áóöàëòã¿é ººð÷ëºëò ãàðàõ, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлөх;

- õ¿í òºðºëõòíèé íèéòëýã ñî¸ëûã äýýäëýõ, áóñàä øàøíûã õ¿íäýòãýõ, зарим тохиолдолд албан ёсны бус гаднаас орж ирсэн шашны урсгалд автах ¿çýë áîëîí ìîíãîë ¿íäýñòíèé òºðºëõ õýë, ñî¸ë, áóðõàíû øàøèí, ¸ñ çàíøèë, óäìûí ñàí, óãñàà ãàðâàëàà õàäãàëàí õàìãààëàõ ãýñýí ýðìýëçëèéí õîîðîíä çºð÷èë, ñºðãºëäººí ¿¿ñýõ, ýíý íü óëñ òºðæèõ çàìààð íèéãýìä áóõèìäàë ¿¿ñãýх.

<u>Áàéãàë îð÷íû õ¿ðýýíä:</u>

- Äýëõèéí öàã óóðûí äóëààðàë, ººð÷ëºëò áîëîí áóñàä øàëòãààíààñ ¿¿äýí áàéãàëèéí ãàìøèãò ¿çýãäë¿¿ä îëøðîõ ýíý íü óëñ îðíû ýäèéí çàñàã, íèéãýìä äààæ äààâàøã¿é õîõèðîë учруулах;

- Хэт их гадаадын хөрөнгө оруулалт бүхий óóë óóðõàéí áîëîí áîëîâñðóóëàõ ¿éëäâýðëýëèéã ýð÷èìæ¿¿ëýõ ÿâöàä áàéãàëèéí òýíöâýð àëäàãäàõ, óñ, ãîë ìºðºí, àãààð ìàíäàë, õºðñ áîõèðäîõ, îé ñ¿éäýõ, öºëæèëò ãàçàð àâàõ, áýë÷ýýðèéí òàëõäàë, òàðèàëàíãèéí òàëáàéí õîìñäîë èõñýõ, ýäãýýðýýñ ¿¿äýí õ¿í àìûí íýëýýä õýñãèéí àìüæèðãààíû ýõ ¿¿ñâýð áîëñîí ìàë àæ àõóé, ãàçàð òàðèàëàíãèéí õºãæèë çîãñîíãè áàéäàëä îðîõ, өөр хоорондоо тэрсэлдэх;

- Манай орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах оролдлого гарах.

**4.1.3. Геополитикийн салбарт баримтлах бодлогын үндсэн зорилго, чиглэл, агуулга, хэрэгжүүлэх арга зам.**

Ìîíãîë Óëñûí õóâüä ºíººãèéí íºõöºëä геополитикийн àþóëã¿é áàéäëàà áèå äààí õàíãàõ óëñ òºð, öýðãèéí àðãà õýðýãñýë, ýäèéí çàñãèéí íººö áîëîìæîî õÿçãààðëàãäàìàë юм. Èéìýýñ улс орны геополитикийн àþóëã¿é байдлаа хөрш болон ойр зэргэлдээ том гүрнүүдийн Монгол Улсын талаар баримталж буй геостратегийн бодлого болон тэдгээрийн хоорондын геополитикийн өрсөлдөөний учир шалтгааныг тунгаан ойлгох, тооцох, эерэг нөлөөллийг ухаалгаар ашиглах, сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, болзошгүй үр дагаврыг нь арилгахад бэлэн байхад чиглэсэн, геополитикийн салбарт төрөөс баримтлах өөрийн гэсэн тусгайлсан áîäëîãûã õýðýãæ¿¿ëýõ çàìààð õàíãàõ íü ç¿éòýé þì. Энэ áîäëîãî íü ó÷èð÷ áîëîõ геополитикийн áîäèò àþóëûã òîãòîîë ¿íýëæ, геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõàä îëãîæ áàéãàà á¿õ áîëîìæèéã äýýä çýðãýýð àøèãëàõ áîëîí ìàíàé орны геополитикийн áîäèò íººö, áîëîìæîîíä òóëãóóðëàñàí áàéõ íü ÷óõàë áîëîí.

Ìîíãîë Óëñûí геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõ àñóóäàë þóíû ºìíº ìàíàé îðíû геополитикийн íýð õ¿íäèéã îëîí óëñûí òàâöàíä òîãòîîë íýìýãä¿¿ëýõ, геополитикийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн ýäèéí засгийг хөгжүүлэх цэгцтэй бодлоготой байх, àðä÷èëëûã öààøèä áýõæ¿¿ëýõ, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëººã õàìãààëàõòàé øóóä õîëáîîòîé þì. ¯¿íèé äîòîð геополитикийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн ýäèéí засгийг хөгжүүлэх цэгцтэй бодлого íü àðä÷èëàë, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëººã õàìãààëàõ, àðä ò¿ìýíä çàñãèéí ýðõèéã áîäèòîéãîîð áàðèõ íºõöëèéã áèé

áîëãîõ à÷ õîëáîãäëîîðîî òýðã¿¿ëýõ ááéð ñóóðü ýçëýõ ó÷èðòàé áîëíî. Íºãººòýéã¿¿ð ýäèéí çàñãèéí õºãæèë íü улс орны аюулгүй байдлыг хангах нэг ãîë õ¿÷èí ç¿éë болох учиртай юм. Ìîíãîë óëñ çºâõºí òîãòâîðòîé õºãæèæ áóé ýäèéí çàñàãòàé, òºðèéí áàéãóóëàëòûí àðä÷èëñàí òîãòîëöîîòîé ááéæ õýìýýí äýëõèéí áóñàä îðíóóäòàé аюулгүй байдлын салбарт èæèë ò¿âøèíä õàðüöàõ áîëîìöîîòîé áºãººä ýíý íü геополитикийн àþóëã¿é ááéäëàà áàòàëãààæóóëàõ ãîë õýðýãñýë байх болно.

Ìîíãîë Óëñ æèæèã îðíû õóâüä èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ íü геополитикийн àþóëã¿é ááéäëûã õàíãàõ ÷óõàë õýðýãñýë ìºí. Èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ íü òýäíèé îþóíû ÷àäààõè, áîëîâñðîë, ýð¿¿ë ìýíä, àìüäðàëûí ò¿âøèíã äýýøë¿¿ëýõ, íèéãìèéí èäýâõèéã íü íýýí ãàðãàõ, ººðºã ñýòãýëãýýã õºãæ¿¿ëýõ, Ýõ îðíîîðîî áàõàðõàõ, ¿íäýñ óõààãààà õàäãàëàõ ãýñýí ¿å äàìæñàí õ¿ì¿¿æèëòýé áîëãîõ çýðýã îëîí àñóóäëûã ººðòºº àãóóëàõ þì.

Ýíý á¿õýíä ä¿ãíýëò õèéæ ¿çýõýä Ìîíãîë Óëñûí геополитикийн íýð õ¿íäèéã îëîí óëñûí òàâöàíä ºðãºõ, òºð, íèéãìèéí àðä÷èëñàí òîãòîëöîîã õàìãààëàí áýõæ¿¿ëýõ, óëñ îðíû гео ýäèéí çàñãèéí òîãòâîðòîé õºãæëèéã õàíãàõ, Ìîíãîëûí õ¿í àìûã õ¿÷èðõýãæ¿¿ëýõ çýðýã íü ºíººãèéí øèíý íºõöºë ááéäààëä геополитикийн àþóëã¿é ááéäëûã õàíãàõ бодлого, үйл ажиллагааны ãîë àãóóëãà áîëîõ íü õàðàãäààæ ááéíà.

**Алсын хараа, стратегийн зорилт, үндсэн чиглэл.**

<u>Алсын хараа.</u>

Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын алсын харааг “Энхийг ýðõýìëýñýí олон тулгуурт ãàäààä бодлогоо эрчимжүүлэх, Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, олон улсын тавцанд геополитикийн өндөр нэр хүнд, өөрийн гэсэн байр суурь, дуу хоолойтой хэмээн хүлээн зөвшөөрөгдөх, геополитикийн шинэ нөхцөл байдал, үндэсний хөгжлийн онцлог, өнөөгийн шаардлага, хэтийн төлөвт нийцсэн геостратегийн бодлого баримтлахад оршино” хэмээн тодорхойлж болохоор байна.

Үүн дээр тулгуурлан геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын стратегийн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг дараах байдлаар тодорхойлж болох юм гэж үзлээ:

<u>Стратегийн 1 дүгээр зорилт</u>

Шинээр буй болсон геополитикийн нөхцөл байдал, олон улсын аюулгүй байдлын гадаад орчин, улс орны хөгжлийн шинж чанар, хэтийн төлөв, ирээдүйн хандлагад нийцүүлэн Үндэсний аюулгүй байдлын бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болгон геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулж хэрэгжүүлэх, үйл ажиллагааных нь технологи, арга механизм, эрх зүйн орчныг бий болгох.

<u>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</u>

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг манай улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ орчин, үүнээс үүдэн улс орны дотоодод бий болсон нөхцөл байдалд нийцүүлэн шинэ утга агуулгаар баяжуулж, тодотгон шинэчлэх;

- “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” нэртэй байж болох бодлогын баримт бичгийг боловсруулах.

- Аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, бусад салбарын бодлогод геополитикийн үүдэл сэдэлтэй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах агуулга бүхий тодотгол хийх, геополитикийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан бодлого хэрэгжүүлэх, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизмыг бий болгох, үйл ажиллагааг нь хэвшүүлэх.

<u>Стратегийн 2 дугаар зорилт</u>

Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, îëîí óëñûí аюулгүй байдлын õàìòûí ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэх замаар геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэх.

<u>Үйл ажиллагааны үндсэн чиглэл:</u>

- Ýíõ òàéâíûã тогтоон барих, аливаа маргаантай асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхэд ÷èãëýñýí óëñ õîîðîíäûí á¿õ òàëûí õàìòûí àæèëëàãàà дахь Ìîíãîë Óëñûí îðîëöîîã èäýâõæ¿¿ëýõ, ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ын зэрэгцээ ÀÍÓ тэргүүтэй гуравдагч áóñàä óëñ орон, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаагаа

өргөжүүлэх, өөрийн зарчимч байр суурь, дуу хоолойгоо нэмэгдүүлэн Ìîíãîë Óëñûí олон улсын геополитикийн тавцанд эзлэх áàéð суурь, ач холбогдлыг өндөрсгөх;

- Хөрш орнууд, нөлөө бүхий гуравдагч бусад гүрний Монгол дахь геополитикийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, эдгээр гүрний геостратегийн зөрчил, сөргөлдөөнөөс үүдэлтэй элдэв, аюул, сорилт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах утга агуулгаар гадаад болон батлан хамгаалах бодлогоо баяжуулах.

Стратегийн 3 дугаар зорилт:

Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалд нийцүүлэн ард÷èëàë, сайн засаглалыг áàòàëãààæóóëàõ, монгол, соёл иргэншил, áàéãàëü îð÷ноо õàäãàëàí õàìãààëàõ, õ¿íèé эрхийг бататгах, èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ, амьдрах таатай орчин, ýðõ чөлөөгөөр хангах зэрэг улс орны геополиттикийн хүчин зүйлийг дээд зэргээр ашиглахад чиглэсэн цэгцтэй бодлого хэрэгжүүлэн үндэсний аюулгүй байдлын дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Үйл ажиллагааны үндсэн чиглэл:

- Ардчиллыг гүнзгийрүүлэх, сайн засаглалыг төрийн удирдлага, нийгмийн харилцаа, хууль эрх зүйн хүрээнд бүрэн хэвшүүлэх, сонгуулийн тогтолцооны шударга байдлыг баталгаажуулах, төрийн байгууллага, улс төрийн нам, иргэний байгууллага, нийт иргэдийн холбоог улс үндэстэн, газар шороо, төр засгаа дээдлэх төрт ёсны уламжлал, үндэсний эх оронч үзэлд тулгуурлан бэхжүүлж óëñ төрийн òîãòâîðòîé áàéäëûã õàíãàõ;

- Ядуурал, нийгмийн баялгийн øóäðààã бус хуваарилалт, авлига болон нийгмийн бусад сөрөг үзэгдэлтэй шийдвэртэй тэмцэх, эдийн засгийн, юуны өмнө óóë óóðõàéí үйлдвэрлэлийн үр ашгийг ард түмэнд тэгш хүртээх, нийт иргэдийг àæëûí áàéð, эдийн засгийн эрх чөлөө, áîëîâñðîë олох, áîëîâñðîë эзэмших, ýð¿¿ë энх амьдрах, хөдөлмөрлөх нөхцөл бололцоогоор бүрэн хангах үндсэн дээр хүн амын амьдралын ò¿âøèíã хурдтай äýýøë¿¿ëýõ;

- Байгалийн ãàìøãûí õîð óðøãààñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ, íýðâýãäýãñýäýä òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ улс орны íýãäñýí òîãòîëöîîã áèé áîëãîõ, óóë óóðõàéí ÷èãëýëèéí áîëîí áóñàä õ¿íä ¿éëäâýðëýë, дэд бүтцийг õºãæ¿¿ëýõäýý áàéãàëèéã ñ¿éòãýõã¿é,

íºõºí ñýðãýýäýã байхыг шаардсан ýðõ ç¿éí õàòóó çîõèöóóëàëòûã áèé áîëãîõ, ãàçðûí àøèãëàëòûã ¿ð ä¿íòýé áîëãîõ, ò¿¿íèé äîòîð áýë÷ýýðèéí áîëîí òàðèàëàíãèéí ãàçàð àøèãëàëòûã ýäèéí çàñãèéí àðãààð çîõèöóóëàõ төрийн бодлогыг хэрэгжүүлэх.

**Хэрэгжүүлэх арга зам**

Улс төрийн  салбарт

- ªºðèéí ãýñýí ¿çýë áîäëîãîé áàéõ, ø¿òýõ, ýñ ø¿òýõ õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëºº, ÷ºëººò õýâëýëèéã òóóøòàé äýìæèõ, îëîíõèéí çàñàãëàëààñ öººíõèéí ýðõ àøãèéã õàìãààëàõ ìåõàíèçìûã áîëîâñðîíãóé áîëãîæ èðãýíèé íèéãìèéã òºëºâø¿¿ëýí óëñ òºðèéí òîãòâîðòîé áàéäëûã õàíãàõ íü Ìîíãîë Óëñûí геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàìãààëàí áýõæ¿¿ëýõ áîëíî.

- Ñîíãóóëèéí òîãòîëöîîã áîëîâñðîíãóé áîëãîõ, àðä èðãýä ñîíãîõ ñîíãîãäîõ ýðõýý ýäëýõäýý á¿õ òºðëèéí ìýäýýëëýýð õàíãàãäàõ, ººðñäèéí ýðõ àøãèéã õàìãààëæ, èëýðõèéëæ ÷àäàõóéö õ¿ì¿¿ñèéã ñîíãîõ áîëîëöîîã îëãîñîí òèéì íºõöºë áàéäëûã á¿ðä¿¿ëýõ íü òºð çàñãèéí áîëîí òºðèéí áóñ áàéãóóëëàãóóä, íèéò èðãýäèéí ÷óõàë ¿¿ðýã áîëæ áàéíà.

- Öàãäàà, òàãíóóë, ø¿¿õ, ïðîêóðîð ãýõ ìýò áàéãóóëëàãóóäûã õ¿íèé ¿íäñýí ýðõèéã çºð÷èõã¿éãýýð ãýìò õýðýãòýé òýìöýõ, íèéãìèéí õýâ æóðìûã ñàõèóëàõ ¿éë àæèëëàãààíä ñóðàëöóóëàõ, íºãºº òàëààñ èðãýäèéã òºðèéí õóóëü ¸ñûã ñàõèí áèåë¿¿ëýã, äýýðõ áàéãóóëëàãóóäûí ¿éë àæèëëàãààã îëãîíîã, äýìæäýã íºõöëèéã á¿ðä¿¿ëýõ ÿâààë à÷ õîëáîãäîëòîé áîëæ áàéíà.

- Òºð, çàñãèéí áàéãóóëëàãûí ¿éë àæèëëàãààã öààøèä èë òîä áàéëãàõ íü òºð, îëîí ò¿ìíèé õîëáîîã áýõæ¿¿ëýõ, ¿ð àøãèéã íýìýãä¿¿ëýõ, àâèëãàëòàé òýìöýõýä îëîí íèéòèéí ñàíàà áîäîë, õ¿ñýë ýðìýëçëèéã òóñãààã áîëãîõîä òóñòàé áàéõ áîëíî. Ìºí èðãýäèéí ø¿òýõ, ýñ ø¿òýõ ýðõèéã áîäèòîéãîîð õàíãàõ àñóóäàë õóðöààð òàâèãäñààð áàéõ òºëºâòýé áàéíà.

Эдийн çàñãèéí салбарт

- Ýäèéí çàñãèéí ñàëáàðûí òîãòâîðòîé õºãæèë íü геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõàä øèéäâýðëýõ ¿¿ðýãòýé áîëæ áàéíà. Õóâèéí õýâøèë òýðã¿¿ëñýí, ýêñïîðòûí ÷èãëýëòýé, íýýëòòýé ýäèéí çàñãèéã õºãæ¿¿ëýõ, Ìîíãîë Óëñàà àøèãòàé ãàäààäûí õºðºíãº îðóóëàëòûã äýìæèõ íü äýëõèéí çàõ çýýë äýýð áîëæ áàéãàà

ººð÷ëºëòºä ò¿ðãýí äàñàõ ÷àäâàðòàé ýàèéí çàñãèéí á¿òýö áèé áîëãîõ áîäëîãî, ¿éë àæèëëàãààíû ¿íäñýí àãóóëãà þì. Ýíý íü Ìîíãîëûí ýäèéí çàñãèéí ºðñºëäºõ ÷àäâàðûã íýìýãä¿¿ëýõýä ãîëëîõ ¿¿ðýãòýéí çýðýãöýý геополитикийн àþóëã¿é áàéäëûí ãîë áàòàëãàà áîëîõ ó÷èðòàé.

- Ýêñïîðòûã äýìæèõ, ýíý ÷èãëýëèéí ãàäààä äîòîîäûí õóâèéí õýâøëèéí ¿éëäâýð¿¿äòýé Çàñãèéí ãàçðààñ àæèëëàõ àðãà áàðèë, òóõàéëáàë, ýêñïîðòûã ñàíõ¿¿æ¿¿ëýõ, ìýäýýëëèéã ò¿ðãýí øóóðõàé áîëãîõ, á¿òýýãäýõ¿¿íèé ÷àíàð, ñòàíäàðòûí òàëààð ñóðãàëò ÿâóóëàõ õºòºëáºð ãàðãààæ àæèëëàõ øààðäëàãà òàâèãäààæ áàéíà. Çàñãèéí ãàçàð, ãàäààäû äîòîîäûí õºðºíãº îðóóëàã÷äûí õóâèéí õýâøëèéí õàìòûí àæèëëàãààã àëáàí ¸ñîîð õýëáýðø¿¿ëæ, ¿éë àæèëëàãààã íü ñàéæðóóëàõ íü ÷óõàë áîëíî.

- Òºðººñ õºãæëèéí àñóóäàë õàíäàõäàà á¿ñ÷èëñýí õºãæëèéí ¿çýë áàðèìòëàëûã òóëãóóð áîëãîæ áàéãàà íü геополитикийн àþóëã¿é áàéäëûí àøèã ñîíèðõîëä íèéöýõ þì. Ìºí àëü áîëîõ àæëûí îëîí áàéð áèé áîëãîñîí ãàäààä äîòîîäûí êîìïàíèóäûã òºðººñ äýìæèõ àñóóäàë ÷óõàë à÷ õîëáîãäîëòîé þì. Ýíý íü ÿäóóðëûã áóóðóóëàõàä áîäèòîé íºëºº ¿ç¿¿ëýõ áîëíî.

- Áàíê, ñàíõ¿¿ãèéí ñàëáàðò îëñîí îëîëòûã áàòàòãàæ, öààøèä ýíý ñàëáàðò õóâèéí õýâøèë, ò¿¿íèé äîòîð ãàäààäûí íýð õ¿íä á¿õèé áàíê, ñàíõ¿¿ãèéí áàéãóóëëàãóóäàà ¿éë àæèëëàãààãàà ÿâóóëàõ ýðõ ç¿éí òààëàìæòàé íºõöëèéã õàíãàõ ÿâààë ÷óõàë þì. Ò¿¿í÷ëýí Ìîíãîë Óëñûí ýêñïîðòûí ãîë íýðèéí áàðààã äýëõèéí çàõ çýýëèéí ¿íèéí õýëáýëçýëýýñ äààòãóóëàõ íü ýäèéí çàñãèéí ºð߀ñãºë á¿òýöòýé Ìîíãîë îðíîä òºñâèéí òîãòâîðòîé ýõ ¿¿ñâýðòýé áàéõàä íºëºº áîëîõ à÷ õîëáîãäîëòîé áàéæ áîëîõ òàëòàé.

Нийгмийн салбарт

- Геополитикийн àþóëã¿é áàéäëûí àñóóäëààð á¿õ íèéòýä àëáàí áóñ áîëîâñðîë îëãîõ õºòºëáºð õýðýãæ¿¿ëýõ øààðäëàãàòàé á¿ãººä ýíý íü Ìîíãîëûí íèéãìèéí õóâüä ¿íäýñíèé çºâøèëöºë áèé áîëãîõîä òóñòàé áàéõ áîëíî.

- ßäóóðàëòàé òýìöýõ, õ¿í àìûã îðëîãîîðîî òóéëøðàõûí ýñðýã á¿õ òàëûí àðãà õýìæýý àâàõ íü Ìîíãîë Óëñûí геополитикийн àøèã ñîíèðõîë øààðäààæ áàéíà. Èíãýõäýý çàõ çýýëèéí æàì ¸ñíû õºãæëèéã áîîìèëæ áàñ áîëîõã¿é þì.

- Ãàäàààä îðíîîñ èðæ îðøèí ñóóã÷èä, öàãàà÷äûí àìüäðàõ, àæèëëàõ ýðõ ç¿éí îð÷íûã òîäîðõîé áîëãîõ, ò¿¿í÷ëýí ãàäàààààä îðøèí ñóóã÷ ìîíãîë èðãýäýä òºðèéí ç¿ãýýñ áîëîí îëîí óëñûí áàéãóóëëàãûí òóñëàìæòàéãààð òàë á¿ðèéí òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ àðãà ìåõàíèçìä ìàíàé áàéãóóëëàãóóä ñóðàëöàõ ¸ñòîé áîëæ áàéíà.

- Ãýð á¿ëèéí ¿íý öýíèéã õàìãààëàí áýõæ¿¿ëýõ, ýíý òàëààð àæèëëàæ áàéãàà îëîí íèéòèéí áîëîí õóâèéí áàéãóóëëàãàä á¿õ òàëààð äýìæëýã òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ ÿâäàë íèéãìèéã ¸ñ ñóðòàõóóíû äîðîéòîë, ÄÎÕ-ûí àþóëààñ àâðàõ ¿ð ä¿íòýé àëõàì áàéõ áîëíî.

Áàéãàëü орчны салбарт

- Áàéãàëèéí ãàìøèã ãýñýí îéëãîëòûí ýðõ ç¿éí болон геополитикийн àãóóëãûã òîäîòãîæ, ò¿¿íä íýðâýãäýãñýäýä òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ òîãòîëöîîã áèé áîëãîõ, ýíý òàëààð îëîí óëñûí õ¿ì¿¿íëýãèéí áàéãóóëëàãóóäòàé ºðãºí õàìòûí àæèëëàãàà ÿâóóëàõ øààðäëàãàòàé áîëæ áàéíà.

- Ìîíãîë Óëñàä óóë óóðõàé ÷èãëýëèéí áîëîí áóñàä õ¿íä ¿éëäâýðëýëèéã õºãæ¿¿ëýõäýý áàéãàëèéã ñ¿éòãýõ¿é, íºõºí ñýðãýýäýã áàéõ ýðõ ç¿éí õàòóó çîõèöóóëàëòûã áèé áîëãîõ àñóóäàë òóëãàìäñàí çîðèëò áîëæ áàéíà. ¯¿íýýñ ãàäíà ãàçðûí àøèãëàëòûã ¿ð ä¿íòýé áîëãîõ, ò¿¿íèé äîòîð áýë÷ýýðèéí áîëîí òàðèàëàíãèéí ãàçàð àøèãëàëòûã ýäèéí çàñãèéí àðãààð çîõèöóóëàõ ÿâäàë ÷óõëààð òàâèãäàæ ýõýëëýý.

**4.2. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Батлан хамгаалах бодлогын үндэст тодотгол хийх үндэслэл.**

**4.2.1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодотгол хийх үндэслэл.**

1990-ýýä îíä ñîöèàëèñò õàìòûí íºõºðëºëèéí ãýãäýæ áàéñàí îðíóóäûí ¿çýë ñóðòàë, ýäèéí çàñàã, áàòëàí õàìãààëàõ íýãäñýí òîãòîëöîî çàäðàí òàðñíààð ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëàà õàíãàõ төрийн бодлого, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг цоо шинээр цэгцлэн боловсруулах çàéëøã¿é øààðäëàãà òóëãàðñàí áèëýý.

Эхлээд Монгол Улсын шинэ Үндсэн хуульд үндэсний аюулгүй байдалтай холбогдол бүхий гол зүйл, заалтуудыг тусган дараа нь үүн дээрээр тулгуурлан

“Ìîíãîë Óëñûí ¯íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàë” õýìýýõ íýãýí áàðèìò áè÷ãèéã áîëîâñðóóëæ 1994 îíä ÓИХ-аас áàòëàí ãàðãàñàí íü Ìîíãîëûí òºðò ¸ñíû óëàìæëàëä òóëãóóðëàñàí ýð¿¿ë ñàðóóë óõààíû òîì àìæèëò áîëñîí þì. Үүний дараагаар энэ Үзэл баримтлал дээр тулгуурлан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулийг боловсруулж УИХ-аар  батлан гаргасан. Улмаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг тодотгон шинэчилж 2010 онд УИХ-аас батлан гаргасан билээ. Эдгээр нь үндэсний аюулгүй байдлын салбарын эрх зүйн зохицуулалтын үндсэн эх баримт бичгүүд юм.

Үндэсний аюулгүй байдлын салбарын эрх зүйн тогтолцоог бий болгох ажил эхэлснээс хойш 30 шахам жил өнгөрлөө. Ìîíãîë Óëñ àðä÷èëàë, çàõ çýýëèéí ýäèéí çàñàã, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëººã ýðõýìëýñýí èðãýíèé àðä÷èëñàí íèéãýì áàéãóóëàõ èõ øèëæèëòèéã ááãàà¿é àìæèëò îëëîî. Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ íýãäìýë òîãòîëöîîã á¿ðä¿¿ëýõ àæèë àëãóóð áîëîâ÷ óðàãøèëñààð áàéíà**.** Ãýâ÷ ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí салбарын эрх зүйн зохицуулалт бүрэн дүүрэн боловсруулагдаж энэ салбарын үйл ажиллагааг òºðèéí áîäëîãîîð íýãòãýí õýðýãæ¿¿ëýõ, ã¿éöýòãýëä íü õÿíàëò òàâèõ ¿ð ä¿íòýé ìåõàíèçì áèé áîëëîî ãýæ õýëýõ áàñ õàðààõàí áîëîîã¿é áàéãàààãèéí äýýð Ìîíãîë Óëñûã õ¿ðýýëñýí ãàäààä îð÷èí, манай орныг хүрээлсэн олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдал, мөн äîòîîä íºõöºë áàéäàëä ÷ ºíãºðñºí õóãàöààíä áàãààã¿é ººð÷ëºëò îðëîî. Èéì ó÷ðààñ үндэсний аюулгүй байдлын салбарын хууль тогтоомжуудыг бүхэлд нь эргэн харж бий болсон геополитикийн шинэ орчинтой нийцүүлэн òîãòîãîî øèíý÷ëýõ òàëààð ÿðèãääàõ áîëñîí íü ç¿é ¸ñíû õýðýã þì.

Òýãýýä ч àþóëã¿é áàéäëûí салбарын хууль тогтоомжид олон улсыг геополитикийн нөхцөл байдал, äýëõèé äàõèíû, á¿ñ íóòãèéí áîëîí óëñ îðíû áàéäàë, õºãæèë, ºðíºëòèéí ÷èã õàíäëàãàä ãàð÷ áàéãàà эрс ººð÷ëºëòòýé уялдуулан цаг тухайд нь өөрчлөлт хийж байхын ач холбогдол хэн бүхэнд ойлгомжтой зүйл юм.

Ер нь аливаа óëñûí àþóëã¿é áàéäëûí салбарын хууль тогтоомж íü õàðüöàíãóé óðò õóãàöààíû òºðèéí áîäëîãûí èëýðõèéëýë байхынхаа зэрэгцээ äýëõèé åðòºíö ò¿ðãýí ººð÷ëºãäºæ áàéãàà íºõöºëä ò¿¿íä òîõèðîí òîãòîãîîãîæ, äîòîîä ãàäààä áîäëîãûí ¿ð ºãººæèéã íýìýãä¿¿ëýõ ÷àíàð íü ñàéæðàí, òºð, íèéãýì, èðãýäèéí ¿éë àæèëëàãààíû òóõàéí öàã ¿åèéí íýãäìýë õ¿ñýë ýðìýëçëèéã òîãòîõîéëîã÷ õ¿÷èí ç¿éë áîëîõ ¸ñòîé нь олон улсын жишиг áàéäàã.

Ìîíãîë Óëñûí ¯íäýñíèé àþóëã¿é áàéäëûã îëîí óëñûí геополитикийн нөхцөл áàéäàë, ò¿¿íèé õºãæèë, õàíäëàãà, õºðø çýðãýëäýý îðíóóäûí äîòîîä, ãàäààä áàéäàë, òýäíèé õîîðîíäûí õàðèëöàà çýðýã îëîí õ¿÷èí ç¿éëýýñ àíãèä àâ÷ ¿çýõ áîëîìæã¿é þì. Óëàì á¿ð íýýëòòýé áîëæ áàéãàà äýëõèé åðòºíöºä ÿìàð ÷ îðíû àþóëã¿é áàéäàë óëñ õîîðîíäûí õàðèëöààíû øèíæ ÷àíàðààñ èõýýõýí õàìààðàõ áîëæ áàéíà. ßëàíãóÿà Ìîíãîë ìýòèéí áàãà îðíû õóâüä ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëàà õàìãààëàí áýõæ¿¿ëýõ áîäëîãî, ¿éë àæèëëàãàà íü äýëõèéí îëîí óëñûí õºãæëèéí ç¿é òîãòîë, óëñ õîîðîíäûí õàðèëöààíû болон геополитикийн өрсөлдөөний чиг хандлагыг óðüä÷èëàí õàðæ ò¿¿íä ººðèéí áàéð ñóóðèà çºâ îëîõîîñ èõýýõýí øàëòãààëàõ áîëíî.

Ингэхдээ 2010 онд шинэчлэгдэн батлагдсан Үндэсний аюулгүй байдлын ¿çýë áàðèìòëàëûã òîäîðõîé õýìæýýíèé òîäîòãîë õèéí ¿íäñýí àãóóëãûã íü õ¿÷èíòýéãýýð үлдээн геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан холбогдох тодотгол хийгээд, мөн өнөөг хүртэл тодотгон шинэчлэгдэхгүй явсаар байгаа Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай хуулийг нухацтай өөрчлөн, шинэчлэн боловсруулах нь зүйтэй байж болох юм. Үүний дараагаар гадаад болон батлан хамгаалах бодлогын болон бусад салбарын аюулгүй байдалтай холбогдол бүхий хууль тогтоомжуудыг бүхэлд нь тодотгон шинэчлэх хэрэгтэй болно.

Аюулгүй байдлын салбарын хууль тогтоомжуудыг тодотгон шинэчлэхийн тулд юуны өмнө Монгол Улсын үндэсний аюулгүй байдалтай холбогдол бүхий үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, үндэсний язгуур эрх ашиг, үндэсний ашиг сонирхол, эдгээрийг хангах арга зам гэх мэт тулгуур ойлголтуудыг өнөөдөр бий болсон олон улсын аюулгүй байдал, геополитикийн нөхцөл байдал, гадаад орчин, олон улсын эрх зүйн өөрчлөлттэй уялдуулан дахин эргэн харах нь ихээхэн чухал юм.

Ò¿¿õýí óëàìæëàëûí òàëààñàà болон îëîí óëñûí ýðõ ç¿éí îéëãîëòîîð àëèâàà óëñ îðíû ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë баримтлалын ìºí ÷àíàð íü ýöñèéí ä¿íäýý áóñàä óëñàà öýðýã, çýâñãèéí õ¿÷ýýð çàíàëõèéëýõ, ò¿ðýìãèéëýõ íºõöºëä ººðèéãºº õàìãààëàõ áîëîëöîî, ÷àäàâõèéã á¿ðä¿¿ëýõýä îðøäîã áàéíà.

¯¿íèé çýðýãöýý, ÿëàíãóÿà ”Õ¿éòýí äàéí” òºãñãºë áîëñíîîñ õîéø, ýíý îéëãîëòîíä óëàìæëàëò áóñ áóþó ýäèéí çàñãèéí õàðüöàíãóé áèå äààñàí õºãæèë, ò¿¿õýí óëàìæëàë, ºâºðìºö ñî¸ë èðãýíøèëò àìüäðàë, õ¿í àìûíõàà ýð¿¿ë ìýíä, óäìûí ñàí, óãñàà

ãàðâàë, õ¿ðýýëýí áóé áàéãàëü îð÷íîî ãàäààä äîòîîäûí óëñ òºð, ýäèéí çàñàã, øàøíû ãýõ ìýò ýëäýâ íºëººëëººñ õàäãàëàí õàìãààëàõ ãýõ ìýò ºðãºí óòãûã õàìààðóóëàõ, ýäãýýðèéã òºðèéí áîäëîãûí ò¿âøèíä òàâèõ íü  íü ááãà áóþó ááãààâòàð îðíóóäàä íýëýýä ò¿ãýýìýë áîëæ áàéíà.

Ийм учраас ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë баримтлалыг хэрэгжүүлэх òºðèéí áîäëîãî íü íýã òàëààñ ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ òàëààð òºðººñ áàðèìòëàõ ¿çýë áîäîë, íºãºº òàëààñ ò¿¿íèéã õýðýãæ¿¿ëýõ ¿éë àæèëëàãààíû íýãäýë áàéõ ¸ñòîé юм. Èíãýõäýý ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ òºðèéí ¿çýë áàðèìòëàëûí òºâä õóâü õ¿í, íèéãýì, òºð ãóðàâ áàéõ íü ç¿éòýé болно.

¯¿íèé äîòðîîñ Ìîíãîë Óëñûí èðãýí, õóâü õ¿í ýëáýã õàíãàëóóí àìüäðàëòàé, ýð¿¿ë ñàðóóë áàéæ, àæèë õºäºëìºð ýðõëýõ, ñóðàëöàõ áîëîâñðîõ, õóóëèéí ºìíº àäèë òýãø áàéõ çýðýã îëîí ýðõýýð á¿ðýí õàíãàãäñàí, ýäãýýðèéí ¿ð ä¿íä Ýõ îðîíîî áàõàðõàõ ¿çëýýð òºãñ õ¿ì¿¿æñýí áàéõààñ ¿íäýñíèé àþóëã¿é áàéäàë èõýýõýí øàëòãààëàõ юм.

Ýíý íü îäîî ¿éë÷èëæ áóé ¯íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëä ò¿¿íèé ãîë àãóóëãûã Ìîíãîë Óëñûí îðøèí òîãòíîõ ãàäààä äîòîîä òààòàé íºõöëèéã õàíãàõ ãýñýí óòãààð òîäîðõîéëñîíîîñ àðàé ººð ñîíñîãäîæ áàéæ áîëîõ þì. Ãýõäýý ºíººãèéí íºõöºëä Ìîíãîë Óëñûí îðøèí òîãòíîõ ãàäààä äîòîîä òààòàé íºõöºë ¿íäñýíäýý õàíãàãäñàí ãýæ ¿çýæ áîëîõîîð áàéãàà ó÷èð ýíý ¿çýë áàðèìòëàëûí òºâä ìàíàé îðíû èðãýí, õóâü õ¿íèé àç æàðãàëòàé, ýíõ àìãàëàí àìüäðàõ íºõöëèéã á¿ðä¿¿ëýõ àñóóäëûã òàâèõ öàã áîëñîí õýìýýí áîäîæ áàéíà.

Èéì íºõöºëä Ìîíãîëûí íèéãýì íü òºð, óëñäàà ¿íýí÷ ìàíàé àðä èðãýäýýñ á¿ðäýæ, ¿íäýñíèé áàÿëàã, ¿íäýñíèé áàõàðõàëûã áèé áîëãîã÷, òýäãýýðèéã àãóóëàã÷, õàäãàëàã÷, õºãæ¿¿ëýã÷, óëàìæëóóëàã÷èéí ¿¿ðãèéã áèåë¿¿ëýí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ ¿íäñýí õ¿÷èí ç¿éë áàéõ áîëíî.

Òºðèéí òóõàéä áîë óäèðäàõ, õàìãààëàõ ººðèéí ¿¿ðãèéí õ¿ðýýíä ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ òîãòîëöîîã á¿ðä¿¿ëýí áàéãóóëæ, ò¿¿íä íºëººëºõ ãàäààä äîòîîäûí õ¿÷èí ç¿éë¿¿äèéã ¿íäýñíèé àþóëã¿é áàéäàëä çàíàëõèéëýõ àþóëûí õýìæýýíä õ¿ðãýõã¿éãýýð çîõèöóóëàõ ¿¿ðãèéã õ¿ëýýõ ¸ñòîé áîëîâ óó.

### 4.2.2. Гадаад бодлогын үзэл баримтлалд тодотгол хийх үндэслэл.

Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ áîäëîãî íü þóíû ºìíº ãàäààä äîòîîä áîäëîãûí õ¿ðýýíä õýðýãæèõ ó÷èðòàé áîëíî. ¯¿íèé äîòðîîñ ãàäààä áîäëîãûí õóâüä äèïëîìàò áîäëîãî, áàòëàí õàìãààëàõ ñàëáàð, õóóëü ñàõèóëàõ áàéãóóëëàãóóäûí áîëîí áàéãààëü îð÷èí, õ¿í àìûí ýð¿¿ë ìýíäèéã õàìãààëàõ ÷èãëýëèéí ãàäààä õàìòûí àæèëëàãààíû àñóóäëóóä өнөөгийн геополитикийн шинэ нөхцөл байдлын ¿åä èõýýõýí ãîëëîõ áàéð ñóóðü ýçëýõ áîëæ áàéíà.

<u>Äèïëîìàò áîäëîãî:</u> Îéðûí èðýýä¿éä Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõàä ìàíàé óëñààñ áóñàä îðíóóäòàé òîãòîîñîí õàðèëöààã õºãæ¿¿ëýõ ÿâääë îíöãîé ÷óõàë à÷ õîëáîãäîëòîé. ¯íäýñíèé àþóëã¿é áàéäëàà õàíãàõ çîðèëãî, çîðèëòóóä ãàäààä õàðèëöààãàà геополитикийн бий болсон шинэ нөхцөл байдалд нийцүүлэн ºðãºæ¿¿ëýí õºãæ¿¿ëýõ, îëîí óëñûí á¿õ òàëûí õàìòûí àæèëëàãààíä ìàíàé óëñûí îðîëöîîã èäýâõæ¿¿ëýõ çàìààð õàíãàãäàíà. ßëàíãóÿà õºðø ÎÕÓ, ÁÍÕÀÓ áîëîí äýëõèéí õ¿÷èðõýã ã¿ðýí ÀÍÓ-òàé íàéðñàã õàðèëöààã õºãæ¿¿ëýõ, ò¿¿í÷ëýí áóñàä óëñ îðíóóäòàé äèïëîìàò áîëîí ýäèéí çàñãèéí õàìòûí àæèëëàãààã ºðãºæ¿¿ëýõ íü èõýýõýí ÷óõàë áàéõ áîëíî.

Ýäãýýð çîðèëãî, çîðèëòóóäûã õýðýãæ¿¿ëýõýä ìàíàé óëñûí ãàäààä áîäëîãûã áîëîâñðóóëàõ, õýðýãæ¿¿ëýõ ¿¿ðýã á¿õèé, ò¿¿íèé äîòîð ýíý ÷èãëýëýýð ñóäàëãàà õèéäýã ýðäýì øèíæèëãýýíèé áàéãóóëëàãóóä, áóñàä óëñ îðîíòîé õàìòûí àæèëëàãààã õºãæ¿¿ëýõ ÷èãëýëýýð ¿éë àæèëëàãààãàà ÿâóóëäàã òºðèéí áóñ áàéãóóëëàãóóä, ò¿¿í÷ëýí ìàíàé óëñààñ ãàäààäàä ñóóãàà äèïëîìàò áàéãóóëëàãà, òºëººëºã÷èéí ãàçðóóäûí ¿¿ðýã àñàð èõ þì. Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àøèã ñîíèðõîëä ñºðãººð íºëººëæ áîëîõ, түүний дотор геополитикийн учир холбогдол талаас нь анхаарах ёстой àëèâàà øèíæ òýìäã¿¿äèéã óðüä÷èëàí èëð¿¿ëæ, òýäãýýðýýñ ñýðãýìæëýõ àðãà õýìæýýíèé ¿íäñèéã áîëîâñðóóëæ, öàã ¿åèéí ÷óõàë øèéäâýð¿¿äèéã ãàðãàí, ¿ð ä¿íòýé õýðýãæ¿¿ëýõ íü òýäíèé ¿éë àæèëëàãààíû ¿íäñýí çîðèëò ìºí. Ãàäààä õàðèëöàà õàðèóöñàí òºðèéí çàõèðãààíû òºâ áàéãóóëëàãà, Ýë÷èí ñàéäûí ÿàìä, êîíñóëûí ãàçàð, òºëººëºã÷äèéí газрууд болон àþóëã¿é áàéäàë, геополитик, îëîí óëñûí õàðèëöààíû àñóóäàë ñóäàëäàã ýðäýì øèíæèëãýýíèé байгууллагууд хоорондын àæèë ¿¿ðãèéí óÿëäààã õàíãàõ, ìýäýýëýë ñîëèëöîõ áîëîìæèéã íýìýãä¿¿ëýõ íü ìàíàé геополитикийн аюулгүй байдал, ¿íäýñíèé àøèã ñîíèðõëûã ãàäààäàä õàìãààëàõàä øèéäâýðëýâýë çîõèõ íýã ÷óõàë àñóóäàë áîëæ áàéíà.

Ìîíãîëûí òºðèéí áóñ áàéãóóëëàãà, õóâü õ¿ì¿¿ñèéí òîãòîîñîí ãàäààä õàðèëöàà õîëáîî, òýäãýýðèéí îëîí óëñàà õ¿ëýýí çºâøººðºãäñºí íýð õ¿íäèéã àøèãëàí Ìîíãîë Óëñûí

ãàäààä áàéð ñóóð, геополитикийн нэр хүндийг ºðãºõ ÿâääë ìàíàé ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã áýõæ¿¿ëýõòýé õîëáîîòîé àñóóäàë áîëæ áàéíà. ßëàíãóÿà äýëõèé íèéòýä Ìîíãîëûí òóõàé ç°â ìýäýýëýë õ¿ðãýõ, ìàíàé óëñàä áîëæ áóé ¿éë ÿâäëûã áîäèòîé ñóðòàë÷ëàõ ÿâääë ìàíàé улсыг геополитикийн болон үндэсний àøèã ñîíèðõëûã ãàäààääàä õàíãàõàä ÷óõàë õýðýãñýë áîëîõ ¸ñòîé þì.

<u>Батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагаа</u>**.** Ìîíãîë Óëñûí àþóëã¿é áàéäëûí ãàäààä îð÷íûã áîäèòîé ¿íýëýõ ¿¿äíýýñ îéðûí áîëîí äóíä õóãàöààíû èðýýä¿éä Ìîíãîë Óëñàä çàíàëõèéëæ áîëçîøã¿é öýðãèéí àþóë õºðø áîëîí îéð çýðãýëäýý îðíóóäûí ç¿ãýýñ ¿íäñýíäýý áàéõã¿é ãýæ ä¿ãíýæ áîëîõ þì. ¯¿íýýñ ¿¿äýí òºðèéí áàòëàí õàìãààëàõ áîäëîãî, ò¿¿íèé äîòîð òºðèéí öýðãèéí өнөөгийн бодлогын улс төр, дипломатын аргыг тогтвортой үргэлжлүүлэх нь зөв юм. Ãýõäýý ýíý íü Çýâñýãò õ¿÷íèé òºð íèéãìèéí áàéãóóëëàãàíä ã¿éöýòãýõ цэргийн ¿¿ðãèéã ¿ã¿éñãýñýí õýðýã áèø áºã°°ä õàðèí ч ò¿¿íèé çîðèóëàëò, á¿òýö, çîõèîí áàéãóóëàëò, ñóðãàëò áýëòãýë, àð òàë, òåõíèêèéí õàíãàëòûí òîãòîëöîîã áàòëàí õàìààëàõ áîëîí çýâñýãò õ¿÷íèé òóõàé äýëõèé íèéòýýð °°ð÷ëºãäºæ áóé îéëãîëò, ºí°°ãèéí øèíý øààðäëàãààä íèéö¿¿ëýí äîðâèòîé °°ð÷ëºõ öàã áîëæýý ãýæ íýëýýä ñóäëàà÷èä ¿çýæ áàéíà.

ªí°°ãèéí áèé áîëîîä áàéãàà íèéòèéã õàìàðñàí геополитикийн үүдэл сэдэл бүхий óëàìæëàëò áóñ àþóë çàíàëûí íºõöºëä òýäãýýðýýñ õàìãààëàõ àñóóäàë íü óëñ ã¿ðí¿¿äèéí õèë õÿçãààðààð çààãëàãäààõã¿éãýýð õóâü õ¿ì¿¿ñèéí àþóëã¿é áàéäàëä øóóä íºë°°ëºõ áîëæ áàéãààòàé õîëáîãäîí õ¿íèé àþóëã¿é áàéäëûã óëñ îðîí á¿ðèéí èäýâõòýé îðîëöîîòîéãîîð, òýð äîòîð çýâñýãò õ¿÷í¿¿äèéíõýý íýãäñýí ÷àðìàéëòààð õàíãàõ ÿâääë îëîí óëñûí õàðèëöààíû íýã øèíý õýëáýð áîëîí õºãæèæ ¿¿íä Ìîíãîë Óëñûí Çýâñýãò õ¿÷èí èäýâõòýé îðîëöîæ ýõýëëýý.

¯¿íýýñ ¿¿äýí Ìîíãîë Óëñûí áàòëàí õàìãààëàõ áîäëîãî, ¿éë àæèëëàãààíû àãóóëãà, ò¿¿íèé äîòîð Çýâñýãò õ¿÷íèé ¿¿ðýã, çîðèóëàëò ÷ îãò °°ð°°ð òºñ°°ëºãäºõ áîëæ áàéíà.

Ýõñèéí ä¿íäýý төрийн áàòëàí õàìãààëàõ бодлогод Зэвсэгт хүчнийг ¿íäñýí ÷èã ¿¿ðãèéíõýý çýðýãöýý ýíõèéã ñàõèóëàõ, òåððîðèçìòàé òýìöýõ áîëîí îëîí óëñûí áóñàä ¿éë àæèëëàãààíä îðîëöîõ, íèéòèéã õàìàðñàí áàéãàëèéí ãàìøèã, òåõíîëîãèéí îñîë, õ¿ì¿¿íëýãèéí ñ¿éðýë çýðýã õÿìðàëò áàéäëûí ¿åä îëîí òàëò ¿¿ðýã ã¿éöýòãýõ ÷àäàâõè á¿õèé, ºíäºð ìýðãýøñýí áîëãîí °°ð÷ëºí çîõèîí áàéãóóëàõ áîëîí îðîí íóòãèéí õàìãààëàëòûã æèíõýíý ¸ñîîð íü á¿ðä¿¿ëýí áèé áîëãîõ асуудлыг øèéäâýðëýõ àðãà çàìûã øèíæëýõ

óõààíû ¿íäýñëýëòýé òîäîðõîéëîõ, ¿¿íòýé óÿëäóóëàí Çýâñýãò õ¿÷íèéõýý ¿¿ðýã, çîðèóëàëò, á¿òýö, çîõèîí áàéãóóëàëò, çýâñýãëýë, òåõíèê, ¿éë àæèëëàãààíû ñòðàòåãè, òàêòèêèéã ººð÷ëºõ øààðäëàãûã áèé áîëãîæ áàéíà.

Ýíý á¿õýí íü Ìîíãîë Óëñ Çýâñýãò õ¿÷íèéã óëñ õîîðîíäûí ìàðãààíòàé àñóóäëûã øèéäâýðëýõ õýðýãñýë ãýæ ¿çýõã¿é áàéõ, ìàíàé Çýâñýãò õ¿÷íèéã õºðø áîëîí áóñàä îðíû çýâñýãò õ¿÷èíòýé õàìòðàí îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ, òåððîðèçìòàé òýìöýõ, óëñ õîîðîíäûí õèëèéí äýãëýìèéã ñàõèóëàõ, á¿ñ íóòãèéí ýíõ àìãàëàíã õàìãààëàõ, áàéãàëèéí ãàìøèãòàé òýìöýõ çîðèóëàëòòàé áîëãîõ àñóóäàë òºðèéí áàòëàí õàìãààëàõ áîäëîãûí үндсэн чиглэл ¸ñòîéã õàðóóëæ áàéíà.

<u>Õóóëü ñàõèóëàõ áàéãóóëëàãûí ãàäààä õàìòûí àæèëëàãàà</u>**.** Îëîí óëñûí òåððîðèçì, ñàëàí òóñãààðëàõ ¿éë àæèëëàãàà, øàøíû õàðãèñ óðñãàëóóäûí íºëºº íýâòðýõ, õàð òàìõè òàðààõ, äàìæóóëàí ºíãºð¿¿ëýõ, õóóëü áóñààð çýâñýã, õ¿í õóäàëäààëàõ çýðýã геополитикийн үүдэл сэдэл бүхий îëîí óëñûí ÷àíàðòàé ãýìò õýðýãòýé òýìöýõ ÿëàíãóÿà  çîõèîí áàéãóóëàëòòàé ãýìò õýðãèéí á¿ëýãëýëýýñ ººðñäèéãºº õàìãààëàõàä Ìîíãîë Óëñûí õóóëü ñàõèóëàõ áàéãóóëëàãóóäûí ãàäààä îðíóóäûí èæèë ò¿ðëèéí áàéãóóëëàãàòàé òîãòîîñîí õàðèëöààã õºãæ¿¿ëýõ ÿâäàë ìàíàé геополитикийн болон ¿íäýñíèé àþèã ñîíèðõëûã õàìãààëàõ ÷óõàë õýðýãñýë áàéõ þì. ßëàíãóÿà ãýìò õýðýãòí¿¿äèéã óëñ îðíû õèë õÿçãààðûã ¿ë òîîöîí ìºðäºí ìºøãèæ, èëð¿¿ëäýã, òýäýíä øèéòãýë îíîãäóóëàõ áàéõ òàëààð õºðø áîëîí áóñàä óëñ îðíóóäòàé ýðõ ç¿éí òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ ãýðýý õýëýëöýýðèéã ìàíàé òàëààñ áàéãóóëàõ ÿâäàë ÷óõàë áàéõ áîëíî.

Õóóëü ñàõèóëàõ áàéãóóëëàãûí ãàäààä õàìòûí àæèëëàãàà õàðèóöñàí áîëîâñîí õ¿÷èí áýëòãýõ, äàâòàí áýëòãýõýä мөн àíõààðàõ õýðýãòýé áàéíà.

Ìàíàé çàëóó ¿åèéã ìàíñóóðóóëàõ áîäèñ, õàð òàìõè, ÄÎÕ-ûí àþóëààñ ñýðýìæë¿¿ëýõ òàëààð ãàäààäûí áàéãóóëëàãàòàé õ¿÷ õàìòðàí àæèëëàõ, äîòîîäîî àâëèãàëûí ýñðýã òýìöýõ ¿ð ä¿íòýé òîãòîëöîî á¿ðä¿¿ëýõ øààðäëàãà òàâèãäàæ áàéíà.

<u>Байгаль îð÷èí, õ¿í àìûí ýð¿¿ë ìýíäèéã õàìãààëàõ îëîí óëñûí õàìòûí àæèëëàãàà.</u> Áàéãàëü îð÷íûã áîëîí õ¿í àìûí ýð¿¿ë ìýíäèéã õàìãààëàõ, òýäãýýðèéã ýëäýâ õàëäâàðò ºâ÷èí òàðõàõ àþóëààñ ñýðýìæëýõ àñóóäàë ºíºº ¿åä ÷óõàë áàéãàà áºãººä ýíý òàëààð ãàäààä õàìòûí àæèëëàãààã ºðãºæ¿¿ëýõ íü ìàíàé геополитикийн болон  ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ýðõ àøèãò íèéöýõ áîëíî.

ßëàíãóÿà çàõ çýýëä íèéë¿¿ëæ áàéãàà ãàäààäûí áàðàà, õ¿íñíèé áîëîí ýìèéí á¿òýýãäõ¿¿íèé íýð òºðºë, òîî õýìæýý íýìýãäýæ áàéãààòàé õîëáîãäóóëàí áàðààíû ÷àíàð, õ¿íñíèé áàðàà, ýìèéí á¿òýýãäõ¿¿íèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ òàëààð õîëáîãäîõ áàéãóóëëàãóóä ãàäààä õàðèëöààãàà èäýâõæ¿¿ëæ, õºðø îðíóóäòàé õàìòðàí àæèëëàõ øààðäëàãà òàâèãäààæ áàéíà.

Äîòîîä õ¿÷èí ç¿éëèéí õóâüä бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдалд ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõ áîäëîãî, ¿éë àæèëëàãààã íü óðüäûí àäèë ýäèéí çàñàã, óëñ òºð, íèéãìèéí òîãòâîðòîé áàéäàë, áàéãàëü îð÷íûã õàäãàëàí õàìãààëàõ õ¿ðýýíä ãîëëîí õýðýãæèõ ёстой юм.

### 4.2.3. Батлан хамгаалах бодлогын үндэст тодотгол хийх үндэслэл.

Àëèâàà óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëûí öýðýã-ñòðàòåãèéí àãóóëãà íü òºðèéí ãàäààä äîòîîä áîäëîãî, ò¿¿íèé íèéãýì, óëñ òºð, ýäèéí çàñàã, ãàçàð ç¿éí áàéðëàë áîëîí ò¿¿íä çàíàëõèéëæ áîëçîøã¿é öýðãèéí àþóëûí îíöëîã øèíæ, áàòëàí õàìãààëàõ ÷àäàâõè, øèíæëýõ óõààí, ¿éëäâýðëýëèéí õºãæëèéí ò¿âøèí áîëîí áóñàä õ¿÷èí ç¿éë¿¿äýýð òîäîðõîéëîãääîã áîëíî.

Åðºíõèéäºº, ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëûí öýðýã-ñòðàòåãèéí àãóóëãà ãýäãèéã òóõàéí óëñûí àëèâàà äàéí, çýâñýãò ìºðãºëäººíä õàíäàõ õàíäëàãà, òºðººñ ÿâóóëàõ áàòëàí õàìãààëàõ áîëîí öýðãèéí áîäëîãûí øèíæ òºëºâ, ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõàä óëñûí áàòëàí õàìãààëàõ ÷àäàâõè, öýðãèéí õýðýãñëèéã àøèãëàõ ãîë ÷èãëýë¿¿äèéã òîäîðõîéëîõ àëáàí ¸ñîîð çºâøººðºãäñºí ¿çýë áîäëûí èëýðõèéëýë ãýæ îéëãîæ áîëîõ òàëòàé þì.

¯íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëûí öýðýã-ñòðàòåãèéí àãóóëãûã óëñ òºðèéí áîëîí öýðãèéí äýýä óäèðäëàãà òîäîðõîéëäîã áºãººä äàðààõ àñóóäëóóäàä õàðèó ºãºõ çîðèëãîòîé áàéäàã áàéíà. ¯¿íä:

- Òóõàéí óëñ îðîí äàéí, çýâñýãò ìºðãºëäººíä õýðõýí õàíäàõ, òýäãýýðèéã ººðèéíõºº óëñ òºðèéí áîëîãûã õýðýãæ¿¿ëýõ õýðýãñýë ãýæ ¿çäýã ¿¿, ýñâýë ¿ã¿é ãýæ òîîöäîã óó.

- Òóõàéí óëñàä çàíàëõèéëæ áîëçîøã¿é öýðãèéí àþóëûí øèíæ òºëºâ, öàð õýìæýý, óëñ îðíû çýâñýãò õ¿÷èí äàéí, çýâñýãò ìºðãºëäººíä îðîëöîõ áîëçîøã¿é íºõöºë áàéäàë, òýäãýýðèéí çîðèëãî, øèíæ òºðõ.

- Ýõ îðíîî õàìãààëàõ äàéí, çýâñýãò ìºðãºëäººíèéã àìæèëòòàé ÿâóóëàõàä ÷óõàìõ¿¿ ÿìàð çýâñýãò õ¿÷èí õýðýãòýé, ÿìàð ÷èãëýëýýð òýäãýýðèéã á¿ðä¿¿ëýõ, õýíòýé õîëáîîòîí áàéæ áîëîõ.

- Óëñ îðîíû áîëîí çýâñýãò õ¿÷íèéã áîëçîøã¿é äàéí, çýâñýãò ìºðãºëäººíä áýëòãýõ æóðàì áîëîí òýäãýýðèéã ÿâóóëàõ öýðãèéí ñòðàòåãèéí àðãóóä ÿìàð áàéõ, çýðýã áîëíî.

¯¿íèé çýðýãöýý ñ¿¿ëèéí æèë¿¿äýä, çýâñýãò õ¿÷íèéã äàéí, çýâñýãò ìºðãºëäººíèéã ñýðýìæëýí çàéëóóëàõ, îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ áîëîí áóñàä ¿éë àæèëëàãààíä àøèãëàõ, îëîí óëñûí òåððîðèçìòîé òýìöýõ, áàéãàëûí ãàìøèã áîëîí áóñàä îíöãîé íºõöºë àðä èðãýäèéí àìü íàñ, íèéãìèéí õºðºíãèéã õàìãààëàõ, õîð õîõèðîëûã àðèëãàõ, ñýðãýýí áîñãîõ, çàëóó ¿åèéã çîðèã òýñâýð, ýõ îðîí÷ ¿çýëä ñóðãàõ çýðýãò òýðýãëýõ àñóóäëóóä ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí öýðãèéí-ñòðàòåãèéí àãóóëãàä òîäîðõîé áàéð ýçëýõ áîëñîîð áàéíà.

¯íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëûí öýðãèéí-ñòðàòåãèéí àãóóëãà íü òîäîðõîé, äýëãýðýíã¿é õýëáýðýýðýý öýðãèéí íîìëîë áóþó öýðãèéí ñòðàòåãè íýðòýéãýýð òóñãàéëàí áîëîâñðóóëàãäàõ íü íýëýýä ò¿ãýýìýë áàéäàã áîëíî. Ìîíãîë Óëñûí õóâüä ýíý íü ”Монгол Улсын батлан хамгаалах áîäëîãûí ¿íäýñ” íýðòýéãýýð ÓÈÕ-ààð 1915 îíä шинэчлэгдэн áàòëàãäñàí òóë энэ баримт бичигт çºâõºí геополитикийн аюулгүй байдлыг хангахад Зэвсэгт хүчнийг ашиглах агуулга бүхий öººí хэдэн àñóóäëûã нэмж òóñãàõ íü ç¿éòýé юм.

Ýíý íü:

”Ìîíãîë Óëñ àëèâàà äàéí, çýâñýãò ìºðãºëäººíèéã óëñ õîîðîíäûí áîëîí äîòîîäûí ìàðãààíò àñóóäëûã øèéäâýðëýõ õýðýãñýë ãýæ ¿çýõã¿é. Äýëõèé äàõèíä áîëîí á¿ñ íóòàãò äàéí, çýâñýãò ìºðãºëäººí ãàðãóóëàõã¿éí òºëºº òýìöýë, çýâñýã õóðààõ, ÿëàíãóÿà öºìèéí áîëîí áóñàä ¿é îëîíîð õºíººõ çýâñãèéí á¿ðìºñºí õîðèãëîõ, îëîí óëñûí òåððîðèçìòàé òýìöýõýä ÷èãëýñýí îëîí óëñûí á¿õ ¿éë àæèëëàãààíä èäýâõòýé îðîëöîíî.

¯¿íèé çýðýãöýý óëñ îðíóóäûí îëîí ÿíçûí ýðõ àøãûí çºð÷èë, геополитикийн өрсөлдөөн ¿å ¿å õóðöäàæ, çàðèìäàà çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýí, çýâñýãò õ¿÷íèéã óëñ òºðèéí áîëîí ìàðãààíòàé áóñàä àñóóäëûã øèéäâýðëýõ çîðèëãîîð õýðýãëýõ ñýòãýëãýý õýâýýð õàäãàëàãäñààð áàéãààãèéí ãààíà á¿ñ íóòãèéí èõ ã¿ðí¿¿äýä òºðºë á¿ðèéí çýð çýâñãèéí àñàð èõ íººö á¿õèé öýðãèéí õ¿÷èðõýã á¿ëýãëýë¿¿ä îðøèíîð, ò¿¿í÷ëýí Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò àþóëã¿é áàéäëûí õàìòûí òîãòîëöîî á¿ðäýõ

ýõëýë òàâèãààãàã¿é çýðãýýñ ¿¿äýí àëèâàà ääéí, ò¿ðýìãèéëýëèéí áîäèò àþóë á¿ðìºñºí àðèëààã¿é áàéíà ãýæ ¿çíý.

Èéìä Ìîíãîë Óëñûí òºð, çàñãààñ Ýõ îðíûõîî öýðãèéí àþóëã¿é áàéäëûã ÷óõàë÷ëàí ¿çýæ, ¿íäýñíèé болон өөрийн геополитикийн ýðõ àøãàà õàìãààëàõûí òóëä òºðèéí áàòëàí õàìãààëàõ áîäëîãîî îíîâ÷òîé áîëãîí áýõæ¿¿ëýõ àñóóäëûã àíõààðëûí òºâä áàéëãàíà.

Ìîíãîë Óëñ Í¯Á-ûí ä¿ðìèéí äàãóó ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëàà äàíãààðàà áóþó õàìòûí õ¿÷ýýð áàòëàí õàìãààëàõ ýðõýý ýäýëíý. Óëñ îðíû òóñãààð òîãòíîë, íóòàã äýâñãýðèéí á¿ðýí á¿òýí áàéäëûã áàòëàí õàìãààëàõ, îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ áîëîí áóñàä ¿éë àæèëëàãààíä îðîëöîõ ¿¿ðýã á¿õèé ººðèéã ººõàìãààëàõ ¿íäýñíèé Çýâñýãò õ¿÷èíòýé áàéíà" ãýñýí àãóóëãûí õ¿ðýýíä òîãòîõîéëîãîõ áîëîâ óó ãýæ áîäîæ áàéíà.

ªíººãèéí áèé áîëîîä áàéãàà геополитикийн үүдэл сэдэл бүхий íèéòèéã õàìàðñàí óëàìæëàëò áóñ àþóë çàíàëûí íºõöºëä òýäãýýðýýñ õàìãààëàõ àñóóäàë íü óëñ ã¿ðí¿¿äèéí õèë õÿçãààðààð çààãëàãäààõã¿éãýýð õóâü õ¿ì¿¿ñèéí àþóëã¿é áàéäààë øóóä íºëººëõ áîëæ áàéãààòàé õîëáîãäîí õ¿íèé àþóëã¿é áàéäëûã óëñ îðîí á¿ðèéí èäýâõòýé îðîëöîîòîéãîîð, òýð äîòîð çýâñýãò õ¿÷í¿¿äèéíõýý íýãäñýí ÷àðìàéëòààð õàíãàõ ÿâäàë îëîí óëñûí õàðèëöààíû íýã øèíý õýëáýð áîëîí õºãæèæ ¿¿íä Ìîíãîë Óëñûí Çýâñýãò õ¿÷èí èäýâõòýé îðîëöîæ ýõýëëýý.

¯¿íýýñ ¿¿äýí Зэвсэгт хүчнийг ¿íäñýí ÷èã ¿¿ðãèéíõýý çýðýãöýý ýíõèéã ñàõèóëàõ, òåððîðèçìòàé òýìöýõ áîëîí îëîí óëñûí áóñàä ¿éë àæèëëàãààíä îðîëöîõ, íèéòèéã õàìàðñàí áàéãàëèéí ãàìøèã, òåõíîëîãèéí îñîë, õ¿ì¿¿íëýãèéí ñ¿éðýë çýðýã õýìðàëò áàéäëûí ¿åä îëîí òàëò ¿¿ðýã ã¿éöýòãýõ ÷àäâàðõè á¿õèé, ºíäºð ìýðãýøñýí áîëãîîí ººð÷ëºí çîõèîí áàéãóóëàõ áîëîí îðîí íóòãèéí õàìãààëàëòûã æèíõýíý ¸ñîîð íü á¿ðä¿¿ëýí áèé áîëãîõ асуудëûã øèéäâýðëýõ àðãà çàìûã øèíæëýõ óõààíû ¿íäýñëýëòýé òîãòîõîéëîõ, ¿¿íòýé óÿëäóóëàí Çýâñýãò õ¿÷íèéõýý ¿¿ðýã, çîðèóëàëò, á¿òýö, çîõèîí áàéãóóëàëò, çýâñýãëýë, òåõíèê, ¿éë àæèëëàãààíû ñòðàòåãè, òàêòèêèéã ººð÷ëºõ øààðäëàãûã áèé áîëãîæ áàéíà.

Монгол Улс төрийн батлан хамгаалах бодлогын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэн Зэвсэгт хүчнийхээ шилжилтийн нэг үеийг амжилттай давн туулсан. Одоо манай Зэвсэгт хүчний өмнө бий болсон олон улсын геополитикийн шинэ нөхцөлд нийцүүлэн Хуурай замын болон бусад төрөл, тусгай мэргэжлийн цэргээ жигд хөгжүүлэх, бэхжүүлэх замаар Зэвсэгт хүчнийхээ тайван цагт үндсэн үүргээ

биелүүлэх бэлтгэлийг жинхэнэ ёсоор нь хангах буюу цэргийн шинэчлэлийн дараагийн шатны зорилго, зорилтуудыг ухаан зарж, зөвөөр хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна. Ингэснээр мэргэжлийн бүрэлдэхүүнд суурилсан Зэвсэг хүчин жинхэнэ утгаараа байгуулагдах болно.

## ДҮГНЭЛТ

### I. ОЛОН УЛСЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ.

**Нэг**. Өнөө үед их гүрнүүдийн өөр хоорондын харилцаанд тодорхойгүй байдал хэвийн зүйл болох төлөвтэй байна. Хурдацтай өөрчлөгдөх, тааварлахын аргагүй нөхцөл байдалд төр улсууд дасан зохицох ёстой болж, үүний улмаас ямар ч гэнэтийн явдал, дайсагнагч хүчний халдлагад хариу барихад бэлэн гэдгээ харуулахын тулд эдгээр гүрэн ойлгоход бэрх олон янзын, түүний дотор илэрхий түрэмгийлэх үйлдэл ч гаргах боллоо. Энэхүү яаруу, эмх замбараагүй байдал дунд “олон туйлт ертөнцөд шилжих” гэж нэрлэгдэж буй бүх нийтийг хамарсан шинэ төлөв байдал үүсээд байна. Өөрөөр хэлбэл, Орос болон Азийн орнууд, тэр дундаа Энэтхэг, Хятад өсөн дэвжиж , бэхжиж байхад хүйтэн дайны дараа хэлбэржсэн Өрнөдийн улс хоорондын тогтолцоо эмх замбараагаа алдан, АНУ-ын давамгайлал төгсгөл болох тал руугаа явж, Европын холбоо задрах эхлэл тавигдан, улмаар улс орнуудын харьцангүй бие даасан байдалд тулгуурласан улс хоорондын харилцааны шинэ нөхцөл байдал бий болох төлөвтэй байна.

**Хоёр.** Урт хугацаанд үргэлжилж буй улс төр, эдийн засгийн хямралын хэд хэдэн чиг хандлагаас үүдэн улс хоорондын аюулгүй байдлын хамтын ажиллагааны эдүгээгийн тогтолцоо улам бүр суларч, ээдрээтэй болж байна. Эдгээр чиг хандлага нь улс орон, хүн бүхэнд нөлөөлж буй технологийн эрчимтэй дэвшил, уур

амьсгалын өөрчлөлттэй хавсран явагдаж байна. Асар олон төрлийн нэн чухал, харилцан нэгнээ өдөөгч энэ бүх чиг хандлагаас үүдэн өнөөгийн эрин үеийг өмнөхийн адилаар “Хүйтэн дайн”, “Намжмал байдал” гэх мэтийн нэг үгээр тодорхойлох боломжгүй болоод байна. Улс хоорондын харилцаанд өөрийн нөлөөгөө өргөтгөх гэсэн их гүрнүүдийн ширүүн өрсөлдөөн, үүний хариуд явагдаж буй энэ эмх замбараагүй нөхцөл байдлын дунд өөрийн байр сууриа олох гэсэн бусад улсын алдаж оносон тогтворгүй, тэмтэчсэн гэж хэлж болох тэмцэл” давамгайлах боллоо. Эдгээр өрсөлдөөн, тэмцлийн цаад зорилго янз бүр байна Цөөхөн жишээ хэлэхэд, АНУ Венесуэл, Украины хямралыг дэвэргэж, Афганистан, Иракт цэргийн ажиллагаа явуулж байхад, Оросууд Украйны салан тусгаарлахыг хүсэгчдийг нь илэрхий дэмжсэн бодлого явуулж, Сирид цэрэг, зэвсгийн тусламж үзүүлэн, Венесуэлийг хамгаалж байгаа юм. Үүний зэрэгцээ энэ бүх зөрчил сөргөлдөөн, тэмцэл нь том гүрнүүд хоорондын стратегийн тэнцвэрийг өөрчилж төдийлөн чадахгүй байгаа бөгөөд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр эсрэг талаа муухай харагдуулах, өөрийгөө магтах замаар дэлхийн олон нийтэд  нөлөөлөхийг оролдохоос бас төдийлөн хэтэрч чадахгүй байна.

**Гурав.** “Оросын аюул” гэдэг зүйлийг Өрнөдийн орнууд идэвхтэй ашиглах эрмэлзэлтэй байна. Жишээлбэл, АНУ-д энэ нь бусад улс оронтой харилцахдаа баримтлах улс төрийн гол арга хэрэгсэл болж байгаа юм. Энэ оронд бүхий л хэрэг явдалд Оросыг буруутгах оролдлого Трампын гэнэтийн ялалтаас үүдэн улам даамжирсан билээ. Өөрөөр хэлбэл “хэн Оростой сайн байна тэр манай дайсан” гэсэн хандлага давамгайлсаар байна. Наад зах нь АНУ-ын ерөнхийлөгчийн дараагийн сонгууль хүртэл энэ сэдэв тус улсын эрх баригчдын хувьд толгой өвтгөсөн асуудал хэвээр үлдэх нь дамжиггүй тул ийм нөхцөлд Оросууд өөрийгөө хэчнээн ч хамгаалсан төдийлөн үр дүнд хүрэхгүй болоод байгаа юм. Гэтэл энэ нь харин ч эсрэг үр дүн авчирч  Орос улс улам бүр Өрнөдийн орнууд дахь ялзарч буй дэглэмийг өөрчлөх зорилго бүхий, бүрэн чадварлаг, боловсронгуй, түрэмгий тоглогчийн дүр төрхтэйгөөр дүрслэгдэх боллоо. Үүний зэрэгцээ, Орос улс АНУ-ын түрэмгий, бодлогогүй, лалын терроризмыг дэмжсэн маягийн тогтворгүй байр суурь буюу нэг төрлийн  “Америкийн аюул”-аар дэлхийг сүрдүүлэх аргаар Ойрх Дорнод, Зүүн Европ, Төв Евразид өөрийн нөлөөг  бэхжүүлэх, түүнчлэн Хятадтай бүх салбарт, түүний дотор цэрэг-стратегийн чиглэлд ойртон нягтрах эрмэлзэл бүхий чармайлтдаа багагүй амжилт олоод байгаа юм.

**Дөрөв.** Өрнөдийн тогтолцоо зохион байгуулалтаа алдаж байгаагаас үүдэн Европ тив төдийгүй АНУ-ын улс төрийн тавцанд энэ нь “Орос, Хятадын хамтын аюул занал”-аас болж байна гэсэн тайлбар урт хугацаагаар яригдах төлөвтэй байна. Олон улсын өнөөгийн нөхцөл байдалд улс орнуудыг “танай”, “манай” “сайн”, “муу” хэмээн хуваах өнгөц үзэл том гүрнүүдийн хувьд хэвээр үлдэх төлөвтэй байна. Гэтэл олон улсын аюулгүй байдлын нөхцөл байдлын өөрчлөлтийг тайлбарлах энэ хялбаршуулсан хандлага нь улс орнуудын өөрсдийнх нь дотоод улс төрийн нөхцөл байдлыг таамаглахын аргагүй өөр болгож, тэр ч байтугай үүний улмаас тайлбарлахын аргагүй сонгуулийн үр дүн гарах болсны цаад учрыг Өрнөдийн удирдагчид төдийлөн ойлгож өгөхгүй байна.

**Тав.** Манай улсын хувьд энэ ширүүн өрсөлдөөнөөс үүдсэн шинэ сорилт, ашигтай боломжийн аль алинтай нь учраад байна. Азид оршиж буй хүчний туйлуудын өөр хоорондын сөргөлдөөний явц Москвагийн сонирхолд гол төлөв нийцэж байгаа юм. Орос Хятадтай болон Монголтой өргөн газар нутгаар хил залгадаг төдийгүй Солонгос, Японтой ч ойрхон байрлалтай. Иймээс тус бүс нутагт дэлхийн эдийн засгийн төв шилжсэнээр Орос энэ үйл явцад идэвхтэй үүрэг гүйцэтгэж болох юм. Дэлхийн хүчний туйл Ази руу шилжих явцад олон улс дахь хэд хэдэн төрлийн хагарал гүнзгийрэх нь дамжиггүй боловч энэ нь Орост хамаарахаас илүүтэй Европ тивийн аюулгүй байдлын асуудлуудтай холбогдоно. Энэ тохиолдолд Орос сөргөлдөгч талуудын дунд тэнцвэржүүлэх үүрэг гүйцэтгэж, эсвэл зуучлагч болох боломжтой бөгөөд үүнийгээ ч сайн ухаарч харьцангуй үр дүнтэйгээр ашиглах боллоо.

**Зургаа**. Их гүрнүүдийн шинэ өрсөлдөөн олон улсын харилцаанд бараг хэвийн зүйл болж байгаа тул энэ нь тодорхой хэмжээгээр хүчний тэнцвэрийг бий болгож томоохон дайн гарах магадлалыг багасгаж байна. Учир нь дайн, дажин нь дайсагналыг улам даамжруулна уу гэхээс шийдвэрлэхгүй гэдгийг улс орнууд улам бүр ойлгох болж байна. Өнөөгийн орчинд аливаа дайн асар их хор хохирол дагуулах нь тодорхой бөгөөд улс төрийн зорилгоо биелүүлэх ямар ч найдварыг бөхөөнө гэдэг нь хэн бүхэнд ойлгогдох болоод байгаа юм. Ийм ч учраас улс хоорондын өрсөлдөөнийг аль нэг улсын дотоод нөхцөл байдалд хүчтэй нөлөөлөх олон төрлийн өдөөн хатгалга хэлбэрээр явуулбал дэлхий нийтийн тухайд илүү аюул багатай байж магадгүй гэсэн нийтлэг ойлголт газар авч байна. Түүнчлэн өнөөгийн нөхцөл байдлыг “Хүйтэн дайн”-ы үетэй адилтгах нь мөн үндэслэл муутай болоод байна. Энэ нь дэлхий дахинд өрнөж буй бүхнийг урьдын адил АНУ-Оросын

сөргөлдөөнөөр тайлбарлах боломжгүй болсонтой холбоотой байна. Энэ хоёр орны уламжлалт сөргөлдөөний зэрэгцээ АНУ-ын зүгээс Хятад, Герман, Турк зэрэг улстай, мөн Энэтхэг нь Пакистан, Хятадтай, Иран Саудын Арабтай гэх зэргээр хүчний олон туйл доторх өөр хоорондын өрсөлдөөн хүчтэй өрнөж байна.

**Долоо**. ОХУ-АНУ хоёр орны харилцааны тухайд бол тууштай бус байдал зонхилсоор байх төлөвтэй байна. АНУ-ын элитүүдийн нэг хэсэг нь өөрсдийнх нь дотоодын асуудалд “хөндлөнгөөс оролцсоных” нь төлөө Оросын эсрэг үл итгэлцэл өвөрлөн, Москваг ийм төрлийн хөндлөнгийн оролцоо дахин хийхээс сэргийлэхийн тулд илүү хатуу хориг арга хэмжээ авахыг уриалсаар байна. Харин Оросыг АНУ-тай сөргөлдөгчдийн эгнээнд нэгдээсэй гэж хүсэхгүй байгаа Вашингтон дахь зарим улс төрч Оросын эсрэг үзэлтнүүдийн түрэмгий зорилгыг тогтоон барихыг чадах чинээгээрээ чармайсаар байна. Эдгээрийн зэрэгцээ, улам бүр олон улс орон өөр өөрийнхөө хэмжээнд бие даасан байдлаа нэмэгдүүлж байгаагаас улбаалан тэдгээрийн дипломат ажиллагаанд нарийн, няхуур бодож төлөвлөсөн арга, алхмууд улам бүр хэрэгцээтэй болж байна. Хамгийн сүүлийн жишээ гэхэд Орос-Туркийн хооронд болж буй үйл явдлуудыг хэлж болох юм. Оросын зүгээс Туркийг өөртэйгөө найрамдалт харилцаатай боловч НАТО-гийн идэвхтэй, дуулгавартай гишүүн орон хэмээн үздэг байсан нь эцэс болох төлөвтэй байна. Анкара бүс нутагт томоохон дайн үүсгэх аюулт үйлдэл хийх чадавхтай, геостратегийн бодлогын хувьд бие даасан, тусгаар хүчний төв гэдгээ хэний ч өмнө нь таамаглаагүй байдлаар харуулсаар байна.

**Найм.** Хэдийгээр том гүрнүүдийн өрсөлдөөн ширүүссээр байгаа боловч олон улс дахь өнөөгийн нөхцөл байдал харьцангуй тогтвортой хэвээр үргэлжлэх бөгөөд дэлхий дахиныг бүхэлд нь хамарсан хагарал гарах шалтаг, шалтгаан хомс байна. Бид бүгд харилцан холбоотой дэлхийд аж төрж, даяаршлын үр шимийг хүртэж, дэлхий ертөнц жил ирэх тусам улам бүр аюулгүй, тогтвортой болсоор байна. Гэвч энэ нь улс орнууд цэрэг, армиа болзошгүй дайнд бэлтгэхгүй байгаа гэсэн үг бас биш юм. Харин ч тусгаар тогтнолыг хамгаалахад цэргийн хүч нэн чухал хэвээр байгаа энэ нөхцөлд тэдний хэн нь ч энэ шалтгаанаар өөрийгөө хамгаалах дайнд бэлтгэсээр байх нь дамжиггүй юм. Гэхдээ дээр өгүүлсэн олон улсын харилцаанд улс төрийн өдөөн хатгалга давамгайлах болсонтой уялдаатайгаар улс орнууд бие биеийн эсрэг зэвсэгт том түрэмгийлэл буюу байлдааны ажиллагаа явуулахаас татгалзаж, цэрэг зэвсгийн хүчээр сүрдүүлсэн маягтай харьцангуй аюул багатай өдөөн хатгалгад шилжих болсон нь өнөө цагийн

олон улсын цэрэг-улс төрийн харилцааны нэгэн шинэ зүйл болж байна. Эдгээр өдөөн хатгалгуудад зэвсэг хэрэглэсэн, цэргийн анги, салбаруудын хүчээр явуулах бодит дайнаас ялгаатай буюу элдэв төрлийн нисгэгчгүй аппарат, тагнуулын хэрэгсэл, тусгай хүчний үйл ажиллагаа, цэргийн нисэх болон пуужингийн хүчний ганц нэг гэнэтийн, оновчтой бөмбөгдөлт, цохилт, радио электрон тэмцлийн хэрэгслийн дайралт гэх мэт хэлбэрүүд улам бүр давамгайлах шинжтэй байна..

## II. ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ.

**Нэг.** Сүүлийн жилүүдэд олон улсын аюулгүй байдалд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь их гүрнүүдийн улам бүр ширүүсэж буй геополитикийн өрсөлдөөн болоод байна. Энэ нь эдгээр орон хүн төрөлхтний ирээдүйн талаар өөрийн гэсэн бодитой, яв цав тодорхой төсөөлөлтэй болж чадаагүй байгаа учир бий болсон өнөөгийн эмзэг нөхцөл байдалд өөрсдийн давамгайлагч байр суурийг алдаж, бусдаас хоцорч, сул дорой болж харагдахаас эмээх үүднээс эмх замбараагүй гэж хэлж болох алдаж оносон давшингуй, түрэмгий үйлдэл хийх болсонтой холбоотой бололтой байна. Үүний улмаас улс орнуудын геостратегийн бодлого өөрийн аюулгүй байдлыг хангах гэхээсээ илүүтэйгээр “бусдын доор орохгүйг” эрмэлзсэн маягтай, энэ талаасаа аль болох ашигтай нөхцөл байдлыг өөртөө бий болгоход чиглэсэн буюу юмыг ихээхэн хялбаршуулан ойлгохыг хичээсэн хэлбэртэй болсоор байна. Гэхдээ энэхүү эмх замбараагүй гэж хэлж болох геополитикийн ширүүн өрсөлдөөн нь олон улсын аюулгүй байдлын тэнцвэрийг алдагдуулах хэмжээнд бас хараахан хүрээгүй байгаа юм

**Хоёр.** Үүний зэрэгцээ дэлхийн геополитикийн нөхцөл байдлыг Орос-Өрнөд, АНУ-Хятад, Умард-Өмнөд гэсэн ганц нэг эсвэл цөөн хэдэн гол тоглогчийн сөргөлдөөнөөр тайлбарлах боломжгүй болоод байна. Учир нь өнөөгийн геополитикийн ширүүн өрсөлдөөн нь одоогоор партизаны дайнтай нэгэн адилаар ямар нэг фронтын шугамгүй, гэнэт дүрэлзэн асаж тэгснээ огцом алга болох зэрэг тогтворгүй байдалтай, олон хэсэг бүлэг, голомтоос бүрдэж байна. Нэг талаас, тайван цаг үе чухал болохыг улс орон бүхэн хүлээн зөвшөөрч байгаа боловч бүгд л олон улсын геополитикийн өрсөлдөөнөөс үүдэлтэй шинэ хямрал гарахыг хүлээсэн, түүнд бэлтгэсэн байдалтай байна. Нөгөө талаасаа, эдгээр хямралын эх сурвалж нь юу байж ямар шинж чанартай, цар хүрээтэй болох, ямар үр дагаварт хүргэж болох талаар тодорхой төсөөлөл одоогоор хэнд чиг байхгүй байна.

**Гурав.** Улс төр болон геополитикт тодорхой байдал ус агаар шиг хэрэгтэй байдаг тул тэд болохгүй бүтэхгүй бүх зүйлд нэг бол Өрнөд, Америк үгүй бол Хятад, Орос, буруутай гэх мэтээр болж буй үйл явдлыг өмнөх үеийнхээрээ буюу мэддэгээрээ л тайлбарлахыг оролдох болоод байна. Энэ нь аливаа зүйл, үзэгдэл юмсыг аль болох амархнаар харахыг хичээх нь хүний дотоод зөн эрмэлзэл байдагтай ч холбоотой байж болох юм. Жишээлбэл, америкийн элитүүд чухамхүү Москва л тэдэнд "хүсээгүй" ерөнхийлөгчийг нь сонгоод өгчихсөн маягийн юм ярьж байгаа бол Оросын зарим "ардчилагчид" америкууд өөрсдөд нь туслахгүй байгаа учраас л өөрсдийнх нь улсад ардчилал байхгүй, Путин ноёрхсоор байна гэж үзэж байх жишээтэй.

**Дөрөв**. Орос ба Өрнөдийн хооронд геополитикийн буюу "шинэ хүйтэн дайн" өрнөж байна гэсэн хуурамч тодорхой байдлыг бий болгож түүндээ бүгд итгэсээр байна. Гэтэл үнэндээ өнөө үед бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдлын учир шалтгааныг ухаж үзвэл үнэндээ ийм "хүйтэн дайн" байхгүй бололтой байгаа юм. Өөрөөр хэлбэл, нэг талаас Өрнөдийн нэгдэл алдагдаж байгааг өөрсдөдөө үр дүнтэйгээр ашиглах гэсэн Орос болон Хятад, нөгөө талаас энэ эв нэгдлийг хадгалж өөрөө түүнийхээ манлайлагч нь хэвээр байх гэсэн АНУ хоорондын өрсөлдөөн л явагдаж байгаа бололтой юм. Үүний зэрэгцээ олон улсын геополитикийн нөхцөл байдлыг шинээр ойлгох шаардлага ч бас байгаа юм. Стратегийн тухайд бие даасан бодлого явуулах хэмжээнд хүрсэн Энэтхэг, Иран, Турк магадгүй Хойд Солонгос гэх мэтийн улс орны тоо нэмэгдэж байгаа нь олон улсын аюулгүй байдлын гадаад орчныг ээдрээтэй болгож, энэ нөхцөл байдалд бодитой дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлыг үүсгэж буйг үндсэндээ бүгд хүлээн зөвшөөрөх болоод байна.

## III. МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН АЧ ХОЛБОГДЛЫН ТАЛААРХ ДҮГНЭЛТ.

**Нэг.** Монгол Улсын геополитикийн болон үндэсний аюулгүй байдал нь маш нарийн, олон талт нийгмийн өвөрмөц асуудал хэвээр байна. Үндэсний аюулгүй байдал нь болзошгүй болон бодит аюул, занал, эрсдэлийг хумин хаах, улс орны геополитик, геостратеги болон амин чухал бусад ашиг сонирхлыг хамгаалах чадавх, бэлэн байдлаар тодорхойлогдож байна. Өнөөгийн байдлаар, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг өөр хоорондоо тодорхой хэлбэрээр холбоотой, бүтцийн зохион байгуулалттай янз бүрийн түвшин, чанартай бүрэлдэхүүн хэсэг,

элементүүдээс бүрдсэн, нээлттэй хэлбэрийн тогтолцоо гэж үзэж болохоор байна. Чингэхдээ, уг тогтолцоо нь геополитикийн бий болсон нөхцөл байдал, гадаад, дотоод орчны нөлөөлөлд мэдрэмтгий, тааламжгүй хүчин зүйлийг саармагжуулах, тааламжтай нөлөөллийн нөхцөлийг бүрдүүлэх чадвартай байх талаасаа ихээхэн учир дутагдалтай байна. Тухайлбал, гадаад, дотоод үүдэл сэдэл бүхий геополитикийн хүчин зүйлсийг тооцох тухайд энэ нь онцгой хамаарах юм.

**Хоёр.** Геополитикийн хүчин зүйлсийн мөн чанар, агуулгын философи-улс төр судлал болон цэрэг-стратегийн үнэлгээнээс үзэхэд Монгол Улсын гадаад хүрээлэлд үүсэн үйлчилж буй болон дотоод нөхцөл байдлаас үүдэлтэй үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй геополитикийн гадаад, дотоод гэсэн хоёр том бүлэг хүчин зүйлс байгаа нь харагдаж байна. Энэ хоёр бүлэг хүчин зүйлс хоёулаа Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд тогтворжуулах ба тогтворгүйжүүлэх гэсэн нөлөөлөл үзүүлж байна. Эдгээр нөлөөллийн чиглэл маш нарийн, олон талтай байгаа боловч үндсэндээ ард иргэд, төр болон бүхэлд нь авч үзвэл нийт нийгмийн аюулгүй байдалд сөрөг талдаа нөлөө үзүүлэх хандлагатай байна. Тиймээс геополитикийн хүчин зүйлсийн мөн чанар, учир шалтгаан, агуулга болон илэрч мэдэгдэх хэлбэр талаарх гүн гүнзгий мэдлэг нь үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд тэдгээрийн үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, засаж залруулах, ингэснээрээ аюулгүй байдлын тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх боломж олгох бололтой байна.

**Гурав**. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилго, зорилтуудыг шийдвэрлэх үүднээс авч үзвэл геополитикийн хүчин зүйлсийн нийт систем дотор улс төр, эдийн засаг, нийгмийн хүчин зүйлс онцгой чухал ач холбогдолтой хэвээр байна. Учир нь геополитикийн өвөрмөц байрлалаасаа үүдэн Монгол Улсад улс төр, эдийн засгийн улмаар нийгмийн зөрчил хурцдаж, хөгжлийн бодлого алдагдах аюул заналд өртөх магадлал бодитой байгаа юм. Тиймээс төрийн бодлогын тэргүүлэх чиглэлүүдэд сайн засаглал, тогтвортой хөгжлийн асуудал зайлшгүй орох ёстой байна. Үүний зэрэгцээ Монгол Улс үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод аюул заналын зэрэг түвшин, улс орны цэрэг-улс төрийн зорилго, эдийн засгийн боломж, газар зүй болон геостратегийн байршилд тохирсон чадварлаг зэвсэгт хүчин, цэргийн байгуулал болон шударга, үр дүнтэй үйл ажиллагаа явуулдаг хууль сахиулах байгууллагуудын тогтолцоотой байх нь бас залшгүй шаардлага болсоор байна.

**Дөрөв.** Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилтуудыг шийдвэрлэхэд геополитикийн хүчин зүйлсийг харгалзах арга механизмын талаарх мэдлэг нь тэдгээрийн эерэг нөлөөллийг ашиглах, сөрөг нөлөөллийг нь саармагжуулах тодорхой арга хэмжээг цаг тухайд нь авах боломжийг олгох юм. Мэдээж хэрэг энэ бол маш амаргүй, гэхдээ боломжтой зүйл. Тиймээс үндэсний аюулгүй байдлын субъектүүд улс оронд, хөрш зэргэлдээ бүс нутаг болон даян дэлхийд бий болсон бодит нөхцөл байдал, геополитикийн хүчин зүйлсийн нөлөөллийн боломжит хувилбарууд, тэдгээрийн эерэг боломжийг ашиглах, сөрөг нөлөөллийг "унтраах" шинжлэх ухаанч арга механизмын талаар цэгцтэй мэдлэгтэй байх ёстой болоод байна.

## IV. ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БОЛЗОШГҮЙ ГЕОПОЛИТИКИЙН ҮҮДЭЛ СЭДЭЛ БҮХИЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ.

**Нэг. Гадаад хүчин зүйлс:**

- Хятад улс эдийн засгийн хөгжлийн хувьд өнөөгийн ертөнцөд хамгийн хурдац, далайцтай урагшилж байгаа орон бөгөөд түүний өдөр ирэх тутам өсөн нэмэгдэж буй цэргийн хүч Зүүн Хойд Азийн улс орнуудын санааг зовоох зүйл болж байна. Хүчтэй эдийн засаг, хурдацтай хөгжиж буй зэвсэгт хүчин, их хүн амтай байдлаа ашиглан Хятад улс зөвхөн өөрийн газар нутаг гэж үздэг Тайван руу төдийгүй Оросын Сибирь, Алс Дорнод, түүнчлэн Монгол руу анхаарлаа хандуулахыг үгүйсгэж болохгүй байна.

- Сүүлийн үед ОХУ-ын зүгээс АНУ-ын болон НАТО-ийн эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэллээ. Үүний тулд эдгээрийн эсрэг холбоотон байж болох улс орныг эрж хайх, зарим улсад ялангуяа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан орнууудад үүндээ нэгдэхийг хатуу, зөөлөн янз бурийн хэлбэрээр тулгах байдал ч ажиглагдаж байна. Энэ нь хуучин социалист хамтын нөхөрлөлийн гэгдэж байсан улс орнуудад, түүний дотор Монгол улсад ямар нэг хэлбэрээр хамаарч болохыг үгүй гэх баталгаагүй байна.

- Орчин цагийн хамгийн хүчирхэг гүрний хувьд АНУ-ын хүчин чадал байнга өсөж, энэ орон Зүүн Хойд болон Төв Азид өөрийн нөлөөллийн бүсийг өргөтгөн тэлэхийг чармайсаар байгаа нь хүссэн хүсээгүй Монгол Улсад учирч болзошгүй эрсдэл сорилтын нэг үндэс суурь болох магадлалтай байна. Үүний зэрэгцээ АНУ-

тай тогтоосон стратегийн түншлэл Монгол Улсын хувьд аюулгүй байдал талаасаа багагүй эрсдэл сорилтыг дагуулж байгаа боловч одоохондоо манай орны аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах нэг гол чухал хүчин зүйл болж байгааг бас үгүйсгэж болохгүй юм. Ойрын ирээдүйд ч ийм байдал тогтвортой үргэлжлэх нь үндсэндээ тодорхой байна.

- Ìîíãîë Óëñ ØХАБ-ûí òàëààð áàðèìòëàõ ººðèéí гэсэн тодорхой áàéð ñóóðüòàé байна. ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ûí ç¿ãýýñ ýíý áàéãóóëëàãàä Ìîíãîë Óëñûã èäýâõòýé îðîëöóóëàõ ñîíèðõîëòîé буйгаа удаа дараа èëýðõèéëæ áàéñàí áîëîâ÷ манай орон ØХАБ-ûí õºãæèë, òºëºâèéã àíõààðàëòàé àæèãëàæ, õàðçíàæ байгаа юм. Ýíý íü уг áàéãóóëëàãûã ãîë÷ëîí öýðýã, óëñ òºðèéí áîëîí àþóëã¿é áàéäëûí ºíöãººñ õàðàõ ÿâääë áóñàä îðíû õóâüä íýëýýä ò¿ãýýìýë áàéãààòàé голлон õîëáîîòîé áайна.

- НАТО-гийн хувьд Монгол Улс түүний аюулгүй байдалд нөлөөлөхүйц шууд ашиг сонирхол бүхий улс орон биш юм. Харин улс төр, эдийн засаг, нийгмийн, түүний дотор батлан хамгаалах салбарын шинэчлэлийг ардчилсан орнуудын жишгээр амжилттай хэрэгжүүлж буй улсын хувьд социализмын дараах орнууд, ялангуяа Төв Азийн орнуудад үлгэр болох тод жишээ гэдгээрээ НАТО-ийн анхаарлыг татаж байгаа болох нь олон зүйл дээрээс харагдаж байна. НАТО-той тогтоосон өнөөгийн харилцаа нь Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэх, улмаар манай улсын нэр хүндийг олон улсын тавцанд өсгөх, аюулгүй байдлаа хангахад тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгч байгаа, сүүлийн үед Монгол Улсын талаар идэвхтэй гэж хэлж болох бодлого явуулах болсон хоёр хөршийнхөө ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх зорилго бүхий гуравдагч хөршийн бодлогын нэг чухал хүчин зүйл болон хувирч байгаа нь ойлгогдож байна.

- ЕАБХАБ-тай тогтоосон ажил хэрэгч хамтын ажиллагаа ардчилал, зах зээлийн нийгэмд шилжиж орж байгаа Монгол Улсын хувьд аюулгүй байдлыг улс төр дипломатын аргаар хангах, тогтвортой хөгжих, байгаль орчныг хамгаалах, сайн засаглал, сонгуулийн ардчилал, жендерийн тэгш байдлыг хангах зэрэг олон томхон зорилтыг шийдвэрлэхэд Европын улсуудын арга туршлага, тэднийг эгнээндээ нэгтгэдэг бодитой дэмжлэг үзүүлж байна.

**Хоёр. Дотоод хүчин зүйлс:**

- Манай орны улс төрийн нөхцөл байдлын гол илэрхийлэл болох улс төрийн тогтвортой байдал нь төрт ёсны уламжлалаа хадгалах, үндэсний тусгаар тогтнол,

газар нутгаа хамгаалахын тулд Монголын ард түмний олон зуун жилийн турш явуулж ирсэн түүхэн тэмцэлтэй буюу гадаад хүчин зүйлийн нөлөөлөлтэй шууд холбоотой ойлголт юм. Сүүлийн жилүүдэд манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд гарч буй өөрчлөлт нь дотоод улс төрийн нөхцөл байдлыг тэргүүн зэрэгт авч үзэхийг шаардаж буй нь улам бүр тодорхой болсоор байна. Өөрөөр хэлбэл, дотоодын шинж чанартай улс төрийн хямралт үзэгдлүүд газар авах болж энэ нь нийгмийн зүгээс төр, засгаа дэмжихгүй байх, итгэл алдарснаа мэдрүүлэх байдлаар илэрч эхэлж буй бөгөөд үүнийг засаж залруулах дорвитой бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй бол ноцтой нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

- Орчин үеийн олон улсын эдийн засгийн дэг журам бага буурай Монгол мэтийн орны хувьд өрсөлдөөнд үндэслэсэн сонгодог зах зээлээс, огт өөрөөр нөлөөлж байгааг олон орны судлаачид хүлээн зөвшөөрөх болж байна. Өнөө ¿åä àëèâàà íýã óëñ íºãººãèéíõºº эдийн засгийг бүхэлд нь буюу аль нэг салбарыг нь хараат байдалдаа оруулахыг оролдох гэх мэт øóóä заналхийлэл èõýýõýí áàãàññàíààð áèäýíä òàéâøðàõ áîëîìæîî ãàð÷ èðæ áàéãàà ìýò áîëîâ÷ ìàíàé ¿íäýñíèé эдийн засгийн àøèã ñîíèðõîëä õàðøèëàõ, àþóëã¿é áàéäëûã нь õýâðýãø¿¿ëýõ îëîí øèíý ¿éë ÿâäàë, õ¿÷èí ç¿éë¿¿ä áèé áîëæ áàéãàà íºõöºëä áèä àìüäàð÷ áàéíà.

- Нийгэм дэх авлига, шударга бус байдал, гэмт хэргийн өсөлт, төр засгаас тэдний эсрэг явуулж буй тэмцлийн үр дүн төдийлөн сайн биш байгаа нь Монголын нийгэмд анхаарал татсан асуудал болсон хэвээр байж нийгмийн аюулгүй байдлыг хэврэгшүүлэх нэг гол учир шалтгаан болсоор байгаа нь судалгаанаас харагдаж байна. Монголын нийгэмд учирч болзошгүй аюул олон нийтийн оюун санааны хямралтай салшгүй холбоотой байгаа явдал бас ажиглагдаж байна. Монгол Улсын хүн амын аж амьдралын эрхэмлэх зүйл, гэгээн зорилго, зорилт өөрчлөгдсөнтэй холбоотойгоор оюун санааны хямралт байдалд орсон нь өнөө хэр дуусаагүй байна.

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан тодотгон шинэчлэх залшгүй шаардлага үүссэн байна. Анхны үзэл баримтлал 1994 онд Улсын Их Хурлаар батлагдан гарсан. Уг үзэл баримтлал нь шинэ Үндсэн хуулийн үзэл санааг бататган бэхжүүлж, аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаанд үндэсний язгуур ашиг сонирхлыг дээдлэх үзэл санааг анхлан тунхагласны зэрэгцээ,

эрхэмлэн шүтэх энэ үзэл санааг иргэдэд төлөвшүүлэх үндсийг тавьж, үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогын чухал тулгуур болж ирсэн байна. Улмаар 2000-аад оны эхээр бий болсон гадаад дотоод нөхцөл байдалтай уялдуулан уг үзэл баримтлалыг тодотгон шинэчилж 2010 онд УИХ-аар батлан гаргасан боловч үүнээс хойших хугацаанд чухамхүү геополитикийн нөхцөл байдлыг харгалзан үзээгүй гэсэн агуулга бүхий багагүй шүүмжлэл дагуулж иржээ.

- Гадаад бодлогын үзэл баримтлал хэмээх урт хугацааны бодлогын чанартай баримт бичгийг мөн олон улсын геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан баяжуулах шаардлагатай болсон байна. Энэ баримт бичгийн чухал ач холбогдол нь Монгол улсын ¯íäýñíèé àþóëã¿é áàéäëûí ¿çýë áàðèìòëàëòàé óÿëäààòàéãààð боловсруулагдаж áàòëàãäñàí явдал бөгөөд ¿íäñýíäýý ò¿¿íèé íýã òóëãóóð á¿ðýëäõ¿¿í õýñýã болсон байна. Үүний зэрэгцээ, гадаад áîäëîãûí ¿çýë áàðèìòëàëûã òºðèéí áîäëîãîîð íýãòãýí õýðýãæ¿¿ëýõ, ã¿éöýòãýëä íü õÿíàëò òàâèõ ¿ð ä¿íòýé ìåõàíèçì áèé áîëîî ãýæ õýëýõ áàñ õàðààõàí áîëîîã¿éí äýýð 2011 оноос хойш îëîí óëñûí õàðèëöààí дахь геополитикийн өрсөлдөөний òàëààðõ îéëãîëò îíîëûí áîëîí ñýòãýëãýýíèé àãóóëãà òàëààñàà èõýýõýí øèíý÷ëýãäýæ, Ìîíãîë Óëñûã õ¿ðýýëñýí аюулгүй байдлын îð÷èí, óëñ îðíû äîòîîä íºõöºë áàéäàëä чиг багагүй ººð÷ëºëò гарсан байна.

- 2015 онд УИХ-аар батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” хэмээх баримт бичигт батлан хамгаалах бодлогын улс төрийн чиглэлийн асуудлыг тусгай бүлэг болгон авч үзжээ. Өмнө нь үйлчилж байсан “Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгээс ялгагдах зарчмын гэж хэлж болох энэ өөрчлөлт нь улс төр, нийгмийн салбар бүрийн батлан хамгаалахад оролцох үйл ажиллагааны үндсэн агуулгыг нь тусгайлан тодорхойлж өгсөн болон Зэвсэгт хүчин нэгдмэл байх тухай олон жил үргэлжилсэн маргаан, үзэл бодлын зөрчилдөөнийг үндсэнд нь нэг тийш нь болгон шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл төрийн батлан хамгаалах тогтолцооны агуулгад “Төрийн цэргийн байгууллал” гэдэг эрх зүйн үндэслэлийн хувьд шинэ ойлголтыг томьёолон оруулж үүндээ Зэвсэгт хүчин, Хилийн ба дотоодын цэрэг, Онцгой байдлын байгууллага багтана гэдгийг албан ёсоор тогтоож өгсөн байна. Гэвч энэ баримт бичигт батлан хамгаалах бодлогын геополитикийн чиглэл гэсэн шинэ агуулгыг нэмж оруулах нь чухал байгааг энэхүү суурь судалгаа харуулсан болно.

## V. ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭСЛЭГЭЭНИЙ ТАЛААР.

**Нэг.** Манай орны үндэсний аюулгүй байдалд олон шинэ эрсдэл, сорилт тулгарах болж, зарим нь лавшрах хандлагатай байна. Улс орны улс төр, нийгмийн байдал хурцадмал хэвээр, зөрчил сөргөлдөөн үргэлжилсээр, эдийн засгийн тэнцвэртэй хөгжил төдийлөн хангагдаж чадахгүй, сайн засаглал байгуулах ажил удаашралтай, ард түмний нэлээд хэсгийн амьдралын түвшин төдийлөн сайжрахгүй байгаа зэргээс улбаалан нийгэмд тогтворгүй, хуваагдмал байдал үүсэн бий болох шинж тэмдэг ажиглагдаж, байна.

Түүнчлэн урд өмнө нийгмийн улс төрийн амьдралд байгаагүй зарим ноцтой аюулын шинж тэмдэг бас илрэх боллоо.

**Хоёр.** Ойрын áîëîí äóíä õóãàöààíû èðýýä¿éä Ìîíãîë Óëñûí òóñãààð òîãòíîë, á¿ðýí эрхт ááéääë, ãàçàð íóòãèéí á¿ðýí á¿òýí, улсын хилийн халдашгүй дархан ááéääë, òºðèéí ááéãóóëàëòàä ãààíààñ öýðãèéí õ¿÷ýýð øóóä çàíàëõèéëýõ àþóë ¿íäñýíäýý ááéõã¿é ááéíà.

¯¿íèé çýðýãöýý á¿ñ íóòãèéí õ¿ðýýíä ¿¿ñýí Ìîíãîë Óëñ òàòàãäààí îðæ áîëîõ ýñâýë дотоод õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí ¿¿ñ÷ áîëîõ зарим аюул áîäèòîéãîîð оршиж ááéãàà нь энэхүү төслийн хүрээнд явуулсан судалгаанаас тодорхой õàðàãäàæ ááéíà.

¯¿íèé çýðýãöýý á¿ñ íóòãèéí õ¿ðýýíä ¿¿ñýí Ìîíãîë Óëñ òàòàãäààí îðæ áîëîõ ýñâýë өөр бусад ãàäààä õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí ¿¿ñ÷ áîëîõ äàðààõ àþóëóóä áîäèòîéãîîð оршиж ááéãàà нь бас õàðàãäàæ ááéíà.

**Á¿ñ íóòãèéí геополиткийн нөхцөл байдлаас үүдэн Ìîíãîë Óëñ òàòàãäààí îðæ áîëçîøã¿é аюул заналын таамаглал.**

- Îëîí óëñûí òåððîðèçì óëàì á¿ð õ¿ðýýãýý òýëæ Ç¿¿í õîéä Àçè, Òºâ Àçèéí á¿ñ íóòãèéã, ò¿¿íèé äîòîð Ìîíãîë Óëñûí íóòàã äýâñãýðèéã õàìðàõ;

- Óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé Õÿòàäûí ýäèéí çàñãèéí ýð÷èìòýé хөгжлийг даган Àçè òèâä öýðýã-óëñ òºðèéí нөлөөллөө ºðãºæ¿¿ëýõ энэ улсын эрмэлзлийг төрүүлэн ¿¿íèé óëìààñ ¿¿íòýé èæèë òºñòýé àøèã ñîíèðõîë á¿õèé ÎÕÓ áîëîí

ÀÍÓ-òàé íîöòîé, ºðãºí õ¿ðýýòýé зөрчилдөхөд õ¿ðãýõ, ¿¿íä íü Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðîõ;

- Õî¸ð Ñîëîíãîñ, Õÿòàä-Òàéâàíü, Ýíýòõýã-Ïàêèñòàí õîîðîíäûí ýñðýã òýñðýã áàéð ñóóðü, Êóðèëèéí àðëóóäûí òàëààðõ Îðîñ-ßïîíû ìàðãààí зэрэг нь óëñ õîîðîíäûí õàðèëöààíû òîãòâîðãvé íºõöºë áàéäàëä çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýõ. Ýíý íü á¿ñ íóòãèéã õàìàðñàí øèíæòýé áîëæ ºðãºæèõ Ìîíãîë Óëñûã ÿìàð íýã õýëáýðýýð õàìðàõ;

- Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé НАТО-ийí öýðýã-óëñ òºð, ýäèéí çàñãèéí íºëººã õÿçãààðëàõ зорилго бүхий Øàíõàéí õàìòûí àæèëëàãààíû áàéãóóëëàãûí öýðýã-óëñ òºðèéí ýâñýë õýëáýðèéí ¿éë àæèëëàãàà ºðãºæèí ¿¿íèé ¿ð äàãâàðààð ÀÍÓ, Баруүны орнууд нэг талаас áîëîí нөгөө талаас Орос, Хятадын õîîðîíä öýðýã, çýâñãèéí õ¿÷èéã òóëãóóð áîëãîñîí çºð÷èë, ñºðãºëäººí үүсэх, ¿¿íä Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðîõ;

- 2008 îíä òîõèîëäñîíòîé төсөөтэй íèéòèéã õàìàðñàí ýäèéí çàñãèéí õÿìðàë Àçè òèâ áîëîí Ç¿¿í Хойд Àçèä áèé áîëæ ýíý íü Ìîíãîë Óëñûí ýäèéí çàñàã, íèéãìèéí õºãæëèéã ñààðóóëàõ áóþó çîãñîîãè áàéäàëä îðóóëàõ;

- Õºðø çýðãýëäýý áîëîí áóñàä îðîíä ¿¿ñññýí õÿìðàëò áàéäëààñ ¿¿äñýí õýíàëòààñ ãàðñàí öàãàà÷ëàë, æèðèéí áîëîí çýâñýãëýñýí ä¿ðâýëòýä íýðâýãäýõ çýðýã áîëîí.

**Уламжлалт бус аюул заналын таамаглал.**

Олон улсын ээдрээтэй нөхцөл, улс төрийн тогтворгүй байдал, үндэсний эдийн засгийн хямрал, нийгмийн хуваагдал, түүний дотор шашин хоорондын харилцааны зарим нэг зөрчил сөргөлдөөн зэрэг нь манай орны аюулгүй байдалд учрах гадаад, дотоод үүдэлтэй уламжлалт бус аюул заналын эх сурвалж болж байна. Үүнд:

<u>Óëñ òºðèéí õ¿ðýýíä:</u>

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгай байдлаа бий болгох гэсэн том гүрнүүдийн зөрчил сөргөлдөөн болон тэдгээрийн манай улсын тухайд

явуулж буй тус тусын тодорхой чиглэл, зорилго бүхий геостратегийн бодлогын нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн бодлогод саад бэрхшээл үүсэх, àëü íýã óëñ îðîí, óëñ òºð-öýðãèéí ýâñýë õîëáîî áóþó ¿íäýñòýí ääìæñàí òîì êîðïîðàöóóäààñ улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар õàðààò áàéäàëä орох;

- Олон улсын терроризм улам бүр газар авч байгаа болон манай улс терроризмын эсрэг барууны эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гадны хүчний явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирэх;

- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад орнуудын зүгээс манай орны эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаагаа нэмэгдэх, энэ нь чиглэл, зорилготой, нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болох.

<u>Ýäèéí çàñãèéí õ¿ðýýíä:</u>

- Гадаадын хөрөнгө оруулалт, бусад улстай хийх худалдааг тэнцвэржүүлэх нэгдсэн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох;

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого, үйл ажиллагаанд алдаа, доголдол гарах, үүний улмаас эдийн засгийн салбарт тогтвортгүй байдал үүсэх, мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гарах, дампуурalд орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл сулрах ;

- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажаагүй гадны зээл тусламж нэмэгдэх, үнэт цаасны зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр çàñàã, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орох, улс орон âàëþòûí íººöºº àëäàõ, áàðüöààëóóëàõ, ãàäààä äîòîîäûí õºðºíãº îðóóëàëò эмх замбараагүй байдалтай болох, түүнчлэн çýýë, òóñëàìæûã çàìààñ íü çàâøèõ ÿâäàë ãàçàð àâñàíààñ ¿¿äýí ãàäààä îðíóóä, ò¿¿íèé äîòîð òîì ã¿ðí¿¿ä ýíý òºðëèéí ¿éë àæèëëàãààã õýðýãæ¿¿ëýõýý çîãñîîõ.

<u>Íèéãìèéí õ¿ðýýíä:</u>

- Õóóðàì÷, õàäãàëàõ õóãàöàà õýòýðñýí, õ¿íèé áèå îðãàíèçìä õîðòîé õ¿íñ, ýì òàðèà, õóâöàñ, ýä õýðýãëýë ãýõ ìýò ç¿éë¿¿ä ãààíààñ ихээр îðæ èðýõ, ãàäààä

õàðèëöàà ºðãºæèæ õ¿í,  ìàë, áàðàà á¿òýýãäõ¿¿íèé óðñãàë ÷ºëººòýé áîëîõ õýðýýð ýëäýâ õàëäâàðò ºâ÷èí òàðõàõ, ¿¿íèé äîòîð ÄÎÕ, шинэ вирусийн болон íýí õàëäâàðò áóñàä ºâ÷íººð ºâ÷ëºãñäèéí òîî ºñºõ;

- Óëñ îðíû õýìæýýíä, ¿íäýñòýí ààìæñàí ãýìò õýðãèéí á¿ëýãëýë¿¿ä áèé бол, ýð¿¿ãèéí íºõöºë áàéäàë õýíàëòààñ ãàðàõ ìàíàé óëñûí íóòàã äýâñãýðèéã ìàíñóóðóóëàõ áîäèñ, ýëäýâ òºðëèéí çýâñýã, öºìèéí ò¿¿õèé ýä, ìàòåðèàë, õ¿í õóäàëäààëàõààð çººâºðëºõ, äàìæóóëàõ òàëáàð áîëãîõ îðîëäëîãî ãàðàõ, òýäãýýðèéí õîð óðøèã íü óëñ îðíû óëñ òºð, ýäèéí çàñãèéí áîäëîãîä íºëººëºõ õýìæýýíä хүрэх;

- Харт тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн хэлбэрт шилжих .

<u>Ñî¸ë èðãýíøëèéí õ¿ðýýíä:</u>

- Ìîíãîë Óëñûí ãàäààä õàðèëöàà ºðãºæèõ, íýýëòòýé áîëîõ õýðýýð áóñàä îðíû àìüäðàõ õýâ ìàÿã, ýðõýìëýõ ¿íýò ç¿éëñèéí õ¿÷òýé íýâòðýë гүнзгийрэх, ¿¿íýýñ ¿¿äýí ¿íäýñíèé ¿íýò ç¿éëñèéí ¿íýëýìæèä ýðãýæ áóöàëòã¿é ººð÷ëºëò ãàðàõ, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлөх;

- õ¿í òºðºëõòíèé íèéòëýã ñî¸ëûã äýýäëýõ, áóñàä øàøíûã õ¿íäýòãýõ, зарим тохиолдолд албан ёсны бус гаднаас орж ирсэн шашны урсгалд автах ¿çýë áîëîí ìîíãîë ¿íäýñòíèé òºðºëõ õýë, ñî¸ë, áóðõàíû øàøèí, ¸ñ çàíøèë, óëìûí ñàí, óãñàà ãàðâàëàà õàäãàëàí õàìãààëàõ ãýñýí ýðìýëçëèéí õîìðîíä çºð÷èë, ñºðãºëäººí ¿¿ñýõ, ýíý íü óëñ òºðæèõ çàìààð íèéãýìä áóõèìäàë ¿¿ñãýх.

<u>Áàéãàë îð÷íû õ¿ðýýíä:</u>

- Äýëõèéí öàã óóðûí äóëààðàë, ººð÷ëºëò áîëîí áóñàä øàëòãààíààñ ¿¿äýí áàéãàëèéí ãàìøèãò ¿çýãäë¿¿ä îëøðîõ ýíý íü óëñ îðíû ýäèéí çàñàã, íèéãýìä äààæ äààâøã¿é õîõèðîë учруулах;

- Хэт их гадаадын хөрөнгө оруулалт бүхий óóë óóðõàéí áîëîí áîëîâñðóóëàõ ¿éëäâýðëýëèéã ýð÷èìæ¿¿ëýõ ÿâöàä áàéãàëèéí òýíöâýð àëäàãäàõ, óñ, ãîë ìºðºí, àãààð ìàíäàë, õºðñ áîõèðäîõ, îé ñ¿éäýõ, öºëæèëò ãàçàð àâàõ, áýë÷ýýðèéí òàëõàäàë, òàðèàëàíãèéí òàëáàéí õîìñäîë èõñýõ, ÿäãýýðýýñ ¿¿äýí õ¿í àìûí íýëýýä õýñãèéí

àìüæèðãààíû ýõ ¿¿ñâýð áîëñîí ìàë àæ àõóé, ããçàð òàðèàëàíãèéí õºãæèë çîãñîíãè áàéääàëä îðîõ, өөр хоорондоо тэрсэлдэх;

- Манай орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах оролдлого гарах.

**Гурав.** Бий болсон шинэ нөхцөл байдалд өдөө мөрдөгдөж буй Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг òîãîðõîé хэмжээгээр өөрчлөн ¿íäñýí зорилго, àãóóëãûã íü геополитикийн болон үндэсний язгуур эрх ашгийг хадгалан хамгаалах бодлого, үйл ажиллагаа болгон өөрчлөх зайлшгүй шаардлага үүсэн болох нь энэхүү суурь судалгааны төслийн явцаас тодорхой харагдаж байна. Юуны өмнө Ìîíãîë Óëñûí èðãýí, õóâü õ¿í ýëáýã õàíãàëòóóí àìüäðàëòàé, ýð¿¿ë ñàðóóë áàéæ, àæèë õºäºëìºð ýðõëýõ, ñóðàëöàõ áîëîâñðîõ, õóóëèéí ºìíº àäèë òýãø áàéõ çýðýã îëîí ýðõýýð á¿ðýí õàíãààãäñàí, ýäãýýðèéí ¿ð ä¿íä Ýõ îðîíîðîî áàõàðõàõ ¿çëýýð òºãñ õ¿ì¿¿æñýí áàéõààñ ¿íäýñíèé àþóëã¿é áàéäàë èõýýõýí øàëòãààëàõ болоод байна. Түүнчлэн геополитикийн болон үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудаа îëîí óëñûí аюулгүй байдлын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд шийдвэрлэхийг эрмэлзэх, үүнийхээ зэрэгцээ дотооддоо төр, íèéãýì, хувь хүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний эрх зүйн цэгцтэй зохицуулалтыг бий болгох нь ихээхэн чухал болоод байна.

**Дөрөв.** Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалд нийцүүлэн тодотгон шинэчлэхтэй уялдуулан Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулиудыг мөн шинэчлэх зайлшгүй шаардлагатай болоод байна. Ингэхдээ анхаарах хамгийн чухал асуудал бол хэдийгээр 2010 онд 1994 оны Үзэл баримтлалыг шинэчлэн баталсан боловч эдгээр хуулийг өнөөг хүртэл шинэ үзэл баримтлалтай уялдуулан тодотгох ажил хийгдээгүй байгааг засах явдал юм. Ийм учраас эдгээр хуулийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсны дараагаар дахин боловсруулах шаардлага үүсэх нь тодорхой байна

**Тав**. Îéðûí èðýýä¿éä Ìîíãîë Óëñûí ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûã õàíãàõàä гадаад бодлогын үзэл баримтлалыг геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тодотгон шинэчлэх, ингэхдээ ìàíàé óëñààñ áóñàä îðíóóäòàé òîãòîîñîí найрамдалт õàðèëöààã үргэлжлүүлэх асуудал îíöãîé ÷óõàë àñ õîëáîãäîëòîé байх нь судалгааны

үр дүнгээс харагдаж байна. ¯íäýñíèé àþóëã¿é ááéäëàà õàíãàõ çîðèëãî, çîðèëòóóäыг çºâõºí ãàäààä õàðèëöàãàà ºðãºæ¿¿ëýí õºãæ¿¿ëýõ, îëîí óëñûí á¿õ òàëûí õàìòûí àæèëëàãààíä ìàíàé óëñûí îðîëöîîã èäýâõæ¿¿ëýõ болон өөрийн улсын геополитикийн нэр хүндийг олон улсад өргөх çàìààð  хангаж болох нь ойлгогдож байна. Энэ нь гадаад харилцааны салбарын шинэчлэлийг геополитикийн шинэ нөхцөл байдалтай нийцүүлэн гүнзгийрүүлэх нэг гол арга зам байх нь тодорхой байна..

**Зургаа**. Батлан хамгаалах бодлогын үндсийн тухайд бол, с¿¿ëèéí æèë¿¿äýä, çýâñýãò õ¿÷íèéã äàéí, çýâñýãò ìºðãºëäººíèéã ñýðýìæëýí çàéëóóëàõ, улс орны геополитикийн аюулгүй байдлыг хангах, îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ áîëîí áóñàä ¿éë àæèëëàãààíä àøèãëàõ, îëîí óëñûí òåððîðèçìòîé òýìöýõ, áàéãàëûí ãàìøèã áîëîí áóñàä îíöãîé íºõöºëä àðä èðãýäèéí àìü íàñ, íèéãìèéí õºðºíãèéã õàìãààëàõ,  õîð õîõèðîëûã àðèëãàõ, ñýðãýýí áîñãîõ, çàëóó ¿åèéã çîðèã òýñâýð, ýõ îðîí÷ ¿çýëä ñóðãàõ çýðýãò õýðýãëýõ àñóóäëóóä ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëûí öýðýã-ñòðàòåãèéí àãóóëãàä òîãòîðõîé áàéð ýçëýõ болжээ. Үүнтэй уялдаатайгаар Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийг өнөөгийн геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан тодотгох, улмаар Батлан хамгаалах тухай болон Зэвсэгт хүчний тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, түүнчлэн төрийн батлан хамгаалах  бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй уялдан үүсэж буй зарим шинэ харилцааг зохицуулах зорилго бүхий бусад хууль, тогтоомжийг шинээр боловсруулах нь энэ салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэх үндсэн чиглэл байх ёстой байна.

## VI. СУУРЬ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУДЫН БИЕЛЭЛТ,  ҮР ДҮНГИЙН ТАЛААР.

**Нэг.** Энэхүү төслийн хүрээнд хэрэгжүүлсэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй  геополитикийн хүчин зүйлсийн судалгаанаас үзэхэд, дэлхий ертөнц илүү энгийн, элдэв зөрчил сөргөлдөөнгүй, аюул багатай болох нь ирээдүй цагийн асуудал хэвээр байна. Зарим нэг их гүрэн, тухайлбал АНУ, ОХУ болон Европын холбоо зэргийн олон улсын улс төр, цэрэг-стратегийн чухал асуудлуудыг шийдвэрлэхэд үзүүлэх нөлөөлөл тодорхой хэмжээгээр суларсныг ашиглан шинээр хүчирхэгжиж буй өөр бусад зарим орны, түүний дотор Хятад, Энэтхэг, Турк гэх мэтийн зүгээс тэдгээрийн эзэмшиж байсан геополитикийн орон зайн зарим хэсгийг эзлэх гэсэн эрмэлзэл гарах болсон нь манай мэтийн бага орны үндэсний ашиг сонирхолд аюул учруулах гаднаас шинэ аюул занал үүсэх, хуучин аюул занал өөр хэлбэрээр  эргэж ирэх бодит үндсийг бий болгож байна.

Үүний зэрэгцээ, геополитикийн үүдэл сэдэлтэй зарим эрсдэл сорилтын улмаас улс төр, нийгэм, эдийн засгийн салбар дахь манай хөгжлийн бодлого тогтвортой бус байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болох дотоодын хүчин зүйлсийг чиг үүсгэх болсон байна.

Гэтэл суурь судалгааны төслийн явцад геополитикийн шинэ нөхцөл байдлыг харгалзсан үндэсний аюулгүй байдлын дүн шинжилгээ манай улс төр, эдийн засаг, нийгэм, цэрэг-стратегийн судалгаанд зохих тусгалаа одоогоор төдийлөн олоогүй байгаа нь олон зүйл дээр харагдсан болно.

Ийм учраас аюулгүй байдал, геоолитик судлалын суурь судалгааны энэ төслийг хэрэгжүүлэхдээ:

- Өнөө үеийн олон улсын нөхцөл байдлын өөрчлөлтийг аюулгүй байдал, геополитик судлалын байр сууринаас тусгайлан авч үзэж үнэлэлт дүгнэлт өгөн, геополитик судлалын хөгжлийн өнөөгийн байдал, том гүрнүүдийн манай орны тухайд явуулж буй геостратегийн бодлоготой уялдаатайгаар манай орны эргэн тойронд бий болсон шинэ нөхцөл байдал, үүний мөн чанар, учир шалтгааныг нээн илрүүлэх, Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг судлан тодорхойлох;

- Бий болсон геополитикийн  шинэ нөхцөл байдлыг судлан тооцох үндсэн дээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын, түүний дотор гадаад харилцаа батлан хамгаалах салбарын бодлогын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх; цаашид эдгээр бодлогыг хэрэгжүүлэхдээ геополитикийн шинэ хүчин зүйлсийг заавал харгалзаж байх шаардлага, үндэслэлийг судлан боловсруулах;

- Үндэсний аюулгүй байдлын бодлого, гадаад бодлого болон батлан хамгаалах салбарын гадаад харилцааг хөгжүүлэхэд тулгарч буй тулгамдсан чухал асуудлуудын мөн чанар, учир шалтгааныг судлан тодорхойлох, энэ үндсэн дээр төрөөс геополитикийн салбарт баримтлах бодлогын үндсийг тусгайлан боловсруулах;

- Үндэсний аюулгүй байдлын нэгдсэн тогтолцоо, түүний дотор дипломат алба, зэвсэгт хүчин, цаашилбал цэргийн байгууллыг болон хууль сахиулах тогтолцоог бүхэлд нь геополитикийн шинэ хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан өөрчлөн шинэчлэх шаардлага, үндэслэлийг бий болгоход чиглэсэн зарим санал

зөвлөмжийг боловсруулах зэрэг асуудлуудад гол анхаарлаа хандуулан тавьсан зорилго, зорилтуудаа амжилттай шийдвэрлэлээ.

**Хоёр. Суурь судалгааны үр дүн.**

1. Олон улсын харилцаанд гарч буй эрс өөрчлөлт, Монгол Улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдлын улмаас үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлсийг судлан тодорхойлж, тулгамдсан чухал асуудлуудыг нээн илрүүлж, улмаар манай оронд учирч болзошгүй геополитикийн үүдэл сэдэл бүхий аюулын тухай шинэ төсөөллийг боловсруулан, эдгээрээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах зорилго бүхий шинжлэх ухааны үндэслэлтэй арга замыг судлан тодорхойлж **“Геополитикийн шинэ нөхцөл байдал ба үндэсний аюулгүй байдал” сэдэвт нэгдсэн тайланг** анх удаа нэгтгэн боловсруулсан нь энэхүү суурь судалгааны төслийн гол үр дүн болно.

2. Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдал, улам бүр өсөн нэмэгдэж буй Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдолтой уялдуулан “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийн хувилбарыг боловсрууллаа.

3. Шинээр боловсруулсан“Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичигтэйгээ нийцүүлэн **“Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдэд тодотгол хийх санал** зэргийг мөн анх удаа цэгцлэн боловсрууллаа.

## VII. САНАЛ ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗҮЙН ТАЛААР.

**Нэг.** Энэхүү суурь судалгааны төсөлд онолын дүн шинжилгээний агуулга, үр дүн болон асуудал тус бүрээр гаргасан нэгдсэн дүгнэлтэд тулгуурлан онол, практикийн шинж чанартай тодорхой санал зөвлөмжүүдийг боловсруулсан болно.

Онол-арга зүйн талаас нь авч үзвэл, үндэсний аюулгүй байдлын бүх төрөл зүйлийн онол, практикийн судалгаанд геополитикийн олон янзын үүдэл сэдэл бүхий хүчин зүйлсийн нөлөөллийг заавал харгалзаж байхыг санал болгож байгаа нь эдгээр зөвлөмжийг хэрэгжүүлэх арга зүйн үндэс болох учиртай болно.

**Хоёр.** Суурь судалгааны төслийн үр дүнгээр боловсруулсан санал, зөвлөмжийг амьдралд хэрэгжүүлэхдээ эдгээрийг дараах байдлаар бүлэглэн авч үзэх нь зөв байж болох юм. Үүнд:

Нэгдүгээр бүлэг - геополитикийн төрөл бүрийн хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан үндэсний аюулгүй байдлын бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг боловсронгуй болгох үүднээс Монгол Улсын гүйцэтгэх болон хууль тогтоох засаглалын байгууллагуудын авч үзэж болох санал зөвлөмжүүд. Тухайлбал, бидний явуулсан суурь судалгаанаас үзэхэд, геополитикийн төрөл бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг харгалзан бий болсон нөхцөл байдалд үнэлгээ өгөх болон үндэсний аюулгүй байдалд учрах магадлал бүхий аюул заналаас цаг тухайд нь урьдчилан сэргийлэх зорилгоор болзошгүй эрсдэл сорилтыг таамаглахад Монгол Улсын ҮАБЗ-ийн зохицуулагчийн үүргийг нэмэгдүүлэх шаардлага, үндэслэлийг тусгасан санал, зөвлөмжүүд энд голлох ёстой юм.

Цаашилбал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох геополитикийн хүчин зүйлсийг үүсэн бий болох эхний үе шатанд нь илрүүлэхийн ач холбогдлыг төрийн удирдлагын түвшинд ойлгох нь чухал болоход хамаарах санал зөвлөмжүүдийг боловсрууллаа. Эдгээрийн дотор, үндэсний аюулгүй байдлын салбарт гаргах шийдвэрийг дэмжих мэдээлэл-дүн шинжилгээний тусгайлсан тогтолцоо бий болгох асуудал ихээхэн чухал санал болох ёстой юм .

Түүнчлэн, дэлхийн янз бүрийн бүс нутагт буй манай стратегийн түншүүдийн Монгол Улсын тухайд хэрэгжүүлж буй геостратегийн бодлогын мөн чанар, учир шалтгаан, цаад зорилгыг нь шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлох боломжийг бүрдүүлэх, мөн тодорхой улс орон, бүс нутгийг чиглэсэн бодлогоо юуны өмнө үндэсний ашиг сонирхлын тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй геополитикийн үүдэл сэдэл бүхий хүчин зүйлстэй уялдуулан явуулж байхыг санал болгосон зөвлөмжүүдийг боловсруулсан болно.

Хоёрдугаар бүлэг санал зөвлөмж нь энэхүү суурь судалгааны төслийн үр дүнг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад, ҮАБЗ-ийн ажлын алба, Шинжлэх ухааны академи, ГХЯ, БХЯ болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бусад байгууллага, түүнчлэн хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг өөрчлөн шинэчилж үр дүнг нь нэмэгдүүлэх зорилгоор практик дээр ашиглах боломжтой арга хэмжээнүүдэд хамаарч байгаа

юм. Ингэхдээ юуны өмнө, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдэд шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдлыг тооцсон зарим өөрчлөлт оруулах шаардлагатай байгааг зөвлөмж болголоо.

Жишээлбэл, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн “Батлан хамгаалах бодлогын улс төрийн чиглэл” хэмээх Гуравдугаар хэсэгт цэрэг-улс төрийн нөхцөл байдалд сөрөг нөлөө үзүүлэгч үндсэн хүчин зүйлүүдийг дурдсан байгаа. Гэсэн хэдий ч тэдгээрийн агуулга нь дэлхий болон улс оронд өнөөдөр бүрэлдээд байгаа орчин үеийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тусган харуулахгүй байгаа юм. Тухайлбал, энэ цэрэг-улс төрийн байдалд эдийн засаг, хүн ам зүй, шашин, экологийн зэрэг геополитикийн бусад хүчин зүйлийн үзүүлж буй нөлөөг тухайн хэсэгт тусгаагүй бөгөөд эдгээр хүчин зүйлсийг бүрдүүлэгч олон элемент үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдэг болохыг орхигдуулсан байгаа юм. Иймээс энэ баримт бичигт геополитикийн хүчин зүйлсийг тусгасан тусгайлсан чиглэлийг боловсруулан оруулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Ер нь, үндэсний аюулгүй байдлын нэгдсэн тогтолцооны (улс төр, эдийн засаг, нийгэм, байгаль орчин, шинжлэх ухаан, шашин, хүн ам зүйн гэх мэт) талаарх суурь мэдээлэлд тулгуурлалгүйгээр орчин үеийн батлан хамгаалах бодлогыг боловсруулах боломжгүй юм. Тухайлбал, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-т тусгагдсан манай орны эсрэг түрэмгийлэл үйлдэх зарим боломж бодитой бөгөөд тодорхой нөхцөл байдалд Монгол Улсын эсрэг дайсан гарч ирэх магадлал боломжтой гэсэн агуулга бүхий үзэл санааг манай орны эргэн тойронд бий болсон  геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан илүү тодорхой болгох залшгүй шаардлага байгаа жишээтэй юм.

Гуравдах бүлэг санал зөвлөмж нь судалгааны материалуудыг ШУА-ын холбогдох хүрээлэнгүүд, олон улсын харилцаа, цэргийн болон хүчний бусад байгууллагын их дээд сургуулиудад ашиглахад зориулагдсан болно. Тухайлбал, эдгэр сургуулийн ерөнхий улс төр, олон улс судлал болон аюулгүй байдал судлалын сургалтын төлөвлөгөөнд “Орчин үеийн геополитикийн үндэс” нэртэй байж болох хичээлийг нэмж оруулан, түүндээ геополитикийн тухай үндсэн ойлголт, ухагдахуун, судлах зүйл, арга зүй болон үндэсний аюулгүй байдлыг хангах

бодлого, үйл ажиллагаанд геополитикийн хүчин зүйлсийг харгалзах арга механизмтай холбогдол бүхий асуудлуудыг оруулах нь зүйтэй юм. Түүгээр ч үл барам, Монгол Улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдлыг хэрхэн зөвөөр ухаж ойлгох, түүний хүчин зүйлсийг үндэсний аюулгүй байдлын салбар тус бүрд харгалзах асуудлуудаар тусгайлсан сэдвүүдийг боловсруулах нь чухал байж болох юм.

Энэхүү суурь судалгааны үр дүнд тулгуурдан боловсруулсан дүгнэлт, практик зөвлөмжүүд нь маргаангүй, төгс зүйл биш ч гэсэн төр, нийгмийн байгууллагууд, олон улсын харилцаа, цэргийн болон хүчний бусад байгууллагын сургуулиудын сургалт, эрдэм шинжилгээний ажилд тэдгээрийг харгалзах нь үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, мөн холбогдох бүтцүүдийн боловсон хүчнийг бэлтгэх үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд тодорхой хэмжээгээр тус дөхөм болно гэж үзлээ.

**Гурав.** Санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг арга зүйн өндөр түвшинд гүйцэтгэхийн тулд эхлээд доорх асуудлуудыг шийдвэрлэх нь зүйтэй юм. Үүнд:

- геополитикийн хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан үндэсний аюулгүй байдлын тогтолцооны онолын цогц загварыг боловсруулах;

- геополитик судлал бол үндэсний аюулгүй байдлыг өөрийн судалгааны объект, харин үндэсний ашиг сонирхлын мөн чанар, агуулга, түүнийг хадгалан хамгаалахын тулд хэрэгжүүлэх бодлогын арга механизмыг өөрийн судлах зүйлээ болгосон улс төрийн шинжлэх ухааны нэг салбар гэсэн ойлголт дээр үндэслэн Монгол Улсад энэ судалгааны өөрийн гэсэн арга зүйг бий болгох;

- улс төр, аюулгүй байдал судлалын өвөрмөц арга болох геополитикийн дүн шинжилгээний аргыг үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд нөлөөлж буй гадаад% дотоод үүдэл бүхий геополитикийн хүчин зүйлсийн судалгаанд аль болох өргөн, гэхдээ тодорхой үр дүнтэй ашиглах бололцоог бүрдүүлэх;

- үндэсний аюулгүй байдлын тогтолцоонд геополитикийн хүчин зүйлсийн үзүүлж буй сөрөг нөлөөг тогтоох, урьдчилан сэргийлэх асуудлаар төр засаг болон иргэний нийгмийн хамтран ажиллах хамгийн оновчтой арга хэлбэрийг олж тогтоох;

- улс орны үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох геополитикийн үүдэл сэдэл бүхий хүчин зүйлсийг саармагжуулахад Зэвсэгт хүчин, цэргийн байгууллын бусад байгуулага болон хууль сахиулах байгууллагуудын оролцооны асуудлыг геополитик судлалд тусгай салбар болгон судлах, үр дүнг нь эдгээрийг хөгжүүлэн бэхжүүлэх, зарим тохиолдолд өөрчлөн байгуулахад ашиглах.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


1. Francis Fukuyama. The End of History and The Last Man.NY: Free Press,1992
2. Timothy Stanley and Alexander Lee. It's Still Not The End of History// "The Atlantic"Sep,1.2014 http://www.theatlantic.com/politics/archive/2014/09/its-still-not-the-end-of-history-francis-fukuyama/379394/
3. Eliane Glaser. Bring Back Ideology: Fukuyama's 'end of history' 25 years on// "The Guardian" March,21.2014
4. https://www.theguardian.com/books/2014/mar/21/bring-back-ideology-fukuyama-end-history-25-years-on
5. Current Debates in International Relations. Ed. by Eric B.Shiraev and Vladislav M.Zubok. Oxford University Press,2015
6. Современная мировая политика. Прикладной анализ. Под ред А.Д. Богатурова. . М., 2009.
7. Хелд Д., и др. Глобальные трансформации. Политика, экономика и культура. Пер. с англ. М., 2004.
8. К.С.Гаджиев. Геополитические горизонты России:Контуры нового мирового порядка. Изд,Экономика. Москва., 2007
9. Мир после кризиса. Глобальные тенденции – 2025: меняющийся мир. Доклад Национального разведывательного совета США. Пер. с англ. М., 2009.
10. U.S. Census Bureau. Percent of the Projected Population by Race and Hispanic Origin for the United States: 2010 to 2050 (NP 2008-T6). August 14, 2008.
11. Баталов Э., Как развивается глобальный мир. Международные процессы.Том 10, Январь-Апрель 2012
12. Барановский В., Новое в мирополитической системе. Международные процессы. Том 8, ЯнварьАпрель 2010
13. Huntington S. Why International Primacy Matters //International Security. 1993. Spring. Vol.17. № 4.
14. William I.Robinson.Gloabalization, the World System, and "Democracy Promotion" in U.S. Foreign Policy // Theory and Society, Vol.25,no.5(Oct.1996), pp.615-665
15. Alexandra de Hoop Scheffer, Rory Kinane, Martin Quencez, Xenia Wickett. The Future of US Global Leadership Implications for Europe, Canada and Transatlantic Cooperation// The German Marshall Fund of the United States. May 2016
16. Dmitry Suslov.US Global Leadership Dilemma as a Challenge for the US- Russia relations // National Research University Higher School of Economics. WP BRP 03/IR/2013
17. Frances Mautner-Markhof. Order and Chaos in the 21st Century. Do We Need a New Standpoint for Seeing and Judging Events"? // Studien und Berichte zur Sicherheitspolitik 1/2004
18. Кузык Б.Н. , Яковец Ю.В. Цивилизации: теория, история, диалог, будущее. В двух томах. Том II. Будущее цивилизаций и геоцивилизационные измерения. М., 2006.

19. Elimma C. Ezeani. The 21st Century Terrorist: Hostis Humani Generis?// Beijing Law Review, 2012, no3, pp.158-169
20. Boaz Ganor. Terrorism in the Twenty-First Century// S.C. Shapira et al. (eds.), Essentials of Terror Medicine, Springer,2009,pp.13-26
21. Peter R. Neumann. Terrorism in the 21st century .The rule of law as a guideline for German policy // Compass 2020. Germany in international relations: Aims, instruments, prospects, May 2008
22. Бертран Бади. Конец истории отменяется. Международные процессы. Том 14. Апрель-Июнь 2016
23. Пантин В.И., Лапкин В.В. Философия исторического прогнозирования: ритмы истории и дерспективы мирового развития в первой половине XXI века . Дубна “Феникс”,2006.
24. К.С.Гаджиев. Геополитические горизонты России:Контуры нового мирового порядка. Изд,Экономика. Москва., 2007
25. Central Asian Regional Economic Cooperation, 3rd CAREC- Federation of Carrier and Forwarder Associations (CFCFA) Annual Meeting, Day 1, presentation by I.Segal.
26. Fu Mengzi, Strategic Concept on Constructing One Belt One Road, Mongolian Journal of Strategic, №67 (3/2014)
27. Н.Соёлгэрэл, СХХ, Евразийн бүс дэх эдийн засгийн хамтын ажиллагаа: МУ-ын оролцох боломж, Евразийн геополитик ба Монгол Улс сэдэв ЭШБХ” товхимол, 2016, х 9
28. Meena Singh Roy, International North-South Transport Corridor: Re-energizing India`s Gateway to Eurasia,
29. http://www.indiawrites.org/diplomacy/international-north-south-transport-corridor-re-energising-indias-gateway-to-eurasia/
30. Рашид Алимов. Шанхайская организация сотрудничества. Становление, развитие,перспективы. Изд-во “Весь мир”. Москва, 2017
31. Trump’s National Security Strategy. a Timely Counter to China’s Expansionism by Don Tse & Larry Ong, January 04, 2018
32. Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) дахь Монгол Улсын цаашдын оролцоо. МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль. УБ,2017
33. NATO, The Partnership for Peace programme,http://www.nato.int/cps/en/natolive/topics_50349.htm
34. Д.Баярхүү. Евразийн геополитик...
35. З.Бжезинский. Великая шахматная доска.”Международные отношения”. Москва, 2002
36. Б.Хөгжилт. Монгол Улсын геополитик, геоэдийн засгийн байр суурийн тухай шинжилгээ. МУИС-ОУХНУС. Олон улсын харилцаа сэтгүүл. 2016 №1/32 (458)
37. Mei-hua lan, Associate-professor, National Chengchi University, Taiwan. /XX зуны Монгол... /
38. В.В.Грайворонский. Концепция внешней политики Монголии в действии: отношения с Россией, КНР, США и Японией. /XX зууны Монгол... н. 231 /

39. Процесс принятия внешнеполитических решений в малых государствах / на примере Монголии/”. Москва, Научная книга. 1999г
40. Karl W.Deutsch. The Analyses of International Relations. Engelwood Cliffs. Prentice-Hall, 1968
41. R.F.Barston (ed.). The Other Powers: Studies in the Foreign Policies of Small States. London, Allen and Unvin., 1971
42. ГХЯ.Дипломатын академи. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын 20 жил.УБ.,2014
43. Hans J.Morgenthau. Politics among Nations: The Struggle for Power and Peace.5th edition, NY.,1972
44. Гадаад харилцааны төв архив. ГХЯ
45. МУ-ын гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм. 1911-2011. Улаанбаатар 2011
46. Ц.Батбаяр “Олноо өргөгдсөн Монгол улсын гадаад харилцаа”
47. Т.Төмөрхүлэг. “Монголын асуудал Орос, Хятадтай учир холбогдсон нь”. УБ., 2014
48. Х.Олзвой. “ОУХ дахь гуравдахь түншлэлийн зарим асуудал”. МУ-ын үндэсний аюулгүй байдал ба гуравдахь түнш орнууд: өнөө, ирээдүй. УБ.,2002
49. Д.Уламбаяр.Монгол Улсын “гуравдагч хөршийн” бодлого:Онолын баримтлал, түүх, орчин үеийн зангилаа асуудалд. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.УБ.,2014
50. Б.Батхишиг “Арван хоёр жил Элчин сайд”. УБ.,2017
51. Д.Ганбат. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, анхаарах зарим асуудал. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ.УБ.,2014
52. И.А. Новиков. Стратегическое партнерство как феномен международной политики. Вестн. Волгогр. гос. ун-та. Сер. 4, Ист. 2010. № 1 (17)
53. Б.Батхишиг “Арван хоёр жил Элчин сайд”. УБ.,2017
54. Гадаад харилцааны төв архив. ГХЯ
55. PAX MONGOLICA” :Монгол энх төр. Vol.4 2018 №1 (9) 13.Sharad K.Soni. The geopolitical dilemma of small states in external relations: Mongolia’s tryst with “immediate” and “third” neighbours. /XX зууны Монгол... /
56. Mei-hua lan, Associate-professor, National Chengchi University, Taiwan. /XX зуны Монгол...
57. Б.Баасансүрэн. Орос, Хятадын завсар дахь Монгол Улс. Их эрсдэл сорилтууд, эвтэй боломжууд. УБ 2014/
58. Б.Баасансүрэн. Орос, Хятадын завсар дахь Монгол Улс. Их эрсдэл сорилтууд, эвтэй боломжууд. УБ 2014
59. В.В.Грайворонский. Концепция внешней политики Монголии в действии: отношения с Россией, КНР, США и Японией. /XX зууны Монгол... н. 231 /
60. В.Родионов. “Третий сосед” Монголии: фактор идеологии. /XX зууны Монгол... /
61. Н.Доржсүрэн. МУ хэрхэн ЗХА-ийн уламжлалт аюулгүй байдлын хамтын ажиллагааны нэг хэсэг болох вэ. Стратегийн судалгаа №71 (3/2015)
62. Ж.Энхсайхан., Монголын цөмийн ирээдүй... УБ, 2015

63. Ж.Энхсайхан.,МУ-ын цөмийн зэвсгээс ангид статусын баталгаажуулалт, түүний олон улсын ач холбогдол. Монгол Улсын ҮАБ-ын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ, 2014
64. Enkhsaikhan J., Establishing a NEA-NWFZ: an idea whose time has come? UB dialogue on NEA Security. International conference. UB, September 2014
65. Ж.Энхсайхан.,МУ-ын цөмийн зэвсгээс ангид статусын баталгаажуулалт, түүний олон улсын ач холбогдол. Монгол Улсын ҮАБ-ын гадаад, дотоод орчны судалгаа, дүн шинжилгээ. УБ, 2014
66. Д.Мягмар. ,ЦЗҮД гэрээ ба МУ-ын цөмийн зэвсгээс ангид статус. Геополитик судлал №1.2016
67. Enkhsaikhan J., Establishing a NEA-NWFZ: an idea whose time has come? UB dialogue on NEA Security. International conference. UB, September 2014
68. Ж.Бор. Дэлхийн дипломатын нэвтэрхий толь бичиг. УБ, 2018
69. P.5 - "American interests and UN reform" report of the Task force on United Nations – United States Institute of Peace, Washington D.C., 2006
70. ГХЯ. Монгол Улсын гадаад харилцааны зуун жилийн түүхийн тойм.1911-2011. УБ, 2011
71. МУ-ын гадаад бодлогын хөх ном – 2016. Гадаад харилцааны яам. УБ, 2017
72. Mendee Jargalsaikhan & Thomas Bruneau, "Discovering Peacekeeping as a New Mission: Mongolia," in T. Bruneau and F. Matei (eds.,) *The Routledge Handbook of Civil-Military Relations* (Routledge, 2012), pp.204-218.
73. Mendee Jargalsaikhan & Thomas Bruneau, "Discovering Peacekeeping as a New Mission: Mongolia," in T. Bruneau and F. Matei (eds.,) *The Routledge Handbook of Civil-Military Relations* (Routledge, 2012), pp.204-218.
74. Mendee Jargalsaikhan, "Asymmetrical Military Socialization – Mongolia as a Case Study," *Armed Forces & Society Journal*, 39:2 (April, 2013), 305-330.
75. Mendee Jargalsaikhan, "Military Training Assistance Program (MTAP): Merging Interests of Canada and Mongolia," *Canadian Military Journal,* No.1 (2009), 30-38.
76. Mendee Jargalsaikhan & David Last, "Whole of Government Responses in Mongolia: From Domestic Response to International Implication," *The Pearson Papers,* 11:2 (2008), 1-22.
77. Mendee Jargalsaikhan, "Mongolia's Peacekeeping Commitment," *Discussion Paper,* National Defense Intelligence College, May 2007.
78. Ariunbold Dashjivaa, *Why has Mongolia Chosen to Participate in Peace Support Operations* (MA Thesis), Monterey, CA: Naval Postgraduate School, 2013). /

# НОМ ЗҮЙ


## Олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм. 1945 он
2. НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын дүрэм. 1945 он
3. Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1948 он
4. Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай. 1972 он
5. Соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц. 1972 он
6. Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм: 1998 он
7. Терроризмыг санхүүжүүлэхийг хориглох тухай олон улсын конвенц. 1999 он
8. Авлигын эсрэг НҮБ-ын конвенц. 2003 он

## Хууль тогтоомж

1. Монгол улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он
3. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он
4. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль. 1992 он
5. Монгол улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. 2011 он
6. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. 2015 он
7. Гамшгаас хамгаалах тухай хууль, УИХ-ын тогтоол. 2017 он.
8. Тагнуулын байгууллагын тухай хууль. 2015 он.
9. Хилийн тухай хууль, УИХ-ын тогтоол. 2016 он.
10. Цагдаагийн байгууллагын тухай хууль. 2017 он.
11. Дотоодын цэргийн тухай хууль. 2017 он.
12. Онц байдлын тухай хууль. 1995 он.
13. Дайн бүхий байдлын тухай хууль. 1998 он.
14. Дайны тухай хууль. 1998 он.
15. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал. 2017 он.
16. “Алсын хараа 2050” хөтөлбөр. Засгийн газар, УБ хот, 2020 он.

## Монгол хэл дээрх ном, бүтээл

1. Ч.Улаанхүү. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. УБ.2014 он
2. З.Болдбаатар. Хөрш орнуудын цэргийн бодлого. УБ. 2004 он
3. А.Түвшинтөгс. Хүйтэн дайны дараах Монголын аюулгүй байдлын гадаад орчин. УБ. 2012 он.
4. Т.Намсрай, З.Болдбаатар, А.Сүхбаатар “Геополитикийн үндэс”. УБ.2008 он
5. Монгол Улсын Батлан хамгаалахын цагаан ном БХЯ, 1998, 2003 он
6. Монгол Улсын Гадаад бодлогын хөх ном ГХЯ 2007-2011
7. Стратеги судлал сэтгүүл. ССХ. УБ. 2006-2016
8. Геополитик судлал. ГПСХ. УБ. 2010-2019

## Ном, зохиол, нэг сэдэвт бүтээл

1. Н. Алтанцэцэг- “БНХАУ-ын гадаад бодлого” УБ. 2012 он
2. М. Батчимэг- “Шатрын өрөг дэх Монгол Улс” УБ, 2012.
3. Ж.Баясах- “Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал ( Түүвэр зохиол)” УБ . 2010.
4. Жөн Илжүнь, Ж. Баттөр- “Солонгосын орчин үеийн улс төрийн түүх” Сөүл, 2013

5. Х.Киссинжер- “Дипломат үйл ажил.” Орчуулсан Д. Чулуундорж. УБ. 2012.
6. Б. Лхагваа- “Нэгдсэн Солонгос айсуй” УБ. 2015 он.
7. Г.Төмөрчулуун- “Даяар Ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа.” УБ. 2009 он
8. А. Түвшинтөгс- “Хүйтэн дайны дараах Монголын аюулгүй байдлын гадаад орчин (Судалгааны бүтээлийн түүвэр)” УБ,. 2012.
9. Үндэсний Тагнуулын Академи - “Жижиг улсын аюулгүй байдал өнөө, ирээдүй”, УБ, 2010
10. Ж. Энхсайхан- “Монголын цөмийн ирээдүй” УБ, 2015.

**Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, тайлан**

1. Стратеги судлал сэтгүүл. ССХ. УБ. 2006-2016
2. Геополитик судлал. ГПСХ. УБ. 2010-2019
3. Аюулгүй байдал, Батлан хамгаалах судлал сэтгүүл. БХЭШХ. УБ.2015-2019
4. “Монгол Улсын Гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал” ГХЯ Дипломат Академи. УБ, 2014.
5. МУИС ОУХНУС “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2019
6. Олон Улс Судлал сэтгүүл. ОУСХ. УБ, 2010-2019
7. “2019 оны дэлхийн цэргийн тэнцвэрийн тооцоо” ССХ. Лондон. 2019.
8. “2015 оны мэдээллийн тайлан”, Стокгольм. Стокгольмын Олон Улсын Энх тайван судлалын хүрээлэн. 2015- 2019
9. “Олон Улсын эрчим хүчний статистикийн оны эмхэтгэл”.Энэрдата. 2019

**Өгүүлэл, нийтлэл, илтгэл**

1. Н. Ариунгуа- “Монгол Улсын гадаад орчны ойрын хүрээлэл ба БНХАУ” Олон Улс Судлал 2010/3,4. УБ, 2010. 15-р тал
2. Ж. Баттөр- “Зүүн Азийн орнуудын зөрчил, маргаан: сорилтууд ба боломжууд” “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2011. 173-р тал
3. Ж. Баясах- “Азийн аюулгүй байдал” “Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал (түүвэр зохиол)” УБ, 2010. 87-р тал
4. Ж. Баясах- “БНХАУ-ын гадаад бодлогын хувьсал” “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2011. 71-р тал.
5. Б. Даваадорж- “Ази, Номхон далайн бүс нутаг дахь аюулгүй байдлыг хангах механизмын төлөв байдал.” Аюулгүй байдал, Батлан хамгаалах судлал сэтгүүл. 2010/ 14
6. Х. Сайхансанаа, Д. Даш- “Хүйтэн дайны дараах Монгол Улсын гадаад харилцааны бодлого ба олон тулгуурт гадаад харилцааны бодлого” Олон Улс Судлал 2012/2. УБ,2012
7. Г.Төмөрчулуун- “Дөрвөн “Де”-гийн чиг шугам” илтгэл, ГХЯ Дипломат Академи-“Монгол Улсын Гадаад бодлогын анхны үзэл баримтлал батлагдсаны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын материал” УБ, 2014. 19-р тал
8. А. Түвшинтөгс- “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын тойм.” Стратегийн судалгаа сэтгүүл 2005.3

9. А. Түвшинтөгс- “Зүүн Хойд Азид аюулгүй байдлын олон талт механизм бүрэлдэх боломж ба Монгол Улс” Олон Улсын харилцаа сэтгүүл 2004-2, УБ., 2004. 19-р тал
10. А. Түвшинтөгс- “Зүүн Хойд Азид Цөмийн зэвсэггүй бүс байгуулах асуудал ба Монгол Улс” Мэргэжлийн зэвсэгт хүчин 2007/2, УБ, 2007. 15-р тал
11. Д, Цолмон- “Барак Обама: АНУ-ын гадаад бодлогын шинэ чиглэл” “Орчин үеийн олон улсын харилцааны шинэ чиг хандлага ба Монгол улс” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ. 2011. 82-р тал.

**Гадаад хэл дээрх ном бүтээл**

Ном, товхимол

1. David Christian. A History of Russia, Central Asia and Mongolia, Volume II: Inner Eurasia from the Mongol Empire to Today, 1260 – 2000. Wiley-Blackwell. 2018.
2. Asian Strategic Review 2014.-2019. The National Institute for Defense Studies Japan
3. International Strategic Situation and China’s National Security 2011/2012. Institute for Strategic Studies, National Defense University, PLA
4. Збигнев Бжезинский. Великая шахматная доска. Господство Америки и его стратегические императивы. АСТ. Москва. 2017.
5. В Карпов В.И., Павлов Д.Б.. Основы теории обеспечения безопасности личности, обшества и государства. М., 2000

Хууль тогтоомж, эрх зүйн баримт бичиг

1. “Treaty on the Non-Proliferation of Nuclear Weapons” NY, 1968.
2. ROK, PRC, Japan- “Joint Declaration on Northeast Asian peace and cooperation” Seoul, 2015.11.01

Нэг сэдэвт бүтээл

1. T.V.Paul, James J. Wirtz, Michael Fortman- “Balance of Power: Theory and Practice in the 21st century.” Станфорд. 2004.
2. Kent Calder, Min Ye- “The Making of Northeast Asia (Studies in Asian Security)” Станфорд. 2010
3. Tae Han Kwak, Edward A. Olsen- “The Major Powers of Northeast Asia seeking Peace and Security” Колорадо, 1996.
4. S. Walt- “The Origins of Alliance”. Нью-Йорк. 1990.

Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл, тайлан

1. Ministry of Foreign Affairs of Republic of Korea- “Northeast Asia Peace and Cooperation Initiative- 2015” Сөүл, 2015.
2. The Mongolian Journal of International affairs 2012, УБ, 2012,
3. “The Mongolian Journal of International Affairs” Vol 19, 2014.
4. The Mongolian Journal Of Geopolitical Studies, 2014/2. UB, 2014,

Өгүүлэл, нийтлэл, илтгэл

1. J. Bayasakh- “Mongolia’s view on the security of the Korean Peninsula” “Гадаад бодлого хийгээд аюулгүй байдал (түүвэр зохиол)” УБ, 2010

2. Elliott School of International Affairs, The George Washington University- “Balancing Acts: The U.S. Rebalance and Asia-Pacific Stability” 2011.08
3. Kawasaki- “Northeast Asia Nuclear-Weapon-Free Zone- Necessity and Challenges” The Mongolian Journal of International affairs 2012, УБ, 2012, 88-р тал
4. D.Munkh-Ochir- “Mongolia’s Third Neighbor Doctrine and North Korea’ The Mongolian Journal Of Geopolitical Studies, 2014/2. UB, 2014, 34-р тал
5. B.Obama- “Speech before the Australian parliament” (www.m.state.gov) 2011.11.07
6. Marcin A. Piotrowski- “Russia’s Security Policy”
7. Stephen Ranger, Yang Gyu Kim- “The Balance of Power in a Complex Northeast Asia” (http://www.isn.ethz.ch) 2012.06.12
8. S.Soni- “Russian Policy towards Northeast Asia: The Mongolia Factor” “Mongolian Journal of International Affairs” Vol 19, 2014. 34-р тал
9. Yun Sun- “China-Russia relations: Alignment without alliance” (http://csis.org/) 2015.10.07
10. Kenneth Waltz- “The Emerging Structure of International Politics.” 2005

Цахим эх сурвалж

1. www.csis.org
2. www.isn.ethz.ch
3. www.m.state.gov
4. www.nytimes.com
5. www.un.org
6. www.understanrussia.com
7. www.english.vovnews.vn

Улсын бүртгэлийн дугаар Нууцын зэрэглэл А
Код

## ГЕОПОЛИТИК СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# ГЕОПОЛИТИКИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Суурь судалгааны төслийн тайлан
2017-2019

**II БОТЬ**
**(**Хавсралт)


Төслийн удирдагч Д.Мягмар. Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал. Геополитик судлалын хүрээлэнгийн захирал.



Захиалагч байгууллага БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн бодлогын газар


**Улаанбаатар хот**
**2019 он**

Улсын бүртгэлийн дугаар
Код

Нууцын зэрэглэл А
Гэрээний дугаар ШуСс/2017/03

## ГЕОПОЛИТИК СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# ГЕОПОЛИТИКИЙН ШИНЭ НӨХЦӨЛ БАЙДАЛ БА МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Суурь судалгааны төслийн тайлан
2017-2019

**II БОТЬ**
(Хавсралт)

| | |
|---|---|
| Төслийн удирдагч | Д.Мягмар, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, шинжлэх ухааны доктор, профессор, хошууч генерал, Геополитик судлалын хүрээлэнгийн захирал. |
| Санхүүжүүлэгч байгууллага | Шинжлэх ухаан технологийн сан |
| Захиалагч байгууллага | БСШУСЯ-ны Шинжлэх ухаан технологийн бодлогын газар |
| Тайлан өмчлөгч | Геополитик судлалын хүрээлэн. Улаанбаатар-14210. Энх тайвны гудамж 7а. ГХЯ-ны байр. Өрөө 31. Утас 93138353. 80018142. И-мэйл: igsmongolia@gmail.com |

**Улаанбаатар хот**
**2019 он**

Хавсралт 1

# "ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС" БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ

Суурь судалгааны төслийн үр дүн 2

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД .............................. ТАНАА

УИХ-ын тогтоолын төсөлд санал авах тухай

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Ийм учраас улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсон ”Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” нэртэй баримт бичгийн төслийг цэгцлэн боловсруулах, улмаар үндэсний аюулгүй байдлын салбарын бодлогод хамаарах үндсэн баримт бичгүүдэд тодотгол хийх нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллоо.

Үүнтэй уялдаатайгаар Монгол Улсын Геополитик судлалын хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын баг БСШУСЯ-ны захиалгаар олон улсын харилцаанд гарч буй эрс өөрчлөлт, Монгол Улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдлын улмаас үндэсний аюулгүй байдалд нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлсийг судлан тодорхойлох, тулгамдсан чухал асуудлуудыг нээн

илрүүлэх, улмаар манай оронд учирч болзошгүй геополитикийн үүдэл сэдэл бүхий аюулын тухай шинэ төсөөллийг боловсруулах, эдгээрээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах зорилго бүхий шинжлэх ухааны үндэслэлтэй арга замыг судлан тодорхойлохыг зорилго болгосон суурь судалгааны төсөл хэрэгжүүлсэн болно.

Энэ судалгааны гол үр дүнгээр боловсруулсан санал зөвлөмжид тулгуурлан шинээр бий болсон улс хоорондын харилцааны нөхцөл байдал, улам бүр өсөн нэмэгдэж буй Монгол Улсын олон улсын геополитикийн ач холбогдолтой уялдуулан боловсруулсан “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг батлах болон “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдэдэд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг, холбогдох хавсралтын хамт боловсруулан хүргүүлэв.

Хянан үзэж холбогдох саналаа өгөхийг хүсье.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

БАТЛАВ.
ХУУЛЬ САНААЧЛАГЧ ........................................

## “ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС” БАРИМТ БИЧИГ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос эдгээр хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, үнэлэлт дүгнэлт өгсөн ”Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” нэртэй баримт бичгийн төслийг цэгцлэн боловсруулах, улмаар үүн дээрээ тулгуурлан үндэсний аюулгүй байдлын салбарын бодлогод хамаарах үндсэн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж байна.

Ийм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичиг батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг, уг баримт бичгийн хувилбарыг хавсралт болгон хамт өргөн мэдүүлж байна.

**1.1. Хууль эрх зүйн үндэслэл**

Хууль, эрх зүйн үндэслэлийн хувьд энэхүү тогтоолын төслийг хавсралтын хамтаар Монгол Улсын Үндсэн хуулийн “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэсэн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр, “Төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох” гэсэн 25 дугаар зүйлийн 1-ийн 2 дугаар заалт, “ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль”, Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдийн холбогдох зүйл заалтуудад тулгуурлан боловсруулав.

**1.2. Практик шаардлага**

Практик хэрэгцээ, шаардлагын хувьд энэхүү тогтоолыг хавсралтын хамт батлан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орныг тогтвортой хөгжүүлэх бодлогыг олон улсын аюулгүй байдал, геополитикийн шинээр бий болсон нөхцөл байдалтай уялдуулан явуулах болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдол бүхий заалтууд хэрэгжүүлэх бодит бололцоо бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм.

Түүнчлэн, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг баримт бичгүүдэд олон улсын аюулгүй байдал, геополитикийн шинээр бий болсон нөхцөл байдалд нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлт оруулах нь чухал болоод байна.

**Хоёр. Тогтоолын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу тогтоолын төслийн хавсралтыг буюу “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг:

1. Нийтлэг үндэслэл

2. Геополитикийн үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилт, учирч болзошгүй àþóё занал

3. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэслэгээ

4. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа гэсэн үндсэн бүтэцтэйгээр боловсрууллаа.

Ингэхдээ одоо хүчин төгөлдөр үйлчилж буй үндэсний аюулгүй байдлын салбарт төрөөс баримтлах нэгдсэн бодлогын үндсэн үзэл санаа, зорилго, агуулгыг хөндөлгүйгээр энэ бодлогыг зөвхөн геополитикийн салбарт төрөөс баримтлах чиг баримжаа талаас нь тодорхой болгох зорилго бүхий эрх зүйн зохицуулалтын үндэслэлийг цэгцлэн боловсруулахад гол анхаарлаа хандуулсан болно.

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.**

Энэхүү тогтоол, хавсралтын хамт батлагдсанаар үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого үйл ажиллагааг аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах салбарт хамаарах бусад хууль тогтоомжийн хүрээнд, олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдалтай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх хууль эрх зүйн бодит бололцоо тодорхой хэмжээгээр бүрдэх болно

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**.

Энэхүү тогтоол, түүний хавсралтыг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Хилийн тухай хууль болон Тагнуулын байгууллагын тухай хуулиуд, түүнчлэн олон улсын эрх зүйн холбогдох шаардлага, үндэслэл, энэ чиглэлийн конвенц, гэрээ, хэлэлцээрүүдийн зүйл заалтуудтай чанд нийцүүлэн, ямар нэгэн уялдаа холбоогүй асуудал болон өөр бусад ямар нэгэн нэмэгдэл ачаалал үүсэхгүй байхаар боловсруулав.

“Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг батлах тухай УИХ-ын энэхүү тогтоол, хавсралтын хамт батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн хүндрэл гарахгүй бөгөөд одоо хэрэгжүүлж байгаа аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд зориулагдсан зардлын хүрээнд уг баримт бичгийг хэрэгжүүлэх боломжтой юм.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**“ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС” БАРИМТ БИЧГИЙГ БАТЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

1. Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос эдгээр хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, үнэлэлт дүгнэлт өгсөн ”Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” нэртэй баримт бичгийн төслийг цэгцлэн боловсруулах, улмаар үүн дээрээ тулгуурлан үндэсний аюулгүй байдлын салбарын бодлогод хамаарах үндсэн баримт бичгүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж байна.

Ийм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг батлах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан, уг баримт бичгийн хувилбарын хамт өргөн мэдүүлж байна.

2. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу УИХ-ын тогтоолын төслийн хавсралт болгон “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийн төслийг нийт 4 бүлэг, 11 зүйл, 41 заалттай байхаар боловсрууллаа. Ингэхдээ:

**“Нийтлэг үндэслэл”** гэсэн 1 дүгээр бүлэгт олон улсын геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөн, олон улсын харилцаан дахь Монгол Улсын геополитикийн ач холбогдол болон манай орны геополитикийн давуу тал, чадавхыг тодорхойлов.

**“Геополитикийн үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилт, учирч болзошгүй àþóë занал”** гэсэн 2 дугаар бүлэгт олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдлаас үүдэн Монгол Улсад тулгарч буй эрсдэл сорилтод үнэлэлт дүгнэлт өгөн үндэсний аюулгүй байдалд учирч болзошгүй аюул заналын тухай төсөөллийг боловсрууллаа.

“**Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс”** гэсэн 3 дугаар бүлэгт геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн агуулга, зорилго, алсын хараа, стратегийн зорилт, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга замыг тодорхойллоо.

Ингэхдээ, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын хамрах хүрээнд геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын зорилго, зорилтыг хангах зохицуулалтыг нарийвчлан тусгахад голлон анхаарсан болно.

“Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл болон түүний хавсралтыг ҮАБЗ-ийн ажлын алба, ГХЯ, БХЯ, ЗХЖШ, ТЕГ-ын удирдлагуудад урьдчилан танилцуулсан бөгөөд тэдгээрийн саналыг судалж, анхаарах зүйлүүдийг тусгасан болно

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар сарын ... -ны өдөр Улаанбаатар хот

Дугаар ...

“ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС” БАРИМТ БИЧГИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

“Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс”-ийг хавсралтаар баталсугай.

2. “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс”-ийн олон нийтэд танилцуулах найруулгыг Төрийн нууцын тухай хуульд, болон Төрийн нууцад хамаарах баримт бичгийн жагсаалт батлах тухай Засгийн газрын ... оны .. дүгээр сарын ...-ны өдрийн ... тоот тогтоод нийцүүлэн боловсруулж төрийн төв хэвлэлд нийтлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны
.... дугаар тогтоолын хавсралт

# ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС

## Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1. Олон улсын геополитикийн нөхцөл байдлын өөрчлөлт

1.1.1. Стратегийн ач холбогдол бүхий чухал бүс нутаг, газар нутаг, тэнгис далайн сав нутгийн төлөөх дэлхийн том гүрнүүдийн өрсөлдөөн улам бүр геополитикийн утга агуулгатай болж, дэлхий нийтийг бүхэлд нь хамран, хурцдах төлөвтэй байна.

1.1.2. Хүн төрөлхтний хөгжлийн төв буюу том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөн аажмаар дорно зүгт шилжиж байна.

1.1.3. Олон улсын геополитикийн дахин хуваарилалтад Европ, Хойд Америкийн зэрэгцээ олон зуун сая, тэрбумаар тоологдох хүн амтай Хятад, Энэтхэг болон лалын гэгдэх ертөнц хүч түрэн орж ирж байна.

1.1.4. Том гүрнүүдийн геополитикийн өрсөлдөөний объектод цэрэг-стратегийн хувьд чухал болон эдийн засгийн чухал ач холбогдол бүхий район, бүс нутаг, далай тэнгисийн сав газрын зэрэгцээ байгалийн баялаг их хэмжээгээр төвлөрсөн болон нэгдмэл соёл иргэншилт үндэстэн ястан төвлөрөн суурьшсан газар нутаг бас хамаарах боллоо.

1.1.5. Геополитикийн хувьд өндөр ач холбогдол бүхий тив дэлхий, бүс нутгийг өөрийн эзэмшилд буюу нөлөөндөө байлгах нь соёл иргэншлүүдийн геополитикийн өндөр статус, аюулгүй байдлын түвшин, эдийн засгийн хөгжлийн чадавхын илэрхийлэл болж байна.

1.1.6. Геополитикийн орон зайн төлөөх өрсөлдөөний хүч хэрэгсэл, арга хэлбэр хүн төрөлхтний амьдралын бүх салбарыг хамран өргөжиж, зөрчил, сөргөлдөөний гол талбар нь эдийн засаг, олон улсын худалдааны зах зээл, оюун санаа, соёл иргэншлийн үнэт зүйлсийн өрсөлдөөн болж хувирах талтай байгаа

боловч үүнтэй зэрэгцэн цэрэг, зэвсгийн хүчээр асуудлыг шийдвэрлэх хандлага улам бүр газар авсаар байна.

1.1.7. Эцсийн дүндээ энэ зууны дунд гэхэд хүн төрөлхтөн соёл, иргэншлийн хуваарилалтын шинэ эринд амьдарч болзошгүй байна. Үүний дотор Хятад, Энэтхэгийн соёл иргэншил хүч түрэн гарч ирж, Европын соёл иргэншлийн нөлөө ихээхэн сулран, Хойд Америк танигдахын аргагүй өөрчлөгдөх магадлалтай байна. Гэхдээ дэлхий ертөнц илүү ёс суртахуунтай, байгаль орчинтойгоо зохицсон, ухаалаг болох төлөвтэй байна.

### 1.2. Олон улсын харилцаан дахь Монгол Улсын геополитикийн ач холбогдол

1.2.1. Сүүлийн жилүүдэд Монгол Улс том гүрнүүдийн ашиг сонирхлын өрсөлдөөний шинэ төв хэмээн нэрлэгдэх боллоо. Манай орны эргэн тойронд бий болсон геополитикийн энэ шинэ нөхцөл байдал нь ардчилал, эдийн засгийн зах зээлийн харилцааны замыг сонгосон 1990-ээд оноос бүрдэж эхэлсэн юм. Үүний гол учир шалтгаан нь Монгол орон Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашин, төр, нийгмийн байгууллын өөр хоорондоо ялгаа бүхий улс орнуудын зах нийлсэн заагт, Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд байдагт оршиж байна. Ер нь Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь эртнээс дэлхийн том гүрнүүдийн анхаарлын төвд байсаар ирсэн билээ.

1.2.2. Монгол Улс бага орон гэлтгүй олон улсын геополитикийн тэмцлийн талбарт идэвхтэй тоглогч болон хувирсныг хэн бүхэн хүлээн зөвшөөрөх боллоо. Энэ нь нэг талаасаа алт, уран, нүүрс, зэс, газрын ховор элементүүд, бусад ашигт малтмалын асар том ордыг ашиглахдаа гадаадынхантай хамтрах асуудлыг монголчууд харьцангуй сайн шийдвэрлэж чадаж байгаатай, нөгөө талаасаа, төр нийгмийн ардчилсан тогтолцоог амжилттай хэвшүүлж буй социализмын дараах Дорнын ганц орон гэдгээрээ олон улсад ихээхэн нэр хүнд хүлээх болсонтой шууд холбоотой байна.

1.2.3. Өөрөөр хэлбэл, эрдэс баялгийн улам бүр нэмэгдэж буй хэрэгцээ, үүнийг дагасан үнийн эрс өсөлт, эдгээртэй зэрэгцүүлэн эх орныхоо баялгийг ухаалгаар ашиглах, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэсэн, иргэний ардчилсан нийгэм

байгуулахын төлөө хийж буй Монголын төр засгийн болон нийт иргэдийн идэвхтэй тэмцэл манай орны геополитикийн ач холбогдлыг ихээхэн нэмэгдүүлж байна.

1.2.4. Монгол Улсын энхийг эрхэмлэсэн олон тулгуурт гадаад бодлого, гуравдагч хөршийн үзэл баримтлал, цөмийн зэвсгээс ангид статус, Хойд Солонгостой харилцахдаа баримталж байгаа найрамдалт байр суурь зэрэг нь нь их гүрнүүдийн зүгээс Зүүн хойд Азийн тухайд болон манай орны талаар баримтлах геостратегийн бодлогодоо анхаарах зайлшгүй учир шалтгаан болж байна.

**1.3. Монгол Улсын геополитикийн давуу тал, чадавх**

1.3.1. Төрийн тусгаар тогтнол, газар нутаг, монгол үндэстэн, соёл иргэншлээ хэдэн зуун, мянган жилийн турш хадгалан хамгаалж ирсэн цэрэг-эх оронч өндөр сэтгэлгээ бүхий ард түмэнтэй;

1.3.2. Онгон тансгаараа хадгалагдан үлдсэн эрүүл байгаль орчин, газрын доор орших асар их эрдэс баялаг, сэргээгдэх эрчим хүчний барагдашгүй их нөөц бүхий уужим тал, малын бэлчээр, уул ус, ургамал жигдрэн зохицсон, хангай говь хосолсон өргөн уудам газар нутагтай;

1.3.3. Хүн амын тоо цөөн боловч чанар сайтай, төрөлх хэл, соёл, уламжлал зэрэг түүхэн мөн чанар, оюун санааны болон ёс суртахууны үнэт зүйлс, өвөг дээдсээсээ уламжлан ирсэн үр, удам, төрөлх газар нутгаа хамгаалах өндөр сэтгэлгээтэй;

1.3.4. Түүхийн ямар ч нөхцөл байдалд үндэстний онцлох шинж чанараа хадгалах, дахин сэргээж ирсэн уламжлалтай;

1.3.5. Өөрийн орны геополлитикийн давуу тал, уламжлалаа баяжуулан хөгжүүлэх, оюун санаа, соёл иргэншлийн өвөрмөц шинж чанараа бусдаар хүлээн зөвшөөрүүлэх гүн эрмэлзэлтэй;

1.3.6. Манай иргэдийн ёс суртахууны болон үйл хөдлөлийн загвараар илэрхийлэгдэх үндэсний соёл иргэншлийн дархлаатай;

1.3.7. Үндэсний соёл иргэншлийн дархлаагаа хадгалан хамгаалах төрийн хатуу чанд үзэл бодолд тулгуурласан геополитикийн салбарт төрөөс баримтлах

бодлогын уг сурвалжтай. Энэ бодлогын язгуур үндсийг тодорхойлж хадгалан хамгаалах үндэстний удирдагчдын болон ухаантнуудын эрхэм чухал үүрэг байдаг.

### 1.4. Монгол Улсын геополитикийн аюулгүй байдлын баталгаа.

1.4.1. Монгол соёл иргэншил бусдад дарамтлагдаж, дайнд нэрвэгдэж, харийнханд сүйтгүүлэгдэж, элдэв бусад аюулд өртөж байсан боловч өөрсдийн уламжлалт үнэт зүйлс, амьдрах эрчим хүч, соёл иргэншлийн дархлаагаа хадгалж ирсэн дайчин уламжлалтай. Энэ дайчин уламжлалаа нэр төртэйгөөр үргэлжлүүлэх нь монгол үндэстэн оршин тогтнож, өөдлөн хөгжих, түүний геополитикийн аюулгүй байдлын баталгаа болж байна.

## Хоёр. ГЕОПОЛИТИКИЙН ҮҮДЭЛ СЭДЭЛ БҮХИЙ ЭРСДЭЛ СОРИЛТ, УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ÀÞÓË ЗАНАЛ.

### 2.1. Эрсдэл сорилт.

2.1.1. Олон улсын аюулгүй байдлыг хангах өнөөгийн механизмууд, юуны өмнө НҮБ, ЕАБХАБ зэргийн үүрэг, ач холбогдлыг бууруулах гэсэн зарим том гүрний эрмэлзэл хүчтэй нэмэгдэж байна;

2.1.2. Олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд бага орнуудыг аль болох оролцуулахгүй байх, тэднийг үл тоомсорлох хандлага газар авах боллоо;

2.1.3. Улс хоорондын харилцаанд цэрэг-улс төрийн эвсэл холбоодыг бэхжүүлэх, юуны өмнө НАТО-г дорно зүгт тэлэх, Орос, Хятадын цэрэг-стратегийн хамтын ажиллагааг холбоотны хэмжээ рүү ойртуулан гүнзгийрүүлэх эрмэлзэл ажиглагдаж байна;

2.1.4. Улс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр зэвсэгт хүчнээ ашиглах практик АНУ, Орос, Хятад, Турк гэх мэт орнууд болон НАТО-ийн тухайд хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна. Тэр ч байтугай үүнийгээ цэрэг-стратегийн номлолдоо тусгадаг болоод байна.

2.1.5. Тэргүүлэгч зарим гүрний технологийн хөгжлийн хэт тасархай байдал улам нэмэгдэж, шинэ үеийн зэвсэг, байлдааны техник бүтээх чадавх нь ихсэж байгаа нь зэвсэглэлийн чанараар өрсөлдөх шинэ үе шатыг авчирч, байлдааны

ажиллагааны арга хэлбэрт эргэлтийн гэж хэлж болох өөрчлөлт оруулах магадлалтай байна.

2.1.6. Олон улсын терроризм дэлхий нийтийн хэмжээний, олон талт шинж төрхтэй болж байгаа бөгөөд бүх улс орны аюулгүй байдалд ноцтой, нийтлэг аюул занал учруулах боллоо.

**2.2. Учирч болзошгүй аюул заналын тухай төсөөлөл.**

2.2.1. Ìîíãîë Óëñûí эргэн тойронд буй болсон геополитикийн шинэ нөхцөл байдал, ¿íäýñíèé аюулгүй байдалд íºëººëæ áîëçîøã¿é гадаад, дотоод õ¿÷èí ç¿éëñèéã íýãòãýí ä¿ãíýæ ¿çýõýä îéðûí áîëîí äóíä õóãàöààíû èðýýä¿éä Ìîíãîë Óëñûí òóñãààð òîãòíîë, á¿ðýí эрхт áàéäàë, ãàçàð íóòãèéí á¿ðýí á¿òýí, улсын хилийн халдашгүй дархан áàéäàë, òºðèéí áàéãóóëàëòàä ãààíààñ öýðãèéí õ¿÷ýýð øóóä çàíàëõèéëýõ àþóë ¿íäñýíäýý áàéõã¿é áàéíà.

2.2.2. Ìàíàé óëñûí îëîí óëñûí íýð õ¿íä ñ¿¿ëèéí æèë¿¿äýä èõýýõýí ºññºí, õºðø õî¸ð îðîíòîéãîî ýëäýâ ìàðãààíòàé àñóóäëàà îëîí óëñûí ýðõ ç¿éí õ¿ðýýíä ýöýñëýí øèéäâýðëýñýí, ýíý õî¸ð óëñòàé болон гуравдагч бусад хөрштэйгөө òîãòîîñîí íàéðñàã õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà ºäðººñ ºäºðò ºðãºæèí õºãæèæ áàéãàà íü èéì ä¿ãíýëòýíä õ¿ðãýæ áàéíà.

2.2.3. ¯¿íèé çýðýãöýý á¿ñ íóòãèéí õ¿ðýýíä ¿¿ñýí Ìîíãîë Óëñ òàòààãàí îðæ áîëîõ ýñâýë өөр бусад ãàäààä õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí манай улсын дотоодод үүсэж áîëîõ äàðààõ àþóë занал áîäèòîéãîîð оршиж áàéíà.

2.2.4. Á¿ñ íóòãèéí геополиткийн нөхцөл байдлаас үүдэн Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðæ áîëçîøã¿é аюул занал:

- Îëîí óëñûí òåððîðèçì óëàì á¿ð õ¿ðýýãýý òýëæ Ç¿¿í õîéä Àçè, Òºâ Àçèéí á¿ñ íóòãèéã, ò¿¿íèé äîòîð Ìîíãîë Óëñûí íóòàã äýâñãýðèéã õàìðàõ;

- Óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé Õÿòàäûí ýäèéí çàñãèéí ýð÷èìòýé хөгжлийг даган Àçè òèâä öýðýã-óëñ òºðèéí нөлөөллөө ºðãºæ¿¿ëýõ энэ улсын эрмэлзлийг төрүүлэн ¿¿íèé óëìààñ ¿¿íòýé èæèë òºñòýé àøèã ñîíèðõîë á¿õèé ÎÕÓ áîëîí ÀÍÓ-òàé íîöòîé, ºðãºí õ¿ðýýòýé зөрчилдөхөд õ¿ðãýõ, ¿¿íä íü Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðîõ;

- Õî¸ð Ñîëîíãîñ, Õÿòàä-Òàéâàíü, Ýíýòõýã-Ïàêèñòàí õîîðîíäûí ýñðýã òýñðýã áàéð ñóóðü, Êóðèëëèéí àðëóóäûí òàëààðõ Îðîñ-ßïîíû ìàðãààí зэрэг нь óëñ õîîðîíäûí õàðèëöààíû òîãòîðõîé íºõöºë áàéäàëä çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýõ. Ýíý íü á¿ñ íóòãèéã õàìàðñàí øèíæòýé áîëæ ºðãºæèí Ìîíãîë Óëñûã ÿìàð íýã õýëáýðýýð õàìðàõ;

- Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé НАТО-ийн öýðýã-óëñ òºð, ýäèéí çàñãèéí íºëººã õÿçãààðëàõ зорилго бүхий Øàíõàéí õàìòûí àæèëëàãààíû áàéãóóëëàãûí öýðýã-óëñ òºðèéí ýâñýë õýëáýðèéí ¿éë àæèëëàãàà ºðãºæèë ¿¿íèé ¿ð äàãàâàð ÀÍÓ, Баруун орнууд нэг талаас áîëîí нөгөө талаас Орос, Хятадын õîîðîíä öýðýã, çýâñãèéí õ¿÷èéã òóëãóóð áîëãîñîí çºð÷èë, ñºðãºëäººí үүсэх, ¿¿íä Ìîíãîë Óëñ òàòàãääàí îðîõ;

- 2008 îíä òîõèîëäñîíòîé төсөөтэй íèéòèéã õàìàðñàí ýäèéí çàñãèéí õÿìðàë Àçè òèâ áîëîí Ç¿¿í Хойд Àçèä áèé áîëæ ýíý íü Ìîíãîë Óëñûí ýäèéí çàñàã, íèéãìèéí õºãæèëä ñààðóóëàõ áóþó çîãñîîãè áàéäàëä îðóóëàõ;

- Õºðø çýðãýëäýý áîëîí áóñàä îðíóä ¿¿ñññýí õÿìðàëò áàéäëààñ ¿¿äñýí õÿíàëòààñ ãàðñàí öàãàà÷ëàë, æèðèéí áîëîí çýâñýãëýñýí ä¿ðâýëòýä íýðâýãäýõ çýðýã áîëíî.

2.2.5. Уламжлалт бус аюул занал:

2.2.5.1. Олон улсын ээдрээтэй нөхцөл, улс төрийн тогтворгүй байдал, үндэсний эдийн засгийн хямрал, нийгмийн хуваагдал, түүний дотор шашин хоорондын харилцааны зарим нэг зөрчил сөргөлдөөн зэрэг нь манай орны аюулгүй байдалд учрах гадаад, дотоод үүдэлтэй уламжлалт бус аюулын эх сурвалж болж байна.

2.2.5.2. Ойрын ирээдүйд ãàäààä, äîòîîä àëèâàà õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí дотоодын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй уламжлалт бус гэж хэлж болох дараах аюул занал үүсэж болзошгүй байна. Үүнд:

2.2.5.3. Óëñ òºðèéí õ¿ðýýíä:

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгай байдлаа бий болгох гэсэн том гүрнүүдийн зөрчил сөргөлдөөн болон тэдгээрийн манай улсын тухайд явуулж буй тус тусын тодорхой чиглэл, зорилго бүхий геостратегийн бодлогын

нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн бодлогод саад бэрхшээл үүсэх, àëü íýã óëñ îðîí, óëñ òºð-öýðãèéí ýâñýë õîëáîî áóþó ¿íäýñòýí äàìæñàí òîì êîðïîðàöóóäààñ улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар õàðààò áàéäàëä орох;

- Олон улсын терроризм улам бүр газар авч байгаа болон манай улс терроризмын эсрэг баруунbы эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гадны хүчний явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирэх;

- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад орнуудын зүгээс манай орны эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаагаа нэмэгдэх, энэ нь чиглэл, зорилготой, нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болох.

<u>2.2.5.4. Ýäèéí çàñãèéí õ¿ðýýíä:</u>

- Гадаадын хөрөнгө оруулалт, бусад улстай хийх худалдааг тэнцвэржүүлэх нэгдсэн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох;

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого, үйл ажиллагаанд алдаа, доголдол гарах, үүний улмаас эдийн засгийн салбарт тогтвортгүй байдал үүсэх, мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гарах, дампуурлад орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл сулрах ;

- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажаагүй гадны зээл тусламж нэмэгдэх, үнэт цаасны зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр çàñàã, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орох, улс орон âàëþòûí íººöºº àëäàõ, áàðüöààëóóëàõ, ãàäààä äîòîîäûí õºðºíãº îðóóëàëò эмх замбараагүй байдалтай болох, түүнчлэн çýýë, òóñëàìæûã çàìààñ íü çàâøèõ ÿâääë ãàçàð àâñàíààñ ¿¿äýí ãàäààä îðíóóä, ò¿¿íèé äîòîð òîì ã¿ðí¿¿ä ýíý òºðëèéí ¿éë àæèëëàãàà õýðýãæ¿¿ëýõýý çîãñîîõ.

<u>2.2.5.5. Íèéãìèéí õ¿ðýýíä:</u>

- Õóóðàì÷, õààãàëàõ õóãàöàà õýòýðñýí, õ¿íèé áèå îðãàíèçìä õîðòîé õ¿íñ, ýì òàðèà, õóâöàñ, ýä õýðýãëýë ãýõ ìýò ç¿éë¿¿ä ãààíààñ ихээр îðæ èðýõ, ãàäààä õàðèëöàà ºðãºæèæ õ¿í, ìàë, áàðàà á¿òýýãäõ¿¿íèé óðñãàë ÷ºëººòýé áîëîõ õýðýýð

ýëäýâ õàëäââàðò ºâ÷èí òàðõàõ, ¿¿íèé äîòîð ÄÎÕ, шинэ вирусийн болон íýí õàëäââàðò áóñàä ºâ÷íººð ºâ÷èºãñäèéí òîî ºñºõ;

- Óëñ îðíû õýìæýýíä, ¿íäýñòýí äàìæñàí ãýìò õýðãèéí á¿ëýãëýë¿¿ä áèé бол, ýð¿¿ãèéí íºõöºë áàéäàë õýíàëòààñ ãàðàõ ìàíàé óëñûí íóòàã äýâñãýðèéã ìàíñóóðóóëàõ áîäèñ, ýëäýâ òºðëèéí çýâñýã, öºìèéí ò¿¿õèé ýä, ìàòåðèàë, õ¿í õóäàëäààëàõààð çººâºðëºõ, äàìæóóëàõ òàëáàð áîëãîõ îðîëäëîãî ãàðàõ, òýäãýýðèéí õîð óðøèã íü óëñ îðíû óëñ òºð, ýäèéí çàñãèéí áîäëîãîä íºë××ëºõ õýìæýýíä хүрэх;

- Харт тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн хэлбэрт шилжих .

2.2.5.6. Ñî¸ë èðãýíøëèéí õ¿ðýýíä:

- Ìîíãîë Óëñûí ãàäààä õàðèëöàà ºðãºæèõ, íýýëòòýé áîëîõ õýðýýð áóñàä îðíû àìüäðàõ õýâ ìàÿã, ýðõýìëýõ ¿íýò ç¿éëñèéí õ¿÷òýé íýâòðýë гүнзгийрэх, ¿¿íýýñ ¿¿äýí ¿íäýñíèé ¿íýò ç¿éëñèéí ¿íýëýìæèä ýðãýæ áóöàëòã¿é ººð÷ëºëò ãàðàõ, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлөх;

- õ¿í òºðºëõòíèé íèéòëýã ñî¸ëûã äýýäëýõ, áóñàä øàøíûã õ¿íäýòãýõ, зарим тохиолдолд албан ёсны бус гаднаас орж ирсэн шашны урсгалд автах ¿çýë áîëîí ìîíãîë ¿íäýñíèé òºðºëõ õýë, ñî¸ë, áóðõàíû øàøèí, ¸ñ çàíøèë, óäìûí ñàí, óãñàà ãàðâàëàà õàäãàëàí õàìãààëàõ ãýñýí ýðìýëçëèéí õîîðîíä çºð÷èë, ñºðãºëäººí ¿¿ñýõ, ýíý íü óëñ òºðæèõ çàìààð íèéãýìä áóõèìäàë ¿¿ñãýх.

2.2.5.7. Áàéãàë îð÷íû õ¿ðýýíä:

- Äýëõèéí öàã óóðûí äóëààðàë, ºº𗀀ëºëò áîëîí áóñàä øàëòãààíààñ ¿¿äýí áàéãàëèéí ãàìøèãò ¿çýãäë¿¿ä îëøðîõ ýíý íü óëñ îðíû ýäèéí çàñàã, íèéãýìä äààæ äààâøã¿é õîõèðîë учруулах;

- Хэт их гадаадын хөрөнгө оруулалт бүхий óóë óóðõàéí áîëîí áîëîâñðóóëàõ ¿éëäâýðëýëèéã ýð÷èìæ¿¿ëýõ ÿâöàä áàéãàëèéí òýíöâýð àëäàãäàõ, óñ, ãîë ìºðºí, àãààð ìàíäàë, õºðñ áîõèðäîõ, îé ñ¿éäýõ, öºëæèëò ãàçàð àâàõ, áýë÷ýýðèéí òàëõàäàë, òàðèàëàíãèéí òàëáàéí õîìñäîë èõñýõ, ýäãýýðýýñ ¿¿äýí õ¿í àìûí íýëýýä õýñãèéí àìüæèðãààíû ýõ ¿¿ñâýð áîëñîí ìàë àæ àõóé, ãàçàð òàðèàëàíãèéí õºãæèë çîãñîíãè

áàéäàëä îðîõ, өөр хоорондоо тэрсэлдэх;

- Манай орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах оролдлого гарах.

**Гурав. ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН ҮНДСЭН АГУУЛГА, АЛСЫН ХАРАА, ЗОРИЛТ.**

**3.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн агуулга:**

3.1.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндсэн агуулга нь Монгол Улсын геополитикийн аюулгүй байдлыг хангах явдал байна.

3.1.2. Монгол Улсын геополитикийн аюулгүй байдал гэж үндэсний язгуур ашиг сонирхлоо олон улсын аюулгүй байдлын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд найдвартай хадгалан хамгаалах, бусад орон, эвсэл холбоодтой найрсаг харилцаа хамтын ажиллагаатай байх болон гадаад ертөнцөд тодорхой хэмжээгээр нөлөө бүхий байр суурь эзлэх нөхцөл бололцоог олгосон, олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдсөн, геополитикийн өндөр статус, нэр хүндтэй байх улс орны чадамжийг хэлнэ. Геополитикийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

3.1.3. Геополитикийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаа нь Монгол Улсын геополитикийн давуу тал, чадавхаа дээд зэргээр үр дүнтэй ашиглах, геополитикийн үүдэлтэй гадаад дотоод сөрөг хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, саармагжуулах болон арилгах замаар улс орны үндэсний ашиг сонирхлыг хамгаалах бололцоог олгосон ãàäààä, дотоод òàòàé нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

3.1.4. Ìîíãîë Óëñûí õóâüä геополитикийн àþóëã¿é áàéäëàà áèå äààí õàíãàõ óëñ òºð, öýðãèéí àðãà õýðýãñýë, ýäèéí çàñãèéí íººö áîëîìæ õÿçãààðëàãäìàë учир энэ бодлогоо хөрш болон ойр зэргэлдээ том гүрнүүдийн Монгол Улсын талаар баримталж буй геостратегийн бодлогоос үүдэн гарч буй эерэг нөлөөллийг ухаалгаар ашиглах, сөргөөр нөлөөлж болох хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх, болзошгүй үр дагаврыг нь арилгахад бэлэн байхад чиглэсэн, тусгайлсан арга хэмжээнүүдийг õýðýãæ¿¿ëýõ çàìààð хангана. Эдгээр арга хэмжээг ó÷èð÷

болзошгүй геополитикийн үүдэл, сэдэл бүхий àþóë заналыг òîãòîîë ¿íýëæ, áàéãàà á¿õ боломжоо äýýä çýðãýýð àøèãëàõ áîëîí ìàíàé орны геополитикийн áîäèò íººö, áîëîìæîîíä òóëãóóðëàí хэрэгжүүлнэ.

3.1.5. Ìîíãîë Óëñûí геополитикийн àþóëã¿é байдал нь þóíû ºìíº ìàíàé îðíû геополитикийн íýð õ¿íäèéã îëîí óëñûí òàâöàíä òîãòîîë íýìýãä¿¿ëýõ, ýäèéí засгаахөгжүүлэх, àðä÷èëëûã öààøèä áýõæ¿¿ëýõ, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëººã хамгаалахтай шууд холбоотой байна. ¯¿íèé äîòîð ýäèéí çàñãèéí цэгцтэй бодлого íü àðä÷èëàë, õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëººã õàìãààëàõ, àðä ò¿ìýíä çàñãèéí ýðõèéã áîäèòîéãîîð áàðèõ íºõöëèéã áèé áîëãîõ à÷ õîëáîãäëîîðîî òýðã¿¿ëýõ áàéð ñóóðü ýçëýõ ó÷èðòàé áîëîî. Íºãººòýéã¿¿ð ýäèéí çàñãèéí õºãæèë íü òºðèéí òîãòâîðòîé áàéäëûã õàíãàõ ãîë õ¿÷èí ç¿éë болох учиртай юм. Ìîíãîë óëñ çºâõºí òîãòâîðòîé õºãæèæ áóé ýäèéí çàñàãòàé, òºðèéí áàéãóóëàëòûí àðä÷èëñàí òîãòîëöîîòîé áàéæ õýìýýí äýëõèéí áóñàä оронтой èæèë ò¿âøèíä õàðüöàõ áîëîìæîîòîé áºããä ýíý íü геополитикийн àþóëã¿é áàéäëàà áàòàëãààæóóëàõ үндсэн õýðýãñýë болно.

3.1.6. Ìîíãîë Óëñ онгон байгаль, газар нутгаа хадгалан хамгаалах болон èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ íü геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõ өөр нэг ÷óõàë õýðýãñýë ìºí. Èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ íü òýäíèé îþóíû ÷àäàâõè, áîëîâñðîë, ýð¿¿ë ìýíä, àìüäðàëûí ò¿âøèíã äýýøë¿¿ëýõ, íèéãìèéí èäýâõèéã íü íýýí ãàðãàõ, ººäðºã ñýòãýëãýýã õºãæ¿¿ëýõ, Ýõ îðíîîðîî áàõàðõàõ, ¿íäýñ óãñààãàà õàäãàëàõ ãýñýí ¿å äàìæñàí õ¿ì¿¿æèëòýé áîëãîõ çýðýã îëîí àñóóäëûã ººðòºº агуулна. Ìîíãîë Óëñûí геополитикийн íýð õ¿íäèéã îëîí óëñûí òàâöàíä ºðãºõ, òºð, íèéãìèéí àðä÷èëñàí òîãòîëöîîã õàìãààëàí áýõæ¿¿ëýõ, óëñ îðíû ýäèéí çàñãèéí òîãòâîðòîé õºãæëèéã õàíãàõ, õ¿í àìûã õ¿÷èðõýãæ¿¿ëýõ çýðýã íü ºíººãèéí øèíý íºõöºë áàéäàëä геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõ ñòðàòåãèéí ãîë àãóóëãà байна.

**3.2. Алсын хараа, стратегийн зорилт, үндсэн чиглэл, хэрэгжүүлэх арга зам.**

3.2.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын алсын хараа:

Энхийг ýðõýìëýñýí олон тулгуурт ãàäààä бодлогоо эрчимжүүлэн, Зүүн Хойд Азийн аюулгүй байдлын хамтын ажиллагаанд идэвхтэй оролцдог, олон улсын тавцанд геополитикийн өндөр нэр хүнд, өөрийн гэсэн байр суурь, дуу хоолойтой орны нэг болж, хүлээн зөвшөөрөгдөх, геополитикийн шинэ нөхцөл байдал, үндэсний хөгжлийн онцлог, өнөөгийн шаардлага, хэтийн төлөвт нийцсэн

геополитикийн салбарт төрөөс баримтлах өөрийн гэсэн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхэд оршино” .

3.2.2. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын стратегийн зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам:

3.2.2.1. Стратегийн 1 дүгээр зорилт

Монгол Улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдал, олон улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, улс орны хөгжлийн шинж чанар, хэтийн төлөв, ирээдүйн хандлагад нийцүүлэн үндэсний аюулгүй байдлын бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлэх, энэ бодлогын эрх зүйн орчныг бий болгох.

*Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*

- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг манай орны эргэн тойронд бий болсон геополитикийн нөхцөл байдал, үүнээс үүдэн улс орны дотоодод бий болсон нөхцөл байдалд нийцүүлэн шинэ утга агуулгаар баяжуулах, тодотгон шинэчлэх;

- “Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогын үндэс” баримт бичгийг боловсруулан УИХ-аар батлуулах, гүйцэтгэлд нь хяналт тавих үр дүнтэй механизмыг бий болгох.

- ”Аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын хууль тогтоомж, төрийн бодлогын бусад баримт бичигт геополитикийн үүдэл сэдэлтэй аюулаас урьдчилан сэргийлэх, саармагжуулах, хамгаалах агуулга бүхий тодотгол хийх,

3.2.2.2. Стратегийн 2 дугаар зорилт

Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, îëîí óëñûí аюулгүй байдлын õàìòûí ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэх замаар геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэх.

*Үйл ажиллагааны үндсэн чиглэл*:

- Ýíõ òàéâíûã тогтоон барих, аливаа маргаантай асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхэд ÷èãëýñýí óëñ õîîðîíäûí á¿õ òàëûí õàìòûí àæèëëàãààíä Ìîíãîë Óëñûí îðîëöîîã èäýâõæ¿¿ëýõ, ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ын зэрэгцээ ÀÍÓ тэргүүтэй гуравдагч áóñàä óëñ орон, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаагаа өргөжүүлэх, өөрийн зарчимч байр суурь, дуу хоолойгоо нэмэгдүүлэн Ìîíãîë Óëñûí олон улсын геополитикийн тавцанд эзлэх áàéð суурь, ач холбогдлыг өндөрсгөх;

- Хөрш орнууд, нөлөө бүхий гуравдагч бусад гүрний Монгол дахь геополитикийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, эдгээр гүрний геостратегийн зөрчил, сөргөлдөөнөөс үүдэлтэй элдэв, аюул, сорилт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах утга агуулгаар гадаад, дотоод бодлогоо баяжуулах.

3.2.2.4. Стратегийн 3 дугаар зорилт:

Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалд нийцүүлэн ардчилал, сайн засаглалыг áàòàëãààæóóëàõ, монгол, соёл иргэншил, áàéãàëü орчноо õàäãàëàí õàìãààëàõ, õ¿íèé ýðõ, èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ, амьдрах таатай орчин, ýðõ чөлөөгөөрхангах зэрэг улс орны геополитикийн давуу тал, чадавхыг дээд зэргээр ашиглахад чиглэсэн цэгцтэй бодлого хэрэгжүүлэн геополитикийн аюулгүй байдлын дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх.

*Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*

- Ардчиллыг гүнзгийрүүлэх, сайн засаглалыг төрийн удирдлага, нийгмийн харилцаа, хууль эрх зүйн хүрээнд бүрэн хэвшүүлэх, бүх шатны сонгуулийн тогтолцооны шударга байдлыг баталгаажуулах, төрийн байгууллага, улс төрийн нам, иргэний байгууллага, нийт иргэдийн холбоог улс үндэстэн, газар шороо, төр засгаа дээдлэх төрт ёсны уламжлал, үндэсний эх оронч үзэлд тулгуурлан бэхжүүлж óëñ төрийн òîãòâîðòîé áàéäëûã õàíãàõ;

- Ядуурал, нийгмийн баялгийн øóäðààã бус хуваарилалт, авлига болон нийгмийн бусад сөрөг үзэгдэлтэй шийдвэртэй тэмцэх, эдийн засгийн, юуны өмнө óóë óóðõàéí үйлдвэрлэлийн үр ашгийг ард түмэнд тэгш хүртээх, нийт иргэдийг àæëûí áàéð, эдийн засгийн эрх чөлөө, áîäèòîé îðëîãî олох, áîëîâñðîë эзэмших, ýð¿¿ë

энх амьдрах, хөдөлмөрлөх нөхцөл бололцоогоор бүрэн хангах үндсэн дээр хүн амын амьдралын ò¿âøèíã хурдтай äýýøë¿¿ëýõ;

- Байгалийн ãàìøãûí õîð óðøããàñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ, íýðâýãäýãñýäýã òóñëàìöàà ¿ç¿¿ëýõ улс орны íýãäñýí òîãòîëöîîã áèé áîëãîõ, óóë óóðõàéí ÷èãëýëèéí áîëîí áóñàä õ¿íä ¿éëäâýðëýë, дэд бүтцийг õºãæ¿¿ëýõäýý áàéãàëèéã ñ¿éòãýõã¿é, íºõºí ñýðãýýäýã байхыг шаардсан ýðõ ç¿éí õàòóó çîõèöóóëàëòûã áèé áîëãîõ, ãàçðûí àøèãëàëòûã ¿ð ä¿íòýé áîëãîõ, ò¿¿íèé äîòîð áýë÷ýýðèéí áîëîí òàðèàëàíãèéí ãàçàð àøèãëàëòûã ýäèéí çàñãèéí àðãààð çîõèöóóëàõ төрийн бодлогыг хэрэгжүүлэх.

3.2.2.5. Хэрэгжүүлэх арга зам

*Улс төрийн  салбарт*

- ªºðèéí ãýñýí ¿çýë áîäîëòîé áàéõ, ø¿òýõ, ýñ ø¿òýõ õ¿íèé ýðõ, ýðõ ÷ºëºº, ÷ºëººò õýâëýëèéã òóóøòàé äýìæèõ, îëîíõèéí çàñàãëàëààñ öººíõèéí ýðõ àøãèéã õàìãààëàõ ìåõàíèçìûã áîëîâñðîíãóé áîëãîæ èðãýíèé íèéãìèéã òºëºâø¿¿ëýí óëñ òºðèéí òîãòâîðòîé áàéäëûã õàíãàõ íü Ìîíãîë Óëñûí геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàìãààëàí áýõæ¿¿ëýõ áîëíî.

- Ñîíãóóëèéí òîãòîëöîîã áîëîâñðîíãóé áîëãîõ, àðä èðãýä ñîíãîõ ñîíãîãäîõ ýðõýý ýäëýõäýý á¿õ òºðëèéí ìýäýýëëýýð õàíãàãäàõ, ººðñäèéí ýðõ àøãèéã õàìãààëæ, èëýðõèéëæ ÷àäàõóéö õ¿ì¿¿ñèéã ñîíãîõ áîëîìöîîã îëãîñîí òèéì íºõöºë áàéäëûã á¿ðä¿¿ëýõ íü òºð çàñãèéí áîëîí òºðèéí áóñ áàéãóóëëàãóóä, íèéò èðãýäèéí ÷óõàë ¿¿ðýã áîëæ áàéíà.

- Öàãäàà, òàãíóóë, ø¿¿õ, ïðîêóðîð ãýõ ìýò áàéãóóëëàãóóäûã õ¿íèé ¿íäñýí ýðõèéã ç¿ð÷èõã¿éãýýð ãýìò õýðýãòýé òýìöýõ, íèéãìèéí õýâ æóðìûã ñàõèóëàõ ¿éë àæèëëàãààíä ñóðàëöóóëàõ, í¿ã¿¿ òàëààñ èðãýäèéã òºðèéí õóóëü ¸ñûã ñàõèí áèåë¿¿äýã, äýýðõ áàéãóóëëàãûí ¿éë àæèëëàãààã îéëãîäîã, äýìæäýã íºõöëèéã á¿ðä¿¿ëýõ ÿâäàë à÷ õîëáîãäîëòîé áîëæ áàéíà.

- Òºð, çàñãèéí áàéãóóëëàãûí ¿éë àæèëëàãààã öààøèä èë òîä áàéëãàõ íü òºð, îëîí ò¿ìíèé õîëáîîã áýõæ¿¿ëýõ, ¿ð àøãèéã íýìýãä¿¿ëýõ, àâèëãàëòàé òýìöýõýä îëîí íèéòèéí ñàíàà áîäîë, õ¿ñýë ýðìýëçëèéã òóñãààãã áîëãîõîä òóñòàé áàéõ áîëíî. Ìºí èðãýäèéí ø¿òýõ, ýñ ø¿òýõ ýðõèéã áîäèòîéãîîð õàíãàõ àñóóäàë õóðöààð òàâèãäñààð áàéõ òºëºâòýé áàéíà.

*Эдийн çàñãèéí салбарт*

- Ýäèéí çàñãèéí ñàëáàðûí òîãòâîðòîé õºãæèë íü геополитикийн àþóëã¿é áàéäëûã õàíãàõàä øèéäâýðëýõ ¿¿ðýãòýé áîëæ áàéíà. Õóâèéí õýâøèë òýðã¿¿ëñýí, ýêñïîðòûí ÷èãëýëòýé, íýýëòòýé ýäèéí çàñãèéã õºãæ¿¿ëýõ, Ìîíãîë Óëñàä àøèãòàé ãàäààäûí õºðºíãº îðóóëàëòûã äýìæèõ íü äýëõèéí çàõ çýýë äýýð áîëæ áàéãàà ººð÷ëºëòºä ò¿ðãýí äàñàõ ÷àäâàðòàé ýäèéí çàñãèéí á¿òýö áèé áîëãîõ áîäëîãî, ¿éë àæèëëàãààíû ¿íäñýí àãóóëãà þì. Ýíý íü Ìîíãîëûí ýäèéí çàñãèéí ºðñºëäºõ ÷àäâàðûã íýìýãä¿¿ëýõýä ãîëëîõ ¿¿ðýãòýéí çýðýãöýý геополитикийн àþóëã¿é áàéäëûí ãîë áàòàëãàà áîëîõ ó÷èðòàé.

- Ýêñïîðòûã äýìæèõ, ýíý ÷èãëýëèéí ãàäààä äîòîîäûí õóâèéí õýâøëèéí ¿éëäâýð¿¿äòýé Çàñãèéí ãàçðààñ àæèëëàõ àðãà áàðèë, òóõàéëáàë, ýêñïîðòûã ñàíõ¿¿æ¿¿ëýõ, ìýäýýëëèéã ò¿ðãýí øóóðõàé áîëãîõ, á¿òýýãäýõ¿¿íèé ÷àíàð, ñòàíäàðòûí òàëààð ñóðãàëò ÿâóóëàõ õºòºëáºð ãàðãàæ àæèëëàõ øààðäëàãà òàâèãäààæ áàéíà. Çàñãèéí ãàçàð, ãàäààä äîòîîäûí õºðºíãº îðóóëàã÷äûí õóâèéí õýâøëèéí õàìòûí àæèëëàãààã àëáàí ¸ñîîð õýëáýðø¿¿ëæ, ¿éë àæèëëàãààã íü ñàéæðóóëàõ íü ÷óõàë áîëíî.

- Òºðººñ õºãæëèéí àñóóäàëä õàíäàõäàà á¿ñ÷èëñýí õºãæëèéí ¿çýë áàðèìòëàëûã òóëãóóð áîëãîæ áàéãàà íü геополитикийн àþóëã¿é áàéäëûí àøèã ñîíèðõîëä íèéöýõ þì. Ìºí àëü áîëîõ àæëûí îëîí áàéð áèé áîëãîñîí ãàäààä äîòîîäûí êîìïàíèóäûã òºðººñ äýìæèõ àñóóäàë ÷óõàë à÷ õîëáîãäîëòîé þì. Ýíý íü ÿäóóðëûã áóóðóóëàõàä áîäèòîé íºëºº ¿ç¿¿ëýõ áîëíî.

- Áàíê, ñàíõ¿¿ãèéí ñàëáàð îëîí îëîëòûã áàòàëãààæ, öààøèä ýíý ñàëáàð õóâèéí õýâøèë, ò¿¿íèé äîòîð ãàäààäûí íýð õ¿íä á¿õèé áàíê, ñàíõ¿¿ãèéí áàéãóóëëàãóóäàä ¿éë àæèëëàãààãààà ÿâóóëàõ ýðõ ç¿éí òààëàìæòàé íºõöëèéã õàíãàõ ÿâäàë ÷óõàë þì. Ò¿¿í÷ëýí Ìîíãîë Óëñûí ýêñïîðòûí ãîë íýðèéí áàðààã äýëõèéí çàõ çýýëèéí ¿íèéí õýëáýëçýëýýñ äààòãàõóóëàõ íü ýäèéí çàñãèéí ºð ººñãºë á¿òýöòýé Ìîíãîë îðîíä ò¼ñâèéí òîãòâîðòîé ýõ ¿¿ñâýðòýé áàéõàä íºëºº áîëîõ à÷ õîëáîãäîëòîé áàéæ áîëîõ òàëòàé.

*Нийгмийн салбарт*

- Геополитикийн àþóëã¿é áàéäëûí àñóóäëààð á¿õ íèéòýä àëáàí áóñ áîëîâñðîîë îëãîõ õºòºëáºð õýðýãæ¿¿ëýõ øààðäëàãàòàé áºãººä ýíý íü Ìîíãîëûí íèéãìèéí õóâüä ¿íäýñíèé çºâøèëöºë áèé áîëãîõîä òóñòàé áàéõ áîëíî.

- ßäóóðàëòàé òýìöýõ, õ¿í àìûã îðëîãîîðîî òóéëøðàõûí ýñðýã á¿õ òàëûí àðãà õýìæýý àâàõûã Ìîíãîë Óëñûí геополитикийн àøèã ñîíèðõîë øààðäààæ áàéíà. Èíãýõäýý çàõ çýýëèéí æàì ¸ñíû õºãæëèéã áîîìèëæ áàñ áîëîõã¿é þì.

- Ãàäààä îðîîñ èðæ îðøèí ñóóã÷èä, öàãàà÷äûí àìüäðàõ, àæèëëàõ ýðõ ç¿éí îð÷íûã òîäîðõîé áîëãîõ, ò¿¿í÷ëýí ãàäààààä îðøèí ñóóã÷ ìîíãîë èðãýäýä òºðèéí ç¿ãýýñ áîëîí îëîí óëñûí áàéãóóëëàãûí òóñëàìæòàéãààð òàë á¿ðèéí òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ àðãà ìåõàíèçìä ìàíàé áàéãóóëëàãóóä ñóðàëöàõ ¸ñòîé áîëæ áàéíà.

- Ãýð á¿ëèéí ¿íý öýíèéã õàìãààëàí áýõæ¿¿ëýõ, ýíý òàëààð àæèëëàæ áàéãàà îëîí íèéòèéí áîëîí õóâèéí áàéãóóëëàãààä á¿õ òàëààð äýìæëýã òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ ÿâààë íèéãìèéã ¸ñ ñóðòàõóóíû äîðîéòîë, ÄÎÕ-ûí àþóëààñ àâðàõ ¿ð ä¿íòýé àëõàì áàéõ áîëíî.

*Áàéãàëü орчны салбарт*

- Áàéãàëèéí ãàìøèã ãýñýí îéëãîëòûí ýðõ ç¿éí болон геополитикийн àãóóëãûã òîäîòãîæ, ò¿¿íä íýðâýãäýãñýäýä òóñëàëöàà ¿ç¿¿ëýõ òîãòîëöîîã áèé áîëãîõ, ýíý òàëààð îëîí óëñûí õ¿ì¿¿íëýãèéí áàéãóóëëàãóóäòàé ºðãºí õàìòûí àæèëëàãàà ÿâóóëàõ øààðäëàãàòàé áîëæ áàéíà.

- Ìîíãîë Óëñàä óóë óóðõàéí ÷èãëýëèéí áîëîí áóñàä õ¿íä ¿éëäâýðëýëèéí õºãæ¿¿ëýõäýý áàéãàëèéã ñ¿éòãýõã¿é, íºõºí ñýðãýýäýã áàéõ ýðõ ç¿éí õàòóó çîõèöóóëàëòûã áèé áîëãîõ àñóóäàë òóëãàìäñàí çîðèëò áîëæ áàéíà. ¯¿íýýñ ãàäíà ãàçðûí àøèãëàëòûã ¿ð ä¿íòýé áîëãîõ, ò¿¿íèé äîòîð áýë÷ýýðèéí áîëîí òàðèàëàíãèéí ãàçàð àøèãëàëòûã ýäèéí çàñãèéí àðãààð çîõèöóóëàõ ÿâààë ÷óõàëààð òàâèãääàæ ýõýëëýý.

**Дөрөв. БУСАД**

4.1. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцооны үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

4.2. Геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого, үйл ажиллагаа нь олон улсын нөхцөл байдлын өөрчлөлт, Монгол Улсын геополитикийн давуу тал, чадавхтай уялдаатайгаар тодотгон шинэчлэгдэж байна.

Хавсралт 2

**“МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”, “МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”, МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ САНАЛ**

**Суурь судалгааны төслийн үр дүн 3**

Төсөл

БАТЛАВ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ ......................................................................................................

## “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсоны үндсэн дээр ”Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д” холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллоо.

ЗИйм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

### 1.1. Хууль эрх зүйн үндэслэл

Энэхүү тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн "Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэсэн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр, "Төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох" гэсэн 25 дугаар зүйлийн 1-ийн 2 дугаар заалт, " Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль", "Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль", Гадаад бодлогын үзэл баримтлал" болон "Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгүүдийн холбогдох зүйл заалтуудад тулгуурлан боловсруулав.

### 1.2. Практик шаардлага

Практик хэрэгцээ, шаардлагын хувьд энэхүү тогтоолын төслийг батлан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, улс орныг тогтвортой хөгжүүлэх бодлогыг олон улсын аюулгүй байдал, геополитикийн шинээр бий болсон нөхцөл байдалтай уялдуулан явуулах болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдол бүхий заалтууд хэрэгжүүлэх бодит бололцоо бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм

## Хоёр. Тогтоолын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Уг тогтоолын төслийг боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж буй үзэл баримтлал"-ийн үндсэн зорилго, үзэл санаа, агуулгыг хадгалахад ихээхэн анхаарч, зөвхөн олон улсын геополитикийн хүчин зүйлсийг тооцсон зохицуулалтуудыг нэмсэн болно.

## Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.

Энэхүү тогтоол батлагдсанаар Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах салбарт хамаарах бусад хууль тогтоомжийн хүрээнд, олон улсын геополитикийн шинэ

нөхцөл байдлыг харгалзан тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх хууль эрх зүйн бодит бололцоо тодорхой хэмжээгээр бүрдэх болно

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**.

Уг тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Хилийн тухай хууль болон Тагнуулын байгууллагын тухай хуулиуд, түүнчлэн олон улсын эрх зүйн холбогдох шаардлага, үндэслэл, энэ чиглэлийн конвенц, гэрээ, хэлэлцээрүүдийн зүйл заалтуудтай чанд нийцүүлэн, ямар нэгэн уялдаа холбоогүй асуудал болон өөр бусад нэмэгдэл ачаалал үүсэхгүй байхаар боловсруулав.

Ийм учраас“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын энэхүү тогтоол батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн хүндрэл гарахгүй бөгөөд одоо хэрэгжүүлж байгаа үндэсний аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд зориулагдсан зардлын хүрээнд уг баримт бичгийг хэрэгжүүлэх боломжтой юм.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

## “МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын ээлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байлд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсоны үндсэн дээр ”Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д” холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллоо.

Ийм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

2. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д дараах нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахыг санал болгож байна.

- Одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын ззэл баримтлал”-ын “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчин,

тулгамдаж байгаа сорилт, эрсдэл” гэсэн Хоёрдугаар бүлэгт геополитикийн үүдэл сэдэл бүхий хүчин зүйлийн улмаас үүсэж болзошгүй эрсдэл, сорилт, аюул заналтай холбогдол бүхий зүйл заалтуудыг нэмэх.

- “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам.” гэсэн Гуравдугаар бүлэгт байгаа “Оршин тогтнохуйн аюулгүй байдал”-ын тодорхойлолтод Геополитикийн аюулгүй байдлыг хангах асуудлыг чухлыг тодотгосон найруулга оруулах.

- Мөн энэ бүлгийн 3.2.5 дугаар зүйл болгон геополитикийн аюулгүй байдалтай холбогдол бүхий заалтуудыг нэмж оруулах.

Ингэхдээ одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Үзэл баримтлалын үндсэн үзэл санаа, зорилго, агуулгыг хадгалан зөвхөн геополитикийн аюулгүй байдлыг хангах зорилго бүхий зохицуулалтуудыг нэмж оруулсан болно.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг ҮАБЗ-ийн ажлын алба, ГХЯ, БХЯ, ЗХЖШ, ТЕГ-ын удирдлагуудад урьдчилан танилцуулсан бөгөөд тэдгээрийн саналыг судалж, анхаарах зүйлүүдийг төсөлд тусгасан болно

ХУУЛЬ САНААЧЛАГЧ.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны ... дугаар сарын ... -ны өдөр Улаанбаатар хот

Дугаар ...

**“МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ**

**БАРИМТЛАЛ”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

**1. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын гадаад орчин, тулгамдаж байгаа сорилт, эрсдэл” гэсэн бүлэгт хоёрдугаар бүлэгт дараах заалтуудыг нэмсүгэй:**

**2.1. Геополитикийн үүдэл сэдэл бүхий эрсдэл сорилт**.

2.1.1.1. Олон улсын аюулгүй байдлыг хангах өнөөгийн механизмууд, юуны өмнө НҮБ, ЕАБХАБ зэргийн үүрэг, ач холбогдлыг бууруулах гэсэн зарим том гүрний эрмэлзэл хүчтэй нэмэгдэж байна;

2.1.1.2. Олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд бага орнуудыг аль болох оролцуулахгүй байх, тэднийг үл тоомсорлох хандлага газар авах боллоо;

2.1.1.3. Улс хоорондын харилцаанд цэрэг-улс төрийн эвсэл холбоодыг бэхжүүлэх, юуны өмнө НАТО-г дорно зүгт тэлэх, Орос, Хятадын цэрэг-стратегийн хамтын ажиллагааг холбоотны хэмжээ рүү ойртуулан гүнзгийрүүлэх эрмэлзэл ажиглагдаж байна;

2.1.1.4. Улс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэхэд НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр зэвсэгт хүчнээ ашиглах практик АНУ, Орос, Хятад, Турк гэх мэт орнууд болон НАТО-ийн тухайд хэвийн үзэгдэл болох төлөвтэй байна. Тэр ч байтугай үүнийгээ цэрэг-стратегийн номлолдоо тусгадаг болоод байна.

2.1.1.5. Тэргүүлэгч зарим гүрний технологийн хөгжлийн хэт тасархай байдал улам нэмэгдэж, шинэ үеийн зэвсэг, байлдааны техник бүтээх чадавх нь ихсэж байгаа нь зэвсэглэлийн чанараар өрсөлдөх шинэ үе шатыг авчирч, байлдааны ажиллагааны арга хэлбэрт эргэлтийн гэж хэлж болох өөрчлөлт оруулах магадлалтай байна.

2.1.1.6. Олон улсын терроризм дэлхий нийтийн хэмжээний, олон талт шинж төрхтэй болж байгаа бөгөөд бүх улс орны аюулгүй байдалд ноцтой, нийтлэг аюул занал учруулах боллоо.

**2.2. Геополитикийн үүдэл сэдэл бүхий аюул заналын тухай төсөөлөл.**

2.2.1. Ìîíãîë Óëñûí эргэн тойронд буй болсон геополитикийн шинэ нөхцөл байдал, ¿íäýñíèé аюулгүй байдалд íºëººëæ áîëçîøã¿é гадаад, дотоод õ¿÷èí ç¿éëñèéã íýãòãýí ä¿ãíýæ ¿çýõýä îéðûí áîëîí äóíä õóãàöààíû èðýýä¿éä Ìîíãîë Óëñûí òóñãààð òîãòíîë, á¿ðýí эрхт áàéäàë, ãàçàð íóòãèéí á¿ðýí á¿òýí, улсын хилийн халдашгүй дархан áàéäàë, òºðèéí áàéãóóëàëòàä ãàäíààñ öýðãèéí õ¿÷ýýð øóóä çàíàëõèéëýõ àþóë ¿íäñýíäýý áàéõã¿é áàéíà.

2.2.2. Ìàíàé óëñûí îëîí óëñûí íýð õ¿íä ñ¿¿ëèéí æèë¿¿äýä èõýýõýí ºññºí, õºðø õî¸ð îðîíòîéãîî ýëäýâ ìàðãààíòàé àñóóäëàà îëîí óëñûí ýðõ ç¿éí õ¿ðýýíä ýöýñëýí øèéäâýðëýñýí, ýíý õî¸ð óëñòàé болон гуравдагч бусад хөрштэйгөө òîãòîîñîí íàéðñàã õàðèëöàà, õàìòûí àæèëëàãàà ºäðººñ ºäºðò ºðãºæèì õºãæèæ áàéãàà íü èéì ä¿ãíýëòýíä õ¿ðãýæ áàéíà.

2.2.3. ¯¿íèé çýðýãöýý á¿ñ íóòãèéí õ¿ðýýíä ¿¿ñýí Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðæ áîëîõ ýñâýë өөр бусад ãàäààä õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí манай улсын дотоодод үүсэж áîëîõ äàðààõ àþóë занал áîäèòîéãîîð оршиж áàéíà.

2.2.4. Á¿ñ íóòãèéí геополитκийн нөхцөл байдлаас үүдэн Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðæ áîëçîøã¿é аюул занал:

- Îëîí óëñûí òåððîðèçì óëàì á¿ð õ¿ðýýãýý òýëæ Ç¿¿í õîéä Àçè, Òºâ Àçèéí á¿ñ íóòãèéã, ò¿¿íèé äîòîð Ìîíãîë Óëñûí íóòàã äýâñãýðèéã õàìðàõ;

- Óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé Õÿòàäûí ýäèéí çàñãèéí ýð÷èìòýé хөгжлийг даган Àçè òèâä öýðýã-óëñ òºðèéí нөлөөллөө ºðãºæ¿¿ëýõ энэ улсын эрмэлзлийг төрүүлэн ¿¿íèé óëìààñ ¿¿íòýé èæèë òºñòýé àøèã ñîíèðõîë á¿õèé ÎÕÓ áîëîí ÀÍÓ-òàé íîöòîé, ºðãºí õ¿ðýýòýé зөрчилдөхөд õ¿ðãýõ, ¿¿íä íü Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðîõ;

- Õî¸ð Ñîëîíãîñ, Õÿòàä-Òàéâàíü, Ýíýòõýã-Ïàêèñòàí õîîðîíäûí ýñðýã òýñðýã áàéð ñóóðü, Êóðèëèéí àðëóóäûí òàëààðõ Îðîñ-ßïîíû ìàðãààí зэрэг нь óëñ õîîðîíäûí

õàðèëöààíû òîäîðõîé íºõöºë áàéäàëä çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýõ. Ýíý íü á¿ñ íóòãèéã õàìàðñàí øèíæòýé áîëæ ºðãºæèí Ìîíãîë Óëñûã ÿìàð íýã õýëáýðýýð õàìðàõ;

- Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò óëàì á¿ð ºñºí íýìýãäýæ áóé НАТО-ийí öýðýã-óëñ òºð, ýäèéí çàñãèéí íºëººã õÿçãààðëàõ зорилго бүхий Øàíõàé õàìòûí àæèëëàãààíû áàéãóóëëàãûí öýðýã-óëñ òºðèéí ýâñýë õýëáýðèéí ¿éë àæèëëàãàà ºðãºæèí ¿¿íèé ¿ð äàãâàðààð ÀÍÓ, Барууны орнууд нэг талаас áîëîí нөгөө талаас Орос, Хятадын õîîðîíä öýðýã, çýâñãèéí õ¿÷èéã òóëãóóð áîëãîñîí çºð÷èë, ñºðãºëäººí үүсэх, ¿¿íä Ìîíãîë Óëñ òàòàãäàí îðîõ;

- 2008 îíä òîõèîëäñîíòîé төсөөтэй íèéòèéã õàìàðñàí ýäèéí çàñãèéí õÿìðàë Àçè òèâ áîëîí Ç¿¿í Хойд Àçèä áèé áîëæ ýíý íü Ìîíãîë Óëñûí ýäèéí çàñàã, íèéãìèéí õºãæëèéã ñààðóóëàõ áóþó çîãñîîõ áàéäàëä îðóóëàõ;

- Õºðø çýðãýëäýý áîëîí áóñàä îðîíä ¿¿ñññýí õÿìðàëò áàéäëààñ ¿¿äñýí õýíàëòààñ ãàðñàí öàãààí÷ëàë, æèðèéí áîëîí çýâñýãëýñýí ä¿ðâýëòýä íýðâýãäýõ çýðýã áîëîí.

2.2.5. Уламжлалт бус аюул занал:

2.2.5.1. Олон улсын ээдрээтэй нөхцөл, улс төрийн тогтворгүй байдал, үндэсний эдийн засгийн хямрал, нийгмийн хуваагдал, түүний дотор шашин хоорондын харилцааны зарим нэг зөрчил сөргөлдөөн зэрэг нь манай орны аюулгүй байдалд учрах гадаад, дотоод үүдэлтэй уламжлалт бус аюулын эх сурвалж болж байна.

2.2.5.2. Ойрын ирээдүйд ãàäààä, äîòîîä àëèâàà õ¿÷èí ç¿éëýýñ ¿¿äýí дотоодын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй уламжлалт бус гэж хэлж болох дараах аюул занал үүсэж болзошгүй байна. Үүнд:

2.2.5.3. Óëñ òºðèéí õ¿ðýýíä:

- Монгол Улсад стратегийн ашиг сонирхлоо хадгалах, хөрөнгө оруулалт, дэд бүтэц болон эдийн засгийн бусад чухал салбарт давамгай байдлаа бий болгох гэсэн том гүрнүүдийн зөрчил сөргөлдөөн болон тэдгээрийн манай улсын тухайд явуулж буй тус тусын тодорхой  чиглэл, зорилго бүхий геостратегийн бодлогын

нөлөөлөл, үр дагавраас үүдэн Монгол Улсын төр засгийн бодлогод саад бэрхшээл үүсэх, àëü íýã óëñ îðîí, óëñ òºð-öýðãèéí ýâñýë õîëáîî áóþó ¿íäýñòýí äàìæñàí òîì êîðïîðàöóóäààñ улс төрийн хувьд ямар нэгэн байдлаар õàðààò áàéäàëä орох;

- Олон улсын терроризм улам бүр газар авч байгаа болон манай улс терроризмын эсрэг барууны эвсэлд нэгдсэнд дургүйцсэн гадны хүчний явуулгын улмаас энэ аюул ямар нэг хэлбэрээр Монгол Улсад орж ирэх;

- Монгол Улсын геополитик, цэрэг-стратегийн түшиц нутгийн ач холбогдол улам бүр өсөх болсонтой уялдаатайгаар гадаад орнуудын зүгээс манай орны эсрэг явуулах тагнуулын болон бусад үйл ажиллагаагаа нэмэгдэх, энэ нь чиглэл, зорилготой, нийгмийн тодорхой хэсэг бүлэг рүү чиглэсэн агуулгатай болох.

<u>2.2.5.4. Ýäèéí çàñãèéí õ¿ðýýíä:</u>

- Гадаадын хөрөнгө оруулалт, бусад улстай хийх худалдааг тэнцвэржүүлэх нэгдсэн бодлого алдагдах, үүнээс үүдэн улсын хөгжил удаашрах, зогсонги байдалд орох;

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлого, үйл ажиллагаанд алдаа, доголдол гарах, үүний улмаас эдийн засгийн салбарт тогтвортгүй байдал үүсэх, мөнгөний бодлого, валютын зах зээлийн хямрал гарах, дампууралд орох, улмаар Монгол Улсын банк, санхүүгийн үйл ажиллагаанд итгэх гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн итгэл сулрах ;

- Сайтар тооцоогүй, эдийн засгийн өсөлтөөр баталгаажаагүй гадны зээл тусламж нэмэгдэх, үнэт цаасны зах зээл өргөжих, үүнээс үүдэн төр çàñàã, аж ахуйн нэгж байгууллага, иргэд өрөнд ихээр орох, улс орон âàëþòûí íººöºº àëäàõ, áàðüöààëóóëàõ, ãàäààä äîòîîäûí õºðºíãº îðóóëàëò эмх замбараагүй байдалтай болох, түүнчлэн çýýë, òóñëàìæûã çàìààñ íü çàâøèõ ÿâäàë ãàçàð àâñàí ¿¿äýí ãàäààä îðíóóä, ò¿¿íèé äîòîð òîì ã¿ðí¿¿ä ýíý òºðëèéí ¿éë àæèëëàãààã õýðýãæ¿¿ëýõýý çîãñîîõ.

<u>2.2.5.5. Íèéãìèéí õ¿ðýýíä:</u>

- Õóóðàì÷, õààãàëàõ õóãàöàà õýòýðñýí, õ¿íèé áèå îðãàíèçìä õîðòîé õ¿íñ, ýì òàðèà, õóâöàñ, ýä õýðýãëýë ãýõ ìýò ç¿éë¿¿ä ãààíààñ ихээр îðæ èðýõ, ãàäààä õàðèëöàà ºðãºæèæ õ¿í,  ìàë, áàðàà á¿òýýãäõ¿¿íèé óðñãàë ÷ºëººòýé áîëîõ õýðýýð

ýëäýâ õàëäâàðò ºâ÷èí òàðõàõ, ¿¿íèé äîòîð ÄÎÕ, шинэ вирусийн болон íýí õàëäâàðò áóñàä ºâ÷íººð ºâ÷ëºãñäèéí òîî ºñºõ;

- Óëñ îðíû õýìæýýíä, ¿íäýñòýí äàìæñàí ãýìò õýðãèéí á¿ëýãëýë¿¿ä áèé бол, ýð¿¿ãèéí íºõöºë áàéäàë õýíàëòààñ ãàðàõ ìàíàé óëñûí íóòàã äýâñãýðèéã ìàíñóóðóóëàõ áîäèñ, ýëäýâ òºðëèéí çýâñýã, öºìèéí ò¿¿õèé ýä, ìàòåðèàë, õ¿í õóäàëäààëàõààð çººâºðëºõ, äàìæóóëàõ òàëààð áîëãîõ îðîëäëîãî ãàðàõ, òýäãýýðèéí õîð óðøèã íü óëñ îðíû óëñ òºð, ýäèéí çàñãèéí áîäëîãî íºëººëºõ õýìæýýíä хүрэх;

- Харт тамхи, мансууруулах төрлийн бусад бодисын хэрэглээ, ялангуяа залуучуудын дунд хяналтаас гарах, ийм төрлийн бодисын тээвэрлэлт, түгээлт, сурталчилгаа, тараалт, худалдаа нь олон улсын зохион байгуулалттай гэмт хэргийн хэлбэрт шилжих .

2.2.5.6. Ñî¸ë èðãýíøèëèéí õ¿ðýýíä:

- Ìîíãîë Óëñûí ãàäààä õàðèëöàà ºðãºæèõ, íýýëòòýé áîëîõ õýðýýð áóñàä îðíû àìüäðàõ õýâ ìàÿã, ýðõýìëýõ ¿íýò ç¿éëñèéí õ¿÷òýé íýâòðýë гүнзгийрэх, ¿¿íýýñ ¿¿äýí ¿íäýñíèé ¿íýò ç¿éëñèéí ¿íýëýìæèä ýðãýæ áóöàëòã¿é ººð÷ëºëò ãàðàõ, энэ нь монгол хүний удмын сан, угсаа гарваль, төрөлх хэлэнд сөргөөр нөлөөлөх;

- õ¿í òºðºëõòíèé íèéòëýã ñî¸ëûã äýýäëýõ, áóñàä øàøíûã õ¿íäýòãýõ, зарим тохиолдолд албан ёсны бус гаднаас орж ирсэн шашны урсгалд автах ¿çýë áîëîí ìîíãîë ¿íäýñòíèé òºðºëõ õýë, ñî¸ë, áóðõàíû øàøèí, ¸ñ çàíøèë, óäìûí ñàí, óãñàà ãàðâàëàà õàäãàëàí õàìãààëàõ ãýñýí ýðìýëçëèéí õîîðîíä çºð÷èë, ñºðãºëäººí ¿¿ñýõ, ýíý íü óëñ òºðæèõ çàìààð íèéãýìä áóõèìäàë ¿¿ñãýх.

2.2.5.7. Áàéãàë îð÷íû õ¿ðýýíä:

- Äýëõèéí öàã óóðûí äóëààðàë, ºº÷ëºëò áîëîí áóñàä øàëòãààíààñ ¿¿äýí áàéãàëèéí ãàìøèãò ¿çýãäë¿¿ä îëøðîõ ýíý íü óëñ îðíû ýäèéí çàñàã, íèéãýìä äààæ äààâøã¿é õîõèðîë учруулах;

- Хэт их гадаадын хөрөнгө оруулалт бүхий óóë óóðõàéí áîëîí áîëîâñðóóëàõ ¿éëäâýðëýëèéã ýð÷èìæ¿¿ëýõ ÿâöàä áàéãàëèéí òýíöâýð àëäàãäàõ, óñ, ãîë ìºðºí, àãààð ìàíäàë, õºðñ áîõèðäîõ, îé ñ¿éäýõ, öºëæèëò ãàçàð àâàõ, áýë÷ýýðèéí òàëõäàë, òàðèàëàíãèéí òàëáàé õîìñäîë èõñýõ, ýäãýýðýýñ ¿¿äýí õ¿í àìûí íýëýýä õýñãèéí àìüæèðãààíû ýõ ¿¿ñâýð áîëñîí ìàë àæ àõóé, ãàçàð òàðèàëàíãèéí õºãæèë çîãñîíãè

áàéäàëä îðîõ, өөр хоорондоо тэрсэлдэх;

- Манай орны нутаг дэвсгэрийг цөмийн хаягдал болон байгаль орчинд хор хөнөөлтэй бусад материалыг булшлахад ашиглах оролдлого гарах.

**2. "Гурав .Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гэсэн бүлгийн "3.1. Оршин тогтнохуйн аюулгүй байдал" гэсэн заалтыг дараах байдлаар өөрчилсүгэй.**

"Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, геополитикийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс мөн" .

**3. Гурав. Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гэсэн бүлэгт 3.1.5 дугаар зүйл болгон дараах заалтуудыг нэмсүгэй.**

3.1.5. Геополитикийн аюулгүй байдал

3.1.5.1. Монгол Улсын геополитикийн аюулгүй байдал гэж үндэсний язгуур ашиг сонирхлоо олон улсын аюулгүй байдлын эрх зүйн хэм хэмжээний хүрээнд найдвартай хадгалан хамгаалах, бусад орон, эвсэл холбоодтой найрсаг харилцаа хамтын ажиллагаатай байх болон гадаад ертөнцөд тодорхой хэмжээгээр нөлөө бүхий байр суурь эзлэх нөхцөл бололцоог олгосон, олон улсын тавцанд хүлээн зөвшөөрөгдсөн, геополитикийн өндөр статус, нэр хүндтэй байх улс орны чадамжийг хэлнэ;

3.1.5.2. Монгол Улсын эргэн тойронд бий болсон геополитикийн шинэ нөхцөл байдал, олон улсын аюулгүй байдлын гадаад орчны өөрчлөлт, улс орны хөгжлийн шинж чанар, хэтийн төлөв, ирээдүйн хандлагад нийцүүлэн үндэсний аюулгүй байдлын бодлогын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болох геополитикийн салбарт төрөөс баримтлах бодлого боловсруулан хэрэгжүүлэх, энэ бодлогын эрх зүйн орчныг бий болгох;

3.1.5.3. Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, îëîí óëñûí аюулгүй байдлын õàìòûí ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын

гадаад харилцааг өргөжүүлэх замаар геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэх;

3.1.5.4. Шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалд нийцүүлэн ардчилал, сайн засаглалыг áàòàëãààæóóëàõ, монгол, соёл иргэншил, áàéãàëü орчноо õàäãàëàí õàìãààëàõ, õ¿íèé ýðõ, èðãýäýý õ¿÷èðõýãæ¿¿ëýõ, амьдрах таатай орчин, ýðõ чөлөөгөөр хангах зэрэг улс орны геополитикийн давуу тал, чадавхыг дээд зэргээр ашиглахад чиглэсэн цэгцтэй бодлого хэрэгжүүлэн геополитикийн аюулгүй байдлын дотоод таатай нөхцөлийг бүрдүүлэх.

Төсөл

БАТЛАВ.
ХУУЛЬ САНААЧЛАГЧ ..........................................................................................

**“МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсоны үндсэн дээр ”Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал””д”холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллИйм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл  баримтлал-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

**1.1. Хууль эрх зүйн үндэслэл**

Хууль, эрх зүйн үндэслэлийн хувьд энэхүү тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэсэн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр, “Төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох” гэсэн 25 дугаар зүйлийн 1-ийн 2 дугаар заалт, “ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын

үзэл баримтлал", "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль", "Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль", Гадаад бодлогын үзэл баримтлал" болон "Батлан хамгаалах бодлогын үндэс" баримт бичгүүдийн холбогдох зүйл заалтуудад тулгуурлан боловсруулав.

**1.2. Практик шаардлага**

Практик хэрэгцээ, шаардлагын хувьд уг тогтоолын төслийг батлан Монгол Улсын гадаад харилцааг олон улсын аюулгүй байдал, геополитикийн шинээр бий болсон нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэх болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн энэ салбартай холбогдол бүхий заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх бодит бололцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм

**Хоёр. Тогтоолын зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Энэхүү тогтоолын төслийг боловсруулахдаа одоо баримталж буй үзэл баримтлалын үндсэн зорилго, үзэл санаа, агуулгыг хадгалахад ихээхэн анхаарч, зөвхөн олон улсын геополитикийн хүчин зүйлсийг тооцсон зохицуулалтуудыг нэмсэн болно.

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.**

Уг тогтоол батлагдсанаар гадаад бодлогыг аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах салбарт хамаарах бусад хууль тогтоомжийн хүрээнд, олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдлыг харгалзан тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх хууль эрх зүйн бодит бололцоо тодорхой хэмжээгээр бүрдэх болно

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**.

Энэхүү тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Батлан

хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Хилийн тухай хууль болон Тагнуулын байгууллагын тухай хуулиуд, түүнчлэн олон улсын эрх зүйн холбогдох шаардлага, үндэслэл, энэ чиглэлийн конвенц, гэрээ, хэлэлцээрүүдийн зүйл заалтуудтай чанд нийцүүлэн, ямар нэгэн уялдаа холбоогүй асуудал болон өөр бусад нэмэгдэл ачаалал үүсэхгүй байхаар боловсруулав.

Ийм учраас Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын энэхүү тогтоол батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн хүндрэл гарахгүй бөгөөд одоо хэрэгжүүлж байгаа үндэсний аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд зориулагдсан зардлын хүрээнд уг баримт бичгийг хэрэгжүүлэх боломжтой юм.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

**“МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН**
**ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**
**УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

1. Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос

болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын ээлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсоны үндсэн дээр дээр  ”Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал””д”холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллоо.

Ийм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл  баримтлал-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

2. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл  баримтлал”-д 4 заалт бүхий “Геополитикийн салбарт баримтлах гадаад харилцааны бодлого” гэсэн зүйлийг нэмэхээр тусгалаа.

Энэхүү тогтоолын төслийг ҮАБЗ-ийн ажлын алба, ГХЯ, БХЯ, ЗХЖШ, ТЕГ-ын удирдлагуудад урьдчилан танилцуулсан бөгөөд тэдгээрийн саналыг судалж, анхаарах зүйлүүдийг төсөлд тусгасан болно

ХУУЛЬ САНААЧЛАГЧ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар сарын ... -ны өдөр Улаанбаатар хот

Дугаар ...

“МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ”-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-д дараах зүйл, заалтыг нэмсүгэй:

НАЙМ. ГЕОПОЛИТИКИЙН САЛБАРТ БАРИМТЛАХ ГАДААД ХАРИЛЦААНЫ БОДЛОГО

28. Геополитикийн салбарт баримтлах гадаад харилцааны бодлогын үндэс нь шинээр бий болсон геополитикийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогынхоо агуулгыг гүнзгийрүүлэх, шинэ утга агуулгаар баяжуулах, îëîí óëñûí аюулгүй байдлын õàìòûí ажиллагаанд оролцох идэвх, чармайлтаа нэмэгдүүлэх, харилцан ашигтай улс төр, эдийн засаг, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг өргөжүүлэх замаар геополитикийн аюулгүй байдлын олон улсын таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

29. Геополитикийн салбарт баримтлах гадаад харилцааны бодлогын үндсэн чиглэл:

29.1. Ýíõ òàéâíûã тогтоон барих, аливаа маргаантай асуудлыг эвийн аргаар шийдвэрлэхэд ÷èãëýñýí óëñ õîîðîíäûí á¿õ òàëûí õàìòûí àæèëëàãààíä Ìîíãîë Óëñûí îðîëöîîã èäýâõæ¿¿ëýõ, ÎÕÓ, ÁÍÕÀÓ-ын зэрэгцээ ÀÍÓ тэргүүтэй гуравдагч áóñàä óëñ орон, олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаагаа өргөжүүлэх, өөрийн зарчимч байр суурь, дуу хоолойгоо нэмэгдүүлэн Ìîíãîë Óëñûí олон улсын геополитикийн тавцанд эзлэх ááéð суурь, ач холбогдлыг өндөрсгөх;

29.2. Хөрш орнууд, нөлөө бүхий гуравдагч бусад гүрний Монгол дахь геополитикийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэх, эдгээр гүрний геостратегийн зөрчил, сөргөлдөөнөөс үүдэлтэй элдэв, аюул, сорилт, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах утга агуулгаар гадаад, дотоод бодлогоо баяжуулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Төсөл

БАТЛАВ.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ ..........................................................................................

**“МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС”-Т НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсоны үндсэн дээр ”Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллоо.

Ийм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон ”Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

**1.1. Хууль эрх зүйн үндэслэл**

Хууль, эрх зүйн үндэслэлийн хувьд энэхүү тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэсэн 11 дүгээр зүйлийн 1 дүгээр, “Төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох” гэсэн 25

дугаар зүйлийн 1-ийн 2 дугаар заалт, “ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль”, “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль”, Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдийн холбогдох зүйл заалтуудад тулгуурлан боловсруулав.

**1.2. Практик шаардлага**

Уг тогтоолын төслийг батлан Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг олон улсын аюулгүй байдал, геополитикийн шинээр бий болсон нөхцөл байдалтай уялдуулан хөгжүүлэх болон Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн энэ салбарт холбогдол бүхий заалтуудыг хэрэгжүүлэх бодит боломжийг бүрдүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм

**Хоёр. Тогтоолын зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Энэхүү тогтоолын төслийг боловсруулахдаа одоо баримталж буй бодлогын үндсэн зорилго, үзэл санаа, агуулгыг хадгалахад ихээхэн анхаарч, зөвхөн олон улсын геополитикийн хүчин зүйлсийг тооцсон зохицуулалтуудыг нэмсэн болно.

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал.**

Уг тогтоол батлагдсанаар төрийн батлан хамгаалах бодлогыг аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах салбарт хамаарах бусад хууль тогтоомжийн хүрээнд, олон улсын геополитикийн шинэ нөхцөл байдлыг харгалзан тооцож, үр дүнтэй хэрэгжүүлэх хууль эрх зүйн бодит боломж тодорхой хэмжээгээр бүрдэх болно

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**.

Энэхүү тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Хилийн тухай хууль болон Тагнуулын байгууллагын тухай хуулиуд, түүнчлэн олон улсын эрх зүйн холбогдох шаардлага, үндэслэл, энэ чиглэлийн конвенц, гэрээ, хэлэлцээрүүдийн зүйл заалтуудтай чанд нийцүүлэн, ямар нэгэн уялдаа холбоогүй асуудал болон өөр бусад нэмэгдэл ачаалал үүсэхгүй байхаар боловсруулав.

Ийм учраас “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын энэхүү тогтоол батлагдсанаар улсын төсөвт ямар нэгэн хүндрэл гарахгүй бөгөөд одоо хэрэгжүүлж байгаа үндэсний аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанд зориулагдсан зардлын хүрээнд уг баримт бичгийг хэрэгжүүлэх боломжтой юм.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

## “МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС”-Т НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ УИХ-ЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Монгол Улс Ази, Европын соёл иргэншил, дэлхийн гурван том шашны уулзварт, төр, нийгмийн өөр тогтолцоот улс орнуудын зах нийлсэн заагт, Орос болон Европоос Ази руу, Хятадаас Орос болон Европ руу дамжих их замын дунд

оршдог бөгөөд Евразийн уужим том нутаг дэвсгэрийн төвд орших манай орны геостратегийн чухал байршил нь дэлхийн том гүрнүүдийн анхаарлыг эртнээс татсаар ирсэн билээ. Ийм ч учраас сүүлийн жилүүдэд Монгол Улсын эзэлж байгаа геополитикийн орон зай дэлхийн их гүрнүүдийн анхаарлыг хүчтэй татах болж, манай улс тэдгээрийн геостратегийн сөргөлдөөний шинэ талбар болон хувирч байгаа нь нэгэнт бодит зүйл болоод байна.

Гэтэл энэ шинэ нөхцөл байдалд зохицсон төрийн бодлого хэрэгжүүлэх онол, эрх зүйн цэгцтэй үндэслэл өнөөдрийг хүртэл боловсруулагдаагүй, одоо хүчин төгөлдөр байгаа “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Гадаад бодлогын үзэл баримтлал” болон “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг төрийн бодлогын тулгуур баримт бичгүүдэд манай улсын үндэсний аюулгүй байдалд эергээр болон сөргөөр нөлөөлж болзошгүй геополиткийн хүчин зүйлсийг харгалзан үзсэн зүйл, заалт тийм ч тодорхой тусгагдаагүй байгаа юм.

Үүнтэй уялдаатайгаар улс орны аюулгүй байдалд хамаарах өргөн хүрээтэй олон талт асуудлын дотроос үндэсний язгуур эрх ашигт эерэг, сөргөөр нөлөөлж болзошгүй геополитикийн хүчин зүйлсийг тусгайлан авч үзэн, эдгээрийг тооцсоны үндсэн дээр ”Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах нь зайлшгүй шаардлага болон тавигдаж боллоо.

Ийм учраас хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дээр дурдсан үндэслэл, болон өнөөгийн бодит практик хэрэгцээ шаардлагыг тулгуур болгон ”Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг боловсруулан өргөн мэдүүлж байна.

2. Дээр дурдсан үндэслэл, шаардлагын дагуу “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл  баримтлал”-д 6 заалт бүхий “Батлан хамгаалах бодлогын геополитикийн чиглэл” гэсэн зүйлийг нэмэхээр тусгалаа.

Энэхүү тогтоолын төслийг ҮАБЗ-ийн ажлын алба, ГХЯ, БХЯ, ЗХЖШ, ТЕГ-ын удирдлагуудад урьдчилан танилцуулсан бөгөөд тэдгээрийн саналыг судалж, анхаарах зүйлүүдийг төсөлд тусгасан болно

ХУУЛЬ САНААЧЛАГЧ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар сарын ... -ны өдөр Улаанбаатар хот

Дугаар ...

“МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГО”-Д
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс”-т дараах зүйл, заалтыг нэмсүгэй:

Долоо. Батлан хамгаалах бодлогын геополитикийн чиглэл

7.1. Ìîíãîë Óëñ àëèâàà äàéí, çýâñýãò ìºðãºëäººíèéã óëñ õîîðîíäûí áîëîí äîòîîäûí ìàðãààíò àñóóäëóóäûã øèéäâýðëýõ õýðýãñýë ãýæ ¿çýõã¿é. Äýëõèé äàõèíä áîëîí á¿ñ íóòàãò äàéí, çýâñýãò ìºðãºëäººí ãàðãóóëàõã¿éí òºëºº òýìöýë, çýâñýã õóðààõ, ÿëàíãóÿà öºìèéí áîëîí áóñàä ¿é îëíîîð õºíººõ çýâñãèéã á¿ðìºñºí õîðèãëîõ, îëîí óëñûí òåððîðèçìòàé òýìöýõýä ÷èãëýñýí îëîí óëñûí á¿õ ¿éë àæèëëàãààíä èäýâõòýé îðîëöîíî.

7.2. Улс îðíóóäûí îëîí ÿíçûí ýðõ àøãûí çºð÷èë ¿å ¿å õóðöäàæ, çàðèìäàà çýâñýãò ìºðãºëäººíä õ¿ðãýí, çýâñýãò õ¿÷íèéã óëñ òºðèéí áîëîí ìàðãààíòàé áóñàä àñóóäëûã øèéäâýðëýõ çîðèëãîîð õýðýãëýõ ñýòãýëãýý õýâýýð õàäãàëàãäñààð áàéãààãèéí ãàäíà á¿ñ íóòãèéí èõ ã¿ðí¿¿äýä òºðºë á¿ðèéí çýð çýâñãèéí àñàð èõ íººö á¿õèé öýðãèéí õ¿÷èðõýã á¿ëýãëýë¿¿ä îðøñîîð, ò¿¿í÷ëýí Àçè, Íîìõîí äàëàéí á¿ñ íóòàãò àþóëã¿é áàéäëûí õàìòûí òîãòîëöîî á¿ðäýõ ýõëýë òàâèãäààã¿é çýðãýýñ ¿¿äýí àëèâàà äàéí, ò¿ðýìãèéëýëèéí áîäèò àþóë á¿ðìºñºí àðèëààã¿é áàéíà ãýæ ¿çíý.

7.3. Ìîíãîë Óëñûí òºð, çàñãààñ Ýõ îðíûõîî öýðãèéí àþóëã¿é áàéäëûã ÷óõàë÷ëàí ¿çýæ, ¿íäýñíèé ýðõ àøãàà õàìãààëàõûí òóëä òºðèéí áàòëàí õàìãààëàõ áîäëîãî îíîâ÷òîé áîëãîí áýõæ¿¿ëýõ àñóóäëûã àíõààðëûí òºâä áàéëãàíà.

7.4. Ìîíãîë Óëñ Í¯Á-ûí ä¿ðìèéí äàãóó ¿íäýñíèé àþóëã¿é áàéäëàà äàíãààðàà áóþó õàìòûí õ¿÷ýýð áàòëàí õàìãààëàõ ýðõýý ýäýëíý. Óëñ îðíû òóñãààð òîãòíîë, íóòàã äýâñãýðèéí á¿ðýí á¿òýí áàéäëûã áàòëàí õàìãààëàõ, îëîí óëñûí ýíõèéã ñàõèóëàõ áîëîí áóñàä ¿éë àæèëëàãààíä îðîëöîõ ¿¿ðýã á¿õèé ººðèéãºº õàìãààëàõ ¿íäýñíèé Çýâñýãò õ¿÷èíòýé áàéíà.

7.5. ªíººãèéí áèé áîëîîä áàéãàà íèéòèéã õàìàðñàí óëàìæëàëò áóñ àþóë çàíàëûí íºõöºëä батлан õàìãààëàõ àñóóäàë óëñ ã¿ðí¿¿äèéí õèë õÿçãààðààð çààãëàãäàõã¿é áîëæ áàéãààòàé õîëáîãäîí улс орны àþóëã¿é áàéäëûã óëñ îðîí á¿ðèéí èäýâõòýé îðîëöîîòîéãîîð, òýð äîòîð çýâñýãò õ¿÷í¿¿äèéíõýý íýãäñýí ÷àðìàéëòààð õàíãàõ ÿâäàë

îëîí óëñûí õàðèëöààíû íýã øèíý õýëáýð áîëîí õºãæèæ ¿¿íä Ìîíãîë Óëñûí Çýâñýãò õ¿÷èí èäýâõòýé оролцоно.

7.6. Зэвсэгт хүчнийг ¿íäñýí ÷èã ¿¿ðãèéíõýý çýðýãöýý ýíõèéã ñàõèóëàõ, òåððîðèçìòàé òýìöýõ áîëîí îëîí óëñûí áóñàä ¿éë àæèëëàãààíä îðîëöîõ, íèéòèéã õàìàðñàí áàéãàëèéí ãàìøèã, òåõíîëîãèéí îñîë, õ¿ì¿¿íëýãèéí ñ¿éðýë çýðýã õÿìðàëò áàéäëûí ¿åä îëîí òàëò ¿¿ðýã ã¿éöýòãýõ ÷àäàâõè á¿õèé, ºíäºð ìýðãýøñýí áîëãîí ººð÷ëºí çîõèîí áàéãóóëàõ áîëîí îðîí íóòãèéí õàìãààëàëòûã æèíõýíý ¸ñîîð íü á¿ðä¿¿ëýí áèé áîëãîõ асуудлыг øèéäâýðëýõ àðãà çàìûã øèíæëýõ óõààíû ¿íäýñëýëòýé òîäîðõîéëîõ, ¿¿íòýé óÿëäóóëàí Çýâñýãò õ¿÷íèéõýý ¿¿ðýã, çîðèóëàëò, á¿òýö, çîõèîí áàéãóóëàëò, çýâñýãëýë, òåõíèê, ¿éë àæèëëàãààíû ñòðàòåãè, òàêòèêèéã ººð÷ëºõ øààðäëàãàûã áèé áîëãîæ áàéíà.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА